ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХАМААРАХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 01 дүгээр сарын 09 Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ.

1.1. Салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хяналтад авсан зүйл, заалтуудын хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж биелэлтэд гарч буй өөрчлөлтийг хэмжих, дүгнэлт гарган удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, хэрэгжилтийг сайжруулах чиглэлд зөвлөмж өгч, биелэлтийг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын 6-д заасан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй”-г баримталсан.

1.3. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн нэгдсэн дүнг тус журмын 6.3-д заасан томьёогоор тооцож гаргасан болно.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН.

2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамааруулж, ЗГХЭГ-ын цахим системээр хяналтад авсан нийт **277** хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн **727** заалтыг салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системээр хяналтад авч, холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ хийв.

Хүснэгт 1. Хяналт-шинжилгээ хийсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэр

Нийт	Нийт	Хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	УАБЗ-ийн зөвлөмж	УАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэр, тоо	277	17	28	28	8	87	91	9	3	5	1
Эзлэх хувь	100.0	6.1	10.1	10.1	2.9	31.4	32.9	3.2	1.1	1.8	0.4
Хяналтад авсан нийт зүйл, заалт, тоо	727	50	129	150	14	138	167	60	3	15	1
Эзлэх хувь	100.0	6.9	17.7	20.6	1.9	19.0	23.0	8.3	0.4	2.1	0.1

2.2. Хяналтад авч тайлагнасан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт 2024 онд гарсан шийдвэр 23.8%, заалт 21.5%, 2025 онд гарсан шийдвэр 27.8%, заалт 33.0%, Засгийн газрын шийдвэр 66.8%, заалт 49.8% (Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгавар)-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, заалтын төрөл, оноор

		2011	2012	2013	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Дүн
хууль	шийдвэр	-	1	-	1	2	-	2	-	-	2	5	4	-	17
	заалт	-	3	-	3	5	-	3	-	-	6	12	18	-	50
УИХ тогтоол	шийдвэр	-	-	-	-	1	2	1	6	2	5	3	3	5	28
	заалт	-	-	-	-	1	2	1	13	6	55	6	30	15	129
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	шийдвэр	-	-	-	-	-	3	1	3	3	4	5	2	6	27
	заалт	-	-	-	-	-	6	3	18	6	26	32	13	46	150
Ерөнхийлөгч зарлиг	шийдвэр	-	-	-	1	-	1	1	-	1	2	-	1	1	8
	заалт	-	-	-	1	-	1	4	-	4	2	-	1	1	14
ҮАБЗ зөвлөмж	шийдвэр	1	-	1	-	-	2	-	-	3	1	-	-	-	8
	заалт	1	-	1	-	-	3	-	-	3	10	-	-	-	18
ҮАБЗ тэмдэглэл	шийдвэр	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1
	заалт	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1
ЗГ тогтоол	шийдвэр	-	-	-	-	-	1	-	-	4	8	14	33	29	89
	заалт	-	-	-	-	-	1	-	-	5	11	22	52	49	140
ЕС захирамж	шийдвэр	-	-	-	-	-	-	-	-	-	1		1	1	3
	заалт	-	-	-	-	-	-	-	-	-	1		1	1	3
ЗГ-ын хуралдаан тэмдлэл	шийдвэр	-	-	-	-	-	-	-	-	-	15	21	20	31	87
	заалт	-	-	-	-	-	-	-	-	-	22	28	30	82	162
ЗГ албан даалгавар	шийдвэр	-	-	-	-	-	-	-	-	-	2	1	2	4	9
	заалт	-	-	-	-	-	-	-	-	-	2	1	11	46	60
Нийт	шийдвэр	2	1	1	2	3	9	5	9	13	40	49	66	77	277
	заалт	2	3	1	4	6	13	11	31	24	135	101	156	240	727
Эзлэх хувь	**шийдвэр**	**0.7**	**0.4**	**0.4**	**0.7**	**1.1**	**3.2**	**1.8**	**3.2**	**4.7**	**14.4**	**17.7**	**23.8**	**27.8**	**-**
	заалт	**0.3**	**0.4**	**0.1**	**0.6**	**0.8**	**1.8**	**1.5**	**4.3**	**3.3**	**18.6**	**13.9**	**21.5**	**33.0**	**-**

2.3. Нийт хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт 2020 оноос өмнөх заалтууд 5.5% байна.

2.4. Ерөнхий сайдын захирамж (100%), Засгийн газрын албан даалгавар (92.1%)-ийн үнэлгээ хамгийн өндөр, МУ-ын хууль (67.0%) болон УИХ-ын тогтоол (72.6%) хамгийн бага үнэлгээтэй байна.

Хүснэгт 3. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн үнэлгээ, шийдвэрийн заалтаар

Бүгд			Үүнээс									
			МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	УАБЗ-ийн зөвлөмж	УАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл
ХОЁР. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ												
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо			277	17	28	28	8	87	91	9	3	5	1
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо			727	50	129	150	14	138	167	60	3	15	1
Үнэлгээ	Хэрэгжсэн		422	18	56	77	7	86	121	48	3	6	-
	Хэрэгжих шатанд	Ахиц гарсан	91	11	19	22	2	15	17	4	-	1	-
		Тодорхой үр дүнд хүрсэн	96	10	35	19	3	13	9	3	-	4	-
		Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай	67	10	14	21	-	9	9	2	-	2	-
	Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас	4	1	-	1	-	1	-	-	-	-	1
		Хөрөнгө дутагдсанаас	3	-	-	-	-	2	1	-	-	-	-
	Хугацаа болоогүй		28	-	3	7	1	11	3	3	-	-	-
	Хэрэгжих боломжгүй		16	-	2	3	1	1	7	-	-	2	-
Хяналтаас хасуулах санал /хүчингүй болсон эсэх/			195	16	22	31	-	51	64	6	1	4	-
Дүн /хувь/			80.4	67.0	72.6	77.1	79.2	82.9	88.2	92.1	100.0	73.1	-

2.5. Нийт хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 58.0% (422/727) хэрэгжсэн буюу 100%-аар үнэлэгдсэн байна.

Хүснэгт 4.

Үнэлгээ		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	УАБЗ-ийн зөвлөмж	УАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	**Нийт**
Хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%	18	56	77	7	86	121	48	3	6	-	**422**
Хэрэгжих шатанд	Ахиц гарсан - 50%	11	19	22	2	15	17	4	-	1	-	**91**
	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	10	35	19	3	13	9	3	-	4	-	**96**
	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	10	14	21	-	9	9	2	-	2	-	**67**
Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас - 0%	1	-	1	-	1	-	-	-	-	1	**4**
	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	-	-		-	2	1	-	-	-	-	**3**
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Х.Б	-	3	7	1	11	3	3	-	-	-	**28**
Хэрэгжих боломжгүй	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	-	1	-	-	-		-	-	-	-	**1**
	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	-	-	3	1	-	4	-	-	2	-	**10**
	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	-	1	-	-	-	1	-	-	-	-	**2**
	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	-	-	-	-	-	1	-	-	-	-	**1**
	Хэмжигдэхүйц биш	-	-	-	-	1	1	-	-		-	**2**
		50	**129**	**150**	**14**	**138**	**167**	**60**	**3**	**15**	**1**	**727**

ГУРАВ. ДҮГНЭЛТ.

3.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамааралтай хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 2025 оны жилийн эцсийн байдлаар 80.3 хувьтай дүгнэгдэв.

3.2. Хяналт-шинжилгээний дүнд үндэслэн нэг удаагийн шинж чанартай, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дараагийн шийдвэр гарсан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн чиг үүрэгт хамааралгүй, бусад хүчин зүйл (гадаад, дотоод)-ээс шалтгаалан хэрэгжих боломжгүй зэрэг нийт 127 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 195 заалтыг хяналтаас хасуулах саналыг тусгав. Хяналт-

шинжилгээний тайлан бүрээр хяналтаас хасуулах санал хүргүүлж байгаа боловч хасалт хийхгүй байгаагаас тайлагнагч албан хаагчдад тайлант хугацааны хэрэгжилтийг тайлагнах, эсвэл өгөгдсөн цаг хугацааны мэдээллийг тайлагнах гэх зэрэг ойлгомжгүй байдал үүсгэж хяналт-шинжилгээний тайлагналт, үнэлгээнд нөлөөлж байна.

3.3.Хяналтад авсан нийт заалтын 58 хувь буюу 422 заалт биелэлт бүрэн хангагдаж, хэрэгжсэн байна.

3.4. Асуудал хариуцсан зарим албан хаагчид нь агуулгын алдаатай, тайлант хугацаанд салбарын хэмжээнд гүйцэтгэсэн ажлыг дутуу, хүрсэн үр дүнг бус процесс тайлагнаснаас хяналтад авсан нийт заалтын 35 хувь буюу 254 заалт (ахиц гарсан 91, тодорхой үр дүнд хүрсэн 96, удаашралтай/эрчимжүүлэх шаардлагатай 67) хэрэгжих шатанд “50 хувь” үнэлгээгээр үнэлэгдсэн.

3.5. Хяналтад авсан нийт заалтын 2% буюу 15 заалт “хэрэгжих боломжгүй” үнэлэгдсэн нь шийдвэр гаргахдаа судалгаа, нотолгоонд сайтар үндэслэх хэрэгтэйг харуулж байна. Үүнд:

- “Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй” үнэлэгдсэн УИХ-ын тогтоол 1;
- “Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй” үнэлэгдсэн Байнгын хорооны тогтоол 3, Ерөнхийлөгчийн зарлиг 1, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж 2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 4 буюу нийт 10;
- “Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй” үнэлэгдсэн УИХ-ын тогтоол 1, Засгийн газрын тэмдэглэл 1 буюу нийт 2;
- “Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй” үнэлэгдсэн Засгийн газрын тэмдэглэл 1;
- “Хэмжигдэхүйц биш” үнэлэгдсэн Засгийн газрын тогтоол 1, Засгийн газрын тэмдэглэл 1 буюу нийт 2.

3.6. Хяналт-шинжилгээгээр төсөв, хөрөнгөтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээгүй, тухайн заалтыг биелүүлэх талаар дорвитой ямар нэгэн ажил зохион байгуулаагүй шалтгааны улмаас нийт 7 заалт “хэрэгжээгүй” үнэлэгдсэн. Үүнд:

- зохион байгуулалтаас - хууль 1, Байнгын хорооны тогтоол 1, Үндэсний аюулгүй байдлын тэмдэглэл 1, Засгийн газрын тогтоол 1 буюу нийт 4 заалт;
- санхүүжилтээс - Засгийн газрын тогтоол 2, Засгийн газрын тэмдэглэл 1 буюу нийт 3 заалт.

3.7.Цахим системд зарим тогтоол шийдвэрийг хавсаргаагүй эсхүл зөрүүтэй хавсаргасан, /https://legalinfo.mn/-д оруулаагүй тохиолдолд шийдвэр, заалтын хэрэгжилт агуулгын алдаатай тайлагнагдаж, үнэлгээнд нөлөөлж байна.

3.8.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг батлахдаа өмнөх ижил агуулга, зохицуулалт бүхий шийдвэрийн хэрэгжилтийг хэлэлцэн дүгнэж, шаардлагатай бол нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэх, хэрэгжсэн гэж үзвэл тухайн шийдвэрээр хүчингүй болгож шийдвэрлэхгүй байгаагаас хяналт-шинжилгээний явцад өөрчилт, хаваржилтын талаар олон давтагдсан агуулгатай 5 шийдвэрийн 34 заалт (2023, 2024, 2025 он)-ыг тайлагнаж байгаа нь тайлангийн чанар, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлөх шалтгааны нэг болж байна.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ.

4.1.Харьяа байгууллага, яамны бүтцийн нэгжийн удирдлага, албан хаагчдад:

4.1.1.Тушаал шийдвэр боловсруулах, хянах явцдаа шийдвэр батлах эрх зүйн үндэслэлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний дугаар, өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой зааж байх;

4.1.2.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг тайлагнахдаа заалтын агуулгын хүрээнд үр дүнг нотлох баримт хавсарган иж бүрэн, тодорхой тайлагнах, хамтран хэрэгжүүлсэн бол оролцооны зааг ялгааг тусгах, үр дүнд хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг бичих;

4.1.3. Тогтоол, шийдвэрийн төсөл боловсруулахдаа өмнө нь тухайн чиглэлээр гарсан шийдвэрийн хэрэгжилт хангагдсан эсхүл хангагдах боломжгүй байгаа бол тогтоолыг бүрэн эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох зохицуулалтыг төсөлд тусган боловсруулах;

4.1.4.Бусад яамдаас санал авахаар ирүүлсэн тогтоол, шийдвэрийн төсөлд санал өгөхдөө хариуцлагатай хандаж, салбарт хамаарахгүй шийдвэрээс салбар, яамыг хасах саналыг тухай бүр хүргүүлж байх зэрэг болно.

4.2. **Төрийн захиргааны удирдлагын газарт:**

4.2.1.“Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хуваарилалтыг оновчтой хийгээгүйгээс тайлагналт хангалтгүй ирж байгаа тул бүтцийн нэгж, харьяа байгууллагын чиг үүргийн дагуу хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хуваарилалтыг оновчтой хийх (ХШҮ үр дүн баталгаажсаны дараа тайланг татан авч дахин хуваарилалтыг ХШҮДАГ-тай хамтран бэлтгэх);

4.2.2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийн 10.19.4.1-д “Тогтоол, шийдвэр батлах эрх зүйн үндэслэлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний дугаар, өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой зааж байхыг Засгийн газрын гишүүд..." гэж заасныг мөрдөж ажиллах;

4.2.3. Салбарт хамааралгүй тогтоол, шийдвэр, заалтыг системд тайлагнах эрх нээгдэхээс өмнө хяналтаас хасуулах тухай санал гаргаж шийдвэрлүүлэх;

4.2.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр өгсөн зөвлөмжийг тухай бүр Төрийн нарийн бичгийн даргын үүрэг даалгавраар салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд бүртгэх зэрэг болно.

ТАВ. Санал

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт:

5.1.Ижил агуулга, зохицуулалт бүхий болон цаг хугацааны хувьд ач хобогдолгүй болсон, тухайн асуудлаар дараагийн шийдвэр гарсан, бүрэн хэрэгжсэн үнэлгээтэй хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хяналтаас хасч, тайлагналтын чанарыг сайжруулах боломж олгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

5.2.Тайлант хугацааны төгсгөлөөр гарсан шийдвэрийг дараагийн тайлант хугацаанаас хяналтад авах;

5.3.Ижил агуулга, зохицуулалт бүхий болон цаг хугацааны хувьд ач хобогдолгүй болсон, тухайн асуудлаар дараагийн шийдвэр гарсан, бүрэн хэрэгжсэн үнэлгээтэй хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийг дахин дахин тайлагнуулж, тайлагнах заалтын тоог хэт олон болгосноор тайлагналтын чанарт сөргөөр нөлөөлж, хяналт-шинжилгээний дүнгээр тайланд сайжруулалт хийх хугацаа гарахгүй байгаагаас гадна тухайн албан хаагчид чиг үүргээр хүлээсэн бусад ажлаа үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бууруулж байна. Тухайлбал: ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан 5 мэргэжилтний хувьд тайлант хугацааны тайланд зөвхөн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт ХШҮ хийхэд ажлын 10 өдөр орчим зарцуулсан ба 4 улирал тутамд ХШҮ хийж тайлагнахад жилийн ажлын нийт өдрийнхөө 1/6-ийг зөвхөн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд ХШҮ хийхэд зарцуулахаар байна;

5.4. Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын 6.2-д заасан арга зүйд тодорхой үр дүнд хүрсэн ажлыг удаашралтай байгаа заалттай нэг хэмжүүрээр хэмжихээр тусгасан, цахимд журамд заагдаагүй ахиц гарсан гэсэн үзүүлэлтийг нэмж оруулсан зэрэг нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын үнэлгээ бодитой хийгдэж байна гэж үзэх боломжгүй байгаа тул тус журам өөрчлөлт оруулах.

5.5. Тогтоол, шийдвэрт УИХ, УИХ-ын Байнгын хороо, Засгийн газар гэх мэт дээд түвшинд танилцуулахаар үүрэг ихээр өгөгддөг боловч хэрэгжилт хангагдсан эсэх нь тайлангаар ихэнхдээ нотлогдохгүй эсвэл тайлагнахгүй байна. Иймд шийдвэрт заасан процессийн хэрэгжилтийг хангах чиглэлд анхаарах эсвэл тогтоол, шийдвэрийн үр дүнд чиглэсэн заалтыг хяналтад авч, тайлагнахад анхаарах нь хэрэгтэй байна.

5.6. Засгийн газрын тогтоол, тэмдэглэл нь утга, агуулга ижил, давхцуулан гаргасан болон хуулиар тодорхой зааж зохицуулсан асуудлыг Засгийн газрын шийдвэрт давтан тусгаж, тайлагнах шийдвэрийн тоог өсгөснөөр тайлангийн нэгдсэн үнэлгээ бодитой гарахад нөлөөлж байна.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХШҮ-НИЙ ТАЙЛАН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ, 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС.

Шийдвэр Д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
МУ-ын хууль					
1	1	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012-12-20 Дугаар 2012.12.20	7.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална./7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөсхамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ:7.1.1.хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал;7.1.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал;7.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал.	1.“Хүнсний жижиглэнгийн худалдаа, хүнс тээвэрлэлтэд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал”-г хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг боловсруулж, гүйцэтгэл 80%-тай байна. 2.“Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ын төслийг боловсруулж, гүйцэтгэл 90%-тай байна. ХХААХҮЯ-ны сайтад (https://mofa.gov.mn/files/pdf-files/s6ez6vwyssr/684f7b1683d7de7c1b04bb1e.pdf) санал авахаар төслийг байршуулсан. Хавсралт : 4 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	2		9.5. Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	"Мал, амьтны гаралтай гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ын төслийг боловсруулсан. "Мал, амьтны гаралтай гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ын төслийг боловсруулах ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Цар тахлын дараах орчинд хүнсний аюулгүй байдлыг сайжруулах” төслийн дэмжлэгтэйгээр Мал, амьтны гаралтай гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох зураглал хийлгэсэн. Журмын төсөлд санал авч, батлахаар ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	3		14.1. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй,хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/602, А/393, А/689 дугаар хамтарсан тушаалаар Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэх журмыг батална. Журмын хуулбарыг хавсаргав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны цахим хуудаст хувиргасан амьд организмын бүртгэлийг нийтэлсэн. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	Хэрэгжсэн – 100%
2	4	Тариалангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-01-29 Дугаар 2016.01.29	15.8.. Энэ хуулийн 15.7-д заасан газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлалыг тариалангийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/37, А/31 хамтарсан тушаалаар “Хүрээлэн байгаа орчны хохирол тооцох аргачлал”-ыг батлсан бөгөөд уг аргачлал атаршсан газрыг хохирол тооцох, нөхөн сэргээх талаар тусгагдсан байна.Тариалангийн тухай хуульд заасан Тариалангийн газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох журмын төслийг боловсруулж байна. Түүнчлэн Тариалангийн салбарын эрсдэлийг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах Хуулийн төсөл бэлэн болсон ба Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн. Үзэл баримтлалын төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар ажиллаж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	5		23.4.. Энэ хуулийн 23.1-д заасан мэдээ гаргах, хүргүүлэх болон энэ хуулийн 23.3-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх журмыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн болон Сангийн сайдын 2022 оны А/218/А/146 дугаар хамтарсан тушаалаар “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”, мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/196 дугаар тушаалаар Ургамал, түүний	Хэрэгжсэн – 100%

				гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг тус тус баталсан бөгөөд эдгээр журмуудад тариалангийн салбарын мэдээ гаргах, хүргүүлэх, мэдээллийн сангийн журмын харилцаа бүрэн зохицуулагдаж байгаа учраас энэ журмыг гаргах шаардлагагүй гэж үзсэн. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530810636531 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530825185141 Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	
	6		20.6. Энэ хуулийн 20.2.9-д заасан хөдөө аж ахуйн инженер, агрономичид мэргэшлийн зэрэг олгох журмыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хөдөө аж ахуйн инженер, агрономичид мэргэшлийн зэрэг олгох журмын төслийг боловсруулан Хөдөө аж ахуйн их сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. 2026 онд батлуулахаар төлөвлөж байна. Хавсралт : 2 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
3	7	Мал, амьтны эрүүл мэндийн тухай 2017-12-08 Дугаар 2017.12.08	14.2. Мал, амьтны халдварт өвчнийг тандах, үр дүнг мэдээлэх болон хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /Энэ хэсэгт 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/475 тушаалаар “Мал, амьтны халдварт өвчнийг тандах, үр дүнг мэдээлэх журам” (https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760446193991) батлагдсан. Тус журмын дагуу мал, амьтны гоц халдварт өвчийг эрт илрүүлэх тандан судлах зорилгоор идэвхтэй, идэвхгүй тандалтуудын ажлыг хийж гүйцэтгэж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/249 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих журам”-ыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгүүлэхээр ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын бүртгэлийн хэлтэст хүргүүлж, 11 дүгээр сарын 24-ний өдөр ХЗДХЯ-нд уг журмын талаар мэдээлэл солилцсон. ХЗДХЯ-наас “Хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих журам”-ыг шинэчлэх шаардлагагүй, шууд эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэхээр ажиллаж байгааг мэдээлсэн ба энэ тухай ХЗДХЯ-наас ирүүлэхийг хүлээж байна. Хавсралт : 2 файл Үр нөлөө : мал, амьтны гоц халдварт өвчийг эрт илрүүлэх тандан судлах арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжсэн – 100%
4	8	Малын генетик нөөцийн тухай 2017-12-14 Дугаар 2017.12.14	5.9. Энэ хуулийн 5.1.1, 5.1.3-т заасан бүртгэлийн журам, малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх үйл ажиллагааны аргачлалыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /5.1.1.малын бүртгэл; /5.1.3.малын удам зүйн үнэлгээний бүртгэл;/	Нуулийн 5.1.1, 5.1.3-т заасан бүртгэлийн журмыг ХХААХҮ-ийн Сайдын 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/405 тушаалаар “Малын бүртгэлийн журам” (https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760156054471), 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/282 дугаар тушаалаар “Малын удам зүйн үнэлгээний бүртгэлийн журам” (https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531363281081) тус тус батлагдсан. Засгийн газрын 2023 оны 48 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн төрийн захиргааны төв байгууллагад хуулиар эрх олгосон заалтыг 2 дахин багасгах чиглэлийн дагуу Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжийн хүрээнд Малын генетик нөөцийн тухай хуульд Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад эрх олгосон заалтыг 50 хувь багасгах асуудлыг тусгасан. Малын генетик нөөцийн тухай хуульд эрх олгосон нийт 17 заалтыг хянан үзэж, холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг авч нэгтгэн ХХААХҮ-ийн Сайдын дэргэдэх Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны хурлаар хэлэлцүүлж, Хуулийн хэлтэстэй хамтран хуулийн төслийг шинэчлэн боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн тул хасах саналтай.	Хэрэгжсэн – 100%
	9		6.9. Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам, энэ хуулийн 6.2-т заасан зааврыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /6.2.Удам зүйн үнэлгээг энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, энэ хуулийн 11.2-т заасан үйлчилгээний нэгж нь технологийн арга зүй, аргачлал, зааврын дагуу хийнэ./	1. ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны А/145 тушаалаар батлагдсан үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам (https://legalinfo.mn/mn/detail?lawId=208662)-д нэмэлт өөрчлөлт оруулахаар санал авч байна. 2. Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөлд салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоо, төрийн байгууллага болон хувийн хэвшлийн саналыг албан бичгээр авч, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн дарга, мэргэжилтэн, сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, олон улсын төсөл хөтөлбөрийн төлөөлөл, хувийн мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийн мал зүйчид, мэргэжлийн холбооны төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг	Тодорхой үр дүнд хүрсэн – 50%

				зохион байгуулж саналыг авч тусган нийт 6 зүйлийн хүрээнд холбогдох заалтуудыг нэмж өөрчлөн найруулж хүчингүй болгох зохицуулалтуудыг тусгасан. Ялангуяа Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний ажил үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаа явуулах эрх зүй, мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн өөрчлөлтүүдийг оруулахаар тусгасан. Тус үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр баталсан боловч сайд солигдсонтой холбогдуулан дахин батлуулахаар М.Бадамсүрэн сайдад танилцуулах арга хэмжээ авч байна. Үр нөлөө : Малын ашиг шимийн гарц, чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх	
	10		13.4. Тоо, тархалтын хувьд доройтолд орсон, устаж мөхөж болзошгүй байдалд хүрсэн малын төрөл, зүйлийг тусгайлан хамгаалж, үржүүлэх арга хэмжээ авч, удам гарвал нь тодорхой, стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч бойжуулж зах зээлд борлуулсан малчин, мал бүхий этгээд, энэ хуулийн 11.2-т заасан үйлчилгээний нэгжид Засгийн газраас дэмжлэг, урамшуулал олгож болох бөгөөд урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.	1.Тоо толгой нь цөөрсөн, устаж болзошгүй болон тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай үүлдэр, омгийн малын судалгааг гаргаж, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах зорилгоор 2018-2019 онд Нарийн, нарийвтар ноост хонь үржүүлэгчдийн болон Сарлаг үржүүлэгчдийн улсын зөвлөгөөн, Цааны баяр, Тэмээчдийн бүсийн зөвлөгөөнийг тус тус зохион байгуулж, зөвлөмж гарган ажиллаж байна. 2. Тоо толгойн хувьд цөөрсөн нарийн, нарийвтар ноост хонины эх үүлдэр болох Цыгай, Меринос үүлдрийн хуцыг импортлон Малын удмын сангийн үндэсний төвд үр үйлдвэрлэн тус хонийг сайжруулахаар ашиглаж байна. 3. Баталгаажсан үүлдэр, омгийн малаас удам гарваль нь тодорхой, стандартын шаардлага хангасан үржлийн мал бойжуулж борлуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээдтэй хамтран цөм сүрэг бүрдүүлэх ажлыг 2020 оноос эхлүүлэн 21 аймгийн 150 суманд цөм сүрэг бүхий малчин 1245 өрхөд батламж олгоод байна. Малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайланг боловсруулан Засгийн газарт танилцуулсан боловч Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газар үндэсний хөтөлбөр батлах боломжгүй болсон. Баталгаажсан үүлдэр омгийн малын генийн санг хамгаалах цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор жил бүр тоо толгойн хувьд цөөрч буй үүлдэр омгийн малыг цөм сүргийг нэмэгдүүлэх шилмэл хээлтүүлэгчээс үр авч гүн хөлдөөн хадгалах арга хэмжээг зохион байгуулж одоогоор улсын хэмжээнд 8 үүлдэр омгийн 4657 тун үрийг Малын удмын сангийн үндэсний төвийн генийн санд хадгалж байна. Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүйгээс журам батлагдаагүй. Хяналтаас хасуулах санал : Малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайланг боловсруулан Засгийн газарт танилцуулсан боловч Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газар үндэсний хөтөлбөр батлах боломжгүй болсон тул хяналтаас хасах	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	11		15.4. Малын үндэсний генийн санд үржүүлгийн бүтээгдэхүүн байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих болон гойд ашиг шимт мал шалгаруулах журам, энэ хуулийн 15.1-д заасан үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны бүтэц, орон тоог малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Малын үндэсний генийн санд үржүүлгийн бүтээгдэхүүн байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А-382 дугаар тушаалаар баталж, Улсын нэгдсэн бүртгэлд 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр 5633 дугаарт бүртгүүлэн хүчин төгөлдөр мөрдөж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-346 дугаар тушаалын хавсралтаар “Гойд ашиг шимт мал шалгаруулах журам” (https://legalinfo.mn/mn/detail?lawId=211350)-ыг баталсан. “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн 15.1-д зааснаар Малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах чиг үүрэг бүхий Малын удмын сангийн үндэсний төвийн бүтэц, стратегийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны А-132 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Уг төв нь 34 орон тоотойгоор Дархан-Уул аймгийн Хонгор сум дахь цогцолборт үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн – 100%
5	12	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай 2019-05-30 Дугаар 2019.05.30	10.2.10.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/178, А/238, А/173 дугаар хамтарсан тушаалаар “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам” батлагдсан. Журмын 2.1.2 -т заасны дагуу сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хангамжийг сайжруулахад 5 санал өгсөн. Журмын 2.1.3-т заасны дагуу БЯ, ХХААХҮЯ, НЭМҮТ, БЕГ хамтран 1 ,4, 6 дугаар сард “Хүүхдийн өсөлтийн үеийн хооллолт, шим тэжээлийн агууламж, хүнсний хангамж” агуулгаар сургалт 2 удаа, туршлага судлах 1 удаа, зөвлөлдөх уулзалт 1, хэлэлцүүлэг 1 удаа зохион байгуулж, 21 аймгийн мэргэжилтнүүд, сургууль, цэцэрлэгийн тогооч нарын төлөөлөл 250 гаруй хүнд МУ, БНСУ, АНУ, Япон Улс, Англи улсын хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай ойлголт,	Хэрэгжсэн – 100%

				мэдлэг олгосон. Обзервстар ХХК-тай хамтран 10 дугаар сард “Илчлэг тооцох нь, онцлог бүлгийн хооллолт” сэдвээр цахимаар 57 тогооч, иргэдийн төлөөлөл, танхимаар 22 цэцэрлэгийн 12 эцэг эхийн төлөөлөлд сургалтыг зохион байгуулсан. Журмын 2.4.3-ыг хэрэгжүүлэхэд 1000 гаруй хандалттай Facebook /төлбөргүй/ групп нээн зурагт хуудас байршуулж, 21 аймгийн мэргэжилтнүүдийг мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажилласан. Хавсралт нийт : 12, Файл : 6 Зураг : 6	
6	13	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай /Шинэчилсэн найруулга/ 2019-06-06 Дугаар 2019.06.06	9.3. Энэ хуулийн 9.2-т заасан ажилтны тоо, борлуулалтын орлогын хэмжээг нэгтгэн тооцох үндэслэлийг хянаж, зохих ангилалд хамааруулахтай холбогдсон журмыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	1. Монгол Улсын Их “Өрсөлдөх чадварын микро эдийн засаг” академик сүлжээний Ази-Номхон далайн бүсийн салбартай хамтран зохион байгуулсан “Ази-Номхон далайн бүсийн кластерийн хамтын ажиллагаа ба хамтран бүтээх үнэ цэнэ” сургалтад 3 албан хаагч хамрагдаж, олон улсын эрдэм шинжилгээний хурлаар ЖДҮҮ-ний кластерын ангилал тооцох журмын төслийг хэлэлцүүлсэн. 2. Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргын тушаалаар байгуулагдсан “Кластерын ангилал тооцох журмын төсөл боловсруулах” чиг үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын ХАА кластерын аргачлал, хэрэгжүүлэх тогтолцоо зэрэг асуудлаар “Кластерын ангилал тооцох журам”-ын саналыг нэгтгэн боловсруулж, 2021 оны 08 дугаар сард хүргүүлсэн. 3. Жижиг, дунд үйлдвэрийг кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэлийн төслийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал шинэчлэхтэй холбоотойгоор батлагдсан үед нь дахин уялдуулан боловсруулж ирүүлэхээр буцаасан. 4. Монгол Улсын Их Сургуулийн “Өрсөлдөх чадварын микро эдийн засаг” академик сүлжээний Ази-Номхон далайн бүсийн салбартай хамтран зохион байгуулсан “Ази-Номхон далайн бүсийн кластерийн хамтын ажиллагаа ба хамтран бүтээх үнэ цэнэ” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлаар ЖДҮҮ-ний кластерын ангилал тооцох журмын төслийг хэлэлцүүлэн шинэчлэн боловсруулж, ХХААХҮЯ-нд 2025.10.30-ны өдөр саналыг цахимаар дахин хүргүүлж, ХХААХҮЯ цахим хуудаст байршуулан шинэчлэн найруулж боловсруулсан журмын төсөлд олон нийтээс санал авч байна. Хавсралт : 2 файл Үр нөлөө : борлуулалтын орлогын хэмжээг нэгтгэн тооцдог болох	Тодорхой үр дүнд хүрсэн – 50%
	14		11.10. Энэ хуулийн 11.8-д заасны дагуу Сангаас зээлийн хүүгийн татаас олгох журмыг жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11.10-т заасны дагуу экспортод бүтээгдэхүүнээ гаргасан “Дунд” ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээлийн хүүгийн татаас олгох хяналт тавих журмын төслийг боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдаар батлуулж, Сангийн сайдад хүргүүлсэн. Үр нөлөө : -	Ахиц гарсан – 50%
7	15	Таримал ургамлын үр, сортын тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-10-29 Дугаар 2022.01.01	8.1. Хүнсний аюулгүй байдал, байгаль орчин, хүн, малын эрүүл мэндэд нөлөөлөх байдлыг харгалзан үрийн чанарыг баталгаажуулах шаардлагатай таримал ургамлын төрөл, зүйлийн жагсаалтыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүнсний аюулгүй байдал, байгаль орчин, хүн, малын эрүүл мэндэд нөлөөлөх байдлыг харгалзан үрийн чанарыг баталгаажуулах шаардлагатай таримал ургамлын төрөл, зүйлийн жагсаалтыг боловсруулсан. 2026 онд батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	16		8.5. Үр үйлдвэрлэлийн талбайд сортын хянан баталгаа хийх, хянан батлагчийг сургах, давтан сургах, хянан батлагчийн эрх олгох, цуцлах, бүртгэл хөтлөхтэй холбогдсон журмыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Үр үйлдвэрлэлийн талбайд сортын хянан баталгаа хийх, хянан батлагчийг сургах, давтан сургах, хянан батлагчийн эрх олгох, цуцлах, бүртгэл хөтлөхтэй холбогдсон журмыг бүрэн боловсруулж дууссан бөгөөд тушаалыг батлуулахаар Сайдад танилцуулсан. Хавсралт : 3 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	17		11.5. Үрийн технологийн нөөцөд байх таримлын төрөл, нөөцийг бүрдүүлэх, удирдах үйл ажиллагааны журмыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Үрийн технологийн нөөцөд байх таримлын төрөл, нөөцийг бүрдүүлэх, удирдах үйл ажиллагааны журмыг боловсруулсан. 2026 онд батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлаг

					атай - 50%
	18		27.5. Хүнс, хөдөө аж ахуйн таримал ургамлын генетик нөөцийн санг баяжуулах, генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлон бүртгэх, хадгалж хамгаалах, судалж ашиглах болон харилцан солилцохтой холбогдсон журмыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүнс, хөдөө аж ахуйн таримал ургамлын генетик нөөцийн санг баяжуулах, генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлон бүртгэх, хадгалж хамгаалах, судалж ашиглах болон харилцан солилцохтой холбогдсон журмыг бүрэн боловсруулж дууссан бөгөөд батлуулахаар Сайдад танилцуулсан. Хавсралт : 3 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	19		28.14. Энэ хуулийн 28.13-т заасан зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.(28.13.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны бус үр, сортын зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ ажиллах бөгөөд зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ	ХХААХҮСайдын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/276 тушаалаар Үр, сортын зөвлөлийн дүрмийн батлуулсан. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	Хэрэгжсэн – 100%
8	20	Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ 2022-06-28 Дугаар 2022.06.28	13.2. Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдах монгол үүлдрийн адууны стандартыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох үндэсний спортын холбооны саналыг үндэслэн боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар төрийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн Монгол адууны стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу Монгол адууны стандартыг шинэчлэн боловсруулж, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн “Үндэсний стандартыг шинэчлэн батлах, хүчингүй болгох тухай” С/31 дүгээр тушаалаар MNS2025:4099 “Мал аж ахуй Монгол адуу ерөнхий шаардлага стандарт”-ыг батлуулсан. Үр нөлөө : Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдах монгол үүлдрийн адууны стандарттай болсон Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжсэн – 100%
9	21	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01	5.2. Уламжлалт технологиор үйлдвэрлэснээс бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгох бөгөөд дуудлага худалдаа зохион байгуулах журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.	1. Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 283 дугаар тогтоолоор согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журмыг баталсан. 2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/630 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Уламжлалт технологиор үйлдвэрлэснээс бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааны оролцогчийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг Засгийн газрын 2023 оны 283 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу зохион байгуулсан. Дэлгэрэнгүй тайланг хавсаргав. 3.2025 онд Уламжлалт технологиор үйлдвэрлэснээс бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааны оролцогчийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулаагүй. Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	Хэрэгжсэн – 100%
	22		11.6. Энэ хуулийн 11.1-д заасан тоног төхөөрөмж нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн цахим санд холбогдсон байх бөгөөд тоног төхөөрөмжид тавигдах шаардлага, нэгдсэн сүлжээнд холбох, үйл ажиллагаанд хяналт тавих журмыг хүнсний болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	1. Согтууруулах ундааны үйлдвэрийн шугамын тоолуурын төхөөрөмжид тавигдах шаардлага, нэгдсэн сүлжээнд холбох, үйл ажиллагаанд хяналт тавих журмын төслийг холбогдох журамд нийцүүлэн боловсруулж, Газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу уг журмын төслийн хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан. 2. ХХААХҮСайдын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/2771 тоот албан бичгээр Сангийн яам, СХЗГ-аас санал авахаар албан бичгийг хүргүүлсэн. Хараахан хариу ирүүлээгүй байна. 3. Журмын төсөл, Сангийн яаманд хүргүүлсэн албан бичиг, хэлэлцүүлгийн хөтөлбөр, холбогдох зургуудыг хавсаргав. Хавсралт нийт : 8, Файл : 4 Зураг : 4	Ахиц гарсан – 50%
	23		14.1. Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг эрүүл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/567 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулж, импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтын төслийг урьдчилсан байдлаар боловсруулж,	Удаашралтай / эрчимжүү

			мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.	ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлээд байна. Хавсралт : 2 файл	лэх шаардлагатай - 50%
	24		14.7. Импортлох, экспортлох соГтууруулах үндааны чанар, аюулгүй байдалд хяналт тавих, импортлох тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг Засгийн газар батална.	Захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагын дагуу журмын төслийг хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд болох Гаалийн ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газрын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, гарсан саналын дагуу төслийг боловсронгуй болгон эцэслэсэн. Үүний дараа соГтууруулах үндааны импорт, экспорт эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулж, төслийн эцсийн хувилбар дээр өргөн хүрээний санал авсан. Журмын төслийг 2025 оны 2 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн боловч Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулан Хуулийн хэлтсээс Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг түр хойшлуулах чиглэл өгсөн. Улмаар 2025 оны 6 дугаар сард Засгийн газрын хуралдаанд дахин оруулахаар төлөвлөсөн ч энэ хугацаанд Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ солигдсонтой холбоотойгоор Засгийн газрын хуралдааны дэгийн дагуу журмын төсөлд шинээр томилогдсон сайд нараас дахин санал авах шаардлага үүссэн. Үүний улмаас төсөлд санал авч нэгтгэх нь тодорхой хугацаа шаардаж, журам батлагдах явцыг сунжруулах нөхцөл болсон. Гэвч дээрх шалтгаанаар хойшлогдсон хугацаанд журмын төслийг хууль эрх зүйн шинэ зохицуулалт, бодит хэрэгжилттэй нийцүүлэн олон талаас нь нягталж, заалтуудыг дахин дахин сайжруулан боловсруулсан нь журам илүү чамбай, хэрэгжих боломжтой, маргаан дагуулахгүй түвшинд хүрэх нөхцөлийг бүрдүүлсэн. Засгийн газрын шинээр томилогдсон 2 сайдаас санал авч (Шадар сайд Х.Ганхуяг, ХЗДХСайд Б.Энхбаяр) төслийг эцэслэн. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахаар төлөвлөж байна. Хавсралт : 2 файл	Ахиц гарсан – 50%
	25		38.7. Энэ хуулийн 38.1-д заасан цахим санг бүрдүүлэх, ашиглах, баяжуулах журмыг хүнсний, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн 2023 оны “Журам батлах тухай” А/280, А/166, А/432 дугаар тушаалаар “СоГтууруулах үндаа үйлдвэрлэх, импортлох, худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн цахим санг бүрдүүлэх, ашиглах, баяжуулах журам”-ыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760332482401 Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	Хэрэгжсэн – 100%
	26		24.4. СоГтууруулах үндаагаар үйлчлэх үйлчилгээний стандартыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж, Засгийн газар батална.	Зөвшөөрлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл холбоотойгоор СоГтууруулах үндааны эргэлтэд хяналт тавих, архидан соГтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд уг заалтыг хасах санал өгсөн. Учир нь ХЗДХЯ-наас хариуцлагатай үйлчилгээний журмыг батлан мөрдүүлж байгаа түүнчлэн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний холбогдох стандартууд батлагдсан тул эдгээр стандартыг мөрдүүлэх нь зүйтэй байна. Хяналтаас хасуулах санал : Зөвшөөрлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл холбоотойгоор СоГтууруулах үндааны эргэлтэд хяналт тавих, архидан соГтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд уг заалтыг хасах санал өгсөн	Хэрэгжсэн - 100%
	27		16.6. Энэ хуулийн 16.1, 16.2-т заасан тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалаар СоГтууруулах үндаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760242271811 Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	Хэрэгжсэн - 100%
10	28	Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган	5.1. Төрөөс олгох урамшууллаас иргэний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.	Төрөөс олгох урамшууллаас иргэний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан Засгийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн "Журам батлах тухай" 361 дугаар тогтоолыг батлуулсан.	Хэрэгжсэн - 100%

		төлөх тухай 2023-04-21 Дугаар 2023.04.21		Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	
11	29	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-12-07 Дугаар 2023.12.07	52.12.. Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний загварыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална.	Газрын тухай хуулийн 52.12 дахь заалтаар эрх олгогдсоны “Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний загварыг боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-н сайдын 2025 оны А/107 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг нийт 6 удаа хуралдан журмын болон, гэрээний загварыг боловсруулан дараах байдлаар хэлэлцүүлэв. Үүнд: 1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нараас санал авахаар 2025 оны 07 дугаар 22-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн бөгөөд 11 аймаг санал ирүүлснээс 3 аймаг дэмжсэн, 8 аймаг санал тусгуулахаар ирүүлснийг тусгаж ажилласан. 2. Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт ХХААХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 02/1556 тоот албан бичиг хүргүүлж санал авсан. 1. Төслийг Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн ерөнхий газрын газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлж, гарсан саналыг тусгасан. 2. АДАПТ болон АСДИП төсөлтэй хамтран журмын төслийн цахим хэлэлцүүлгийг 08 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар, ХҮнс, хөдөө аж ахуйн газар, Барилга, хот байгуулалтын газар, зарим сумдын Засаг даргын тамгын газрын холбогдох мэргэжилтнүүдийн төлөөлөл 150 гаруй хүн оролцож, дэшүүлсэн саналуудаас 10 саналыг тусгаж ажиллав. 3. Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран 09 дүгээр сарын 02-ны өдөр цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт ХХААГ, бүх сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд 50 гаруй хүн оролцож, асуулт тавьсан. Санал гараагүй. 4. Аймаг, нийслэлийн ХХААГ, БХБГ, ЦУГ, бусад холбогдох албан хаагчдыг оролцуулан 11 дүгээр сарын 07-ны өдөр 4 дэх цахим хэлэлцүүлэг зохион байгуулав. 5. Олон нийтээс санал авахаар яамны вэб сайтад 08 дугаар сарын 15-ны өдөр байршуулсан.Ийнхүү малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний загварыг боловсруулж, хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болгож ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн. Хавсралт : 4 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
12	30	Гэрийн тэжээвэр амьтны тухай 2023-12-08 Дугаар 2023.12.08	30.1.3.. 30 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 30.1.3.гэрийн тэжээвэр амьтны үзэсгэлэн худалдаа, уралдаан, тэмцээн зохион байгуулах журам батлах;	"Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, “Гэрийн тэжээвэр амьтны үзэсгэлэн, худалдаа, уралдаан, тэмцээн зохион байгуулах журам”-ын төслийг боловсруулсан. Журмын төслийг МЭЕГ-ын албан ёсны цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтээс нээлттэй санал авч, ирүүлсэн саналуудыг нэгтгэн тусган сайжруулсан бөгөөд журмын төслийн нөлөөллийн үнэлгээг хийж, Мал эмнэлгийн ерөнхий газраас 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 01/1191 тоот албан бичгээр журмын төсөл болон нөлөөллийн үнэлгээний тайланг хавсарган ХХААХҮЯ-нд ирүүлсэн. Тус журам батлагдах шатанд байна. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
13	31	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын	26.5.. Энэ хуулийн 26.4-т заасан эрсдэлийн үнэлгээ хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ТНБД-ын 2025 оны А/106 тушаалаар "Эрсдэлийн үнэлгээний журам" боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэхтэй холбоотой зохицуулалтыг Ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний олон улсын стандарт /ISPMs/-д нийцүүлэн журмын төслийг боловсруулж, санал авахаар ХХААХҮЯ-ны сайтад байршуулсан. Сайдаар батлуулахад бэлэн болсон. Хавсралт : 2 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	32	тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	5.5.. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн түвшинг харгалзан импортын мэдэгдэл олгох амьтан,	Жагсаалтыг шинэчлэн батлуулан, нийтэд ил тод байршуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431290249552	Хэрэгжсэн - 100%

		тухай 2023-12-08 Дугаар 2023.12.08.	ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хавсралт : 2 зураг Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	
14	33	Органик бүтээгдэхүүний тухай 2024-01-17 Дугаар 2024.01.17.	7.4.. Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/09 дүгээр тушаалаар “Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалт"-ыг батлуулан мөрдөж ажиллаж байна. Органик бүтээгдэхүүний тухай хууль шинэчлэн баилагдаж 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг үндэслэн “Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалт"-ыг шинэчлэн батлуулахаар 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Хавсралт : 2 файл Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	34		9.4.. Энэ хуулийн 9.1.2-т заасан хамтын баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт үндэслэн “Хамтын баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх журам”-ыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны А/590 тоот тушаалаар батлууллаа. Уг журмыг ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр холбогдох материалыг боловсруулж ТЗУГ-т хүргүүлэв. ТЗУГ-аас 2025 оны 11 дүгээр сарын 27-ны 02/3603 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	35		12.2.. Мэдээллийн санд баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг бүртгүүлэх тухай журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална	Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг тус тус үндэслэн "Баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, үйлчилгээг мэдээллийн санд бүртгэх журам", Шилжилтийн үеийн болон органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэгийн загвар"-ыг "Шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнд олгох баталгаажуулалтын гэрчилгээний загвар"-ыг тус тус боловсруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний А/545 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	Хэрэгжсэн - 100%
	36		15.3.. Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг үндэслэн “Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журам”-ыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны А/591 тоот тушаалаар батлууллаа. Уг журмыг ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр холбогдох материалыг боловсруулж ТЗУГ-т хүргүүлэв. ТЗУГ-аас 2025 оны 11 дүгээр сарын 27-ны 02/3603 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн.	Хэрэгжсэн - 100%
	37		15.3.. Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшуулалтай холбогдох журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт үндэслэн “Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшуулалтай холбогдох журам”-ыг боловсруулсан бөгөөд хэлэцүүлэг, санал авах ажлыг дараах байдлаар харуулаа. Цахим хэлэлцүүлгийг дараах байдлаар зохион байгуулсан. Үүнд: 1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны https://www.mofa.gov.mn/law/tosol цахимд “Хамтын баталгаажуулалтын	Ахиц гарсан - 50%

				байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх журам”-ын төслийн хэлэлцүүлгийг 2025 оны 08 дугаар сарын 05-наас 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл байршуулсан. 2. Цахим хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэжлийн холбоо, 21 аймгийн органик хариуцсан мэргэжилтнүүд, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүд, УИХ-ын гишүүний зөвлөх, АХБ-ны төлөөлөл, судлаачид, хамтын баталгаажуулалтын байгууллагын болон хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагын удирдлагууд, төлөөллүүдийн дунд танхим болон цахим хэлбэрээр олон нийтийн оролцоог ханган зохион байгууллаа. 3. Мөн Захиргааны ерөнхий хуулийн 61.2.3охицуулах харилцаа нь бусад захиргааны байгууллагын чиг үүрэгт давхар хамаарч байгаа бол тухайн захиргааны байгууллагаас албан ёсоор санал авна гэсний дагуу Сангийн яамнаас санал авахаар 2025 оны 09 дүгээр сарын 29-ний 01/2863 тоот албан бичгийг хүргүүлсэн. Уг бичгийн хариуг СА-наас 2025 оны 10 дугаар сарын 30-ны 01/9793 тоот албан бичгээр хариуг ирүүллээ. Дээрх Хэлэлцүүлэг, албан тоотоор ирсэн саналуудыг журмын төсөлд тусган эцэслэн боловсрууллаа. Хавсралт : 1 файл	
15	38	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай 2024-06-05 Дугаар 2024.06.05	15.2.. Хорио цээртэй хөнөөлт организмгүй, хөнөөлт организмын тархалт багатай болон аюулд өртсөн газар нутагт тавих шаардлага, газар нутгийг тогтоох, цуцлах журмыг Олон улсын ургамал хамгааллын конвенцын холбогдох стандартад нийцүүлэн хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Хорио цээртэй хөнөөлт организмгүй, хөнөөлт организмын тархалт багатай болон аюулд өртсөн газар нутагт тавих шаардлага, газар нутгийг тогтоох, цуцлах журам”-ын төслийг боловсруулан 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 04 хүртэлх хугацаанд ХХААХҮЯ-ны цахим хуудсанд байршуулсан санал авсан. Мөн Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Хурлын танхимд 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт нийт 18 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон.Аж ахуйн нэгж, иргэдийн ирүүлсэн саналуудыг журамд тусган, нөлөөллийн шинжилгээ хийж байна.	Ахиц гарсан - 50%
	39		18.8.. Биологийн гаралтай бэлдмэл, ашигт организмыг турших, бүртгэх, ашиглах, импортлох, худалдаалахтай холбогдсон журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална	Монгол улсын нутаг дэвсгэрт тархсан хөнөөлт хортон шавж, хачиг, ургамлын өвчин, дугариг хорхой, мэрэгч амьтдын тархалт хор хөнөөлийг бууруулах, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд Ургамлын эрүүл мэнд ургамал хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8-д заасан биологийн гаралтай бэлдмэл, ашигт организмыг турших, бүртгэх, ашиглах, импортлох, худалдаалахтай холбогдсон харилцааг зохицуулах журмыг НҮБ-ын ХХААБ-ын "Шинээр байгуулагдсан Ургамал хамгааллын агентлагийн чадавхыг бэхжүүлэх" TCPMON-4003 техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд боловсруулан ХХААХҮЯ-ны цахим хуудсанд 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай байрлуулан олон нийтээс санал авсан. Ирсэн саналуудыг журмын төсөлд тусган нөлөөллийн шинжилгээг хийж, Сайдаар батлуулахаар хүргүүлсэн.. Хавсралт нийт : 3, Файл : 2 Зураг : 1	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	40		19.1.4.. 19.1.Засгийн газар ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах;	Засгийн газрын 2008 оны 190 дүгээр тогтоолын хавсралт "Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журам" батлагдсан. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл. 5.1.4. дэх заалт, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн 19 дүгээр зүйл. 19.1.4 дэх заалтаар дээрх тогтоолыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Дээрх тогтоолд, төмөр зам, олон улсын нисэх буудал, хилийн боомт, хилээр дамжин өнгөрүүлэх цэгт хорио цээр тогтоох тухай холбогдох заалтууд тусгагдаагүй бөгөөд Ургамал хамгааллын олон улсын конвенцын хүрээнд Ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатай тул НҮБ-ын ХХААБ-ын "Шинээр байгуулагдсан Ургамал хамгааллын агентлагийн чадавхыг бэхжүүлэх" TCPMON-4003 техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд шинэчлэхээр ажлын хэсэг ажиллаж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				Хавсралт : 1 файл	
	41		21.3.. Ургамал хамгааллын мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, эрх олгох, бүртгэхтэй холбогдсон журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Ургамал хамгааллын мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, эрх олгох, бүртгэхтэй холбогдсон журам"-ын төслийг боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 11 дүгээр сарын 28 хүртэлх хугацаанд ХХААХҮЯ-ны цахим хуудсанд байршуулсан санал авсан. Журмын төсөлтэй холбогдуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэдийн ирүүлсэн саналуудыг журамд тусган, нөлөөллийн шинжилгээ хийж байна. 2026 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна. Хавсралт : 3 файл	Ахиц гарсан - 50%
	42		26.3.. Мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална	НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газартай байгуулсан “Шинээр байгуулагдсан Ургамал хамгааллын газрыг чадавхижуулах” Техник хамтын ажиллагааны TCP/MON/4003 төслийг 2025 оны 04 дүгээр сараас 2027 оны 03 дугаар сарыг хүртэл 2 жилийн хугацаанд үргэлжлэх төслийн ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн хүрээнд Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийг дагаж гарах 5 журам, 1 төлөвлөгөөний ажлын даалгаврыг хүргүүлж, НҮБ-ын ХХААБ-ын Гүйцэтгэгч байгууллага болох Ургамал хамгаалал, эрүүл ахуй НҮТББ-аас 5 журам, 1 төлөвлөгөөний төслийг ХХААХҮЯ-ны цахим хуудсанд 30 хоногийн хугацаанд нээлттэй хэлэлцүүлэг, 3 удаагийн оролцогч талуудыг хамруулсан танхимын хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулан саналыг тусгуулан хүлээн авсан бөгөөд захиргааны хэм хэмжээний актын нөлөөллийн шинжилгээг хийж боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн, 2026 онд батлуулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Хавсралт : 4 файл	Ахиц гарсан - 50%
	43		27.5.. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг хүнс, хөдөө аж ахуйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	“Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журам"-ын төслийг боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 11 дүгээр сарын 28 хүртэлх хугацаанд ХХААХҮЯ-ны цахим хуудсанд байршуулсан санал авсан. Журмын төсөлтэй холбогдуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэдийн ирүүлсэн саналуудыг журамд тусган, нөлөөллийн шинжилгээ хийж байна. 2026 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна. Хавсралт : 2 файл	Ахиц гарсан - 50%
16	44	Малчны тухай 2024-06-05 Дугаар 2024.06.05	4.3.. Энэ хуулийн 4.2.4, 4.2.5, 4.2.6, 4.2.7, 4.2.8, 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.	1. 4.2.5.малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах журам нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан. 2. 4.2.4, 4.2.6, 4.2.8, 4.2.9-д заасан журмын төслүүд боловсруулагдсан. 4.2.8-д заасан журам нь Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоол, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоол, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын А/36 дугаар тушаалаар хэрэгжиж буй арга хэмжээтэй давхардсан шинжтэй. 4.2.9-т заасан журмын боловсруулсан төсөлд Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яам, Хууль зүйн яамнаас дэмжихгүй санал өгсөн. 2026 оны төсөвт суулгах боломжгүй гэсэн саналыг өгсөн. 4.2.4-т заасан журмын төсөл, танилцуулга, эдийн засгийн тооцоо, судалгааг гаргаж 21 аймаг, нийслэлийн ХХААГ-ын удирдлага, албан хаагчдаас санал авч, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/2417 тоот албан бичгээр хүргүүлсэн ба тус яамны 2025 оны 09 дүгээр сары 19-ний өдрийн 01/3525 тоот албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 45 дугаар захирамжаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орлогод нийцсөн орон сууцны санхүүжилтийн тусгайлсан чиг үүрэгтэй банк байгуулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа. Тус банк	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				байгуулагдсанаар одоо мөрдөгдөж буй орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам шинэчлэн боловсруулагдах ба тухайн үед яамдын санал авахад малчдыг орон нутгийн ипотекийн зээлийн хөтөлбөрт хамруулах, зээлийн хөнгөлөлт үзүүлэх талаар санал тусгаж ажиллахыг зөвлөсөн байна. нэмэлт тайлбарыг хавсаргав. Хавсралт : 1 файл Үр нөлөө : МАА-н салбарын боловсон хүчний хангамжийг сайжруулах	
	45		7.11.. Малчны хөгжлийн индексийг тооцох аргачлалыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Үндэсний статистикийн хороотой хамтран батлуулж, хяналт тавина.	Малчны хөгжлийн индекс тооцох аргачлалын төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэхээр “Монголын байгаль хамгаалах анагаах ухааны нийгэмлэг” ТББ-тай ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2025 оны 04-р сарын 07-ны 250417/04-277 дугаартай гэрээг байгуулсан. Аргачлалын хамрах хүрээ, бүтцийн эхний төслийг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр судалгаа, тайлангийн хамт МААБХЗГ-т ирүүлж, танилцуулсан. Гэрээний дагуу 2025 оны 06 дугаар сарын 07-нд төслийг эцсийн байдлаар хүлээн авч гэрээг дүгнэсэн. Үндэсний статистикийн хорооны Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтэс холбогдох мэргэжилтэн нартай уулзалт хийж "Малчны хөгжлийн индекс тооцох аргачлал"-ын төсөлд санал авч ажилласан. Төслийг ҮСХ-ний арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хавсралт : 3 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	46		9.10.. Улсын аварга, хошой аварга малчин, саальчин, фермер шалгаруулах болон энэ хуулийн 9.4-т заасан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.	1.Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Журам шинэчлэн батлах, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин, шалгаруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулан, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэв. 2."Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам " 2020 оны 3Г-ын 130 дугаар тогтоолоор батлагдсан. 3."Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам" 2013 оны 394 дүгээр тогтоол батлагдсан. 4."Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам "2019 оны 343 дугаар тогтоол тус тус хүчин төгөлдөр хэрэгжиж байна. 5. Улсын Их Хурлын 2011 оны "Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" 30 дугаар тогтоолд өөрчлөлт оруулан самнасан сарлагийн хөөврийн кг тутамд 10000 төгрөгийн урамшуулал олгодог болсон. 2024 онд үндэсний үйлдвэрт 42,620.8 кг сарлагийн хөөвөр бэлтгэн тушаасан 1,443 малчин, мал бүхий иргэдийн урамшуулалд хамрагдсан. Хавсралт : 3 файл Хяналтаас хасуулах санал : Журам батлагдсан хэрэгжиж байгаа тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	47		13.6.. Малчны хөгжлийн сангийн удирдлага, зохион байгуулалтын жишиг дүрэм, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Малчны тухай хуулийн 13.1-д мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжихэд зориулан сум бүрд Малчны хөгжлийн сан байгуулахаар заасан ба тус хуулийн 13.6-д тус сангийн удирдлага, зохион байгуулалтын жишиг дүрэм, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар эрх олгосон. Уг журмын төсөлд хөдөө аж ахуй, малчдын хөгжлийн дэмжих чиглэлээр тусгах саналыг боловсруулсан. Журмыг ахлан боловсруулах төрийн захиргааны төв байгууллагатай хамтран журмын төслийг боловсруулж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%

17	48	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай 2024-06-05 Дугаар 2024.06.05	10.9.. Биобэлдмэлийн улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх, хэвийн хорогдол тооцох, биоаюултай хог хаягдлыг эгүүлэн татах, устгах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.	Мал, амьтны эм тэжээлийн нэмэлтийн тухай хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлж боловсруулан, батлуулах, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг МЭЕГ-ын даргын А/321 дугаар тушаалаар байгуулагдсан. Мал, амьтны эм тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дахь хэсэгт “Биобэлдмэлийн улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх, хэвийн хорогдол тооцох, биоаюултай хог хаягдлыг эгүүлэн татах, устгах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулан МЭЕГ-ын "Фейсбүүк" цахим хуудсанд байрлуулан олон нийтээс санал авч "Захиргааны ерөнхий хуулийн 62.1.Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна" гэсэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Санал авах хугацаа 2025 оны 11 дүгээр сарын 7-нд дуусгавар болсон. МЭЕГ-ын даргын А/321 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ажиллаж байна.	Ахиц гарсан - 50%
	49		16.5.. Мал эмнэлгийн байгууллагад хэрэглэсэн мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн орлого, зарлага, устгалын бүртгэл хөтлөх, зарцуулалтыг тайлагнах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг экспортлох эрх олгогдоогүй бөгөөд тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг МАЭТНтХ-тай уялдуулах саналаа 2025 оны 09 сарын 30-ний өдрийн 01/991 тоот албан бичгээр ХЗДХ-ийн сайдад хүргүүлсэн. Одоогоор мал эмнэлгийн байгууллагууд мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг хүн эмнэлгээс авч хэрэглэн, ЦЕГ-ын хар тамхитай тэмцэх тасагт жилд нэг удаа хэрэглэсэн эмийн орлого, зарлага, устгалын бүртгэл, зарцуулалтыг тайлагнан ажиллаж байна. Хавсралт : 4 файл	Зохион байгуулалтаас - 0%
	50		20.4.. Эмийг жороор олгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/356 дугаар тушаалаар "Мал, амьтны эмийг жороор олгох эмийн журам"-ыг батлан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хавсралт : 1 файл	Ахиц гарсан - 50%
УИХ-ын тогтоол					
18	51	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /Малын генетик нөөцийн тухай хууль/ 2017-12-14 Дугаар 2017 №82	1.1. Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэх бэлтгэл ажлыг хангаж, үнэлгээг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний дотор явуулж, дүнг тухайн онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;	Малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэх ажлыг 21 аймаг, нийслэл, 331 сум, мал бүхий 6 дүүргийн хэмжээнд нийт 66,4 сая толгой малд 2019 онд улсын төсвийн 290.0 сая, төсөл хөтөлбөрийн 412.5 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж, 2019 оны 12 дугаар сард зохион байгуулж, Мал зүйчдийн улсын зөвлөгөөнд урьдчилсан тайланг хэлэлцүүлэв. Мал сүргийн үүлдэрлэг байдал, популяцийн тархац, эрсдэлийн түвшинг тогтоосон ба төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан Монгол Улсад өсгөн үржүүлж байгаа малын генетикийн олон янз байдал, популяцийн үүлдэрлэг байдал, тоо, газар зүйн тархалтын хувьсал, өөрчлөлт, малын генетик нөөц ашиглалт, түүний эдийн засгийн үр өгөөж, цаашдын хандлагыг бүс нутаг, аймаг, сум, дүүрэг тус бүрээр сүүлийн 10 жилээр гаргасан. Тайланг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, 19 дүгээр тэмдэглэлийн дагуу УИХ, НҮБ-ын ХХААБ-д хүргүүлсэн. Хавсралт : 1 файл Үр нөлөө : Монгол Улсын мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц боломж, генетик судалгаа, үржил селекцийн стратеги, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хариу арга хэмжээ авах, төлөвлөх үндэслэлийг нарийвчлан тогтоох, олон улсын тайланд үндэсний тайланг нэгтгэх, баталгаажуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, харилцан мэдээлэл солилцох, баяжилт, нөхөн бүрдүүлэлтийг давтамжтай хийх боломжийг бүрдүүлж буйгаар онцлогтой юм. Хяналтаас хасуулах санал : 1. Нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжилт хангагдсан тул	Хэрэгжсэн - 100%

				хяналтаас хасах - үнэлгээг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний дотор явуулж, 2. Дараагийн шийдвэр гарсан - 2025 №73. Засгийн газарт чиглэл өгөх тухай / 2025-07-04 / УИХ-ын тогтоол	
19	52	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-05-03 Дугаар 2018 №30	1.2. Хүнсийг албан журмаар баяжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, баяжуулагч бэлдмэлийн импортыг дэмжих, үйлдвэрлэл эрхлэгч нарт дэмжлэг үзүүлэх боломжит арга замыг судалж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний дотор танилцуулах.	Хүнс баяжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж , баяжуулагч бэлдмэлийн талаарх зардлын тооцоог НҮБ-ын хүүхдийн сангийн мэргэжилтэнтэй хамтран хийсэн. Хүнс баяжуулах зардлын гарган тооцоог Улсын төсөвт суулгах болон ОУ-ын байгууллага хандаж дэмжлэг үзүүлэх боломжийг судалж танилцуулан 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 336 дугаар тогтоолоор «Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалт» баталж, түүний дагуу буудайн гурил болон давсыг баяжуулахыг тогтоосон.Энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор нийт 6 стандарт болон дагалдах 2 журмыг баталж гаргасан. 2. Гурилын баяжуулалтыг эхлүүлсэн хэдий ч гурил болон гурилан бүтээгдэхүүнд амин дэмийн агууламжийг шинжлэх лабораторийн чадамж хангалтгүй байна. Тодруулбал, Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори нь цайр болон Д-аминдэмийн агууламжийг шинжлэх техникийн боломжтой боловч B1, B2, B3, B9, D3 амин дэмийг тодорхойлох шинжилгээ хийх чадамжгүй байна. 2025 онд Монгол Улсад нийт 8.3 мянган тонн давс үйлдвэрлэсэн бөгөөд үүнээс 5.7 мянган тонн (68.7 хувь) нь иоджуулсан давс байна. Импортын давс, гурилд ч мөн «Баяжуулсан хүнсний тухай» хууль болон холбогдох стандартыг хангах шаардлага тавьж ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дуусан.	Хэрэгжсэн - 100%
20	53	Ерөнхийлөгчийн хоригийн тухай 2018-11-23 Дугаар 2018 №87	2. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах экспортод чиглэсэн үйлдвэрүүдийг барьж байгуулахад шаардагдах 500.0 тэрбум төгрөг хүртэлх нэн хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 34.1.4-т заасныг үндэслэн төсөвт тодотгол хийх замаар шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.	“Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 101 дүгээр тогтоолыг баталсан. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд МУХБ-ны эх үүсвэрээр 1 жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй 300 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. 2020 онд ноолуур бэлтгэлийн зориулалтаар Хөгжлийн банкнаас 44 аж ахуйн нэгж 103,9 тэрбум төгрөгний зээл олгосон. Зээлийн хүүгийн татаасад ХХААХҮЯ-наас 5 тэрбум төгрөг шилжүүлсэн болно. Хэрэгжсэн тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Тухайн үед хэрэгжсэн тул хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
21	54	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62	1.3/г/. цэвэр усны түгээлт, хэрэглээнд хэмнэлтийн горимыг баримтлах, үйлдвэрлэлийн хэрэгцээнд саарал ус ашиглах дэвшилтэт технологийг нэвтрүүлэх асуудлыг зохицуулсан бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Цэвэр усны түгээлт, хэрэглээнд хэмнэлтийн горим нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн хэрэгцээнд саарал ус ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолыг боловсруулан батлуулсан. Уг тогтоолоор “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэршүүлсэн технологийн бохир усыг үйлдвэрт дахин ашиглах стандарт”-ыг боловсруулж батлуулах үүргийг Стандарт, хэмжилзүйн газарт даалгасан. Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-г баталж, уг төлөвлөгөөний VI.9-д MNS 6734:2018 “Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг судалж, шинэчлэн батлуулах ажлыг БОУАӨЯ-д даалгасан. БОУАӨЯ нь Үйлдвэрийн хаягдал усыг дахин боловсруулж дулааны цахилгаан станцуудад нийлүүлэхтэй холбоотойгоор MNS 6734:2018 стандартад оруулах өөрчлөлтийн асуудлаар 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогч талуудын саналыг тусган ажилласан. Мөн төлөвлөгөөний VI.18-д тусгагдсан “Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өртөг, зардал, бохирдол багатай хамгийн сайн үйлдвэрлэлийн технологийн хувилбаруудын цогц судалгаа хийж, зөвлөмж боловсруулах” ажлыг хэрэгжүүлж, уг зөвлөмжийг “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага”-д тусган боловсруулсан бөгөөд гарын авлагыг хавсаргав. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
22	55	Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн	Гурав.6/. 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд элсэн чихэр, ургамлын тос, бүх төрлийн хүнсний будаа, 15.0 /арван таван/ мянган тонн элит үрийн улаан буудай, 160.0 /нэг зуун жаран/ мянган тонн хүнсний улаан буудайг импортлоход гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.	УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн чуулганаар "Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай" хуулийг батлаж, 2020 оны хаврын тариалалтад шаардагдах 15.0 /арван таван/ мянган тонн улаан буудайн элит үр, дотоодын гурил үйлдвэрлэлд шаардагдах 160.0 /нэг зуун жаран/ мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, элсэн чихэр, ургамлын тосыг 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд импортлоход гаалийн албан татвараас чөлөөлсөн.	Хэрэгжсэн - 100%

		засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай 2020-04-09 Дугаар 2020 №21		Хяналтаас хасуулах санал : Хэрэгжиж дууссан. Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. Хяналтаас хасах саналтай.	
	56		Дөрөв.4/. дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлж төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах, боловсролын алсын зайн сургалтын үйлчилгээг үзүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах хяналт бүхий цахим худалдааг дэмжих, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодод үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардлагатай үнэ, тарифын хөнгөлөлтийг үзүүлэх, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Цар тахлын үеэр бусад орнуудад хэрэгжүүлж буй туршлагыг судлах зорилгоор "Ковид-19 коронавируст халдварт цар тахлын үеэр дэлхийн улс орнуудын авч хэрэгжүүлсэн бодлого төлөвлөлт"-ийн талаар судалгааг тухайн үед удирдлагад танилцуулж хэрэгжилтийг ханган ажилласан, Хэрэгжсэн тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн тул хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
23	57	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай 2020-04-29 Дугаар 2020 №32	2.4/. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх;	2020-2025 оны хооронд Зээлийн батлан даалтын сангаас "Бизнесийн зээл"-д 163 тэрбум төгрөгийн батлан даалтыг 516 аж ахуйн нэгжид, 2023-2025 оны хооронд "Ипотекийн зээл"-д 179 тэрбум төгрөгийн батлан даалтыг 1627 ЖДҮҮЭ-д, 2024-2025 онд "Хоршооны зээл"-д 447 тэрбум төгрөгийн батлан даалтыг 13521 хоршоонд тус тус гаргасан байна. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон.	Хэрэгжсэн - 100%
	58		3.1/. ноолуурын түүхий эдийн нөөц бүрдүүлэх, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдуулан ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг яаралтай зохион байгуулах; (3.Малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:)	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 101 дүгээр тогтоолын дагуу Олон улсад шинэ коронавирус (Covid 19)-ийн халдвар дэгдсэний улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хилийн хязгаарлалт тавьсантай холбогдуулан ноолуурын салбарыг дэмжих зорилгоор тодорхой хэмжээний эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгаж, мөн энэ тогтоолоор түүхий эдийн нөөц бүрдүүлэх, үнийг тогтвортой байлгах арга хэмжээг тухай бүр нь авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгасан. Уг ажлын хүрээнд ХХААХҮЯ, Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд 2020 оны 04 сарын 03-ны өдөр “Ноолуур бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийн зардлыг санхүүжүүлэх гэрээ” байгуулсан. 2020 онд ноолуур бэлтгэлийн зориулалтаар Хөгжлийн банкнаас 44 аж ахуйн нэгж 103,9 тэрбум төгрөгний зээл авсан ба 2020 оны хүүгийн хөнгөлөлтэнд ХХААХҮЯ-аас 5 тэрбум төгрөг шилжүүлсэн болно. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн. Хяналтаас хасуулах саналтай.	Хэрэгжсэн - 100%
	59		3.2/. ноолуурын экспортыг дэмжих чиглэлээр ноолуурыг хилийн бүх боомтуудаар саадгүй нэвтрүүлэх, холбогдох хураамжуудын хэмжээг “0” болгох асуудлыг шийдвэрлэх; (3.Малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:)	Коронавирус /Covid-19/-ийн халдвар тархсантай холбогдуулан 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-аас ноолуурын салбарт малчдын орлогыг бууруулахгүй байх, үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын арилжаатай холбоотой бүх татвар шимтгэлийг тэглэх шийдвэр гарсны дагуу УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолыг үндэслэн Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 5 дугаар тогтоол гарч 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл ноолуурын арилжааны шимтгэлийг тэглэсэн. Мөн нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг дэмжих зорилгоор Хөдөө Аж Ахуйн Биржийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 6-р сарын 29-ний 05 дугаар тогтоолоор самнасан ноолуурын арилжааны шимтгэлийн хэмжээг 0.2 хувь болгон бууруулсан. Арилжааны шимтгэлийн хэмжээг бууруулснаар 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл нийт 1821 тонн самнасан ноолуур арилжигдсан байна. Нэхмэлийн салбарын нийт экспортын хэмжээ 2021 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр дүнгээр 368.4 сая.ам долларт хүрч, 2020 онтой харьцуулахад 34 хувиар өссөн. Хяналтаас хасуулах санал : Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед хийгдсэн ажил тул цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. Хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
	60		3.3/. малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 /хорин мянган/ төгрөгийн урамшууллыг Малын генетик	УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолын дагуу 203,641 малчин, мал бүхий этгээдэд ноолуурын мөнгөн урамшуулал 174.0 тэрбум төгрөгийг олгосон.	Хэрэгжсэн - 100%

			нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд бүрд олгох; (3.Малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:)	Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. Хяналтаас хасах саналтай.	
	61		3.4/. ноолуурын зах зээлд өрсөлдөөнийг бий болгож, бодит үнэ тогтоох зорилгоор гадаад улсын худалдан авагч нарыг ноолуур бэлтгэх үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг шуурхай зохион байгуулах. (3.Малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:)	Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооноос 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 1450 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсаас ноолуур өндөр үнээр худалдан авах хүсэлт гаргасан БНХАУ-ын 8 иргэнийг хилээр нэвтрүүлэх асуудлыг холбогдох дүрэм журамд нийцүүлэн яаралтай шийдвэрлэх талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргад 01/2062 тоот албан бичгээр уламжилсан болно. Монгол Улсад ноолуурын салбарт хөрөнгө оруулсан БНХАУ-ын 2 иргэнийг хилээр нэвтрүүлэх асуудлыг холбогдох дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлэх талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргад 01/2407 тоот албан бичгээр уламжилсан болно. Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон.	Хэрэгжсэн - 100%
24	62	“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2020-05-01 Дугаар 2020 №35	4.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/энэ тогтоолын 3 дахь заалтад заасан барааны үндэсний кодыг 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах;	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.13, 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг тус тус үндэслэн Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх түүхий эд бүтээгдэхүүний жагсаалтыг батлуулсан. Үүнийг хэрэгжүүлэх зорилгоор улаанбуудай, тослог ургамал, ургамлын түүхий тос, ургамлын тос, бүх төрлийн хүнсний будаа импортлогч аж ахуйн нэгжүүдтэй гурил, хивэг, ургамлын тосны хангамж, нийлүүлэлт, үнийг тогтвортой байлгах зорилгоор импортлогч аж ахуйн нэгжүүдтэй бодлогын гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд 12 аж ахуйн нэгж 200000 гаруй тонн хүнсний улаанбуудайг импортлон, 7356295.7 мянган төгрөгийн гаалийн албан татвараас, 15448220.9 мянган төгрөгийн НӨАТ-аас чөлөөлөгдсөн. Цагаан будааг 41 аж ахуйн нэгж 20205,5 тн импортолж, 1641767.3 мянган төгрөгийн Гаалийн албан татвар, 3447711.4 мянган төгрөгийн НӨАТ-ын хөнгөлөлт эдэлсэн. Гурвалжин будаа импортлогч 12 ААН нийт 1061 тн импортолж, 116038.9 мянган төгрөгийн гаалийн албан татвар, 243763.6 мянган төгрөгийн НӨАТ-ын хөнгөлөлт эдэлсэн. Хөц будааг нийт 12 ААН 416.6 тн-ийг импортолж, 242415.3 мянган төгрөгийн Гаалийн албан татвар, 37021 мянган төгрөгийн НӨАТ-аас чөлөөлөгдсөн байна. Шар будааг 14 ААН 1762,2 тн-ийг импортолж, 85201.9 мянган төгрөгийн Гаалийн албан татвар, 178924.1 мянган төгрөгийн НӨАТ-аас чөлөөлөгдсөн. Ургамлын тосыг нийт 45 ААН, 12714.77 тн-ыг импортолж, 679236.8 мянган төгрөгийн Гаалийн албан татвар, 4564215.5 мянган төгрөгийн НӨАТ-аас тус тус чөлөөлөгдсөн байна. Хүнсний улаанбуудай, бүх төрлийн будаа, ургамлын тос нийт 236160.1 тн-ыг импортолж, 10.12 тэрбум/ 10120955,9 мян.төгрөг/ төгрөгийн Гаалийн албан татвар, 23.9 тэрбум /23919856.5 мянган.төг/ төгрөгийн НӨАТ-ын хөнгөлөлт эдэлсэн байна. https://legalinfo.mn/mn/detail?lawId=103845 https://legalinfo.mn/mn/detail?lawId=15791 Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн.	Хэрэгжсэн - 100%
	63		4.2/. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтаар Улсын Их Хурлаас эрх олгосны дагуу мөн тогтоолын хавсралтын 07 дугаар бүлэгт заасан хязгаарт багтаан барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг шинэчлэн тогтоох;	Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулахаар “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталж, батлагдсан үзэл баримтлалын хүрээнд тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаан, Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын 4 дэх заалтаар Улсын Их Хурлаас Засгийн газарт эрх олгосны дагуу Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хуралдаанаар "Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				https://legalinfo.mn/mn/detail?lawId=17434725955702&showType=1 Хавсралт : 1 файл	
	64		4.3/. Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор Дэлхийн худалдааны байгууллагын “Хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээр”-т нийцүүлэн “Хамгаалалтын арга хэмжээний журам”-ыг батлах, хэлэлцээрийн хүрээнд үйлчлэх импортын барааны тоо хэмжээний хязгаар болон гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох.	Засгийн газрын 2021 оны "Журам батлах тухай" 24 дүгээр тогтоолоор Дэлхийн худалдааны байгууллагын "Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх журам батлагдсан. Тус журмын 6.3-т "Хамгаалалтын арга хэмжээ нь гаалийн тариф, эсхүл импортын тоо хэмжээний хязгаарлалт гэсэн хэлбэртэй байх ба эдгээр арга хэмжээг хослуулан хэрэглэж болно." гэж заасан. Мөн 6.1д "Энэ журмын 5.13-т заасан эцсийн дүгнэлт гарсан тохиолдолд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх тухай саналаа гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж, холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Шийдвэрт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх огноог заасан байна." гэж тусгасан. Одоогоор хамгаалалтын арга хэмжээний журам хэрэглэгдээгүй байна. Хяналтаас хасуулах санал : https://legalinfo.mn/mn/detail?lawId=16160842257081	Хэрэгжсэн - 100%
25	65	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52	3.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай: 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн уе шаттайгаар хэрэгжүүлэх;	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу салбарын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, зохион байгуулалтыг ханган ажиллаж байна. Үүнд: - “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, - “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, - "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө" зэрэг болно. Салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн батлагдсан баримт бичгийг хэрэгжүүлэхээр ХХААХҮ-ийн салбарт 2025 онд 662.6 тэрбум төгрөгийг батлуулж ажилласан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
26	66	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020-08-28 Дугаар 2020 №24	2.4/. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан экспортыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгон иргэдийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засагт нөлөө үзүүлэх 10 томоохон төслийг санхүүгийн боломжит бүх арга хэрэгслийг ашиглан санхүүжүүлэх.	Алсын хараа 2050 4.2. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ДАШЦББ-ийн арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Дархан, Хонгор сум/, "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/ төсөл, арга хэмжээний төсвийг 2024 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдан батлагдсан. 1. "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/ төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжих 5 багц ажил гүйцэтгэх гэрээний хугацаа сунгалт, нэмэгдэл санхүүжилтийн гэрээний дагуу цахим системд төсөв, зардлын задаргаа, ажлын хуваарийн өөрчлөлтийг оруулан баталгаажуулсан бөгөөд 10,461.6 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг СЯ-нд хүргүүлэн санхүүжүүлсэн. 2. "ДАШЦББ-ийн арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Дархан, Хонгор сум/" төсөл, арга хэмжээний 1,580.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгох хүсэлтийг СЯ-нд хүргүүлэн санхүүжүүлсэн. Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дууссан.	Хэрэгжсэн - 100%
27	67	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2020-11-05 Дугаар 2020 №32	2.8/. Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийн үед импортыг орлох, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн мөнгө, санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 101 дүгээр тогтоолын дагуу Олон улсад шинэ коронавирус (Covid 19)-ийн халдвар дэгдсэний улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хилийн хязгаарлалт тавьсантай холбогдуулан ноолуурын салбарыг дэмжих зорилгоор тодорхой хэмжээний эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгаж, мөн энэ тогтоолоор түүхий эдийн нөөц бүрдүүлэх, үнийг тогтвортой байлгах арга хэмжээг тухай бүр нь авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгасан. Уг ажлын хүрээнд ХХААХҮЯ, Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд 2020 оны 04 сарын 03-ны өдөр “Ноолуур бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийн зардлыг санхүүжүүлэх гэрээ” байгуулсан. 2020 онд ноолуур бэлтгэлийн зориулалтаар Хөгжлийн банкнаас 44 аж ахуйн нэгж 103,9 тэрбум төгрөгний зээл авсан ба 2020 оны хүүгийн хөнгөлөлтэнд ХХААХҮЯ-аас 5 тэрбум төгрөг шилжүүлсэн болно. ЗГ-ын 2021.02.17-ны өдрийн 42, 2021.03.10-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө” баталсан. Уг төлөвлөгөөний 2.5-д ноолуур бэлтгэлийг дэмжих зорилгоор 200 тэрбум төгрөгийг арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан жилийн 3 хувийн хүүтэй олгох, уг зээлд	Хэрэгжсэн - 100%

				хамрагдсан ААН-д ЗГ-аас 7.65 хувийн зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэхээр тусгуулан батлуулсан.Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Хөдөө аж ахуйн зээл"-ийн зээлийн хүүгийн дэмжлэгийн гэрээ /2021.04.29-ний өдрийн 0521/201/70, 210430/05-270/-г ХХААХҮЯ, Сангийн Яам, Монгол банктай байгуулав. "Хөдөө аж ахуйн зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээг Төрийн банк, Хаан банк, ХХБ, Голомт банк, Капитрон банк, Хас банктай байгуулсан.Арилжааны банкууд 2021 онд ноолуур бэлтгэлд зориулсан зээлийг 38 ААН-д 94.9 тэрбум төгрөг, ноос бэлтгэлд 4 ААН-д 3.2 тэрбум төгрөг, арьс шир бэлтгэлд 5 ААН-д 2.8 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна Хяналтаас хасуулах санал : цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон.	
28	68	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-05-06 Дугаар 2021 №40	1.1/. сум хөгжүүлэх санг хоршоог дэмжих чиглэлээр өөрчилж, холбогдох журмыг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан батлах; (1.Хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:)	Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/243, 2023 оны А/521 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг батлуулан мөрдөж ажиллаж байна. Хэрэгжиж дууссан тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дууссан - холбогдох журмыг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан батлах. Хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
	69		1.2/. ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хоршоонд олгох санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгуулж байх;	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2025 онд хөнгөлөлттэй зээл олгохоор төслийн хүсэлтийг 8 удаа зарлаж, нийт 1210 аж ахуйн нэгжийн 174,0 тэрбум төгрөгийн хүсэлтийг хүлээн авч төсөл үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан үнэлгээ өгч сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Төсөл сонгон шалгаруулалтын үр дүнд 371 төсөлд 57,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор батлагдснаас 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 324 төсөлд 47,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Биелэлтийг дэлгэрэнгүйгээр хавсралтаар оруулав. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	70		1.3/. хоршооны шинэчилсэн бүртгэлийг Хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор багтаан зохион байгуулах;	Хоршооны шинэчилсэн бүртгэлийг 2023 УБЕГ-тай хамтран хийж үйл ажиллагаа явуулаагүй хоршоодын бүртгэл зохион байгуулсан. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 6599 хоршоо шинээр байгуулагдаж, нийт 11,046 хоршоо улсын бүртгэлд бүртгэлтэй байна. Засгийн газрын 2024 "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" оны 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 1.0 их наяд төгрөгийн “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн гэрээг Сангийн яам, Монголбанк, Арилжааны 8 банктай байгуулж хэрэгжүүлж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	71		1.7/. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд хоршоог дэмжихэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тэргүүн ээлжид шийдвэрлэх;	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 324 аж ахуйн нэгжид 47,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон ба үүнээс 2.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 23 хоршоонд олгож, 124 ажлын байрыг нэмэгдүүлж, 126 ажлын байрыг хадгалсан байна. Хавсралт : 2 зураг Хяналтаас хасуулах санал : "Шинэ хоршоо-чинээлэг малчин" хөтөлбөр хэрэгжиж байгаа тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	72		1.8/. Монгол Улсад хоршооллын салбар үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд хоршоог сурталчлах, шилдэг туршлагыг дэлгэрүүлэх аяныг улсын хэмжээнд өрнүүлж, ойн арга хэмжээг зохион байгуулах;	Монгол Улсад хоршооллын салбар үүсэж, хөгжсөний 100 жилийн ойг 2021 оны 12 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Улаанбаатар хотод "Хоршоологчдын үндэсний 7 дугаар чуулган"-ыг зохион байгуулсан. Мөн ойн хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 21-22 өдрүүдэд хоршоодын туршлага судлах бүтээлч арга хэмжээг Төв аймгийн Баянчандмань суманд зохион байгуулсан. Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчлах, хоршоод хоорондын туршлага судлах уулзалтыг 21 аймгийн хоршоо жижиг, дунд үйлдвэрийн салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн, хоршоодын төлөөллүүд болон хоршооны салбарын хөгжлийн төлөө ажилладаг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулсан. https://www.facebook.com/share/p/1HtjNMqau6/ Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон.	Хэрэгжсэн - 100%

29	73	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-12-30 Дугаар 2021 №104	1.1/. Генетик нөөцийн тухай хуульд заасан холбогдох журмыг боловсруулж 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор баталж, мөрдүүлэх; (1.Генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А-68 дугаар тушаалын хавсралтаар “Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд баримтлах жишиг үнийн үзүүлэлт”-ийг шинэчлэн боловсруулах тушаалын төсөл, жишиг үнийн үзүүлэлтийг өнөөгийн нийгэм эдийн засгийн нөхцөлд тохируулан нэмэгдүүлэх үндэслэл тооцоололд үндэслэн боловсруулж салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, орон нутгийн төр, хувийн хэвшлийн байгууллага, мэргэжлийн холбооны саналыг авч, 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг нэгтгэн тусгаж, ажил арга хэмжээ тус бүрийн үнэлгээг анх батлагдсан үеэс 17-85 хувиар нэмэгдүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/565 дугаар тушаалын хавсралтаар "Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг үнийг" шинэчлэн батлуулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлэв. Хавсралт : 1 файл	Ахиц гарсан - 50%
30	74	Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2022-05-05 Дугаар 2022 №19	1.3/. хялгас ялгасан ноос, ноолуур, хөөвөр, ээрмэл утас болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй, урт хугацаат, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүр бүрдүүлэх;	Малын гаралтай түүхий эдийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоол батлагдсан (https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140837405211). Тогтоолын хүрээнд 2025 онд малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдэд эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зориулалтаар олгох хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зардалд 66.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгуулан суулгасан. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилгоор үйлдвэр аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч эргэлтийн хөрөнгийн 379.3 тэрбум төгрөгийн 117 хяналтын гэрээ, хөрөнгө оруулалтын зээлийн 120.8 тэрбум төгрөгийн 56 хяналтын гэрээ, нийт 500.1 тэрбум төгрөгийн 173 зээлийн хяналтын гэрээг албажуулаад байна. “Цагаан алт” хөдөлгөөний үрд дүнд ноолуурын үйлдвэрлэлийн салбарт 6,000 тн ноолуур бэлтгэсэн нь анх удаа түүхий эдийн 70 орчим хувийг дотоодын үйлдвэрлэгч нар бэлтгэсэн үзүүлэлт болж байна. Мөн ээрэх хүчин чадлыг 400.0 тн, сүлжих хүчин чадлыг 200 мянган ширхэгээр нэмэгдүүлэх боломж бүрдүүлээд байна. Ноосны үйлдвэрлэлийн салбарт ээрэхийн хүчин чадлыг 300 тн, хялгас ялгахын хүчин чадлыг 530 тн, нэхэх /хивс/ хүчин чадлыг 200 мянган м.кв, сүлжих хүчин чадлыг 50 мянган ширхэгээр, ноосон дулаалгын хүчин чадлыг 3 мянган м.кв нэмэгдүүлэх боломж бүрдүүлээд байна. Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт 1.2 сая ширхэг бог, 488.5 мянган ширхэг бодын шир бэлтгэх нөхцөл бүрдэж, гутал үйлдвэрлэлийн чиглэрээр 550.0 мян.хос гутал үйлдвэрлэх хүчин чадал нэмэгдэж, уургийн гаралтай хаягдал боловсруулах чиглэлээр 4.8 мян.тн желатин үйлдвэрлэх хүчин чадал суурилагдаж байна. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%
	75		1.4/. малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж боловсруулах үйлдвэрт тушаасан сарлагийн хөөвөр, торомны ноосны чанараас хамааруулан мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Улсын Их Хурлын 2011 оны "Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" 30 дугаар тогтоолд өөрчлөлт оруулан самнасан сарлагийн хөөврийн кг тутамд 10000 төгрөгийн урамшуулал олгодог болсон. 2024 онд үндэсний үйлдвэрт 42,620.8 кг сарлагийн хөөвөр бэлтгэн тушаасан 1,443 малчин, мал бүхий иргэдийн урамшуулалд хамрагдсан. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%
	76		1.5/. байгаль орчинд ээлтэй, тогтвортой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүнийг баталгаажуулах хөндлөнгийн итгэмжлэгдсэн	ХХААХҮЯ, Монголын ноос ноолуурын холбоотой хамтран ажиллах 250527/06-438 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан ба энэхүү гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд: 1. Малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх,	Хэрэгжсэн - 100%

			лабораторийн хүрээг өргөтгөн олон улсын түвшинд хүргэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацыг хөгжүүлэх, ноос, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ноолуурын чанарыг орон нутгийн байршилтай нь холбож судлах, шилжилгээнд хамруулах, Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэхэд шаардлагатай судалгаа хийх ажил гүйцэтгүүлэхээр "Монголын ноос ноолуурын холбоо" ТББ-тай байгуулсан 251107/06-883, Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичиг боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажил гүйцэтгүүлэхээр "Монголын ноос ноолуурын холбоо" ТББ-тай байгуулсан 251107/06-884 дугаар гэрээнүүдийг байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан. 2. Монгол Улсын экспортын чиг баримжаатай ноос, ноолууран бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах, бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, бизнес эрхлэгчид хамтран ажиллах, туршлага солилцох нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотод жил бүр уламжлан зохион байгуулагддаг “Apparel, accessoties & footwear Coterie” нэхмэлийн салбарын үзэсгэлэнд 2025 оны 09 дүгээр сарын 14-16-ний өдрүүдэд үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд оролцохтой холбогдуулан үзэсгэлэнгийн талбайн түрээсийн зардал болох 74,4 сая төгрөгийг санхүүжүүлсэн. 3. Тогтвортой текстилийн үйлдвэрлэл шаардлагыг хангасан 17, Монголын хаан ширхэгт чанарын шаардлагыг хангасан 8 хуулийн этгээдийг баталгаажуулалтад хамруулан гэрчилгээ олгосон. Шинжээчийн давтан сургалтад 16 шинжээч хамрагдаж, аудит хийх эрхээ сунгуулсан. 5 шинжээч шинээр бэлтгэсэн. Хавсралт : 9 файл	
31	77	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-06-17 Дугаар 2022 №36	1/а. хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 онд улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	ХХААХҮ-ийн сайдын 2025 оны батлагдсан төсөвт Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжүүлэхээр 177.3 тэрбум төгрөгийг батлуулж 51.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласан бөгөөд хүлээгдэж буй 33.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг олгохоор Сангийн яаманд санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлт хүргүүлсэн.	Ахиц гарсан - 50%
	78		1/б. энэ тогтоолын хавсралтад заасан хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны намрын эээлжит болон 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж өргөн мэдүүлэхтэй холбоотой хэрэгжилтийн тайланг хавсралтаар тайлагнав. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	79		1/в. тарифын зохицуулалт хийх замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхээр “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төсөл, холбогдох судалгааг боловсруулсан. Тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан. Монгол Улс-Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоотой байгуулах, чөлөөт худалдааны хэлэлцээртэй холбогдуулан тогтоолын төслийг өргөн мэдүүлэх ажил хүлээгдэж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%

	80		1/г. хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгохтой холбогдсон асуудлыг зохицуулахаар хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд үндэслэн Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Боловсролын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан. Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай ЗГ-ын 2024 оны 181 дүгээр тогтоолын 91-д Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үндсэн байгууллагаар Боловсролын яам болсон. Иймд хуулийн төслийн үзэл баримтлалыг гурван сайдаар батлуулан Боловсролын сайдад хүргүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Боловсролын сайд үзэл баримтлалын төслийг дахин батлуулахаар ирүүлснийг ХХААХҮ-ийн сайд батлан хүргүүлээд байна. Хавсралт : 6 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	81		1/е. мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	1.Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өрийн А/196 дугаар тушаалаар баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530810636531 Батлагдсан журмын хүрээнд Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэл мэдээллийг Plant.mofa.gov.mn цахим системийг ашиглалтад оруулан тариалангийн талбай, тариаланчдийн бүртгэл, ургац хураалтын мэдээ болон гарал үүслийн гэрчилгээг олгон, төрөөс олгож буй дэмжлэг, урамшуулал болон бусад дэмжлэгийг тус цахим системээр дамжуулан олгож байна. plant.mofa.gov.mn 2."Мал, амьтны гаралтай гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ын төслийг боловсруулсан. "Мал, амьтны гаралтай гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ын төслийг боловсруулах ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Цар тахлын дараах орчинд хүнсний аюулгүй байдлыг сайжруулах” төслийн дэмжлэгтэйгээр Мал, амьтны гаралтай гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох зураглал хийлгэсэн. Журмын төсөлд санал авч, батлахаар ажиллаж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	82		1/ж. хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, пестицид, малын эм, хоруу чанар өндөртэй нян, хүнд металлын үлдэгдлийг хянах, хяналтын төлөвлөгөөг батлах; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Салбарын хяналтын газраас 2024 онд улсын хэмжээнд хийсэн 11 удаагийн хяналт, шалгалтаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 76 аж ахуйн нэгж, иргэний 280 нэр төрлийн 2753 дээжийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулснаас 2560 нь стандартын шаардлага хангасан, 193 дээж 44 үзүүлэлтээр хангаагүй дүнтэй гарсан. Мөн дээрх дээжийн 296 дээжид пестицид, 43 дээжид афлатоксины үлдэгдлийг шинжлэхэд пестицидийн болон афлатоксины үлдэгдэл тус тус илрээгүй байна. Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн Хүнсний нян судлалын шинжилгээгээр 2020-2022 оны хооронд дунджаар 2966 сорьц шинжлэгдэж байсан бол 2023-2024 онд 7500 гаруй сорьц шинжлэгдэж, сорьцын тоо 4-5 дахин өссөн байна. 2023 онд 7533 сорьц шинжлэгдсэнээс нийт сорьцын 0.96% буюу 73 сорьц эерэг, 2024 онд 7192 сорьц шинжлэгдсэнээс нийт сорьцын 1.3% буюу 93 сорьц эерэг гарсан байна. Мөн Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх салбар дундын үйл ажиллагааны 2022-2025 төлөвлөгөөний хүрээнд Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторит 319, Аймгуудын мал эмнэлгийн лабораторит 2145 буюу нийт 2464 дээжид 16 эмийн үлдэгдлийг тодорхойлох тандалт хийхэд үлдэц илрээгүй байна. Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан А/225, А/137 тушаалаар “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” (2022-2025)-г боловсруулж, батлуулсан. Мөн Шадар сайдаас боловсруулж ирүүлсэн “Пестицидийн талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөлд 8 заалт бүхий саналыг тусгуулахаар 2025 оны 04 сарын 10-ны 02/1043 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хүнд металлын үлдэгдэл тодорхойлох шинжилгээгээр зөвхөн хар тугалга, кадьмийн үлдэгдэл тодорхойлж байна.	Ахиц гарсан - 50%

	83		1/и. хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, нөөцийн нэгдсэн тогтолцоо, түүний удирдлагын системийг бий болгож, логистик нийлүүлэлтийн төвүүдийг үе шаттайгаар байгуулах, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/317 дугаар тушаалаар “Тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журам”-ыг шинэчлэн батлсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17048052757221. Тус журмаар ачаа тээвэрлэлтийн баримт бичиг нь холбогдох шаардлагатай мэдээллийг агуулсан цахим QR код байх бөгөөд Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн сан руу шууд дамжуулах боломжийг бүрдүүлсэн. Мөн зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн санд “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын дотоодын ачаа тээврийн www.logistics.transdep.mn систем, “Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-ын хөгжүүлсэн тээвэр зуучийн www.teeverzuuch.mn систем, “Юү эл пи ди” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар хөгжүүлсэн www.e-logistics.mn программ хангамж, ачаа тээврийн www.PapaLogistic аппликейшныг холбох тохиргоог хийсэн. АТҮТ, ТӨҮГ энэхүү арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд дотоодын ачаа тээвэрлэлт, Замын-Үүд –Улаанбаатар чиглэлийн тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх ажлыг олон улсын ачаа тээврийн зөвшөөрөл олгох үйл явцтай уялдуулахаар төлөвлөн, тээврийн нэгдсэн системийг хөгжүүлэх туршилтын ажил хийгдэж байна. Тээврийн нэгдсэн системийг гаалийн системтэй холбохоор холбогдох ажлыг эхлүүлээд байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	84		1/к. хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын татаас, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, шаардлагатай урамшууллын хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт бүрэн тусгаж, хэрэгжүүлж байх. (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	1. Хүнсний ногооны урамшуулал: Тариалангийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 15 дугаар тогтоол, Сангийн сайд, ХХААХҮС-ын хамтарсан 2022 оны А/218/146-журамын дагуу 2022-2025 оны 06 дугаар сарын байдлаар 361.1 мя.тн хүнсний ногоо зах зээлд борлуулсан 2761 тариалан эрхлэгчид 36,133.55 сая төгрөг, 2. Улаанбуудайн урамшуулал: Тариалангийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 15 дугаар тогтоол, Сангийн сайд, ХХААХҮС-ын хамтарсан 2022 оны А/218/146 журамын 2010-2025 оны 06 дугаар сарын байдлаар дагуу стандартын шаардлага хангасан 3,601 мянган тонн хүнсний улаанбуудай нийлүүлсэн 10,523 тариалан эрхлэгчид 272,678.95 сая төгрөг, 3. Сүүний урамшуулал: Хүнсний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 363 дугаар тогтоолын дагуу 2020 оноос 12 сард үндэсний үйлдвэрүүдэд 47,676.3 мяган литр сүү бэлтгэн нийлүүлсэн 36,630 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид 43,396.17 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгосон. Урамшууллыг 2023 оноос Төсвийн урамшууллын систем /www.uramshuulal.gov.mn/ цахим системээр дамжуулан малчин, эрчимсэн мал аж ахуй эрхлэгч болон тариалан эрхлэгчдэд урамшууллыг олгож байна. 2025 оны сүүлийн хагас жилийн урамшууллыг олгохоор Сангийн яаманд санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлт хүргүүлсэн хүлээгдэж байна.	Хэрэгжсэн - 100%
	85		2/а. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг урт хугацаатай, хүү багатай эх үүсвэрээс санхүүжүүлэх, улсын болон орон нутгийн төсөв, бусад санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан зохион байгуулах; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	"Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй 1.27 их наяд төгрөгийн арилжааны банкны эх үүсвэртэй хөнгөлөлттэй зээлийг 2525 иргэн, аж ахуйн нэгжид олгосон. Нийт зээлийн дүнгийн 57.5 хувийг хүнсний үйлдвэрийн салбар, 32.2 хувийг газар тариалангийн салбар, 8.1 хувийг мал аж ахуйн салбар, 2.2 хувийг хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэлийн салбарт 2023, 2024 онд тус тус олгож дууссан. Зээлийн хүүгийн татаасыг 2025 оны улсын төсөвт тусгаж олгосон.	Хэрэгжсэн - 100%
	86		2/б. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Засгийн газраас батлан улс орон даяар "Эх орны эрүүл хүнс" уриан доор хэрэгжүүлж байгаа "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-тай уялдуулан хэрэгжүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг "Эх орны эрүүл хүнс" уриан дор "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-тай уялдуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Улмаар Атрын IV аяныг сурталчлах хүрээнд газар тариалан, мал аж ахуй эрхлэгч болон хүнсний үйлдвэрлэгчдийг нэгэн дор цугларч, харилцан туршлага судлах, кластер байдлаар хамтран ажиллах боломжийг олгох, төрийн бодлого, хууль эрх зүйн орчинг сайжруулахад санал, зөвлөмж гаргах зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 14-нээс эхлэн 7 хоногийн хугацаатай технологийн хуралдаануудыг зохион байгуулсан. Мөн “Атрын IV” аян хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөн 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү зөвлөгөөнд 21 аймаг, нийслэлийн үр тарианы 156 аж ахуйн нэгж, 94 иргэн, төмс, хүнсний ногооны 14 аж ахуйн нэгж, 136 иргэн, жимс жимсгэний 6 аж ахуйн нэгж, 94 иргэн, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 50 аж ахуйн нэгж, нийт 226 аж ахуйн нэгж, 324 иргэн, төрийн орон нутгийн байгууллагын 40 албан хаагч, банк санхүүгийн байгууллагын 10, нийт албан бус тоогоор 1000 гаруй төлөөлөгч оролцсон.	Хэрэгжсэн - 100%

	87		2/в. хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 206 дугаар тогтоолоор Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг ШУТИС-ын Хүнсний судалгаа, инновацийн нээлттэй төвийг түшиглэн, 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140478206121 Хяналтаас хасуулах санал : Тухайн асуудлаар шийдвэр гарсан.	Хэрэгжсэн - 100%
	88		2/г. мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	-Мал аж ахуй: “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага MNS 6891:2020 стандартыг нэвтрүүлэх, тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийх зах зээлтэй холбох чиглэлээр Монголын бэлчээр ашиглагчдын холбоо ТББ дараахь ажлуудыг хийж гүйцэтгээд байна. /https://opendatalab.mn/search/120446?model=TProcurement/ Үүнд: 1. Архангай, Өвөрхангай аймгийн 6 сумын 18 бэлчээр ашиглагчдын хэсгийн 9 хоршооны 400 гаран малчдад сургалтыг зохион байгуулав. “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” ТББ-ын Баталгаажуулалтын алба нь нийт 5 хоршооноос хөндлөнгийн үнэлгээнд хамрагдах хүсэлт авч 4 байгууллагатай гэрээ байгуулан, хөндлөнгийн үнэлгээ баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэж, 4 хоршооны үнэлгээний тайланг баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж тохирлын гэрчилгээ олгоод байна. -Газар тариалан: 2 төрлийн баталгаажуулалт хийгддэг Эхнийх нь хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх ажил энэ хүрээнд ХААЗД-ыг нэвтрүүлэх, баталгаажуулах эрх авсан байгууллага 1, ХААЗД–ын гэрчилгээ авсан аж ахуй нэгж, иргэдийн тоо 40 байна. Цаашид баталгаажуулах байгууллагыг нэмэгдүүлэх тариаланчдыг өөрсдийн үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, зохистой дадлын тэмдэг бүхий бүтээгдэхүүний борлуулалт, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор тариаланч болон хэрэглэгчдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, түүнээ дэлгэрүүлэх ажлуудыг олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн багуудтай хамтран зохион байгуулж байна. Хоёр дахь баталгаажуулалт нь органик бүтээгдэхүүний баталгаажуулалтад хамтын баталгаажуулалтын 34 байгууллага, хөндлөнгийн баталгаажуулалтын 3 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. https://organic.gov.mn/#/validator-organization/list Хүнс: Засгийн газрын 2025 оны “Техникийн зохицуулалт шинэчлэн батлах тухай” 69 дүгээр тогтоолоор Сүү бэлтгэл, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд техникийн зохицуулалтыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17356246681231	Хэрэгжсэн - 100%
	89		2/д. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Засгийн газрын 2014 оны 154 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж байна. 2025 оны байдлаар төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын чиглэлээр нийт 12 удирдамжид аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын хэрэгжилтийг шалгах заалтыг оруулан аймаг, нийслэлийн нийт 7475 объектод шалгалтыг хийж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд дотоод хяналтыг сайжруулж мөрдүүлэх чиглэлээр 335 зөвлөмж, 928 албан шаардлага хүргүүлэн ажилласан. Шалгалтын явцад дотоод хяналтын журам мөрдүүлж хэрэгжүүлээгүй 103 аж ахуйн нэгжид 103 сая төгрөгийн торгууль ноогдуулж хялбаржуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж шийдвэрлэсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	90		2/е. хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн төрийн өмчит их, дээд сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, сургалтын чанарыг сайжруулах, эдгээр салбарт тэргүүлэх чиглэлээр суралцагчид сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, мэргэшсэн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	ХААИС-д элсэн суралцах оюутны босго оноо багш, эмчийн хөтөлбөрийн нэгэн адилаар хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр элсэгчдэд 450 болгон өөрчлүүлэх хүсэлтийг БШУ-ны Сайдад 2024.05.28-ны өдрийн 01/1852 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлсэн байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын 69 сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд нийт 40,906 суралцагч суралцаж байна. Үүнээс: Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй чиглэлийн 12 мэргэжлээр 2025 суралцагч Хүнс боловсруулалт чиглэлийн 5 мэргэжлээр 848 суралцагч суралцаж байгаа хэдийч салбарын яамд суралцагчдад үзүүлэх сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх талаар үр дүнтэй ажил хийгээгүй байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын болон хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг Бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө батлах тухай" А/96 дугаар тушаалыг батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг товлолт хугацаанд хэрэгжүүлсэн. Тайланг хавсаргав. Орон нутгийн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй

				нэгдсэн судалгааг авч нийт 281 албан хаагчийн мэдээлэл ирүүлснээс ажилласан жил, гүйцэтгэлийн үр дүн бусад шаардлага хангасан албан хаагч, яамны нийт албан хаагч нийт 81 албан хаагчийг Удирдлагын академийн багц сургалтад хамруулах хүсэлтийг хүргүүлсэн. Төсвийн тухай хуульд орсон тодотголоор улсын төсвөөр суралцуулах боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан энэхүү хүсэлтийг Төрийн албаны зөвлөл, ЗГХЭГ-ын Засгийн газрын хүний нөөцийн газарт албан бичгээр хүргүүлсэн хэдий ч 2025.12.04-ний өдрийн ХЭГ/3395 тоот албан бичгээр төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн байна.	
	91		2/ж. хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, эрчим хүч, уур, дулааны эх үүсвэр, шатахуунаар тогтвортой хангах; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	1."ХҮНСНИЙ НОГООНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" Засгийн газрын 2022 оны 118 дугаар тогтоолд "Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 324 дүгээр тогтоолын 2 дахь заалтын "11 дүгээр сарын 1-нээс" гэснийг "10 дугаар сарын 15-наас" гэж, "22:00 цагаас" гэснийг "18:00 цагаас" гэж тус тус өөрчилсөн тул хөнгөлөлтэд хамрагдах эрх зүйн үндэслэл үүссэн. Үүнтэй холбогдуулан 2025 онд шинээр өвлийн хүлэмж байгуулсан 1 аж ахуйн нэгжийн 2200м2 талбай бүхий хүлэмжийг цахилгааны хөнгөлтөд хамруулахаар Эрчим хүчний яаманд 02/3685 тоот албан бичгээр уламжилсан. 2.Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шатахууны хангамжийг сайжруулах арга хэмжээний үр дүнд хөрс боловсруулах, тариалалт, таримлын арчилгаа, уринш боловсруулалт, ургац хураалтын ажлыг зохион байгуулахад шаардлагатай шатах тослох материалын үнэ буурч, хангамж хэвийн болсон тул уг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзсэн тул зогсоосон. 3.Мах, сүү, гурил, цэвэр усны үйлдвэрүүдээс цахилгааны хэрэглээний судалгааг авч үзэхэд цахилгааны хэрэглээний зардлыг хөнгөлөх, чөлөөлөх асуудалд зохицуулалт хийх нөхцөл байдал үүсэхээргүй байна гэж үзлээ. (Улсын хэмжээнд тогны мөнгө нэмэгдсэнтэй холбогдуулан дээрх үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний өртөг зэрэгт нөлөөлөх нөлөөлөл гарахаар байна.) https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207180440441 Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	92		2/з. монгол орны байгаль, газар зүй, цаг уурын онцлогтой уялдсан уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх, хүнс бэлтгэх уламжлалт мэдлэгт суурилсан, инновац шингэсэн бүтээгдэхүүн бий болгох тогтолцоог бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	1. ХХААХҮ-ийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтэд орон нутгийн онцлог бүхий уламжлалт брэнд хоол, идээ ундааг түгээн дэлгэрүүлэхээр Баян-Өлгий аймагт Гүзээ, үхрийн хэлэн салат, "Элэг, ногооны царцаамал", Говь-Алтай аймагт Сультай цай, боорцог, арвай, борви тойгтой хоол, Дорноговь аймагт Аарцтай гурилтай шөл, хөмөлтэй битүү шөл, өглөөний цайны хийц, Хөмөл, сонгино, халиартай гамбир, Дорнод аймагт Үзэмчин брэнд, Энхлэн цай, Өвөрхангай аймагт Зүрхэн стейк, Айраг, саамны багц, Сарлагийн өрөм, Сүүтэй багц, Өмнөговь аймагт ингэний айраг, Сүхбаатар аймагт Дарьганга үндэсний өглөөний цай, ундаа, жимбий, нүүдэлчин зоог, Монгол цуглуулга зэргийг тодорхойлсон. Дархан-Уул аймагт 2019 онд "Зум", Хөвсгөл аймагт 2022 онд "Загасны хорхоглосон шөл" орон нутгийн брэндээр шалгарсан, Батламжтай. 2. “Монгол зоог, ундааг тогтвортой хөгжүүлэх нь” арга хэмжээг Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв ГҮТББ-тай хамтран 2024.04.05-ны өдөр нийт 400 гаруй хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарын төлөөлөл оролцож, "Монголын уламжлалт зоог, ундаа ба өглөөний цай ба танилцуулгат зоогийн үйлчилгээ", "Соёлын аялал жуулчлалд Монгол уламжлалт зоог, ундааны нөлөөлөл, жуулчдын талаарх хүлээлт, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн замналд Монгол зоог ундааны орчин цагийн хувьсал", "Бүс нутгийн идээ, ундааг жуулчны цэсэнд нэвтрүүлэх боломж" зэрэг сэдвийн хүрээнд оролцогчдод мэдээлэл хийж, цаашид Монгол зоог, идээ ундааг хөгжүүлэх талаар санал солилцсон. 3.“Үндэсний уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулан, сурталчлах” ажлыг Монголын цахилгаан мэдээ ХХК нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай байгуулсан 250801/07-668 дугаар гэрээний дагуу гүйцэтгэж, нийт 30 мэдээлэл бэлтгэж, www.24tsag.mn цахим хуудсанд байршуулан олон нийтэд сурталчилсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	93		2/и. хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах хүрээнд мал аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуй эрхлэхээр нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан	ЖДҮХС-ийн хөнгөлөлтэй зээлд 2025 онд 324 аж ахуйн нэгжид 47.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг олгосон. Үүнээс 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 10 аж ахуйн нэгж нь нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан ба төслийг хэрэгжүүлснээр 31 ажлын байрыг шинээр	Хэрэгжсэн - 100%

			иргэн, аж ахуйн нэгжид татварын болон бусад дэмжлэг үзүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	бий болгож, 45 ажлын байрыг хадгалсан байна. Мал аж ахуй, Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд татварын таатай орчинд үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал, ААНОАТ хуульд жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалттай аж ахуйн нэгжүүдийн тус хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө. /ААНОАТ-ын тухай хуулийн 22.1/ гэж, Үр тариа, төмс, хүнсний ногоо, сүү, жимс, жимсгэнэ, тэжээл, тэжээлийн ургамал тариалсан, эрчимжсэн тахианы аж ахуйн үйлдвэрлэсэн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжүүдийн албан татварыг 50 хувиар хөнгөлнө. /ААНОАТ-ын тухай хуулийн 22.5.10/ гэж, ХХОАТ хуульд үр тариа, Төмс, хүнсний ногоо, түүний үр, Жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац, Тэжээлийн ургамал, Модны суулгац үйлдвэрлэсэн болон тариалсан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө./ХХОАТ-ын тухай хуулийн 23.2/ гэж, НӨАТ хуулийн 13.1.15, 13.1.16, 13.1.17 дугаар заалтын дагуу чөлөөлсөн. Импортоор оруулж байгаа болон дотоодод борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгаллын бодисыг 2025 он хүртэл НӨАТ-аас чөлөөлнө. /НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ 2021.04.23-НЫ ӨДӨР БАТЛАГДСАН ХУУЛЬ/ гэж тус тус заасан байна. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207180440441	
	94		2/к. Монгол Улсад үйлдвэрлэсэн брэнд бүтээгдэхүүнийг олон улсын болон бүс нутгийн хэмжээний үзэсгэлэн худалдаанд танилцуулах, сурталчлах боломжийг бүрдүүлж, экспортлох эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	2025 онд гадаад улсад зохион байгуулагдсан 6, дотоодод зохион байгуулсан 8 үзэсгэлэн арга хэмжээнд үндэсний үйлдвэрлэгчдийг оролцуулан тэдгээрийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, дотоод зах зээлд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Дараах үзэсгэлэн, худалдааг зохион байгуулан ажилласан. 1."Хүнсний хувьсгал" хөдөлгөөний хүрээнд хүнсний салбарт бий болсон 300 гаруй нэр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг танилцуулах үзэсгэлэн худалдаа, 2."Үндэсний үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа" 3."Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2025" нэгдсэн арга хэмжээ, 4."Милк фестиваль-2025" нэгдсэн арга хэмжээ, 5.“Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг үйлдвэрлэгч”-ийг шалгаруулах арга хэмжээ, 6.“Монгол-Хятадын V Экспо” арга хэмжээ, 7.“Хааны эрэлд-2025” үзэсгэлэнд холбогдох аж ахуйн нэгжийг оролцуулах, 8.Итали Улсын Ром хотноо "Үр тарианаас эцсийн бүтээгдэхүүн хүртэл" үзэсгэлэнд холбогдох аж ахуйн нэгжийг оролцуулсан. Хавсралт : 5 файл	Хэрэгжсэн - 100%
	95		2/л. хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хүрээлэнгээр захиалгат судалгаа, туршилтын ажил хийлгэх хөрөнгийг нэмэгдүүлэх. (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Шинжлэх ухаан, технологийн тухай (шинэчилсэн найруулга), Инновацийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар 2018-2024 онуудад хийгдсэн шинжлэх ухаан, технологийн 8-н төслийг салбарын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачид боловсруулан ирүүлээд байна. Иймд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам” -н “6.5, журмын 3.5.2, 3.5.4-т заасан захиалагч нь төслийн үр дүнг гүйцэтгэгчээс хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шинжээчээр хянан магадалгаа хийлгэнэ.” гэсний дагуу хавсралтад тусгасан нэр бүхий 8-н төсөлд Үр дүнгийн даалгавар тус бүрээр шинжилгээ хийж, үнэлгээ, дүгнэлтийг хийлгэхээр 2025 оны 06 дугаар сарын 03-ны 02/1746 тоот албан бичгийг хүргүүлсэн. Судалгаа, хөгжлийн төв Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр 2, мал эмнэлэгийн чиглэлээр 2, газар тариалангийн чиглэлээр 2, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 1 төсөлд тус тус үнэлгээ хийн 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 01/93 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна. Үүний дагуу ХХААХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	Ахиц гарсан - 50%
	96		3/а. тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган гектар хүртэл атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, эргэлтийн талбайг 1.1 сая гектарт хүргэх,	2025 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн Ерөнхий газартай хамтран Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэр дэх 1137.80 га, Хонгор сумын нутаг дэвсгэр дэх 2937.07 га болон 895 га, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 524 га, Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэр дэх 497.1 га, Матад сумын нутаг дэвсгэр дэх	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

			усалгаатай тариалангийн талбайг 5000 гектараар нэмэгдүүлэх, тариалангийн газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	15000 га, Булган сумын нутаг дэвсгэр дэх 1500 га, Баянтүмэн сумын нутаг дэвсгэр дэх 3000 га, Халх гол сумын нутаг дэвсгэр дэх 30000 га, Чулуунхороот сумын нутаг дэвсгэр дэх 4000 га, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэр дэх 651.16 га, Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр дэх 957.84 га, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэр дэх 72.8 га, Баян-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 431 га, Биндэр сумын нутаг дэвсгэр дэх 577.4 га, Баянхутаг сумын нутаг дэвсгэр дэх 1049 га, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэр дэх 600 га, 4655.16 га болон 2749.69 га, нийт 71235.02 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 166 дугаар тогтоолыг боловсруулан батлуулсан. Нийт тариалангийн талбайн хэмжээ 71.2 мянган га талбайгаар нэмэгдэж 1033.2 мянган га талбайд хүрэв. Засгийн газрын тогтоолыг хавсаргав.	
	97		3/б. ургамлын генетик нөөцийн ашиглалт, хамгаалалт, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ болон ашигт таримлын үр үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх, Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд тулгуурлан улсын хэмжээнд улаан буудайн 4, тэжээлийн 2, хүнсний ногооны 5, төмсний 4, нийт 15 үрийн аж ахуйг байгуулах, сорт сорилтын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Газар тариалангийн салбар нь жил бүр ган, өвчин хортод тэсвэртэй сортыг шинээр туршдаг бөгөөд 2025 онд улсын төсвийн 210,000,000.00 /Хоёр зуун арван сая/ төгрөгөөр Сэлгээний таримлын сорт сорих ажлын хүрээнд тэжээлийн Вандуй, Эрдэнэшиш, Арвай, Тритикал, Шар буурцаг нийт 5 таримлыг тус бүр 5 хяналт сорттой харьцуулж 10 сортыг шинээр туршсан. Ургамал газар тариалангийн хүрээлэнд 2025 онд Буудайн үндсэн сорилтын талбарт зусах буудайн 22 сорт тус тус соригдсоноос эртийн болцтой 6 сортыг хяналт Халх гол-1, Дархан-131, дундын болцтой 11 сортыг хяналт Дархан-34, дунд оройн болцтой 5 сортыг хяналт Дархан-144 сортуудтай харьцуулан судалсан. мөн Төмсний сорт судалгааны ажлын хүрээнд 7 орны 51 сорт дээжүүд, өөрийн орны нөхцөлд эрлийзжүүлгийн аргаар бий болсон 3 дугаарыг сорилоо. Энэ талбарт соригдож байгаа сортууд нь нэн эрт, дунд, дунд орой гэсэн 3 бүлэгт хамрагдаж, үүний ихэнх хувийг дунд болцтой сортууд 70.5 хувийг эзэлж байна. Хүнсний ногоо судлалын секторын Хонгор туршилт, үйлдвэрлэлийн талбайд усалгаатай хүнсний ногооны 9 төрлийн төримлын 47 сорт, дээжийн сорт судалгааны ажлыг явуулж биологи, аж ахуйн үнэт шинжүүдээр нь үнэлгээ өгч ажилласан. Хавсралт : 2 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	98		3/в. "Монгол Улсад газар тариалан эрхлэх систем" технологийн баримт бичгийг мөрдлөг болгож, хөрсний доройтлыг бууруулах, үржил шимийг хамгаалах, сайжруулах, зохистой ээлжлэн тариалалт бүхий дэвшилтэт технологи нэвтрүүлэх, түүнд нийцсэн техник, технологийн шинэчлэл хийх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хаврын тариалалтын техникийн бэлэн байдлыг хангуулахаар аймгуудын ХХААГ, дилер аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласан. Аймгуудын ХХААГ-уудаар дамжуулан тариалангийн аж ахуйн нэгжүүдийн тариалалтын техникийн бэлэн байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, дилер аж ахуйн нэгжүүдийг трактор, хөрс болосвруулах техник, үр тариа, төмс, хүнсний ногооны үрлүүр, дарш тэжээлийн техникийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажилласан. Дарш тэжээлийн технкийн хангамжийг нэмэгдүүлэхийн тулд дилер аж ахуйн нэгжүүд болон ХААК ТӨХХК-ийн ороолцоотой хамтрасан уулзалтыг зохион байгуулж эрдэнэшиш тариалах, дарш бэлтгэх машины системийг шинээр нэвтрүүлэх чиглэлээр үүрэг өгч хэрэгжилтийг хангуулсан. ХААК ТӨХК, Агромаштех ХХК, Энсадатракторон ХХК-ууд эрдэнэшиш тариалах үрлүүрийг тариалалтын өмнө нийлүүлсэн. Хаврын тариалалтын техникийн бэлэн байдлыг 90 хувьтай хангасан. Тариалалтын ажилд 3334 трактор, үр тарианы үрлүүр 2112 үүнээс хийн үрлүүр 363, төмс суулгагч 317, хүнсний ногооны үрлүүр 279, анжис 1293, бордоо бууц цацагч 300, хор цацагч 428, бусад хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмж 4353 ажиллаж байна. Ургац хураалтын ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, механикжуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 97 иргэн, аж ахуйн нэгжийн тухайн жилд худалдан авсан 104 ширхэг техникийн үнийн дүнд 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээнд 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр төмс, хүнсний ногооны 1200 га талбайн ажлыг механикжуулах боломж бүрдсэн. Атар 4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд газар тариалангийн техникийн шинэчлэл хийхэд зориулж 10 дилер аж ахуйн нэгжид 25.7 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Мөн 69 аж ахуйн нэгжүүдэд техникийн шинэчлэл хийхэд зориулж 20.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг арилжааны банкнаас олгосон. Эдгээр 79 аж ахуйн нэгжүүдэд хүүгийн дэмжлэг олгож Хяналтын гэрээ байгуулж ажилласан.	Хэрэгжсэн - 100%

				Хавсралт : 2 файл	
	99		3/г. тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйд шаардагдах дотоодын хэрэгцээт тэжээлийн хангамжийг 1.9 сая тоннд хүргэхэд зохион байгуулалт болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Малын тэжээлийн тогтвортой хангамжийг бүрдүүлэх, сэлгээний таримлын нэр төрөл, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 166 дугаар тогтоолыг батлуулан, Дархан-Уул, Дундговь, Дорнод, Төв, Хэнтий, Говьсүмбэр зэрэг аймгуудад атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх шийдвэр гарч нийт тариалангийн эргэлтийн талбайг 71.2 мянган га-аар нэмэгдүүлсэн. АТАР-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд 171,499,504.0 төгрөгийн үнэ бүхий Шар буурцгийн үр 22 тн-ийг худалдан авч 480 га-д, 113,104,640.0 төгрөгийн үнэ бүхий Судан өвсний үр 20 тн-ийг худалдан авч 400га-д, 195,143,320.0 төгрөгийн үнэ бүхий Тэжээлийн холимог үр 10 тн-ийг худалдан авч 250 га-д, 414,960,000.0 төгрөгийн үнэ бүхий Хошуу будаа 260 тн-ийг худалдан авч 3900 га-д тариалах боломж бүрдсэн. Тус аяны хүрээнд хүүгийн хөнгөлөлтэй арилжааны эх үүсвэрээр тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, түүхий эд дотоодоос худалдан авах, тоног төхөөрөмж шинэчилэх чиглэлээр 8 аж ахуй нэгжид 14.89 тэрбум төгрөг зээлийн олгож тэжээл үйлдвэрлэх хүчин чадлыг 42 мянга орчим тонноор нэмэгдүүллээ.Малын тэжээл үйлдвэрийн хүчин чадлыг 246.9 мянган тонноос 600 мянган тоннд хүргэхээр ажиллаж байна. Аяны хүрээнд жилд 30.0 мянган тонн бүрэн найрлагатай тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай нэг үйлдвэр, 1808 м.кв бүхий 3 тэжээлийн агуулах шинээр ашиглалт оруулсан. Дэлхийн банкны санхүүжилтээр баруун бүс нутагт малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр Завхан аймгийн Тэс сум, Ховд аймгийн Жаргалант сумдад нийт 19.0 мянган тонн бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэх 2 үйлдвэрийг ашиглалтад оруулаа. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд малын тэжээлийн үйлдвэрийн зангилаа төвийг баруун болон төвийн бүс нутагт байгуулж байна. Уг зангилаа төв ашиглалтад орсноор тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг 22,800 тонноор нэмэгдүүлж байна.	Ахиц гарсан - 50%
	100		3/д. хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг 270 гектар хүртэл нэмэгдүүлэн хөгжүүлж, хүн амыг жилийн туршид шинэ ургацын ногоогоор тогтвортой хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, дулааны хангамж, дэд бүтэц бүхий бүс нутгуудад 50 гектар өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Засгийн газрын “Аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоолын хүрээнд өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах чиглэлээр 2025 онд 10 зээлдэгчид 6,26 тэрбум төгрөгийн Засгийн газрын хүүгийн дэмжлэгтэй хөрөнгө оруулалтын зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр олгосон бөгөөд зээлийн үр дүнд өвлийн хүлэмж 0.3 га талбайгаар нэмэгдэх боломж бүрдсэн. Мөн Жижиг, дунд үйлдвэрийн газраас хүлэмжийн аж ахуй байгуулах 9 аж ахуйн нэгжид 1.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ЖДҮХС-гаас олгосн бөгөөд зээлийн үр дүнд 5387 мкв буюу 0.5 га талбайд өвлийн хүлэмж байгуулагдана. Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд өвлийн хүлэмжийн аж ахуй шинээр байгуулагдаж байна. Тухайлбал: АНУ-ын Олон улсын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл, зах зээлийн гарцыг нэмэгдүүлж эдийн засгийг дэмжих” төслөөс Төв, Дархан-Уул аймагт тус бүр 1000 мкв талбай бүхий дэвшилтэт технологийн 2 хүлэмж баригдаж, 2025 оны 02 сард ашиглалтанд орсон, БНСУ-ын Хөдөөгийн хөгжлийн захиргаатай хамтран тус улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яамны бүцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Монгол Улсад хүнсний ногооны судалгаа хөгжлийн төв болон ухаалаг хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулах” төслийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв, Хангён үндэсний их сургууль, Солонгосын хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны газар (KRC)-тай хамтран хэрэгжүүлж байна. Уг төслийг Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд хэрэгжүүлэх бөгөөд энэ онд цахилгаан татах ажлыг хийж гүйцэтгэсэн. Улсын дүнгээр өвлийн хүлэмжийн талбай хэмжээ 40.3 га-, зуны хүлэмж 119,4 га-д хүрсэн. Хавсралт : 8 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	101		3/е. хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр уул уурхайн үйлдвэрийг түшиглэн азот, фосфорын бордооны үйлдвэр байгуулах	Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж байгаа “Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/”-ийг хэрэгжүүлэхээр заасан УТ2400900259022 дугаартай “Бордооны үйлдвэрийн ТЭЗҮ /Төвийн бүсэд/ боловсруулах гэрээ” гэрээний дагуу Азот, фосфор, калийн (NPK) нийлмэл эрдэс бордоог бууц сангас зэрэг органик хаягдлаар дүүргэгч болгон ашиглаж нийлмэл бордоо	Хэрэгжсэн - 100%

			техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжилтийг хангах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	үйлдвэрлэх технологи ТЭЗҮ-ийг боловсруулсан. Байршил: Тариалангийн төв цэг болох Дархан-Уул аймгийн Хонгор сум Төсөв: Нийт 16,6 сая долларын хөрөнгийн эх үүсвэр хэрэгтэй байгаагаас эхний жилд 14%, 2 дахь жилд 36,1%, 3 дахь жилд 49,9% нь хэрэгцээтэй тооцоолол гарсан байна. Жилд 30 мян.тн бордоо үйлдвэрлэж зах зээлийн одоогийн үнийг баримжаалан тооцоолвол 6 дахь жилээс эхлэн хуримтлагдсан мөнгөн урсгалтай болох ба 4,95 жилд хөрөнгө оруулалтаа нөхнө. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	
	102		3/ж. бүх төрлийн будаа, чихрийн манжин, бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэхэд анхаарч, шаардлагатай санхүүжилт, зээл олголтын оновчтой тогтолцоог бий болгох, бодлогын дэмжлэг үзүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	ХХААХҮЯ-ны харъяа байгууллага болох ХААК ТӨХХК нь "Дархан хотод элсэн чихрийн үйлдвэр барих" төслийг хэрэгжүүлэхээр БНХАУ-ын CHINA CAMC Engineering Co,.Ltd компанитай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Дархан-Уул аймгийн Хонгор суманд 9000 га талбайд чихрийн манжин тариалах, жилд 50,0 мян.тн элсэн чихэр үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулсан. Цаашид уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчтай уулзалт хийн ажиллаж байна. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	103		3/з. стандартын шаардлага хангасан үр тарианы элеваторын багтаамжийг 20.0 мянган тонноор, төмс, хүнсний ногоог хадгалах механикжсан агуулах, зоорины багтаамжийг 50.0 мянган тонноор тус тус бүсчилсэн байдлаар нэмэгдүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Улсын хэмжээнд үр тариа хадгалах 557.3 мянган тонны багтаамжтай элеватор байгаагаас “Хөдөө аж ахуйг корпораци” ТӨХХК-ийн 182.0 мянган тонн, хувийн хэвшилд 375.3 мянган тонн нь ашиглагдаж байгаа бөгөөд элеваторуудын ариутгал, засвар үйлчилгээ бүрэн хийгдэж буудай хүлээн авах ажил явагдаж байна. Алслагдсан бүсэд үр тариа хадгалах агуулахын хангамжийг сайжруулах, тариалаланчдын тээврийн өртгийг бууруулах зорилгоор Улсын төсвийн хөрөнгөөр Увс аймгийн Баруунтуруун сум, Дорнод аймгийн Хэрлэн суманд тус бүр 10.0 мянган тонн багтаамжтай үр тариа хадгалах зориулалттай элеваторын байгууламжийн суурийн ажил үндсэндээ дууссан. Монгол Улсын хэмжээнд төмс, хүнсний ногоог хадгалах 305 мянган тонны хүчин чадалтай 7559 зоорь ашиглаж байна. Энэ нь хүн амын хүнсний ногоо, төмсний хэрэглээ болон хураан авч байгаа ургацтайгаа харьцуулахад 170 мянган тонны зоорь, агуулах нэмэх шаардлагатай байна. Иймээс Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах тухай Улсын Их хурлын 36 дугаар тогтоол болон Атрын аян өрнүүлэх тухай Засгийн газрын 47 дугаар тогтоолын хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн асуудлыг шийдвэрлэн 2023-2025 онд зоорь агуулах барих чиглэлээр хөрөнгө оруулалтын зээлийг олгосны үр дүнд 33 мянган тонноор агуулах, зоорины багтаамжийг нэмэгдүүлээд байна. Мөн түүнчлэн Улсын төсвийн хөрөнгөөр 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “(Сэлэнгэ, Орхон, Мандал, Баянгол, Шаамар, Хушаат, Жавхлант, Зүүнбүрэн сум) Төмс, хүнсний ногооны зоорь, 200 тн, 500 тн барилгын ажил эхлээд явж байна. Эдгээр зоорь ашиглалтад орсноор 2800 тонноор мөн хөргөлттэй агуулахын хүчин чадал нэмэгдэх боломж бүрдлээ. Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	104		3/и. байгаль цаг уурын эрсдэлийг даван туулах зорилгоор экологид ээлтэй, усыг зөв зохистой ашиглах усалгааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх, услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах, шинэчлэх, усан сан бүхий ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, дэмжлэг үзүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд 7 аймгийн 9 суманд 2,970 га талбайг услах хүчин чадал бүхий 9 услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил хийгдэж байгаагаас 7 услалтын системийн ажил бүрэн дуусаж улсын комисс хүлээн авсан. Хэнтий аймгийн Хэрлэн сумын “Дулааны тал”, Говь-Алтай аймгийн Жаргалан сумын “Цахир” услалтын системийн ажлууд нь тоног төхөөрөмжийн нийлүүлэлтээс шалтгаалан хугацаандаа дуусаагүй байгаа бөгөөд гүйцэтгэгч “Жинсийн орой” ХХК, “Комп Трейд” ХХК нарын түншлэл, “Алтайн Үндэс Констракшн” ХХК гэрээ сунгах хүсэлт ирүүлээд байна. Үр нөлөө : -	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	105		3/к. үйлдвэр, фермер, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн үйл ажиллагааг дэмжсэн кластерыг бий болгоход чиглэсэн хөдөө	Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын XVIII.1.32 дугаартай "Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/ байгуулах ажил нь 5,0 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд уг ажлын худалдан авах ажиллагааны	Удаашралтай / эрчимжүү

			аж ахуйн агро парк байгуулах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	эрхийг 2024 оны Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолыг үндэслэн Сэлэнгэ аймгийн Засаг даргад шилжүүлсэн. Сэлэнгэ аймгийн Засаг дарга нь "Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/ байгуулах" ажлыг гүйцэтгүүлэхээр Интерконсалтинг констракшн ХХК-тай УТ2104900410 дугаартай гэрээг байгуулсан бөгөөд гүйцэтгэгч байгууллага нь Мандал, Сант, Баруунбүрэн, Сүхбаатар, Баянгол сумдад барих өвлийн хүлэмжийн барилгын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвөөр 2025.12.11-ний өдрийн 2327/2025 дугаартай магадлал хийлгүүлж, зуны нийлэг хальсан хүлэмж 134 ширхэг болон өвлийн хүлэмж барих бараа материалыг татан авсан байна. Иймд Сэлэнгэ аймгийн Засаг дарга нь гэрээт ажлыг 40 хувь гүйцэтгэсэн гэж дүгнэн Сангийн яаманд 1,9 тэрбум төгрөгийг гүйцэтгэгч байгууллагын дансанд шилжүүлж эрх нээлгэх талаар 2025.12.09-ний өдрийн 01/ 1565 дугаартай албан бичгийг хүргүүлсэн байна. Хавсралт : 4 файл Үр нөлөө : -	лэх шаардлагатай - 50%
	106		3/л. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээнд аймгийн төвд 30 гектар, сумын төвд 10 гектар агро ойн аж ахуйг тус тус байгуулах, жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төв, цэцэрлэгийн аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн талбайг хашаажуулж ойн зурвас байгуулах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Тус яамнаас "Орон нутагт жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн газар байгуулах" тендерийг зарлаж, шалгарсан "Эм Жи Ди" ХХК-тай ажил гүйцэтгэх 250501/05-305 дугаартай гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч нь Дархан-Уул аймгийн Орхон суманд 10 га талбайд улсын төсвийн 1,115.5 сая төгрөгийн санхүүжилтээр жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн газрыг байгуулсан. Тус суулгац үржүүлгийн газрыг хашаалж, эх цэцэрлэгт үхрийн нүдний 10 сортын суулгац 3000ш, алимны 2 сортын суулгац 700ш, чавганы 2 сортын суулгац 480ш, интоорын 2 сортын суулгац 720ш, хөх далан хальсны 4 сортын суулгац 1600ш тус тус тариалж, бойжуулгийн талбайг бэлтгэж, гүний худаг, усан сан, усны нөөцийн сав, техник тоног төхөөрөмж хадгалах агуулах, жимс жимсгэний таримлын тайрдас, үндэслэсэн мөчир, тарьц хадгалах зориулалт бүхий 24м2, перионоор ажилладаг автомат тохируулга бүхий сэндвичэн хөргөлттэй агуулах, тарьц, суулгац ангилах, сортлох, түр хадгалах зориулалт бүхий 10м*15м харьцаатай сүүдрэвч, 36 мкв талбай бүхий ажилчдын байр, зуны нийлэг хальсан хүлэмж 2ш, дуслын усалгааны систем 4 га талбайд байршуулж, жимс жимсгэний таримлыг хүйтнээс хамгаалах хэрэгсэл, шаардлагатай техник, тоног төхөөрөмж зэргийг байршуулсан. “Тэрбум-мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тариалангийн талбайг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Сайхан /30,6 км/, Орхон /12 км/, Зүүнбүрэн /24 км/ сумдууд, Дархан-Уул аймгийн Хонгор /36 км/ суманд нийт 4 байршилд улиас, хайлаасны суулгацаар 3 эгнээ хамгаалалтын ойн зурвасыг 93 км-ийн урттай 9 мянга орчим га талбайг хамгаалан байгуулсан. Хавсралт : 8 файл Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	107		3/м. жил бүрийн намрын ургацаас стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор 100.0 мянгаас доошгүй тонн хүнсний улаан буудайг худалдан авах нөөц бүрдүүлэх. (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	ХААК ТӨХХК-д 2025 оны эхний үлдэгдэл 73.5 мянган тонн хүнсний улаанбуудайн нөөцтэй байснаас одоогийн байдлаар 68.1 мянган тонныг гурил үйлдвэрлэлд худалдан борлуулж 5.4 мянган тонныг үлдэгдэл нөөцтэй байна. 2025 оны дотоодын шинэ ургацаас 7.4 мянган тонн үрийн буудай, 29.5 мянган хүнсний улаанбуудайн нөөцийг бүрдүүлсэн. Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	108		4/а. бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох, малын эрүүл мэндийг хамгаалах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг чанаржуулах, малчдын үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй хамтран ажиллах; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	ХХААХҮ-н сайдын 2025 оны А/205 тушаалаар 6 аймгийн 37 сумын 188.0 мянган толгой үхэрт үзлэг ангилалт хийх төлөвлөгөөний дагуу нийт 149.8 мян.толгой малд үзлэг ангилалт хийсэн. Төв аймаг, Дорнод аймгуудад гүйцэтгэл ирүүлээгүй. 2. Сэлэнгэ аймгийн 14 сум, Дорнод аймгийн 15 сум төв аймгийн 4 сум үхэр сүргийг төрөлжүүлэн хөгжүүлэх шийдвэр гаргасан.Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтад, шавжийн тархалт, олшролтыг тодорхойлох судалгааг 12 аймгийн 106 сумын Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын нөөц 4 бэлчээрийн нийт 32.7 сая га талбайд, шавжийн тархалт, олшролтыг тодорхойлох судалгааг 5 аймгийн 16 сумын 4.5 сая га, нийт 37.3 сая га талбайд тус тус хийж, 5.7 сая га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготно, 2.8 сая га талбайд царцаа голомтлон тархсан байгааг тогтоож, үлийн цагаан оготнотой 1.9 сая га талбайд, царцаатай 770.5 мян.га	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%

				талбайд тэмцэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан. “109” тусгай дугаарт нийт дуудлага /32842/ хүлээн авч малчдад мэдээлэл хүргэхээс гадна өдөр тутам цахим хуудас, улирал тутмын сэтгүүл, 7 хоног бүрт телевиз хэвлэл мэдээллийн сувгуудаар “Малчин лавлах 109” тусгай дугаарын үйл ажиллагаа, ХХААХҮЯ, МЭЕГ пейж хуудсуудын мэдээ, мэдээллийг цахим орчинд 1,152,714 “Малчин лавлах 109” төвийн рекламыг сэтгүүлд 32,500%, телевизээр 1452 нийт 1,217,508 удаа олон нийтэд мэдээлэл хүргэсэн. 2. МЭ-н урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг өвчний гаралт, тархвар зүйн нөхцөлд уялдуулан мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэний дагуу МЭЕГ-н даргын 2025.03.24-ний А/99 тушаалаар батлуулан аймаг, нийслэлийн МЭГ-т хүргүүлэн дархлаажуулалтыг эхлүүлсэн. 2025 онд Улсын хэмжээнд 19 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 20.9 сая толгой мал хамрагдахаар төлөвлөсөн. Дархлаажуулалт улсын хэмжээнд 20.3 сая толгой мал хамрагдаж 97.0% гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Халдварт өвчнөөр 2025.12.19-ны байдлаар 19 нэр төрлийн 246 голомтод 1386 толгой мал өвчилж өмнөх оноос (479 голомтод 1125 тохиолдол) тохиолдлын тоо өмнөх оноос өссөн бол голомтын тоо 51%-р буурсан	
	109		4/б. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж,бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, загвар хоршоог байгуулах, шинэчлэх, хоршоолох хөдөлгөөнийг бүх талаар дэмжих; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хоршооны бүтцэд тулгуурлан малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэн нийлүүлэлт, боловсруулалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох зорилгоор махны болон сүүний гарц нэмэгдүүлэх Загвар хоршооны төслийг Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн 3 хоршоон дээр хэрэгжүүлсэн . ЖДҮХС-гаас "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор хөдөө аж ахуйн загвар хоршоодод дэмжлэг үзүүлэхээр 2023 онд 4 хоршоонд 0.6 тэрбум, 2024 онд 9 хоршоонд 1.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон ба 2025 онд 7 хоршоонд 784.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Хавсралт : 1 зураг	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	110		4/в. хот, суурин газрын ойролцоо, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, махны чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой, сүүний чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой үхрийн аж ахуй, махны болон нарийн ноост хонины үржлийн цөм сүргийн аж ахуйг бий болгох, өндөр ашиг шимт малын үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил селекцийн ажилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, холбогдох санхүүжилтийг төсөвт тусгах; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд махны үхрийн 13 аж ахуйн нэгж нийт 17,54 тэрбум төгрөгийн эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл авсан бол сүүний үхрийн аж ахуй эрхэлж байгаа 7 аж ахуйн нэгж нийт 9.24 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна. Тус аж ахуйн нэгжүүд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, цэвэр үүлдрийн арвин ашиг шимтэй үржлийн үхэр болон нэгдүгээр үеийн эрлийз үхрийн тоо 1838 толгойгоор нэмэгдээд байна. Засгийн газрын “Аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжиж буй Атар-4 хүрээнд махны үхрийн аж ахуй эрхэлж байгаа 25 иргэн аж ахуйн нэгж 18.86, сүүний үхрийн аж ахуй эрхэлж байгаа 24 иргэн, аж ахуйн нэгж 40.91, өсвөр мал бордох аж ахуй эрхэлж байгаа 17 иргэн, аж ахуйн нэгж 6.75 нийт 66.52 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан байна. Зээлийн үр дүнд аж ахуйн нэгжүүд дэвшилтэд техник, тоног төхөөрөмж, цэвэр үүлдрийн болон нэгдүгээр үеийн эрлийз арвин ашиг шимт үржлийн үхэр худалдан авч үйл ажиллагаагаа өргөжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэн ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 аймаг, нийслэлийн 18 сум дүүрэгт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх өндөр ашиг шимт малын тоо толгойг нэмэгдүүлэхээр мах-сүүний хосолмол ашиг шимт 1465, махны 1430, сүүний 1355 нийт 4250 толгой үнээ мөн орон нутгийн малчид аж ахуй нэгжийн захиалгын дагуу 3390 толгой үнээ, улсын хэмжээнд 7640 толгой үнээд зохиомол хээлтүүлэг хийсэн. Адра олон улсын байгууллагатай хамтран мерино үүлдрийн хуцны үр импортолж, бог малд биотехнологийн дэвшилтэд лагароскопийн буюу дурангийн аргаар гүн хөлдөөсөн хуцны үрээр 2 аймгийн 5 суманд нийт 1253 толгой хонинд толь тавьж үрлэх аргаар 4 аймгийн 4 суманд нийт 1186, өндөр ашиг шимт хуцны үрээр толь тавьж үрлэх аргаар 4 аймгийн 4 суманд нийт 1186 хонинд, улсын хэмжээнд 2439 толгой хонинд зохиомол хээлтүүлэг хийсэн. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	111		4/г. гахай, тахианы болон өсвөр хонь, үхэр бордох аж ахуйг өргөтгөх, шинээр байгуулахад аж ахуйн нэгжийн оролцоог	УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36-р тогтоолын хүрээнд 2023-2024 онд шувууны 7 аж ахуйн нэгж 43.42 тэрбум төгрөгийн	Хэрэгжсэн - 100%

			нэмэгдүүлэх, урт хугацаатай хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	зээл авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Засгийн газрын 2025 оны “Аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоолын хүрээнд Атар-4 хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл шувууны аж ахуйд 20.0, өсвөр мал бордох аж ахуйн нэгжүүдэд 15.0 нийт 35,0 тэрбум төгрөгийн зээл олгох санхүүжилт шийдвэрлэгдсэн. Тус аяны хүрээнд аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зээлийн хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжүүдээс банкны шаардлага хангасан шувууны аж ахуй эрхэлж байгаа 7 иргэн аж ахуйн нэгж 7.4, өсвөр мал бордох аж ахуй эрхэлж байгаа 17 иргэн, аж ахуйн нэгж 6.75, 24 зээлдэгч 14.15 тэрбум төгрөгийн зээл аваад байна. Мөн Жижиг дунд үйлдвэрийн газрын жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас шувууны аж ахуй эрхлэгч 1 аж ахуйн нэгж 297.5 сая төгрөгийн зээл авсан. Дээрх аж ахуйн нэгжүүд хөнгөлөлттэй зээлийн үр дүнд шувууны аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 100 хувиар, өсвөр мал бордох аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 15 хувиар тус тус өсөж, аж ахуй нэгжүүд чадавхижаад байна. Үр нөлөө : -	
	112		4/д. зөгийн аж ахуйг хоршоолсон хэлбэрээр хөгжүүлэх, түүний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортлох боломжийг бүрдүүлэх; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Засгийн газрын 2025 оны “Аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоолын хүрээнд Атар-4 хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл зөгийн аж ахуй эрхлэгчдэд 4.0 тэрбум төгрөгийн зээл олгох санхүүжилт шийдвэрлэгдсэн. Тус аяны хүрээнд зээлд хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжүүдээс банкны шаардлага хангасан зөгийн аж ахуй эрхэлж байгаа 10 иргэн, аж ахуйн нэгж нийт 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан. Мөн Жижиг дунд үйлдвэрийн газрын Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зөгийн аж ахуй эрхлэгч 3 иргэн 325.0 сая төгрөгийн зээл авч дэвштилтэд техник, тоног төхөөрөмж, зөгийн бүл худалдан авч үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна. Дээрх зээлийн үр дүнд зөгийн аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 10 хувиар өсөж, аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, чадавхижаад байна. Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	113		4/е. /мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, оношилгооны лабораторийг чадавхжуулах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах. (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх чиглэлээр ДМАЭМБ-аар баталгаажуулсан шүлхий өвчинтэй тэмцэх албан ёсны хаяналтын хөтөлбөрт заасны дагуу МЭЕГ-ын даргын А/127 дугаар тушаалаар 2025 оны хаврын төлөвлөгөөт дархлаажуулалтыг зохион байгуулж14 аймгийн 2.5 сая толгой үхэр, А/297 дугаар тушаалаар намрын төлөвлөгөөт дархлаажуулалтыг зохион байгуулж зохион байгуулж 21 аймгийн 6 сая толгой үхэр хамруулсан. яаралтай дархлаажуулалтад 800 мянган толгой бог мал хамруулж 2025 онд нийт 9.3 сая толгой мал дархлаажуулалтад хамруулсан байна. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 14 аймгийн 15.1 сая толгой бог мал дархлаажуулалтад хамруулсан. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 1.3 сая толгой мал хамруулсан. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 15 аймгийн 18.1 сая толгой хонь хамруулсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	114		5/а. мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	1. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын хаврын чуулганы хуралдаанаар хэлэлцэж дэмжигдсэн ба техникийн ажлын хэсэг байгуулсан. Энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт: “Органик бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид үзүүлэх дэмжлэг, урамшуулал” гэсэн 2 зүйл тусгагдсан. 2. Органик бүтээгдэхүүний тухай хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан дагалдан гарах мэдээллийн санд баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, үйлчилгээг бүртгэх, гэрчлэх тэмдэг хэрэглэх журмын төслийг эцэслэн боловсруулж "Журам шинэчлэн батлах тухай" ХХААХҮСайдын А/545 дугаар тушаалыг батлав. ХЗДХЯ-нд хүргүүлж, 6927 дугаараар бүртгүүлж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулав 3. Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 130 дугаар тогтоолоор сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан. Мөн Засгийн газрын 2023 оны "Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 363 дугаар тогтоолоор дараах өөрчлөлт оруулсан. Үүнд: - бүх төрлийн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн аж ахуй эрхлэгчид, - Хэрэгжилтийн хугацааг 2026.12.31-ний өдрийг хүртэл, -Түүхий сүүний 1 литр тутамд 500.0 төгрөгөөр урамшууллыг нэмэгдүүлсэн, - Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрт тушаасан сүүнд	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				урамшуулал олгох - Тухайн жилийн малын тоо толгойн албан татварыг төлсөн малчинд сүүний урамшуулал олгох,	
	115		5/б. хүүхдийн хоол, сүү, ногоо, жимс, жимсгэнийн тэжээлийн үйлдвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, үндсэн түүхий эдийг дотоодоос бэлтгэн нийлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүүхдийн хоол, хүнсний хэрэглээнд зориулан ногоо, жимс, жимсгэний тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах зориулалтаар 2023 онд 9 аж ахуйн нэгж, 2024 онд 2 аж ахуйн нэгжид зээл олгогдсон байна. Хөнгөлөлттэй зээлийн үр дүнд ногоо, жимс, жимсгэнэ боловсруулах чиглэлээр Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт Еден ХХК, Гарааны эс ти эс фүүдс ХХК-иудын үйлдвэрийн барилгын гүйцэтгэл 30-100%-тай байна. Хүнсний ногооны 2022 оны дотоодын үйлдвэрлэлийн тоо хэмжээг 2024 оны дүнтэй харьцуулахад 132.5 мянган тонн буюу 88.5%-иар нэмэгдсэн байна.	Хэрэгжсэн - 100%
	116		5/в. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчийн хоолны зардлыг шим тэжээл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоог хангах; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсролын яам, Боловсролын Ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Обзервстар ХХК хамтран хоолны орц, шим тэжээлийн үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр танхим, цахимаар сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 7 удаа зохион байгуулан ажилласан. 2024 оны 73 дугаар тогтоолын 3 дахь заалтад хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлын 1000 (нэг мянга) төгрөгийг хуульд заасны дагуу эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хариуцуулах арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн. Сүү хөтөлбөрийг орон нутгийн төсөв, эцэг эх асран хамгаалагчийн дэмжлэгээр хэрэгжүүлж, Ерөнхий гэрээ байгуулсан 2 үйлдвэр, тендер, шууд худалдан авалтаар орон нутагт 4 үйлдвэр сүү нийлүүлж байна. ЕБС, СӨБ-ын хүүхдэд 7 хоногийн 2-5 өдөр 100-200 мл, дотуур байрны хүүхдэд 7 хоногийн 5 өдөр 200-300 мл сүү нийлүүлж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	117		5/г. хуурай сүү, хүнсний давс, хүнсний тос, төмс, төрөл бүрийн будаа, элсэн чихрийн боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, банкнууд хооронд байгуулсан “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн гэрээ”, ”Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гэрээ”-г арилжааны 10 банктай байгуулсан ажиллаж байна. Үүнд: хүнсний давс,-2023 онд 4 ААН (Монголхан ХХК, Баяндөрт таваг ХХК, Зэт эм эл ХХК, Баялаг органик ХХК)-д 0.9 тэрбум төгрөг, 2024 онд 1 аж ахуйн нэгжид 0.10 тэрбум төгрөг буюу нийт 5ААН-д 1тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Увс аймаг: Хасу дэвшил хоршоо шинээр тоног төхөөрөмж худалдан авч, үйлдвэрлэлийн хэмжээг 15-20%-иар нэмэгдүүлсэн.Баялаг органик ХХК -ний үйлдвэр 100% ашиглалтад орсон. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төмс хүнсний ногоо боловсруулах үйлдвэрийг дэмжих зорилгоор нийт 4 аймгийн Засаг даргын захирамжаар 6 төсөлд 1.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгохоор батлагдсан ба 584.5 сая төгрөгийн санхүүжилтийг 3 төсөлд олгож, 594.1 сая төгрөгийн санхүүжилт бүхий 3 аж ахуйн нэгжийн зээлийн болон барьцааны гэрээг байгуулахаар ажиллаж байна..Хөдөө аж ахуйн корпораци ТӨХК нь БНХАУ-ын Синотранс ХК-тай хамтран чихрийн манжин тариалах, түүнийг боловсруулах замаар элсэн чихрийн боловсруулах үйлдвэр байгуулахаар хөрөнгө оруулалтыг ажлын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан үйлдвэр байгуулах судалгааг хийж байна. Хоногт 20.0 мянган литр шингэн сүүг боловсруулж, хуурай сүү үйлдвэрлэх үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд ХХААХҮЯ болон банкуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч тухайн зээлийн арга хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хамрагдах хүсэлт гаргаагүй байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	118		5/д. хүнсний зориулалтын тусгай тээврийн хэрэгслээр /автомашин, вагон, онгоц/ тоноглогдсон тээврийн паркийг шинээр бий болгох, дотоодын болон экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнсний зориулалтын тусгай тээврийн хэрэгслийн парк шинээр байгуулагдаагүй бөгөөд “АПУ” ХХК, “Талх чихэр” ХХК, MCS“ ХХК, “Тэсо” групп, Витафит групп, “Сүү” ХК, “Өгөөж” ХХК, “Жэм интернэйшнл” ХХК-иуд дэргэдээ хүнсний технологийн зориулалт бүхий автотээврийн парктайгаар үйл ажиллагаа явуулж байна. 2. 2024 онд Төмс, хүнсний ногоо, үр тариа, гурил, будаа, хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүн болон автотээврийн хэрэгслээр мал, амьтан тээвэрлэхэд тавигдах 4 стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. 2025 онд Буудайн гурил хадгалалт, тээвэрлэлт MNS7054:2025 стандарт шинээр батлагдсан. Хүнс, газар тариалан (үр тариа)-гийн техник тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ бүхий 5.5.3 ангиллаар 2023 онд нийт 189 аж ахуйн нэгж, иргэнд 175.97 тэрбум төгрөг, 2024 онд 115 аж ахуйн нэгж, иргэнд 85.77 тэрбум төгрөг буюу нийт 304 ААН, иргэнд 161.74 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	119		5/е. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах,	Монгол Улсын Их хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд олгогдсон хүнсний зориулалтын сав, баглаа	Тодорхой үр дүнд

			бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, хатаах, хөлдөөх, нөөшлөх бага, дунд оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг дэмжих, хүнсний сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	боодлын үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 2023-2024 онд хөрөнгө оруулалтын -1, эргэлтийн хөрөнгийн -13 нийт 14 аж ахуйн нэгж хамрагдсан. Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжихэд зориулж олгосн нийт зээлийн дүн: 27,6 тэрбум төгрөг. Зээлийн үр дүнд: 6156м2 бүхий хүнсний ногооны хуванцар тэвшний үйлдвэр шинээр ашиглалтанд оров; Эргэлтийн хөрөнгө 20 орчим хувиар нэмэгдсэн; Борлуулалтын орлого 18 хувиар өссөн; Бүтээгдэхүүний нэр төрөл дунджаар 16-аар нэмэгдсэн; Ажлын байр 83-аар нэмэгдсэн; Улсад төлөх татварын хэмжээ 14 хувиар өссөн байна. Хөрөнгө оруулалтын зээлийн талаар: “ОБ Пластик” ХХК нь нийт 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авч өөрийн эзэмшлийн 4,0 га газарт 100м гүний худаг, дотроо уурын зуухтай нам даралтын халаагуур болон 800кв хүчин чадалтай под станц бүхий 6156м2 хуванцар сав үйлдвэрлэх зориулалттай үйлдвэрийн барилга барьж, бүрэн ашиглалтанд оруулаад байна. Өнөөдрийн байдлаар тус үйлдвэр нь 6, 10, 15, 30 ширхэгтэй өндөгний сав, 2 төрлийн жимс ногооны амьсгалдаг сав, 300гр, 500гр хэмжээтэй жимс ногооны таваг, 5 төрлийн хэмжээтэй аяга, 2 төрлийн таг, сэндвичний сав, хэрчим бялууны суурь гэх мэт 16 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж эхлээд байна. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн нэгдсэн дата бааз, систем үүсгэх зорилгоор Plant.mofa.gov.mn цахим системийг ашиглалтад оруулан мэдээллийг хөгжүүлэлтийг жил бүр тасралгүй хийж байна. 2025 онд тус систем хөгжүүлэлт хийх замаар жимс, жимсгэнэ, хүлэмж, зоорь, агуулахын бүртгэл мэдээллийн хөгжүүлэлтийг хийх гэрээг Универсалбинари солюшн ХХК-тай байгуулж, гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.	хүрсэн - 50%
	120		5/ж. хүнсний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар бүтээгдэхүүний амт чанар, сав, баглаа боодлыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэн экспортын зориулалтын брэндийг хөгжүүлэх, үйлдвэрийн үйл ажиллагааг нь тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Монгол Улсын Их хурлаас 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталсан бөгөөд тус хуулийн төсөлд трактор, комбайны импортын барааны гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлөхөөр заасан. Хүнс, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татварыг хөнгөлөх Засгийн газрын 2023 оны "Жагсаалт батлах тухай" 107 дугаар тогтоолын хүрээнд сүүлийн 2 жилийн хугацаанд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нийт 250 аж ахуй нэгжид 110 төрлийн 3123 ширхэг тоног төхөөрөмжийн нийт 10.2 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг чөлөөлсөн. Мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 2024 онын байдлаар 714 буюу 37%-иар нэмэгдсэн ба үүнээс 1060 нэр төрлийн экспортын чиг баримжаатай хүтээгдэхүүн бий болсон. (суурь түвшин 1931, гүйцэтгэлээр 2645) Хүнсний үйлдвэрийн тоног төхөөржийн шинэчлэл хийж, бүтээгдэхүүний амт чанар, сав баглаа боодлыг сайжруулах чиглэлээр 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 4 аймгийн Засаг даргын захирамжаар 5 төсөлд 589 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгохоор батлагдсан ба 100 сая төгрөгийн 1 төсөлд санхүүжилтийг олгож, 489 сая төгрөгийн санхүүжилт бүхий 4 аж ахуйн нэгжийн зээлийн болон барьцааны гэрээг байгуулахаар ажиллаж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	121		5/з. хүнсний нэмэлт, биологийн идэвхт хүнсний бүтээгдэхүүн, зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийг дэмжих; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/515 дугаар тушаалаар баталсан “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам батлах тухай” журмын дагуу бүртгэлийг хийж байна. Одоогоор хүнсний нэмэлт-199, Өсгөврийн хөрөнгө-85, Баяжуулагч бэлдмэл:15 /үүнээс албан журмаар-1 / улсын бүртгэлд бүртгэж, цахим сайтад байршуулсан байна. https://mofa.gov.mn/branch/huns/6179198dacc8eb0a8c236cd6, https://organic.gov.mn/#/home	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	122		5/и. улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх замаар хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториос боловсруулсан шинжилгээний аргачлалын стандартын төсөлд санал боловсруулж хүргүүлсэн. ХХААХҮЯ, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх лабораторийн шинжилгээний үзүүлэлтийн улсын хэмжээний нэгдсэн цахим систем боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна. /IF SIRS төсөл/	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%

	123		5/к. хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах. (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	2024 онд “Бүх нийтийн хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, соён гэгээрүүлэх, боловсролыг дэмжих агуулга бүхий мэдээлэл боловсруулж, контент бэлтгэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах” ажлыг 49,5 сая төгрөгөөр “Ти Би Дайтус” ХХК гүйцэтгүүлж, "Эрүүл байх амархан” уриан дор нийт 18 контент рийлс, 28 постер бүтээж, нийт 493300 хүнд түгээсэн. “Иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зохион байгуулж байгаа хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх соён гэгээрүүлэх боловсролыг дэмжих ажилд дэмжлэг үзүүлж, олон нийтэд сурталчлах” ажлыг 10.0 сая төгрөгөөр Монголын цахилгаан мэдээ ХХК-аар гүйцэтгүүлж, нийт 20 сэдвийн хүрээнд хэвлэлийн мэдээ видео, контентийг 30.0 мянга орчимд хүнд сурталчилсан. 2025 онд Хоолзүй, шим судлалын монголын нийгэмлэг ГҮТББ нь “Бүх нийтийн хоол, хүнсний зохистой хооллолт, хэрэглээний талаар сурталчлах” ажлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай байгуулсан 250801/07-667 дугаар гэрээний дагуу гүйцэтгэж, нийт 16 цуврал зөвлөгөө, бүхий видео бичлэг, рийл бүтээж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон бусад цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд сурталчилсан. Обзервстар ХХК нь “Хоол, хүнсний зөв зохистой хэрэглээний талаарх сургалт зохион байгуулах” ажлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай байгуулсан 250801/07-669 дугаар гэрээний дагуу гүйцэтгэж, нийт 9 цуврал хичээл бэлтгэн, танхим, цахим хосолсон сургалтад 711 хүн хамруулж, бичлэгийг youtube хуудсанд байршуулан, нийтэд нээлттэй хүргэж, нийт 5 төрлийн гарын авлага 800 ширхэг тараасан. Мөн “Хоол, хүнсний зөв зохистой хэрэглээ /төлбөргүй сургалт/” гэсэн нэртэй Facebook хуудас нээж, олон нийтэд ойлгомжтой байдлаар 40 орчим зурган мэдээлэл байршуулсан ба 1013 хүн хандсан. Холбоос: /https://www.facebook.com/groups/1267124357916677/. Хавсралт нийт : 11, Файл : 8 Зураг : 3	Хэрэгжсэн - 100%
	124		3. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Х.Болорчулуун/, Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус даалгасугай.	УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал: УИХ-ын 2023 оны "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай" 39 дүгээр тогтоолын төлөвлөгөөний "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна" тэргүүлэх чиглэл, төсөл, арга хэмжээг төсөвтэй нь тусгасан. УИХ-ын 2024 оны "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" 35 дугаар тогтоолын төлөвлөгөөний 1.3.Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоод хангамжийг нэмэгдүүлэхээр тусгасан.	Хэрэгжсэн - 100%
32	125	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2022-07-05 Дугаар 2022 №46	1/. паркийн үйл ажиллагаанаас төсөвт төвлөрөх орлогын тодорхой хувьтай тэнцэх санхүүжилтийг паркийг хөгжүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зориулалтаар жил бүрийн улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;	“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Хүнсний хувьсгал” үндэсний хувьсгал, “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй байдлаар хөгжүүлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийг нийлүүлэлтийн сүлжээний хамт үе шаттайгаар байгуулах зорилтууд тусгагдсан. Дээрх зорилтуудтай уялдуулан “Хөнгөн, хүнсний үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2025 оны 271 дүгээр тогтоолыг батлуулсан. Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл технологийн паркуудыг төвийн бүсэд Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн парк”, Баруун бүсэд Ховд аймагт “Шинэ Ховд аж үйлдвэрийн парк”, Нийслэлд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, говийн бүсэд Говьсүмбэр аймагт “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”, Зүүн бүсэд Дорнод аймагт “Зүүн бүсийн үйлдвэрлэл технологийн парк”-уудыг байгуулахаар төлөвлөн, төр хувийн хэвшлийн оролцоотойгоор бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. Дэд бүтцийн нийт хөрөнгө оруулалт: - Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн парк: 2025-2027 онд 23.8 тэрбум төгрөгийг	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2025 онд 7.1 тэрбум төгрөг төсөвлөгдсөн, гүйцэтгэл 71,8%. - "Шинэ Ховд" үйлдвэр технологийн парк: 2022-2026 онд 35,943.6 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2025 онд 18.2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн, гүйцэтгэл 90.8%. - Эмээлт эко аж үйлдвэрийн парк: 2025-2028 онд 515.9 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөв, олон улсын зээл тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2025 онд 30.0 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт тусгасан. гүйцэтгэл 10% Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	
33	126	ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ 2022-11-10 Дугаар 2022 №65	2.4. уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний боловсруулалтыг шат ахиулж, экспортыг дэмжихэд чиглэсэн гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх;	1. 2024 онд “Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай” хууль 38.1.24.оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал гэж тусгасны дагуу "Гаалийн татвараас чөлөөлөх оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материалын жагсаалт"-ыг 2024 оны 240 дүгээр тогтоолыг ХөҮБХЗГ-аас хариуцан боловсруулж батлуулсан. 2. Монгол Улсын Их хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн чуулганаар “Монгол улсын 2023 оны төсвийн тухай” хуулийг дагалдан “Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай” хууль батлагдсан. Хуулийн хэрэгжилтийг хангахаар "Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр "Жагсаалт батлах тухай" 2023 оны Засгийн газрын 107 дугаар тогтоолыг батлуулсан. Энэхүү жагсаалтын дагуу гаалийн албан татварын хөнгөлөлтөд экспортын голлох салбар болох нэхмэл, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүд, хүнсний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, хаяг шошго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд, мод боловсруулах салбарын эцсийн бүтээгдэхүүн тавилга, модон эдлэл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд болох нийт 19 үйлдвэрийн чиглэлийн нийт 428 төрлийн тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас хөнгөлөх бодлогын шийдвэрийг гаргасан. Хяналтаас хасуулах санал : хугацааны хувьд ач холбогдолгүй болсон.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
34	127	МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72	1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;	ХХААХҮ-ийн салбарт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах арга хэмжээ батлагдаагүй болно. Үр нөлөө : - Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дууссан бөгөөд цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон - 2023 онд шуурхай зохион байгуулах	Хэрэгжсэн - 100%
	128		1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулахтай холбогдуулан ХХААХҮ-сайдын хөрөнгө оруулалтын төсвийн 2025.05.31-ний өдрийн байдлаар гэрээ байгуулагдаагүй арга хэмжээ болон тендерийн хэмнэлт болох 2.2 тэрбум төгрөгөөр бууруулаад байна. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
35	129	ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ	1.1. Хөдөө аж ахуйг дэмжих санг татан буулгасантай холбогдуулан тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өр төлбөр, авлагыг "Хөдөө аж ахуйн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүрэн шилжүүлэх;	Хөдөө аж ахуйг дэмжих санг татан буулгасантай холбогдуулан тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өр төлбөр, авлагыг "Хөдөө аж ахуйн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүрэн шилжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар хуулийн хүрээнд хийж дууссан бөгөөд цаг тухайд нь дээд шатны байгууллагад тайлагнаж хэрэгжилтийг хангаж ажилласан болно.	Хэрэгжсэн - 100%

		ТУХАЙ 2023-04-21 Дугаар 2023 №25		Үр нөлөө : - Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгсэн тул хяналтаас хасах	
	130		1.2. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хугацаа хэтэрсэн өр, авлагыг ангилж, улсын төсөвт төлөх өр төлбөрийг 2024 онд багтаан төлж барагдуулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;	Хөдөө аж ахуйг дэмжих сангаас санхүүгийн тайланд бүртгэлтэй улсын төсөвт төвлөрүүлэх өр төлбөрөөс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын зээлийн эх үүсвэртэй өглөгөөс 2025 онд 3.6 тэрбум төгрөг, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газрын зээлийн эх үүсвэртэй өглөгөөс 2025 онд 3.7 тэрбум төгрөгийг тус тус барагдуулж ажилласан байна. Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	131		1.4. "Хөдөө аж ахуйн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн засаглалыг төр--хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх хүрээнд газар тариалан, мал аж ахуй эрхлэгчдийн болон мэргэжлийн холбоодын оролцоог хангасан олон нийтэд нээлттэй компани болгох арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу тус байгууллага нь ХХАА-н салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаанд саад болох хөдлөнгөөс оролцож бизнест нь халдах үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд харин ч ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч--диллер нарыг холбосон цогц үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд хүнс, хөдөө аж ахуйн салбарт оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж, дотоодын эдийн засгийн өсөлтөд ХАА-н салбарын үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болов. Мөн ХХАА-н салбарт олгодог улсын төсвийн ачааллыг бууруулж, ХАА-н корпораци ТӨХХК нь үйл ажиллагааны орлогоороо санхүүжүүлж үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2026 онд Засгийн газрын тогтоолоор нээлттэй хувьцаат компани болохоор шийдвэрлэсэн тул бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	132		1.5. "Хөдөө аж ахуйн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн хуулийн этгээдтэй өрсөлдөхгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК нь хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, ургамал хамгаалллын бодис, бордоо нийлүүлэгч дилер аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүнийг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нарт дамжуулан зээлдүүлэх, эргэн төлөлтийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ буюу улаанбуудайгаар төлөх боломжийг олгох үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Дамжуулан зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд 2025 он 12.4 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж, ургамал хамгаалллын бодис, бордоог нийт 97 тариаланчдад дамжуулан зээлдүүлсэн байна. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
36	133	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59	3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.	"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2025 оны Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 11 сарын байдлаар гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Хавсралт : 2 файл Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
37	134	МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93	1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулж ажилласан. Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
38	135	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний	2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-	ХХААХҮЯ нь “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г байгууллагын албан хаагчдад танилцуулан, холбогдох чиглэлийг өгөн, мөрдөн ажиллах байна. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн шинэчлэн батлуулахтай холбогдуулан тус журмын төсөлд	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлаг

		хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	тусгуулах саналыг ТЗУГ-т хүргүүлэн ажилласан. Үр нөлөө : -	атай - 50%
39	136	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2024-06-05 Дугаар 2024_63	2.1.а. а/хөнгөн үйлдвэрлэлд хамаарах салбар, оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих, хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийн үзэл баримтлал, тандан судалгааг шинэчлэн Монгол улсын их хурлын аж үйлдвэржилтийн бодлогын байгын хороонд ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 01/433 тоот албан бичгээр хүргүүлсэн. Аж үйлдвэржилтийн бодлогын байгын хорооны 2025 оны УИХ-12/3630 тоот бичгээр холбогдох судалгааг шинэчлүүлэхээр буцаан ирүүлсэн. Байгын хорооноос ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/296 дугаар тушаалаар Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг яамны бүтцийн нэгж болон салбарын 6 холбоодын төлөөллийг оролцуулан байгуулан, хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг дахин шинэчлэн боловсруулсан. Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	137		2.1.б. б/үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, 2024 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	1.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд 2024 оны 12 сарын 12-ны өдрийн өөрчлөлтөөр “Газар тариалангийн болон боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдэл, трактор, комбайны импортын барааны гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлнө.” гэж өөрчлөлт орсон. 2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд “Албан татвар төлөгчийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн хугацаанд 90 хувиар” гэж тус тус нэмэлт өөрчлөлт ороод байна. 3.ХХААХҮ-имйн сайдын 2025 оны 01/473 тоот албан бичгээр татварын багц хуудийн шинэчлэлд Хувь хүний орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулхаар хүргүүлсэн. Сангийн яамны ТНБД-ын 2025 оны 08 сарын 07-ны өдрийн 02/7498 тоот бичгээр түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг бүтээн байгуулалтын үе шатнаас экспортод гаргах хүртэл олон төрлийн татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлж байгаа тул дэмэхгүй хариу өгсөн. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	138		2.1.в. в/малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;	1.Засгийн газрын 2024 оны "Цагаан алт хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 190 дүгээр тогтоол, Монголбанк, Сангийн яамтай хамтарч “Ноос ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл”-ийн хүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн ерөнхий гэрээ, Арилжааны банкуудтай эргэлтийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гэрээ байгуулан 2025 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар 173 ААН-д 487.56 тэрбум төгрөгийн зээл олгож байна. 2.Улсын Их Хурлын Байнгын хорооны 2025 оны "Чиглэл өгөх тухай" 09 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дугаар тэмдэглэлийн хүрээнд дэлхийн эдийн засгийн худалдааны тарифын нөхцөл байдал, зах зээл дэх ноолуурын борлуулалтыг дэмжих, ноолуур бэлтгэлийн хугацаанд дотоодын үйлдвэрлэгчнарын санхүүжилтийг шийдвэрлэх, зээл олголтыг цаг алдалгүй зохион байгуулж ноолуур худалдан авахад Монголбанк, арилжааны банк, ХХААХҮЯ, ХААБирж хамтран 7 тэрбум төгрөгийг вексель гаргасан. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	139		2.1.г. г/Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Монгол Улсын Их Хурлын "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 2024 оны 63 дугаар тогтоолын хавсралт "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 1.1.3 дахь заалтад тусгасан хэрэгжилтийг хангах хүрээнд "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бүтээгдэхүүний биржийн тухай" Хуулийн төсөл, Үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулахад мэргэжлийн холбоодоос санал авахаар тухайлбал Монголын ноос, ноолуурын холбоо, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын нэгдсэн холбоо, Монголын	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				Махны холбоо зэрэг нэр бүхий холбоодод 2025 оны 03 дугаар сарын 20-ны 02/796 тоот албан бичгийг, Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК-д 2025 оны 03 дугаар сарын 12-ны 02/697 тоот албан бичгийг, МҮХАҮТ-д 2025 оны 08 дугаар сарын 15-ны 02/2466 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн. МҮХАҮТ-аас аж ахуйн нэгжүүдийг төлөөлж саналаа 2025 оны 09 дүгээр сарын 05-ны 02/827 тоот албан бичгээр хуулийн төсөл болон Үзэл баримтлалын төсөлд тусгах саналаа ирүүлснийг судлан үзэж төсөлд тусгалаа. Уг хуулийн төслийг эцэслэн боловсруулахаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/384 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгууллаа. Хуулийн үзэл баримтлалын хүрээнд бусад хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 25 зүйлтэй байхаар боловсруулж, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо”-г Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран гүйцэтгэсэн байна. 2026 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна. Хавсралт : 2 файл	
	140		2.1.д. д/малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд хэрэгжүүлж байгаа урамшууллыг дүгнэж, үр дүнд суурилсан, зах зээлийн зарчимд нийцүүлэхэд чиглүүлэх;	1) Үндэсний боловсруулах үйлдвэрт 2024 онд 16,089 ширхэг бодын шир, 118,108 ширхэг богийн арьс бэлтгэн тушаасан 3,898 малчин, мал бүхий иргэнд олгох 595,659,000.0 (таван зуун ерэн таван сая зургаан тавин есөн мянга) төгрөгийн мөнгөн урамшууллыг олгохоор ХХАААХҮ-ийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/644 тоот тушаалыг батлуулав (Хавсралт 1). 2) Үндэсний үйлдвэрүүдэд 2024 онд 3,495,207.0 кг хонины ноос бэлтгэн тушаасан 14,175 иргэн, 71,388 кг тэмээний ноос бэлтгэн тушаасан 308 малчин, мал бүхий иргэдийн урамшуулал, 42,620.8 кг сарлагийн хөөвөр бэлтгэн тушаасан 1,443 малчин, мал бүхий иргэдийн урамшуулал, 2023 онд тушаасан хонины ноосны И-баримтын дүн малчны А дансанд бүртгэгдсэн малаас гарах ноосны боломжит гарцаас зөрүүтэй байсан 2,289,377.8 кг хонины ноос бэлтгэн тушаасан 9768 малчин, мал бүхий иргэдийн урамшуулал, нийт ноосны урамшуулалд шаардагдах 6,545,606,781.0 төгрөгийг ХХАААХҮ-ийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/648 тоот тушаалыг батлуулав (Хавсралт 1). Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	141		2.1.е. е/дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулахад шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг батлан хэрэгжүүлэх.	1) Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт тогтвортой үйлдвэрлэлийн стандарт батлуулах бэлтгэл ажлын хүрээнд ISO 17065 аудиторын сургалтыг зохион байгуулсан. Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын мэргэшсэн, туршлагатай 10 экспертүүдийг сонгон сургалтад хамруулсан. (https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSeUOcFxCRkzCgdmPu-TRi4_XgYkjdGp3-iX2BNcaMd3uSHnpw/viewform, Зураг) 2) “Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн технологийн хаягдал. Зумласан ноос. Стандартын техникийн шаардлага. MNS 5251:2008” стандартыг шинэчлэн боловсруулж батлуулсан (Хавсралт 1). 3) “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа-Ерөнхий шаардлага. MNS 4930:20XX”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Химийн шингэн бодисоос хамгаалах хувцас Хамгаалалтын хувцасны материалын даралттай шингэний нэвтрэлтийг эсэргүүцэх чадварыг тодорхойлох MNS ISO 13994:202X”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Будгийн ажил. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS XXXX:XXXX” зэрэг стандартын төсөлд санал тусган БТГ-т хүргүүлэв (Хавсралт 2). 4) ISO/TC 38/WG 33 мал амьтны тавлаг байдал; ноолуур бэлтгэх, боловсруулах, шошголох, мөшгөх тогтолцоонд тавих шаардлага (ISO/TC 38/WG 33: Requirements for Animal welfare, Raw cashmere production, Processing, Traceability and Labelling) стандартыг батлуулсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				Хавсралт нийт : 9, Файл : 3 Зураг : 6 Үр нөлөө : -	
	142		2.2.а. а/малыг эрүүлжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологи бүхий дотоодын вакцин үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, мал вакцинжуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, тогтолцоог сайжруулах;	МЭЕГ-аас баталсан 2025 онд мал сүргийг дархлаажуулах төлөвлөгөөний дагуу Биокомбинат ТӨХХК, МЭЕГ болон 21 аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний дагуу 131,5 мянган литр шингэн, 31,7 сая тун вакцин, биобэлдмэл, оношлуурыг МЭЭСБУЛ-ийн хяналтан дор, өөрийн тээврээр хүргэж, графикт цаг хугацаанд нь 100 хувь нийлүүлж, гэрээ дүгнэгдсэн. Дотоодын вакцин үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Биокомбинат ТӨХХК-ийн шингэн вакцины савлагааг автоматжуулах төслийг "Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл"-ийн Мал аж ахуйн салбарын ангилалд шийдвэрлүүлж, хэрэгжүүлсэн ба шингэн вакцины үйлдвэрлэлийн хэмжээг 40-50 хувь нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлсэн. Мөн Дэлхийн банкны МААЭЗЭН төслийн хүрээнд шугаман эсийн технологи нэвтрүүлэх лабораторийг байгуулж, хонины цэцгээс сэргийлэх вакцины Peregо M омгийг Vero омгод өсгөвөрлөж, хээрийн тууршилтууд гүйцэтгэж, эхний 01 цувралыг үйлдвэрлэж, МЭЭСБУЛ-ын дүгнэлт гаргуулсан. Уг төслийн ажлуудыг Ажлын комисс хүлээн авч, ажил нь хэвийн үргэлжилж байна..	Ахиц гарсан - 50%
	143		2.2.б. б/улс, аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн үйл ажиллагааг уялдуулан, стандартын шаардлага хангасан өндөр хүчин чадалтай бүсийн мал эмнэлгийн лаборатори байгуулж, орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах;	Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам хамтран хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд: Ховд аймагт 30 нэрийн 56 тоо ширхэг лабораторийн багаж, тоног төхөөрөмж, нийт 82,599,961 төгрөг , 7 нэрийн 24 тоо ширхэг, лабораторийн тавилга нийт 31,790,000 төгрөг. Хэнтий аймагт 29 нэрийн 73 тоо ширхэг лабораторийн багаж, тоног төхөөрөмж, нийт 75,527,347 төгрөг ,11 нэрийн 40 тоо ширхэг, лабораторийн тавилга нийт 64,870,000 төгрөгөөр нийлүүлэгдсэн. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	144		2.2.в. в/бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан хөдөө аж ахуйн тэргүүлэх бүсүүдэд дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын тайван бүсийн үзүүлэлтийг тогтоож, тогтвортой хадгалах;	2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо зохион байгуулагдсан Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын 92 дахь удаагийн Ерөнхий чуулганы хуралдааны үеэр Монгол Улсын шүлхий өвчинтэй тэмцэх албан ёсны хяналтын хөтөлбөрийг батламжилж, гэрчилгээг гардан авсан байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад жил бүр тайлагнаж, цаашдаа шүлхий өвчингүй, тайван улс болох зорилт тавин ажиллаж байна. Мөн Үхрийн цээж өвчнөөр тайван бүсийн үзүүлэлтийг тогтвортой хадгалж байна. Монгол Улсыг үхрийн цээж өвчний байгалийн халдваргүй, тайван статусыг хадгалах стратегийн хэрэгжилтийн тайланг ДМАЭМБ-д хүргүүлэх ажлын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан зааврын дагуу майл болон тусгай мэдээллийн системээр илгээсэн. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн гүйцэтгэлд үнэлгээ хийж, тайланг 2024 оны 10 дугаар сард ДМАЭМБ-д хүргүүлсэн. Үр нөлөө : Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бүс нутгийн болон олон улсын худалдааны чөлөөт байдлыг хангах, зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	145		2.2.г. г/малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгож, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;	"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны А/80 дугаар тушаалаар “Амьд малын төвлөрсөн цэгийг боломжит бүсэд байгуулах судалгаа хийх, бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгуулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж дор дурьдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу гадаад улс орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын талаарх судалгаа, Амьд мал болон мах худалдаалах зах зээлийн суурь судалгаа, Малын төвлөрсөн цэг байгуулах боломжит бүс, байршлын талаархи судалгаа, Мал, махны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагыг төрөөс дэмжиж буй урамшуулал, дэмжлэгийн талаар, Малын тэжээлийн норм норматив, махны стандарт, үйл ажилллагаанд мөрдөж буй стандартуудын талаар тус тус судалгааны ажлуудыг хийн нэгтгэсэн. - 10 га газар амьд малын захын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг, төсвийн	Ахиц гарсан - 50%

				үнийн саналыг “зураг төслийн ажлын жишиг үнэ” БД 81-16-20-ийн дагуу тооцож боловсруулан аж ахуйн нэгжүүдээс холбогдох саналыг авсан. Үр нөлөө : -	
	146		2.2.д. д/түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлж, гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх, экспортлохыг дэмжих;	1) түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлэх ажлын хүрээнд А) Хонь, тэмээний ноос, сарлагийн хөөвөрт мөнгөн урамшуулал олгох цахим программыг хөгжүүлэв (http://43.231.113.221:3000/dashboard/procurement/). Үндэсний үйлдвэрүүдэд 2024 онд 3,495,207.0 кг хонины ноос бэлтгэн тушаасан 14,175 иргэн, 71,388 кг тэмээний ноос бэлтгэн тушаасан 308 малчин, мал бүхий иргэд, 42,620.8 кг сарлагийн хөөвөр бэлтгэн тушаасан 1,443 малчин, мал бүхий иргэдийн урамшуулал, нийт ноосны урамшуулалд шаардагдах 6,545,606,781.0 төгрөгийг ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/648 тоот тушаалыг батлуулав (Хавсралт 1). В) Арьс ширэн түүхий эдэд мөнгөн урамшуулал олгох цахим программыг хөгжүүлэв (http://43.231.113.221:3005). Үндэсний боловсруулах үйлдвэрт 2024 онд 16,089 ширхэг бодын шир, 118,108 ширхэг богийн арьс бэлтгэн тушаасан 3,898 малчин, мал бүхий иргэнд олгох 595,659,000.0 төгрөгийн мөнгөн урамшууллыг олгохоор ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/644 тоот тушаалыг батлуулав (Хавсралт 1). 2) Гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх, экспортлох ажлын хүрээнд А) “MNS 3283:1991 Ноос, ноолуур. Үйлдвэрлэл. шивмэл эсгий. Техникийн шаардлага”, “Ноос, ноолуур. Хялгас. Техникийн шаардлага. MNS 0037:2007”, “Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн технологийн хаягдал. Зумласан ноос. Стандартын техникийн шаардлага. MNS 5251:2008” стандартыг тус тус шинэчлэн батлав (Хавсралт 2). В) Өвөрхангай, Архангай, Хөвсгөл аймгуудад ХААБиржийн туршилтын арилжааг зохион байгуулав. Архангай аймагт 200 ширхэг үхрийн шир, Өвөрхангай аймагт 1,000 ширхэг хонины нэхий, суффолк хонины 20 ширхэг нэхий, Мирно хонины 20 ширхэг нэхий, Хөвсгөл аймагт 500 ширхэг үхрийн ширний туршилтын арилжааг тус тус зохион байгуулав (Хавсралт 3). Хавсралт : 3 файл Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	147		2.2.е. е/түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг стандартын дагуу түүхий эд бэлтгэхэд чадавхжуулах, мэргэшүүлэх.	1) Баянхонгор аймгийн Бөмбөгөр суманд “Ноолуурын чанар ба бэлтгэн нийлүүлэлт” сэдэвт зөвлөлдөх уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг сургалт, хэлэлцүүлэгт (малчид, хоршоодын төлөөлөл, ноолуур бэлтгэн нийлүүлэгчид): 60 хүн, 20 хоршоо, 60 малчин өрхийн төлөөлөл хамрагдсан бөгөөд оролцогчид ноолуурын чанар, бэлтгэн нийлүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, зах зээлийн шаардлага, үндэсний боловсруулах үйлдвэрийн хэрэгцээ, “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжиж буй бодлого, дэмжлэгийн талаар нэгдсэн ойлголт авсан. 2) МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор “Алтан хайч-2025” хонь ноослогчдын улсын аварга шалгаруулах анхдугаар тэмцээнийг Төв аймгийн Зуунмод хотноо 2025.06.20-21-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг тэмцээн хонины ноосны үнэ цэнийг өсгөх, хаягдалгүй ашиглах, ноосон бүтээгдэхүүний эцсийн үйлдвэрлэлийг дэмжих зорилготой төдийгүй малчдын хөдөлмөрийг хөнгөвчилж, цаг хугацааг хэмнэсэн техник, технологийг нэвтрүүлэх, сурталчлах, таниулах, түүнийг эзэмшсэн залуусыг урамшуулснаараа онцлогтой. “Алтан хайч-2025” тэмцээнийг уламжлалт гар хайч болон цахилгаан хайчаар ахлан суралцагч, мэргэжлийн гэсэн 3 төрлөөр зохион байгуулсан бөгөөд 21 аймгийн 100 гаруй малчин, тамирчид хурд хүч, ур чадвараа сорин өрсөлдсөн. Тус тэмцээнийг ЕТГ, ХХААХҮЯ, Төв аймгийн ЗДТГ, ЖДҮГ болон “Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо” “Монголчуудтай туршлага хуваалцая, үнэ цэнэ бүтээе” ТББ-ууд хамтран зохион байгуулж, ноосон бүтээгдэхүүний загварын шоу, шагайн болон сур харваа жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа зэрэг арга хэмжээг зохион байгуулав. 3) "Арьс ширэн түүхий эд бэлтгэл-2025" Төвийн бүсийн Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн 20 сум, Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн 47 сум, Хангайн бүсийн Өвөрхангай, Архангай аймгийн 38, Хойд бүсийн Хөвсгөл аймгийн 23 сум, нийт 128 сумын салбар хариуцсан мэргэжилтнүүд, хоршоод, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгчид нийт 461 оролцогчдыг хамруулан 2025.10.12-27-ны хороонд зохион	Хэрэгжсэн - 100%

				байгуулав. Хавсралт : 39 зураг Үр нөлөө : -	
	148		2.3.а. а/түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд татвар, зээлийн хүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх;	Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн улс орон даяар амжилттай хэрэгжиж, бодит үр дүнгүүд гарч эхлээд байна. Хөдөлгөөний хүрээнд 2025 онд үндэсний үйлдвэрлэгчдэд хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийн зориулалтаар нийт 501.0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж, дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд: - “Цагаан алт” хөдөлгөөний бодит үр дүнгийн нэг илрэл нь ноолуурын үйлдвэрлэлийн салбарт анх удаа түүхий эдийн 70 хувийг дотоодын үйлдвэрлэгчид бэлтгэсэн амжилт бөгөөд энэ нь малчид, хоршоод, үндэсний үйлдвэрүүдийн уялдаа холбоо сайжирсны тод жишээ болж байна. Мөн манай улс ноос, ноолууран түүхий эдийн нэмүү өртөг шингээх анхан шатны боловсруулалтын буюу угаах, самнах дамжлагын хүчин чадлаар дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах түвшинд хүрч, цаашлаад үйлдвэрлэлийн дараагийн шатны хөгжлийг эрчимжүүлж байна. - Үндэсний үйлдвэрүүдийн ээрэх хүчин чадлыг 700 тонн, сүлжмэлийн хүчин чадлыг 250 мянган ширхэгээр тус тус нэмэгдүүлсэн бол хивс нэхэх хүчин чадлыг 200 мянган квадрат метр, ноосон дулаалгын үйлдвэрлэлийн хүчин чадлыг 3 мянган квадрат метрээр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлээд байна. - Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт ч ахиц дэвшил гарч, жилд 1.1 сая хос гутал үйлдвэрлэх хүчин чадал бүрдсэнээс гадна уургийн гаралтай хаягдлыг бүрэн боловсруулж, 4.8 мянган тонн желатин үйлдвэрлэх үйлдвэрүүд байгуулагдан, түүхий эдийг иж бүрэн ашиглах шинэ шатанд гарч байна. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	149		2.3.б. б/олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлберийг бүсийн онцлогт тулгуурласан үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахад чиглүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн Аж үйлдвэржилтийн сэргэлтийн бүлгийн 3.4.2-т заасан Баруун бүсэд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шинэ ховд үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахаар тусгаад байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоолоор батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний 3.2-т Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэхээр баталсан. Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн төслийн хөрөнгө оруулалт 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2026 онд бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусахаар төлөвлөсөн. Тус төслийг нийт төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг бөгөөд 5-н багц арга хэмжээнд хувааж Оффроүд таван богд ХХК, Воком констракшн ХХК, Эм Ай Эс Эс ХХК, Монкабель ХХК, Жаргалантлуу ХХК тус тус гүйцэтгэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 90.8 хувьтай. Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	150		2.3.в. в/эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэхэд чиглэсэн бодлогоор дэмжиж, үндэсний үйлдвэрүүдийг олон улсын томоохон үзэсгэлэнд тогтмол оролцоход дэмжлэг үзүүлэх;	2025 оны жилийн эцсийн байдлаар үндэсний болон олон улсын чанартай дараах үзэсгэлэн худалдаанд дэмжлэг үзүүлж болон зохион байгуулж ажиллав. 1) Итали улсын Милан хотноо 2025 оны 02 дугаар сард Монголын ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид Миланы загварын долоо хоногт анх удаа оролцлоо. Уг арга хэмжээний хүрээнд Монголын ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, үйлдвэр аж ахуйн нэгжийн төлөөллүүд Итали улсын нэхмэлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч томоохон аж ахуйн нэгжүүдтэй уулзан холбогдох гэрээ хэлэлцээрүүдийг байгуулан ажилласан. https://www.facebook.com/share/v/1AxKQfJcfa/?mibextid=oFDknk 2) 2025 оны 05 дугаар сарын 28-30-	Хэрэгжсэн - 100%

				ны хооронд БНХАУ-ын Гуанжоу хотод зохион байгуулагдсан “GISMA 2025-Guangdong International Intelligent Shoe Machine Equipment Exhibition” үзэсгэлэнд арьс шир боловсруулах, гутал, хувцас үйлдвэрлэгч Дархан нэхий ХК, Булигаар ХК-ууд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ танилцуулан оролцов. Мөн салбарын 30 гаруй гутал үйлдвэрлэгчид гутал үйлдвэрлэлийн дэвшилтэт тоног төхөөрөмж судлахаар тус үзэсгэлэн худалдаанд оролцов. 3) “Монгол-Хятадын V экспо” БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-ы Хөх хотноо 2025.08.25-29-ны өдөр болж өнгөрсөн. Уг арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар ХХААХҮЯ ажиллалаа. Уг экспод Монгол Улсаас 350 гаруй аж ахуйн нэгж ноос, ноолуур, арьс шир, гоо сайхан, бэлэг дурсгал, арьсан эдлэл, хүнс зэрэг 700 гаруй нэр төрлийн органик бараа бүтээгдэхүүнтэй оролцсон. 4) АНУ-ын Нью Йорк хотод жил бүр намар, өвөл зохион байгуулагддаг "Fashion Coterie 2025" үзэсгэлэн 9-р сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулагдав. Уг үзэсгэлэнд 95 орны 13,000 борлуулагч, худалдан авагчид болон 1,200 гаруй брендүүд оролцдог бөгөөд Монголын ноос ноолуурын холбоо, ноолуурын компаниудын хамтаар 11 дэх жилдээ тогтмол оролцож байна. Хавсралт нийт : 22, Файл : 2 Зураг : 20	
	151		2.3.г. г/байгаль орчин, мал амьтанд ээлтэй, тохирлын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцыг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх;	ХХААХҮЯ, Монголын ноос ноолуурын холбоотой хамтран ажиллах 250527/06-438 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан ба энэхүү гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд: 1. Монгол Улсын экспортын чиг баримжаатай ноос, ноолууран бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах, бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, бизнес эрхлэгчид хамтран ажиллах, туршлага солилцох нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотод жил бүр уламжлан зохион байгуулагддаг “Apparel, accessoties & footwear Coterie” нэхмэлийн салбарын үзэсгэлэнд 2025 оны 09 дүгээр сарын 14-16-ний өдрүүдэд үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд оролцож монгол ноолуурыг сурталчлан таниулсан. https://www.facebook.com/share/p/1AvGbLdGUu/ 2. Тогтвортой текстилийн үйлдвэрлэл шаардлагыг хангасан 17, Монголын хаан ширхэгт чанарын шаардлагыг хангасан 8 хуулийн этгээдийг баталгаажуулалтад хамруулан гэрчилгээ олгосон. Шинжээчийн давтан сургалтад 16 шинжээч хамрагдаж, аудит хийх эрхээ сунгуулсан. 5 шинжээч шинээр бэлтгэсэн. Хавсралт нийт : 10, Файл : 4 Зураг : 6 Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	152		2.3.д. д/нэмүү өртөг шингэсэн, байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, байгаль орчинд эерэг нөлөөтэй, зохистой дадал, стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг ногоон санхүүжилтэд хамруулах, арга туршлагыг нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулах;	1) "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд хөнгөлөлттэй зээл олгоход ногоон зээлийн хүүгийн асуудлыг тусгасан. Сангийн яам, Монголбанктай хамтран байгуулах хүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд ногоон зээлийн талаар ".... Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн дэмжлэг жилийн 10 нэгж хувь, зээлдэгчийн төлөх хүүгийн хэмжээ жилийн 6 нэгж хувиас хэтрэхгүй байна" гэж тусгаж оруулсан. 2025 оны хагас жилийн байдлаар 9 аж ахуйн нэгж 74.9 тэрбум төгрөгийн Ногоон зээлийн санхүүжилтээр хөнгөлөлттэй зээлд хамрагдаад байна. 2) Байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг олон нийтэд таниулах арга хэмжээний хүрээнд Мянганы сорилтын сантай хамтран "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааны талаар таниулан сурталчлах кампанит ажлыг зохион байгуулж ААН-үүдийг оролцуулан медиа контент, рийлс, богино видео, сошиал постерууд, радио реклам хийж байгаа бөгөөд Мон-Ирээдүй ХХК, Монгол шевро ХК оролцоод байна. https://www.youtube.com/watch?v=6f99unc8Pqw&t=2s&fbclid=IwY2xjawLIRNtleHRuA2FlbQIxMQBicmlkETE3cGI1eVBVT1QyUHhrUHE1AR4OUnVgU5pczvoDxdCTkeZNE8uNV4bFaI05l-6ehIDi8rVfzaLgjyh82spQbg_aem_6DipaIMNeC0zCTOfGcXmJA 3) Арьс шир, ноос ноолуурын салбарын Нэмүү өртөг шингэсэн, байгаль орчинд ээлтэй шинэ, дэвшилтэд технологи, стандарт нэвтрүүлж буй аж ахуйн нэгж, Үйлдвэрийн үйл ажиллагаанд байгальд ээлтэй технологи, хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах технологи нэвтрүүлсэн арьс, ширний гүн боловсруулах	Ахиц гарсан - 50%

				болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгчдийг сурталчлах кампанит ажлыг зохион байгуулж ААН-үүдийг оролцуулан медиа контент, рийлс, богино видео хийхээр гэрээ байгуулан ажилласан.	
	153		2.3.е. е/үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэлт, байгаль орчинд ээлтэй тогтолцооны болон зохистой дадлын стандартын хэрэгжүүлэлт, баталгаажуулалт зэрэг үйлдвэрлэлийн хөгжил, дэвшлийн талаарх мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;	1) ЕТГ-тай хамтран арьс шир, ноос, ноолуурын үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэлт, байгаль орчинд ээлтэй тогтолцооны болон зохистой дадлын стандартын хэрэгжүүлэлт, баталгаажуулалт хийсэн 10 үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн хөгжил, дэвшлийн талаарх мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан (https://www.facebook.com/profile.php?id=61572790192581). 2) Байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг олон нийтэд таниулах арга хэмжээний хүрээнд Мянганын сорилтын сантай хамтран "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааны талаар таниулан сурталчлах кампанит ажлыг зохион байгуулж ААН-үүдийг оролцуулан медиа контент, рийлс, богино видео, сошиал постерууд, радио реклам хийж байгаа бөгөөд Мон-Ирээдүй ХХК, Монгол шевро ХК, Их-Эргэлт ХХК оролцоод байна (https://www.facebook.com/profile.php?id=61576283843505, https://www.youtube.com/watch?v=6f99unc8Pqw&t=2s&fbclid=IwY2xjawLIRNtleHRuA2FlbQIxMQBicmlkETE3cGI1eVBVT1QyUHhrUHE1AR4OUnVgU5pczvoDxdCTkeZNE8uNV4bFaI05l-6ehIDi8rVfzaLgjyh82spQbg_aem_6DipaIMNeC0zCTOfGcXmJA) 3) Арьс шир, ноос ноолууры салбарын Нэмүү өртөг шингэсэн, байгаль орчинд ээлтэй шинэ, дэвшилтэд технологи, стандарт нэвтрүүлж буй аж ахуйн нэгж, Үйлдвэрийн үйл ажиллагаанд байгальд ээлтэй технологи, хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах технологи нэвтрүүлсэн арьс, ширний гүн боловсруулах болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгчдийг сурталчлах кампанит ажлыг зохион байгуулж ААН-үүдийг оролцуулан медиа контент, рийлс, богино видео хийхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Хавсралт : 5 зураг Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	154		2.3.ж. ж/"Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилтийг түүхий эдийн нөөцийн зохистой харьцаагаар хангасан, нэмүү өртөг бий болгох үйлдвэрлэлд түлхүү чиглүүлэх;	1.Ноолуурын ээрэх үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авахаар 3 аж ахуйн нэгжид 14,4 тэрбум төгрөгийн зээл олгосон. Ингэснээр хүчин чадал 400 тн-оор нэмэгдэх боломжтой болсон. Тус 3 аж ахуйн нэгж тус бүртэй хяналтын гэрээ байгуулсан ба Сноу филдс ХХК тоног төхөөрөмжөө оруулан ирж суурилуулсан, Сор кашемир ХХК-ийн эхний тоног төхөөрөмжүүд орж ирэн суурилуулалт эхэлж байна. Өгөөж шим ХХК захиалга өгч ачигдаж эхэлсэн. 2.Ноосны хөрөнгө оруулалтын чиглэлээр 50,4 тэрбум төгрөгийн зээл олгож 25 хяналтын гэрээ байгуулсан. Ээрэхийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 8.5 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь хүчин чадлыг 300 тн, хялгас ялгахын хөрөнгө оруулалтын зориулалтаар 9.3 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь хүчин чадлыг 530 тн, сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах хөрөнгө оруулалтын зориулалтаар 21.1 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь нэхэх /хивс/ хүчин чадлыг 200 мянган м.кв, сүлжих хүчин чадлыг 50 мянган ширхэгээр, ноосон дулаалгын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 297 сая төгрөгийн зээл олгогдсон нь 3 мянган м.кв нэмэгдүүлэх боломжийг тус тус бүрдүүлээд байна. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	155		2.3.з. з/малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх.	ХХААХҮЯ, Монголын ноос ноолуурын холбоотой хамтран ажиллах 250527/06-438 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан ба энэхүү гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд: 1.Малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ноолуурын чанарыг орон нутгийн байршилтай нь холбож судлах, шилжилгээнд хамруулах, МУ-д бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэхэд шаардлагатай судалгаа хийх ажил гүйцэтгүүлэхээр "Монголын ноос ноолуурын холбоо" ТББ-тай байгуулсан 251107/06-883, МУ-д бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад	Хэрэгжсэн - 100%

				бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичиг боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажил гүйцэтгүүлэхээр "Монголын ноос ноолуурын холбоо" ТББ-тай байгуулсан 251107/06-884 дугаар гэрээнүүдийг байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Япон улсын Токио хотод 2025.03.11-03.14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан FOODEX JAPAN 2025" үзэсгэлэнд Хаан жимс ХХК, Шар доктор ХХК нь чацарганын бүтээгдэхүүн, Нордроуд ХХК-ийн хушны самар болон бусад бүтээгдэхүүнээр оролцсон. Эдгээр ААН-ийг үзэсгэлэнд оролцох бэлтгэх ажлыг хангах төлөвлөгөө боловсруулан экспортод гаргах бараа бүтээгдэхүүний сав баглаа, боодол болон тээвэрлэлтийн талаар үе шаттай сургалтад хамруулсан. Хаан жимс ХХК нь үзэсгэлэнгийн хугацаанд чацарганы охь, нэрсний охь, чацарганы 2 төрлийн тос, болон аньсны амтлаг охь, "Өглөөний мэнд" чацарганы нухаш гэсэн нийт 6 нэр төрлийн бүтээгдэхүүнийг танилцуулж, 1034 зочид амталгаа хийж зочилсноос 86 орчим ААН, иргэдтэй нэрийн хуудас солилцож, бүтээгдэхүүнээ сурталчилсан. Уг үзэсгэлэнд Япон улсын ААН, иргэд 79,1%- ийг эзэлж, бусад нь БНХАУ, БНСУ иргэд, ААН оролцсон. Нордроуд ХХК нь "FOODEX JAPAN 2024" үзэсгэлэнд оролцсоны үр дүнд БНХАУ-ын Тайванын Eastern Home shopping&Leisure компанитай амжилттай гэрээ байгуулж, экспортын зах зээлээ тэлэн 200,000 гаруй долларын борлуулалт хийсэн. Хавсралт : 5 файл	
	156		2.4.а. а/үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт /ҮАМАТ-08/ болон сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах;	Улсын стратегийн ач холбогдолтой, экспортын баримжаатай Ноолуурын салбарт олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, суурь зарчимд нийцсэн цалин хөлсний нэгдсэн системийг нэвтрүүлэх зорилгоор МННХ, Монголын хөнгөн үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн холбоо, ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сан хамтран "Тарифын хэлэлцээр" төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Уг төслийн хүрээнд ноолуурын салбарын 230 гаруй ажил мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолтуудыг үйлдвэрлэлийн шат, дамжлага бүрээр нарийвчлан гаргаж, Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолтод нийцүүлэн, ажил мэргэжил бүрт тавигдах мэдлэг, ур чадварын шаардлага, хүчин чармайлт, хариуцлага, хөдөлмөрийн нөхцөл зэрэг шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн бүлэглэж, цалингийн итгэлцүүрийг тогтоон, ажил мэргэжлийг үнэлэх аргачлал, ноолуурын салбарын жишиг цалин хөлсний тарифын сүлжээг боловсруулан ажил олгогч нарт ноос ноолуурын холбооноос хүргүүлээд байна. Монголд анх удаа олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцүүлсэн тарифт цалингийн хамтын хэлэлцээрийг байгуулж байна. Уг цалингийн системийг салбарын түвшинд нэвтрүүлснээр ноолуурын салбарт зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай ШУ-ны үндэслэл бүхий цалин хөлсний нэгдсэн системтэй болох, МУ-н нэгдэн орсон Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцуудыг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хөдөлмөрийн зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжих,ажилтны мэргэжил, ур чадварыг хэмжих, үнэлэх, хөдөлмөрийн норм, норматив тогтоох арга хэрэгсэл илүү нарийвчлагдаж, боловсронгуй болох зэрэг эерэг үр нөлөөтэй юм. Тарифын хэлэлцээрээр нэг талаас ажилтны төлөөлөл, нөгөө талаас ажил олгогчдын төлөөлөл нийгмийн түншлэлийн хүрээнд, хэлэлцээр хийх замаар цалин хөлсийг тухайн жилийн салбарын эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлтэй уялдуулан илүү ШУ-ы үндэслэлтэйгээр тогтоодог бөгөөд энэхүү хэлэлцээрийг дагаж мөрдөж буй ААНБ-ууд хөдөлмөрийн хүрээний суурь эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх хамгийн сонгодог тогтолцоо юм. Үр нөлөө : -	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	157		2.4.б. б/гадаадын өндөр хөгжилтэй оронд инженер, техникийн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, "Ерөнхийлөгчийн илгээлт 2100" хөтөлбөрт хамруулах;	"Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний төсөлд Ерөнхийлөгчийн илгээлтэд нарийн мэргэжлийн ажилтнуудыг дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцуулах саналыг тусгав. Энэ хүрээнд Ерөнхийлөгчийн илгээлтийн хүрээнд хөрс судлал мэргэжлээр 1, дэлхийн шилдэг сургуульд суралцах зээлийн хүрээнд агрономи мэргэжлээр 1, Засгийн газрын тэтгэлгийн хүрээнд хөдөө аж ахуйн кибернетик мэргэжлээр 2, сургалтын зээлийн хүрээнд 7 мэргэжлээр 48(мал зүй 2, тэжээл бэлчээр судлал 7, аграномн 15, хөрс судлал 2, ургамал хамгаалал 2, ойн аж ахуй 9, мал эмнэл зүй 11) буюу нийт 9 мэргэжлээр 52 оюутан боловсролын	Хэрэгжсэн - 100%

				зээлийнсангийн 642.4 тэрбум төгрөгөөр гадаадын их, дээд сургуульд суралцаж байна. Үр нөлөө : -	
	158		2.4.в. в/бүсийн үйлдвэрлэлийн чиглэлтэй уялдуулан салбарын хүний нөөцийг коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд сургах, нарийн мэргэжлийн ажилтнуудыг дотоод, гадаадын их, дээд сургууль, коллежид суралцахад дэмжлэг үзүүлэх;	1. “Design Vitality Festival – 2025” олон улсын бүтээлч наадмыг ШУТИС-ын Хүнс, Хөнгөн Үйлдвэрлэл, Дизайны сургуулиас зохион байгууллаа. Текстилийн салбарын инженер, технологич, дизайнер, загвар зохион бүтээгч зэрэг салбарын академик боловсролыг олгодог үндсэн мэргэжлийн сургуулийн үйл ажиллагааг дэмжих, залуусын чөлөөт сэтгэлгээ, уран сэтгэмжийг хөгжүүлэх, бүтээлч сэтгэлгээг дэмжих зорилготойгоор Design Vitality наадмын “Олон улсын эрдэм шинжилгээний хурал”-ыг Монголын ноос ноолуурын холбооноос ивээн тэтгэгчээр оролцлоо. 2. НҮБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллага, БНСУ-ын Засгийн Газрын санхүүжилттэй, Монголын ноолуурын салбарт ажиллаж буй залуучуудын ур чадвар болон техник, мэргэжлийн боловсрол нэмэгдүүлэх, сургалтын байгууллагын төгсөгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, ажил олгогч, залуу ажилтны хооронд соёл ойлголтын зөрүүг арилгах, ажил олгогч, ажилтны хамтын ажиллагааг сайжруулах замаар шийдэл олж хэрэгжүүлэх зорилготой “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл нээлтээ хийсэн. Уг төсөл нь 2024 оны 7-р сараас 2026 оны 12-р сар хүртэл хэрэгжих бөгөөд төслийн түншлэгч талуудаар Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагууд, Монголын ноос ноолуурын холбоо, Монголын хөнгөн үйлдвэрийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, сургалтын байгууллагууд болон БНСУ-ын талаас БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний агентлаг (KLES) БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн үйлчилгээний агентлаг (KEIS) нар ажиллаж ноолуур, зочлох үйлчилгээний салбарын ажил олгогчид, залуу ажилчдад чиглэн хэрэгжих юм. Төслийг 5 үйлдвэрт хэрэгжүүлсэн. ttps://www.mofa.gov.mn/news/TIME/691d40bf07a19340d6cb0aa0?fbclid=IwdGRjcAPF2IdjbGNrA8XYWGV4dG4DYWVtAjExAHNydGMGYXBwX2IkDDM1MDY4NTUzMTcyOAABHhNyRxvu0JCKgEMi__xWoa8xaiWXuq2TugOVbNpleaDv6E5mU5CdKBCUQ4AW_aem_LhTZYMdu0b5pz3kowbEo7Q Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	159		2.4.г. г/Улаанбаатар хотоос орон нутгийн хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллахаар шилжин суурьших иргэдийг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах;	1. "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд “АРЬС, ШИР, НООС НООЛУУРЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ” ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРийг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран хэрэгжүүлэхээр төслийг боловсруулж, батлуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Энэхүү хөтөлбөр батлагдан хэрэгжиснээр “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний зорилт арга хэмжээтэй уялдуулан малын гаралтай түүхий эд (арьс, шир, ноос, ноолуур)-ийн анхан шатны боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг орон нутагт хөгжүүлэх, хоршоонд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээний сүлжээг өргөжүүлэх, тогтвортой ажлын байр шинээр бий болгох боломжийг бүрдүүлэх юм. Хөтөлбөрийн төслийг хавсаргав. 2. ЖДҮХС-ийн хөнгөлөлтэй зээлд 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 324 аж ахуйн нэгжид 47.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг олгосон ба үүнээс 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхийн 10 аж ахуйн нэгж нь нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан ба төслийг хэрэгжүүлснээр 31 ажлын байрыг шинээр бий болгож, 45 ажлын байрыг хадгалж байна. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%
	160		2.4.д. д/үндэсний ажил мэргэжлийн стандарт ба цалин хөлсний бодлогыг боловсруулах, ажилтнуудын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, хүн төвтэй зохистой хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэх Тарифын хэлэлцээр боловсруулж, хэрэгжүүлэх.	Улсын стратегийн ач холбогдолтой, экспортын баримжаатай Ноолуурын салбарт олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, суурь зарчимд нийцсэн цалин хөлсний нэгдсэн системийг нэвтрүүлэх зорилгоор МННХ, Монголын хөнгөн үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн холбоо, ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сан хамтран “Тарифын хэлэлцээр” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Уг төслийн хүрээнд ноолуурын салбарын 230 гаруй ажил мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолтуудыг үйлдвэрлэлийн шат, дамжлага бүрээр нарийвчлан гаргаж, Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолтод нийцүүлэн, ажил мэргэжил бүрт тавигдах мэдлэг, ур чадварын шаардлага, хүчин чармайлт, хариуцлага, хөдөлмөрийн нөхцөл зэрэг шалгуур	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				үзүүлэлтүүдэд үндэслэн бүлэглэж, цалингийн итгэлцүүрийг тогтоон, ажил мэргэжлийг үнэлэх аргачлал, ноолуурын салбарын жишиг цалин хөлсний тарифын сүлжээг боловсруулан ажил олгогч нарт ноос ноолуурын холбооноос хүргүүлээд байна. Монголд анх удаа олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцүүлсэн тарифт цалингийн хамтын хэлэлцээрийг байгуулж байна. Уг цалингийн системийг салбарын түвшинд нэвтрүүлснээр ноолуурын салбарт зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай ШУ-ны үндэслэл бүхий цалин хөлсний нэгдсэн системтэй болох, МУ-н нэгдэн орсон Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцуудыг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хөдөлмөрийн зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжих,ажилтны мэргэжил, ур чадварыг хэмжих, үнэлэх, хөдөлмөрийн норм, норматив тогтоох арга хэрэгсэл илүү нарийвчлагдаж, боловсронгуй болох зэрэг эерэг үр нөлөөтэй юм. Тарифын хэлэлцээрээр нэг талаас ажилтны төлөөлөл, нөгөө талаас ажил олгогчдын төлөөлөл нийгмийн түншлэлийн хүрээнд, хэлэлцээр хийх замаар цалин хөлсийг тухайн жилийн салбарын эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлтэй уялдуулан илүү ШУ-ы үндэслэлтэйгээр тогтоодог бөгөөд энэхүү хэлэлцээрийг дагаж мөрдөж буй ААНБ-ууд хөдөлмөрийн хүрээний суурь эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх хамгийн сонгодог тогтолцоо юм. Үр нөлөө : -	
	161		3. 3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүжилтийг "Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй уялдуулан ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	Уур амьсгалын ногоон сан (Green Climate Fund)-ийн санхүүжилтээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон UNDP in Mongolia - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нар хамтран хэрэгжүүлж буй "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" (АДАПТ) төсөлтэй хамтран "Монголын Хаан Ширхэгт" чанарын тэмдэг, "Тогтвортой текстилийн үйлдвэрлэл" тогтолцооны гэрчилгээ, бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ болон ноос ноолуурын салбарын баталгаажуулалтыг олон улсад сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх талаар хамтран ажиллаж байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор тус төслөөс зөвлөх үйлчилгээний 2 тендер зарлаж шалгаруулсан.	Хэрэгжсэн - 100%
	162		4. 4.Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган, хэрэгжилт, үр дүнг Монгол Улсын Их Хуралд жил бүр танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Ж.Батжаргал/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Г.Ганболд/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.	“Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны улсын төсөвт 788.9 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт батлагдсан бөгөөд эргэлтийн хөрөнгөд 400.0 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зээлд 388.9 тэрбум төгрөг, эргэлтийн болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийн Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн хөнгөлөлтөд 66.4 тэрбум төгрөг тусгаад байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилгоор үйлдвэр аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч эргэлтийн хөрөнгийн 379.3 тэрбум төгрөгийн 117 хяналтын гэрээ, хөрөнгө оруулалтын зээлийн 120.8 тэрбум төгрөгийн 56 хяналтын гэрээ, нийт 500.1 тэрбум төгрөгийн 173 зээлийн хяналтын гэрээг албажуулаад байна. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
40	163	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2024-08-27 Дугаар 2024_21	2.3. 3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд ХХААХҮ-ийн салбарт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2025 онд 662.6 тэрбум төгрөг үүнд: урсгал зардал 618.8 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 56.2 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 12.4 тэрбум төгрөгийг батлуулсанаас 2025.11.30-ний өдрийн байдлаар 278.5 тэрбум төгрөг хүлээгдэж буй гүйцэтгэл 376.9 тэрбум төгрөг байна. Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	164		2.4. 4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах 4 бодлогын хүрээнд үндсэн хэрэгжүүлэх 12 зорилго 47 зорилтын 129 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 76.29%, бусад салбартай хамтран хэрэгжүүлэх 32 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 81.2%-тай тус тус 2025 оны жилийн эцсээр үнэлэгдсэнийг https://new.unelgee.gov.mn/govplan/ цахимд баталгаажуулсан.	Хэрэгжсэн - 100%

41	165	Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай 2025-05-30 Дугаар 2025_49	2. 2.Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.	Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийг ханган ажиллахаар 2026 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Үр нөлөө : -	Х.Б
42	166	Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай 2025-06-19 Дугаар 2025_57	1.10/. 10/Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох зээлийн багцын 50-аас доошгүй хувийг ногоон барилга, барилгын материал үйлдвэрлэгч, эрчим хүчний хэмнэлт бий болгох чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч, ногоон барилгын баталгаажуулалт хийх иргэн, аж ахуйн нэгжид олгох ажлыг зохион байгуулах;	ЖДҮХС-ийн хөнгөлөлтэй зээлд 2025.12.25-ны өдрийн байдлаар 324 аж ахуйн нэгжид 47.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг олгосон. Үүнээс 3.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан 21 аж ахуйн нэгж нь барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр төсөл хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлснээр 118 ажлын байрыг нэмэгдүүлж, 90 ажлын байрыг хадгалж байна. Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
43	167	Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-06-25 Дугаар 2025 №60	1.1/. "1.Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжиж үнийг зохистой түвшинд тогтворжуулах зорилгоор импортоор оруулах мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонтой холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай: 1/Өрсөлдөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Худалдааны тухай болон Демпингийн эсрэг хуулийн төслийг тус тус боловсруулж, 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;"	1. Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолд Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Худалдааны тухай анхдагч хуулийг Эдийн засаг хөгжлийн яамнаас ахлан боловсруулж 2027 онд өргөн мэдүүлэхээр тусгагдсан. Энэ хүрээнд байгуулагдсан ажлын хэсэгт салбарын яамнаас холбогдох мэргэжилтнүүд ажиллаж байна. 2.Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын Даргын захирамжаар 2024 оны 11 дүгээр сард Ц.Сандаг-Очир гишүүнэр ахлуулан байгуулсан ба 2025 оны 4 дүгээр сараас Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг ахлан ажиллаж байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандын ахалсан ажлын хэсэг 2024 оны 25 дугаар тушаалаар байгуулагдсан байна. Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсронгуй болгох үүрэг бүхий дээрх хоёр ажлын хэсэг нь хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл шинэчилсэн найруулга хийх эсэхийг тохирох, нэгдсэн нэг ажлын хэсэг байгуулах талаар зарчмын асуудлыг тохирохоор ажиллаж байна. Үр нөлөө : -	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	168		1.2/. 2/улсын стратегийн нөөцөд шаардлагатай 100.000 тонн улаанбуудайн нөөцийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх;	ХААК ТӨХХК-д 2025 оны эхний үлдэгдэл 73.5 мянган тонн хүнсний улаанбуудайн нөөцтэй байснаас одоогийн байдлаар 68.1 мянган тонныг гурил үйлдвэрлэлд худалдан борлуулж 5.4 мянган тонныг үлдэгдэл нөөцтэй байна. 2025 оны дотоодын шинэ ургацаас 7.4 мянган тонн үрийн буудай, 29.5 мянган хүнсний улаанбуудайн нөөцийг бүрдүүлсэн. Үр нөлөө : -	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	169		1.3/. 3/гурил үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний улаанбуудайн чанарыг итгэмжлэгдсэн, лавлагаа лабораторийн сорилтын үр дүнд үндэслэн баталгаажуулах;	УИХ-ын 2025 оны Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 60 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, 2025 оны намрын ургац хураалтын бэлтгэл ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн салбар нэгжүүд болон Гурил үйлдвэрлэгчдийн улаанбуудайн шинжилгээний лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг Стандарт, хэмжил зүйн газрын холбогдох мэргэжилтнүүдээр стандартын дагуу шалгаж, баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Нийт шалгалт, баталгаажуулалтын үйл явцад гурилын үйлдвэрүүдтэй хамтран, багаж тоног төхөөрөмжийн хэмжилтийн үзүүлэлтүүдийг нэг эталон загвар дээр харьцуулсан байдлаар хянан тохируулсан нь улаанбуудайн борлуулалт, нийлүүлэлтийн үеэр тариаланчид болон худалдан авагчдын хооронд лабораторийн шинжилгээтэй холбоотой ангиллын зөрүү гарахаас сэргийлэх, буудайн чанарыг үнэн зөв шинжлэн дүгнэх боломж бүрдэж байгаа юм.	Ахиц гарсан - 50%
	170		1.4/. 4/гурилын үйлдвэрийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлж, улаанбуудайн гурил, үр тариаг	2025 оны ургац хураалтын дүнгээр энэ намрын ургацаас стратегийн нөөцөд “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 27.3 мянган тонн, гурилын үйлдвэрүүд 126.4 мянган тонныг тус тус худалдан авсан. Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 320.0 мянган тонн цэвэр	Хэрэгжүүлэх хугацаа

			татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэн ажиллах;	хүнсний улаанбуудай шаардлагатай бөгөөд 2025-2026 оны гурлын хэрэгцээг хангахад 148.3 мянган тонн хүнсний улаанбуудай дутагдах урьдчилсан тооцоо гарсан. 2025-2026 оны гурилын хэрэгцээг хангахад 148.3 мянган тонн хүнсний улаанбуудай дутагдах урьдчилсан тооцоо гарсан. Мөн Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй гурилын үйлдвэрүүд суурилагдсан хүчин чадлын 30%-ийг ашиглаж байгаа ба бүрэн хүчин чадлаар ажилбал жилд 300 гаруй мянган тонн гурил экспортлох боломжтой байна. Хавсралт : 1 файл	тодорхойгүй
	171		1.5/. 5/баруун бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, гурил, тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийн тогтвортой байдлыг бий болгох, төлөвлөгөө гаргаж, “Атрын 4 дүгээр аян”-ы хүрээнд хэрэгжүүлэх;	ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/264 дугаар тушаалаар Баруун бүсийн газар тариалангийг үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал, нарийвчилсан төлөвлөгөө болосруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Баруун бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, гурил, тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах, цаашид бүс нутгийн хэмжээнд импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд "Баруун бүсийн газар тариаланг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө" болон арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан тухайн бүсээс сонгогдсон УИХ гишүүдээс саналыг авч тусгасан байна. Хавсралт : 2 файл Үр нөлөө : -	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	172		1.6/. 6/алслагдсан бүс нутгийн гурил, тэжээлийн үйлдвэрлэл, хангалтыг хэвийн түвшинд хүртэлх хугацаанд үнийн өсөлтөд голлон нөлөөлж буй тээврийн зардлыг бууруулах, шаардлагатай гурил, малын тэжээлийг тухайн бүс нутгийн хилийн боомтоор оруулж үнийн болон хангалтын тогтвортой байдлыг бий болгох;	Монгол Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн "Тогтоолд нэмэлт оруулах тухай" 112 дугаар тогтоолыг баталсан. Ингэснээр Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор импортлосон Тэжээлийн хөх тариа, Тэжээлийн арвай, овьёос, эрдэнэшиш, хорголжин гаалийн татварт зохицуулалт хийсэн. Ингэснээр 2026 оны дөрөвдүгээр сарын 15 хүртэл гаалийн албан татвараас чөлөөлөхөөр болсон.	Хэрэгжсэн - 100%
	173		1.7/. 7/мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилын хангамж, нийлүүлэлт хомсдох, үндэслэлгүйгээр үнэ өссөнийг эрх бүхий байгууллагаас тогтоосныг үйлдвэрлэгчдэд мэдэгдэх, үйлдвэрлэгчдийн зүгээс холбогдох арга хэмжээ аваагүй тохиолдолд гурил, тэжээлийг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлэх.	2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 9 гурилын үйлдвэрийн дээд зэргийн гурилын дундаж үнэ 2545 төгрөг, нэгдүгээр зэргийн гурил 1878 төгрөг, хоёрдугаар зэргийн гурил 1102 төгрөгийн үнэтэй, зах, худалдааны төвүүдийн гурилын үнийн мэдээг гурилын үйлдвэрийн үнэтэй харьцуулахад Барс худалдааны төвд 10-15 хувь, хүнсний сүлжээ дэлгүүрүүдэд 30-40 хувийн нэмэгдэлтэйгээр борлуулагдаж байна. Энэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад үнэ тогтвортой байгаа тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлэх шаардлага үүсээгүй байна. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
44	174	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2025-06-27 Дугаар 2025 №61	4.. 4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хуульд нийцүүлэн хийж, үнэлгээг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тогтмол байршуулах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод, Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Баасандорж/, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Хүнсний хуулиуд дахь эрх олгосон заалтыг бууруулах, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжуудын давхардал хийдлийг тодорхойлсон үнэлгээг хийлгүүлж тайланг хүлээн авсан байна. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
45	175	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-07-04 Дугаар 2025 №73	1.1/. "1.Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтийг хангуулах, монгол малын генетик нөөцийг хамгаалах, ашиглалтын тогтвортой байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар	Монгол Улсад 2024 оны байдлаар өсгөн үржүүлж байгаа нийт гадаад дотоодын нийт 74 үүлдэр омгийн нийт 57.6 сая толгой мал сүргийн 96.2-99.7 хувийг монгол мал, 0.3-3.8 хүртэл хувийг гадаад улсаас импортлосон цэвэр үүлдрийн болон тэдгээрээр сайжруулсан эрлийз мал тус тус эзэлж байна. Дээрх 10 төрөл зүйлийн мал, тэжээвэр амьтны 74 үүлдрийн 39.4 хувь нь хил дамнасан, 60.6	Х.Б

			/Г.Занданшатар/-т даалгасугай: 1/малын генетик нөөцийн төлөв байдлыг үндэсний хэмжээнд шинэчлэн тодорхойлох ажлыг зохион байгуулж, уг арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулах, цаашид хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг зохион байгуулах;"	хувь нь бүс нутгийн үүлдрүүд байна. Монгол Улсад байгаль, уур амьсгалын онцлогт дасан зохицсон 37 үүлдэр, 4 үүлдрийн хэсэг, 5 үржлийн хэсэг, 13 омог нийт 59 баталгаажсан мал сүргийг өгсөн үржүүлж байна. Тэдгээрийн дотроос хонины 15 үүлдэр, 9 ямааны үүлдэр, үхэр тэмээний тус бүр 5 үүлдэр, адууны 3 үүлдэр батлагдаж орон нутагт сайжруулагч, үндсэн цөм сүргээр тус тус ашиглаж байна. Эдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үнэлэх ажлыг 2026 онд зохион байгууллахаар холбогдох санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Хавсралт : 2 файл Үр нөлөө : -	
	176		1.2/. 2/“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д заасны дагуу бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, дэмжин хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д заасны дагуу Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" 92 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны "Төрөл бүрийнүүлдэр омгийн малыг үржүүлэх бүс байршлыг тогтоох тухай" А/144 тушаалын хүрээнд бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг бүрдүүлэн үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулахаар хувийн "Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж"-ийн үйл ажиллагааны хүртээмжийг сайжруулах, мөн малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлон хамгаалах, шаардлагатай тохиолдолд тухайн бүс нутгийн малын гадаадын өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн мал түүний үржүүлгийн бүтээгдэхүүнээр сайжруулахаар орон нутагт тохирсон бодлогыг хэрэгжүүлэхээр чиглэл хүргүүлэв; Хавсралт : 2 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	177		1.3/. 3/үржлийн адуу, түүний үр, хөврөлийг импортлох тоо хэмжээг 2026-2036 он хүртэлх хугацаанд тэг /“0”/ хувьтай тэнцүү байхаар тогтоох;	Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, малын төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах асуудлыг зохицуулах зорилгоор Улсын Их Хурлын 2025 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 73 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолын 3 дахь хэсэгт "үржлийн адуу, түүний үр, хөврөлийг импортлох тоо хэмжээг 2026-2036 он хүртэлх хугацаанд тэг /"0"/ хувьтай тэнцүү байхаар тогтоох" чиглэлийг Засгийн газарт даалгасан. Энэхүү чиглэлийн дагуу 2026 онд улсын хилээр "Импортлох мал үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл тоо хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд үржлийн адуу, түүний үржүүлгийн бүтээгдэхүүний тоо хэмжээг тогтоохгүй байхаар тусган энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй иргэн аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна. Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	178		1.4/. 4/адуун сүргийн тархац, үүлдэрлэг байдлыг бүс нутгаар гаргах, үржлийн адуунд удам зүйн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх, үндэсний хэмжээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, адуу судлал, төрөлжилт, ашиглалтыг нэгдсэн бодлогоор хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх.	Адуун сүргийн генетик нөөц: Малын генетик нөөцийг төлөв байдлыг тодорхойлсон 2019 оны үндэсний тайланг мал аж ахйн салбарын 2024 оны статистик мэдээлэлтэй харьцуулан дүгнэхэд Монгол Улсын уугуул үүлдэр, омгийн 4.7 сая адуун сүрэг генетик нөөцийн хувьд “эрсдэлгүй” гэж дүгнэгдсэн боловч адуун сүргийн 30.8 хувьд нь ашиг шимийн чиглэлийг нарийвчлан “тогтоох” шаардлагатай гэж шинжээчид дүгнэжээ. Адуун сүргийн ашиглалтын түвшинг авч үзэхэд 2024 оны байдлаар Монгол Улсад үржүүлж буй нийт адуун сүргийн 52.2 хувийг “уналга, махны”, 10.5 хувийг “уналга, сүүний”, 6.5 хувийг “хурдны болон спортын” чиглэлээр өсгөн үржүүлж байна. Үлдсэн 30.8 хувьд ашиг шимийн чиглэлийг нарийвчлан тогтоох шаардлагатай. Адууг үүлдэрлэг байдлаар нь үзвэл нийт адууны 97.5 хувийг Монгол үүлдэр, 1.3 хувийг Тэс үүлдэр, 0.2 хувийг Галшар үүлдэр, 0.3 хувийг Дархад омог, 0.2 хувийг Өндөршил омог, 0.1 хувийг Мянгад омог үлдсэн 0.5 хувийг гадаад улсаас импортлон үржүүлж буй адуу тус тус эзэлж байна. Импортоор авч үржүүлж буй адуунд Англи, Араб, Ахалтехин, Будёный, Орлов, Кабирдин, Оросын хатирч үүлдрийн адуу голлож байна. Эдгээр импортын адууг Төв, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Сүхбаатар аймгийн зарим сумд Улаанбаатар хотод цэврээр нь үржүүлж, бусад аймаг сумдад сайжруулагчаар борлуулж байна. Бүс нутгийн онцлогт тохирсон адуун сүргийг үржүүлэх бодлого хэрэгжүүлэх бүртгэлжүүлэх хянах тогтолцоог бүрдүүлэх судалгааны ажлыг 2026 онд хийхээр төлөвлөн ажиллаж байна. Монгол улсад үржүүлж буй 6 үүлдэр омгийн адууны генетик нөөц геномын судалгааг шинжлэх ухааны байгууллагатай хамтран зохион байгуулж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				Хавсралт : 3 файл	
	179		2.. 2.Энэ тогтоолын биелэлтийг 2027-2036 он хүртэл хугацаанд жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай.	Малын генетик нөөцийн төлөв байдлыг 2026 онд тодорхойлох зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж, төсвийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.	Х.Б
УИХ-ын байнгын хорооны тогтоол					
46	180	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.20.. Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.	Тус яам нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны ажилтны Үйлдвэрчний эвлэлийн холбоотой 3 жилийн хугацаатай байгуулсан. Энэхүү хэлэлцээрт “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллахаар санал тусгасан. /Хэлэлцээрийг хавсаргав/ Тайланг дараа оны 1 сард тайлагнана. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
47	181	Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ	2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах;	Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахимд орох Мета өгөгдлийн шаардлагатай үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн хороонд бүрэн хүргүүлсэн. Үндэсний статистикийн хороо бүх яамдын Мета өгөгдлийг нэгтгэн Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг үүсгэнэ.	Хэрэгжсэн - 100%
48	182	Чиглэл өгөх тухай 2018-11-02 Дугаар 2018 №08 БОХХААБХ	1.1/. Бэлчээрийн тухай болон Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Бэлчээрийн тухай хуулийн төслийг ХХААХҮЯ-наас боловсруулж, холбогдох судалгаа хийж, хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулж, батлуулахаар 2019 онд явуулсан боловч Газрын ерөнхий хуулиар бэлчээрийн талаарх зохицуулалтыг оруулна гэж үзээд батлаагүй байна. Мөн ХХААААХҮЯ-наас Газрын ерөнхий хуулийн төсөлд тусгуулах саналыг 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/1584 тоот албан бичгээр Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Зохион байгуулалтын бүх арга хэмжээг авч ажилласан. "Таримал ургамлын үр, сортын тухай хууль"-ийг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр болон 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр тус тус өөрчлөлт оруулсан болно. Хавсралт : 2 файл	Ахиц гарсан - 50%
	183		1.2/. 2019 оноос эхлэн хүн амын гурилын хангамжийг тогтворжуулах зорилгоор жил бүр улаан буудайг тухай жилийн дотоодын ургацаас нэн тэргүүнд улсын нөөцөд худалдан авч байхаар тооцож эдийн засгийн болон эрх зүйн зохицуулалт хийх;	УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний улаанбуудайн стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор 100.000 тонн хүртэлх улаанбуудайг улсын нөөцөд худалдан авах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор 2023 онд 28.8 мянган тонн, 2024 онд 24.5 мянган тонн, 2025 онд 49.6 мянган тонн хүнсний улаанбуудай худалдан авч нийт 102.9 мянган тонн нөөц бүрдүүлж ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%
	184		1.4/. тариалангийн бүс нутагт сэлгээний таримлыг сонгон нэвтрүүлэх, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	АТАР-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд 171,499,504.0 төгрөгийн үнэ бүхий шар буурцгийн үр 22 тн-ийг худалдан авч 480 га-д, 113,104,640.0 төгрөгийн үнэ бүхий Судан өвсний үр 20 тн-ийг худалдан авч 400га-д, 195,143,320.0 төгрөгийн үнэ бүхий Тэжээлийн холимог үр 10 тн-ийг худалдан авч 250 га-д, 414,960,000.0 төгрөгийн үнэ бүхий Хошуу будаа 260 тн-ийг худалдан авч 3900 га-д тариалах боломж бүрдсэн. 2025 онд 270 мян.га талбайд уринш бэлтгэснээс 110 мян.га талбайд механик уринш, 160 мян.га талбайд хосолсон аргаар уринш бэлтгэсэн бөгөөд нийт тариалах талбайн 28%-д цулгуй уринш хийсэн байна.	Хэрэгжсэн - 100%

	185		1.7/. малыг зах зээлийн эргэлтэд оруулах, махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, орон нутагт үйлдвэрлэлийн аргаар мах бэлтгэх ажлыг өргөжүүлэх;	Мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжүүд 2025-2026 онд нийт 162.0 мянган тонн мах экспортлохоор төлөвлөж, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 59 аж ахуйн нэгж 75.3 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг (түүхий ястай маханд шилжүүлэн тооцвол 93.9 мянган тонн) 305.3 сая ам.долларoор экспортолсон байна. Мөн Бүгд Найрамдах Узбекистан Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад нийт 103.0 мянган толгой амьд малын экспорт хийгдсэн байна. Мах боловсруулах чиглэлээр 21 аймаг, нийслэлд 135 үйлдвэр, гүн хөлдөөх зориулалт бүхий 6.8 мянган тонн багтаамжтай 12, хөргөх, хадгалах зориулалт бүхий 86.0 мянган тонн багтаамжтай 125 агуулахад эрх бүхий иргэн, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна. Малчдын мал худалдаалах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Атар 4, тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд мал, мах худалдан авах эргэлтийн хөрөнгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгохоор шийдвэрлэж, холбогдох зохицуулалтыг хийж байна.	Ахиц гарсан - 50%
49	186	Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019 №04 ЭЗБХ	1.6/. Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийн цогцолбор, төслийн хөрөнгө оруулалтыг төслийн үе шаттай уялдуулан хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, шаардлагатай дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тухай бүр тусгах;	“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Хүнсний хувьсгал” үндэсний хувьсгал, “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй байдлаар хөгжүүлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийг нийлүүлэлтийн сүлжээний хамт үе шаттайгаар байгуулах зорилтууд тусгагдсан. Дээрх зорилтуудтай уялдуулан “Хөнгөн, хүнсний үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2025 оны 271 дүгээр тогтоолыг батлуулсан. Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл технологийн паркуудыг төвийн бүсэд Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн парк”, Баруун бүсэд Ховд аймагт “Шинэ Ховд аж үйлдвэрийн парк”, Нийслэлд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, говийн бүсэд Говьсүмбэр аймагт “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”, Зүүн бүсэд Дорнод аймагт “Зүүн бүсийн үйлдвэрлэл технологийн парк”-уудыг байгуулахаар төлөвлөн, төр хувийн хэвшлийн оролцоотойгоор бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. Дэд бүтцийн нийт хөрөнгө оруулалт: - Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн парк: 2025-2027 онд 23.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2025 онд 7.1 тэрбум төгрөг төсөвлөгдсөн, гүйцэтгэл 71,8%. - "Шинэ Ховд" үйлдвэр технологийн парк: 2022-2026 онд 35,943.6 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2025 онд 18.2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн, гүйцэтгэл 90.8%. - Эмээлт эко аж үйлдвэрийн парк: 2025-2028 онд 515.9 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөв, олон улсын зээл тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2025 онд 30.0 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт тусгасан. гүйцэтгэл 10% Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	187		3.. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Монгол Улсын Хөнжлийн банк /Б.Батбаяр/-нд даалгасугай.	Эдийн засгийн байнгийн хорооноос 2019 онд гаргасан 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан. Хэрэгжилт бүрэн хангагдсан тул хасах саналтай байна. Үр нөлөө : - Хяналтаас хасуулах санал : Эдийн засгийн байнгийн хорооноос 2019 онд гаргасан 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан. Хэрэгжилт бүрэн хангагдсан тул хасах саналтай байна.	Хэрэгжсэн - 100%
	188		1.4. олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, мэдлэг, инновaци шингэсэн хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, аялал жуулчлал болон бусад салбарыг хувийн хэвшилд тулгуурлан хөгжүүлэх бодлого, стратегийг танилцуулах;	Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан МУ-ын 2022, 2023, 2024 оны төсөвт нийтдээ 17,950.8 сая төгрөгийн санхүүжилт тусгасан ба үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийг 18 тербум төгрөгийг 2025 оны Улсын төсөвт тусгуулан батлуулсан. Нийт ажлын гүйцэтгэл 54.9 хувьтай. - Төвийн бүсийн ҮТП-ын байршил, үйл ажиллагааны чиглэлийг Засгийн газрын тогтоолоор батлуулсан. Тус паркийн дэд бүтцийн ажилд шаардлагатай 7,1 тэрбум	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				төгрөгийн төсвийг 2025 оны улсын төсөвт батласан бөгөөд 2 ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээг байгуулан бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. Тус цогцолборын суурь судалгаа, төлөвлөлт, дэд бүтцийн бэлтгэл ажлыг хангах зардлыг Сайдын тушаалаар баталсан. “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын ажил болон парк доторх цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажлыг Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан, Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр Эдийн засаг, хөгжлийн яамны хэрэгжүүлж буй “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.	
50	189	Чиглэл өгөх тухай 2020-05-06 Дугаар 2020 №06 БОХХААБХ	1.1/. 1.Байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн шалгалтын дүнг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/таримал ургамлын анхдагч үрийн аж ахуйг хөгжүүлэх, үр үржүүлэг, сорт сорилтын салбарын бүтэц, үрийн аж ахуйн тогтолцоог бүсчилсэн хэлбэрээр шинэчлэн зохион байгуулж, импортын таримлын үрийн хэрэгцээг багасгаж, үрийн бодлогыг шинэчлэн тогтоох;	Улсын хэмжээнд 278.3 мянган тонн үр тариа, үүнээс 252.3 мянган тонн улаанбуудай, 108.0 мянган тонн төмс, 208.6 мянган тонн хүнсний ногоо, 146.5 мянган тонн тэжээлийн ургамал, 27.4 мянган тонн тосны ургамал нийтдээ 762.5 мянган тонн ургац хураан авч нийт хүн амын хэрэгцээт улаанбуудайн 62.5 хувийг, төмсний 76.9 хувийг, хүнсний ногооны 72.6 хувийг дотоодын ургацаас хангах боломжтой гэсэн тооцоо гараад байна. Монгол Улсын 2026 оны хаврын тариалалтад нийт 50.0 орчим мян.тн үрийн улаанбуудай шаардлагатай байгаагаас 2025 оны ургацаас газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн нөөцөд 26.1 мян.тн, ХААК ТӨХХК-д 10.8 мян.тн үр, нийт 36.9 мян.тн нөөцөлсөн байна. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 004 дүгээр зөвлөмжөөр 2026 оны хаврын тариалалтад шаардлагатай улаанбуудайн үрийн тоо хэмжээг 12.0 мян.тн-оор тогтоосон бөгөөд өнөөдрийн байдлаар 7-8 мян.тн үр оруулж ирэхээр аж ахуй нэгж хүсэлтээ ирүүлээд байна. Иймд 2026 оны хаврын тариалалтад 5.0 мян.тн үр дутагдах төлөв гарч байгаа бөгөөд дутагдах үрийг нөөцийг зайлшгүй бүрдүүлэх шаарлагатай байна. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Зохион байгуулалтаас - 0%
	190		1.2/. Торгон /элит/ үр үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Ургамал, газар тариалангийн хүрээлэнд 2000-аас доошгүй га атар газрыг үр үржүүлгийн зориулалтаар эзэмшүүлэх, таримал ургамлын үр үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;	УГТЭШХүрээнлэнгээс улаан буудайн судалгаа үр үйлдвэрлэлд 2024 онд 573.4 га-д хийж 609.3 тн ургац хурааснаас нутагшсан 5 сорт, эрт болцтой Дархан-131 сортын 10 тн үр, Дархан-160 сортын 2 тн, дунд болцтой Дархан-166 сортын 23 тн, Дархан-34 сортын 18 тн, дунд оройн болцтой Дархан-144 сортын 379 тн үр буюу нийт 432 тн элит үрийг үйлдвэрлээд байна. 2025 онд нийт 383 га талбайд улаан буудайн тариалалт хийгдсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 166 дугаар тогтоолыг Дархан-Уул, Дундговь, Дорнод, Төв, Хэнтий, Говьсүмбэр зэрэг аймгуудад атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх шийдвэр гарч нийт тариалангийн эргэлтийн талбайг 71.2 мянган га-аар нэмэгдүүлсэн. Элит үр үйлдвэрлэлийн чиглэлээр шинээр газар олгох хүсэлтийг Хонгор сумын Засаг дарга уламжилсан байна. УГТЭШХүрээлэн нь хээрийн туршилт судалгаа явуулах, таримлын үр суулгац үржүүлэх зориулалтаар нийт 1382.5 га /үүний 162.2 га усалгаатай/ тариалангийн талбай эзэмшин үр үржүүлэг, сорт судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Хавсралт : 2 файл Үр нөлөө : -	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	191		1.4/. Усын хэмжээнд улаан буудай тариалахаар төлөвлөсөн үрийн хангамж хүрэлцээгүйн улмаас улаан буудай тарихаар төлөвлөсөн талбайд тэжээлийн болон сэлгээний таримал тариалахаар тооцож, дотоодоосоо үрийн нөөц бүрдүүлэх арга хэмжээг судалж хэрэгжүүлэх;	АТАР-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд 171,499,504.0 (Нэг зуун далан нэгэн сая дөрвөн зуун ерэн есөн мянга таван зуун дөрвөн) төгрөгийн үнэ бүхий Шар буурцгийн үр 22 тн-ийг худалдан авч 480 га-д, 113,104,640.0 (Нэг зуун арван гурван сая нэг зуун дөрвөн мянга зургаан зуун дөчин) төгрөгийн үнэ бүхий Судан өвсний үр 20 тн-ийг худалдан авч 400га-д, 195,143,320.0 (Нэг зуун ерэн таван сая нэг зуун дөчин гурван мянга гурван зуун хорин) төгрөгийн үнэ бүхий Тэжээлийн холимог үр 10 тн-ийг худалдан авч 250 га-д, 414,960,000.0 /Дөрвөн зуун арван дөрвөн сая есөн зуун жаран мянга/ төгрөгийн үнэ бүхий Хошуу будаа 260 тн-ийг худалдан авч 3900 га-д тариалах боломж бүрдсэн.	Хэрэгжсэн - 100%

				Хавсралт : 4 файл Үр нөлөө : -	
	192		1.5/. Тариалангийн хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулж нөхөн сэргээх, эрдэс болон шим бордооны зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх, хөрсний үржил шимд эерэг нөлөөтэй тэжээлийн үр тариа, буурцагт таримлын сэлгээг нэвтрүүлж нутагшуулах;	Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа УИХ-ын 36 дугаар тогтоол, Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд хөрсний үржил шимийг сайжруулж ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоо хэрэглэсэн тариаланч хүн, хуулийн этгээдэд хэрэглэсэн бордооны үнийн дүнгийн 30 хүртэл хувьд нь урамшуулал олгохоор баримт бичигт заагдсан байдаг. Үүний хүрээнд 32 диллер ААН-ийн 16,7 мянган тонн бордоог тариалан үйлдвэрлэлийн нэгдсэн системээр хянаж баталсан. Үүнээс эрдэс бордоо 14,5 мян.тн, биологийн гаралтай бордоо 1,1 мян.тн, дотоодын үйлдвэрийн 5 ААН-ийн 10 нэр төрлийн 1 мян.тн бордоо тус тус батлагдсан байна. Хөрсний үржил шимийг сайжруулж, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд батлагдсан баримт бичгийн дагуу тариалан үйлдвэрлэлийн нэгдсэн системээр ирүүлсэн хүсэлтийг support.mofa.gov.mn системээр хянаж шаардлага хангасан хүсэлтийг урамшуллын систем рүү илгээсэн. Энэ жил 15 аймгийн нийт 35,4 тэрбум төгрөгөөр бордоо худалдан авсан 311 иргэн, ААН-ийн хүсэлтийг урамшууллын системийн тушаалын төсөлд хянаж оруулаа. Батлагдсан баримт бичигт 3,2 тэрбум төгрөгийн урамшууллыг олгохоор заасан байгаа бөгөөд 35.4 тэрбум төгрөгийн үнийн дүнгийн 9,79 %-аар дэмжлэг хэлбэрээр олгохоор байна. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	193		1.6/. Оросын Холбооны Улсаас импортолсон торгон /элит/ үрийг хөндлөнгийн лабораториор чанарын хянан баталгаажуулалтыг дахин хийх;	Оросын Холбооны Улсаас импортолсон торгон /элит/ үрийг хөндлөнгийн лабораториор чанарын хянан баталгаажуулалтыг дахин хийх ажлын биелэлтийг хангаж ХАБУЛ-т шинжилгээ өгч баталгаажуулсан. Үр нөлөө : -	Ахиц гарсан - 50%
	194		1.7/. Хаврын тариалалтад зориулж улаан буудайн үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор үр нийлүүлэх импортын гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгжид цаашид импортын зөвшөөрөл олгохгүй байх арга хэмжээг авч, тэдгээрт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцох;	Хаврын тариалалтад зориулж улаан буудайн үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор үр нийлүүлэх импортын гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж 2025 оны 12 сарын байдлаар гараагүй байна. /2020 оны БОХХАБХ-ийн чиглэл олгох тухай тул хасах,/ Хяналтаас хасуулах санал : Хаврын тариалалтад зориулж улаан буудайн үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор үр нийлүүлэх импортын гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж 2025 оны 12 сарын байдлаар гараагүй байна. /2020 оны БОХХАБХ-ийн чиглэл олгох тухай тул хасах,/	Хэрэгжсэн - 100%
	195		1.8/. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээг хангахад шаарлагатай стандартын шаардлага хангасан дэвшилтэт технологи бүхий зоорь, агуулахыг газар тариалангийн бүс нутгийн онцлогтой уялдуулан зохион байгуулах;	Монгол Улсын хэмжээнд төмс, хүнсний ногоог 305 мянган тонны хүчин чадалтай 7559 зоорь ашиглаж байна. Энэ нь хүн амын хүнсний ногоо, төмсний хэрэглээ болон хураан авч байгаа ургацтайгаа харьцуулахад 170 мянган тонны зоорь, агуулах нэмж шаардлагатай байна. Иймээс Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах тухай Улсын Их хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн асуудлыг шийдвэрлэн 2023-2024 онд зоорь агуулах барих чиглэлээр хөрөнгө оруулалтын зээлийг нийт 69 иргэн, аж ахуй нэгжид 63.7 тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгосон бол 2025 онд Атрын IV аяны хүрээнд төмс, хүнсний ногооны механикжсан агуулах барих зорилгоор 37 иргэн, аж ахуй нэгжид 17.6 тэрбум төгрөгийн зээлийг тус тус үргэлжлүүлэн олгосон бөгөөд эдгээрийн үр дүнд 37 мянган тонноор агуулах, зоорины багтаамжийг нэмэгдүүлээд байна. Мөн түүнчлэн Улсын төсвийн хөрөнгөөр “(Сэлэнгэ, Орхон, Мандал, Баянгол, Шаамар, Хушаат, Жавхлант, Зүүнбүрэн сум) Төмс, хүнсний ногооны зоорь, 200 тн, 500 тн барилгын ажил эхлээд явж байна. Эдгээр зоориуд ашиглалтад оруулснаар 2800 тонноор мөн хөргөлттэй агуулахын хүчин чадал нэмэгдэх боломжтой болох юм. Энэ оны тухайд эхний 5 зоорийг ашиглалтад хүлээж авахаар ажиллаж байна. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	196		1.9/. Импортын үрийн чанар, зохион байгуулалттай холбоотой үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллага шийдвэрээ гаргаж холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх;	1. Импортын үрийн чанар, зохион байгуулалттай холбоотой үүссэн маргаан 2025 оны 12 сарын байдлаар гараагүй. 2. мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсан. 3. 2020 он БОХХААБХ-ийн чиглэл өгөх тухай тул хасах. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%

				Хяналтаас хасуулах санал : 1. Импортын үрийн чанар, зохион байгуулалттай холбоотой үүссэн маргаан 2025 оны 12 сарын байдлаар гараагүй. 2. мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсан. 3. 2020 он БОХХААБХ-ийн чиглэл өгөх тухай тул хасах.	
	197		1.10/. Газар тариалангийн салбарт цахим мэдээллийн систем нэвтрүүлэх, аж ахуйн нэгж, иргэний тариалангийн талбай, хураасан ургацын хэмжээ, урамшууллын асуудлыг нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах;	Тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн нэгдсэн сан plant.mofa.gov.mn-д 2025 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар 1.1 сая га талбай бүхий 2455 хуулийн этгээд, 13841 тариаланч бүртгэлтэй байна. Энэ системээр дамжуулан төрөөс тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг, урамшууллын хүсэлтыг хүлээн авч, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох гэрчилгээ олгож байна. Хаврын тариалалт, намрын ургац хураалт болон газар тариалангийн 10 өгөгдлийн хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад мэдээллийг хэрэгслээр нээлттэй олон нийтэд хүргээд байна. Тариалалт, ургац хураалтын мэдээллийг хавар, намрын улиралд 7 хоногт 2 удаа, хүлэмж, усалгаатай тариалан зоорь агуулах, бодис бордооны мэдээллийг жил 2 удаа авч нэгтгэн холбогдох байгууллагуудад танилцуулан ажиллаж байна. Үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээл, тос, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй, ажиллах хүчний мэдээллийг сүүлийг арван жилээр нэгтгэн гаргаж холбогдох тайланд мэдээнд тусган ажиллаж байна. Цаашид газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн системийн мэдээллийн агууламжийг нэмэгдүүлэх, агро цаг уурын хяналтыг боловсруулангуй болгох чиглэлээр хүлэмж, зоорь, усалгаатай тариалангийн үйлдвэрлэл бүртгэл зэрэг бусад нэмэлт хөгүүлэлт хийх “Тариалангийн үйлдвэрлэлийн цахим бүртгэл мэдээллийн системийн хөгжүүлэлт” үйлчилгээ үзүүлэх тендер сонгон шалгаруулалтын зохион байгуулж "Универсалбинари сольюшн" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Энэ хүрээнд Plant.mofa.gov цахим системийг шинээр зураглан гаргаж холбогдох нэмэлт хөгжүүлэлтийг хийж хүлээлгэн өгөөд байна. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	198		1.11/. Нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мэдээ мэдээллийг үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлж байх.	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэл мэдээллийг Plant.mofa.gov.mn цахим системийг ашиглалтад оруулан тариалангийн талбай, тариаланчдийн бүртгэлийг 100 хувь хамруулан төрөөс олгож буй дэмжлэг, урамшуулал болон бусад дэмжлэгийг тус цахим системээр дамжуулан олгож байна. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 13834 тариаланч, 2449 хуулийн этгээд тус системд бүртгүүлэн тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөлт, мэдээллээ оруулж байна. Тариалангийн салбарын эх өгөгдөлд суурилсан салбарын бодлогын хэрэгжилтийн үр дүн, хяналт, төлөвлөлтийг сайжруулах зорилгоор Агро үйлдвэрлэлийн нэгдсэн тайлан "АГРО-ТАЙЛАН"-гийн загварыг боловсруулан тайланг орон нутгаас авч нэгтгэн авсан. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
51	199	Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ	1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх;	Монгол Улс 2018 онд 70.4 мян.тн, 2019 онд 58.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон ба Дэлхийн нийтийн хамарсан Короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас дээрх тоо хэмжээ дунджаар 45% буурч 2020 онд 38.8 мян.тн, 2021 онд 21.8 мян.тн, 2022 онд 16.0 мян.тн, 2023 онд 80.4 мян.тн, 2024 онд 71.1 мян.тн, 2025 онд 85.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүнийг экспортолсон ба экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: а/ Монгол Улсын эрх бүхий байгууллага 2023 оны 12 сард Персийн булангийн орны GSO итгэмжлэлийн байгууллагаас “Халал баталгаажуулалт” хийх итгэмжлэл авснаар энэ онд Ойрд Дорнодын орнуудад нийт 20.0 мян.тн хонины шинэ болон хөлдөөсөн мах экспортолсон ба энэ нь нийт экспортын 30 гаруй хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. б/ Монгол Улсаас БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох 20, самар экспортлох 7 аж ахуйн нэгжийн хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан баталгаажуулж, тус улсын Гаалийн ерөнхий газарт мах, махан бүтээгдэхүүн экспортлох 7, самар экспортлох 5, загас экспортлох 1, сүүн бүтээгдэхүүн экспортлох 1, нийт 14 аж ахуйн нэгжийг шинээр бүртгүүлж, экспортын эрхтэй болсон. в/ Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хооронд “Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад экспортлох тэжээлийн зориулалттай уураг болон өөх, тосны мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протокол”-ыг харилцан тохиролцож, хамтран байгуулсан. г/ Монгол Улсаас БНХАУ-д дайвар бүтээгдэхүүн экспортлох хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протоколын төсөл, холбогдох тайланг боловсруулж БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт	Хэрэгжсэн - 100%

				хүргүүлсэн. д/ Мах, махан бүтээгдэхүүний экспортод “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын нэг цонхны цахим систем”-ийг (export.mofa.gov.mn) нэвтрүүлсэн Хавсралт : 5 файл Үр нөлөө : -	
	200		1.2/. Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг мал, мах бэлтгэлийг үед бага хүүтэй, урт хугацаатай зээлийн эх үүсвэрээр дэмжих;	2023 онд: Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хүнсний боловсруулах үйлдвэрт эргэлтийн хөрөнгийн зээлийг 187 аж ахуйн нэгжид, 159.3 тэрбум төгрөгийн зээл батлагдаж, 143.6 тэрбум төгрөгийн зээлийг олгож, эх үүсвэрийн ашиглалт 99.5 хувьтай байна. Үүнээс мал төхөөрөх, мах боловсруулах 25 аж ахуйн нэгж нийт 57.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээл авсан. 2024 онд: Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих (Мах бэлтгэхэд зориулан эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн дэмжлэг) зээл жилийн нийт 19 хувь (зээлдэгчээс 6 хувь, Засгийн газраас хариуцан төлөх 13 хувь)-ийн хүүтэй 12 сарын хугацаатайгаар тусгасан. 18 аж ахуйн нэгж, нийт 41.2 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	201		1.3/. Мах, махан бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг аж ахуйн нэгжийн үйлдвэрийн хүчин чадал, мал, мах бэлтгэл, аж ахуйн нэгжийн агуулах, нөөцийн махны бүрдүүлэлт зэрэгтэй уялдуулан зөвшөөрөл олгож байх;	1. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны "Монгол Улсын 2022-2023 онд экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээний тухай" 03 дугаар зөвлөмжийн дагуу 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд үхрийн махнаас бусад төрлийн малын махны экспортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн хүчин чадалтай уялдуулан 14 аж ахуйн нэгжид 7700 тн үхрийн түүхий мах, 12 аж ахуйн нэгжид 5000 тн дулааны аргаар боловсруулсан үхрийн мах экспортлох зөвшөөрлийг тус тус олгосон. 2. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны "Монгол Улсын экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээний тухай" 04 дүгээр зөвлөмжийн дагуу 2024 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд бүх төрлийн малын махны экспорт, импортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэж, экспортын зөвшөөрөл олгохгүй болсон. Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт хангагдсан, хяналтаас хамсуулах саналтай.	Хэрэгжсэн - 100%
	202		1.4/. Олгосон зөвшөөрлөөс илүү мах бэлтгэсэн аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дулааны боловсруулалт хийсэн 2,0 мянган тн үхэр, 9,0 мянган тн бог мал, 3,0 мянган тн адууны ясгүй түүхий хөлдүү махны экспортын зөвшөөрлийг шинээр нэмж олгох, 2020 онд олгосон махны экспортын зөвшөөрлийн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл сунгах асуудлыг шийдвэрлэх;	1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Дээрх журмын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспорт, импортын тоо хэмжээний саналыг тухайн жилийн өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, сүргийн бүтцийг харгалзан 09 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнө Хүнс, аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, тус зөвлөлөөс гаргасан Зөвлөмжид үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд тогтоодог болсон. 2. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны "Монгол Улсын 2022-2023 онд экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээний тухай" 03 дугаар зөвлөмжийн дагуу 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд хонь, ямааны түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах, адууны түүхий махны экспортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. 3. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны "Монгол Улсын экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээний тухай" 04 дүгээр зөвлөмжийн дагуу 2024 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд бүх төрлийн малын махны экспорт, импортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэж, экспортын зөвшөөрөл олгодоггүй болсон. Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт хангагдсан, хяналтаас хасуулах саналтай.	Хэрэгжсэн - 100%

	203		1.5/. Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүний тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийх;	2025 онд хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн 2 удаагийн хэлэлцүүлэгт салбарын хяналтын чиглэлээр тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, хяналтын тогтолцоо, бүтэц чиг үүргийг оновчтой зохион байгуулах талаар санал боловсруулж танилцуулсан. Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт хангагдсан, хяналтаас хасуулах саналтай.	Хэрэгжсэн - 100%
	204		1.8/. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед махны экспортыг тасралтгүй явуулах, БНХАУ-аас мах, махан бүтээгдэхүүний импортод эрүүл ахуй, хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, жолоочийн аюулгүй байдал, тээвэрлэлтийг хэрхэн хамтран зохион байгуулах талаар импортлогч талтай холбогдох нөхцөл, шаардлагыг яаралтай тохиролцох;	1. БНХАУ-ын Эрээн боомтын Коронавируст халдварын нөхцөл байдлаар шалтгаалан БНХАУ-ын эрх бүхий байгууллагаас Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн экспортлохыг тодорхойгүй хугацаагаар зогсоосон байсан бөгөөд экспортлогч аж ахуйн нэгжийн бэлтгэсэн 3817 тн адууны мах, 6965 тн дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны махыг экспортлох боломжгүй байсан. Харин 2 улсын Засгийн газрын хамтын ажиллагааны дүнд Монгол Улсаас 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мах, махан бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн. Монгол Улс КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс өмнөх 2 жилд 129 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолж байсан бол цар тахлын хязгаарлалт, тээвэр логистикийн хүндрэл, эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалан энэ хэмжээ 45%-иар огцом буурч 2020 онд 38.8 мян.тн, 2021 онд 21.8 мян.тн, 2022 онд 16.0 мян.тн мах, махан бүтээгдэхүүнийг тус тус экспортолсон байна. Монгол Улс 2023 оны гаалийн гүйцэтгэлээр 80.4 мян.тн /түүхий ястай маханд шилжүүлэн тооцвол 117.0 мян.тн/ мах, махан бүтээгдэхүүнийг 322.8 сая.ам.доллароор экспортолсон нь урьд өмнө хүрч байгаагүй өндөр түвшин бөгөөд 2022 онтой харьцуулахад 5 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2. ХХААХҮ-ийн сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/372 дугаар тушаалын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын нэг цонхны цахим систем”-ийг (export.mofa.gov.mn) нэвтрүүлсэн. Уг системийг нэвтрүүлснээр төрийн болон төрийн бус байгууллагын ажлын уялдаа холбоо сайжирч, мах, махан бүтээгдэхүүн экспортлох үеийн баримт бичиг бүрдүүлэх, 4 байгууллагаас экспортын гэрчилгээ авахад зарцуулдаг байсан 13 хоногийн хугацааг бууруулж, ажлын 8 цагт багтаасан бөгөөд уг цахим системээр 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш нийт мах, махан бүтээгдэхүүн экспортлогч 74 аж ахуйн нэгжийн 585 хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн. Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт хангагдсан, хяналтаас хасуулах саналтай.	Хэрэгжсэн - 100%
	205		1.9/. 2021 оноос богийн болон адууны ясгүй түүхий хөлдүү махыг экспортын зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй экспортлодог болгох, экспортлох үхрийн махны тоо хэмжээг тухайн жилийн зуншлагын байдал, сүргийн бүтцийг харгалзан жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тогтоож байх.	1. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны "Монгол Улсын 2022-2023 онд экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээний тухай" 03 дугаар зөвлөмжийн дагуу 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд үхрийн махнаас бусад төрлийн малын махны экспортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн хүчин чадалтай уялдуулан 14 аж ахуйн нэгжид 7700 тн үхрийн түүхий мах, 12 аж ахуйн нэгжид 5000 тн дулааны аргаар боловсруулсан үхрийн мах экспортлох зөвшөөрлийг тус тус олгосон. 2. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны "Монгол Улсын экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тоо хэмжээний тухай" 04 дүгээр зөвлөмжийн дагуу 2024 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд бүх төрлийн малын махны экспорт, импортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэж, экспортын зөвшөөрөл олгохгүй болсон. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт хангагдсан, хяналтаас хасуулах саналтай.	Хэрэгжсэн - 100%
52	206	Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №11 БОХХААБХ	1.. Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Ургамал, газар тариалангийн хүрээлэн болон Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнг Боловсрол, шинжлэх ухааны яам буюу хөдөө аж ахуйн их сургуулийн харьяалалд байгааг өөрчилж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяалалд шилжүүлэх	Хөдөө аж ахуйн их сургууль болон түүний харьяанд байгаа Ургамал газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяалалд шилжүүлэх эсэх асуудлыг судлан, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, гишүүдээс санал аван нэгтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Энэ шийдвэрийн төсөлд Боловсрол, шинжлэх ухааны яам эсрэг санал өгсөн тул хуралдаанаар хэлэлцэгдэн, дэмжигдээгүй болно.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлаг

			асуудлыг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор судалж, хэлэлцэн шийдвэрлэхийг Монгол Улсын засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай.		атай - 50%
53	207	Чиглэл өгөх тухай 2021-02-26 Дугаар 2021 №07 БОХХААБХ	2.1/. Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ХХААХҮЯ /З.Мэндсайхан/-нд чиглэл болгосугай: Стратегийн хүнсний түүхий эд болох улаанбуудай тариалах талбайн хэмжээг өмнөх оныхоос нэмэгдүүлэхийн тулд чанар сайтай үрээр хангах асуудалд онцгой анхаарч ажиллах, мөн тариалалт уриншид хэрэглэх гербецид, бордоог технологийн дагуу хэрэглэх хугацаанаас өмнө татан төвлөрүүлж, тариалалтын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах.	Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Атрын-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоолыг тус тус үндэслэн газар тариалангийн салбарын 2025 оны зорилтыг тодорхойлж, хэрэгжилтийг ханган ажиллаа. Хаврын тариалалтын ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр аймгуудад үүрэг чиглэл өгч зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Тайлант онд улсын хэмжээгээр 360.7 мянган га-д үр тариа, үүнээс 310.1 мянган га-д улаанбуудай, 17.1 мянган га-д төмс, 16.5 мянган га-д хүнсний ногоо, 144.1 мянган га-д малын тэжээл, 103.7 мянган га-д тосны ургамал нийтдээ 642.3 мянган га талбайд тариалалт хийхээр зорилт тавьсан. Монгол Улсын хэмжээнд 2025 онд 312.8 мянган га-д үр тариа, үүнээс 272.8 мянган га-д улаанбуудай, 12.9 мянган га-д төмс, 15.9 мянган га-д хүнсний ногоо, 87.2 мянган га-д малын тэжээл, 148.5 мянган га-д тосны ургамал нийтдээ 577.5 мянган га талбайд тариалалт хийгдсэн. Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт хангагдсан, хяналтаас хасуулах саналтай.	Хэрэгжсэн - 100%
	208		2.2/. МУИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 35 дугаар тогтоолоор импортын төмс, хүнсний ногооны татварын хувь хэмжээг 30 хүрт эл хувиар тогтоосонтой холбогдуулан хүнсний ногооны тариалалтыг 15-аас дээш хувиар нэмэгдүүлж, дотоодын хүнсний ногооны хангалтыг 60 хувьд хүргэх.	2021–2024 онуудад хүнсний ногооны тариалалтын талбай 80 гаруй хувиар, хураан авсан ургацын хэмжээ 130 гаруй хувиар тус тус өсч, үйлдвэрлэлийн хэмжээ тогтвортой нэмэгдсэн. 2025 онд хүнсний ногоог 15.9 мянган га-д тариалалт хийн 208 мянган тонн хүнсний ногоо хураан авч дотоодын үйлдвэрлэлээр 76 хувийг хангасан. Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт нь хангагдсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	209		2.3/. Хаврын тариалалт болон үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Хөдөө аж ахуйг дэмжих сангийн удирдлагад салбарын мэргэжлийн хүмүүсийг шуурхай томилох	Уг тогтоолыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б-04 тушаалаар О.Сумьяасүрэнг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн захирлаар томилсон. Улмаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 269 дүгээр тогтоолоор "Хөдөө аж ахуйг дэмжих сан" ажлын албыг татан буулгасан. Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : Хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
54	210	Ноос ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021-04-06 Дугаар 2021 №02 ҮББХ	1. "Монгол Улсын Их Хурлаас баталсан ““Алсын хараа 2050”” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай”,“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд тусгагдсан ноос, ноолуурын салбарын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эд худалдан авалт, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд 3 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй 200.0 тэрбум төгрөгийн зээлийг ноолуурын салбарт, 70.0 тэрбум төгрөгийн зээлийг ноосны салбарт олгох, дахин санхүүжүүлэх. Дахин санхүүжилтэд зориулан олгох зээлийн хэмжээ Компанийн тухай хуульд заасан хамаарал бүхий этгээдэд 10.0 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй байх;"	Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын дагуу 2024 оны ноолуур бэлтгэлд зориулан 228.1 тэрбум төгрөгийг ноолуур бэлтгэгч 46 зээлдэгчид олгосон зээлийн хөнгөлөлтөд 2024 онд 18,546.0 сая төгрөг, 2025 онд 5,401.72 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгосон. Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт хангагдсан, хяналтаас хасуулах	Хэрэгжсэн - 100%

	211		2. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 2023 оноос угаасан ноолуурыг экспортлохгүй, самнаж боловсруулсан болон хялгасыг ялгасан ноолуурыг экспортлох, эдгээртэй холбоотой үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг баталж мөрдүүлэх	УИХ-ын 2022 оны "Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 19 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын 2022 оны 380 дугаар "Техникийн зохицуулалт батлах тухай" тогтоолоор ноолуурын худалдаа, боловсруулалтад мөрдөх техникийн зохицуулалтыг баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр тогтсон. Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоолоор уг техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж эхлэх хугацааг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулсан байсныг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр баталсан. Хавсралт : 3 файл	Хэрэгжсэн - 100%
55	212	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-12-28 Дугаар 2021 №06 ҮББХ	3. Төсөл, хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хувь оролцоо, эзэмшил, борлуулалтын асуудлаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллахдаа менежментийн тогтвортой байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай.	Монгол Улсын Их хурлын байнгын хорооны 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 06 дугаар "Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" тогтоолд Тавантолгой нүүрсний ордыг ашиглах, уйл ажиллагааг нь эрчимжүүлэхтэй холбоотой Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөрүүдийг шуурхай эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг чиглэлтэй байна. Уг тогтоолын хэрэгжилт нь манай салбарт хамааралгүй тул хэрэгжилтийг гаргах боломжгүй байна. Хяналтаас хасуулах санал : Салбарын чиг үүрэгт хамааралгүй заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
56	213	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ	1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 11 тоот тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг МУ-ын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/ Стратегийн таримал болох улаанбуудайн үйлдвэрлэлийг дэмжих, тогтворжуулах, эрсдэлээс хамгаалах, тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах;	Улсын төсвийн 9,2 тэрбум төгрөгөөр тариалангийн төв бүс болох Сэлэнгэ /186,875 ширхэг/, Дархан-Уул /101,565 ширхэг/ Төв /21,250 ширхэг/, Булган /51,550 ширхэг/ нийт 361,240 ширхэг төмөр бетон шонгоор 1806 км-ийн урттай 80 мян.га талбайг хамгаалах нөхцөлийг бүрдүүлж тариалангийн талбайг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Сайхан /30,6 км/, Орхон /12 км/, Зүүнбүрэн /24 км/ сумдууд, Дархан-Уул аймгийн Хонгор /36 км/ суманд нийт 4 байршилд улиас, хайлаасны суулгацаар 3 эгнээ хамгаалалтын ойн зурвасыг 93 км-ийн урттай 9 мянга орчим га талбайг хамгаалан байгуулсан. Хавсралт нийт : 6, Файл : 2 Зураг : 4	Хэрэгжсэн - 100%
	214		1.2/. Эрэлтэд суурилсан хүнсний ногооны үйлдвэрлэлийн бодлогыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны дотор боловсруулж, танилцуулах;	Хүн амын гол нэрийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганаар "Хүнсний хангамж ачуулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолыг хэлэлцүүлэн батлсан. Энэ хүрээнд бодлогын баримт бичигт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ болон ашигт таримлын үр үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээнүүдийг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : Өмнө хэрэгжилт хангагдсан, хяналтаас хасуулах	Хэрэгжсэн - 100%
	215		1.3/. Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хүнсний ногооны салбарт техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, хүнсний ногооны үр үйлдвэрлэл, нөөц бүрдүүлэлт, хадгалалт, борлуулалтын тогтолцоог төлөвшүүлэх замаар хүнсний ногооны тариалах талбай, хураан авах ургацыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээний 80 хүртэл хувийг хангах, газар тариалангийн бүтээгдэхүүний урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, үрийн буудай болон шувууны аж ахуйн тэжээлд нийлүүлэгдсэн хүнсний улаанбуудайд уурамшуулал олгох, боловсруулах үйлдвэр, төрийн болон бусад байгууллагуудын худалдан авалтаар борлуулалт нь баталгаажсан төмс, хүнсний ногоонд мөнгөн урамшуулал олгох асуудлыг судалж шийдвэрлэх;	2025 оны ургацын дүнгээр 15.9 мянган талбайд тариалалт хийснээс 208.6 мянган тонн хүнсний ногоо хураан авсан. 2026 онд 18.3 мянган.га-д хүнсний ногооны тариалалт хийхээр төлөвлөж байна. Монгол Улсын хэмжээнд гол нэр төрлийн байцаа, шар лууван, шар манжин, хүрэн манжин, сонгино, саримс, тарвасны үр 790 тн орчим шаардлагатай байгаагаас дотоодын үрийн үйлдвэрлэгч аж ахуй нэгж шар лууван, шар манжин, хүрэн манжингийн үр 6,000-11,200 кг үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг 100 хувь, саримсны үрийг 600 тн-ийг үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг 25 хувийг тус тус хангаж байна. Цаашид Монголд Улсад үйлдвэрлэх боломжтой хүнсний ногооны үрийн аж ахуйг хөгжүүлэхэд тоног төхөөрөмж, усалгаа, санхүүгийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай байна. 2022 оны ЗГ-ын 118 дугаар тогтоол батлагдаж худалдан авалтаар борлуулалт нь баталгаажсан хүнсний ногоонд мөнгөн урамшуулыг олгон ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	216		1.4/. Төмсний үрийн шинэчлэл хийх, боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай төмсний тариалалтыг	2025 оны ургацын урьдчилсан балансаар 12.9 мянган талбайд тариалалт хийсэнээс 2.1 мянган га талбай ургац алдаж 10.8 мянган га-аас 108 мян.тн төмс хураан авах авсан. Тооцооллын дагуу нийт	Тодорхой үр дүнд

			нэмэгдүүлэх чиглэлээр Монгол төмс-2 хөтөлбөр боловсруулах, санхүүжилтийг шийдвэрлэх, нийслэлийн эзэмшилд авч буй 14.0 мянган тонны багтаамжтай төмс, хүнсний ногоо хадгалах зоорийн үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулж, нийслэлийн сургууль, цэцэрлэг болон төсөвт байгууллагуудыг стандартын шаардлага хангасан, эрүүл аюулгүй, ижил үнийн нөхцөлтэй төмс, хүнсний ногоогоор хангах, ногоочдын борлуулалтыг дэмжих ажлыг зохион байгуулах;	хураан авсан төмсний буюу 70 мян.тн хүнсэнд, 30 мян.тн үрэнд нөөцөлнө. Атар-4 тогтвортой хөгжлийн аяны зорилтот тусгагдсанаар 2026 онд 16 мян.га талбайд төмс тариалахаар тооцоход нийт 40.0 мян.тн төмсний үр шаардлагатай. Энэхүү тооцооллоос үзэхэд 10.0 мян.тн үр дутагдахаар байна. Дээрх тооцооллын дагуу үрийн шинэчлэл хийхээр 2026 оны төсвийн төсөлд санал хүргүүлээд байна. Хавсралт : 1 файл	хүрсэн - 50%
	217		1.5/. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15 хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах арга хэмжээний хүрээнд сэлгээний тарималд тэжээлийн таримлын үр үржүүлгийг бий болгож цаашдаа тэжээлийн тарималын тариалалтыг нэмэгдүүлэх нөхцлөөр ханган ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дууссан. 2022 онд танилцуулахыг үүрэг болгосон.	Хэрэгжсэн - 100%
	218		1.6/. Газар тариалангийн зориулалттай техник, усалгааны тоног төхөөрөмжийн шинэчлэлд санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх;	ХААК ТӨХХК-иас хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, ургамал хамгаллын бодис, бордоо нийлүүлэгч дилер ААН-үүдийн нийлүүлдэг бараа бүтээгдэхүүнийг тариаланч нарт дамжуулан зээлдүүлэх, эргэн төлөлтийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ буюу улаанбуудайгаар төлөх боломжийг олгох үйлчилгээ үзүүлдэг бөгөөд дамжуулан зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд 2025 он 12.4 тэрбум төгрөгийг хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, ургамал хамгаллын бодис, бордоо дамжуулан 197 тариаланчид зээлээр олгосон байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	219		1.7/. Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр Алтан ширээгийн Гарн тос боловсруулах үйлдвэрийн дэргэд азотын бордооны, Эрдэнэт үйлдвэрийн зэс хайлуулах үйлдвэрийг түшиглэн фосфорын бордооны үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, цаашид хэрэгжилтийг хангаж ажиллах;	Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж байгаа “Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/”-ийг хэрэгжүүлэхээр заасан УТ2400900259022 дугаартай “Бордооны үйлдвэрийн ТЭЗҮ /Төвийн бүсэд/ боловсруулах гэрээ” гэрээний дагуу Азот, фосфор, калийн (NPK) нийлмэл эрдэс бордоог бууц сангас зэрэг органик хаягдлаар дүүргэч болгон ашиглаж нийлмэл бордоо үйлдвэрлэх технологи ТЭЗҮ-ийг боловсруулсан. Байршил: Тариалангийн төв цэг болох Дархан-Уул аймгийн Хонгор сум Төсөв: Нийт 16,6 сая долларын хөрөнгийн эх үүсвэр хэрэгтэй байгаагаас эхний жилд 14%, 2 дахь жилд 36,1%, 3 дахь жилд 49,9% нь хэрэгцээтэй тооцоолол гарсан байна. Жилд 30 мян.тн бордоо үйлдвэрлэж зах зээлийн одоогийн үнийг баримжаалан тооцоолвол 6 дахь жилээс эхлэн хуримтлагдсан мөнгөн урсгалтай болох ба 4,95 жилд хөрөнгө оруулалтаа нөхнө. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : хэрэгжсэн.	Хэрэгжсэн - 100%
	220		1.8/. Хөдөө аж ахуйн таримлын генефонд, таримлын шинэ сорт бүтээх, селекц, үрийн аж ахуйн хөтөлбөр, хөрсний үржил шимийг сайжруулах, хөрс хамгаалах сэлгээний туршлага зэрэг урт хугацаанд үр дүн нь гардаг шинжлэх ухаан, технологийн төсөлд санхүүжилт олгох, хугацааг нь уртасгах арга хэмжээ авах, тариаланчид, өрхийн болон фермерийн аж ахуй эрхлэгчдийг шинэ техник, технологид сургах, дадлагажуулах төрөл бүрийн сургалт сурталчилгааг эрдэм шинжилгээ, сургалт судалгааны байгууллагаар дамжуулан тогтмол зохион байгуулах, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд оновчтой нэвтрүүлэх;	1. ХАА-н таримлын генефондын чиглэлээр УГТЭШХ 2024 онд авсан бодгалиас өвчилж, гэмтсэн ургамлыг солих зорилгоор 2025 оны судалгаанд нутгийн омгийн төлөөлөл буудайн 100, арвайн 100, бог будааны 31 дээж , нийт 231 дээж судлав. Гербарт зориулан тарьсан нутгийн буудайн 2 зүйл, 4 дэд зүйл, 29 омгийн 100 дээж, арвайн 2 зүйл, 8 омгийн 100 дээж, бог будааны 31, нийт 231 дээжид морфологийн 24 шинж тэмдгүүдэд үнэлгээ өгөв. 2. Өвлийн хүлэмжид амтат гуа, халуун чинжүү, амтат төмс, усан үзмийн хоёр сортын мод, улаан лоолийн Толстой, Unicorn, Ts бор, Tomaten Hellfrucht, Бор помидор, TV 아이템, TV 홀리데이 хар помидор гэсэн 8 сортын 480 үрслэгээг суулгаж, туршилт хийсэн. 3. Амтат төмсний -Beniharuka, аспарагус- Atlantig, Усан үзмийн -vitis vinifera L сортуудыг тариалан манай оронд ургах боломж хэр байх талаар туршилтын тариалалт хийсэн. Гала, Солист сортын супер элит төмсийг нэг га талбайд, Bangor, Red flame, Daytone сортын шүүсний лууванг 300 мкв талбайд, Oneida F1, Tiesaku-1, Штуттгартер ризен, Richhong гэсэн сортуудын 3000 ширхэг үрслэгээ болон төл сонгиныг хар плёнкон хучлагаар хучиж агротехнологийн дагуу туршилтаар тариалсан. Төвийн дэргэдэх 6*8 мкв харьцаатай 2 зуны нийлэг хальсан хүлэмжинд ХААИС-ийн АБС болон JICA-ын сайн дурын ажилтантай хамтран гоёлын	Хэрэгжсэн - 100%

				баглааны 5 сортын 10 төрлийн цэцэг туршилтаар тариалж ХХААХҮЯ-ны улсын сорт сорилтын зөвлөлөөр оруулан Арилжааны зориулалтай баглаа цэцгийн сортоор бүртгүүлсэн. Вирусгүй төмсний бичил булцууны үр үржүүлгийн лаборатори нь 120 м2 хүлэмжид 2000 ширхэг (өлчиржүүлсэн, in vitro нөхцөлд үржүүлсэн) вирусгүй төмсний бичил ургамал, зуны нийлэг хальсан хүлэмжид 240 м2 талбайд 3540 ширхэг бичил булцууг технологийн дагуу тариалсан. "Төмс, хүнсний ногооны технологи, цахим системийн ашиглалт, Хамгаалагдсан хөрсний технологи, "Хүлэмж барих арга технологи", "Шинэ төрлийн тарьмал тариалах боломж" сэдвүүдээр 21 аймагт 13 удаагийн сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, тариалан эрхэлдэг ногоочид, үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжууллаа. Хавсралт нийт : 20, Файл : 4 Зураг : 16	
	221		1.9/. Хүнсний хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор усны эх үүсвэр бүхий газарт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, ашигт таримал тариалах, мод үржүүлгийн газар байгуулахад шинээр газар олгох асуудлыг судалж шийдвэрлэх, нийслэл хот, говийн бүсийн болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудыг түшиглэн өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй, хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулахад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, хүлэмжид хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлтийн цагийн хугацааг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Засгийн газрын 2025 оны 166 дугаар тогтоолоор нийт 71235.02 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлж, жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримал тариалах чиглэлээр ажиллаж байна. Атрын IV аяны хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг эргэлтийн болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд хамруулахаар арилжааны 10 банктай хамтран ажиллах гэрээг байгуулав. Энэхүү арга хэмжээнд ашигт тарималын үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй аж ахуй нэгж, иргэдэд 7-8 хувийн хүүтэй, 24-48 сарын хугацаатай, нийт 800.0 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор төлөвлөснөөс Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мөөгний үйлдвэрлэлд 35 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө, мөөгний үйлдвэр байгуулах, өргөжүүлэхэд 5 тэрбум, хүлэмжийн аж ахуй, ургамлын үйлдвэр (гидропоник, аэропоник) шинээр байгуулах 40 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгохоор шийдвэрлэсэн. Мөн Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 118 дугаар тогтоолоор "Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 324 дүгээр тогтоолын 2 дахь заалтын "11 дүгээр сарын 1-нээс" гэснийг "10 дугаар сарын 15-наас" гэж, "22:00 цагаас" гэснийг "18:00 цагаас" гэж тус тус өөрчилсөн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	222		1.10/. Гамшгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт заасны дагуу гамшигт өртсөн төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч нарт хамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг нөхөн олгох, дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх;	Тариалангийн салбар байгалийн эрсдэлт хүчин зүйлд их өртөмтгий учраас уг асуудлыг "Тариалангийн даатгалын тухай хууль"-ийн төсөл, үзэл баримтлал, холбогдох судалгааг 2026 онд багтаан боловсруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	223		1.11/. Дотоодын үйлдэрлэлээр хүнсний тосны хэрэгцээг хангах зорилгоор Үр, сортын зөвлөлийн шийдвэрээр баталгаажсан сортын үрээр тарьж ургуулсан түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэсэн ургамлын тосыг борлуулалтын нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлэх.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг санаачилан боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. Тус хуулийн хүрээнд дотоодын түүхий эдээр үйлдвэрлэсэн ургамлын тос, дотоодын хүнсний үйлдвэрт борлуулсан хүнсний зориулалттай тосны ургамлыг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлсөн. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468624851211 Хяналтаас хасуулах санал : Тухайн асуудлаар шийдвэр гарсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468624851211	Хэрэгжсэн - 100%
	224		2.. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	Энэ тогтоолын биелэлтийг болон хаврын тариалалт, ургацын урьдчилсан баланс, ургац хураалтын дүнгийн танилцуулгыг 2022, 2023 онд Засгийн газар, УИХ-д тухай бүр танилцуулсан тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дууссан.	Хэрэгжсэн - 100%
57	225	Мал, амьтны эрүүл мэндийн тухай	1.1/. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ХХААХҮСайдын А-17 тоот тушаалаар батлуулсанаар	Удаашралтай /

		хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ	хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/2022 онд шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх дархлаажуулалтын ажилд шаардлагатай /25 сая тун вакцины үнэ 21,0 тэрбум, үйлчилгээний хөлс 17,8 тэрбум, гааль, нэмэгдсэн өртгийн татвар 3,2 тэрбум/ нийт 41,7 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг 2022 оны төсвийн тодотголын хүрээнд шийдвэрлэх;	нийт 12 бүлэг 14 багц тендерийн худалдан авах ажиллагааг 100 хувь зохион байгуулсан. Худалдан авах ажиллагаанд зарцуулах нийт батлагдсан төсөв 16.7 тэрбум төгрөгөөс тендер шалгаруулалтыг 16.7 тэрбум төгрөгөөр зохион байгуулж тайлант хугацаанд худалдан авалтын гэрээний гүйцэтгэлд 10 дугаар сарын 30-ны байдлаар 16.2 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдаж 513.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. 2025 оны худалдан авалт хуулийн хүрээнд гүйцэтгэгдэж санхүүжилт Сангийн яамнаас орлого байхгүй хуваарьт тавиагүйгээс хүлээгдэж байна.	эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	226		1.3/. Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, биобэлдмэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилгоор Биокомбинат төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэхийг нэн даруй шийдвэрлэх;	Дотоодын вакцин үйлдвэрлэгч Биокомбинат ТӨХХК нь хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцин үйлдвэрийн шугаман эсийн технологийг шинэчилж 2025 онд 20 сая тун вакцин үйлдвэрлэж нийлүүлсэн. Мөн бусад вакцин савалагааг шинэчилж сайжруулан ажилласан байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	227		1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах;	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 196 дугаар Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг байгуулах тогтоолоор Архангай аймгийн Цахир сумын Солонготын дабааны ам, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүр, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Төв аймгийн Лүн сумын Айрагийн энгэр, Нийслэлийн Багануур дүүргийн Хэрлэнгийн гүүр, Сонгинохайрхан дүүргийн Баруунтуруун, Эмээлт, Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо Тавантолгойн уулзвар, 14 дүгээр хороо Хөндлөн уулын арын байнгын ажиллагаатай мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг болон Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум, Хэрлэн сумын Хэрлэнгийн гүүр, Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд Мал эмнэлгийн хяналтын цэг, Хэрлэн сумын 3 гүүрний аманд, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Замын цагдаагийн пост, хяналтын түр цэгийг аймаг, сумын Онцгой комисс, Засаг даргын шийдвэрээр байгуулан мал эмнэлгийн улсын байцаагч цагдаагийн албан хаагчид хамтран нар мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүний баталгаажилтанд хяналт шалгалт хийж ажиллаж байна. Аймаг, нийслэлийн МЭГ, сум дүүрэг дэх мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн улсын байцаагч нар отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт, шалгалт хийж байна. Он гарсаар улсын хэмжээнд мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 433864 МЭГ олгосноос байнгын болон түр ажиллагаатай хяналтын цэгээр 27597 МЭГ бүхий мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг шалган нэвтрүүлж ажилласан байна. Мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ны байдлаар хяналт, шалгалтаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-р харьяалуулсан 520 зөрчилд 268.7 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч прокурорт хянуулж төрийн сангийн Мал эмнэлгийн хяналт, шалгалтын орлого 100900000608 тоот дансанд төвлөрүүлэн ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%
	228		1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох;	Зооноз халдвар өвчний сэргийлэх дархлаажуулалтад шаардлагатай вакциныг Дотоодын үйлдвэр болох “Биокомбинат” ТӨХХК-с бүрэн хангаж байна. Шаардлагатай вакцины нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Харин гоц халдварт өвчний вакцины нөөцийг олон улсын лавлагаа лабораториос баталгаажсан вакциныг нээлттэй тендер шалгаруулалт хийж худалдан авч байна. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газрын нөөцөд Hicop 1454кг, Hahkon WS 2582кг, Суперкилл 420кг, Триплекан 30кг, Новасид 2536 литр, Автомакс 16 литр 35 ширхэг, Манацаржуулагч 6ширхэг, Нэг удаагийн халдвар хамгааллын хувцас 23874 ширхэг, олон удаагийн халдвар хамгааллын хувцас 144 ширхэг, усны гутал 10 ширхэг, Хөргөгч DC-40X-14 ширхэг, хөргүүр 12 ширхэг халдваргүйтгэлийн шүршигч аппарат-1 нийт 477.010.320 төгрөгийн халдвар хамгааллын бодис, хувцас хэрэгсэлийн нөөцтэй байна.	Ахиц гарсан - 50%
	229		1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу 2022 онд орон нутгийн төсөвт нийт 19.9 тэрбум төгрөг төвлөрсөн. Төвлөрсөн хөрөнгийг төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасан 13 арга хэмжээнд захиран зарцуулахаар хуульчилж, Сангийн сайдын баталсан журмын хүрээнд зохицуулж байна. Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулахад нийт төвлөрсөн хөрөнгийн 34.3 хувь буюу 7.2 тэрбум төгрөгийг 2024 оны жилийн эцсийн байдлаар захиран зарцуулсан. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг	Ахиц гарсан - 50%

				малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар сайдтай аймгийн Засаг дарга нарын байгуулах гэрээнд тусган хэрэгжилтийг орон нутагт хангаж ажиллахад чиглэл хүргүүлэн ажиллаж байна.	
	230		1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг Мал эмнэлгийн ерөнхий газрын дэргэдэх мэргэжлийн зөвлөлөөр 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцүүлсэн. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оныг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/99 дугаар тушаалаар баталгаажуулж аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт хүргүүлэн төлөвлөгөөний дагуу дархлаажуулалтыг эхлүүлсэн. 2025 онд Улсын хэмжээнд 19 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 25.8 сая толгой мал хамрагдахаар төлөвлөсөн. Үүнээс боом 4,2 сая толгой, 2,2 сая иолгой, листериоз 0,768 толгой тус тус дархлаажуулахаар төлөвлөсөн. Дархлаажуулатад шаардагдах вакциныг "Биокомбинат" ТӨХХК нь орон нутагт гэрээ болон төлөвлөгөөний дагуу орон нутагт вакцин хүргэгдэж дархлаажуулалт технологит хугацаанд нь дархлаажуулсан. Дархлаажуулалт улсын хэмжээнд нийт 7.0 сая мал, амьтанг зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсах. 2025 онд галзуу өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад улсын хэмжээнд 100 хувь эзэнтэй нохойг дархлаажуулж нийтийн эрүүл мэндээс хүн амыг эрсдэлийг бууруулах ажлыг хэрэгжүүлсэн. 16.0 сая мал, амьтнаас 15.5 мал, амьтан хамруулж 97 хувийн гүйцэтгэлтэй дархлаажуулсан. Зооноз, архаг халдварт өвчний тохиолдлын тоо 2025 онд 636 толгой мал өвчилсөн байна.	Ахиц гарсан - 50%
	231		1.8/. Мал эмнэлгийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах цогц арга хэмжээг авах;	Салбарын хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1307 албан хаагч ажиллахаас 1121 албан хаагч (гэрээт ажилтан 25 хүн) ажиллаж, сул орон тоо 211 (төрийн захиргааны албан тушаал 207, төрийн үйлчилгээний албан тушаал 4), байна. Салбарын хүний нөөцийг чадавхижуулах хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1. ХАБЭА-н сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр цахимаар зохион байгуулж, орон нутгийн мал эмнэлгийн байгууллагаас нийт 160 албан хаагчийг хамруулав. Энэ сургалт нь 4 үе шаттай ХАБЭА-н сургалтын эхний сургалт юм. Цаашид ажил олгогч, удирдах ажилтны, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны, эрсдэлтэй ажлын байрны сургалтыг зохион байгуулна. 2. Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн бэлэн байдлын сургалтыг Хил хамгаалах ерөнхий газрын Соёлын төвийн зааланд 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, уг сургалтад МЭЕГ-аас 43/37, НМЭГ-аас 87/69, МЭЭСБУЛ-оос 29/25, УМЭАЦТЛ-оос-50/45 нийт 209 албан хаагч оролцохоос 176 албан хаагч биечлэн орон нутгаас цахимаар 355, нийт 531 албан хаагч хамрагдав. 3. Гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль”-ийг 2025 оны 03 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд ОБЕГ-тай хамтран зохион байгуулж, 1344 албан хаагч хамруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, байгаль орчин, мал амьтныг хамгаалах, аврах, хор уршгийг арилгах, Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн с харилцан уялдаа холбоог сайжруулах, ургаж дадлагажуулах дадлага сургуулалтыг зохион байгуулсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
58	232	Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ	1.3. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасан тохирлын баталгаатай эрүүл аюулгүй, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх;	1. УИХ 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээий 36 дугаар тогтоолын хүрээнд Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлд 49 иргэн аж ахуйн нэгжид 5.2 тэрбум төгрөг, Хүүхдийн сүү, сүүн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах зориулалттай зээлд 9 аж ахуй нэгжид 20.0 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. 2. Монгол Улсын Засгийн газрын “Аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоолын хүрээнд Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд “Эрчимжсэн МАА эрхлэгчдэд өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхэр авах” зориулалтаар 42 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн ба 25 иргэн аж ахуйн нэгжид 26.6 тэрбум төгрөгийн зээл шийдвэрлэснээс 23 иргэн ААН-д 18.8 тэрбум төгрөгийн зээлийн олгож дэмжлэг үзүүлсэн. 3. Мөн “Атар-4” аяны хүрээнд Сүү боловсруулах үйлдвэрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжихээр 17 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгохоор эх үүсвэрийг шийдвэрлэсэн бөгөөд 12.46 тэрбум төгрөгийн зээл шийдвэрлэгдсэн бөгөөд 20 ААН-д 11.55 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгож дэмжлэг үзүүлсэн.	Ахиц гарсан - 50%

				Хавсралт : 2 файл	
	233		1.4. Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх, боловсруулах, үйлдвэрлэх, борлуулахад тээвэрлэхэд онцгой анхаарч, нийслэл орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон төсөвт байгууллагуудыг тохирлын баталгаатай, эрүүл, аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах, үйлдвэрлэгчдийг төрийн худалдан авалт, даатгалын сангийн зарцуулалтаар дэмжих ажлыг зохион байгуулах;	2024-2025 хичээлийн жилд цахим дэлгүүрт байршсан 14 аж ахуйн нэгж байгууллагаас 20 цэцэрлэг, 59 ерөнхий боловсролын сургууль, 2 их сургууль нийт 81 байгууллага 45 нэр төрлийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг 545.5 сая төгрөгөөр худалдан авалт хийсэн байна. Сүүний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр Дэлхийн сүүний өдрөөр сүүний ая холбогдол хэрэглээг сурталчлах ажлыг хийсэн. Мөн Хэрэглэгчдийг эрүүл, аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор Хүнсний тухай хуулийн 10.2, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу Эрүүл мэндийн яамтай хамтран “Сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ыг батлуулсан. Засгийн газрын 2022 оны 69 дүгээр тогтоолоор “Сүү бэлтгэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ыг шинэчлэн батлуулсан. Хавсралт : 3 файл	Хэрэгжсэн - 100%
	234		1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	1.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн 18 суманд хоногт 1000 л сүү хүлээн авч, боловсруулж европ бяслаг болон сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий иж бүрэн /шугам сүлжээний дэд бүтэц бүхий/ үйлдвэр, Булган аймгийн Тэшиг суманд хоногт 6000 л сүү хүлээн авч, боловсруулах хүчин чадал бүхий “Цөцгийн тос үйлдвэрлэх сүүний ферм”, Орхон аймагт цагаан идээ боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл хэтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, Хөвсгөл аймагт 7 бяслагийн үйлдвэрийн барилга угсралтын ажил дуусаж, Орхон аймагт цагаан идээ савлах 8 багц тоног төхөөрөмжийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт шилжүүлж ажилласан. 2024-2025 онд “ОРОН НУТГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ “БЯСЛАГ” төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр, Мөрөн, Архангай, Тариат суманд бяслагийн үйлдвэрийг барихаар 2024 оны төсөвт тусгагдсан. Төв аймагт 10 өрхийн 200 үнээний сүүний кластер фермийн ээлжит төслийн барилгын ажлыг эхлүүлсэн. “Цуна Монгол Дай” ХХК 6.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан байр, фермер өрхийн сууц, тэжээл тариалах талбай, гүний худаг, эмчилгээ, тэжээлийн бааз, нарлагааны хашаа, өсвөр үхрийн байр бүхий 200 үнээний цогцолбор аж ахуй ашиглалтад оруулж, Франц улсаас 65 толгой монбелияард үнээг импортолж, үйл ажиллагаагаа жигдрүүлээд байна. Төв аймгийн хэмжээнд сүүний үхрийн 5 кластер аж ахуй (Архуст, Баяндэлгэр, Баянхангай, Баянчандмань суманд) үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2023 онд 4 суманд 13 тн-ын багтаамж бүхий 5 хөргөлтийн төвийг шинээр байгуулсан. Батсүмбэр суманд 1 цагт 4 тн Хорголжин тэжээлийн үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг байгуулахаар 10 га газрын асуудлыг шийдвэрлэж ажилласан байна. Заамар сумын “Өгсөл ар урт” хоршоонд малын тэжээлийн үйлдвэр байгуулах чиглэлээр 2 га газрын асуудлыг шийдвэрлэж, 75.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлд хамрагдаж гурван төрлийн баяжуулсан тэжээл үйлдвэрлэх цех шинээр байгуулсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
59	235	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-10-26 Дугаар 2022 №08 ҮББХ	4. Баруун, зүүн бүсийн үйлдвэрлэл, технологийн паркийн (Ховд, Дорнод) дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх, “Шинэ Ховд” үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, цэвэрлэх байгууламжийн ажил удааширсан шалтгааныг тодруулан хариуцлага тооцож, цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг түргэвчлэх	Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн төслийн хөрөнгө оруулалт 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2026 онд бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусахаар төлөвлөсөн. Тус төслийн нийт төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг бөгөөд 5-н багц арга хэмжээнд хувааж Оффрөүд таван богд ХХК, Воком констракшн ХХК, Эм Ай Эс Эс ХХК, Монкабель ХХК, Жаргалантлуу ХХК тус тус гүйцэтгэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 90.8 хувьтай. - ХХААХҮЯ-наас 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр зарласан “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй XVI.I.I “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн /Ховд, Жаргалант сум/” ТЭЗҮ, зураг төсөв, төсөл боловсруулах, тоног төхөөрөмжид шаардлагатай засвар үйлчилгээ хийж угсарч суурилуулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад “Саруул цамхаг” ХХК нь шалгарч 4.7 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр №181015/06-393 дугаартай гэрээг байгуулсан. Барилгын хөгжлийн төвийн 2019 оны магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөвт өртөг нь 6.9 тэрбум төгрөг болж нэмэгдсэн. Үндэсний Аудитын газрын 2024 оны 03 дугаар сарын 29-ний 08/891 дугаар дүгнэлтээр үнийн зөрүү 1,720,986,829 төгрөг болсон. - Арьс шир	Ахиц гарсан - 50%

				боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төслийг 2023 онд гүйцэтгүүлэн, нийт төсөв 9,438,212,994 төгрөг, “Цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээний төсөв боловсруулах, барих” ажлын хүрээнд парк доторх цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажлын зураг төслийг 2023 онд гүйцэтгүүлэн, нийт төсөв 3,953,593,248 төгрөгөөр тус тус батлагдсан болно.	
60	236	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-10-26 Дугаар 2022 №08 УББХ	1/. "Дархан арьс ширний цогцолбор” орон нутгийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, төсвийг холбогдох хууль хяналтын байгууллагаар шалгуулж, гаргасан дүгнэлтэд үндэслэн хуулийн дагуу шийдвэрлэх, эдийн засаг, төсөв санхүүгийн хүндрэлтэй үед Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас дээрх цогцолбортой ижил төстэй, тусдаа дэд бүтэц бүхий төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах шийдвэрийг гаргаж, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулж байгааг таслан зогсоож, гаргасан шийдвэрийг Улсын Их Хуралд танилцуулах;	1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 256, 2025 оны 96 дугаар тогтоолоор "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэрийг "Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж өөрчилсөн. Тус ТӨХХК нь Дархан-Уул аймгийн Хонгор суманд 25 га газарт хүнс болон хөнгөн үйлдвэрийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийн үйлдвэр барих аж ахуйн нэгжүүдийг холбогдох дэд бүтэц болон төрөөс үзүүлэх дэмжлэгээр хангах зорилготой. 2025 онд Авто зам /6,59 тэрбум төгрөг/, авто замын техник, технологийн хяналтын ажил /260 сая төгрөг/, гадна холбоо дохиололын ажил /250 сая төгрөг/-ын тендерийг зарлан, гүйцэтгэгчтэй гэрээг байгуулаад байна. 2. “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-аас Хөгжлийн банкны зээлийн төлбөрт тооцон шилжүүлэхээр санал болгосон дуусаагүй гүйцэтгэлтэй дэд бүтцийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн бодит гүйцэтгэлийг батлагдсан зураг төсөл, төсөвтэй харьцуулж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий БХБСайд, ХХААХҮСайд, ЭХСайд нарын хамтарсан 2023.03.10-ны өдрийн 44, А/68/А75 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023.03.11, 12-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт байрлах төслийн талбай дээр ажиллаж, нэгдсэн санал, дүгнэлт гаргасан. Одоогийн байдлаар “Дархан арьс ширний цогцолбор” ХХК болон “Монгол Улсын Хөгжлийн банк” хооронд дэд бүтцийн бүтээн байгуулалтын эцсийн өмчлөгчийн асуудлыг шийдвэрлэсний дараа хамтран ажиллахад бэлэн байгаа тухай ХХААХҮ-ийн сайдын 2023.08.03-ны өдрийн 01/2715 дугаар албан бичгийг “ДАШЦ” ХХК-д хүргүүлсэн. - ХХААХҮЯ-ны зүгээс Хөгжлийн банк “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-ийн хоорондын маргаантай асуудал шийдэгдэх хүртэл хамтын ажиллагааны хэлэлцээг түр зогсоосон болно.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	237		3/. Арьс ширний үйлдвэрүүдийг Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд түүхий эдийн бодит нөөц, үйлдвэрүүдийн чиглэл, хүчин чадлын хэрэгцээг тооцож, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлж ажиллах;	1) Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэн, паркийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Нийслэлийн төсөвт шаардлагатай төсвийг батлуулж, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн суурь дэд бүтэц “24 МВт-ын Дулааны цахилгаан станц, Бохир ус цэвэрлэх байгууламж”-ийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын "Хуа Зи Технологи” ХХК , “Хуа Ши Энержи Индастри” ХХК-ийн түншлэгч компаниудтай “ЭМЭЭЛТ ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРКИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ, БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ (EPC) ГЭРЭЭ”-г байгууллаа. Гэрээгээр 24МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц болоод ахуйн болон үйлдвэрийн бохир ус цэвэрлэх 6'700 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг 2027 онд ашиглалтад оруулна. 2) Паркт байрших ААН-үүдтэй паркийн нэгжийн гэрээ болон газар ашиглуулах гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар Булигаар ХК, Арилдий ХХК, Мон-Ирээдүй ХХК, Түмэн-Шир ХХК, "Аура кашмер" ХХК, "ҮЖИН ПАРТНЕРС" ХХК, "ИХ АСАР" ХХК-тай "Эмээлт эко аж үйлдвэрийн паркт үйл ажиллагаа явуулах нэгжийн гэрээ" болон "Паркт газар ашиглуулах гэрээ"-г байгуулан ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав. Хавсралт : 1 файл	Ахиц гарсан - 50%
	238		4/. Баруун, зүүн бүсийн үйлдвэрлэл, технологийн паркийн (Ховд, Дорнод) дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх, “Шинэ Ховд” үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, цэвэрлэх байгууламжийн ажил удааширсан шалтгааныг тодруулан хариуцлага тооцож, цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг түргэвчлэх;	Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн төслийн хөрөнгө оруулалт 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2026 онд бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусахаар төлөвлөсөн. Тус төслийн нийт төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг бөгөөд 5-н багц арга хэмжээнд хувааж Оффрөүд таван богд ХХК, Воком констракшн ХХК, Эм Ай Эс Эс ХХК, Монкабель ХХК, Жаргалантлуу ХХК тус тус гүйцэтгэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 90.8 хувьтай. - ХХААХҮЯ-наас 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр зарласан “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй XVI.I.I “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн /Ховд, Жаргалант сум/” ТЭЗҮ, зураг төсөв, төсөл боловсруулах, тоног төхөөрөмжид шаардлагатай засвар үйлчилгээ хийж угсарч суурилуулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад	Ахиц гарсан - 50%

				“Саруул цамхаг” ХХК нь шалгарч 4.7 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр №181015/06-393 дугаартай гэрээг байгуулсан. Барилгын хөгжлийн төвийн 2019 оны магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөвт өртөг нь 6.9 тэрбум төгрөг болж нэмэгдсэн. Үндэсний Аудитын газрын 2024 оны 03 дугаар сарын 29-ний 08/891 дугаар дүгнэлтээр үнийн зөрүү 1,720,986,829 төгрөг болсон. - Арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төслийг 2023 онд гүйцэтгүүлэн, нийт төсөв 9,438,212,994 төгрөг, “Цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээний төсөв боловсруулах, барих” ажлын хүрээнд парк доторх цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажлын зураг төслийг 2023 онд гүйцэтгүүлэн, нийт төсөв 3,953,593,248 төгрөгөөр тус тус батлагдсан болно. Үр нөлөө : “Шинэ Ховд” үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Нийт ажлын гүйцэтгэл 90.8 хувьтай. Цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай төсвийг бүрэн тусгуулан батлуулсан. Хавсралт : 1 файл	
61	239	Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №02 БОХХААБХ	1.1/. Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай: 1/ Мал, мах, махан бүтээгдэхүүний экспортын зөвшөөрлийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан "нэг цонх" -ны цахим системээр хэрэгжүүлэх, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох:	ХХААХҮ-ийн сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/372 дугаар тушаалын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын нэг цонхны цахим систем”-ийг (export.mofa.gov.mn) нэвтрүүлсэн. Уг системийг нэвтрүүлснээр төрийн болон төрийн бус байгууллагын ажлын уялдаа холбоо сайжирч, мах, махан бүтээгдэхүүн экспортлох үеийн баримт бичиг бүрдүүлэх, 4 байгууллагаас экспортын гэрчилгээ авахад зарцуулдаг байсан 13 хоногийн хугацааг бууруулж, ажлын 8 цагт багтаасан бөгөөд уг цахим системээр 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс хойш нийт мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжийн 1126 хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн. Хяналтаас хасуулах санал : Тус системээр экспортын гэрчилгээ олгох үйл ажиллагаа хийгдэж хэвшсэн тул энэхүү заалтыг хасуулах саналтай байна.	Хэрэгжсэн - 100%
	240		1.2/. Итпортлогч улсын хорио уээрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;	1. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох 20, самар экспортлох 7 аж ахуйн нэгжийн хүсэлт, холбогдох материалыг хянан баталгаажуулж, тус улсын Гаалийн ерөнхий газарт цахимаар уламжилж, Монгол Улсаас БНХАУ-ын ГЕГ-тай хамтран 2 удаа цахим шалгалтыг зохион байгуулж, мах, махан бүтээгдэхүүн экспортлох хүсэлт гаргасан 7 аж ахуйн нэгжийг хамруулсан. 2. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж, тус улсын Гаалийн ерөнхий газрын цахим системд мах, махан бүтээгдэхүүн экспортлох 7 /адууны мах экспортлох 4, дулааны аргаар боловсруулсан мах экспортлох 7/, самар экспортлох 5, загас экспортлох 1, сүүн бүтээгдэхүүн экспортлох 1, нийт 14 аж ахуйн нэгжийг шинээр бүртгүүлсэн. 3. БНХАУ-ын ГЕГ-тай 2024.04.17-ны өдөр Бээжин хотод уулзалт зохион байгуулж, мах, махан бүтээгдэхүүний экспортын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Энэ хүрээнд ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2024.05.17-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/253 дугаар тушаалаар тус газартай хамтран ажиллах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, БНХАУ-д адууны дайвар бүтээгдэхүүн, дулааны аргаар боловсруулсан дотор мах, дайвар бүтээгдэхүүн экспортлохтой холбогдсон хяналт, хорио цээр, мал эмнэлэг ариун цэврийн шаардлагын тухай протоколын төслийг монгол, англи, хятад хэл дээр тус тус боловсруулж, ХХААХҮ-ийн сайдын албан бичгээр БНХАУ-ын ГЕГ-т хүргүүлсэн. Хяналтаас хасуулах санал : хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, экспортлох үйлдвэрийн тоог нэмэгдүүлсэн байна.	Хэрэгжсэн - 100%
	241		1.3/. Мал, аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл, мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт зохистой дадл, аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (HACCP), хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 22000 стандартыг нэвтрүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;	2023 онд Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 22000 стандартаар 15 аж ахуйн нэгж, Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянах тогтолцооны (HACCP) стандартаар 17 аж ахуйн нэгж гэрчилгээжсэн байна. 2024 онд ISO 22000 стандарт 2, ХАЛАЛ-6, HACCP-3 гэрчилгээ авсан. 2025 онд урьдчилсан байдлаар SO 22000 стандарт 4, HACCP-8 гэрчилгээ авсан. Нийт 55 ISO 22000, HACCP, халал стандарт нэвтрүүлсэн байна.	Хэрэгжсэн - 100%
	242		1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, импортлогч улсын болон Дэлхийн мал амьтны	"Малын эрүүл мэндийг хамгаалах, баталгаажуулах, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих, олон улсын стандартыг нэвтрүүлэх	Хэрэгжсэн - 100%

			эрүүл мэндийн байгууллагын шаардлагын дагуу мал төхөөрөх үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал, эргэлтэд нийцсэн эрүүл, хорио цээрийн тусгаарлалтын бүсийг байгуулахад дэмжлэг үзүүлэх;	зорилгоор “Хамгаалалттай аж ахуй”-н журмыг боловсруулах ажлын хэсэгт ажиллан ХХААХҮЯ-ны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр А/249 тушаалаар ""Хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах хянах"" журмыг батлуулсан. Журмыг олон нийтэд болон холбогдох байгууллагуудад танилцуулан харьяа байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгөв. Журмын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд МЭЕГ-ын даргын 2024 оны А/501 дугаар тушаалаар хамгаалалттай аж ахуйд мөрдөх "Биохамгааллын нийтлэг заавар"-ыг батлуулан мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах эрх зүйн зохицуулалтуудыг бий болгон ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллаа.	
	243		1.5/. Малын дайвар түүхий эдийн бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох үеийн мал эмнэлэг, хорио цээр, ариун цэврийн нөхцөл шаардлагын протоколыг импортлогч улстай харилцан тохиролцох ажлыг эрчимжүүлэх;	"Гаалийн Ерөнхий Газраас экспортын гэрчилгээ. импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл хүлээн авч 2025 оны онд иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн экспорт, импортын 8218 хүсэлтийг Export.mofa.gov.mn нэг цонхны үйлчилгээний цахим системээр шийдвэрлэж ажлын 8 цагт багтаан олгож байна. 2025 онд БНХАУ, ОХУ, Кувейт, Солонгос, Казакстан, Вьетнам, Япон, Хонконг, Катар, Ирак, Таджикастан, Иран, Арабын Нэгдсэн Эмират улс, Азарбайжан, Турк, Узбекистан, Туркеминстан, БНАСАУ, Бахрайн зэрэг 19 улсад 28720.9 тн адууны мах, 30 тн үхрийн мах, 18878,97 тн хонины түүхий мах, 2484,52 тн ямааны түүхий мах, дулааны аргаар боловсруулсан 35 тн хонины мах, 3778,1 тн үхрийн мах, 15099 тн, ямааны мах 2001.5 тн дайвар бүтээгдэхүүн, 31 тн нөөшөлсөн бүтээгдэхүүн, 31 тн махтай шөл, 430 тн ясны шөл, нийт 71519,9 тн мах махан бүтээгдэхүүн, 395 шонхор, 150589 гогцоо бог малын өлөн гэдэс, 60 тн бугын эвэр, 188 толгой ангийн олзвор, 11344 тн малын гаралтай өөхөн тос, 2815 тн ясны тос, 200 тн ясны үнс, 250 тн пептон, 480 кг айраг, 83 тн ямааны хуурай сүү, 7847,545.8 тн ноос, ноолуур, дэл, сүүл, хонины ноос, тэмээний ноос, адууны сүүл, адууны дэл, 188935 ширхэг хонь, ямааны арьс, үхэр, адууны шир, 74190 толгой хонь, ямаа, 5,1 тн нохой, муурны хоол, 6785,9 тн байгалийн хадлан өвс, Узбекистан улсад 86549 толгой хонь, БНХАУ-д 17700 толгой хонь, 98 толгой үржлийн адуу, Монгол улсын Ерөнхийлөгчийн бэлэглэсэн 4 адуу, 219 толгой гэрийн тэжээвэр нохой, муур, экспортонд гарахад 7350 экспортын гэрчилгээ олгосон. Импортын бүтээгдэхүүн 16 төрлийн мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд 868 мал амьтны гаралтай түүхий эд бүтээдэхүүний олон улсын импортын гэрчилгээ бичигдсэн. 15126260 ширхэг хүнсний өндөг, 1295040 ширхэг үржлийн өндөг, 352939.82 тн тахианы мах, 59818 тн гахайн мах, толгой 557 тн үхрийн мах, 233 тн нугасны мах, 16,1 тн нөөшөлсөн бүтээгдэхүүн, 300 тн хонь, ямааны хялгас, 2658 тн загас, далайн гаралтай бүтээгдэхүүн, 50 тн бууз, банш импортлогдсон.	Ахиц гарсан - 50%
	244		1.6/. Малын үйлдвэр угсааг сайжруулах, махны гарцийг нэмэгдүүлэх зорилгоор өндөр ашиг шимтэй, Монгол орны байгаль, цаг уурын онцлогт тохирсон цэвэр үүлдрийн хээлтүүлэгч малыг импортлох болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бодлого, санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх;	Махны үхрийн аж ахуй эрхэлж буй 3 аж ахуйн нэгж 2023-2024 онд хосолмол ашиг шимтэй 330, махны 544, нийт 874 толгой үхрийг импортолж, цэвэр үүлдрийн үхрийн тоо жил бүр 10 хувиар өсгөх боломж бүрдсэн. Мөн мах үйлдвэрлэлийн хэмжээ 5 хувиар нэмэгдсэн. Улсын төсвийн нийт 499.0 сая төгрөгийн санхүүжилтээр хуц 792 /Хотонт, Тамир, Керей, Баянбулаг, Баяд, Говь-Алтай, Сүмбэр, Монгол, Барга, Буриад, Сайнцагаан, Сартуул, Гавилууд, Үзэмчин, Хангай, Ерөө зэрэг үүлдэр, омог/, ухна 610 /Уулын бор, Залаа жинст эдрэн, Эрчимийн хар, Монгол, Дэлгэрэхийн улаан, Завхан буурал, Цогт-Овоогийн улаан, Баяндэлгэрийн улаан, Өнжүүл, Өлгийн улаан, Галшарын улаан зэрэг үүлдэр, омог/, бүгд 1402 хээлтүүлэгчийг худалдан авч Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгжид 5 жилийн хугацаатай гэрээ, нийт 18 аймгийн 25 нэгжид хүлээлгэн өгч, бодлогоор дэмжсэн. УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд нийт махны үхрийн 13 аж ахуйн нэгж нийт 17,54 тэрбум төгрөгийн эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл авсан бол сүүний үхрийн аж ахуй эрхэлж байгаа 7 аж ахуйн нэгж нийт 9.24 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна. Тус аж ахуйн нэгжүүд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, цэвэр үүлдрийн арвин ашиг шимтэй үржлийн үхэр болон нэгдүгээр үеийн эрлийз үхрийн тоо 1838 толгойгоор нэмэгдээд байна. Мөн Засгийн газрын “Аян өрнүүлэх тухай” 47 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжиж буй Атар-4 хүрээнд махны үхрийн аж ахуй эрхэлж байгаа 25 иргэн аж ахуйн нэгж 18.86, сүүний үхрийн аж ахуй эрхэлж байгаа 24 иргэн, аж ахуйн нэгж 40.91, өсвөр мал бордох аж ахуй эрхэлж байгаа 17 иргэн, аж ахуйн нэгж 6.75 нийт 66.52 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авааД байна. Зээлийн үр дүнд аж ахуйн нэгжүүд дэвшилтэд техник, тоног төхөөрөмж, цэвэр	Хэрэгжсэн - 100%

				үүлдрийн болон нэгдүгээр үеийн эрлийз арвин ашиг шимт үржлийн үхэр худалдан авч үйл ажиллагаагаа өргөжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ нэмэгдүүлээд байна.	
	245		1.9/. Баян-Өлгий аймгийн Цагааннуур суманд малын гоц халдварт өвчингүй хорио цээрийн тусгаарлагдсан бүсэд эрүүл мах, мах бэлтгэх цогцолбор төв байгуулах;	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, Засгийн газрын 424 дүгээр тогтоол “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай”, Монгол Улсын Их хурлын байнгын хорооны 2-р тогтоол, ХХАААХҮСайдын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/362 дугаар “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс” тушаалын дагуу Малын эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, экспортын тогтвортой байдлыг хангах зорилгоор талбайд "Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс" шинээр байгуулах ажлын төлөвлөлт, техникийн шаардлагыг бэлтгэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, хамтран ажиллахаар МЭЕГ-ын даргын 2023 оны 10 сарын 31-ний өдрийн А/288 тоот тушаалын дагуу Баян-Өлгий аймгийн Цагааннуур суманд малын гоц халдварт өвчингүй хорио цээрийн тусгаарлагдсан бүсэд эрүүл мах, мах бэлтгэх цогцолбор төв байгуулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. МЭЕГ-аас авч хэрэгжүүлэх бүх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Тус зааltыг хасуулах саналтай. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн тул хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
	246		2.. энэ тогтоолынбиелэлтийг БОХХААБХ-нд 2023 оны хаврын чуулганы хугацаанд багтааж танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.	Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны байнгын хорооны тогтоолын биелэлтийг 2023 оны хаврын чуулганд багтаан танилцуулсан. Бүрэн хэрэгжсэн тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Бүрэн хэрэгжсэн тул хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
62	247	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ	2ж/. эдийн засгийн ил тод байдлыг хангах хүрээнд худалдаа, үйлчилгээний байгууллагын борлуулалтын орлогыг кассын машины баримтад үндэслэн тооцож татвар, хураамжийг ногдуулдаг тогтолцоог судалгаанд үндэслэн боловсронгуй болгох арга хэмжээг авах.	Хамаарах заалт биш байх тул хасах саналтай байна. Хяналтаас хасуулах санал : Чиг үүрэгт хамааралгүй.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
	248		6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	ХХАААХҮ-ийн салбарын 2026 оны төсвийн төлөвлөгөөг боловсруулах явцад иргэд, олон нийт, мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудаас саналыг авч ажилласан	Хэрэгжсэн - 100%
	249		5а/. аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоох аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэх, жил бүр Засгийн газраас Засаг дарга нартай байгуулдаг үр дүнгийн гэрээнд индексийг тусган, биелэлтийг хянах;	Монгол Улсын Засгийн газрын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зарим чиг үүргийг аймаг нийслэлд төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээг хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах урсгал зардал болон бусад зардал, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт тус бүрийг тусган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нийслэл, 21 аймгийн Засаг дарга нартай байгуулсан бөгөөд 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж урьдчилсан байдлаар удирдлагад танилцуулсан.	Хэрэгжсэн - 100%
63	250	Аймаг дундын отрын бүс нутаг, бэлчээр ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-07-04 Дугаар 2023 №13 БОХХААБХ	1.1/. Аймаг дундын отрын бүс нутаг, бэлчээр ашиглалтын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.1/Аймаг дундын отрын бүс нутгийн өнөөгийн байдлын талаар холбогдох мэргэжлийн байгууллагаар судалгаа, дүгнэлтийг гаргуулсны үндсэн дээр отрын бүс нутгуудын асуудлаар шаардлагатай арга хэмжээг цогц байдлаар шийдвэрлэх;	НҮБ-ын АДАПТ төсөл, “Өнө мөнхийн Монгол ТНС олон улсын байгууллага, Даян дэлхийн байгаль орчны сангийн хөрөнгө оруулалттай Хангайн бүсийн уулын ландшафтыг нөхөн сэргээн хамгаалах замаар эко системийн үйлчилгээ болон орон нутгийн иргэдийн амжиргааг сайжруулах төсөл, хөтөлбөрүүдтэй Аймаг дундын отрын бүс нутгийн өнөөгийн байдлын талаар холбогдох мэргэжлийн байгууллагаар судалгаа, дүгнэлтийг гаргуулах, хамтран ажиллах талаар уулзалт зохион байгуулж, отрын бүс нутгуудын асуудлаар шаардлагатай арга хэмжээг цогц байдлаар шийдвэрлэх чиглэлээр хүсэлт хүргүүлэн ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Ахиц гарсан - 50%
	251		1.2/. Аймаг, дундын отрын бүс нутагт хамаарах соёлын өв, түүхийн дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;	Аймаг, дундын отрын бүс нутагт хамаарах соёлын өв, түүхийн дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх талаар аймгуудын Засаг дарга нар болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт хүсэлт хүргүүлэн, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байна	Х.Б
	252		1.3/. Аймаг, дундын отрын бүс нутгийн бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах болон бүс нутгийн	Аймаг, дундын отрын бүс нутгийн бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах болон бүс нутгийн захиргааны ажиллах дүрэм, журмыг шинэчлэх хүрээнд дараах үр дүнд хүрсэн. Үүнд: ЗГ-ын	Хэрэгжсэн - 100%

			захиргааны ажиллах дүрэм, журмыг шинэчлэх, бүс дамнасан отор нүүдлийг зогсоож, босоо чиглэлд отор нүүдэл хийх, отрын бүс нутагт өвөлжиж хаваржсан малын тоо толгойн албан татварыг тухайн сум орон нутагт төлдөг байх, отрын бүсээс хугацаандаа гараагүй малчдад хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх;	2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 112 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Аймаг дундын отрын бэлчээр ашиглах нийтлэг журам"-ын 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ажлын төлөвлөгөө боловсруулж, ХХААХҮ-ийн сайдын 2025.03.13-ны өдрийн "Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээрийг ашиглах, хамгаалах төлөвлөгөө батлах тухай " А/105 дугаар тушаалаар батлуулж, АДОБАЗ-д хүргүүлсэн. 2.МУ-ын ЗГ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, ЗГ-ын 2007 оны “Отрын бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 187 дугаар тогтоолын 4 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 112 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн АДОБАЗ-ны дүрмийг боловсруулж, ХХААХҮ-ийн сайдын 2025.03.13-ны өдрийн "Дүрэм шинэчлэн батлах тухай" А/106 дугаар тушаалаар батлуулж, АДОБАЗ-д хүргүүлсэн. 3.МУ-ын ЗГ-ын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 112 дугаар тогтоолын 2.3 дахь заалтыг үндэслэн Орон тооны бус зөвлөлийн ажиллах журам боловсруулж, ХХААХҮ-ийн сайдын 2025.05.12-ны өдрийн "Улсын тусгай хэрэгцээний отрын бэлчээр ашиглалтыг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай" А/234 дүгээр тушаалаар батлуулсан. Бүс дамнасан отор нүүдлийг зогсоож, босоо чиглэлд отор нүүдэл хийх, отрын бүс нутагт өвөлжиж хаваржсан малын тоо толгойн албан татварыг тухайн сум, орон нутагт төлдөг байх, отрын бүсээс хугацаандаа гараагүй малчдад хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэхээр Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулж, холбогдох судалгааг хийгээд байна. Хавсралт : 3 файл	
	253		1.4/. Аймаг, дундын отрын бүсийн захиргааг Улаанбаатар хотод шилжүүлэх, отрын бүсүүдэд ажиллах мэргэжилтнүүдэд байцаагчийн эрх олгох, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;	Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/512 дугаартай “Төрийн байгууллагыг нийслэл Улаанбаатар хотод шилжүүлэн ажиллуулах тухай” тушаалаар Булган аймгийн Дашинчилэн сумаас Улаанбаатар хотын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Судалгаа хөгжлийн төвийн байранд шилжин ирсэн. Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймаг руу нүүлгэх шийдвэрийн дагуу Улаанбаатар хотоос Дархан-Уул аймгийн Хонгор суманд “Малын удмын сангийн үндэсний төв”-ийн байранд нүүж ирсэн. Байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс Дархан-Уул аймгийн Дархан сумын “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн байранд нүүж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. АДОБАЗ-ны мэргэжилтнүүдийн ажиллах, нөхцөл нийгмийн баталгааг хангахаар өвөл, зуны иж бүрэн хувцсаар хангаж ажиллаа. Отрын бүсийн ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтнүүдэд байцаагчийн эрх олгох тухай саналыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажилласан. Үр нөлөө : Дараагийн шатны шийдвэр гарч Дархан-Уул аймагт шилжин байршиж үйл ажиллагаа явуулж байна.	Хэрэгжсэн - 100%
	254		1.5/. Цаг хүндэрсэн үед ашиглах орон нутгийн тусгай хэрэгцээний газрын отрын бүс нутгийн бэлчээрийн газрын талбайн хэмжээг нэмэгдүүлэх, зүй зохистой ашиглах, тохижилт үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын болон сум дундын отрын нөөц бэлчээрийг нэмэгдүүлэхээр Засгийн газрын 384 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн чиг хандлага, Хөдөө аж ахуйн газрын Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд 1. Хэнтий, Сүхбаатар аймгийн Баян-Овоо, Түмэнцогт сумдын Намхар нэртэй газар /30620,9 га/, 2. Дорнод аймгийн Матад, Булган сумдын “Зэрэглээт ухаа” нэртэй газар /192126,9 га/ 3. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Дуулга нэртэй газар /23748,6 га/, 4. Архангай, Завхан аймгийн Цахир, Тосонцэнгэл, Их-Уул сумдын Загастай нэртэй газар /10739,7 га/, 5. Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Цэнхэр, Эрдэнэцогт,Бат-Өлзий сумдын Ямаат нэртэй газар /22860,2 га/, 6. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Хэрлэн, Биндэр сумдын “Тахилга” нэртэй газар /7235,6 га/ тус тус аймаг дундын отрын бүс нутаг болгох санал тусгагдсан. Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний отрын бүс нутаг шинээр байгуулах, отрын бүсийн талбайн хэмжээг өргөжүүлэх, судалгаа хийх, хамтран ажиллах талаарх саналыг Архангай, Ховд, Дорнод, Сүхбаатар, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий, Баянхонгор аймгийн Засаг дарга нарт Аймаг дундын отрын бэлчээр	Х.Б

				ашиглалтын захиргааны даргын 2025 оны 163 тоот албан бичгээр хүргүүлсэн ажилласан. ХХААХҮ-ийн сайдын холбогдох аймгуудын Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нартай байгуулах 2026 оны “Үр дүнгийн гэрээ”-нд заалтыг тусгаж хэрэгжүүлэх тухай албан хүсэлтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон аймгийн удирдлагуудад Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны даргын 2025 оны 165, 187 тоот албан бичгийг тус тус хүргүүлэн ажилласан. Шийдвэрийг аймгуудын Засаг дарга нар гаргах тул АДОБАЗ-аас албан бичиг хүргүүлэх зэргээр өөрөөс хамаарах арга хэмжээг авч ажиллаж байна. Хугацаа шаардлагатай.	
	255		1.6/. Монгол Улсын нутаг дэвсгэрийн босоо чиглэлд отор нүүдэл зохион байгуулах, мал эмнэлгийн хяналтын явуулын постыг отрын малын дамжин өнгөрөх бэлчээрт байгуулах;	Улсын тусгай хэрэгцээний отрын 9 бүсэд 2025-2026 онд өвөлжих, хаваржих малчдын орох гарах чиглэлийн зураглал болон мал эмнэлгийн түр цэгийн байршлыг Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны даргын 2025 оны А/82 дугаар тушаалаар батлаж, тушаалын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллаж байна. Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаварт тусгагдсан Отрын бүс нутгийг “Эрүүл бүс” болгох зорилтын хүрээнд аймаг дундын 9 отрын бүсэд "Малын эрүүл мэндийн нэгдсэн төв" байгуулах ажлыг эхний ээлжинд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан отрын бүсэд хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд тус төвийг байнгын үйл ажиллагаатай байлгах зорилгоор хамтран ажиллах талаарх саналыг хувийн хэвшил, төсөл хөтөлбөрүүдэд танилцуулан уулзалтууд зохион байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд олон улсын төсөл, хөтөлбөрийн мэргэжилтэн Л.Амарсанаатай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хамтран ажиллаж, дараах 3 үндсэн ажлын бэлтгэл шатны ажлыг хэрэгжүүлсэн. Засгийн газрын 2020 оны 196 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийг Архангай аймгийн Цахир сумын Солонготын давааны ам, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүр, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Төв аймгийн Лүн сумын Айрагийн энгэр, Нийслэлийн Багануур дүүргийн Хэрлэнгийн гүүр, Сонгинохайрхан дүүргийн Баруунтуруун, Эмээлт, Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо Тавантолгойн уулзвар, 14 дүгээр хороо Хөндлөн уулын арын байнгын ажиллагаатай мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг болон Нийслэлийн Засаг даргын Мал эмнэлгийн хяналтын хорио цээрийн хяналтын цэгүүд ажиллуулах тухай А/858 дугаар захирамжаар 4 хяналтын цэг нэмж байгуулан мал эмнэлгийн улсын байцаагч, цагдаагийн албан хаагчид хамтран нар мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл, баталгаажилтад хяналт шалгалт хийж ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%
	256		1.7/. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын бүртгэл, хяналтын нэгдсэн систем нэвтрүүлэх, цахимжуулах.	Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, отрын бүсийн үйл ажиллагааг цахимжуулж бүртгэлжүүлэх үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор НҮБ-ын Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг бэхжүүлэх зорилго бүхий “АДАПТ төслийн 222,7 сая төгрөгийн санхүүжилтээр “Otorchin.gov.mn” цахим системийг 2024 оноос хөгжүүлж, тус системээр дамжуулан аймаг дундын отрын бүс нутагт өвөлжих малчдын хүсэлтийг цахимаар авч хянаж, зөвшөөрлийг олгох бөгөөд үүний хүрээнд -Бэлчээрийн даацын мэдээлэл -Бэлчээр хамгаалах ажиллагаа, -Бэлчээр сайжруулах, хортон мэрэгч устгах мэдээлэл, -Малын хорогдол бүртгэл, -Отрын бэлчээр нутгийн зураглал -Өвөлжөө хаваржаа, худаг уст цэгийн байршил, -Бэлчээрийн даац тодорхойлох мониторингийн цэг, -Отрын бүс нутгийн орох, гарах маршрутын зураглал, -Сэг зэм устгалын цэг зэрэг мэдээллүүдийг солбилцлын хамт бүртгэх, засварлах боломжтойгоор хөгжүүлэлт хийсэн. “OTORCHIN.GOV.MN” цахим системд Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын Орон тооны бус зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, малчид болон сумдын ЗДТГ-тай байгуулсан гэрээний мэдээллийг цахимаар бүртгэх, дүгнэх, зөрчлийн мэдээлэл бүртгэх ажлыг системээр дамжуулан гүйцэтгэх боломжтой. 2025-2026 онд отроор өвөлжих, хаваржих малчдын хүсэлтийг OTORCHIN.GOV.MN цахим системд хүлээн авч Орон тооны бус зөвлөлийн хурлын дүгнэлтийн дагуу отрын бүсийн бэлчээрийн даацад тохируулан 12 аймгийн 35 сумын 414 өрхийн 651892 хонин толгой малд OTORCHIN.GOV.MN цахим системээр дамжуулан зөвшөөрлийг олгон ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%
	257		2.. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтааж	2023-2024 оны өвөл хаврын улиралд 18.8 мянган малчин өрхийн 7.8 сая толгой мал отор нүүдлээр өвөлжсөн. Мөн зудын гамшгийн улмаас 4 аймгийн 6 суманд отрын штаб байгуулагдсан. 1037 өрхийн 654.4 мянган толгой мал Дорнод аймгийн Матад, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум, Хэрлэнбаян-Улаан отрын бүс, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Мөрөн,	Хэрэгжсэн - 100%

			танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай. /ХХААХҮЯ нэгтгэн танилцуулна/	Улаан-Уул сумдад өвөлжсөн. отрын бүс нутагт ХХААГ, ЭМГ, Цагдаа, Онцгой, Мал эмнэлэг, Эрүүл мэндийн байгууллагын 93 ажилтан албан хаагч үүрэг гүйцэтгэж ажилласан. Мөн Дорнод аймгийн Матад сумын нутагт шуурганд уруудсан 8000 гаруй адууг тогтоон, бүртгэлжүүлэх, эзнийг нь тогтоон хүлээлгэн өгөх ажил хийгдсэн байна. Тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтааж танилцуулахад удирдлагыг холбогдох мэдээллээр хангаж ажилласан. Энэ оны хувьд Улсын хэмжээнд отроор 16.6 мянган малчин өрхийн 5,724.0 мянган толгой мал өвөлжихөөр байна. Отор нүүдлийг бүсээр авч үзвэл: • Баруун бүсийн 5 аймгийн хэмжээнд 6,425 мянган малчин өрхийн 2,421.8 мянган толгой мал буюу улсын хэмжээнд хамгийн мал оторлохоор байна. • Хангай бүсийн 3 аймгийн хэмжээнд 2,856 малчин өрхийн 660.8 мянган толгой мал, • Хойд бүсийн 3 аймгийн хэмжээнд 2,256 малчин өрхийн 540 мянган толгой мал, • Төвийн бүсийн 3 аймгийн хэмжээнд 796 өрхийн 239 мянган толгой мал, • Говийн бүсийн 4 аймгийн хэмжээнд 1,003 малчин өрхийн 606.6 мянган толгой мал, • Зүүн бүсийн 3 аймгийн хэмжээнд 3.086 малчин өрхийн 1,214 толгой мал, • Улаанбаатар хотын 187 толгой малын 43 малчин өрх отор нүүдлийн зохион байгуулалттай отроор өвөлжиж байна. Хяналтаас хасуулах санал : 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтааж танилцуулах -нэг удаагийн чанартай тул хяналтаас хасах	
64	258	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-11-01 Дугаар 2023_10 ЁЗСХБХ	1.2. Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлж байх;	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ёс зүйт манлайллыг хэвшүүлэх зорилгоор байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн алба хаагч" аяныг зохион байгуулах арга хэмжээг төлөвлөсөн. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн алба хаагч" аяныг зохион байгуулах удирдамжыг баталж, 4 зорилго, 8 зорилт, 43 арга хэмжээний хүрээнд төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт бүрэн биелсэн. Ёс зүйн хороотой хамтран 2025 оны 11 дүгээр сард салбарын нийт албан хаагчдыг оролцуулан танхим болон цахим хэлбэрээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ёс зүйт манлайллыг хэвшүүлэх сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.	Ахиц гарсан - 50%
65	259	Өвөлжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-19 Дугаар 2023 №17 БОХХААБХ	1.1/. Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, зохион байгуулж байгаа ажлыг эрчимжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай: 1/цас, зудын үүссэн цагийн байдалд үнэлэлт өгч, мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтыг хохирол багатай даван туулах бодлого, зохицуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;	Зудын нөхцөл байдлын үнэлгээгээр 15 аймгийн 89 суманд “цагаан зудын”, 14 аймгийн 62 суманд “цагаанаар зудархуу”, нийт 17 аймгийн 151 суманд өвөлжилт хүндрэх нөхцөл бүрдсэн бол 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 13 аймгийн 58 суманд “төмөр зуд”-ын, 17 аймгийн 139 суманд “цагаан зуд”-ын, 18 аймгийн 69 суманд “цагаанаар зудархуу” нөхцөл байдалтай байсан бөгөөд нийт 21 аймгийн 266 сум, нийслэлийн 2 дүүрэгт өвөлжилт хүндэрсэн байна. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, малчин өрхөд үүссэн нөхцөл байдлыг харгалзан үзэж Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 8 дугаар тушаалаар өвөлжилт, хаваржилтыг хохирол багатай даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын алба, яам, агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага зохицуулалтаар ханган зорилгоор Улсын онцгой комиссын “Шуурхай штаб”-ыг байгуулан ХХААХҮЯ, ЭХЯ, ЭМЯ, ЗТХЯ, БОАЖЯ, ХНХЯ, ЦХХХЯ, УУХҮЯ, БХБЯ, ЗХЖШ, ХХЕГ, ОБЕГ, ЦЕГ, ЦУОШГ, МЭЕГ, АМГТГ, ХХҮЕГ, ГЕГ, ҮСХ, МУЗН зэрэг нийт 19 байгууллагын 56 албан хаагч томилогдон ажилласан.	Хэрэгжсэн - 100%
	260		1.2/. орон нутгийн иргэд, малчид, оторчдод үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмж чанарыг нэмэгдүүлж, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахууны нөөцийн бэлэн байдлыг хангах;	Аймгуудын онцгой комисс, Эрүүл мэндийн газраас малчин өрх болон отор нүүдлээр өвөлжиж буй иргэдийн мэдээлэл, судалгааг тогтмол авч тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажилласан. Өвөлжилт хүндрэх эрсдэлтэй байгаа эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/396, А/403 дугаар тушаалаар 14 аймгийн 20 сумын эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн автомашин худалдан авах төсвийг Эрүүл мэндийн сайдын багцаас шийдвэрлэж, худалдан авах эрхийг эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлж, шийдвэрлүүлсэн. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А127, А/104 дугаар тушаалаар 20 түргэн тусламжийн автомашиныг тус тус шийдвэрлэсэн. 21 аймгийн	Хэрэгжсэн - 100%

				хэмжээнд отор нүүдлээр болон өөрийн аймагт өвөлжиж буй 178,412 малчин иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан, 20,460 өрхөд эмийн багц олгосон. Мөн 0-5 насны 18,087 хүүхдийг товлолт дархлаажуулалтад хамруулсан. Зудын эрсдэлтэй, өвөлжилт хүндэрсэн 19 аймгийн 265 сумдад өвс, тэжээл, эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүргэхэд хаагдсан зам, даваа нээх шаардлагын хүрээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас нийт 236 техник, хэрэгсэл, орон нутгаас нэмэлт техник хэрэгсэл тус тус гарч, орон нутгаас 5,079 өрхөд 41,845 км зам, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас 8,252 өрхөд 67,297 км зам, нэмэлтээр дайчлагдсан ковш, автогрейдер 29,625 км замыг тус тус гаргасан бөгөөд Улсын хэмжээнд нийт 13,331 өрхөд 138,767 км зам гаргахад 408 тээврийн хэрэгсэл, 703 хүн хүч ажилласан бөгөөд тухайн техник хэрэгслүүдийг зудын эрсдэл өндөртэй болон хүндрэлтэй 19 аймагт ажиллах хугацаанд шаардагдах шатахуун, тос, тосолгооны материалаар урьдчилан хангуулах ажлыг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй шатахууны худалдаа эрхлэгч нэр бүхий 17 аж ахуйн нэгжээр дамжуулан зохион байгуулсан.	
	261		1.3/. хөдөө орон нутагт бэлтгэгдсэн махны нөөцийн хэмжээг тогтоон, мал, махны борлуулалтыг дэмжих арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;163/	Зудыг хохирол багатай даван туулах зорилгоор өвөлжилт хүндэрсэн аймаг, сумын малчдын гар дээр бэлтгэсэн мах, амьд малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд мал, мах татан авах ажлыг Мах бэлтгэлийн аж ахуйн нэгж байгууллагуудтай уулзалт зохион байгуулсан бөгөөд Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоонд хүсэлт тавьсны дагуу мах бэлтгэлийн 8 үйлдвэрийн 29 автомашиныг шатахуунаар хангах ажлыг зохион байгуулсан. Малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэн экспортын баримт бичгийг ажлын 8 цагт багтаан олгох, экспортод гарах бүх төрлийн махны квотыг цуцалж, агаарын тээврийн экспортыг сэргээсэн зэрэг арга хэмжээний үр дүнд 2023-2024 онд махны экспорт түүхэн дээд амжилт тогтоон 80.4 мянган тоннд хүргэсэн. Мөн малчдын гар дээр байгаа мал, махыг зах зээлд нийлүүлэх зорилгоор худалдагч, худалдан авагчийн саналд тулгуурлан хүссэн үедээ хаанаас ч захиалга өгөх нөхцөлийг бүрдүүлж, мал, махны дуудлага худалдааны систем болон зарын платформыг бий болгосноор 540 удаагийн хэлэлцээр 15,3 тэрбум төгрөгийн 1,164 тонн махны арилжаа хийгдсэн бөгөөд 617,3 тн хонины мах, 282,4 тн үхрийн мах, 117,3 тн ямааны мах, 147 тн адууны махны арилжааг 405 малчидтай 23 аж ахуйн нэгж хийсэн байна. Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгуудад зам гаргаж, малчны хотонд очиж, хонь худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар улсын нөөцөөс 3.5 тонн түлш шийдвэрлүүлсэн. Үүний дагуу Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас туулах чадвар сайтай машин бүхий шуурхай бүлэг томилж, мал, мах бэлтгэн нийлүүлдэг 2 аж ахуйн нэгжтэй хамтран 6 удаагийн рейсээр 10.0-11.0 мянган толгой хонь худалдан авах ажлыг зохион байгуулав.	Хэрэгжсэн - 100%
	262		1.4/. өвс, тэжээл, биобэлдмэлийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэгчидтэй аймаг, сумдын онцгой комиссыг гэрээ байгуулуулж малчид дундын зуучлалгүй худалдан авах боломжийг бүрдүүлэх, малын тэжээлийн экспортыг зогсоосон хугацааг 2024 оныг дуустал сунгах арга хэмжээг авах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 01/3565 тоот албан бичгээр малын өвс, тэжээлийн экспортыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар хязгаарлах тухай Гаалийн ерөнхий газарт хүргүүлэв. Малчдын гар дээр байгаа мал, махыг зах зээлд нийлүүлэх зорилгоор худалдагч, худалдан авагчийн саналд тулгуурлан хүссэн үедээ хаанаас ч захиалга өгөх нөхцөлийг бүрдүүлж, мал, махны дуудлага худалдааны систем болон зарын платформыг бий болгосон бөгөөд Хөдөө аж ахуйн биржийн худалдааг зохион байгуулах арга хэмжээг авч ажиллаа. Тус худалдаагаар он гарсаар нийт 540 удаагийн хэлэлцээрээр 15,3 тэрбум төгрөгийн 1,164 тонн махны арилжаа хийгдсэн бөгөөд 617,3 тн хонины мах, 282,4 тн үхрийн мах, 117,3 тн ямааны мах, 147 тн адууны махны арилжааг 405 малчинтай 23 аж ахуйн нэгж хийсэн байна. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : 2024 оныг дуустал сунгах	Хэрэгжсэн - 100%
	263		1.5/. бензин, шатахуун, дизель түлшний хангалт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч, сумдын шатахуун түгээх станцыг шатахуунаар бүрэн хангаж, хяналт тавьж ажиллах;	Давхардсан тоогоор нийт 408 тээврийн хэрэгсэл, 703 хүн хүч ажилласан бөгөөд тухайн техник хэрэгслүүдийг зудын эрсдэл өндөртэй болон хүндрэлтэй 19 аймагт ажиллах хугацаанд шаардагдах шатахуун, тос, тосолгооны материалаар урьдчилан хангуулах ажлыг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй шатахууны худалдаа эрхлэгч нэр бүхий 17 аж ахуйн нэгжээр дамжуулан зохион	Хэрэгжсэн - 100%

				байгуулсан. Аж ахуйн нэгжүүдээс нийт дүнгээр А-80 бензин 26,707 литр, Аи-92 бензин 213,377 литр, дизель түлш 237,276 литр, тос, тосолгооны материал 7,030 литр шатахуун, тос, тосолгооны материал буюу нийт 484,4 мянган литр зарцуулсан ба 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан.	
	264		1.6/. гурилын үйлдвэрлэл, чанарын асуудалд судалгаа, тооцоо хийж, холбогдох арга хэмжээг авах;	Монголын гурил үйлдвэрлэгчдийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн холбоо ТББ -тай хамтран гурилын өртөгийн судалгаа хийсэн. Мөн гурилын чанарын асуудлыг онцгойлон анхаарч "Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ыг батлуулсан бөгөөд гурилын үйлдвэрүүдэд мөрдүүлэн ажиллаж байна. Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ыг батлуулсан бөгөөд гурилын үйлдвэрүүдэд мөрдүүлэн ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%
	265		1.7/. улсын хил дагуух аймаг, сумдад өргөн хэрэглээний хүнс, гурил, өвс, тэжээл, бензин, шатахууныг тухайн бүс нутагт байрлах улсын хилийн боомтоор татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх боломжийг судалж, холбогдох арга хэмжээг авах;	Баруун бүсийн таван боомтоор импортлох улаан буудайн гурил, малын тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлөх тогтоолыг 2025 оны 12 сарын 12-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан. Малын тэжээлийн импортод 5%, гурил 15%-ийн татвар ногдуулдаг. Тогтоол батлагдсанаар Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Бургастай боомтоор эдгээр бүтээгдэхүүнийг импортлоход 2026 оны дөрөвдүгээр сарын 15 хүртэл гаалийн албан татвараас чөлөөлөхөөр болсон.	Хэрэгжсэн - 100%
	266		1.8/. өвөлжилтийн байдалтай уялдуулан аймаг, сумдын онцгой комисст өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлж, эргэлтэд оруулах, шатахууны нөөц бүрдүүлэх, хаагдсан зам, даваг нээх, орон нутагт ажиллах зардалд зориулж тодорхой хөрөнгийн дэмжлэг үзүүлэх;	Зудын эрсдэлтэй, өвөлжилт хүндэрсэн 19 аймгийн 265 сумдад өвс, тэжээл, эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүргэхэд хаагдсан зам, даваа нээх шаардлагын хүрээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас нийт 236 техник, хэрэгсэл, орон нутгаас нэмэлт техник хэрэгсэл тус тус гарч, орон нутгаас 5,079 өрхөд 41,845 км зам, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас 8,252 өрхөд 67,297 км зам, нэмэлтээр дайчлагдсан ковш, автогрейдер 29,625 км замыг тус тус гаргасан бөгөөд Улсын хэмжээнд нийт 13,331 өрхөд 138,767 км зам гаргахад 408 тээврийн хэрэгсэл, 703 хүн хүч ажилласан бөгөөд тухайн техник хэрэгслүүдийг зудын эрсдэл өндөртэй болон хүндрэлтэй 19 аймагт ажиллах хугацаанд шаардагдах шатахуун, тос, тосолгооны материалаар урьдчилан хангуулах ажлыг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй шатахууны худалдаа эрхлэгч нэр бүхий 17 аж ахуйн нэгжээр дамжуулан зохион байгуулсан. Аж ахуйн нэгжүүдээс нийт дүнгээр А-80 бензин 26,707 литр, Аи-92 бензин 213,377 литр, дизель түлш 237,276 литр, тос, тосолгооны материал 7,030 литр шатахуун, тос, тосолгооны материал буюу нийт 484,4 мянган литр зарцуулсан ба 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан.	Хэрэгжсэн - 100%
	267		1.9/. улсын нөөцийн өвс, тэжээлийг худалдан борлуулж, нөхөн бүрдүүлэх ажлыг тасралтгүй, шуурхай зохион байгуулах,	Улсын нөөцөд хадгалагдаж буй өвс, тэжээл нь нуцын зэрэглэлтэй байдаг. Онцгой байдлын Ерөнхий газрын улсын нөөцийн газар хариуцаж ажилладаг тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Улсын нөөцөд хадгалагдаж буй өвс, тэжээл нь нуцын зэрэглэлтэй байдаг. Онцгой байдлын Ерөнхий газрын улсын нөөцийн газар хариуцаж ажилладаг тул хасах саналтай.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
	268		1.10/. өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газарт мал оруулах, бэлчээрийн даац нь хүрэлцээтэй бүс нутагт тохирох тооны малыг отроор өвөлжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;	Улсын тусгай хэрэгцээний отрын 9 бүсийн бэлчээрийн даацыг тогтоох ажлыг “Малын бэлчээрийн даац тогтоох нэгдсэн аргачлал”-ын дагуу 2025 оны 07 сарын 23-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулсан. Отрын 9 бүсийн бэлчээрийн талбай тус бүрд 4-10 цэгт бэлчээрийн ургамлын дээжийг нэгдсэн аргачлалын дагуу тооцоолж 2025 оны дундаж ургац 1,2-5,2 цн/га буюу 665809 толгой малыг өвөлжүүлж хаваржуулах бэлчээрийн даацын дүгнэлт гаргасан. Бэлчээрийн даацыг бүс тус бүрээр авч үзвэл: 1. Малахын тал отрын бүс нутаг: нийт 73,1 мян га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж ургац 1.3 цн/га, 2025-2026 онд 98 320 хонин толгой мал 2. ХэрлэнБаянУлаан отрын бүс: нийт 192,8 мян.га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж ургац 5.025 цн/га, 2025-2026 онд 249 016 хонин толгой мал, 3. Чилэн отрын бүс: нийт 34,1 мян га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж ургац 5,2 цн/га, 2025-2026 онд 45758 хонин толгой мал 4. Хөх дэл отрын бүс: нийт 37,9 мян га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж ургац 3,2 цн/га, 2025-2026 онд 26 000 хонин толгой мал 5. Аргалант отрын бүс: нийт 118,6 мян га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж	Ахиц гарсан - 50%

				ургац 0,9 цн/га, 2025-2026 онд 35 184 хонин толгой мал 6. Баяннуруу отрын бүс: нийт 105,2 мян га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж ургац 1,4-2,1 цн/га, 2025-2026 онд 27500 хонин толгой мал 7. Ачит нуур отрын бүс: нийт 28,9 мян га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж ургац 1,2 цн/га, 2025-2026 онд 28 900 хонин толгой мал 8. Багахайрхан отрын бүс: нийт 63,8 мян га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж ургац 2,6-3,9 цн/га, 2025-2026 онд 51373 хонин толгой мал 9. Чойбалсан отрын бүс: нийт 124,4 мян га бэлчээрийн талбайтай, бүсийн дундаж ургац 1,83 цн/га, 2025-2026 онд 103758 хонин толгой малын бэлчээрийн даацыг тодорхойлсон. 2025-2026 онд отрын бүсэд нийт 12 аймгийн 35 сумын 414 өрхийн 651892 хонин толгой малыг өвөлжүүлэх дүгнэлт гаргасан. Хавсралт нийт : 8, Файл : 1 Зураг : 7	
	269		1.12/. дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн бүхий л эх үүсвэрийг судалж, шийдвэрлэх.	Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумын аюулгүй нөөцөд бэлтгэх 36.4 мянган тонн бүдүүн тэжээл (өвс)-ийн 86.7 хувь буюу 31.5 мянга, 30.8 мянган тонн хүчит тэжээлийн 42.8 хувь буюу 13.9 мянган тонныг тус тус бэлтгэж, 64.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэхэд нийт 28.3 тэрбум төгрөг шаардлагатай. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөгдсөний дагуу Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө гаргах тухай тогтоолын төслийг бэлтгэж нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл хангаж байна. Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон.	Хэрэгжсэн - 100%
	270		2.. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд 2023 оны намрын чуулганы хугацаанд багтааж танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын дагуу 21 аймаг, нийслэлээс мал аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнг нэгтгэн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/3637 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн Улсын онцгой комиссын 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 02, 08 дугаар сарын 11-ний өдрийн 03 дугаар хуралдаанаар өгсөн үүрэг, 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 01/3034 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж Засгийн газрын хуралдаан болон Байгаль орчин, Хүнс хөдөө аж ахуйн байнгын хороогоор хэлэлцүүлсэн. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн тул хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
66	271	Газар тариалангийн салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай 2024-04-15 Дугаар 2024 №06 БОХХААБХ	1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Газар тариалангийн салбарын өнөөгийн байдал, тогтвортой хөгжлийн гарц, шийдэл” онол, үйлдвэрлэлийн бага хурлаас гаргасан зөвлөмжийг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай: 1/Мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтээр нийт тариалангийн талбайн хөрсний үржил шимийн 60 гаруй хувь нь доройтсоны улмаас хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор цулгуй уриншийн эзлэх хувийг үе шаттайгаар бууруулах, ногоон бордуурт уринш, эрдэст, органик бордооны хэрэглээг нэмэгдүүлэх, тэжээлийн болон бусад таримлын оновчтой сэлгээг бий болгох, тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах;	Улсын төсвийн 9,2 тэрбум төгрөгөөр Тариалангийн талбайн хөрс хамгаалах, үржил шимийг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Багц 1: Дархан-Уул аймагт 2,564,000,000(хоёр тэрбум таван зуун жаран дөрвөн сая) төгрөгөөр үндсэн төмөр бетон шон 100,560 ширхэг, булангийн шон 1005 ширхэгийг, Багц 2: Булган аймагт 1,370,000,000 (нэг тэрбум гурван зуун далан сая) төгрөгөөр үндсэн бетон шон 51,000 ширхэг, булангийн шон 550 ширхэг, Багц 3: Төв аймагт 550,000,000 (таван зуун таван сая) төгрөгөөр үндсэн бетон шон 21,000 ширхэг, булангийн шон 250 ширхэгийг, Багц 4: Сэлэнгэ аймгийн Сайхан сум / Хөтөл/ 1,786,000,000 (нэг тэрбум долоон зуун наян зургаан сая) төгрөгөөр үндсэн бетон шон 70,000 ширхэг, булангийн шон 700 ширхэгийг, Багц 5: Сэлэнгэ аймагт 2,935,000,000 (хоёр тэрбум есөн зуун гучин таван сая) төгрөгөөр үндсэн төмөр бетон шон 115,000 ширхэг, булангийн шон 1175 ширхэгийг бүрэн бүтэн хүлээн авч ажлын хэсгийн акт, гэрээ дүгнэсэн тэмдэглэл үйлдэн батлуулсан. Сэлэнгэ аймгийн ХХААГ-т 254,290 ширхэг төмөр бетон шонг ХХААХҮСайдын 2025.11.20-ны өдрийн А/589 тоот тушаалаар, Дархан-Уул аймгийн ХХААГ-т 32030 ширхэг, Судалгаа хөгжлийн төвд 304 ширхэг, Малын удмын сангийн үндэсний төвд 304 ширхэг, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд 1512 ширхэг төмөр бетон шонг тус тус ХХААХҮСайдын 2025.11.20-ны өдрийн А/588 тоот тушаалаар, Төв аймагт 21,250 ширхэг, Булган аймагт 51,550 ширхэг төмөр бетон шонг ХХААХҮСайдын 2025.05.30-ны өдрийн А/263 тоот тушаалаар тус аймгуудын ХХААГ-т Хөрөнгө шилжүүлэх тушаалаар тус тус балансаас балансад шилжүүлэв. Хавсралт : 3 файл	Хэрэгжсэн - 100%

	272		1.2/. Монгол Улсын байгаль цаг уур, бүс нутгийн онцлогт тохирсон таримал ургамлын үр үйлдвэрлэх бүтэц, тогтолцоог бий болгоход чиглэгдсэн анхдагч үрийн аж ахуйг хөгжүүлэх, сорт сорилтын төвүүдийг бүсчлэн байгуулах, үрийн аж ахуйг чадавхжуулах, үр үйлдвэрлэгчдэд урамшуулал олгох тогтолцоог бий болгох, хянан баталгаажсан баталгаат үрээр тариалалтыг хийх, технологийн болон стратегийн нөөц бүрэн бүрдүүлэх, дотоодын хэрэгцээг хангаад илүүдэл бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлэх;	Ургамал газар тариалангийн хүрээлэн Дархан-Уул аймгийн Хонгор суманд 400 тонны багтаамжтай үр үржүүлэх агуулахыг Копиа Монгол Төслийн буцалтгүй тусламжаар байгуулаан ашиглалтанд оруулаад УГТХ 2024 онд улаанбуудайн супер элит үр 452 тн, элит үр 30 тн, арвайн элит үр 6 тн, хошуу будааны элит үр 25 тн, төмсний элит үр 110 тн вандуйны элит үр 11.2 тн-ийг тус тус үйлдвэрлэсэн байна. 2025 онд таримал ургамлын үр үржүүлгийн тусгай зөвшөөрөлтэй 10 аж ахуй нэгж нийт 13 мян.тн улаанбуудай, 1,9 тн төмсний үр үржүүлсэн байна. Сорт сорилтын төв байгуулах ТЭЗҮ 2023 онд батлагдсан бөгөөд 2025 байдлаар төсөв батлагдаагүй улмаас сорт сорилтын төв байгуулагдаагүй байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	273		1.3/. Шинжлэх ухааны байгууллагуудыг түшиглэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон шинэ таримлын үр үйлдвэрлэлийн системийг хөгжүүлэх, үр сортыг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, улмаар экспортлох боломжийг бүрдүүлэх чиглэлд зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх	"УГТХ 2024 онд улаанбуудайн супер элит үр 452 тн, элит үр 30 тн, арвайн элит үр 6 тн, хошуу будааны элит үр 25 тн, төмсний элит үр 110 тн вандуйны элит үр 11.2 тн-ийг тус тус үйлдвэрлэсэн байна. 2024 онд аж ахуйн нэгж, УГТХ-тэй гэрээ байгуулсаны үндсэн дээр төмсний 6, хүнсний ногооны 2, улаанбуудай 2, малын тэжээлийн 11, цагаан будааны 6 сортыг тус тус туршсан байна. Хаврын тариалалтад зориулан “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК -аар дамжуулагн 359 аж ахуйн нэгж, иргэнд 11.6 мянган тонн улаанбуудайн 5 сортын элит үрийг нийлүүлсэн. 2024 онд Улсын сорт, сорилтын зөвлөлийн хурлаар Хүнсний ногооны 1, тэжээлийн 1, улаанбуудайн 1 сорт нийт 3 сорт Арилжааны сортоор, хүнсний ногооны 3, тэжээлийн 2, улаанбуудай 1 сорт нийт 6 сорт Ирээдүйтэй сортоор, Жимсний 1 сорт Нутагшсан сортоор тус тус шалгарч батламж гардуулсан. 2025 онд хүнсний ногооны 26 сорт, тэжээлийн 30 сортын шинээр туршиж байна. 2025 онд Улсын төсвийн 210,000,000.00 /Хоёр зуун арван сая/ төгрөгөөр Сэлгээний таримлын сорт сорих ажлын хүрээнд Вандуй, Рапс, Эрдэнэшиш, Арвай, Тритикал, Шар буурцаг нийт 6 таримлыг тус бүр 6 хяналт сорттой харьцуулж 12 сортыг шинээр туршихаар, Анхан шатны үр үржүүлгийн ажлын хүрээнд Дархан-144 сортын супер элит үр 14 тн, Вандуйны Баялаг сортын 14 тн үрийг тус тус үржүүлсэн. БНХАУ-руу улаанбуудай үр, селимарин үр, рапс, арвай зэргийн экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсад тариалж буй шинэ таримлуудын хорио цээрийн протокол байгуулагдсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	274		1.4/. Таримлын сэлгээ, нэр төрөлд тохирсон техникийн сонголтыг хийж, механикжуулалтын түвшинг үе шаттайгаар богино хугацаанд хийх нөхцөлийг бүрдүүлэх;	2025 онд төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник технологийн шинэчлэл хийх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/326, А/327, А/485 дугаартай тушаалаар 121 техник, тоног төхөөрөмж худалдан авсан 97 аж ахуйн нэгж, иргэнд 3,2 тэрбум төгрөгийн буцаан олголтыг олгосон. Хавсралт : 3 файл	Хэрэгжсэн - 100%
	275		1.5/. тариалангийн салбарт учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах зорилгоор даатгалын оновчтой тогтолцоог сонгон нэвтрүүлэх, “Тариалангийн даатгалын тухай” хууль, “Гамшгийн тухай” хуульд холбогдох өөрчлөлт оруулж эрх зүйн орчныг сайжруулах;	Тариалангийн салбарт учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах зорилгоор даатгалын оновчтой тогтолцоог сонгон нэвтрүүлэхээр Санхүүгийн зохицуулах хороо болон Үндэсний давхар даатгал ТӨХХК-тай хамтран Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд туршилын хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн, Тариалангийн даатгалын тухай” хуулийн төсөл болон холбогдох судалгааг 2026 онд боловсруулахаар ажиллаж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	276		1.6/. Тариалангийн үйлдвэрлэлээс гарч байгаа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, стандартын шаардлагад нийцсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нийлүүлэхэд хөндлөнгийн хараат бус лабораториор баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх;	Тариалангийн үйлдвэрлэлээс гарч байгаа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, стандартын шаардлагад нийцсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нийлүүлэхэд хөндлөнгийн хараат бус лабораториор баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд 2025 онд 10 нэр төрлийн хүнсний ногоо дотооддоо үйлдвэрлэж зах зээлд борлуулсан 930 иргэн, аж ахуй нэгжийн бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээнд хамруулж цахим гарал үүслийн гэрчилгээ олгож 6.8 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон байна. plant.mofa.gov.mn	Хэрэгжсэн - 100%
	277		1.7/. Төмс хүнсний ногоо эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, төв суурин газрын иргэдийг шинэ	“Намрын ногоон өдрүүд – Үндэсний үйлдвэрлэл 2025” арга хэмжээнд нийслэл болон орон нутгаас ирсэн 146 ногоочдыг 73 асарт зохион байгуулалттайгаар байршуулж, худалдаа, үйлчилгээ хэвийн	Хэрэгжсэн - 100%

			ургацын ногоогоор тасралтгүй хангах зорилгоор ногоочид дундын зуучлалгүйгээр шууд борлуулалт хийх боломжийг бүрдүүлэх үүднээс жижиглэнгийн болон бөөний худалдаа эрхлэх талбай, байршлыг тогтоож, зохион байгуулалтаар хангаж ажиллах;	явагдах нөхцөлийг бүрдүүлсэн. Нэгдсэн арга хэмжээний хугацаанд нийт 1.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь дотоодын хүнсний ногооны үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан үзүүлэлт боллоо. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай” А/104 тушаалаар төвийн 6 дүүрэгтэй хамтран 13 цэгт 7 аймгийн 70 иргэн, аж ахуйн нэгж хамрагдан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний худалдаа зохион байгуулан, нийт 434тн, 1,5 тэрбум төгрөгийн худалдаа борлуулалт хийсэн байна. Хавсралт : 2 файл	
	278		1.8/. Газар тариалангийн салбарын хүний нөөцийг тасралтгүй бэлтгэх, залгамж халааг бүрдүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх, цалин, нийгмийн баталгааг хангах цогц арга хэмжээг авах;	Газар тариалангийн салбарт ажиллагсдын судалгаа сүүлийн 10 жилээр гаргаж, сумдын мэргэжлтний судалгааг гаргаж хүний нөөцийн бодлого цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган холбогдох их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлийн төвүүдтэй хамтран ажиллах саналыг хүргүүлсэн. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	279		1.9/. Мэргэжлийн яам болон тариаланчид, эрдэмтдийн оролцоотой ажлын хэсэг байгуулан улаанбуудайн өртгийн тооцоог гаргаж, улмаар стратегийн нөөцөд худалдан авах хүнсний улаанбуудайн үнийг тогтоон 2024 оны 04 дүгээр сарын 28-ны дотор зарлах;	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар УИХ, тариаланчдын холбоо, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны төлөөлөөс бүрдсэн ажлын хэсэг 4 удаагийн хэлэцүүлэг зохион байгуулж 1 га талбайд улаанбуудай тариалах, хураах болон бусад зардлыг тооцоог гарган Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-д сратегийн нөөцөд авах хүнсний улаанбуудайн үнийн тогтоон олон нийтэд зарласан. https://agricorp.mn/main?c=J4JANf7WbVSs3Qop9s&p=X2ASiAjJKZ5OK8rxvoDX159fns9CxNlQ&t=post&m=162 Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон.	Хэрэгжсэн - 100%
	280		2.. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн оновчтой тогтолцоог бий болгож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах, холбогдох төсөл, хөтөлбөр болон төр, хувийн хэвшлийн санхүүжилттэй уялдуулах;	Уг тогтоолд заасан арга хэмжээг санхүүжилтийн оновчтой тогтолцоог бий болгож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах, холбогдох төсөл, хөтөлбөр болон төр, хувийн хэвшлийн санхүүжилттэй уялдуулан хэрэгжүүлж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	281		3.. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд 2024 оны намрын чуулганы хугацаанд багтааж танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.	Энэ тогтоолын биелэлтийг болон хаврын тариалалт, ургацын урьдчилсан баланс, ургац хураалтын дүнгийн танилцуулгыг 2024, 2025 онд Засгийн газар, УИХ-д тухай бүр танилцуулсан. Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоол батлуулсан. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Хугацаанд нь танилцуулан ажилласан.	Хэрэгжсэн - 100%
67	282	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ	1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ёс зүйт манлайллыг хэвшүүлэх зорилгоор байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн алба хаагч" аяныг зохион байгуулах арга хэмжээг төлөвлөсөн. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн алба хаагч" аяныг зохион байгуулах удирдамж баталж, 4 зорилго, 8 зорилт, 43 арга хэмжээний хүрээнд төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт бүрэн биелсэн. Ёс зүйн хороотой хамтран 2025 оны 11 дүгээр сард салбарын нийт албан хаагчдыг оролцуулан танхим болон цахим хэлбэрээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ёс зүйт манлайллыг хэвшүүлэх сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан, батлуулав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн	Ахиц гарсан - 50%

				үйлдвэрийн яаманд хамаарах 10 заалтын хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллав. Байгууллагын Үнэт зүйлийг тодорхойлох асуумжийг google формоор https://docs.google.com/forms/d/1hzN2lfczWzBQzCG_8_HJAVJ4q0bHxTRwhT864-mGxVg/edit авч, үр дүнгээр Үнэт зүйлийг тодорхойлсон. Яам, түүний харьяа байгууллагуудаас төрийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс сэтгэл ханамжийн судалгааг google формоор https://docs.google.com/forms/d/1F46xKDxjRGODY6WR7UHmqOeGSHGB_ynZ5wWTvls2j0E/edit үр дүнг нэгтгэж байна. Олон нийтээс төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, авлига, ашиг сонирхлын нөхцөл байдал үүсэж байгаа эсэх талаарх судалгааг авахаар яамны байрны хүлээлгийн хэсэг болон хаалганд судалгааны QR код бүхий асуумжийг Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг дахь байрны үүдний хүлээх хэсэгт байршуулсан.	
	283		1.3 . төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.4, 2.7 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нийт албан хаагчдын дунд 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр явуулсан санал асуулгын үр дүнгээр хамгийн өндөр санал авсан 7 албан хаагчийг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгосон. Үүнтэй холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн "Ёс зүйн дэд хороо байгуулах тухай" Б/10 дугаар тушаалыг батлуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэл бүрэн хангагдсан.	Хэрэгжсэн - 100%
68	284	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-01-14 Дугаар 2025_01 ИЦББХ	1.2 . Төсвийн тухай хуулийн 28Т2.4, 291.3 заалтуудын хэрэгжилтийг хангуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаал “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах, цахим орчинд байршуулж буй төсвийн талаарх мэдээллийг эдгээр журмуудын хавсралтад тусгасан загварт хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэх, мэдээллийг тогтоосон хугацаанд нь нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар оруулах.(Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах)	ХХААХҮ-ийн салбарт 2025 онд батлагдсан хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээг СЯ-ны төсвийн хөрөнгө оруулалтын https://pimis.publicinvestment.gov.mn/ системээр мэдүүлж ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%
69	285	Засгийн газарт чиглэл өгөх тухай. 2025-05-21 Дугаар 2025№12 БОХХААБХ	1.1. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай. 1/Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хөдөө аж ахуйн тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай, тариалангийн даатгалын тухай хуулийн	УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж өргөн мэдүүлэхтэй холбоотой хэрэгжилтийн тайланг хавсралтаар тайлагнав. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

			төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлэх, бусад журам, стандартыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг эрчимжүүлэх;		
	286		1.2. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг "Цагаан алт", "Шинэ хоршоо" "Атарын 4 дүгээр аян" үндэсний хөдөлгөөн, хөгжлийн төлөвлөлттэй нийцүүлэх, салбар хоорондын уялдаа холбоо, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах;	УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд мал аж ахуй, газар тариалан, хүнсний болон хүнсний савбаглаа боодлын үйлдвэр 981 ААН, 1541 иргэн, Атарын аяны хүрээнд мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрийн чиглэлээр 510 ААН, 354 иргэн, Цагаан алтны хүрээнд мал ажуй, хүнсний үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 168 ААН болон нийт 1659 ААН-д 1895 иргэнд зээлийн дэмжлэг олгохын зэрэгцээ салбар хоорондын уялдаа холбоог ханган ажиллаж байна. Мөн "Цагаан алт", "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг орон нутгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах, салбар хоорондын уялдааг сайжруулах, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор ХөҮБХЗГ, Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК, Зээлийн батлан даалтын сан, Аймаг, орон нутгийн ЗДТГ, ХХААГ-ууд, Мэргэжлийн холбоод, үндэсний боловсруулах үйлдвэрүүд хамтран 2025 оны 10 дугаар сарын 12-оос 27-ны хооронд Төвийн бүсийн Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн 20 сум, Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн 47 сум, Хангайн бүсийн Өвөрхангай, Архангай аймгийн 38, Хойд бүсийн Хөвсгөл аймгийн 23 сум, нийт 128 сумын хөдөө аж ахуйн тасгийн салбар хариуцсан мэргэжилтнүүд, хоршоод, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгчид 461 оролцогчдыг хамруулан сургалтыг зохион байгуулав.	Ахиц гарсан - 50%
	287		1.3. Хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдалд тавих хяналтын бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлагын тогтолцоог бий болгох, хүнсний түүхий эдийн бэлтгэл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний худалдаа, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, ул мөрийг мөрдөн тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэх, импортын хүнсний баталгаат байдалд тавих хяналтыг сайжруулах, аймаг, орон нутгийн болон хил гаалийн лабораторийг чадавхжуулж бэхжүүлэх, Улаанбаатар хотод тусгайлсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд аюулгүйн үзүүлэлтээр сорил, шинжилгээ хийх нэгдсэн лабораторийг шинээр байгуулах, хүнсний хяналт, шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар хүнсний баталгаат байдлыг хангах;	Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээрх 30 хууль, 41 дүрэм, журмын хэрэгжилтэд ХХААХҮЯ-ын СХГ, аймаг, нийслэлийн хүнсний чанар, стандарт, мал үржүүлэг технологи, мал эмнэлэг, ургамал хамгаалал, үр, сорт хорио цээрийн хяналтын чиглэлээр нийт 638 улсын (ахлах) байцаагчид хяналт тавин ажиллаж байна. Хүнсний аюулгүй байдлын тогтолцоогоор хяналтын чиг үүрэг нь одоогоор 14 байгууллагад хамаарч нэгдсэн зохион байгуулалтгүй, салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна. Салбарын хяналтын бодлогыг тодорхойлж байгууллагын стратеги, чиг үүрэг ЗГ-ын тогтоолоор батлагддаг. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хяналтын чиглэлээр 2 журам боловсруулж санал авах шатанд явж байна. 2025 онд хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн 2 удаагийн хэлэлцүүлэгт салбарын хяналтын чиглэлээр тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, хяналтын тогтолцоо, бүтэц чиг үүргийг оновчтой зохион байгуулах талаар санал боловсруулж танилцуулсан.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	288		1.4. импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодынэ хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын зах заалийг хамгаалах, хүнсний хангамж, нийлүүлэлт, аюулгүй байдал, үнийн тогтвортой байдлыг хангах бодлого хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах;	Гурил, тэжээлийн хангамж үнийг тогтворжуулах зорилгоор баруун бүсийн таван боомтоор импортлох улаан буудайн гурил, малын тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлөх тогтоолыг 2025 оны 12 сарын 12-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан. Малын тэжээлийн импортод 5%, гурил 15%-ийн татвар ногдуулдаг. Тогтоол батлагдсанаар Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Бургастай боомтоор эдгээр бүтээгдэхүүнийг импортлоход 2026 оны дөрөвдүгээр сарын 15 хүртэл гаалийн албан татвараас чөлөөлөхөөр болсон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431987901992	Хэрэгжсэн - 100%
	289		1.5. хүнсний зарим гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангалт сул байгаа бүс нутагт орон нутгийн өөрийнх нь нөөц боломж, чадавхыг нэмэгдүүлэх замаар тухайн бүсийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, дэмжлэгийн хөрөнгийн эх үүсвэрийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцүүлэн бүсээр нь баталж, төрийн цогц бодлогыг хэрэгжүүлж, үр дүнд хүргэх;	1.Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулахаар “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталж, батлагдсан үзэл баримтлалын хүрээнд тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаан, Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын 4 дэх заалтаар Улсын Их Хурлаас Засгийн газарт эрх олгосны дагуу Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хуралдаанаар "Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлсэн. 2.Баруун аймгийн хүн амын гурилын хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, баруун аймгийн 5 боомтоор 20.0 мян.тн улаанбуудайн гурил	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%

				импортлох, зохицуулалтын арга хэмжээ авах тухай 005 дугаар зөвлөмж гаргуулсан. Хавсралт : 2 файл	
	290		1.6. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн үйл ажиллагааг жигдрүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх ажлын хөрөнгө оруулалтын зардал 2.1 тэрбум төгрөг, хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлдог болох, техник, тоног төрөөхөмжийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт болон уг төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, дэмжлэгийг улсын төсөвт тусгах, төр, хувийн хэвшлийн түншлэл, шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэрэгжилтийг хангах;	“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх” тухай тусгасан. Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн “Хүнсний судалгаа инновацын нээлттэй төв”-ийг түшиглэн байгуулж, холбогдох төсвийг Боловсрол, шинжлэх ухааны яам 2024 оны батлагдсан төсвөөсөө гаргаж, цаашид жил бүрийн улсын төсөвт тусгахаар шийдвэрлэсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	291		1.7. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкнаас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн зээлийн олголт, зохицуулалт зарцуулалт, хуваарилалт, гарч байгаа бодит үр дүнд Монгол банк, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, хамтран хяналт шалгалт хийж, зээлийн хэрэгжилтийн үр дүнг УИХ-д 2025 оны 06 дугаар сарын 30-ны дотор танилцуулах;	Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол хэрэгжиж эхлээд гурван жилийн хугацаа өнгөрсөн энэ хугацаанд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах, улмаар хүнс экспортлогч орон болох зорилготой “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний үр дүнг олон нийтэд танилцуулах хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд болон тус тогтоолыг хэрэгжүүлэгч байгууллага, тус тогтоолын хүрээнд хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж оролцсон арга хэмжээг зохион байгуулсан. https://president.mn/35216/ Тус арга хэмжээнд ХХААХҮ-ийн сайд хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан ж ахуйн нэгж байгууллага, иргэдийн зээлийн олголт, зохицуулалт зарцуулалт, хуваарилалт, гарч байгаа бодит үр дүнг олон нийтэд танилцуулсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	292		1.8. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын тайлан, мэдээний үнэн зөв, бодит байдлыг хангах, уг тогтоолыг хэрэгжүүлэгч холбогдох байгууллагаас ирүүлж байгаа мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах, санхүүжилттэй холбоотой мэдээллийг нягтлах, нэгтгэх, тодорхой, нээлттэй болгох, уг мэдээллийг мэдээллийн санд оруулж тогтоолын хэрэгжилтийн биелэлтийн талаарх статистик мэдээ, тайланг удирдлага, төлөвлөлт хяналтын хэрэглэгдэхүүн болгож ашиглах, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж бодит үр дүнд хүргэх.	1. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд: 2023, 2024 онд хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгжүүдээс https://tinyurl.com/58sxb3rv холбоосоор асуумж, судалгаагаар мэдээллийг шинэчилж замаар үр дүнгийн боловсруулалт хийж байна. 2.“Хүнсний хангамж аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын биелэлтийг 2025 оны 3 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр тайлагнаж, дундаж үнэлгээ 66.5%-тай байна (ХШҮ.) 3. Ерөнхий сайд Г.Занданшатар Дархан-Уул аймагт ажилласантай холбогдуулан "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн үр дүнд тооцоолол хийж, нэгтгэн мэдээллийг танилцуулж ажилласан. 4.Хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний 2024 оны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг 2022 оны тоо хэмжээтэй харьцуулахад дараах байдалтай байна. Тухайлбал, мах, махан бүтээгдэхүүн 211.5 тонн буюу 32%, гурил, гурилан бүтээгдэхүүн 57.8 тонн буюу 28.5%-иар буурсан бол сүүн бүтээгдэхүүн 32.7 тонн буюу 60%-иар, төмс 41 тонн буюу 19.2%, хүнсний ногоо 132.5 тонн буюу 89%, буурцагт ургамал 0.1 тонн буюу 100%, өндөг 0.1 тонн буюу 0.9%, сахар, чихрийн зүйл 28.7 тонн буюу 20.7%-иар тус тус нэмэгдсэн байна. Хавсралт : 1 файл	Ахиц гарсан - 50%
	293		2. энэ тогтоолын биелэлтийг 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтааж БОХХААБХ-нд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.	Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол хэрэгжилтийн тайланг БОХХААБХ-нд тухай бүр тайлагнаж, хүргүүлсэн. Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол хэрэгжиж эхлээд гурван жилийн хугацаа өнгөрсөн энэ хугацаанд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах, улмаар хүнс	Хэрэгжсэн - 100%

				экспортлогч орон болох зорилготой “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний үр дүнг олон нийтэд танилцуулах хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд болон тус тогтоолыг хэрэгжүүлэгч байгууллага, тус тогтоолын хүрээнд хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж оролцсон арга хэмжээг зохион байгуулсан. https://president.mn/35216/. Тус арга хэмжээнд ХХААХҮ-ийн сайд хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн зээлийн олголт, зохицуулалт зарцуулалт, хуваарилалт, гарч байгаа бодит үр дүнг олон нийтэд танилцуулсан. 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд ЗГХЭГ-аас ОУБ-тай хамтран үр нөлөөний үнэлгээний ажлыг эхлүүлсэн байна. Шаардлагатай мэдээллээр мөн үнэлгээний багийг ханган ажиллаж байна. Үр нөлөө : Үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж хүргэсэн.	
70	294	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ	1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах;	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ёс зүйт манлайллыг хэвшүүлэх зорилгоор байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн алба хаагч" аяныг зохион байгуулах арга хэмжээг төлөвлөсөн. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдэлсэн сахилга хариуцлагатай төрийн алба хаагч" аяныг зохион байгуулах удирдамж баталж, 4 зорилго, 8 зорилт, 43 арга хэмжээний хүрээнд төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт бүрэн биелсэн.	Хэрэгжсэн - 100%
	295		1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл хангагдсан. Мөн дэд хорооны дарга, нбд, гишүүдийн урамшууллыг олгох Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулан, тухай бүрт олгож байна.	Хэрэгжсэн - 100%
	296		1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах.	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн урамшууллыг олгох Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг батлуулан, тухай бүрт олгож байна.	Ахиц гарсан - 50%
71	297	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-06-24 Дугаар 2025№14 ЭЗБХ	1.1. Нэг.Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай: 1.Хууль, эрх зүйн орчныг сайжруулах талаар: 1/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;	УИХ-ын даргын 2024 оны 82 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг болон Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 02 дугаар тогтоол, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 02 тогтоолоор тус тус байгуулагдсан ажлын хэсгүүдэд дэмжлэг үзүүлэх, хуулийн хэлэлцүүлэг хийх, салбарын мэдээлэл хийх зорилгоор Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Булган, аймгийн ЖДҮэрхэлэгчидтэй уулзалт хийж, мэдээлэл өгч ажиллав. ХХААХҮСайдын А/52 дугаар томилотлтын тушаалын дагуу ажиллав. Мөн Дорноговь аймагт Говийн бүсийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн хэрэгжилт, цаашид хийх өөрчлөлтийн саналыг авав.ажиллав. Нийсэлэлийн ЖДҮЭрхлэгчидийн зөвлөгөөнийг Д.Сүхбаатарын нэрэмжит танхимд зохион байгуулж мэдээлэл өгч ажиллав. Үүнтэй холбогдуулан Аж үйлдвэржилтийн байнгын хорооны 2025 оны 06 дуаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг батлав. Нэр бүхий УИХ-ын гишүүд намрын чуулганд хуулийн төслийг өргөн барих төлөвлөгөөтэй байгаа болно. Мөн байнгын хороо болон ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Л.Батлутын зөвлөхөөс тодруулахад 12 сард өргөн барих тухай мэдээлэл өгч байсан. ХХААХҮСайд М.Бадамсүрэнгээс өгсөн чиглэлийн дагуу хуулийн төслийг сайдын зөвлөх, ЖДҮГ-тай хамтран боловсрулав. Хууль тогтоомжийн хуулийн дагуу үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулхад шаардагдах судалгааг хийж гүйцэтгээд байна. Холбогдох судалгаа, олон нийтийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, хуулийн төслийг хавсаргав.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				Хавсралт : 2 файл	
	298		1.2. 2/Дээрх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Үндэсний баялгийн сангийн тухай, Хоршооны тухай, Нөхөрлөлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай болон бусад холбогдох хууль хоорондын уялдааг ханган, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2025 оны намрын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4-д ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй гэж заасан байдаг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.1.Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно гэж 3.2.1.5-д “Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ” гэснийг үндэслэг болговсруулж буй ЖДҮҮДТухай хуулийн дагаж өөрчлөлт оруулах дараах хуулиудад өрчлөлт оруулна. Үүнд: • Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, • Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, • Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, • Ашигт малтмалын тухай, • Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, • Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, • Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, • Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай • Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, • Зээлийн батлан даалтын сангийн тухай, • Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.	Х.Б
	299		1.3. 3/Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;	Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэгт орж ажиллан өөрчлөлт оруулах холбогдох саналуудыг ХХААХҮЯ болон Ажлын хэсэгт тухай бүр хүргүүлж ажилласан. Засгийн газрын 2025.01.29-ний өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 48 дугаар тогтоолоор журамд нэмэлт, өөрчлөлт оруулан батлсан. Хавсралт нийт : 2, Файл : 1 Зураг : 1	Хэрэгжсэн - 100%
	300		2.1. 2.Жижиг, дунд үйлдвэрийн газрын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн боломжит хувилбаруудыг танилцуулах: 1/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах;	1. 2025 онд байгууллагын бүтэц, орон тоонд орсон өөрчлөлттэй холбогдуулан ТАЗ-с албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл олгосон 4 тогтоолыг батлуулсан. - Хүний нөөцийн цахим системд давхардсан тоогоор дотоод хөдөлгөөний өөрчлөлтөөр 39 албан хаагчийн мэдээллийг оруулсан. - Сул орон тоог нөхөх, бусад төрийн байгууллагаас шилжүүлэн томилох 4 удаагийн зарыг байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулсан. Төрийн албаны тусгай шалгалтыг 2 дугаар улиралд зохион байгуулж шалгалтад тэнцсэн удирдах-3, гүйцэтгэх-5 нийт 8 орон тоог нөхсөн байна. 2.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагудын уялдаа холбоог хангахаар ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт "жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ ажлын байр бий болгох, хадгалах зорилгоор 1. Бичил бизнесийг дэмжих санг байгуулах, 2. Төр, хувийн хэвшил, олон улсын санхүүгийн байгууллагын хамтарсан хөрөнгө оруулалтаар Жижиг, дунд үйлдвэрийн санхүүгийн корпорацыг байгуулж болно" гэсэн заалтыг тусгуулах саналыг 2025.12.01-ний өдөр хүргүүлсэн.	Ахиц гарсан - 50%
	301		2.2. 2/Одоогийн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг бичил бизнесийг дэмжих сан болгох, харин жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжихээр санхүүгийн корпорац байгуулж, менежментийг сайжруулах;	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт "жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ ажлын байр бий болгох, хадгалах зорилгоор 1. Бичил бизнесийг дэмжих санг байгуулах, 2. Төр, хувийн хэвшил, олон улсын санхүүгийн байгууллагын хамтарсан хөрөнгө оруулалтаар Жижиг, дунд үйлдвэрийн санхүүгийн корпорацийг байгуулж болно" гэсэн заалтыг тусгуулах саналыг 2025.12.01-ний өдөр хүргүүлсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

	302		2.3. 3/Орон нутгийн онцлогт нийцсэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийг аймаг, дүүрэг бүрд бий болгож, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах.	1.Бизнес инкубатор төв байгуулах нөхцөл байдлыг тодорхойлохоор нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгаас судалгаа авч дүнг нэгтгэхэд санхүүгийн дэмжлэг дутмаг, хүрэлцээгүй байгаа талаар дурдсан. Энэ асуудлыг шийдвэрлэх хүрээнд "Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв" НҮТББ-тэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, бодлогын судалгааг гүйцэтгүүлж байна. Үүний үр дүнд 2026 онд 5 аймагт БИТөв баригдах ТЭЗҮ боловсруулагдах нөхцөл бүрдэнэ. 2.АХБ-аас хэрэгжүүлж буй "Эмэгтэй бизнес эрхлэгчдийн дунд ногоон болон цахим эдийн засгийг хөгжүүлэх" төслийн хамтын ажлын хүрээнд санал солилцож Булган, Дархан, Сүхбаатар аймгуудад 3 бизнес инкубатор төвд дэмжлэг үзүүлж 4.0 сая ам.долларааp санхүүжүүлэхээр хэлэлцэж байгаатай холбогдуулан тус 3 аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, ерөнхий мэдээллийг бэлтгэж Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн. 3.Сэлэнгэ аймгийн Баруунхараа сумын 2,0 тэрбум төгрөгийн өртөгтэй ЖДҮТөвийг эзэмших, ашиглах талаар 2 удаагийн хурал зохион байгуулж, нэгдсэн зохион байгуулалтад оруулах талаар хэлэлцэж байна. 4.Улсын хэмжээнд бизнес хөгжлийн төвийг Дорноговь аймагт 1, Дундговь аймагт 2-ыг шинээр ашиглалтад оруулсан бол Ховд аймагт төвийн барилга 80 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна. Хавсралт : 3 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	303		3.1. 3.Санхүүжилтийн эх үүсвэр, зээлийн бодлогын талаар: 1/Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд олон эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтмол нэмэгдүүлэх;	1.ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.01-ний өдөр хүргүүлсэн. Тус төсөлд олон эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэх саналыг тусгасан. 2.ЖДҮГ нь 2025 оны төсөл сонгон шалгаруулах арга хэмжээний хүрээнд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийн бодлоготой уялдуулах зорилгоор орон нутгийн төсвөөс ЖДҮХС-д хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэр баталсан аймгуудад төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Нийт 11 аймагтай байгуулсан “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ”-ний хүрээнд 6,7 тэрбум төгрөг, ЖДҮХСангийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрт 40.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 2025 онд нийт 371 ААНБ-д хөнгөлөлттэй зээлийг олгохоор батлагдсанаас 2025.12.05-ны өдрийн байдлаар 324 ААНБ-д 47.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 3. ХХААХҮ-ийн Сайдын 2025 оны А/240 болон А/280 тоот тушаалын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын эх үүсвэрээс 2.3 тэрбум төгрөгийг хөдөө аж ахуйн загвар хоршоод болон Сэлэнгэ аймгийн Мандал суманд хүнсний зоорь, агуулах бий болгоход зориулсан хөнгөлөлттэй зээлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Хавсралт нийт : 2, Файл : 1 Зураг : 1	Хэрэгжсэн - 100%
	304		3.2. 2/Татвар төлөгчдийн хөрөнгөөс бус, уул уурхайн баялаг болох Үндэсний баялгийн сан, Хөгжлийн сангаас жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх санд жил бүр хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр хуваарилж байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Төвийн болон Зүүн бүсийн аймгийн ЖДҮҮ-Эрхлэгчидтэй уулзалт хийж ЖДҮҮДтХуулийн хэрэгжилтийн талаар ярилцаж, санал, хүсэлтийг авч ажиллаж, уулзалтын үр дүнд Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн дагалдах 7 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг нэгтгэн боловсруулж "Өрхийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-т 2025.04.04-ний өдөр хүргүүлсэн. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ-д "Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодит өсөлт, мөнгөний ханшны өөрчлөлтийг харгалзан тухайн жилд улсын төсөв, Үндэсний баялгийн сангаас болон зээлийн эргэн төлөлтөөс санд нэмж олгох зээлийн хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухайн жилийн төсөвт тусгаж батална." ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ-д "Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууц, шинэ ажлын байр бий болгох болон ажлын байр хадгалах зориулалтаар дэмжлэг үзүүлэх" гэсэн нэмэлт, өөрчлөлтийн саналыг тус тус хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%

				Хавсралт : 1 файл	
	305		3.3. 3/Бүс, салбарын онцлогт тохирсон, олон хувилбартай зээлийн бүтээгдэхүүн бий болгох, үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зээлийг 10 жилээс доошгүй хугацаатай, эргэлтийн хөрөнгийн зээлийг 5 жилээс доошгүй хугацаатайгаар олгох боломжийг бий болгох;	ЖДҮҮДТухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд “бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”-д 9 хүртэл ажилтантай, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 400 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг; “жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”-д 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 400 сая - 2 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг; “дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”-д 51-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, 2-10 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг хамруулна. гэж заасны дагуу зээлийг олон хувилбартай зээлийн бүтээгдэхүүн бий болгох, үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зээлийг 10 жилээс доошгүй хугацаатай, эргэлтийн хөрөнгийн зээлийг 5 жилээс доошгүй хугацаатайгаар олгох боломжийг тусгаад байна.	Ахиц гарсан - 50%
	306		3.4. 4/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хөнгөлөлттэй зээлийг шатлан олгох;	1.2025 онд төсөл сонгон шалгаруулах арга хэмжээний хүрээнд тухайн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийн бодлоготой уялдуулах зорилгоор орон нутгийн төсвөөс ЖДҮХС-д хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэр баталсан аймгуудад төсөл сонгон шалгаруулалтыг зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажилласан. Тайлант хугацаанд нийт 11 аймагтай “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ”-ний хүрээнд 7,8 тэрбум төгрөг, сангийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 40.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн, хөнгөлөлттэй зээл олгосон. 2.ЖДҮХС-аас 2025 онд нийт 371 аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгохоор батлагдсанаас 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 324 аж ахуйн нэгжид 47.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 3. Хөнгөлөлт зээлийн мэдээллийг 35 удаагийн танхим, 4 удаагийн цахим сургалтаар өгч 1107 ЖДҮЭ-ийг хамруулж, утсаар болон биечлэн 4941 иргэн, ААНБ-д мэдээлэл өгсөн.	Хэрэгжсэн - 100%
	307		3.5. 5/Хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг бүс нутгийн онцлог (цаг агаар, газар зүйн байршил, үйлдвэрлэлийн төрөл) дээр үндэслэн ялгавартайгаар хэрэгжүүлж, хөнгөлөлттэй зээлийг тасралтгүй олгох;	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.23-ны өдөр хүргүүлсэн. Үүнд: Хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг бүс нутгийн онцлог (цаг агаар, газар зүйн байршил, үйлдвэрлэлийн төрөл) дээр үндэслэн ялгавартайгаар хэрэгжүүлж, хөнгөлөлттэй зээлийг тасралтгүй олгох саналыг тусгасан. Засгийн газрын 2025 оны "Аян өрнүүлэх тухай" 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Атар-4 Тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй "Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээл"-ийг банкны эх үүсвэрээр үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож байна. Монголбанкнаас ирүүлсэн 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн мэдээгээр Улаанбаатарт хотод нийт 189 зээлдэгчийн 326.61 тэрбум төгрөгийн зээл буюу 67.8 хувь, 750 зээлдэгчийн 221.64 тэрбум төгрөгийн зээл буюу 32.2 хувь нь орон нутагт тус тус шийдвэрлэгдсэн байна.	Ахиц гарсан - 50%
	308		3.6. 6/Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангаас жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;	ЖДҮГ нь 2025 оны төсөл сонгон шалгаруулах арга хэмжээний хүрээнд тухайн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийн бодлоготой уялдуулах зорилгоор орон нутгийн төсвөөс ЖДҮХС-д хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэр баталсан аймгуудад төсөл сонгон шалгаруулалтыг зарлаж, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажилласан. Тайлант хугацаанд нийт 11 аймагтай “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ”-ний хүрээнд 7,8 тэрбум төгрөг, сангийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 40.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн, хөнгөлөлттэй зээл олгосон.	Хэрэгжсэн - 100%
	309		4.1. 4.Дэмжих төвийн хүртээмж, менежментийн талаар: 1/Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас зээл авсан бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 17 дугаар зүйлд дараахь нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар санал боловсруулж ХХААХҮЯ-ны Ажлын хэсэгт хүргүүлсэн. - Зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг чадавхжуулах, тэдгээрийг бүртгэлжүүлэх, үнэлэх, хяналт тавих, дотоодын зөвлөх бэлтгэх тогтолцоог сайжруулах; - Бизнес инкубатор төвүүдийг байгуулах, тэдгээрийн хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагааг дэмжих.	Х.Б

				Хавсралт : 1 файл	
	310		4.2. 2/Дотоодын болон гадаадын байгууллагаас зохион байгуулдаг бизнесийн сургалтад хамрагдаж, итгэмжлэгдсэн гэрчилгээ авсан бизнес эрхлэгчдэд тэргүүн ээлжид хөнгөлөлттэй зээл олгох тогтолцоог бий болгох.	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.23-ний өдөр хүргүүлсэн. Дотоодын болон гадаадын байгууллагаас зохион байгуулдаг бизнесийн сургалтад хамрагдаж, итгэмжлэгдсэн гэрчилгээ авсан бизнес эрхлэгчдэд тэргүүн ээлжид хөнгөлөлттэй зээл олгох тогтолцоог бий болгох саналыг тусгасан. Хавсралт : 2 файл	Х.Б
	311		5.1. 5.Ажлын байр, ажиллах хүчнийг дэмжих талаар: 1/Ажлын байрны түрээсийн үнийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн зохицуулалт бий болгох;	Улсын хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, давхардлыг арилгах, бизнес инкубатор, дэмжих төвийн тогтолцоо, нэгдсэн удирдлага зохион байгуулалттай болох зайлшгүй шаардлага үүсээд байна. Иймээс уул уурхайн бус үйлдвэрлэлийг хөгжүүлж эдийн засгийг солонгоруулах эрэг үр дагавар бий болгож, байгаль орчинд халгүй өндөр болон дэвшилтэд технологи, инновац нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээсэн бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өсгөн импортыг орлох, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих замаар хүн амыг ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг хангах зорилгоор “Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн төслийг боловсруулад байна. Дагалдах хуулийн төслүүд буюу Ажлын байрны түрээсийн үнийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын талаарх төслийг боловсруулаад байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	312		5.2. 2/Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглагдаагүй барилга, байгууламжийг нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд ашиглуулах;	1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглагдаагүй барилга, байгууламжийг нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд ашиглуулах талаар танилцуулга, ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулж, ХХААХҮЯ-д хүргүүлсэн. 2.ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.23-ний өдөр хүргүүлсэн. Үүнд: Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглагдаагүй барилга, байгууламж, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн барилгыг иргэд, аж ахуйн нэгжид нээлттэй болгох зэрэг саналуудыг тусгасан. Хавсралт нийт : 2, Файл : 1 Зураг : 1	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	313		5.3. 3/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн барилгыг иргэд, аж ахуйн нэгжид нээлттэй болгож, нэн бага түрээстэй болон хамтын оффисын хэлбэрээр ашиглах барилгын хүртээмжийг нэмэгдүүлэх;	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.23-ний өдөр хүргүүлсэн. Үүнд: Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглагдаагүй барилга, байгууламж, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн барилгыг иргэд, аж ахуйн нэгжид нээлттэй болгох зэрэг саналуудыг тусгасан. Хавсралт : 2 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	314		5.4. 4/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар газар олгохдоо нэг удаа хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох зохицуулалтыг бий болгох.	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.23-ний өдөр хүргүүлсэн. Үүнд: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар газар олгохдоо нэг удаа хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох зохицуулалтыг бий болгох саналыг тусгасан. Мөн Газрын тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналын төсөл боловсруулсан. Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.4.5.Орон нутагт шинэ ажлын байр бий болгох, хадгалах зорилгоор газрыг үйлдвэр үйлчилгээ эрхлэх зориулалтаар тэргүүн ээлжинд бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид ашиглуулах гэрээг байгуулах;	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%

				Хавсралт : 1 файл	
	315		6.1. 6.Борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх, импортыг зохицуулах талаар: 1/Төр болон томоохон үйлдвэрлэгчдийн ханган нийлүүлэлтэд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, оролцуулах бодлого хэрэгжүүлэх;	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД Төрийн нийтийн өмч газрын хэвлийн баялаг болох ашигт малтмал, газрын тос эрэх хайх, олборлох, боловсруулах, худалдаалах үйл ажиллагаа явуулж буй аливаа хуулийн этгээдийг худалдан авалтын 30-аас доошгүй хувийг орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс авахаар санал өгсөн. 2. ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт ЖДҮҮДТ хуулийг дагалдуулан ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ-д Төр болон томоохон үйлдвэрлэгчдийн ханган нийлүүлэлтэд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих саналыг боловсруулан хүргүүлсэн.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	316		6.2. 2/Төрийн, нийтийн өмч болох газрын хэвлийн баялгийг ашиглан үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн худалдан авалтыг нээлттэй, ил тод болгож жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжих;	1. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД Төрийн нийтийн өмч газрын хэвлийн баялаг болох ашигт малтмал, газрын тос эрэх хайх, олборлох, боловсруулах, худалдаалах үйл ажиллагаа явуулж буй аливаа хуулийн этгээдийг худалдан авалтын 30-аас доошгүй хувийг орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс авахаар санал өгсөн. 2. ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт ЖДҮҮДТ хуулийг дагалдуулан ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ-д Төр болон томоохон үйлдвэрлэгчдийн ханган нийлүүлэлтэд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих саналыг боловсруулан хүргүүлсэн.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	317		6.3. 3/Борлуулалтын сувгийг хилийн боомт, экспорт, импортын урсгал, гадаад худалдааны бүтэцтэй уялдуулан оновчтой болгох;	2025 оны байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан баруун бүсийн хэмжээнд хур тунадас бага, гантай байснаас улбаалан малын өвс, тэжээлийн гарц муу, улаанбуудайн ургац хураалт өмнөх жилүүдээс харьцангуй бага байх төлөвтэй зэрэг тариалангийн үйлдвэрлэлийн бодит нөхцөл байдалд тулгуурлан улаанбуудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийн хангамж, нийлүүлэлт тухайн бүс нутагт доголдох нөхцөл байдал үүсэж болзошгүй нөхцөл байдал үүссэн. Иймд Улсын Их Хурлын 1999 оны “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолд нэмэлт оруулж Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор тэг татвартайгаар импортлохоор баталсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	318		6.4. 4/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын борлуулалт, логистикийн төв, тээвэрлэлтийн дэд бүтцийг кластер хэлбэрээр бүс нутаг бүрийн онцлогт тохируулан бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцүүлэн хөгжүүлэх;	Монгол Улсад зөгийн аж ахуйн үйл ажиллагааг тогтворжуулах, оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, нэгдэх хүсэлтэй зөгийчдийн хөдөлмөр эрхлэлтийг албажуулах, экспортын чиг баримжаатай дээд зэрэглэлийн зөгийн балны кластерын бүлэг байгуулах, тэдгээрийн сургалт, хөгжүүлэх зорилгоор "Монголын зөгийн аж ахуйн форум-2025" арга хэмжээг зохион байгуулсан. Зөгийн аж ахуй эрхлэгчид, хоршоод, үйлдвэр эрхлэгчид, төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөл, судлаачид, олон улсын болон ТББ-ын нийт 90 гаруй оролцогч оролцсон. Арга хэмжээний үр дүнд Монголын зөгийн балны кластерын бүлэг байгуулагдаж, органик, экспортын шаардлага хангасан стандарт, тохирлын үнэлгээтэй болох бүтээгдэхүүн хөгжих боломжийг бүрдүүлсэн. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	319		6.5. 5/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс худалдан авалт хийсэн байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх зохицуулалтыг бий болгох;	УИХ-ын даргын 2024 оны 82 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг болон Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 02 дугаар тогтоол, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 02 тогтоолоор тус тус байгуулагдсан ажлын хэсгүүдэд дэмжлэг үзүүлэх, хуулийн хэлэлцүүлэг хийх, салбарын мэдээлэл хийх зорилгоор Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Булган, аймгийн ЖДҮэрхэлэгчидтэй уулзалт хийж, мэдээлэл өгч ажиллав. ХХААХҮСайдын А/52 дугаар томилотлтын тушаалын дагуу ажиллав. Мөн Дорноговь аймагт Говийн бүсийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн хэрэгжилт, цаашид хийх өөрчлөлтийн саналыг авч ажиллав. Нийсэлэлийн ЖДҮЭрхлэгчидийн зөвлөгөөнийг Д.Сүхбаатарын нэрэмжит танхимд зохион байгуулж мэдээлэл өгч ажиллав. Үүнтэй холбогдуулан	Х.Б

				Аж үйлдвэржилтийн байгуулын хорооны 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг батлав. Нэр бүхий УИХ-ын гишүүд намрын чуулганд хуулийн төслийг өргөн барих төлөвлөгөөтэй байгаа болно. Мөн байгуулын хороо болон ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Л.Батлутын зөвлөхөөс тодруулахад 12 сард өргөн барих тухай мэдээлэл өгч байсан. ХХААХҮСайд М.Бадамсүрэнгээс өгсөн чиглэлийн дагуу хуулийн төслийг сайдын зөвлөх, ЖДҮГ-тай хамтран боловсрулав. Хууль тогтоомжийн хуулийн дагуу үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулхад шаардагдах судалгааг хийж гүйцэтгээд байна. Холбогдох судалгаа, олон нийтийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, хуулийн төслийг хавсаргав. Хуулийн төсөлд төрийн худалдан авалтаар дэмжих холбогдох заалтыг тусган ажиллаж байна.	
	320		6.6. 6/Импортыг орлуулах дотооддоо үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүний жагсаалт гаргаж, тусгай бодлого, квот, татварын зохицуулалт хийх;	Хэрэгжилт тооцох болоогүй	Х.Б
	321		6.7. 7/Экспортыг дэмжих хүрээнд борлуулалтын нэгдсэн суваг бий болгох, гадаад, дотоодын үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх.	АНУ-ын Чикаго, Нью-Йорк хот, Канад улсын Оттава хотуудад "Mongolian Gallery", БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод "Mongol Hot", ХБНГУ-ын Фрайбург хот дахь "Mongolei Zentrum Freiburg" байгуулагаатай дэлгүүр, мэдээллийн төвийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тогтмол дэмжиж тухайн улс орны бусад хотуудад зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд зохион байгуулж ажилласан. Хавсралт : 2 зураг	Хэрэгжсэн - 100%
	322		7.1. "7.Татварын хөнгөлөлт, урамшууллын талаар: 1/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалт, татварын тайланд үндэслэн хөнгөлөлт, урамшууллыг олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх."	Аж үйлдвэржилтийн байгуулын хорооны 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 14 дүгээр тогтоолын 1.1 дэх заалтаар “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2025 оны намрын эээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”; гэсний дагуу Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалт, татварын тайланд үндэслэн хөнгөлөлт, урамшууллыг олгох эрх зүйн орчинг бүрдүүлэх төслийг бэлтгээд байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	323		8.1. "8.Инновац, шинэ технологи, ногоон хөгжлийн дэмжлэгийн талаар: 1/Инновац, шинэ технологи, ногоон хөгжлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд олгох;"	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.23-ний өдөр хүргүүлсэн. Инновац, шинэ технологи, ногоон хөгжлийн дэмжлэгийн талаар саналыг тусгасан.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	324		8.2. 2/Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэд бүтцийн бодлогоор дэмжих.	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.23-ний өдөр хүргүүлсэн. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэд бүтцийн бодлогоор дэмжих саналыг тусгасан. Хавсралт : 2 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	325		2. Хоёр.Энэ тогтоолын биелэлтийг хангаж 2025 оны намрын чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т үүрэг болгосугай.	УИХ-ын даргын 2024 оны 82 дугаар захирамж, УИХ-ын байнгын хорооны 2025 оны 02, 25 дугаар тогтоолоор хуулийн төсөл боловсруулах, тогтолцоог оновчтой болгох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан холбогдох судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн ба ХХААХҮ-ийн Сайд М.Бадамсүрэнгээс өгсөн чиглэлийн дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулахад шаардагдах судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулсан. Хавсралт : 4 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
72	326	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-06-24	2.2. хүнд, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Хүнд болон Хөнгөн үйлдвэрийн тухай анхдагч хуулийн төсөл, холбогдох бусад	Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийн үзэл баримтлал, тандан судалгааг шинэчлэн Монгол улсын их хурлын аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 01/433 тоот албан бичгээр хүргүүлсэн. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны УИХ-12/3630	Удаашралтай / эрчимжүү

		Дугаар 2025№15 ЭЗБХ	хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх;	тоот бичгээр холбогдох судалгааг шинэчлүүлэхээр буцаан ирүүлсэн. Байнгын хорооноос ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/296 дугаар тушаалаар Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг яамны бүтцийн нэгж болон салбарын 6 холбоодын төлөөллийг оролцуулан ажлын хэсгийн байгуулан үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулсан.	лэх шаардлагатай - 50%
73	327	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-07-08 Дугаар 2025_10 НББХ	1.. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, залуучуудын өнөөгийн нөхцөл байдлын үр дүнд үндэслэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг, залуучуудын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хөгжил, оролцоо, нийгмийн асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх зорилго, зорилтыг тусгасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг тус тус боловсруулж, 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай.	Тус яам нь НҮБ-ын ХХААБ-тай хамтран “Залуу малчдын сургалтын тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг 2021 оноос хэрэгжүүлж залуу малчдын уламжлалт нүүдлийн мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, эрсдэлийг бууруулах, дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор “Залуу малчин” сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Уг хөтөлбөр нь Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс сургалтын хөтөлбөрийн стандартад 100% нийцсэн гэсэн үнэлгээ авч, ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/515 дугаар тушаалаар батлагдсан. Залуу малчдын уламжлалт нүүдлийн МАА-г орчин үеийн шинжлэх ухаанд суурилсан мэдлэгтэй хослуулан эрхлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, МАА-н эрсдэлийг бууруулж эдийн засгийн үр ашигтай бизнес эрхлэх чадварыг төлөвшүүлэхэд чиглэсэн дараах 9 чадамжид суурилсан бүтэцтэй. Үүнд: • бэлчээрийн болон байгалийн нөөцийн зохистой менежмент хэрэгжүүлэх, • тэжээл, тэжээллэг тэжээл үйлдвэрлэлийн технологийг эзэмших, • малын эрүүл мэндийг хамгаалах, • малын гаралтай түүхий эдийг нэмүү өртөг шингээж боловсруулах, • мал аж ахуйн бизнес, маркетингийг хөгжүүлэх, • хоршиж ажиллах замаар орлого, амьжиргааг нэмэгдүүлэх мэдлэг, ур чадварыг олгож байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд залуу малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавх сайжирч, МАА-н үйлдвэрлэлийн тогтвортой байдал хангагдан, гэр бүлийн орлого, амьдралын чанар дээшлэх, эдийн засгийн хувьд бие даан тогтвортой бизнес эрхлэх суурь нөхцөл бүрдэх юм. Цаашид сургалтын үйл ажиллагааны хамрах хүрээг бүсчилсэн байдлаар үе шаттайгаар өргөжүүлж, сургалтад хамрагдсан залуу малчдын урт хугацааны үр нөлөө, тогтвортой байдлыг үнэлэх үнэлгээний тогтолцоог бүрдүүлнэ. Мөн уур амьсгалын эрсдэл өндөртэй бүс нутгийн залуу малчдад чиглэсэн зорилтот сургалт, дэмжлэгийн арга хэмжээг нэмэгдүүлж, тухайн бүсийн онцлогт тохирсон мэдлэг, чадварыг олгоно. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	328		2. Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд боловсрол, залуу малчид, орон нутгийн залуус, хөдөлмөр эрхлэлт, хүмүүжил, ёс суртахуун гэсэн дараах 5 үйл ажиллагааг шаардлагатай санхүүжилтийн хамт улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай:	Малчны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх мэдлэг олгох, тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх зорилготой малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг батална гэж заасны дагуу уг сургалтын хөтөлбөрийг боловсруулж “Чадамжид суурилсан залуу малчдад зориулсан сургалтын хөтөлбөр”-ийг ХХААХҮ-н сайдын 2025 оны А/515 р тушаалаар батлуулсан. Энэхүү сургалтын хөтөлбөр нь малчдад мэдлэг олгож, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх дадал эзэмшүүлэн чадавхижуулах зорилготой бөгөөд мал аж ахуйн бизнес маркетингийг хэрхэн хөгжүүлэх, МАА-н салбарт хоршиж ажиллах талаар мэдлэг эзэмшүүлэх чиглэлүүд багтсан. НҮБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллага, БНСУ-ын Засгийн Газрын санхүүжилттэй, Монголын ноолуурын салбарт ажиллаж буй залуучуудын ур чадвар болон техник, мэргэжлийн боловсрол нэмэгдүүлэх, сургалтын байгууллагын төгсөгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, ажил олгогч, залуу ажилтны хооронд соёл ойлголтын зөрүүг арилгах, ажил олгогч, ажилтны хамтын ажиллагааг сайжруулах замаар шийдэл олж хэрэгжүүлэх зорилготой “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл нээлтээ хийсэн. Уг төсөл нь 2024.7 сараас 2026.12-р сар хүртэл хэрэгжих бөгөөд төслийн түншлэгч талуудаар ГБХНХЯ, ХХААХҮЯ, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагууд, Монголын ноос ноолуурын холбоо, Монголын хөнгөн үйлдвэрийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, сургалтын байгууллагууд болон БНСУ-ын талаас БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний агентлаг (KLES) БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн үйлчилгээний агентлаг (KEIS) нар ажиллаж ноолуур, зочлох үйлчилгээний салбарын ажил олгогчид, залуу ажилчдад чиглэн хэрэгжих юм. Төслийг 5 үйлдвэрт хэрэгжүүлсэн. ttps://www.mofa.gov.mn/news/TIME/691d40bf07a19340d6cb0aa0?fbclid=IwdGRjcAPF2IdjbGNrA8XYWGV4dG4DYWVtAjExAHNydGMGYXBwX2IkDDM1MDY4NTUzMTcyOAABHhNyRxvu0JCKgEMi__xWo	Тодорхой ур дүнд хүрсэн - 50%

				a8xaiWXuq2TugOVbNpleaDv6E5mU5CdKBCUQ4AW_aem_LhTZYMdu0b5pz3kowbEo7Q Хавсралт : 1 файл	
	329		2.7. залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зарцуулалтын тодорхой хувийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж буй залуучуудад зарцуулах, Залуучуудын хөгжлийг дэмжих санг байгуулах талаар судалж, танилцуулах;	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ЖДҮҮДтХ-д холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эх бичвэрийн санал боловсруулж 2025.12.23-ний өдөр хүргүүлсэн. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зарцуулалтын тодорхой хувийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж буй залуучуудад зарцуулах саналыг тусгасан.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
Ерөнхийлөгчийн зарлиг					
74	330	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Хөрс хамгаалах/ 2016-12-02 Дугаар 2016_158	1.4. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээр ашиглах уламжлалт арга ажиллагааны дэвшилтэт хэлбэрийг хэрэгжүүлж, хөрс бэлчээрийг сайжруулах дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг иргүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Өмнөх жилээс тодорхой ахиц гараагүй 10 услалтын системийн барилгын ажил эхлүүлснээс бусад ажлууд нь өмнөх жилүүдэд хэрэгжсэн бөгөөд давхардуулан тайлагнасан.	1. Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг байгаль орчинд хоргүй дэвшилтэт технологиор тэмцэх зорилгоор улсын 1547.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөр 295.5 сая төгрөг, нийт 1842.5 сая төгрөгийн хөрөнгөөр 238.1 тн микробиологийн бэлдмэлийг Шим ХХК нийлүүлсэн. ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/70 дугаар тушаалаар Архангай, Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Төв, Хөвсгөл, Дархан-Уул аймгийн 45 сумын 151 багт 238.1 тн микробиологийн бэлдмэлийг 119.2 мянган га бэлчээрийн талбайд зохион байгуулж, арга хэмжээний хэрэгжилтэд яамнаас болон аймгийн ХХААГ, сумын Засаг даргын тамгын газар тогтмол хяналт тавьсан. 2. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд 7 аймгийн 9 суманд 2,970 га талбайг услах хүчин чадал бүхий 9 услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил хийгдэж байгаагаас 7 услалтын системийн ажил бүрэн дуусаж улсын комисс хүлээн авсан. Хэнтий аймгийн Хэрлэн сумын “Дулааны тал”, Говь-Алтай аймгийн Жаргалан сумын “Цахир” услалтын системийн ажлууд нь тоног төхөөрөмжийн нийлүүлэлтээс шалтгаалан хугацаандаа дуусаагүй байгаа бөгөөд гүйцэтгэгч “Жинсийн орой” ХХК, “Комп Трейд” ХХК нарын түншлэл, “Алтайн Үндэс Констракшн” ХХК нар нь гэрээ сунгах хүсэлт ирүүлээд байна. Хавсралт : 7 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
75	331	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Монгол хэлний тухай хуульд төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага 2025 оны 1 сарын 1-нээс албан хэргээ кирилл, үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гэж заасан тул ХХААХҮЯамны албан хаагчдад Монгол бичгийн хичээлийг бие даан судлахад зориулж, цахим системд: 1. Монгол бичгийн үндсэн хичээлүүд нийт 13 хичээл, 2. Дадлага ажлын 6 хичээлийг байршууллаа. Энэхүү хичээлийг Монгол хэл, бичиг, зохиолын багш, магистр О.Төгөлдөр багшаар бэлтгүүлэн онлайн хичээлийн холбогдох линкүүдийг хүргүүлсэн бөгөөд монгол бичгийн хичээлийг судлан, албан бичгийн хэрэглээнд ашиглахыг зөвлөмж болгосон. - Яамны цахим хуудасны мэдээ, мэдээллийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх, цахим хуудас шинэчлэх ажлыг төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна. - Албан бичиг, яамнаас гарч байгаа шийдвэрийг хос бичгээр хөтлөх ажлыг туршихаар бэлтгэл ажлыг хангаж байна. - Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөнд Монгол бичгийн цахим хичээлд албан хаагчдыг хамруулах үйл ажиллагааг тусган үе шаттай хэрэгжүүлж байна. Удирдлагын академиас төрийн албан хаагчдад зориулсан цахим хичээлийн Монгол бичгийн 1 дүгээр шатны сургалтад албан хаагчид хамруулж, төрийн албан хаагчдад зориулсан “Монгол бичгийн гарын авлага” номыг дотоод сүлжээгээр яам болон харьяа байгууллагын албан хаагчдад түгээлээ. - Албан хаагчдын ажлын үнэмлэх дээр яамны нэрийг монгол бичгээр үйлдэж, хэвлэж хэвшсэн. Яамны гадна хаягийг монгол бичгээр үйлдэж байршуулсан. Өрөө тасалгааны хаягийг шинэчилж монгол бичгээр үйлдэж байршуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Хавсралт : 5 зураг	Хэрэгжсэн - 100%
76	332	Засгийн газарт чиглэл өгөх тухай	1.3.. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, нормативыг нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бусад нөлөөлөх үзүүлэлтийг харгалзан шинэчлэн тогтоох,	1) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох тухай А-470/А-327/А-306 тоот хамтарсан тушаалыг батлуулан,	Хэрэгжсэн - 100%

		2019-05-30 Дугаар 2019_104	согтууруулах үндааны импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлд тавих хяналтыг чангатгах, энэ төрлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх цагийн хуваарийг богинсгож 08.00-24.00 цаг болгох, долоо хоног бүрийн нэг өдрийг архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй, худалдан борлуулахгүй байх, 400 мл хүртэлх жижгээр савалсан архи дэлгүүрүүдээр зарахыг хориглох эрх зүйн зохицуулалтыг бий болгох. Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Заалтын хүрээнд товч тодорхой тайлагнах Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022_43 зарлигтай давхардуулсан утгаар тайлагнахгүй байх	мөрдүүлж байна. 2) Согтууруулах үндааны импорттой холбоотой хууль эрхзүйн дараах зохицуулалтууд хэрэгжиж байна. Үүнд: Согтууруулах үндаа импортлох тусгай зөвшөөрөл, гаалийн хяналт, шалгалт, татварын акц, хувийн хэрэглээний квот, олон улсын стандартыг мөрдөх гэх мэт. Эдгээр арга хэмжээ, зохицуулалт нь Монгол Улсад согтууруулах ундааны импортыг хянах, чанарыг хамгаалах, эрүүл мэнд, нийгмийн сөрөг нөлөөг бууруулах үндсэн зорилготой хэрэгжиж байна. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт, дуудлага худалдааны үндсэн дээр олгох, согтууруулах ундааны үйлдвэрлэл, хаяг, савлагаанд тавих шаардлагыг нарийвчлан тусгасан. 3) Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасны дагуу аймаг нийслэлийн Засаг дарга нар орон нутагтаа согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг баталсан захирамж гарган хэрэгжүүлж байна. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12.6-д Гадаад улсад экспортлох, агаарын хөлгийн үйлчилгээ, татваргүй барааны дэлгүүр, зочид буудлын хэрэгцээнд тусгай зориулалтаар, захиалгаар нийлүүлэхээс бусад тохиолдолд 18, түүнээс дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг 0.33 литрээс бага, 1 литрээс их хэмжээгээр савлахыг хориглосон заалт тусгагдсан ба энэ заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760312179111	
	333		1.5.. Улсын хэмжээнд ажиллаж буй хүнсний аюулгүй байдлын лабораторуудыг олон улсын магадлан итгэмжлэлд оруулах, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний бүтэц, найрлагыг нарийвчлан тогтоох, чанар аюулгүй байдлыг батгалгаажуулах, судалгаа шинжилгээ хийх чиглэлээр чадвахжуулах, олон улсад ашиглаж буй стандартуудтай жишсэн үндэсний шинжилгээний арга, аргачлалын стандартыг шинэчлэн боловсруулах, харилцан мэдээлэл солилцох, ялангуяа хүний эрүүл мэндэд хортой бодис илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч ажиллах чиглэлээр нэгдсэн бодлого зохицуулалт хийх.	Улсын хэмжээнд ажиллаж буй хүнсний аюулгүй байдлын лабораторуудыг олон улсын магадлан итгэмжлэлд оруулах чиг үүрэг Шадар сайдад байдаг ба ХХААХҮЯ-аас лабораторийг чадавхжуулахтай холбоотой дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд: Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 206 дугаар тогтоолоор Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг ШУТИС-ийн Хүнсний судалгаа, инновацийн нээлттэй төвийг түшиглэн, 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газрын холбогдох мэргэжилтнүүд тухай бүр ажлын хэсэг болон холбогдох асуудлаар санал боловсруулан ажиллаж байна. 2. Салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, үйл ажиллагааг уялдуулах, бүтээмж үр ашгийг дээшлүүлэх, төсвийн зардлыг бууруулан, лабораториудын харилцан мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын лаборатори, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн үйл ажиллагааг нэгдмэл уялдаатайгаар зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж тогтоолын төсөлд санал тусган хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
	334		1.15.. Биенесийн орчинд хүүхдийн аюулгүй байдал, хамгааллыг хангах, бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж, хүүхдийн эрхийг дээдэлж, дэмжсэн маркетинг, сурталчилгааг ашиглах, хүүхдэд зориулсан хүнс, хийжүүлсэн ундааны маркетингийг хязгаарлах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.	УИХ-ын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн батлагдсан. Энэ хуулиар "чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, ус" -ны чихрийн агууламжаас хамааруулан литр тутамд онцгой албан татвар тогтоохоор зохицуулсан. Хуулийн хэрэгжих хугацаа 2027 оны 1 сарын 01 бөгөөд онцгой татварын хэмжээг үе шаттай нэмэгдүүлэхээр заасан.	Х.Б
	335		1.17.. Хүний эрүүл мэндэд нөлөөтэй эмийн бус бүтээгдэхүүн /чихэр, давс, хансан тос ихээр агуулсан хүнс, зохицуулах үйлчилгээний хүнс, биологийн идэвхт бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, тамхи/ -ийн тусгай зөвшөөрөл, бүртгэл, сав, баглаа боодол, шошгын танилцуулга, зар сурталчилгаа зохицуулах, хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.	1. Бүх төрлийн чихэрлэг ус, ундаанд онцгой албан татварыг үе шаттайгаар ногдуулахаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг 2024 онд хэлэлцэн батлагдсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141531933961&showType=1 Тус хуулийг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө. 2. Монгол Улсын Ерөнхийлөгч архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах чиглэлд бодлогын болон эрх зүйн өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 42 дугаар зарлигийг 2022 онд гаргасан. Энэ хүрээнд согтууруулах ундааны хатуулгыг үе шаттайгаар бууруулахаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг хэлэлцэн батлагдсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530863158441&showType=1 3. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн О.Номинчимэг УИХ-д өргөн мэдүүлсэн. Тус хуулийн төсөлд салбарын яамнаас тухай бүр холбогдох саналыг хүргүүлэн ажиллаж байна.	Ахиц гарсан - 50%

77	336	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.1. Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай. 1.1.Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад Монгол Улсын хувь нэмэр, бодит оролцоог нэмэгдүүлэх, "Алсын Хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх үндэсний цогц хөтөлбөр, стратеги гарган хэрэгжүүлэх	Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны 1.1.6 дахь заалтад Хөрсийг хамгаалах ойн зурвас байгуулах, тариалангийн талбайг хашаажуулах, тариалалтын системд олон наст тэжээлийн таримлыг оруулах, таримал бэлчээр хадлан бий болгох гэж заасны дагуу тариалангийн талбайг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Сайхан /30,6 км/, Орхон /12 км/, Зүүнбүрэн /24 км/ сумдууд, Дархан-Уул аймгийн Хонгор /36 км/ суманд нийт 4 байршилд улиас, хайлаасны суулгацаар 3 эгнээ хамгаалалтын ойн зурвасыг 93 км-ийн урттай 9 мянга орчим га талбайг хамгаалан байгуулсан. Мөн тариалангийн талбайг хамгаалан хашаажуулахад төмөр бетон шонг тариаланчдад хашаагаа дагуулан ойн зурвас байгуулах нөхцөлтэй олгож байна. Хавсралт нийт : 5, Файл : 2 Зураг : 3	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	337		1.4. Цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах зорилгоор агро-ойг хөгжүүлж, иргэдийн амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг бий болгох, иргэн, аж ахуйн нэгжид татварын болон татварын бус бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, халамжаас-хөдөлмөрт шилжих цогц бодлоготой мод тарьж ургуулах бүх нийтийн үйлсийг уялдуулах	“Тэрбум-мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тариалангийн талбайг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Сайхан /30,6 км/, Орхон /12 км/, Зүүнбүрэн /14,4 км/ сумд, Дархан-Уул аймгийн Хонгор /36 км/ суманд нийт 4 байршилд улиас, хайлаасны суулгацаар 3 эгнээ хамгаалалтын ойн зурвасыг 93 км-ийн урттай 9 мянга орчим га талбайг хамгаалан байгуулсан. Мөн Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар Улсын төсвийн 9.2 тэрбум төгрөгөөр тариалангийн төв бүс болох Сэлэнгэ /186,875 ширхэг/, Дархан-Уул /101,565 ширхэг/ Төв /21,250 ширхэг/, Булган /51,550 ширхэг/ аймгуудад нийт 361,240 ширхэг төмөр бетон шонгоор 1806 км-ийн урттай 80 мян.га талбайг хамгаална. Хавсралт : 3 зураг	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	338		1.5. Иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн санг бүрдүүлж, түүнийг улсын нэгдсэн санд бүртгэх, тарьсан модыг зах зээлийн эргэлтэд оруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад нь бодит дэмжлэг үзүүлэх болон гадаад улсаас Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх	Тус яамнаас "Орон нутагт жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн газар байгуулах" тендерийг зарлаж, шалгарсан "Эм Жи Ди" ХХК-тай ажил гүйцэтгэх 250501/05-305 дугаартай гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч нь Дархан-Уул аймгийн Орхон суманд 10 га талбайд улсын төсвийн 1,115.5 сая төгрөгийн санхүүжилтээр жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн газрыг байгуулсан. Тус суулгац үржүүлгийн газрыг хашаалж, эх цэцэрлэгт үхрийн нүдний 10 сортын суулгац 3000ш, алимны 2 сортын суулгац 700ш, чавганы 2 сортын суулгац 480ш, интоорын 2 сортын суулгац 720ш, хөх далан хальсны 4 сортын суулгац 1600ш тус тус тариалж, бойжуулгийн талбайг бэлтгэж, гүний худаг, усан сан, усны нөөцийн сав, техник тоног төхөөрөмж хадгалах агуулах, жимс жимсгэний таримлын тайрдас, үндэслэсэн мөчир, тарьц хадгалах зориулалт бүхий 24м2, периоонор ажилладаг автомат тохируулга бүхий сэндвичэн хөргөлттэй агуулах, тарьц, суулгац ангилах, сортлох, түр хадгалах зориулалт бүхий 10м*15м харьцаатай сүүдрэвч, 36 мкв талбай бүхий ажилчдын байр, зуны нийлэг хальсан хүлэмж 2ш, дуслын усалгааны систем 4 га талбайд байршуулж, жимс жимсгэний таримлыг хүйтнээс хамгаалах хэрэгсэл, шаардлагатай техник, тоног төхөөрөмж зэргийг байршуулсан. "Тэрбум-мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тариалангийн талбайг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Сайхан /30,6 км/, Орхон /12 км/, Зүүнбүрэн /24 км/ сумдууд, Дархан-Уул аймгийн Хонгор /36 км/ суманд нийт 4 байршилд улиас, хайлаасны 90 мянга гаруй суулгацаар 3 эгнээ хамгаалалтын ойн зурвасыг 93 км-ийн урттай 9 мянга орчим га талбайг хамгаалан байгуулсан. Тариалангийн талбайн хөрс хамгаалах арга хэмжээний хүрээнд хашаажуулахаар бетон шонг тариаланчдад нэг шон нэг мод тарих нөхцөлтэйгээр олгож байна. Хавсралт : 5 файл	Хэрэгжсэн - 100%
	339		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	1. 2025 онд "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, харьяа агентлагуудын хамт олон Дархан-Уул аймгийн Дархан сумын 14-р багийн нутаг дэвсгэрт орших Бурхантын гудамжинд 240 ширхэг нарс мод, 250 ширхэг голт бор бут тарьж, гудамж талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах үйлсэд төр болон хувийн хэвшлийн байгууллага, болон иргэдийг өргөнөөр оролцохыг уриаллаа. 2. УИХ-ын гишүүн, БОУАӨ-н сайд асан С.Одонтуяа	Хэрэгжсэн - 100%

				болон УИХ-ын гишүүн Б.Батбаатар нар ХХААХҮЯ-ны харьяа Ургамал хамгааллын газартай хамтран мод тарих ажлыг зохион байгуулсан. 3. Яамны харьяа МУСҮТ-д мод суулгах тохижилтийн ажил хийгдэж байна. 4. 2023 онд яам болон түүний 10 харьяа байгууллага, МЭЕГ-ын 3 харьяа байгууллагын нийт 400 орчим ажилтан, албан хаагчдын 4 төрлийн 1000 орчим мод /улиас, гацуур, монос, хайлаас/ яамны харьяа ХААК ТӨХХК-ний 61 гарам дахь газарт тарьсан бөгөөд усалгаа тордолгоог жил бүрийн мод арчлах хугацаанд бүр хийж хяналт тавьж ажиллаж байна. Хавсралт : 10 зураг	
78	340	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.6. Архи, согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэл, борлуулалттай тэмцэх арга, хэлбэрийг боловсронгуй болгох, цахим техник, технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүнд оногдуулах эрүүгийн болон зөрчлийн ял шийтгэлийн бодлогод өөрчлөлт оруулах; Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Архи, согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэл, борлуулалтад тавих хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнд оногдуулах эрүүгийн болон зөрчлийн ял шийтгэлийн бодлогод өөрчлөлт оруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгах	Архи, согтууруулах ундааны хууль бус үйлдвэрлэл, борлуулалттай тэмцэх арга, хэлбэрийг боловсронгуй болгох, цахим техник, технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлсан бөгөөд тус хуульд холбогдох зохицуулалтыг тусгасан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530861302491. Түүнчлэн согтууруулах ундааны хатуулгын үе шаттайгаар бууруулахаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг хэлэлцэн батлсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530863158441&showType=1.	Ахиц гарсан - 50%
79	341	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	1. Зарлигийн хэрэгжилтийг хангах хүрээнд яамны харьяа байгууллага, аймгуудын ХХААГ, МЭГ-уудад уриалга хүргүүлж нэгдэж ажиллах талаар чиглэл хүргүүлж ажилласан. 2. Эзэн Богд Чингис хааны эш хөргийг Улаанбаатар хот болон Дархан-Уул аймгийн албан өрөөндөө дээдлэн залж байна. Хавсралт : 4 зураг	Хэрэгжсэн - 100%
80	342	Журам шинэчлэн батлах тухай (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам) 2024-05-27 Дугаар 2024_73	4.2.1. Энэхүү журмын 5.2.1, 5.2.2-т заасан шаардлагад нийцсэн мэдээллийг 5.3-т заасан хугацаанд Ажлын албанд ирүүлэх; (Хавсралтад заасны дагуу нийслэлд 5, аймагт 4 төрлийн мэдээлэл, ЗГХЭГ, ЗГХХГ болон яам, агентлаг тус бүрийн чиг үүрэгт хамаарах хавсралтад заасан мэдээлэл) (3.2 дахь заалт "Төрийн холбогдох байгууллагууд Зөвлөлийг энэхүү журмын хавсралтаар батлагдсан мэдээллээр тодорхой давтамжтайгаар тогтоосон хугацаанд тасралтгүй хангах үүрэг хүлээнэ")	Ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлагийг хасаргаагүй, https://legalinfo.mn/-гоос тус зарлиг ороогүй байх тул заалтыг тайлагнах болмжгүй байна	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
81	343	Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2025-04-03 Дугаар 2025_44	1. Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай. 2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай.	2025 онд "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ, харьяа агентлагуудын хамт олон Дархан-Уул аймгийн Дархан сумын 14-р багийн нутаг дэвсгэрт орших Бурхантын гудамжинд 240 ширхэг нарс мод, 250 ширхэг голт бор бут тарьж, гудамж талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах үйлсэд төр болон хувийн хэвшлийн байгууллага, болон иргэдийг өргөнөөр оролцохыг уриаллаа. УИХ-ын гишүүн С.Одонтуяа болон УИХ-ын гишүүн Б.Батбаатар нар ХХААХҮЯ-ны харьяа Ургамал хамгааллын газартай хамтран мод тарих ажлыг зохион байгуулсан. Яамны харьяа МУСҮТ-д мод суулгах тохижилтын ажил хийгдэж байна. 2023 онд яам болон түүний 10 харьяа байгууллага, МЭЕГ-ын 3 харьяа байгууллагын нийт 400 орчим ажилтан, албан хаагчид 4 төрлийн 1000 орчим мод /улиас, гацуур, монос, хайлаас/-ыг яамны харьяа ХААК ТӨХХК-ний 361 гарам дахь байршилд тарьсан бөгөөд усалгаа тордолгоог жил бүрийн мод арчлах хугацаанд бүр хийж хяналт тавьж ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%
ҮАБЗ-ийн зөвлөмж					
82	344	Биоаюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга	4. Биоаюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилготой биоаюулгүй ажиллагааны гуравдугаар	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам хамтран хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд: 2023 оны 05 сарын 31-ний өдөр УМЭАЦТЛ-ийн Биоаюулгүйн 3-р	Хэрэгжсэн - 100%

		хэмжээний тухай 2011-07-07 Дугаар 2011_25/24	зэрэглэлийн лаборатори байгуулах санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжүүлэх	зэргийн лабораторийн засвар үйлчилгээнд агааржуулалтын сорох, өгөх төхөөрөмжүүд, хөргөлтийн төхөөрөмжүүд, цэвэр болон бохир ус шахах насоснууд мөн өрөөний даралт температур болон бусад мэдээллүүдийг нэгтгэн харуулж тэдгээрийг горимын дагуу автомат болон гар удирдлагаар ажиллуулах доорх ажлууд хийгдсэн байна. Үүнд : 1. Хөргөлтийн төхөөрөмжүүдийг хэвийн ажиллагаатай болгож хяналт удирдлагын системд нэгтгэх 2. Агаар өгөх(1 ш), сорох сэнснүүд(4 ш)-ийг хэвийн ажиллагаатай болгож хяналт удирдлагын системд нэгтгэх 3. Цэвэр, бохир усны шугам хоолой засвар, насосуудыг хяналт удирдлагын системд нэгтгэх 4. Удирдлагын самбар 5. Хяналт удирдлагын системийн программчлал 6. Иж бүрэн хяналтын камерын систем 7. Хаалганы нэвтрэлтийн систем тус тус хийгдсэн. Хавсралт : 2 файл	
83	345	Байгалийн ургамал, амьтныг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай 2013-01-08 Дугаар 2013_02/02	5. Бэлчээрийн одоогийн төлөв байдал, цаашдын хандлагад суурилсан бэлчээрийн даацыг байгалийн бүс бүрээр шинэчлэн тогтоож, түүний хүрээнд малын тоо толгой, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангах арга хэмжээ авч бэлчээрийг өнжөөх, сэлгээх боломжийг бүрдүүлэх	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр зөвхөн температур нэмэгдэх бус байгалийн тэнцвэрт байдал алдагдаж байна. Хүчтэй салхи, үер, хэт халалт, ган гачиг зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж, эрч хүч нэмэгдэж, далайн дулаарал, мөсөн голууд, мөсөн бүрхүүл хайлж далайн түвшин дээшлэхийн хэрээр далай тэнгисийн эрэг орчмын газрын элэгдэл нэмэгдэх эрсдэлд хүргэж байна. Бэлчээрийн даацыг өнгөрсөн оны 8 сард тооцсон дүнгээс харахад нийт нутгийн 47 хувь нь бэлчээрийн нөөцтэй, 20 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 21 хувь нь даац 1-3 дахин, 4 хувь нь даац 3-5 дахин, 8 хувь нь даац олон дахин хэтэрсэн байна. Өөрөөр хэлбэл өвөл, хаврын бэлчээрийн даац нутгийн 70 орчим хувьд хүрэлцээтэй, харин 30 гаруй хувьд хэтэрч гарсан. Малчин өрхийн анхдагч холбооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбоотой Газрын тухай хуульд бэлчээрийг малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулахаар заасан. Энэ хүрээнд бэлчээрийг гэрээгээр зохистой ашиглуулах, хамгаалах, төлөв байдалд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар журмын төсөл, гэрээний загварыг боловсруулж, орон нутгийн төр захирааны байгууллагаар хэлэлцүүлээд байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
84	346	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.6. Монгол Улсын зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах үйлчилгээ бүхий ургамлын тархалтыг зогсоох, устгах арга хэмжээг жил бүр зохион байгуулах	Тариалангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д "Тариалангийн газарт хар тамхи, мансууруулах болон хордуулах үйлчилгээтэй таримал тариалахыг хориглоно." гэж заасан тул мансууруулах болон донтуулах үйлчилгээ бүхий ургамлын тариалалт хийлгэдэггүй, харин байгалийн ургамлын асуудал нь Байгалийн ургамлын тухай хуулиараа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяалалд хамаарна.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
	347		1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх.	Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасах саналтай.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
85	348	Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний талаар авах арга хэмжээний тухай 2018-03-16 Дугаар 2018_12/09	3.. Мал, амьтны гоц халдаврт өвчний асуудлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэхгүй байх.	Мал, амьтны гоц халдварт өвчний мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэхдээ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар мэдээлэх зарчмыг баримталж хүргэж байна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга баталгаажуулаагүй мал, амьтны гоц халдварт өвчний мэдээллийг бусад этгээд мэдээлэхийг хориглосны дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : Хуулиар зохицуулсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
86	349	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01	3.1. Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 5 /таван/ жилийн хугацаатайгаар боловсруулан, хүнсний гол нэрийн 13 бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг 100 хувь хангах зорилтыг хэрэгжүүлэх	Үндэсний аюулгүй байдлыг 2022 оны 01 зөвлөмжид заасныг хэрэгжүүлэхээр Улсын Их Хурлын 2022 оны намрын чуулганаар "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэлэлцүүлэн 36 тогтоолыг баталсан. Тус тогтоолоор нь эрх зүй, удирдлага зохион байгуулалт, газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэл бүхий 5 зорилтын хүрээнд 41 үйл ажиллагааны чиглэлд, 114 арга хэмжээний хүрээнд гол нэр төрлийн 19 цаашлаад 54 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангахаар 5 жилийн хөтөлбөрийг баталсан. Хяналтаас хасуулах санал : Тогтоол батлагдсан.	Хэрэгжсэн - 100%

	350		3.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалт, бодлого, үйл ажиллагааны цогц шинэчлэлийг хийхээр шийдвэрлэж, салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор шинээр боловсруулах 4 хуулийн төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах 4 хуулийн төсөл, 12 журам, заавар болон аргачлалыг боловсруулан батлуулахаар тусгасан. Хяналтаас хасуулах санал : Тухайн асуудлаар УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол батлагдсан.	Хэрэгжсэн - 100%
	351		3.3. “Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Улаанбаатар хотын хүн амын төвлөрлийг бууруулах зорилттой уялдуулан хэрэгжүүлэх;	Хүнсний боловсруулах, сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2023-2024 онд нийт 637 аж ахуйн нэгжид 736.5 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Үүнд 300 аж ахуйн нэгжид 335.5 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл, 337 аж ахуйн нэгжид 401.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгосноор салбарт 24 үйлдвэр шинээр байгуулагдсан байна. Үүнээс Хэнтий аймагт 3, Архангай аймагт 3, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Сүхбаатар аймагт тус бүр 1 үйлдвэр ашиглалтад орж, хөдөө орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж, Улаанбаатар хотын хүн амын төвлөрлийг бууруулахад дэмжлэг үзүүлж байна. 2023 онд мал аж ахуйн чиглэлээр 10 аж ахуйн нэгж нийт 14.2 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн, 6 аж ахуйн нэгж нийт 19.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан байна. Харин 2023-2024 онд нийт олгосон зээлийг аж ахуйн төрөлжилтөөр авч үзвэл мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор давхардсан тоогоор 19, өндөг үйлдвэрлэлийн дотоодын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 6, тэжээлийн хангамжийг сайжруулахаар 2, нийт 27 аж ахуйн нэгж 84.35 тэрбум хөнгөлөлттэй зээлд хамрагджээ. Монгол банкны 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн мэдээгээр нийт 939 зээлдэгч, 548.25 тэрбум төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн. Үүнд 228.8 тэрбум төгрөгийг газар тариалангийн чиглэлээр, 74.8 тэрбум төгрөгийг мал аж ахуй, 188.2 тэрбум төгрөгийг хүнсний үйлдвэрийн чиглэлээр тус тус олгосон байна. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 531 иргэн, аж ахуйн нэгж, 140.38 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл, 151 иргэн, аж ахуйн нэгжид 63.37 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл олгосноор техник, технологийн шинэчлэл хийгдэж, хаврын тариалалт, уринш боловсруулалт, ургамал хамгаалах ажлыг технологийн хугацаанд явуулах боломж бүрдсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	352		3.4. Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган га атар газар олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;	2025 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн Ерөнхий газартай хамтран Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэр дэх 1137.80 га, Хонгор сумын нутаг дэвсгэр дэх 2937.07 га болон 895 га, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 524 га, Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэр дэх 497.1 га, Матад сумын нутаг дэвсгэр дэх 15000 га, Булган сумын нутаг дэвсгэр дэх 1500 га, Баянтүмэн сумын нутаг дэвсгэр дэх 3000 га, Халх гол сумын нутаг дэвсгэр дэх 30000 га, Чулуунхороот сумын нутаг дэвсгэр дэх 4000 га, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэр дэх 651.16 га, Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр дэх 957.84 га, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэр дэх 72.8 га, Баян-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 431 га, Биндэр сумын нутаг дэвсгэр дэх 577.4 га, Баянхутаг сумын нутаг дэвсгэр дэх 1049 га, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэр дэх 600 га, 4655.16 га болон 2749.69 га, нийт 71235.02 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 166 дугаар тогтоолыг боловсруулан батлуулсан. Нийт тариалангийн талбайн хэмжээ 71.2 мянган га талбайгаар нэмэгдэж 1033.2 мянган га талбайд хүрэв. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430847389682 Мөн атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх асуудлаар 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 01/2679 тоот албан бичгээр Увс, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Булган, Төв, Сэлэнгэ, Хэнтий, Хөвсгөл аймгийн Засаг дарга нарт орон нутгийн түвшинд атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж ажиллах талаар албан бичиг хүргүүлэн ажилласан. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

	353		3.5.. Үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт үе шаттайгаар тусган санхүүжүүлэх, хувийн хэвшлээс хөдөө аж ахуй, хүнсний салбарт хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөлийг бүрдүүлэх;	УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд 2025 онд олгогдох зээл байхгүй, улсын төсөвт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв болон хүүгийн татаасыг 2025 оны төсөвт тусгаж олгосон. Хүнс, газар тариалан, мал аж ахуйн салбарт нийт 1.26 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 3160 удаагийн олголтоор, 2525 этгээдэд 2023, 2024 онд олгож дууссан бөгөөд хөрөнгө оруулалтын зээл авсан аж ахуйн нэгжүүд өөрсдийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс бүтээн байгуулалтад оруулсны үр дүнд шинээр 53 үйлдвэр ашиглалтад ороод байна.	Хэрэгжсэн - 100%
	354		3.6. Үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр хүнс, хөдөө аж ахуйн салбарт эдийн засаг, нийгэм, үйлдвэрлэлийн бодит үр нөлөө бий болсон. 1. Азийн Хөгжлийн Банк, Ядуурлыг бууруулах Япон сангийн санхүүжилттэй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд 46.25 сая ам.долларын санхүүжилт татан төвлөрүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон услалтын системийг бий болгосноор 2025 онд 785.3 га талбайд тариалалт хийгдэж, 1,094 тн төмс, 240.9 тн хүнсний ногоо, 1,280 тн ногоон тэжээл хураан авсан нь дотоодын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд шууд нөлөө үзүүлсэн байна Төслийн үр шимийг 7 аймгийн 10 сумын 3,548 өрх хүртэж, тариалан эрхлэгчдийн үйлдвэрлэл, орлого нэмэгдсэнээс гадна услалтын системийн барилга угсралтын явцад орон нутгийн 68 иргэн ажлын байраар хангагдаж, орон нутгийн эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн. Мөн мэргэжил, арга зүйн сургалтад 243 хүн хамрагдаж, услалтын болон газар тариалангийн тоног төхөөрөмжийн операторууд бэлтгэгдсэн нь салбарын хүний нөөцийн чадавхыг сайжруулсан бодит үр дүн юм. 2. “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх (МАА-н ЭЗЭН)” төслийг Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж, тайлант хугацаанд 30.0 сая ам.долларын санхүүжилтээс 25.5 сая ам.долларыг ашиглаж, гүйцэтгэл 85 хувьтай байна. Төслийн хэрэгжилтийн үр дүнд: • Малын гоц халдварт өвчний тохиолдол 10 хувиар буурч, • Мах, сүүний гарц 10 хувиар нэмэгдэж, • Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнэ 20 хувиар өссөн бодит үр дүн гарсан нь мал аж ахуйн салбарын эдийн засгийн эргэлт, экспортын чадавхыг нэмэгдүүлэхэд бодит нөлөө үзүүлсэн Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%
	355		3.7. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын байгууллагуудын ажлын уялдаа холбоо, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг бүрэн хянах хяналтын нэгдсэн оновчтой тогтолцоог бий болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, Засгийн газрын 2022 оны "Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 469 дүгээр тогтоолоор хүнсний аюулгүй байдлын хяналт ХХААХҮЯ-нд шилжиж ирсэн. Тус яаманд Салбарын хяналтын газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хяналтын алба, хэлтэс, Мал эмнэлгийн газарт мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, сумдад Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасагт хяналтын улсын байцаагч гэсэн бүтэцтэйгээр нийт 665 хяналтын улсын байцаагч (ахлах) томилогдон (сул орон тоо 236) ажиллаж байна. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр зохион байгуулсан 2 удаагийн хэлэлцүүлэг болон УИХ-ын гишүүн Д.Энхтүвшингээр ахлуулсан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсгийн уулзалтад хүнсний аюулгүй байдлын хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын танилцуулга, бүтэц тогтолцоог сайжруулах чиглэлээр саналыг хэлэлцүүлэн оролцон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Мөн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт ХХААХҮЯ-ны салбарын хяналтын чиглэл, хяналт шалгалтын болон аймаг, нийслэлийн улсын байцаагчдын хүний нөөцийн мэдээлэл, тулгамдаж буй асуудлын талаарх саналыг хүргүүлэв. Хавсралт : 1 файл	Ахиц гарсан - 50%
	356		3.8.Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Сэлэнгэ аймгийн 14, Дорнод аймгийн 15, Төв аймгийн 4 сум үхэр сүргийг төрөлжүүлэн хөгжүүлэх шийдвэр гаргасан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймаг, Нийслэлийн 15 сум, 3 дүүргийн нутагт үржүүлж буй мах, сүү, сүү-махны чиглэлийн өндөр ашиг шимт үнээнд биотехнологийн ололтын нэмэгдүүлэх чиглэлээр сүү, махны хосолмол ашиг шимт гүн хөлдөөсөн үрээр 4250 толгой үнээнд, орон нутаг, иргэдийн захиалгаар 46 суманд 6368 толгой бог,	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				бод, нийт 10618 толгой малд зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлэв. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан "Хөнгөн, хүнсний үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт"-ыг Засгийн газрын 2025 оны 271 дүгээр тогтоолоор батална. Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл технологийн паркуудыг төвийн бүсэд Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн Хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк”, Баруун бүсэд Ховд аймагт “Шинэ Ховд аж үйлдвэрийн парк”, Нийслэлд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, говийн бүсэд Говьсүмбэр аймагт “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”, Зүүн бүсэд Дорнод аймагт “Зүүн бүсийн үйлдвэрлэл технологийн парк”-уудыг байгуулахаар төлөвлөсөн. Үйлдвэрлэл технологийн паркуудын байршил, үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрлийг тухайн бүс нутгийн түүхий эдийн нөөц, ажиллах хүчний хангамж, дэд бүтцийн хөгжил, цаашдын төлөвлөлт, бүс нутгийн эдийн засгийн хөгжил, экспорт, импортын боломжуудад тулгуурлан сонгосон.	
	357		3.9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг үе шаттайгаар бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах орчныг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулах;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг үе шаттайгаар бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах орчныг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулах чиглэлээр хууль эрх зүйн орчинд Улсын Их Хурлын М.Мандхай гишүүний боловсруулан өргөн мэдүүлж буй Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг гишүүний боловсруулан өргөн мэдүүлж буй Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөлд тус тус холбогдох саналыг тусган хүргүүлсэн. Хуулийн төсөлд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг БОХХААБХ-оос байгуулсан ба ажлын хэсэгт тухай бүр ажиллаж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	358		3.10. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах	1. Бүх нийтийн хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, соён гэгээрүүлэх, боловсролыг дэмжих агуулга бүхий мэдээлэл боловсруулж, контент бэлтгэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах” гүйцэтгэгчээр Ти Би Дайтус ХХК-г сонгон шалгаруулж, гэрээг байгуулаад байна. 2. “Монголын уламжлалт таван өнгийн идээ ундааг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж буй иргэн, аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчлан таниулах, контент бэлтгэх” ажлыг гүйцэтгүүлэхээр “Шүрэн соёмбот” ХХК-тай, “Иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зохион байгуулж байгаа хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх соён гэгээрүүлэх боловсролыг дэмжих ажилд дэмжлэг үзүүлж, олон нийтэд сурталчлах” ажлыг гүйцэтгүүлэхээр Монголын цахилгаан мэдээ ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. 3. Яамны мэдээллийн цагаар яамны албан хаагчдад зориулан 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Ти Би Дайтус ХХК-тай хамтран “ӨНДӨР БҮТЭЭМЖ - ХООЛ ШИМ ТЭЖЭЭЛ” сургалт хийв. Сургалтыг Эмчилгээний хоолзүйч, Парис-2024 зуны олимп, параолимпд оролцох Монгол Улсын шигшээ багийн Спортын Хоол зүйн дэмжих багийн ахлагч С.Мөнхтуул удирдан явуулла.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл					
87	359	Биоаюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2011-07-07 Дугаар 25/13	1. Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг бүрэн бүртгэлжүүлж мэдээллийн сан бүрдүүлэх, хүнс, эмийн үйлдвэрт хэрэглэх нэмэлт бүтээгдэхүүн, түүхий эдийн бүртгэлийг нэн даруй хийх	Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар батлуулсан. Уг журам 2022 оноос хэрэгжиж эхэлсэн. Хавсралт : 1 файл	Зохион байгуулалтаас - 0%
ЗГ-ын тогтоол					
88	360	Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай 2018-05-16 Дугаар 2018_131	4.. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавьж, биелэлтийн явц, үр дүнг 2019 оноос эхлэн 2 жил тутам жил бүрийн 2 дугаар сард хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнаж байхыг холбогдох аймгийн Засаг дарга нарт, улсын хэмжээний тайланг нэгтгэн Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригт тус тус даалгасугай.	2025 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн Ерөнхий газартай хамтран Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэр дэх 1137.80 га, Хонгор сумын нутаг дэвсгэр дэх 2937.07 га болон 895 га, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 524 га, Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэр дэх 497.1 га, Матад сумын нутаг дэвсгэр дэх 15000 га, Булган сумын нутаг дэвсгэр дэх 1500 га, Баянтүмэн сумын нутаг дэвсгэр дэх 3000 га, Халх гол сумын нутаг дэвсгэр дэх 30000 га, Чулуунхороот сумын нутаг дэвсгэр дэх 4000 га, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэр дэх 651.16 га, Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр дэх 957.84 га, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэр дэх 72.8 га, Баян-Овоо сумын нутаг	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				дэвсгэр дэх 431 га, Биндэр сумын нутаг дэвсгэр дэх 577.4 га, Баянхутаг сумын нутаг дэвсгэр дэх 1049 га, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэр дэх 600 га, 4655.16 га болон 2749.69 га, нийт 71235.02 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 166 дугаар тогтоолыг боловсруулан батлуулсан. Нийт тариалангийн талбайн хэмжээ 71.2 мянган га талбайгаар нэмэгдэж 1033.2 мянган га талбайд хүрэв. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430847389682	
89	361	Төлөвлөгөө батлах тухай 2021-03-03 Дугаар 2021_53	2. Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт тус тус үүрэг болгосугай.	МУЗГ, АНУ-ын хооронд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Мянганы сорилтын Компакт гэрээний урьдчилсан болзолт нөхцөлийг хангах хүрээнд 1) МУЗГ-ын 2021 оны 53-р тогтоолоор батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөний хэрэгжилт”-ийг хангаж, тайланг тухай бүр гаргаж албан бичиг болон цахимаар БХБОСЯ болон МСС руу илгээж ажиллав. УЦБ зайлшгүй суурилуулах шаардлагатай хөнгөн үйлдвэрлэлийн салбарын 30 ААНБ УЦБ суурилуулж, тулгамдсан асуудал болон туршлагаа бусад салбарын үйлдвэр, ААНБ-уудад хуваалцан ажиллаж байна. 2) Жайка ОУБ-ын “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд ХХААХҮЯ нь “Үйлдвэрийн хаягдал усны менежменттэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, тогтолцооны талаар ойлголт, мэдлэг мэдээллийг үйлдвэр аж ахуйн нэгж, олон нийтэд сурталчлах, танилцуулах, туршлага солилцох IV ажлын хэсгийг ахлан ажилласан. Энэ хугацаанд хөнгөн, хүнсний үйлдвэрийн ААН-үүдийг воркшоп, хэлэлцүүлэгт өргөнөөр хамруулж, туршлага солилцуулахаар мэргэжлийн холбоодтой хамтран мэдээлэл хүргэж, зохион байгуулалтыг хийж ажиллалаа. Төслийн тайлангийн хуралд төсөл хэрэгжүүлэх хугацаанд хийсэн ажлын тайлангаа танилцуулж, панелистаар оролцов. Мөн хөнгөн үйлдвэрийн Говь ХК, хүнсний үйлдвэрийн Жүр Үр ХХК-иуд “Урьдчилсан цэвэрлэх байгууламж байгуулсан туршлага”-аа хуваалцлаа (Зураг 1-3). ЖАИКА-гийн “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн АХ1-ийг ахалж буй БОУАӨЯ-наас "MNS6561:2024 стандартыг хэрэгжүүлэхэд тулгамдаж болзошгүй асуудлуудыг цэгцлэн, хэрхэн шийдвэрлэхийг санал болгосон үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцэх хуралд (2025.12.22) оролцов. 3) “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хамтарсан зохицуулах зөвлөлийн тавдугаар хуралд (2025.09.12) БХБОСЯ дээр болж төслийн төлөвлөлтийн матрицад санал тусгав (Зураг 4).	Ахиц гарсан - 50%
90	362	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2021-08-04 Дугаар 2021_227	3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй холбогдох гэрээг хуульд заасны дагуу байгуулж, хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд үүрэг болгосугай.	Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор “Шинэ Ховд” үйлдвэрлэл технологийн паркт үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу 2025 онд тус үйлдвэрлэл технологийн парк тусгай зөвшөөрлийг шинэчлэн авахаар холбогдох баримт бичгийн бүрдлийг хангуулан ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн Аж үйлдвэржилтийн сэргэлтийн бүлгийн 3.4.2-т заасан Баруун бүсэд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шинэ ховд үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахаар тусгаад байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоолоор батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний 3.2-т Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэхээр баталсан. Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн төслийн хөрөнгө оруулалт 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2026 онд бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусахаар төлөвлөсөн. Нийт ажлын гүйцэтгэл 90.8 хувьтай явж байна. 2025 онд тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тул Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тусгай зөвшөөрөл, лиценз олгох цахим бүртгэлийн системд 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр ирүүлсэн 20250903/004 дугаартай хүсэлтийн дагуу Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд заасныг баримтлан баримт бичгийн бүрдлийг нягтлан үзээд баримтын бүрдэл дутуу тул нөхөн бүрдүүлэлтэд буцаасан.	Ахиц гарсан - 50%

				Хавсралт : 1 файл	
91	363	Төслийн жагсаалт шинэчлэн батлах тухай 2021-10-06 Дугаар 2021_310	2. Энэ тогтоолын хавсралтад заасан төслийг хэрэгжүүлэх талаар Бүгд Найрамдах Беларусь Улсын талтай тохиролцож, холбогдох гэрээг байгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, төслийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай.	Бүгд Найрамдах Беларусь Улстай хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд 2024 онд “Гомсельмаш” үйлдвэртэй шууд худалдан авалтын гэрээ байгуулж, 2 ширхэг өөрөө явагч ангилан хадагч худалдан авсан. Худалдан авсан техник, тоног төхөөрөмжийг салбарын үйлдвэрлэлд ашиглалтад оруулж, ургац хураалтын ажлыг механикжуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Мөн техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор 2025 онд Техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, сервисийн гэрээ байгуулж, үйлдвэрлэгч талын инженер, техникийн мэргэжилтнүүдийг урьж ашиглалтын өмнөх заавар, зөвлөгөө, сургалтыг зохион байгуулсан. Түүнчлэн Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж худалдан авах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хэлэлцээ хийж, бичиг баримтын бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна. Хавсралт : 2 файл	Ахиц гарсан - 50%
92	364	“Дархан арьс ширний цогцолбор”-ын хөрөнгө оруулалтын талаар авах арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_5	2. Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтад шаардлагатай Монголын талаас гаргах 50.0 (тавин) тэрбум төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр зохих журмын дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар (Х.Бадамсүрэн), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т зөвшөөрсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	1) “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК-ийн нэрийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 256 дугаартай тогтоолоор “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор“ ТӨХХК гэж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор компанийн дүрэм, үйл ажиллагааны чиглэл Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 96 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан. Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд "Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц"-ийн бүтээн байгуулалтын ажлыг 2024-2027 онд 23.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар, үүнээс 2025 онд 7.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт баталсантай холбогдуулан дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Паркийн дэд бүтцийн ажлын даалгавар бусад холбогдох баримт бичгийг боловсруулан ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025 оны 02/826 албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн, Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны А/128 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан. Холбогдох 2 багц бүхий тендерийг 2025.04.09-ний өдөр зарлан, 2025.04.30-ны өдөр нээсэн. Нийт 3 ААНБ саналаа ирүүлсэн, үнэлгээний хороо 2025.05.01-ний өдөр хуралдан, тендерийг үнэлэн гүйцэтгэгчийг шалгаруулсан. Багц-1 “Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл технологийн цогцолбор төслийн авто замын ажил”-ын тендер шалгаруулалтад оролцогч “Си Эйч Би Жи констракшн” ХХК, Багц-3 “Гадна холбоо дохиололын тендер шалгаруулалтад оролцогч “Алтай байгууламж” ХХК шалгарсан бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А-1/2399 тоот зөвлөмжийн дагуу ажиллаж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
93	365	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;	Монгол хэлний тухай хуульд төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага 2025 оны нэгдүгээр сарын 1-нээс албан хэргээ кирилл, үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гэж заасан тул ХХААХҮЯамны албан хаагчдад Монгол бичгийн хичээлийг бие даан судлахад зориулж, цахим системд: 1. Монгол бичгийн үндсэн хичээлүүд нийт 13 хичээл, 2. Дадлага ажлын 6 хичээлийг байршууллаа. Энэхүү хичээлийг Монгол хэл, бичиг, зохиолын багш, магистр О.Төгөлдөр багшаар бэлтгүүлэн онлайн хичээлийн холбогдох линкүүдийг хүргүүлсэн бөгөөд монгол бичгийн хичээлийг судлан, албан бичгийн хэрэглээнд ашиглахыг зөвлөмж болгосон. - Яамны цахим хуудасны мэдээ, мэдээллийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх, цахим хуудас шинэчлэх ажлыг төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна. - Албан бичиг, яамнаас гарч байгаа шийдвэрийг хос бичгээр хөтлөх ажлыг туршихаар бэлтгэл ажлыг хангаж байна. - Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөнд Монгол бичгийн цахим хичээлд албан хаагчдыг хамруулах үйл ажиллагааг тусган үе шаттай хэрэгжүүлж байна. Удирдлагын академиас төрийн албан хаагчдад зориулсан цахим хичээлийн Монгол бичгийн 1 дүгээр шатны сургалтад албан хаагчид хамруулж, төрийн албан хаагчдад зориулсан “Монгол бичгийн гарын авлага” номыг дотоод сүлжээгээр яам болон харьяа байгууллагын албан хаагчдад түгээлээ. - Албан хаагчдын ажлын	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

			5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	үнэмлэх дээр яамны нэрийг монгол бичгээр үйлдэж, хэвлэж хэвшсэн. Яамны гадна хаягийг монгол бичгээр үйлдэж байршуулсан. Өрөө тасалгааны хаягийг шинэчилж монгол бичгээр үйлдэж байршуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Хавсралт : 5 зураг	
94	366	Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай 2022-05-04 Дугаар 2022_182	2. Хавсралтад заасан хилийн зааг, эргэлтийн цэгийн солбицол бүхий Төв аймгийн Баян сумын нутаг дэвсгэр дэх Хамар усны 1500 га, Баянжаргалан сумын нутаг дэвсгэр дэх Харнуурын баруун талын 1000 га атар газрыг тус тус тариалангийн газарт шилжүүлсүгэй. 2. Энэ тогтоолын 1-д заасан газрыг зохих журмын дагуу улсын газрын мэдээллийн санд бүртгэхийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (А.Энхманлай)-т, газрын ашиглалт, хамгаалалтад холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Төв аймгийн Засаг дарга Б.Мөнхбаатар нарт тус тус үүрэг болгосугай.	2025 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн Ерөнхий газартай хамтран Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэр дэх 1137.80 га, Хонгор сумын нутаг дэвсгэр дэх 2937.07 га болон 895 га, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 524 га, Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэр дэх 497.1 га, Матад сумын нутаг дэвсгэр дэх 15000 га, Булган сумын нутаг дэвсгэр дэх 1500 га, Баянтүмэн сумын нутаг дэвсгэр дэх 3000 га, Халх гол сумын нутаг дэвсгэр дэх 30000 га, Чулуунхороот сумын нутаг дэвсгэр дэх 4000 га, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэр дэх 651.16 га, Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр дэх 957.84 га, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэр дэх 72.8 га, Баян-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 431 га, Биндэр сумын нутаг дэвсгэр дэх 577.4 га, Баянхутаг сумын нутаг дэвсгэр дэх 1049 га, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэр дэх 600 га, 4655.16 га болон 2749.69 га, нийт 71235.02 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 166 дугаар тогтоолыг боловсруулан батлуулсан. Нийт тариалангийн талбайн хэмжээ 71.2 мянган га талбайгаар нэмэгдэж 1033.2 мянган га талбайд хүрэв. Засгийн газрын тогтоолыг хавсаргав.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
95	367	Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай 2022-05-31 Дугаар 2022_220	1.10. . “Ди Би Эм Лизинг” ХХК-аар дамжуулан Хөдөө аж ахуйг дэмжих санд олгосон санхүүгийн түрээс (лизинг)-ийн өр төлбөрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн буудайн борлуулалтын орлогоос Монгол Улсын Хөгжлийн банкинд төвлөрүүлэх хугацаарь тохирох замаар 2022, 2023 онд багтаан төлөхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд.	"Ди Би Эм лизинг ХХК" болон нийт 3 аж ахуйн нэгжтэй "Худалдах, худалдан авах гурван талт гэрээ"-г байгуулан 5605 /таван мянга зургаан зуу тав/ тонн хүнсний улаан буудайг нийлүүлж, 6,209,625,000.00 /зургаан тэрбум хоёр зуун есөн сая зургаан зуун хорин таван мянга/ төгрөгийн өр төлбөрийг барагдуулав.	Хэрэгжсэн - 100%
96	368	Техникийн зохицуулалт батлах тухай 2022-06-08 Дугаар 2022_224	2. Техникийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Мал эмнэлгийн ерөнхий газар (Д.Батчулуун)-т тус тус үүрэг болгосугай.	1.Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 224 дүгээр тогтоолоор батлагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”, тэдгээрийг дагалдан гарсан журам, заавар, стандартыг мөрдүүлэн, хэрэгжилтийг хангуулахаар “Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт хяналт хэрэгжүүлэх, шаардагдах санхүүжилтийг А/167 дугаар тушаалаар мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийг томилон шаардагдах 15.8 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 08-03-03/720-10 дугаар удирдамжийн дагуу мал бэлтгэх, төхөөрөх, мах үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдаалах, экспортлох үйл ажиллагаанд оролцогч талуудын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээр, протоколоор хүлээсэн үүрэг, шаардлагыг хангуулан ажилласан. Тус онд хүнсний зориулалтаар бэлтгэгдсэн 2,005,314 толгой мал 84464 мал эмнэлгийн гэрчилгээгээр баталгаажиж үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн. Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаалалт, хадгалалтад холбогдох хяналт шалгалтын хүрээнд нийт 8 удирдамжийн дагуу хяналтыг хэрэгжүүлж, нийт 3065 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулан 2524 зөрчлийг илрүүлж, 60.3 хувийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн 719 заалт бүхий 126 хугацаатай албан шаардлага хүргүүлж, мах махан бүтээгдэхүүнээс 1160 сорьц авч мал эмнэлгийн итгэмжлэгдсэн лабороторид хүргүүлэн, шинжилгээнд тус тус хамруулахад “Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 6308:2012 стандарт” болон импортлогч орны холбогдох стандартыг 98.6 хувьтай хангасан байна. Хяналт шалгалтын явцад зөрчил гаргасан 10 аж ахуйн нэгж, 22 иргэнд нийт 26 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ	Хэрэгжсэн - 100%

				ноогдуулж, барагдуулан зөрчил дутагдлыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны 3 албан даалгавар хүргүүлж, 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч ажилласан байна. Хавсралт : 5 файл	
97	369	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа эрхлэх чиглэл, ажиллах хүчний боломж, чадамж, гишүүнчлэл, хаяг байршил, тулгарч буй бэрхшээл, давуу талууд зэрэг мэдээллийг хамарсан дэлгэрэнгүй судалгааг 2025 оны 10 дугаар сард шинэчлэн нэгтгэсэн. Мөн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжит ажлын холбогдох мэдээллийг хэрэгжилтийн газруудаас авч нэгтгэсэн бөгөөд 2026 онд ТББ-уудаар гүйцэтгүүлэх 754,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 арга хэмжээ байна. ХХААХҮЯамнаас хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт яг ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар 21 аймгийн ХХААГ-уудаас мэдээлэл татан авч ажилласан. Орон нутагт 7 аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-аас тайлангаа ирүүлсэн. ХХААХҮЯ-тай гэрээ, санамж бичиг байгуулсан ТББ байхгүй байгаа тул цаашид ТББ-ын удирдлагуудтай уулзалт хийж, цаашид хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын “Хувийн хувшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монголын ноос ноолуурын холбооны дэргэдэх Баталгаажуулалтын албыг бэхжүүлэх, итгэмжлэлийн хүрээг тэлж оёдол, арьс ширний салбарыг баталгаажуулалтад хамруулах чиглэл баримтлан ажиллаж байна. Мөн баталгаажуулалт хийх шинжээчдийг бэлтгэх, мэргэшүүлэх, "Монголын хаан ширхэгт", "Текстилийн тогтвортой үйлдвэрлэл", "Газар зүйн заалттай бүтээгдэхүүн" зэргийг баталгаажуулан дотоодод болон олон улсад сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхээр "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Хавсралт : 2 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	370		3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	ХХААХҮ-ийн салбарын зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, холбоодоор 2022-2025 онд гүйцэтгүүлсэн арга хэмжээний мэдээллийг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлэхээр боловсруулалт хийгдэж байна. "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын 2026 оны төлөвлөгөөг батлуулахаар харьяа байгууллага, нэгжүүдээс санал авч боловсруулав. 2026 оны 01 дүгээр сард багтаан батлуулж, холбогдох газар, байгууллагад хүргүүлэн үүрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	Ахиц гарсан - 50%
98	371	Техникийн зохицуулалт батлах тухай 2022-10-19 Дугаар 2022_380	2. Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг хавсралт ёсоор баталсугай. Техникийн зохицуулалтыг мөрдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттайгаар авч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Стандарт, хэмжил зүйн газар (Б.Билгүүн)-т тус тус үүрэг болгосугай.	Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоолоор уг техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж эхлэх хугацааг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулсан байсныг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр баталсан. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%
99	372	Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	1. Малын эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, экспортын тогтвортой байдлыг хангах зорилгоор хилийн боомтуудыг түшиглэн баруун бүсийн Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, хангайн бүсийн Хөвсгөл аймгийн Ханх, Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Түнэл, Эрдэнэбулган, Булган аймгийн Тэшиг сумдын нутаг дэвсгэрийн тодорхой	Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд: 1. Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дахь улсын тусгай тусгай хэрэгцээний газарт хамгаалалттай аж ахуй байгуулах төсөл сонгон шалгаруулалтыг 2 удаа зарлаж гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт хийгдсэн. Төслийн саналыг үнэлэхэд явцад уг улсын тусгай хэрэгцээний газрын хэмжээ, хил заагт зайлшгүй өөрчлөлт оруулах шаардлага гарсан тул төсөл сонгон шалгаруулалт тус бүр цуцлагдсан.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлаг

		2022-11-23 Дугаар 2022_424	байршилд, мөн зүүн бүсийн Хэнтий аймгийн Дадал сумын нутаг дэвсгэрийн 50.0 мянган хүртэл га талбайд, Дорнод аймгийн Халхгол сумын Хөдөө аж ахуйн Халхгол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн тусгай хэрэгцээний 120.0 мянган хүртэл га талбайд “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс” байгуулах асуудлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газар (Д.Батчулуун)-т тус тус даалгасугай.	Нутгийн иргэдийн болон тухайн тусгай хэрэгцээний газарт аж ахуй нэгжид олгосон газрын маргааныг шийдвэрлэсэн тохиолдолд уг бүсийн асуудал яригдахаар хүлээгдэж байна. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, Засгийн газрын 424 дүгээр тогтоол “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай”, Монгол Улсын Их хурлын байнгын хорооны 2-р тогтоол, ХХААХҮСайдын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/362 дугаар “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс” тушаалын дагуу Малын эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, экспортын тогтвортой байдлыг хангах зорилгоор талбайд "Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс" шинээр байгуулах ажлын төлөвлөлт, техникийн шаардлагыг бэлтгэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, хамтран ажиллахаар МЭЕГ-ын даргын А/501 дугаар тушаал “Хамгаалалттай аж ахуйд мөрдөх биохамгаалллын нийтлэг заавар боловсруулж батласан.2025 оны 11 дүгээр сарын 24-д Мал эмнэлгийн ерөнхий газар, Дэлхийн банк группын гишүүн ОУСК хамтран Малын гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчнөөс ангид хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн талаарх ойлголт, хөтөлбөрт оролцох боломжтой мал аж ахуйн салбарын төлөөлөгчдийг мэдээллээр хангаж, идэвхтэй оролцоог дэмжих зорилготой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.	атай - 50%
	373		2. “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс”-ийг олон улсын шаардлагад нийцүүлэх зорилгоор мал эмнэлгийн хяналтын цэг, лаборатори байгуулах, эм урвалж, тоног төхөөрөмж, бэлчээрийн уст цэг, хамгаалалтын байгууламж барихад шаардагдах зардлыг төсөл, хөтөлбөрт хамруулан санхүүжүүлэх боломжийг судалж, зохих арга хэмжээг авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай.	Бэлчээрт уст цэг: Засгийн газрын тогтоолоор батлагдсан байршилуудаас эхний ээлжинд хамгаалалттай аж ахуй байгуулах Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дахь улсын тусгай хэрэгцээний газарт улсын төсвийн 119.0 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3, Монгол орны хөдөөгийн иргэдий уур амьсгалын өөрчлөлтөд засан зохицох чадамж, болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь төслийн 231.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 нийт 7 инженерийн хийцтэй худаг барьж байгуулах гэрээг ХХААХҮ-ийн 2024 оны А/532 дугаар тушаал болон ХХААХҮЯамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/412 дугаар тушаалаар өөрчлөлт оруулан байршлыг сольсон. Ингэснээр Халхгол сумын улсын тусгай хэрэгцээний газарт 2024 онд худаг гаргахгүй болсон. Газрын маргаантай холбогдуулан зарим арга хэмжээг түр хойшлуулсан хэвээр байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	374		3. “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс” байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагаас гарсан зөвлөмж, зааврын дагуу олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн үр дүнтэй, шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, хууль тогтоомжийн хүрээнд шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Бэлчээрт уст цэг: Засгийн газрын тогтоолоор батлагдсан байршлуудаас эхний ээлжинд хамгаалалттай аж ахуй байгуулах Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дахь улсын тусгай хэрэгцээний газарт улсын төсвийн 119.0 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3, Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж, болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь төслийн 231.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 нийт 7 инженерийн хийцтэй худаг барьж байгуулах гэрээг тус тус байгуулсан. Тухайн улсын тусгай хэрэгцээний газрын бүтнээр нь чөлөөлөх тухай хүсэлтийг тус аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор Засгийн газарт уламжилсан, нутгийн иргэд эсэргүүцэж байгаа зэрэг шалтгааны улмаас өрөмдлөгийн ажил эхлээгүй хүлээгдэж байна. Үр нөлөө : Нийтийн зориулалтаар ашиглах уст цэг байгуулсанаар хувийн хэвшилд газар хуваарилан олгож үйл ажиллагаа эхлүүлэх боломжийг олгосон	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
100	375	Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2023-05-17 Дугаар 2023_178	1.5. Бүтээгдэхүүн, үйлчилгээ баталгаажуулалтын байгууллагын тоог нэмэгдүүлэх, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (О.Амартүвшин)-д	2025 онд БНХАУ, ОХУ, Кувейт, Солонгос, Казакстан, Вьетнам, Япон, Хонконг, Катар, Ирак, Тажикстан, Иран, Арабын Нэгдсэн Эмират улс, Азарбайжан, Турк, Узбекистан, Туркеминстан, БНАСАУ, Бахрайн зэрэг 19 улсад 28720.9 тн адууны мах, 30 тн үхрийн мах, 18878,97 тн хонины түүхий мах, 2484,52 тн ямааны түүхий мах, дулааны аргаар боловсруулсан 35 тн хонины мах, 3778,1 тн үхрийн мах, 15099 тн, ямааны мах 2001.5 тн дайвар бүтээгдэхүүн, 31 тн нөөшөлсөн бүтээгдэхүүн, 31 тн махтай шөл, 430 тн ясны шөл, нийт 71519,9 тн мах махан бүтээгдэхүүн, 395 шонхор, 150589 гогцоо бог малын өлөн гэдэс, 60 тн бугын эвэр, 188 толгой ангийн олзвор, 11344 тн малын гаралтай өөхөн тос, 2815 тн ясны тос, 200 тн ясны үнс, 250 тн пептон, 480 кг айраг, 83 тн ямааны хуурай сүү, 7847,545.8 тн ноос, ноолуур, дэл, сүүл, хонины ноос, тэмээний ноос, адууны сүүл, адууны дэл, 188935 ширхэг хонь, ямааны арьс, үхэр, адууны шир, 74190 толгой хонь, ямаа, 5,1 тн нохой, муурны хоол, 6785,9 тн байгалийн хадлан өвс, Узбекистан улсад 86549 толгой хонь, БНХАУ-д 17700 толгой хонь, 98 толгой үржлийн адуу, Монгол Улсын бэлэглэсэн 4 адуу, 219 толгой	Хэрэгжсэн - 100%

				гэрийн тэжээвэр нохой, муур, экспортод гаргахад 7350 экспортын гэрчилгээг цахимаар олгосон. мөн лабораторийн шинжилгээний хариуг мөн цахимаар олгож байна.	
	376		4.5. Нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шаардагдах импортын түүхий эд, туслах материалд ногдох гаалийн татварыг гадаад худалдаа эрхлэгч, үйлдвэрлэгчийн экспортын гүйцэтгэлд үндэслэн буцаан олгох боломжийг судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт.	2024 онд “Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай” хууль 38.1.24.оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал гэж тусгасны дагуу "Гаалийн татвараас чөлөөлөх оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материалын жагсаалт"-ыг 2024 оны 240 дүгээр тогтоолоор батлуулсан. Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн чуулганаар “Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай” хуулийг дагалдан “Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай” хууль батлагдаж, "Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр "Жагсаалт батлах тухай" 2023 оны Засгийн газрын 107 дугаар тогтоол батлуулсан. Жагсаалтын дагуу гаалийн албан татварын хөнгөлөлтөд экспортын голлох салбар болох нэхмэл, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүд, хүнсний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, хаяг шошго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд, мод боловсруулах салбарын эцсийн бүтээгдэхүүн тавилга, модон эдлэл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд зэрэг нийт 19 үйлдвэрийн чиглэлийн 428 төрлийн тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас хөнгөлөх бодлогын шийдвэр гаргасан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	377		6. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг улирал тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг тухай бүр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажилласан. Мөн Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Евразийн эдийн засгийн түр хэлэлцээрийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж тухай бүр саналыг хүргүүлэн, хэлэлцээрийн үе шат бүрд оролцож, салбарын байр суурийг тухай бүр хүргүүлэн ажиллаж, УИХ-аар соёрхон батлуулсан. Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулахаар хэлэлцэж буй Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээрийн гарал үүслийн бүлэгт Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний өртгийн агууламжийн шаардлагыг хангах боломжтой талаар холбогдох мэргэжлийн холбоод, үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдээс санал авч нэгтгэн, хэлэлцээрийн бүтээгдэхүүний гарал үүслийн дүрмийн шалгуурт оруулах санал боловсруулан хүргүүлж, хэлэлцээрийн шатанд ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%
101	378	“Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-24 Дугаар 2023_193	1. “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан батлуулж, суурь, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.	Өөрийн үнэлгээ : Хэрэгжсэн 1) Бизнес инкубатор, үйлдвэр сургалтын төв, паркийн гадна хашаа, түр цахилгаан хангамжийн дэд станц байгуулагдсан. 2) Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станцын ТЭЗҮ-г "Эрчим хүчний эх үүсвэр, хүрээлэн байгаа орчны судалгааны төв" ТББ гүйцэтгэн 2024.11.19-ны өдөр хүлээлгэн өгөв. Тус ТЭЗҮ-г Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2024.11.05-ны өдрийнээлжит VI хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан юм. 3) Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн "Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ /539 га/"-г Дорнын байгаль ХХК боловсруулж Байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн яамны Мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар дэмжигдэн батлагдсан /2024.11.28/. https://www.facebook.com/reel/465080599530283 2) Улаанбаатар хотыг хөгжүүлэх 24 мега төслийн хүрээнд Эмээлт эко аж үйлдвэрийн парк төслийн бүтээн байгуулалтыг хотын төвөөс 30 км зайд байрлах Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны Шар хөвийн хоолойд 539 га талбайд барих юм. Төслийн хүрээнд 24 МВт дулааны цахилгаан станц, хоногт 6700 метр.куб хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 12.5 км авто зам, үерийн хамгаалалтын байгууламж, хоёр усан сан, инженерийн шугам сүлжээг барьж байгуулна. Өнөөдрийн байдлаар Эмээлт эко аж үйлдвэрийн парк" ХК-нь "Дулааны цахилгаан станц, Цэвэрлэх байгууламж"-ийн EPC+F тендерт шалгарсан түншлэлтэй 08 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулсан юм. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн Бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн дөрвөн давхар барилгыг ашиглалтад оруулсан. Улаанбаатар хотоос арьс ширний үйлдвэрүүдийг Эмээлт паркт нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлын	Ахиц гарсан - 50%

				хүрээнд аж ахуйн нэгжүүдтэй газар ашиглах эрхийн гэрээ байгуулж байна. https://ulaanbaatar.mn/news/20755?fbclid=IwY2xjawJh1aRleHRuA2FlbQIxMAABHniFuKrToRk1jRKBW-_4A8atOIS77PjoFdDiDnH5RJ8uzk6dBBCkv66BOde7_aem_iDJcEsX5L5koISs4X0d-Dw	
	379		2. “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн суурь, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг Улаанбаатар хотын өрсөлдөх чадвар, нөхөн сэргээлтийг дэмжих төслийн хүрээнд хөгжлийн санхүүжилт болон төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээг авахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.	1) Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн суурь дэд бүтэц 24 МВт-ын Дулааны цахилгаан станц, Бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын "Хуа Зи Технологи" ХХК , “Хуа Ши Энержи Индастри” ХХК-ийн түншлэлтэй, Нийслэлийн Засаг даргын А/1082 захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг " нь Гэрээ байгуулах хэлэлцээрийг хийлээ. 2) Паркийн суурь дэд бүтэц “24 МВт-ын Дулааны цахилгаан станц, Бохир ус цэвэрлэх байгууламж”-ийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын "Хуа Зи Технологи” ХХК , “Хуа Ши Энержи Индастри” ХХК-ийн түншлэгч компаниудтай “ЭМЭЭЛТ ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРКИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ, БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ (EPC) ГЭРЭЭ”-г байгууллаа. Ингэснээр олон жил яригдаж хүлээгдсэн малын гаралтай түүхий эдийг үнэ цэнд оруулах, Улаанбаатар хотын суурьшлын бүсэд байгаа арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх, мал аж ахуйн салбарыг кластер цогц байдлаар хөгжүүлэх боломж бүрдэж эхний алхам нь хийгдэж байна.	Ахиц гарсан - 50%
	380		3. Орон нутгийн эзэмшлийн авто замын засвар, нөхөн сэргээлт, тохижилтын ажил болон эко аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын урсгал зардлыг бага түвшинд байхаар тооцон, хөрсний нөхөн сэргээлт, газар шорооны ажлыг Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэлийг баримталж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.	1) Бизнес инкубатор, үйлдвэр сургалтын төв, паркийн гадна хашаа, түр цахилгаан хангамжийн дэд станц байгуулагдсан. 2) Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станцын ТЭЗҮ-г "Эрчим хүчний эх үүсвэр, хүрээлэн байгаа орчны судалгааны төв" ТББ гүйцэтгэн 2024.11.19-ны өдөр хүлээлгэн өгөв. Тус ТЭЗҮ-г Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2024.11.05-ны өдрийн ээлжит VI хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан юм. 3) Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн "Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ /539 га/"-г Дорнын байгаль ХХК боловсруулж Байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн яамны Мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар дэмжигдэн батлагдсан /2024.11.28/. https://www.facebook.com/reel/465080599530283	Хэрэгжсэн - 100%
	381		4. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Харгиа цэвэрлэх байгууламж орчимд үйл ажиллагаа явуулж байгаа арьс, шир, завод ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн эзэмшил газарт үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй зөвшилцөж, тэдгээрийн санхүүжилт, санаачлагад тулгуурлан зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.	1) ЭЭАҮП ХК-тай байгуулсан “Удирдлагын гэрээ”-ний дагуу арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг хотоос нүүлгэн шүлжүүлэх зорилгоор 2024.07.23-ний өдөр “Паркийн нэгжийн сонгон шалгаруулалт”-ыг нээлттэй зарласан. Уг сонгон шалгаруулалтад шалгарсан Булигаар ХК, Мон-Ирээдүй ХХК, Арилдий ХХК, Түмэн шир ХХК зэрэг ААНБ-уудтай нэгжийн гэрээ байгуулав. 2024.11.19-нд гэрээ байгуулсан ААНБ-тай уулзалтаар газар ашиглалт болон үйлдвэрийн зураг төсөв, барилга угсралтын ажлыг эхлүүлэх асуудлаар харилцан зөвлөлдөв (Зура) 2) “Арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх нь” зөвлөлдөх уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулав. ЭЭАҮП-т арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө болон үйлдвэрүүдэд нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой тулгамдаад байгаа асуудлаар санал, хэлэлцүүлэг хийн нүүлгэн шилжүүлэх нэгдсэн төлөвлөлтөд санал нэгдлээ. 3) ЭЭАҮП-т байршин үйл ажиллагаа эрхлэхээр ТЭЗҮ-ээ ирүүлсэн арьс шир боловсруулах үйлдвэрүүд болох "ҮЖИН ПАРТНЕРС" ХХК, "ИХ АСАР" ХХК-иудтай "Эмээлт эко аж үйлдвэрийн паркт үйл ажиллагаа явуулах нэгжийн гэрээ" болон "Паркт газар ашиглуулах гэрээ"-г 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгууллаа. Тус үйлдвэрүүд нь арьс ширийг хагас болон гүйцэт боловсруулах, гутлын улны шир бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах юм. 4) АШҮҮдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх, талуудын байр суурь, үйл ажиллагааг уялдуулан, хамтын ажиллагааг сайжруулах зорилго бүхий зөвлөлдөх уулзалтыг 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулав. Уулзалтад МАШҮХ болон арьс шир боловсруулах Мон Ирээдүй ХХК, Арилдий ХХК ,Түмэн шир ХХК, Их Асар ХХК-ийн удирдлагууд оролцлоо.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
102	382	Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	4.1. Худалдааг хөнгөвчилж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд тус тус даалгасугай: -Хөдөө аж ахуйн биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх,	"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуульд биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, түүнийг коджуулах журмыг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталдаг бөгөөд өнөөдрийн байдлаар биржийн барааны жагсаалтад ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, амьд мал, арьс, шир, мах, хүнсний буудай, тосны ургамал, малын тэжээл, үрийн буудай тус тус бүртгэгдсэн. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны 90	Хэрэгжсэн - 100%

		2023-06-21 Дугаар 2023_233	үйлчилгээний хөлсний хэмжээг бууруулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;	гаруй хувийг угаасан болон самнасан ноолуурын арилжаа эзэлдэг ба биржээр арилжих бараа түүхий эдийн арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээ угаасан ноолуур-0.8%, самнасан ноолуур-0%, бусад бүх бараа түүхий эдэд 0.32% байдаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2022 онд “Биржийн байнгын бус гишүүн хоршоо, тэдгээрийн бэлтгэсэн бараа түүхий эдийг худалдан авч буй үйлдвэр хоорондын арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг 3 жилийн хугацаанд тэглэх”, “биржээр арилжих самнасан ноолуурын хувь хэмжээг тэглэх” тогтоолуудыг гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 13 дугаар тогтоолоор мал, махны арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг “0” болгож бууруулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 21 дүгээр тогтоолоор хүнсний улаанбуудайн арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 0% болгон тэглэсэн. Мөн Хөдөө аж ахуйн биржээс тавьсан саналын дагуу Хөдөө аж ахуйн биржээр арилжсан угаасан болон самнасан ноолуурын Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс 0.04%-иас доошгүй байсныг Хорооны даргын 2025 оны 463 дугаар тогтоолоор 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүртэл хугацаанд хорооны зохицуулалт үйлчилгээний хөлсийг угаасан ноолуур 0.02%, самнасан ноолуур 0% байхаар тус тус тогтсон тул тус заалтыг хяналтаас хасуулах саналтай байна. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай байна.	
	383		4.2. Худалдааг хөнгөвчилж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд тус тус даалгасугай:Хөдөө аж ахуйн биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, үйлчилгээний хөлсний хэмжээг бууруулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд; -Худалдаа эрхлэгч олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг Гаалийн ерөнхий газарт хүргүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ авдаг давхардсан зохицуулалтыг хүчингүй болгох талаар судалж, зохих арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т;	Гаалийн ерөнхий газраас экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох үйл ажиллагааг МЭЕГ-т хүлээн авч 2025 оны онд иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн экспорт, импортын 8218 хүсэлтийг “Экспортын нэг цонхны систем” (Export.mofa.gov.mn) нэг цонхны үйлчилгээний цахим системээр шийдвэрлэж ажлын 8 цагт багтаан олгож байна. Тус системд ХХААХҮЯ, ГЕГ, МЭЕГ, УХГ, СХЗГ, МҮХАҮТ, Лаборатори, ХААБ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд холбогдсон ба экспортын гэрчилгээ авах үйл ажиллагаанд аж ахуйн нэгж байгууллага өмнө нь 13-15 өдөр зарцуулдаг байсныг хөнгөвчилж, 2 өдөрт багтаан шийдвэрлэдэг болсон. 2025 оны 5 дугаар сараас ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын гэрчилгээний бүрдүүлбэрийг тус системээр дамжуулан олгож эхэлсэн. Бирж нь тус систем ашиглалтын хураамжийн хэмжээг экспортын зөвшөөрөл авах бүрдээ төлбөр төлдөг байсныг жилдээ 1 удаа 100,000 төгрөгийн хураамж болгон бууруулсан. Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 23 дугаар зүйлийн 23.1-23.3, 25 дугаар зүйлийн 25.2 дах хэсгүүдэд тус тус заасны дагуу мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний дамжуулан өнгөрүүлэх мэдэгдэл, импортын мэдэгдэл, олон улсын мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн гэрчилгээг МЭЕГ-аас 2025.02.20-ны өдрөөс, УХГ-аас 2025.03.02-ны өдрөөс тус тус олгох болсон. Тус хуулийн өөрчлөлтөөр худалдаа эрхлэгч МЭЕГ-ын олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг ГЕГ-т хүргүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ авдаг давхардсан зохицуулалт арилсан . Хяналтаас хасуулах санал : Давхардсан зохицуулалтыг шийдвэрлэсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	384		12. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/372 дугаар тушаалаар Худалдааг хөнгөвчлөх замаар Хөдөө аж ахуйн биржээр махыг нэг цонхны бодлогоор экспортлох боломжийг судалж, санал боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ, ГХЯ, МХЕГ, СХЗГ, МЭЕГ, ГЕГ, ХААБ, Махны холбоо ТББ төлөөлөл оролцуулан байгуулсан. Үйл ажиллаллагааны явцын хувьд: I- үе шат Процессийн зураглал гаргах, II, III үе шат. Програм хөгжүүлэлт, нэвтрүүлэлт, сайжруулалт хийж гүйцэтгээд байна. Хөгжүүлэгч компани нь оролцогч байгууллагуудын мэдээлэл технологийн инженерүүд хамтарч 20 гаруй удаагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, бизнес процессын зураглалын анхны хувилбарыг боловсруулсан. II үе шатанд Процессын зураглалын дагуу системийн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. III үе шатанд Системийн нэвтрүүлэлтийг зохион байгуулж, үүссэн асуудлыг процессын зураглалын хүрээнд ярилцан шийдлийг гаргаж, системийн сайжруулалтыг хийж гүйцэтгэж байна. Системийн тухайд авч үзэхэд одоогийн байдлаар холбогдсон байгууллага: МЭЕГ, УМЭАЦТЛ, СХЗГ, МҮХАҮТ, ГЕГ, ХХААХҮЯ. Системд 78 компани өөрийн бүртгэлээ үүсгэсэн. Үүнээс 46 компани экспортын эрхтэй төлөөлөх хүнээ сонгосон байна. Үйлчилгээний хүсэлт ирүүлсэн байгууллагуудаас харахад: Бүрэн	Хэрэгжсэн - 100%

				шийдвэрлэсэн: 46, хүсэлт үүсгэсэн:144 байна. Махыг экспортлоход хамгийн багадаа бичиг баримтад зарцуулах хугацаа 316 цаг буюу 13 хоног байсан зарцуулах хугацааг 96 цаг хүртэл болтол багасгасан үр дүн гарч байна. 8 бичиг баримтын бүрдүүлэлтийн давхардлыг арилгаж 0 болголоо. Улсын Их Хурал "Малын гараltай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих тухай" 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, экспортыг нэмэгдүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ зохион байгуулсан. Хяналтаас хасуулах санал : хэрэгжсэн	
103	385	"Журам батлах тухай" /Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх/ Засгийн газрын тогтоол 2023-07-05 Дугаар 2023_251	1. 2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд үүрэг болгосугай.	Тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл олгох цахим бүртгэлийн систем /license.mofa.gov.mn /-ийг 2021 онд хөгжүүлж, салбарын нийт 22 тусгай болон энгийн зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсан. И-Монголиа платформд нэгтгэн иргэд, аж ахуйн нэгжүүд цахим системээр дамжуулан үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн. Одоогоор нийт 1085 тусгай зөвшөөрлийг цахимаар бүртгэж, олгосон бөгөөд зөвшөөрлийн нэгдсэн сангийн license.mn дээр зөвшөөрөл олгосон эрх зүйн актыг бүртгэн оруулж байна.	Хэрэгжсэн - 100%
104	386	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын үйл ажиллагааг Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу хэрэгжүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тайлагнаж ажилласан.	Хэрэгжсэн - 100%
105	387	Журам батлах тухай 2023-07-26 Дугаар 2023_283	2.. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд үүрэг болгосугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/630 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Уламжлалт технологиор үйлдвэрлэснээс бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааны оролцогчийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг Засгийн газрын 2023 оны 283 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу зохион байгуулсан. Дуудлага худалдааны дүнгээр "Памир оргил" ХХК 2-25 хүртэл согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн ялагч болсон.	Хэрэгжсэн - 100%
106	388	Санаачилга дэмжих тухай 2023-08-23 Дугаар 2023_308	1. Энэ тогтоолын 1-д заасан холбоодыг байгуулах, олон улсад сурталчилах, хандивлагч орнуудтай техник хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх чиглэлээр Ази тивийн сүүний түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газартай хамтран ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт даалгасугай.	Ази тивийн сүүний түншлэлийн санаачилга, Дэлхийн сарлагийн холбоо, Дэлхийн хос бөхт тэмээний холбоо байгуулах санаачилгыг олон улсын түвшинд 2025.09.30-нд “Тогтвортой мал аж ахуйн шилжилт” олон улсын бага хурлын нээлттэй арга хэмжээний үеэр танилцуулсан. Монголд төвтэй олон улсын байгууллагуудын анхдугаар уулзалтад оролцогчдод санаачилгуудыг 2025.10.10-нд зохион байгуулсан уулзалтад олон улсын байгууллагын төлөөллүүдэд танилцуулсан. Дэлхийн сарлагийн холбоо, Дэлхийн хос бөхт тэмээний холбоо байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлж холбоодын дүрмийн төслийг боловсруулсан. Ази тивийн сүүний түншлэлийн гишүүн болон хамтран ажиллах боломжит талуудад дүрмийн төслийг танилцуулах ажлыг эхлүүлсэн. Ази тивийн сүүний түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газартай хамтран “Өдөр бүр нэг аяга сүү” форум-ыг 2025 оны 05 дугаар сарын 30-нд, Ази тивийн сүүний түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газар болон холбогдохТөрийн болон төрийн бус байгууллага, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хамтран үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг сүүний үхрийн фермийн төрхөөр тохижуулах "Милк фестиваль-2025" нэгдсэн арга хэмжээг олон талт хөтөлбөрийн хүрээнд буюу өглөөний дасгал, идэвхжүүлэлтийн арга хэмжээ, урлагийн үзүүлбэр, “сүүн өртөө” аялал, гэр бүлийн “Cosplay” шалгаруулалт, хүүхдийн бөхийн барилдаан, сүү, сүүн бүтээгдэхүүний амталгаат худалдаа гэсэн байдлаар зохион байгуулсан. "Сүүний хоршоо" сэдэвт бүсийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Ази тивийн сүүний түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газрын оффисын өрөөний түрээсийг хариуцан төлж байна. Хяналтаас хасуулах санал : тогтмолжсон тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%

107	389	Төсөл, хөтөлбөрийн жагсаалт батлах тухай 2023-08-23 Дугаар 2023_323	2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Азийн хөгжлийн банктай тохиролцож, холбогдох гэрээ, хэлэлцээрийг байгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, төсөл, хөтөлбөрийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай.	Тогтоолын хавсралтад салбарын “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил II” төслийн хэрэгжүүлэх хүрээнд тайлангийн хугацаанд Монгол Улсын хөдөө аж ахуйн хувийн хэвшлийг дэмжих шинэлэг хандлагыг нэвтрүүлж, хүнс, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдэд санхүүжилт олгож, маркетингийн чадавхыг нэмэгдүүлэх сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Төсөл хэрэгжиж эхлэж байгаа ба Төслийн зохицуулагч болон Бизнесийн зөвлөх гэсэн 2 орон тоотой эхлэж байна. Азийн Хөгжлийн Банк санхүүжилттэй зээл -Нийт 68.11 сая ам доллар. Зээлийн санхүүжилт: • АХБ: 57.1 сая доллар • Японы тусгай сан: 2.0 сая ам.доллар • Төсөлд оролцогч байгууллагууд: 6.64 сая ам.доллар Төслийн үйл ажиллагаа эхэлж байгаа тул хэрэгжилтийг тайлагнах боломжгүй	Х.Б
108	390	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	1. Дархан-Уул аймгийн Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, Эрүүл мэндийн газрын тархвар судлаач эмчтэй хамтран "Хамтдаа эрүүл аян"-ы хүрээнд яам, харьяа байгууллагын албан хаагчдад Хүний папилома вирус /HPV/-ийн үүсэл, хэв шинжүүдийн онцлогийн тухай болон бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх талаар мэдээлэл сургалт өгсөн. 2. Албан хаагчдад улирлын томуугийн вакцины танилцуулга бэлтгэн хүргүүлж, албан хаагчдыг хамруулсан. 3. Яам, харьяа байгууллагын албан хаагчдад Томуу, томуу төст өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан, урьдчилан сэргийлэх санамж хүргүүлсэн. 4. ЭМЯ-наас зохион байгуулсан “Сэтгэл бол эрхтэн” нэг сарын аянд нэгдэж хамтран ажилласан. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн https://www.ncmh.gov.mn цахим хаягаас мэдээлэл, сурталчилгааны материалтай танилцан, уг мэдээллийг олон нийтэд түгээж ажилласан байна. Хавсралт нийт : 4, Файл : 2 Зураг : 2	Хэрэгжсэн - 100%
109	391	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-09-06 Дугаар 2023_329	3.. “Хөдөө аж ахуйн сэргэлтийн үндэсний хороо”-ны ажлын албаны чиг үүргийг эрхлэх асуудлын хүрээний дагуу хариуцаж, хорооны ажиллах журмыг хорооны хуралдаанд хэлэлцүүлж батлуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд даалгасугай.	Хөдөө аж ахуйн сэргэлтийн үндэсний хорооны ажиллах журмын болон анхдугаар хуралдааны хөтөлбөрийн төсөл, дэд хороодын гишүүдийн нэрсийн жагсаалт боловсруулж хорооны гишүүдэд хүргүүлсэн. Хорооны гишүүдээс ирүүлсэн саналыг тусган журмын төслийг эцэслэн боловсруулсан бөгөөд хорооны хуралд хэлэлцүүлэхэд бэлтгэсэн. Ерөнхий сайдаас өгөх чиглэлийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулахаар хүлээгдэж байна. Мөн түүнчлэн НҮБ-ын ХХААБ-аас санаачилсан Нэг улс-Нэг бүтээгдэхүүн санаачлагыг дэмжих үүднээс Ингэний хоормогийг Монгол Улсын газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр бүртгүүлэх ажлыг Үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөсөн болно. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлсэн болно.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
110	392	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_337	2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Татварын ерөнхий газар (Б.Заяабал)-т тус тус даалгасугай.	1) Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуульд Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 100 хувь хөнгөлөхөөр тусгагдсан. Хуульд заасны дагуу 426 нэр төрлийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу боловсруулж, 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, 107 дугаар тогтоолоор батлагдсан. 2) 2024 онд "Шинэ Ховд" үйлдвэрлэл технологийн паркийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж худалдан авахад 1.9 тэрбум төгрөг төсөвлөгдсөн бөгөөд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч импортоор оруулах ажилд Засгийн газрын 2023 оны 337 тогтоолоор батлагдсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ыг мөрдөн ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%
111	393	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344	4. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд үүрэг болгосугай.	Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа төрийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Тухайн журамд аймаг, нийслэлийн Засаг дарга нь бэлтгэсэн нөөцийн мэдээллийг доор дурдсан хугацаанд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мах, ундны усны нөөцийн мэдээллийг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор; сүүний нөөцийн мэдээллийг тухайн жилийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор; улаанбуудай, тарианы үр, гурилын нөөцийг тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлж байна (тухайлан нотлох баримт хавсаргах шаардлагагүй.) 21 аймаг, нийслэлээс хүнсний	Хэрэгжсэн - 100%

				гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног тутам авч, мэдээллээр удирдлагыг тухай бүр ханган ажиллаж байна. 2025 онд улсын хэмжээгээр намрын ургацаас стратегийн нөөцөд “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 27.3 мянган тонн, гурилын үйлдвэрүүд 126.4 мянган тонн улаанбуудай тус тус худалдан авсан. Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 320.0 мянган тонн цэвэр хүнсний улаанбуудай шаардлагатай бөгөөд 2025-2026 оны гурилын хэрэгцээг хангахад 148.3 мянган тонн хүнсний улаанбуудай дутагдах урьдчилсан тооцоо гарсан. Үндэсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 004 дугаар зөвлөмжөөр хүнсний улаанбуудайн импортлох хэмжээг 150 мянган тонноор тогтоосон бөгөөд үрийн улаанбуудайг 12.0 мянган тонныг 2026 оны 03 дугаар сард багтаан импортлох шийдвэр гарсан.	
112	394	Журам батлах тухай 2023-09-26 Дугаар 2023_361	2. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нарт тус тус даалгасугай.	2025 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар 1. Хүнсний ногооны урамшуулал: Дотоодын ургацаас 123,507.83 тонн хүнсний ногоог зах зээлд борлуулсан нийт 1581 тариалан эрхлэгчид 12,350.8 сая төгрөгийн урамшууллыг олгосон. 2. Улаанбуудайн урамшуулал: Дотоодын ургацаас 2 176,530.11 тонн улаанбуудайг дотоодын гурилын үйлдвэрүүд болон ХААК-д нийт борлуулсан 504 тариалан эрхлэгчид 14,122.4 сая төгрөгийн урамшууллыг олгосон. 3. Сүүний урамшуулал: 15,769,706 литр сүү бэлтгэн үндэсний үйлдвэрүүдэд тушаасан 8711 малчин, мал бүхий этгээдэд 16,769.7 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгосон.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
113	395	Жагсаалт батлах тухай 2023-11-22 Дугаар 2023_409	4.. Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хуулийн дугаар, төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай.	Монгол Улсын төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаат "Төлөвлөгөө батлах тухай" ХХААХҮС-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/729 дүгээр тушаалаар батлуулсан бөгөөд тендер шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулан үр дүнг нийтлэн ажилласан. Хяналтаас хасуулах санал : Хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	396		5. Тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус үүрэг болгосугай.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль, журмын хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.	Ахиц гарсан - 50%
114	397	Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41	3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.(1.“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар тогтсугай.)	Соёлын биет бус өвийн 7 ай сав 362 төрөл зүйл, түүний дотор Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний бүртгэлд орсон соёлын биет бус өвүүдтэй танилцах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэн тэдгээрийн олон төрөл зүйл, угсаатны бүлгийн онцлогийг таниулан сурталчлах, сэргээн хөгжүүлэх зорилго бүхий “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль Налайх дүүрэг, Тайж хайрхан уулын бэлд дөрөв дэх жилдээ амжилттай зохион байгуулсан. НЖДҮҮДТөв, есөн дүүргийнхээ ЖДҮҮДТ-тэй хамтарч, үзэсгэлэн худалдааны зохион байгуулалт, барааны чанар, өнгө үзэмж, бүтээгдэхүүн өрөлтийн стандартыг олон улсын түвшинд хүргэхээр зорилт тавин ажилласан. 21 аймаг, 9 дүүрийн ЖДҮҮэрхлэгч болон мэргэжлийн холбоод хамтран оролцож, 60 асарт 250 иргэн, аж ахуй нэгж бараа бүтээгдэхүүнээ танилцуулан 452 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. 3 өдрийн хугацаанд давхардсан тоогоор 260,000 гаруй үзэгч /иргэд, жуулчид/ хүрэлцэн ирж оролцсон байна. Монголын 21 аймаг, нийслэлээс ирсэн 1,092 өвлөн уламжлагч, 27 улсын 280 гаруй төлөөлөгч, тамирчин, зочид соёлын өвөө дэлхий дахинд таниулав.	Хэрэгжсэн - 100%
115	398	Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга	3.7.. Амьжиргааны эх үүсвэрээ алдаж, малгүй болсон малчдын судалгааг нарийвчлан гаргаж, малжуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нарт	Малчдыг малжуулах арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн хуваарийн дагуу 21 аймаг, нийслэлийн 3 дүүрэгт нийт 2,769 өрхөд 22,152,000,000 төгрөгийг зарцуулж, хонин толгойд шилжүүлснээр 132,614 толгойг худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар сум, хорооны Засаг дарга бусад холбогдох байгууллагуудтай мэдээ, мэдээлэл түгээн хамтран ажиллаж байна. Малжуулах арга хэмжээнд хамрагдахаар 21 аймаг, нийслэлийн 3	Ахиц гарсан - 50%

		хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_62		дүүргээс 2,718 өрх хүсэлт ирүүлснээс өнөөдрийн байдлаар 950 өрхийн хүсэлтийг аймаг, сумын амьжиргааг дэмжих зөвлөл дэмжиж, 301 өрхийн хүсэлтийг Хөдөлмөр эрхлэлтийг байгууллагаас шийдвэрлэн 108 өрхөд батламж олгосон байна.	
116	399	Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийгдаван туулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-28 Дугаар 2024_76	2 . Тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн буудай болон малын тэжээлийн үнэ, татан авах зардлын тооцоо, аймгуудад олгох хуваарийг гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Улсын хэмжээнд өвөлжилт, хаваржилт хүндэрсэн холбогдуулан “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн худалдан авч нөөцөлсөн буудайг төмөр болон цагаан зудын нөхцөл байдалтай байгаа 14 аймгийн 111 суманд 150-75 тонныг ХХАА ХҮ-ийн сайдын 2024 оны А/101 дүгээр тушаалаар хуваарилж олгосон. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах, зудын эрсдэлтэй байгаа аймаг, сумдын цасанд боогдсон зам даваах чөлөөлөх, айл өрхүүдэд хүнс, түлээ, түлш, малын тэжээл хүргэхтэй холбоотой ажлыг гүйцэтгэх туулах чадвар сайтай цэргийн хүчний байгууллагын болон орон нутаг дахь тээврийн хэрэгслийн судалгааг гаргасан. Давхардсан тоогоор нийт 408 тээврийн хэрэгсэл, 703 хүн хүч ажилласан бөгөөд тухайн техник хэрэгслүүдийг зудын эрсдэл өндөртэй болон хүндрэлтэй 19 аймагт ажиллах хугацаанд шаардагдах шатахуун, тос, тосолгооны материалаар урьдчилан хангуулах ажлыг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй шатахууныг худалдаа эрхлэгч нэр бүхий 17 аж ахуйн нэгжээр дамжуулан хамтран зохион байгуулсан. Аж ахуйн нэгжүүдээс нийт дүнгээр А-80 бензин 26,707 л, Аи-92 бензин 213,377 л, дизель түлш 237,276 л, тос, тосолгооны материал 7,030 л шатахуун, тос, тосолгооны материал буюу нийт 484,4 мянган л зарцуулсан ба 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдөр малын тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх, үнийг бууруулах, үнийн хэлбэлзлийг тогтвортой барих зэрэг асуудлаар Шуурхай штабын байранд 14 тэжээлийн үйлдвэрийн 23 удирдах албан тушаалтантай уулзалт зохион байгуулж, асуудлыг шийдвэрлэсэн. Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	400		3. “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тэжээлийн буудайн үнэ болох 7,140,000,000.0 (долоон тэрбум нэг зуун дөчин сая) төгрөг, тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн буудай болон малын тэжээлийн үнэд шаардагдах зардлыг тооцон 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар санхүүжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд үүрэг болгосугай.	2024 онд олгосон үрийн улаанбуудайн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн дүн 2025 оны эхний үлдэгдэл 3.8 тэрбум төгрөг байснаас 2.5 тэрбум төгрөгийн төлөлт хийлгэж 1.3 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Эдгээр харилцагчийн хугацаа хэтэрсэн төлбөрийг төлүүлэх ажиллагаа хийгдэж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/101 дугаартай тушаалаар өвөлжилт, хаваржилт хүндэрсэн цагаан болон мөсөн зудын нөхцөлд байгаа аймгуудад тэжээлийн буудай олгох ажлын хүрээнд 12 аймагт олгогдсон тэжээлийн будаан үнийг буцаан нөхөн төлүүлэх зорилгоор холбогдох аймгуудын шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байна. Дээрх нэхэмжлэлийн дагуу өнөөдрийн байдлаар 2 аймаг бүрэн, 1 аймаг тал төлбөрийг төлсөн. Шүүхийн шийдвэр гарсан боловч төлбөрөө сайн дураараа төлөөгүй аймгуудыг албадан гүйцэтгүүлэх зорилгоор шүүхэд хүсэлт хүргүүлэн ажиллаж байна.	Ахиц гарсан - 50%
117	401	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”)	Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахимд орох Мета өгөгдлийн шаардлагатай үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн хороонд бүрэн хүргүүлсэн. Үндэсний статистикийн хороо бүх яамдын Мета өгөгдлийг нэгтгэн Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг үүсгэнэ. Үр нөлөө : -	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
118	402	Тоггоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны төсөвт цалин хөлс, нэмэгдэл цалин 60.9 тэрбум төгрөг, НДШимтгэл 7.7 тэрбум төгрөгөөр нийт 68.7 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд тус онд нийт 271 сая төгрөг өгсөн байна. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%

			нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)		
119	403	Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83	3. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагчнар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.)	Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах байгууллагын төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажиллаж, мөнгөн урамшуулал авах нөхцөл хангасан албан хаагчдад олгох мөнгөн урамшууллыг журамд заасны дагуу мөнгөн урамшуулал олгох тухай ХХАА ХҮ-ийн сайдын 2024.05.13-ны өдрийн А/313 дугаар тушаалыг батлуулсан. Шаардагдах зардлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2024 онд батлагдсан хөтөлбөр, арга хэмжээнүүдийн батлагдсан төсвөөс зохицуулалт хийж, санхүүжүүлэх арга хэмжээ авч ХХАА ХҮ-ийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны батлагдсан төсвийн 5 дугаар сарын санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулж 4.7 тэрбум төгрөгийг олгож ажилласан. ХХАА ХҮ-ийн сайдын 2025 оны батлагдсан төсөвт Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 1.1 тэрбум төгрөгийг батлуулж 2025.09.16-ний өдрийн байдлаар 350.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Үр нөлөө : Хяналтаас хасуулах санал : Шаардагдах зардлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2024 онд батлагдсан хөтөлбөр, арга хэмжээнүүдийн батлагдсан төсвөөс зохицуулалт хийж, санхүүжүүлэх арга хэмжээ авч ХХАА ХҮ-ийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны батлагдсан төсвийн 5 дугаар сарын санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулж 4.7 тэрбум төгрөгийг олгож ажилласан.	Хэрэгжсэн - 100%
120	404	Газар тариалангийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2024-04-10 Дугаар 2024_151	1. Хүнсний улаанбуудайн дотоодын хэрэгцээнээс давсан хэсгийг экспортлох асуудлыг Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлөөр яаралтай хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд даалгасугай.	Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар улаанбуудайн гурилын нийлүүлэлт, хангамжийн талаар хэлэлцэж импортлох зөвлөмж гарсан. 2024 оны ургацаас дотоодын хэрэгцээг хангаж хүнсний улаан буудай экспортлох нөхцөл үүсээгүй. Дотоодын хэрэгцээ бүрэн хангагдаагүй. Хавсралт : 2 файл Үр нөлөө : Хяналтаас хасуулах санал : Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар улаанбуудайн гурилын нийлүүлэлт, хангамжийн талаар хэлэлцэж импортлох зөвлөмж гарсан.	Хэрэгжсэн - 100%
	405		2. Тухайн жилийн улаанбуудайн өртгийн судалгаанд үндэслэн стандартын шаардлага хангасан 4 дүгээр ангиллын хүнсний улаанбуудайн жишиг үнийг жил бүрийн 04 дүгээр сард зарлаж, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХК-д нийлүүлэх улаанбуудайн бодит үнийг 08 дугаар сард багтаан тооцож байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд даалгасугай	Тухайн жилийн улаанбуудайн өртгийн судалгаанд үндэслэн стандартын шаардлага хангасан 1-4 дүгээр ангиллын хүнсний улаанбуудайн жишиг үнийг тооцон, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХК-д нийлүүлэх улаанбуудайн бодит үнийг танилцуулсан. “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн өртөгтэй харьцуулсан үнийн санал Улаанбуудайн өөрийн өртөг 1,077,000 төгрөг байна. Үүн дээр эрсдлийн үнэлгээг 5 хувь гэж тооцвол улаанбуудайн өртөг 1,130,850.0 төгрөг болж байна. Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
121	406	Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162	3. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Тайлант хугацаанд Засгийн газрын 2024 оны 162 дугаар тогтоолын хавсралтад заасан 5 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг ерөнхий гэрээний аргаар зохион байгуулсны үр дүнд 89 нийлүүлэгчийн 113 нэр төрлийн 314 бараа, үйлчилгээг шинээр цахим дэлгүүрт бүртгэсэн.Ерөнхий гэрээний дагуу ХХАА ХҮ-ийн сайдын 2025 оны батлагдсан төсвөөс улсын сайн малчин, хошой аварга малчинд олгох гэрийг 1034.9 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж гэрээ байгуулж ажилласан. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
122	407	“Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх	6. Төлөвлөгөөний хүрээнд банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх хоршооны гишүүн малчинд олгох	Шинэ хоршооны хүрээнд 865 тэрбум төгрөгийн зээл гарч Шинээр 1160 ажлын байр бий болгож, зээлийн үр дүнд малын үүлдэрлэг байдал 57.7–63.9 хувь, Өвс, тэжээл бэлтгэлийн хүрэлцээ 34.6–	Хэрэгжсэн - 100%

		тухай 2024-04-24 Дугаар 2024_166	зээлийг эхний ээлжинд 3 жил хүртэл хугацаагаар олгож, шаардлагатай бол нийт зээлийн хугацаа 5 жилээс хэтрэхгүй байхаар сунгах, хоршооны гишүүн малчинд олгох зээлийн 6 (зургаа) нэгж хувийн хүүгээс давсан хүүгийн төлбөрийг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан тооцож Засгийн газраас хариуцан төлөхөд Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар, 2025-2029 онуудад шаардагдах эх үүсвэрийг тухайн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт даалгасугай.	37.9 хувь, Малын хашаа, саравчийн хүрэлцээ 31.3–34.5 хувь, Тоног төхөөрөмжийн хангалт 19.6–23.2 хувь, МАА-н үйлдвэрлэлийн мэдлэг 15.3–19.7 хувь , Ажиллах хүчний хангамж 9.8–11.6 хувь, Малын тэжээл тариалах газрын хүртээмж 9.7–9.9 хувиар өссөн байна. ЖДҮХС-аас 2024 онд хөдөө аж ахуйн Загвар хоршооны төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж, 4,2 тэрбум төгрөгийн эх үүсвэрт 74 төслийн 11,8 тэрбум төгрөгийн хүсэлт хүлээн авч сонгон шалгаруулах төслийн үнэлгээг хийсэн. ЖДҮХСангаас 2022 онд 14 хоршоонд 1,5 тэрбум төгрөг, 2023 онд 16 хоршоонд 1,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож ХХААХҮ-ийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. ХХААХҮ-ийн Сайдын 2025 оны А35, 36, 37 дугаар тушаалын дагуу Дархан Уул аймагт 2 хоршоо 169,0 сая төгрөг, Сэлэнгэ аймагт 2 хоршоо 19,4 сая төгрөг, Төв аймагт 1 хоршоо 100.0 сая төгрөг нийт 468.4 сая төгрөгийн зээлийг 5 хоршоо авсан байна. ХХААХҮС-ын 2025 оны А/240 дугаар тушаалаар Булганы Хангал суманд цэвэр үүлдрийн махны чиглэлийн үхэр үржүүлэх, Дархан-Уулын Орхон суманд хүнсний ногоо ариалах, боловсруулах, Сэлэнгийн Орхон суманд эрт ургацын хүнсний ногоо тариалах, боловсруулахад зориулж 840.0 сая төгрөгийн эх үүсвэр баталсан. Дархан-Уул аймгийн Орхон суманд 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг 2 загвар хоршоонд олгосон ба төсөл амжилттай хэрэгжсэнээр 14 ажлын байр шинээр нэмэгдэж, 10 ажлын байр хадгалагдахаар байна. Үр нөлөө : -	
	408		8.. Төлөвлөгөөний хүрээнд Зээлийн батлан даалтын сангаас хоршооны гишүүн малчинд гаргах зээлийн батлан даалтыг тус сангийн санхүүгийн чадавхыг сайжруулах зорилгоор коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын үед нэмэгдүүлсэн өөрийн хөрөнгөөр хангуулж, зохих журмын дагуу батлан даалт гаргахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөл (Т.Жамбалцэрэн)-д зөвшөөрсүгэй.	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Зээлийн батлан даалтын сангаас хоршооны гишүүн малчны зээлд гаргах батлан даалтын эрэлт их байгааг харгалзан сангийн бүтцийг хууль, журамд нийцүүлэн оновчтой болгох зорилгоор “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай” Хүнс, хөдөө аж ахуй,хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/401 дугаар тушаалыг батлуулав6 Засгийн газрын 2021 оны 42-р тогтоолын хүрээнд Ажлын байрыг дэмжих, Хөдөө аж ахуйг дэмжих болон Орон нутгийн ипотекийн зээлийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг 50.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх тогтоол гарсан. Энэ ажлын хүрээнд дараах бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн. Үүнд: 1. Ипотекийн орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрт батлан даалтын бүтээгдэхүүн /Засгийн газрын 2022 оны 301 дугаарт тогтоол/ Ипотекийн орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрт батлан даалтын хүрээнд 2023 онд 217 урьдчилгаа төлбөрийн дутагдалтай иргэнд 3.6 тэрбум төгрөгийн батлан даалттай 19.5 тэрбум төгрөгийн зээл 2024 онд 1118 урьдчилгаа төлбөрийн дутагдалтай иргэнд 23.4 тэрбум төгрөгийн батлан даалттай 123.2 тэрбум төгрөгийн зээл 2025 оны 1-р сарын 31-ны байдлаар 15 урьдчилгаа төлбөрийн дутагдалтай иргэнд 1.9 тэрбум төгрөгийн батлан даалттай 0.3 тэрбум төгрөгийн зээл тус тус олгосон байна. 2. Хоршооны гишүүн малчны зээлийн батлан даалтын бүтээгдэхүүн /Засгийн газрын 2024 оны 166,167 дугаарт тогтоол/" Хоршооны гишүүн малчны зээлийн батлан даалтын хүрээнд 2024-2025 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар барьцаа хөрөнгийн дутагдалтай хоршооны гишүүн нийт 12613 гишүүн малчинд барьцаа хөрөнгийн 80-100 хувийн санхүүжилтэд 306.1 тэрбум төгрөгийн батлан даалттай 417.4 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.Мөн 2025 онд Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг 5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр ХХААХҮ-ийн сайдын тушаал батлуулсан. Үр нөлөө : -	Хэрэгжсэн - 100%
	409		9.. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бусад арга хэмжээний холбогдох шийдвэрийн төслийг тухай бүрд боловсруулан Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	1.Олон улсын жижиг дунд үйлдвэрийн өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд "Дундын хоршооны өдөрлөг" зохион байгуулж, 21 аймгийн 18 хоршооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулж нийт 34,2 сая төгрөгийн борлуулалт хийсэн. 2.Дотоодын 8 үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 21 аймаг, 9 дүүргийн 100 гаруй хоршооны бараа бүтээгдэхүүнийг худалдан нийт 500 гаруй сая төгрөгийн борлуулалттай ажилласан. 3.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд төрөөс хоршооны талаар баримталж буй бодлогыг сурталчлах зорилгоор "Хоршоологчид тогтвортой хөгжил-2025" туршлага судлах арга хэмжээг 2025 оны 10 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт зохион байгуулсан.Тус арга хэмжээнд ХХААХҮЯ болон 21 аймаг тус тус бүрээс 4, нийслэлийн 9 дүүргийн хоршоодын төлөөлөл, Хоршооллын мэргэжлийн холбоодын төлөөлөл, 21 аймгийн ХХААГ-ын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ЖДҮГ-ын албан хаагч нийт 170 хүнийг хамруулж шилдэг 4 хоршооны үйл ажиллагааг суртачилсан.	Хэрэгжсэн - 100%

				Хавсралт : 1 файл Үр нөлөө : -	
	410		10.. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгасугай.	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хөнгөлөлттэй зээл авсан 25,596 малчны зээлийн үр дүнгийн судалгааг 21 аймаг 330 сумын хэмжээнд гаргаж нэгтгэсэн. Нийт зээлийн 38%-ийг мал үржүүлэг, мах, махан бүтээгдэхүүн боловсруулахад, 32%-ийг сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулахад, 30%-ийг бусад зориулалтаар зарцуулсан байна. Нийт 4 аймгийн 5562 хоршооны гишүүн малчны зээлийн хэрэгжилтэд газар дээр нь хяналт мониторинг хийж зээлийн зарцуулалтыг шалгаж, баримт материалын бүрдлийг тулгахын зэрэгцээ хоршоологчдын санал бодлыг сонсож хоршооны үйл ажиллагааг өргөжүүлэн нийлүүлэлтийн сүлжээнд нэгтгэх ажлыг удирдлагаар хангаж ажиллаж байна. "Олон улсын хоршооллын жил 2025"-ын хүрээнд "Улсын шилдэг хоршоо"-г шалгаруулах арга хэмжээ зохион байгуулж холбогдох материалаа ирүүлсэн 13 хоршооноос Цэвэр хөрсний шим, Лусын сэрчим, Баялаг сутайн хөгжил, Бат бэх найрамдал, Зөв буян арвижих, Оорцог элгэн гэсэн 6 хоршоог Улсын тэргүүний хоршоогоор шалгаруулан 2025 оны 06 дугаар сард "Дэлхийн Жижиг дунд үйлдвэрлэгчдийн өдөр"-өөр тус бүрийг 10.0 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. 2025.10.03-10.06-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд “Хоршоологчид тогтвортой хөгжилд-2025” туршлага судлах арга хэмжээг 21 аймгийн ХХААГ-ын жижиг, дунд үйлдвэр, хоршооны мэргэжилтнүүд мөн аймаг, нийслэлийн хоршоологчид, нийт 170 орчим төлөөллийг оролцуулж, 6 хоршооны сайн туршлагыг танилцуулж ажилласан. ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2025.05.16-ны өдрийн А/164 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэн нийлүүлэлт, боловсруулалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох зорилгоор хоршооны бүтцэд тулгуурласан "Өсвөр үхэр бордох загвар хоршооны төсөл"-ийг Төв аймгийн Баянчандмань сумын Илт оргил хоршоонд, Дархан-Уул аймгийн Хонгор сумын Баян булагтай сант хоршоо, Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Бумбат таван богд хоршоон дээр махны болон сүүний гарц нэмэгдүүлэхээр хэрэгжүүлж байна. Хавсралт : 4 файл Үр нөлөө : Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг ХХААХҮЯ, Сангийн яам, Монголбанк, ЗБДС, Банкууд харилцан тохиролцож 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 240509/84, 240508/03-372, 1824/А73 дугаартай байгуулсан гэрээний 8.1 зааснаар "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн ашиглалт, зарцуулалтад хагас жил тутам хяналт тавьж, дотоод аудитын тайланг хагас жил тутам Монгол банканд Банкны дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж хүргүүлнэ гэж заасан	Ахиц гарсан - 50%
123	411	Жагсаалт батлах тухай 2024-05-01 Дугаар 2024_180	2.. Тогтоолыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт даалгасугай	1.Улсын Их Хурлын 2025 оны "Тогтоолд нэмэлт оруулах тухай" 112 дугаар тогтоолоор баруун бүсийн 5 аймагт байрлах Цагаannуур, Ярант, Боршоо, Бургастай, Арцсуурь боомтоор орж ирэх гурил, малын тэжээлийн гаалийн албан татварт өөрчлөлт оруулаа. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
124	412	Багшийн гурван тулгуурт бодлого цогц арга хэмжээг батлах тухай 2024-05-01 Дугаар 2024_192	3.. Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээ”-г хэрэгжүүлж, багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд салбараас хамаарах шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай	Тогтоолын "3.2.6.багшийн сайн туршлага, цахим контент, сан, судалгааны үр дүн, инновацыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, сургалт, үйл ажиллагаанд нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, дэмжлэг үзүүлэх;" заалтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө батлах тухай" А/96 тоот тушаалаар баталсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2025-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний 4 дэх заалтад "Шинжлэх ухаан технологи, суурь судалгааны төслүүдийг хэрэгжүүлэх, инновацийн загварууд, оюуны өмчүүдийг бий болгох, олон улсын стандарт нэвтрүүлэх, Хамтын ажиллагааг олон улсын улсын хүрээнд тэлэх, сайн туршлага судлах, нэвтрүүлэх, өндөр, био, нано, цэвэр	Хэрэгжсэн - 100%

				технологийн дэшлийг судлах, нутагшуулах замаар үндэсний технологийг хөгжүүлэх, Их, дээд сургуулиуд, мэргэжлийн холбоод, салбарын эрдэм шинжилгээний байгууллага, төр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллахаар тусган, хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал: Шинжлэх ухаан, технологийн сангаас Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-д нийцүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар 2024 оноос хэрэгжүүлэх ШУТ-ийн төслийг шалгаруулах замаар судалгааг Шинжлэх ухаан, технологийн тухай /шинэчилсэн найруулга/, Инновацийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар 2018-2024 онуудад хийгдсэн шинжлэх ухаан, технологийн төслүүдийг салбарын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачид боловсруулан ирүүлсэн. Уг төслүүдийг холбогдох журмын дагуу үр дүнгийн даалгавар тус бүрээр шинжилгээ хийж, үнэлгээ, дүгнэлтийг гаргуулахаар Судалгаа хөгжлийн төвд 2025 оны 6-р сарын 03-ны 02/1746 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үр нөлөө : - Хяналтаас хасуулах санал : Чиг үүрэгт хамааралгүй,	
125	413	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	1.Яамны бүтцийн нэгжийн албан тушаал шинэчлэн батлах тухай тушаал батлагдсантай холбогдуулан яамны 109 албан тушаалын тодорхойлолтыг нэгжийн болон албан тушаалын чиг үүргийн шинжилгээ хийж, тайланг боловсруулж, ТАЗ-д хүргүүлсэн. 2.Яамны төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх 109 албан тушаалын тодорхойлолтод чиг үүрэг, 87 албан хаагчийн мэргэжлийн индексд шинжилгээ хийж, 36 хуудас тайланг боловсруулж, Төрийн албаны зөвлөлд 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлсэн. 3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын шинээр болон шинэчлэн, нэмэлт, өөрчлөлт оруулах нийт 66 албан тушаалын тодорхойлолтын харьцуулалт, танилцуулга, Төрийн албаны зөвлөлийн 5 тогтоолын төслийг тус тус боловсруулан Төрийн албаны зөвлөлд 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлэн, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 362, 363, 364, 365 дугаар тогтоолыг тус тус батлуулав. 4.Албан тушаалын тодорхойлолтууд шинээр болон шинэчлэн, нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор "Хүний нөөцийн удирдлагын цахим тогтолцоо" системд байгууллагын шинэчилсэн бүтэц, албан тушаалын тодорхойлолтуудыг шинээр оруулж, Төрийн албаны зөвлөлд хянуулан, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр батлуулав. 5."Хүний нөөцийн удирдлагын цахим тогтолцоо" системд бүртгэлтэй 99 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн баталгаажуулав. Үр нөлөө : - Хяналтаас хасуулах санал : бүрэн хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%
126	414	Мал аж ахуйн салбарт авах зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_211	3.. Энэ тогтоолыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд даалгасугай	Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоолоор уг техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж эхлэх хугацааг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулсан байсныг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр батлагдсан. Хавсралт : 2 файл	Ахиц гарсан - 50%
127	415	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	2.. Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байхыг бүх албан хаагчдад мэдэгдэж, одоогоор үүнтэй холбогдсон гомдол ирээгүй болно.	Хэрэгжсэн - 100%

	416		4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Албан бичиг солилцооны дундын систем DocX-ээр дамжуулан 2025 онд 3998 бичиг илгээж, 9915 албан бичиг хүлээн аваад байна.	Хэрэгжсэн - 100%
128	417	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2024-05-29 Дугаар 2024_235	2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.4-т заасны дагуу гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд (1.Арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хаягдалгүй, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХК-д 15 жилийн хугацаагаар олгосугай)	1.Засгийн газрын 2024 оны 235 дугаар тогтоолоор “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-д үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийг олгож тогтоолын хэрэгжилтийг хангаж Булигаар ХК, Мон-Ирээдүй ХХК, Арилдий ХХК, Түмэн шир ХХК, "Үжин партнерс" ХХК, "Их Асар" ХХК, Фучер холдинг ХХК-иудтай паркийн нэгжийн гэрээг байгуулан ажиллаж байна. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн суурь дэд бүтэц 24 МВт-ын Дулааны цахилгаан станц, Бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын "Хуа Зи Технологи” ХХК , “Хуа Ши Энержи Индастри” ХХК-ийн түншлэлтэй, Нийслэлийн Засаг даргын А/1082 захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг " нь Гэрээ байгуулах хэлэлцээрийг хийсэн. Паркийн суурь дэд бүтэц “24 МВт-ын Дулааны цахилгаан станц, Бохир ус цэвэрлэх байгууламж”-ийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын "Хуа Зи Технологи” ХХК , “Хуа Ши Энержи Индастри” ХХК-ийн түншлэгч компаниудтай “ЭМЭЭЛТ ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРКИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ, БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ (EPC) ГЭРЭЭ”-г байгуулан ажиллаж байна.2.Засгийн газрын 2023 оны 423-р тогтоолоор “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг Монэксалл ХХК-д олгож 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 231215/06-828 тоот гэрээ байгуулж, 3,380 га газрыг үйлдвэр технологийн паркийн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авч Засгийн газрын 2024 оны 74-р тогтоолоор паркийн байршлыг баталгаажуулж 2024 онд газрын зөвшөөрлийг авсан байна. Тус төслийг хэрэгжүүлэгч Монэксалл ХХК, хөрөнгө оруулагч БНХАУ-ын Шиань хуаюань групп ХХК, үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч Чайна констракшн ХХК-иуд хамтран хэрэгжүүлэхээр бүтээн байгуулалтын бэлтгэл хийгдэж байна. 2026 оны 05 дугаар сараас бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн байна.	Хэрэгжсэн - 100%
129	418	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10	2.. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	ХХААХҮ-ийн салбарт батлагдсан урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан ХХААХҮ-ийн салбарын 2025 оны төсвийн саналыг боловсруулж 1.8 их наяд төгрөгөөр СЯ-ны 2024.07.25-ны өдрийн 01/2423 тоот албан бичгээр хүргүүлж, БОХХААХҮБХ-доор хэлэлцүүлж УИХ-ын 2024.11.15-ны өдрийн хуралдаанаар урсгал зардлыг 664.4 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 58,6 тэрбум төгрөгөөр батлуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333359498301 Хяналтаас хасуулах санал : Тодорхой хугацаа заагдаад хийгдсэн ажил тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
130	419	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28	2.1.. хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулах, улсын тусгай хэрэгцээний отрын бүсэд орох, гарах хөдөлгөөнийг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, ил тод болгох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар мал аж ахуйн салбарын өвөлжилтийг даван туулах 19 заалт бүхий нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд otorchin.gov.mn цахим системийг хөгжүүлж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. Улсын тусгай хэрэгцээт аймаг дундын отрын бүс нутагт орох гарах, шилжилт хөдөлгөөнийг аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны даргын 2025 оны А/82 дугаар тушаалаар батлав. Хяналтаас хасуулах санал : хугацаандаа хэрэгжсэн асуудал тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	420		2.2.. Цаг агаарын аюултай үзэгдлийн үед гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлт хийж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт;	Зудын гамшгийн үед хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгийг авран хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах үеийн салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хүч хэрэгслийг татан оролцуулах, удирдлага зохион байгуулалтыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 4 бүлэг 17 хэсэгтэй “Зудын хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулан батлуулсан. УОК-ын Шуурхай штабаас аймаг орон нутгийн зудын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах талаар заавар,	Хэрэгжсэн - 100%

				зөвлөмж, загварыг өгч, зудын гамшгийн үед хүний амь нас, эрүүл мэнд, мал, аьтан эд хөрөнгийг авран хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах үеийн салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хүч хэрэгслийг татан оролцуулах, удирдлага зохион байгуулалтыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор “Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ”-г хийж, үнэлгээнд тулгуурлан “Зудын хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө” нийт 21 аймаг өөрийн онцлогт тохируулан боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Хяналтаас хасуулах санал : хугацаандаа хийгдсэн цаг хугацаа өнгөрсөн тул хяналтаас хасах	
	421		2.3.. Малын өвс, тэжээлийн хэрэгцээ, нөөцийг харгалзсаны үндсэн дээр өвс, тэжээлийн экспорт, импортын зохистой харьцааг хангах арга хэмжээг авах, орон нутгийн болон тэжээлийн үйлдвэрүүдийн нөөцөд тулгуурлан бүрэн найрлагат хүчит тэжээлийг бэлтгэх, малчид, мал аж ахуй эрхлэгчдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт;	Нийт улсын нөөцөөс 202,957 малчин өрхөд 87,527 тонн өвс тэжээлийн тусламж, хаагдсан 132 мянган км даваа, гүвээг нээж мал, махыг борлуулах, өвс, тэжээл татан авах боломжийг бүрдүүлсэн. мөн цасан шуурганд уруудаж, улсын хилийн зурваст бэлчээрлэж байгаа эзэн тодорхойгүй 5,000 орчим малыг улсын хилийн зурвасаас гаргаж, шуурганд уруудсан 90 мянга гаруй малыг тогтоож үүнээс 21,377 тооны малыг эзэн холбогдогчид хүлээлгэн өгч, учирч болох 9.5 тэрбум төгрөгийн хохирлоос урьдчилан сэргийлж, давхардсан тоогоор 9,063 алба хаагч, 2,414 техник хэрэгсэлтэйгээр ажилласан. Өвөлжилтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар болон MYOHPT, Eagle, TV9, NTV, MN-25, TB-5 ETV телевиз, zarig.mn, urug.mn шууд дамжуулсан. Мөн мэдээллийг “УОК-ын Шуурхай штаб” пейж хуудсанд байршуулан zogii.mn, ubn.mn, “Монголын үнэн” сонин зэрэг 70 гаруй хэвлэлд хэвлэлийн группээр дамжуулан олон нийтэд хүргэсэн. Өвс, тэжээлийн экспортыг зогсоож, импортыг чөлөөтэй түргэн шуурхай улсын хил нэвтрүүлэх чиглэлийг Монгол Улсын шадар сайдаас Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах цаг хугацаандаа хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%
	422		2.4.. Ургацын урьдчилсан балансыг 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор таримлын төрөл тус бүрээр нарийвчлан гаргах, ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлтгэл, зохион байгуулалтын бүрэн байдал, үр тариа, төмс, хүнсний ногооны агуулах, зоорь, эльваторын бэлэн байдлыг хангуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт;	Ургацын баланс тогтоох, ургацын чанарт дүн шинжилгээ хийх ажлыг аж ахуйн нэгж, иргэний тариалсан талбайд нэгж талбар тус бүрээр нарийвчлан гаргаж Засгийн газрын хуралдаанл танилцуулсан байна. Энэ онд нийт 577.5 мянган га-д тариалалт хийж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 60.7 мянган га-аар буюу 10.5 хувиар тариалалт буурсан. Ургацын урьдчилсан балансаар 276.4 мянган тонн үр тариа, үүнээс 255.5 мянган тонн улаанбуудай, 88.3 мянган тонн төмс, 164.1 мянган тонн хүнсний ногоо, 40.7 мянган тонн тосны ургамал, 100.5 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авч хүн амын хэрэгцээт улаанбуудайн 64 хувь, төмсний 72.8 хувь, хүнсний ногооны 62.5 хувийг дотоодын ургацаас хангах боломжтой гэсэн төлөвийг гаргасан. ЦЭнэ жилийн ургац хураалтад 5.0-6.0 мянган хүн нэмэлтээр ажиллах тооцоо гарсныг Засгийн газрын хуралдаанд танилцуулж оюутан, хугацаат цэргийн албан хаагчдыг ургац хураалтад ажиллуулах шийдвэр гарсаны дагуу холбогдох их дээд сургууль, Зэвсэгт хүчний жанжин штабтай хамтран оюутан, хугацаат цэргийн албан хаагчийг ургац хураалтын ажилд оролцуулах, тэдгээрийн цалин хөлс, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг зохицуулж хяналт тавин ажиллалаа. - Ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд зохион байгуулахад шаардагдах шатах, тослох материалын нөөцийг бүрдүүлэх, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах, хадлан тэжээл бэлтгэх, ургац хураах, тээвэрлэхэд зам, гүүрийн эвдрэл, гэмтлийг тогтоож, зам засварын ажлыг шуурхай гүйцэтгэж, ургац болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлтэд саатал учруулахгүй байхад онцгойлон анхаарч ажиллахыг холбогдох мэргэжлийн байгуулагад уламжлан зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Хавсралт : 4 файл Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах цаг хугацаандаа хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%
	423		2.5.. Малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр худалдан борлуулах, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийг хязгаарлах чиглэлээр аливаа арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, “Хөдөө аж ахуйн бирж” ХК (Ц.Батсайхан)-д;	Малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр худалдан борлуулах, хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн үнийг хязгаарлах чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байх зорилгоор малчдаас дундын зуучлалгүйгээр эцсийн хэрэглэгчдэд шууд хүргэх боломжийг бүрдүүлэн бирж нь дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд: - Биржийн арилжааг тодорхой чиглэлүүдээр зохион байгуулах, - Экспортын нэг цонхны системийг бүрэн нэвтрүүлэх, - Мал, малын гаралтай бүтээгдэхүүний хялбар худалдааны платформыг хөгжүүлэн	Хэрэгжсэн - 100%

				нэвтрүүлэх, - Малын төвлөрсөн захыг эрчимжсэн мал аж ахуй төвлөрсөн бүс нутагт байгуулах судалгаа төслийг боловсруулах, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах зэрэг ажлууд хийгдээд байна. Мал, махны биржийн арилжааг тодорхой чиглэлүүдээр зохион байгуулах ажлын хүрээнд 2025 онд: Баруун бүсийн дуудлага худалдааг Завхан аймгийн Улиастай хотод 2025 оны 11 дүгээр сарын 22,23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, дуудлага худалдаагаар Улиастай сумын Богдын гол багын Х.Болд 8 бух, Завхан аймгийн Алдархаан сумын малчин Э.Батсүх 300 толгой ямаа, Завхан аймгийн Алдархаан сумын малчин Н.Дабааням 230 толгой ямаа, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын малчин Б. Рахинжан 20 тонн ямааны мах, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын малчин Д.Далихан 40 тонн үхрийн мах тус тус арилжаалагдаж, худалдан авагчаар “Энх хүслийн ундраг” дундын хоршоо, “Бадар хундаг оргил” ХХК нийт 765.3 мянган төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Зүүн бүсийн дуудлага худалдааг Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод 2025 оны 12 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Дуудлага худалдаа нь 12 сарын 03-07 өдрүүдэд зохион байгуулагдаж, дуудлага худалдаагаар Сүхбаатар аймгийн Асгат сумын малчин Б.Отгонбаатар 21 толгой адуу, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын малчин Х.Сүхбаатар 103 хонь 102 ямаа, Дорнод аймгийн Халхгол сумын малчин З.Батбаяр 643 толгой хонь, Малын удмын сан 139 толгой хурган хуц, эм хонь тус тус арилжаалагдаж худалдан авагчаар “Дорнод мах маркет”ХХК, “Баян тал” ХХК нийт 173,5 сая төгрөгийн арилжаа хийгдсэн. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах цаг хугацаандаа хэрэгжсэн	
	424		2.12.. Ургац хураалтын болон мал, мах бэлтгэлийн үед замын хяналтын цэгийн хяналт шалгалтыг шуурхай хэрэгжүүлэх, хүндрэл чирэгдлийг багасгах, гарал үүсэл тодорхойгүй, халдварт болон гоц халдварт өвчин дэгдээж болзошгүй мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар (Т.Сүхболд), Мал эмнэлгийн ерөнхий газар (А.Нарантуяа)-т;	Мал амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үеийн хяналтыг Засгийн газрын 196 дугаар тогтоол болон Нийслэлийн Засаг даргын 858 дугаар захирамжийн дагуу байгуулагдсан 4 аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн хяналтаар нийт 27591 гэрчилгээ бүхий мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн шалгагдаж нэвтэрсэн байна. 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сум дүүрэг дэх мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нарыг Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тухай бүр мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид 322 зөрчилд 268 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч харьяалах прокурорын байгууллагад хянуулан ажилласан. Хэрэгжилтийн явц:Бүрэн хэрэгжсэн Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах цаг хугацаандаа хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%
	425		2.13.. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөр тайван байдлыг хадгалах арга хэмжээ авахыг Мал эмнэлгийн ерөнхий газар (А.Нарантуяа)-т.	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны халдварт өвчний төлөвлөгөөг Мал эмнэлгийн ерөнхий газрын дэргэдэх мэргэжлийн зөвлөлөөр 2023 оны үр дүн 2024 оны төлөвлөгөөг 2024 оны 3 сарын 06-ны өдөр хэлэлцүүлсэн. Тус зөвлөлөөр танилцуулж мэргэжлийн зөвлөлийн саналыг тусгаж Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 3 сарын 07-ны өдрийн " Дархлаажуулалтын төлөвлөгөө батлах тухай " А/68 тоот тушаалаар батлуулж аймаг орон нутгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.Төлөвлөгөөний дагуу аймаг нийслэлийн мал эмнэлгийн газар дархлаажуулалт хийх захирамж гаргаж дархлаажуулалтын ажил зохион байгуулсан. 2024 оны хагас жилийн байдлаар улс, орон нутагт, иргэнээс нийт 19 нэр төрлийн вакцинаар давтан таригдаж вакцин ороод 20.4 сая толгой мал хамрагдахаас 20,0сая толгой мал хамрагдаж 97.0%-н гүйцэтгэлтэй дууссан. Үйлчилгээний хөлсийг 12 сарын 15-ны дотор өгч дууссан. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах цаг хугацаандаа хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%
	426		4.. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумын аюулгүй нөөцөд бэлтгэх 36.4 мянган тонн бүдүүн тэжээл (өвс)-ийн 86.7 хувь буюу 31.5 мянга, 30.8 мянган тонн хүчит тэжээлийн 42.8 хувь буюу 13.9 мянган тонныг тус тус бэлтгэж, 64.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэхэд нийт 28.3 тэрбум төгрөг шаардлагатай. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөгдсөний дагуу Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө гаргах тухай тогтоолын төслийг бэлтгэж нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл хангаж байна. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах цаг хугацаандаа хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%

131	427	Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс тогтоох тухай 2024-08-14 Дугаар 2024_38_1	2. Дэд бүс дэх хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, төрөлжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт тус тус даалгасугай. (Төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс’’-ээр тогтоох)	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн “Хөнгөн, хүнсний үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт батлах тухай” 271 дүгээр тогтоолыг боловсруулан батлуулсан. Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл технологийн паркуудыг төвийн бүсэд Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн Хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк”, Баруун бүсэд Ховд аймагт “Шинэ Ховд аж үйлдвэрийн парк”, Нийслэлд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, говийн бүсэд Говьсүмбэр аймагт “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”, Зүүн бүсэд Дорнод аймагт “Зүүн бүсийн үйлдвэрлэл технологийн парк”-уудыг байгуулахаар төлөвлөөд байна. Дээрх үйлдвэрлэл технологийн паркуудын байршил, үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрлийг тухайн бүс нутгийн түүхий эдийн нөөц, ажиллах хүчний хангамж, дэд бүтцийн хөгжил, цаашдын төлөвлөлт, бүс нутгийн эдийн засгийн хөгжил, экспорт, импортын боломжуудад тулгуурлан сонгосон. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	428		3.. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, малын тэжээл тариалах, төмс, хүнсний ногоо, үр тарианы тариалалтыг нэмэгдүүлэх, шинэ нэр төрлийн таримал нутагшуулан тариалах зорилгоор атаршсан газрыг тариалангийн газарт шилжүүлэн ашиглах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгасугай.	2025 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн Ерөнхий газартай хамтран Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэр дэх 1137.80 га, Хонгор сумын нутаг дэвсгэр дэх 2937.07 га болон 895 га, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 524 га, Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэр дэх 497.1 га, Матад сумын нутаг дэвсгэр дэх 15000 га, Булган сумын нутаг дэвсгэр дэх 1500 га, Баянтүмэн сумын нутаг дэвсгэр дэх 3000 га, Халх гол сумын нутаг дэвсгэр дэх 30000 га, Чулуунхороот сумын нутаг дэвсгэр дэх 4000 га, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэр дэх 651.16 га, Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр дэх 957.84 га, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэр дэх 72.8 га, Баян-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 431 га, Биндэр сумын нутаг дэвсгэр дэх 577.4 га, Баянхутаг сумын нутаг дэвсгэр дэх 1049 га, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэр дэх 600 га, 4655.16 га болон 2749.69 га, нийт 71235.02 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 166 дугаар тогтоолыг боловсруулан батлуулсан. Нийт тариалангийн талбайн хэмжээ 71.2 мянган га талбайгаар нэмэгдэж 1033.2 мянган га талбайд хүрэв. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430847389682 Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	429		4. Тогтоолын хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнг 2025 оноос эхлэн жил бүрийн 03 дугаар сард багтаан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тайлагнаж байхыг Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн Засаг дарга нарт, нэгдсэн дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт тус тус үүрэг болгосугай.	Атар газрыг тариалангийн газрын ангилалд шилжүүлэх саналыг Төв, Дорнод, Дундговь, Хэнтий, Дархан-Уул, Говьсүмбэр аймгийн Засаг дарга нараас тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн ирүүлсэн нийт 71.2 мян.га атар газрыг тариалангийн газарт шилжүүлж, Засгийн газрын 2025 оны "Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай" 166 дугаар тогтоолыг батлуулсан болно. Түүнчлэн, атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх асуудлыг орон нутгийнхаа түвшинд зохион байгуулж, тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн ирүүлэх тухай ХХААХҮСайдын албан тоотыг 2 удаа холбогдох аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
132	430	Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай	5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хоолны орц, найрлага, шим тэжээлийг нэмэгдүүлснээр хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хөгжилтөд үзүүлсэн нөлөөлөл болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн сэтгэл ханамжийг тандан судалж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсролын сайд П.Наранбаярт, хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохих стандартыг мөрдүүлж, шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг тогтвортой үнээр ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгах санал, хэлэлцүүлгийг 2025.06.06-ны өдөр БЕГ, ХХААХҮЯ, 21 аймгийн Боловсролын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүд хамруулсан. ЕБС-ийн дунд ангийн сурагчдын хоол шим тэжээлийн нөхцөл байдлыг судлах, суралцагч, эцэг, эх асран хамгаалагчаас авах судалгааны 8 асуумжид саналаа 2025.03.26-нд Боловсролын Ерөнхий газарт хүргүүлсэн. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%

		2024-09-11 Дугаар 2024_73_1	үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт тус тус үүрэг болгосугай.		
133	431	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_86-1	4. Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Гадна, дотор 36 цэгт байрлуулсан теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангаж шаардлагатай тохиолдолд Төрийн захиргааны удирдлагын газрын даргын зөвшөөрлөөр Төрийн тусгай хамгаалалтын хэлтэст мэдэгдэж, админ эрх бүхий албан хаагч нэвтрэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Хэрэгжсэн - 100%
134	432	Журам батлах тухай “Төрийн нуцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам” 2024-10-09 Дугаар 2024_120_1	2. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан журмыг (Төрийн нуцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (З.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус даалгасугай)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд төрийн нуцад хамааруулах худалдан авах ажиллагаа байхгүй болно.	Хэрэгжсэн - 100%
135	433	Төрийн өмчийн хөрөнгийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2024-10-30 Дугаар 2024_152_1	4. Энэ тогтоолын хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулан ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	152 дугаар тогтоолын дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/443 дугаар тушаал гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны балансад бүртгэлтэй баянзүрх дүүргийн 23 дугаар хороонд байрлах Агуулах аж ахуйн зориулалттай газрыг хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэн холбогдох материалуудыг Төрийн өмчийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 01/3954 дугаар албан бичгээр хүргүүлээд байна. ХХААХҮЯ-ны дансанд бүртгэлтэй агуулахын дуудлага худалдаа амжилттай зохион байгуулагдаж 1.1 тэрбум төгрөгөөр үл хөдлөх хөрөнгө /орон сууц/ худалдан авах тендерийг ТХААГ-аар зохион байгуулж байна. https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1746498050956 Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
136	434	2026 оныг “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил” болгон зарласантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-10-30 Дугаар 2024_153	2. “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил”-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын болон “Дэлхийн цаа бугын аж ахуй эрхлэгчдийн их хурал”-ын Ажлын алба, 2026 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын оролцогч талуудын 17 дугаар бага хурал”-ын Ажлын албаны үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж, хамтран ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт тус тус үүрэг болгосугай	1.Монгол Улсын санаачлагаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2022 оны A/RES/76/253 дугаар тогтоолоор 2026 оныг “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил” болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 153 дугаар тогтоолоор олон улс, дотоодын түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, бэлтгэл хангах, зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 97 дугаар захирамжаар байгуулсан. "Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил"-ийн хүрээнд салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын А/493 дугаар тушаалаар батлуулав. 2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хандивлагчдын хамтын ажиллагааны уулзалт”-ыг амжилттай зохион байгууллаа. Уулзалтаар Монгол Улсын санаачлагаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2026 оныг “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил” (IYRP) болгон зарласантай холбогдуулан ирэх онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар танилцуулга бэлтгэн, мэдээлэл хүргэсэн. 3.IYRP зохион байгуулах сайн дурын ажлын хэсгийг 3 хуралдуулж, холбогдох яам, байгууллагатай уулзалт зохион байгуулж, төлөвлөгөөг боловсруулан эцэслэж, удирдлагын санал тусгав. 4.IYRP төлөвлөгөөг боловсруулан, эхийг бэлтгэж, QR код үүсгэв. 5.Яамны вэб сайтад бэлчээрийн талаарх мэдээллийг шинэчлэн, ирэх 2026 онд зохион байгуулагдах “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуйн эрхлэгчдийн жил”-ийн үйл	Ахиц гарсан - 50%

				ажиллагаатай холбоотой мэдээлэл оруулах цэсийг холбогдох газрын хариуцсан албан тушаалтантай хамтран нэмэлтээр үүсгэж, мэдээлэл оруулав. 6.IYRP-ийн нээлтийн арга хэмжээний бэлтгэл ажлыг хангав. Хавсралт : 2 файл	
137	435	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_163	2. 2.Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг /Busines Standart буюу Оффисе 365 программын 1 жилийн эрх/-ийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулан худалдан авах 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн ХХААХҮЯ/007 дугаартай гэрээг хэрэгжүүлэн албан хаагчдад хүлээлгэн өгч албан хэрэгцээндээ ашиглаж байна. Хяналтаас хасуулах санал : Төсвийн багцдаа тусган санхүүжүүлж хэвшсэн байна.	Хэрэгжсэн - 100%
138	436	ХУУЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_164_01	1.. "Нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагч, ажилтныг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, ... "	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.11-т албан хаагчийг зайнаас цахим сүлжээгээр ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн заалтыг тусгасан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
139	437	Монгол улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2024-11-20 Дугаар 2024_181	3.. Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газраас мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулах, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, нөөцийг харгалзан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”-ийг хэлэлцэн улаанбуудайн гурилыг тоо хэмжээ, хугацааны хязгаарлалтгүйгээр импортлохоор эцэслэн батлсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140175644351 Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай” хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431874412052	Хэрэгжсэн - 100%
140	438	Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-11-27 Дугаар 2024_191_01	2.2.. Хил орчмын аялал жуулчлалыг дэмжих, жуулчдын урсгалыг татах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор бараа бүтээгдэхүүний үнийг 50 хүртэлх хувиар хөнгөлөх, урамшуулах арга хэмжээг "Хямдралын сар" аяны хүрээнд тогтмол зохион байгуулж хэвшүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин нарт;	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 5 дугаар сар хүртэлх хугацаанд хил орчмын аялал жуулчлалыг дэмжих, жуулчдын урсгалыг татах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Өвлийн болон Нүүдэлчин фестиваль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын 3, аялал жуулчлалын салбарын 1 төрийн бус байгууллага зохион байгуулах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, 27 орны 284 жуулчин, монголын 1000 гаруй төлөөлөгч нарт 80 гаруй хоол үйлдвэрлэгч хамрагдан, Казак, дарьганга, буриад гэх мэт 11 угсаатны болон бүс нутгийн онцлог хоол, идээ, ундааг сурталчилан ажилласан.Онцлох хоол:*Дархан-Уул аймаг тогооч Ц.Ягаанцэцэг- дотор махан хоол, утсан махан бүтээгдэхүүн, "Гүзээний ороомог", https://www.facebook.com/reel/1439990760665391. *Дорнод аймгийн тогооч М.Цэрэнханд- “Ангара буриад бууз”, хуушуур, талх байсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	439		2.3.. Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр	Жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд Алтан намар, Намрын ногоон өдөр, Шилмэл мал, өвлийн идэш, цагаан сар, нөөцийн махны үзэсгэлэн худалдааг зохион байгуулж ажиллаж байна. Тухайлбал:Сар шинийн баярт зориулсан "АМАР БАЙНА УУ 2025" үзэсгэлэн худалдаанд 250 гаруй иргэн, ААНБ, хоршоо оролцож нийт 1.3 тэрбум төгрөгийн	Хэрэгжсэн - 100%

			сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт.	борлуулалт хийсэн. Намрын ногоон өдрүүдийг 20 дахв жилдээ зохион байгуулж 1000 гаруй иргэн, аж ахуй нэгж оролцож 2.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. Хавсралт : 1 файл	
141	440	Эрх шилжүүлэх тухай 2024-12-18 Дугаар 2024_216_1	2. 2. Тусгай зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт үүрэг болгосугай.	Засгийн газрын тогтоол гарснаас хойш ХХАААХҮСайдын тушаалаар 2 аж ахуйн нэгжид тамхи үйлдвэрлэх, 2 аж ахуйн нэгжид тамхи импортлох тусгай зөвшөөрөл тус бүр шинээр олгож, 8 аж ахуйн нэгжийн тамхи импортлох тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан. Хяналтаас хасуулах санал : Тусгай зөвшөөрөл олгогдсон тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
142	441	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 Дугаар 2024_217	2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Танилт нэвтрэлтийн үйлчилгээ үзүүлэх Д-2022/59 гэрээг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хийсэн. Энэ гэрээний дагуу иргэн, хуулийн этгээд ХХАААХҮ-ийн салбарын тусгай болон энгийн зөвгөөрөл авах, урамшуулал авах болон бусад мэдэллийн санд танилт, нэвтрэлтийн “ДАН” систем ашиглаж төрийн үйлчилгээ авч байна. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн тул хасах саналтай.	Хэрэгжсэн - 100%
143	442	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2024-12-20 Дугаар 2024_226	2. 2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Агаарын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга болон нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэсэн үед зарлан мэдээлэх дохиог иргэд, малчдад хүргэх, хэвлэл мэдээллийн байгууллагууд гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг мэргэжлийн байгууллагад нэн даруй дамжуулах, мал аж ахуйн салбарын хүн хүч, техник, материал хэрэгслийн судалгаа гаргах, нөөцийг нэмэх зэрэг арга хэмжээг авч ажилласан. Улсын онцгой комиссын шуурхай штаб-т холбогдох албан хаагч томилогдон ажилласан. Хяналтаас хасуулах санал : 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой асуудал тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
144	443	Жагсаалт батлах тухай 2024-12-25 Дугаар 2024_233	2. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор тус тус хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	ХХАААХҮ-ийн сайдын 2025 оны батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээниээс тогтоолын дагуу 3 арга хэмжээг зохион байгуулахаад шийдвэрлэсний дагуу ХХАААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.02-ны өдрийн 02/898 тоот албан бичгээр ажлын даалгавар болон техникийн тодорхойлолтуудыг хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газарт 4 арга хэмжээг багцлан худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийн дагуу 16.4 тэрбум төгрөгийн гэрээг хуулийн хугацаанд нь байгуулан ажилласан. Хяналтаас хасуулах санал : энэ үйл ажиллагаа тогтмолжсон, хийгдсэн ажил тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	444		3. 3.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.тп)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан дугаар төсөл. арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан дугаар төсөл, арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан дугаар төсөл. арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байх тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	445		4. 4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	ХХАААХҮ-ийн сайдын 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах 84 арга хэмжээг батлуулж 70 худалдан авах ажиллагааны гэрээг байгуулан tender.gov.mn цахим хаягт байршуулан ажилласан.	Хэрэгжсэн - 100%
145	446	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	2. 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэхгүй байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	ХХАААХҮ-ийн салбарт орон тоо нэмэгдээгүй бөгөөд 2025 онд нийт 2117 орон тоотой, 60.9 тэрбум төгрөгийн цалингийн сантайгаар ажиллахаар батлагдсан. Монгол улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиах ХХАААХҮ-ийн салбарт 2025 онд орон тоог 187-гоор бууруулж цалингийн санг 57.9 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийг 7.4 тэрбум төгрөгөөр баталсан.	Хэрэгжсэн - 100%

		2024-12-25 Дугаар 2024_238_1		Хяналтаас хасуулах санал : 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлээгүй тул хяналтаас хасах	
146	447	Төрийн өмчит хуулийн этгээдийн нэрийг өөрчлөх тухай 2024-12-30 Дугаар 2024_256_1	2. 2.Энэ тогтоолын 1-д заасны дагуу хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус компанийн дүрмийн өөрчлөлтийн төслийг боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгасугай.	Дүрмийн өөрчлөлтийн төслийг боловсруулан, зохих журмын дагуу хэлэлцүүлж, 2025 оны 96 тогтоолын хавсралтаар компанийн дүрмийг баталсан. Дархан-Уул аймгийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2025 оны 03 сарын 31-ний өдөр Төвийн бүсийн хүнс хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн дүрмийг бүртгүүлсэн. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : дүрмийг батлуулсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	448		3. 3.“Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК-ийн нэрийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгасугай.	Тогтоолын биелэлтийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Компанийн нэрийн өөрчлөлтийг холбогдох журмын дагуу бүртгүүлэн, 2025 оны 03 сарын 31-ний өдөр хуулийн этгээдийн гэрчилгээг гаргуулж авсан. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : бүртгүүлсэн байх тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
147	449	Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-01-22 Дугаар 2025_32	3. 3 .“Ди Би Эм Лизинг” ХХК-аар дамжуулан “Хөдөө, аж ахуйн корпораци” ТӨХХК-д олгосон санхүүгийн түрээс (лизинг)-ийн төлбөр 29,383,214,773.54 (хорин есөн тэрбум гурван зуун наян гурван сая хоёр зуун арван дөрвөн мянга долоон зуун далан гурван төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийг нэмэгдүүлсэн хүүгийн хамт тоног төхөөрөмж худалдан авсан, дамжуулан зээлийн эргэн төлөлт болон борлуулалтын орлогоос 2028 он хүртэл үе шаттайгаар жил бүр хуваарийн дагуу Монгол Улсын Хөгжлийн банканд төлж барагдуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	Ди Би Эм лизинг ХХК" болон нийт 3 аж ахуй нэгжтэй "Худалдах, худалдан авах гурван талт гэрээ"-г байгуулан 5605 /таван мянга зургаан зуу таван/ тонн хүнсний улаан буудайг нийлүүлж, 6,209,625,000.00 /зургаан тэрбум хоёр зуун есөн сая зургаан зуун хорин таван мянган/ төгрөгийн өр төлбөрийг барагдуулав. Үр нөлөө : хүнсний улаан буудайг нийлүүлж, 6,209,625,000.00	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
148	450	Аян өрнүүлэх тухай 2025-01-29 Дугаар 2025_47	4. 4.Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн дэмжлэгийг Монголбанкны бодлогын хүүгээс хэтрэхгүй байхаар тооцож, тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанаар "Аян өрнүүлэх туха" 47 дугаар тогтоолыг хэлэлцүүлэн баталсан бөгөөд энэ хүрээнд Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг улс орон даяар эрчимжүүлэн хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн банкны эх үүсвэрээр олгон ажиллаж байгаа бөгөөд Монголбанкнаас ирүүлсэн 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн мэдээгээр нийт 939 зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжид 548.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Түүнчлэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2026 оны батлагдсан төсөвт 60.2 тэрбум төгрөгийг тусгасан байна.	Хэрэгжсэн - 100%
	451		5. . 5.“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх, аяны үйл ажиллагааг орон нутагт сурталчлан таниулах, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт үүрэг болгосугай.	Атрын IV аяныг эхлүүлэх, газар тариалан, мал аж ахуй эрхлэгч болон хүнсний үйлдвэрлэгчдийг нэгэн дор цугларч, харилцан туршлага судлах, кластер байдлаар хамтран ажиллах боломжийг олгох, төрийн бодлого, хууль эрх зүйн орчинг сайжруулахад санал, зөвлөмж гаргах зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 14-нээс эхлэн 7 хоногийн хугацаатай технологийн хуралдаануудыг зохион байгуулсан. Цаашлаад “Атрын IV” аян хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөн 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү зөвлөгөөнд 21 аймаг, нийслэлийн үр тарианы 156 аж ахуйн нэгж, 94 иргэн, төмс, хүнсний ногооны 14 аж ахуйн нэгж, 136 иргэн, жимс жимсгэнэний 6 аж ахуйн нэгж, 94 иргэн, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 50 аж ахуйн нэгж, нийт 226 аж ахуйн нэгж, 324 иргэн, төрийн орон нутгийн байгууллагын 40 албан хаагч, банк санхүүгийн байгууллагын 10, нийт албан бус тоогоор 1000 гаруй төлөөлөгч оролцсон. Мөн түүнчлэн тус яам НҮБ-ын ХХААБ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хамтран 2025 оны 9 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд 21 дэх жилдээ "Намрын ногоон	Х.Б

				өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл -2025 он нэгдсэн арга хэмжээ"-г зохион байгууллаа. Төв цэнгэлдэхийн гадаа талбайд 73 асарт нийслэл болон бусад аймгуудаас ирсэн 146 ногоочдыг оролцуулан эх орны хөрсөнд ургасан эрүүл, баталгаатай, шинэхэн хүнсний ногоог худалдан борлуулсан.	
149	452	Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2025 оны хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-01-29 Дугаар 2025_53	2. 2.Энэ тогтоолын 1-д заасан махны нөөцийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт, зохиомол хомсдол үүсэх, үнийн хөөрөгдөл бий болохосс урьдчилан сэргийлж, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Монополын эсрэг газар (Б.Билгүүн)-т тус тус даалгасугай. (2.Энэ тогтоолын 1-д заасан махны нөөцийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт, зохиомол хомсдол үүсэх, үнийн хөөрөгдол бий болохосс урьдчилан сэргийлж, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Монополын эсрэг газар (Б.Билгүүн)-т тус тус даалгасугай.)	Улсын хэмжээнд махны нийлүүлэлт 2024 оны жилийн эцсийн байдлаар өмнөх онтой харьцуулахад 18.1 хувиар буурч, үнэ 17.1 хувиар өссөн үзүүлэлт гарсан, энэ байдал хэвээр хадгалагдвал 2025 оны 05 дугаар сар гэхэд үхрийн махны үнэ 25200 кг/төг, хонины мах 20160 кг/төг хүрэх тооцоолол гарсан. Дээрх нөхцөл байдалтай уялдуулан дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэнээр махны үнийн өсөлтийг тогтворжуулаад байна. Үүнд: 1.ХХААХҮЯ-аас мах экспортлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Бодлогын гэрээ”-ний дагуу 2025 оны 02 дугаар сарын 05-20-ны өдрүүдэд төвийн 5 дүүргийн 5 байршилд зохион байгуулж үхэр 27.8 тн, хонь 192.6, ямаа 4.2 тн нийт 224.6 тн мах худалдан борлуулсан. 2.Борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс үхрийн махны үнийг 800 төг, хонины махны үнийг 1800 төгрөгөөр бууруулж өргөтгөсөн худалдаагаар үхрийн мах 13,000 кг/төг, хонины мах 10,00 кг/төгрөг, хүнсний дэлгүүрт үхрийн мах 13,300 кг/төг, хонины мах 10,300 кг/төгрөгийн үнээр худалдан борлуулж байна. 3.Борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс үхрийн махны үнийг 800 төг, хонины махны үнийг 1800 төгрөгөөр бууруулж өргөтгөсөн худалдаагаар үхрийн мах 13,000 кг/төг, хонины мах 10,00 кг/төгрөг, хүнсний дэлгүүрт үхрийн мах 13,300 кг/төг, хонины мах 10,300 кг/төгрөгийн үнээр худалдан борлуулж байна. 4.2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд өргөтгөсөн худалдаагаар хонины мах 4586.3 тн, үхрийн мах 1102.5 тн, хүнсний дэлгүүрт жижглэнгээр хонины мах 271.2 тн, үхрийн мах 393.5 тн, нийт 6353.5 тн буюу нийт бэлтгэсэн 8380 тонн махны 76.0 хувийг худалдан борлуулсан. Хяналтаас хасуулах санал : 025 оны хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх ажилд хяналт тавьж ажилласан байх тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
150	453	'Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар батлах тухай 2025-02-12 Дугаар 2025_83	3. 3 .“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт, чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Тус арга хэмжээнд ямар нэгэн санхүүжилт гаргах талаар чиглэл ирээгүй чиг үүрэгт хамааралгүй Хяналтаас хасуулах санал : чиг үүрэгт хамааралгүй тул хяналтаас хасах	Х.Б
151	454	Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94	2. 2. Томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт Ховд үйлдвэрлэл, технологийн парк, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн технологийн цогцолборууд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Эдгээрт хөрөнгө оруулалт хийгдэж ашиглалтад орсноор дотооддоо импортыг орлох, экспортыг нэмэгдүүлж, гадаад валютын улсын нөөцөд дунд, урт хугацаандаа эерэг үр дүн үзүүлэх юм. Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн технологийн цогцолборт 5,022.3, Ховд үйлдвэрлэл, технологийн паркт 12,618.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус тус 2025 онд хийсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, гарах үр дүнд зохих журмын дагуу урт, дунд, богино хугацааны суурь судалгааг хийн, төслүүдийн хүрээнд олгож буй зээлийн эргэн төлөлт, валютын ханшийн хэлбэлзлээс үүдэх эрсдэлийг тооцон ажиллаж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	455		4. 4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай.	Гадаадын хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх чиглэлээр бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Салбарын төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангасан тул тайлангийн хугацаанд өргөдөл, гомдол ирээгүй байна	Хэрэгжсэн - 100%

152	456	Захиргааг өөрчлөн зохион байгуулах тухай 2025-03-12 Дугаар 2025_131	4. 4.“20 минутын хот хөгжлийн төв”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөлттэй харилцан уялдуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	"20 минутын хот хөгжлийн төв"-өөс хүсэлт ирүүлсэн тохиолдолд хамтран ажиллахад бэлэн байна.	Хэрэгжсэн - 100%
153	457	Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-03-12 Дугаар 2025_132	1. Олон улсад үүсэж байгаа геополитикийн болон худалдааны хурцадмал, тодорхойгүй нөхцөл байдалтай холбогдуулан хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, зөвлөл, хороо, комиссын дарга нар, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан иргэд, хуулийн этгээдэд үзүүлж буй бүх төрлийн төлбөр хураамжийг нэмэгдүүлэхгүй байхаар баталсан Засгийн газрын 2025 оны 132 дугаар тогтоолын хэрэгжих хугацааг 2026 оны 05 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл сунгах асуудлаар боловсруулсан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/3977 тоот албан бичгийг хүргүүллээ. Энэ асуудалтай холбоотой салбарын зүгээс ямар нэгэн төлбөр хуурамж нэмэгдүүлсэн шийдвэр гараагүй болно. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : 2025 оны төсвийн жилд бүх төрлийн төлбөр хураамжийг нэмэгдүүлээгүй тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
154	458	Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-03-19 Дугаар 2025_133	2. 2.Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд бөгөөд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга С.Одонтуяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь нарт, төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны III улиралд багтаан хангахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай.	Уг арга хэмжээ нь тус яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Уг арга хэмжээ нь тус яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасах саналтай.	Х.Б
	459		3.4. 3.4. Нийслэл Улаанбаатар хотын хүн амын төвлөрлийг сааруулах, хөдөө орон нутагт шилжин суурьших үйл явцыг дэмжих арга хэмжээний саналыг агаарын бохирдлыг бууруулах асуудалтай уялдуулан боловсруулах, энэ хүрээнд хөдөө орон нутагт ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж, чанарыг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг судалж танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын сайд П.Наранбаяр нарт;	УИХ болон ЗГ-ын холбогдох шийдвэрийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
155	460	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг өсгөх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2025-03-19 Дугаар 2025_135	5.1. 5.1.Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 8 дугаар зөвлөмжийн хүрээнд мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, гуриланбүтээгдэхүүн зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангаж, үнийн өсөлтөөс сэргийлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, Монополын эсрэг газар (Б.Билгүүн)-т;	Улсын хэмжээнд махны нийлүүлэлт 2024 оны жилийн эцсийн байдлаар өмнөх онтой харьцуулахад 18.1 хувиар буурч, үнэ 17.1 хувиар өссөн үзүүлэлт гарсан, энэ байдал хэвээр хадгалагдвал 2025 оны 05 дугаар сар гэхэд үхрийн махны үнэ 25200 кг/төг, хонины мах 20160 кг/төг хүрэх тооцоолол гарсан. Дээрх нөхцөл байдалтай уялдуулан дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэнээр махны үнийн өсөлтийг тогторуулаад байна. Үүнд: 1.ХХААХҮЯ-аас мах экспортлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Бодлогын гэрээ”-ний дагуу 2025 оны 02 дугаар сарын 05-20-ны өдрүүдэд төвийн 5 дүүргийн 5 байршилд зохион байгуулж үхэр 27.8 тн, хонь 192.6, ямаа 4.2 тн нийт 224.6 тн мах худалдан борлуулсан. 2.Борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс үхрийн махны үнийг 800 төг, хонины махны үнийг 1800 төгрөгөөр бууруулж өргөтгөсөн худалдаагаар үхрийн мах 13,000 кг/төг, хонины мах 10,00 кг/төгрөг, хүнсний дэлгүүрт үхрийн мах 13,300 кг/төг, хонины мах 10,300 кг/төгрөгийн үнээр худалдан борлуулж байна.УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулахаар “Тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталж, батлагдсан үзэл баримтлалын хүрээнд тогтоолын төслийг боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 08-ны, 11 дүгээр сарын 05-ны өдрийн	Хэрэгжсэн - 100%

				хуралдаанаар тус тус хэлэлцүүлж “Тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлуулсан. Хавсралт : 1 файл	
	461		6. 6.Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг долоо хоног тутам Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тус тус даалгасугай.	Уг арга хэмжээ нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарахгүй байна. Хяналтаас хасуулах санал : Чиг үүрэгт хамааралгүй тул хяналтаас хасах	Х.Б
156	462	2026 оныг “Боловсролыг дэмжих жил болгон зарлах тухай 2025-04-02 Дугаар 2025_158	3. 3.Боловсролыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засагдарга нарт үүрэг болгосугай.	Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасах саналтай. Хяналтаас хасуулах санал : Салбарт хамааралгүй тул хяналтаас хасах	Х.Б
157	463	Ой тэмдэглэх тухай 2025-04-14 Дугаар 2025_183	4. 4.0йг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т, дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, Хангайн бүсийн зөвлөл (Б.Цэрэннадмид)-д даалгасугай.	0йг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний дэд ажлын хэсэгт ТНБД орж ажилласан болно. Хяналтаас хасуулах санал : 2025 оны 07 сарын 25-28-нд ойн арга хэмжээ зохион байгуулагдсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
158	464	Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-28 Дугаар 2025_204	1.3.6.. 1.3.6.Булган аймагт байгуулах “Бизнес инкубатор төв”-ийн барилгын ажлын санхүүжилтийг 2026 оны улсын төсөвт тусгах асуудлыг судалж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан нарт.	Булган аймагт байгуулах “Бизнес инкубатор төв”-ийн барилгын ажлын санхүүжилтийг 2026 оны улсын төсөвт тусгагаагүй, харин Ховд аймгийн Зэрэг суманд “Бизнес инкубатор төв”-ийн барилгын ажлын санхүүжилтийг тусгасан байна. Хяналтаас хасуулах санал : Санхүүжилт тусгагдаагүй тул хяналтаас хасах	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%
159	465	Говийн бүсийн эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2025-05-12 Дугаар 2025_234	1.1.6.. 1.1.6.Өмнөговь аймаг дахь хилийн боомтуудаар уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүн экспортлох, импортлох гарц бий болгох, олон улсын стандартын шаардлага хангасан лаборатори байгуулах асуудлыг судалж, танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Говийн бүсийн зөвлөл (О.Батжаргал)-д;	Олон улсын стандартын шаардлага хангасан лаборатори байгуулах асуудал нь Монгол Улсын Шадар сайдын хамаарах асуудал тул хяналтаас хасах Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах	Х.Б
	466		1.2.2.. 1.2.2.Говьсүмбэр аймгийн Баянтал суманд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх мал аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн тээвэр логистик, дэд бүтцийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг судалж, шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Говьсүмбэр аймгийн Засаг дарга Т.Бат-Эрдэнэ нарт;	Говьсүмбэр аймгийн Баянтал суманд хэрэгжүүлэх “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн Эко парк” төслийг хэрэгжүүлэгч Монэксалл ХХК, хөрөнгө оруулагч БНХАУ-ын Шиань хуаюань групп ХХК, үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч Чайна констракшн ХХК-ууд хамтран хэрэгжүүлнэ. Тус төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг 2025 онд бүрэн хангуулж, 2026 оны 05 дугаар сараас бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. Төслийн тээвэр логистик, дэд бүтцийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг хувийн хэвшил бүрэн хариуцана. “Монэксалл” ХХК нь паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсний дагуу Засгийн газрын 2023 оны 423 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрлийг 15 жилийн хугацаатай, ХХААХҮ-ийн сайдын 2023.12.14-ний өдрийн А/661 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”-ийн удирдлагатай 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 231215/06-828 тоот гэрээ байгуулсан. Говьсүмбэр аймгийн ИТХ-ын 2024 оны 01-р сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор 3,380 га	Хэрэгжсэн - 100%

				газрыг үйлдвэр технологийн паркийн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. Говьсүмбэр аймгийн Засаг дарга 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/331 дүгээр захирамжийн дагуу сонгон шалгаруулалтад оролцож, газрын зөвшөөрлийг авсан. Говьсүмбэр аймгийн Баянтал сумд 30 жилийн хугацаанд 3,380 га газарт үйл ажиллагаа явуулах бөгөөд 15 жилийн дотор 4 үе шатаар бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахаар төлөвлөсөн. Хяналтаас хасуулах санал : Төрөөс авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлсэн тул хяналтаас хасах - Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.	
	467		1.2.3.. 1.2.3.Дундговь аймгийн Сайнцагаан суманд хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг судалж, шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан нарт.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн, “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод нийцүүлэн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэр дундаас мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийг нийлүүлэлтийн сүлжээг хамт үе шаттайгаар байгуулах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үйлдвэрлэл технологийн паркуудын байршил, үйл ажиллагааны чиглэлийг тухайн бүс нутгийн түүхий эдийн нөөц, ажиллах хүчний хангамж, дэд бүтцийн хөгжил, цаашдын төлөвлөлт, бүс нутгийн эдийн засгийн хөгжил, экспорт, импортын боломжуудад тулгуурлан тогтоодог. Засгийн газрын 2025 оны 271 дүгээр тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркын байршил, үйл ажиллагааны чиглэлийг баталсан. Тус тогтоолын дагуу улсын хэмжээнд 5 бүс нутагт хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар ажиллаж байна. Дундговь аймагт үйлдвэрлэл технологийн парк байгуулах тухай асуудлыг судлан, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйлдвэрлэл технологийн паркийн төслийн танилцуулга, холбогдох судалгаа, мэдээллийг ирүүлэх тухай болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах боломжтойг Дундговь аймгийн Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн.	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%
160	468	Жагсаалт батлах тухай 2025-05-28 Дугаар 2025_271	2. 2.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгасугай.	Засгийн газрын 2025 оны 271 дүгээр тогтоолын хүрээнд Дархан-Уул аймагт хэрэгжиж буй "Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор" төслийн хүрээнд Хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, бизнес инкубатор, сургалт, судалгаа хөгжлийн байгууллагуудаас тус паркд үйл ажиллагаа явуулах санал, холбогдох танилцуулга, санал авах урилгыг бэлдэж www.mofa.gov.mn сайт болон фэйсбүүк фэйж хуудсанд нийтлүүлж, МХНХ, МШХАҮТ, ММХ, МЖЖҮХ, ЖДҮГ холбоодуудад санал авах урилгыг цахим болон албан бичгээр хүргүүлсний дагуу дараах аж ахуйн нэгжүүд хүсэлт ирүүлсэн. Үүнд: Монпеллетс ХХК /хонины ноосон бордооны түүхий эд бэлтгэн нийлүүлдэг/, Сүү ХК /сүү, сүүн бүтээгдэхүүн/, Төгс ургац ХХК /4 улирлын хүлэмжийн аж ахуй эрхэлдэг/, “Хийморь сүхбаатар мах импекс” ХХК /мах боловсруулалт/, “Шүтэн-Уул" ХХК /даавуун хувцас үйлдвэрлэл/. Дээрх ҮТП-д үйл ажиллагаа явуулах хүсэлт ирүүлсэн компаниудын үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцаж, албан уулзалтуудыг зохион байгуулсан ба ҮТП-д үйлдвэр байгуулах газар хүссэн албан бичгүүдийг хүлээн авсан. ААН-үүдийн ирүүлсэн хүсэлтээр газрын хэмжээ урьдчилсан байдлаар 21.5 га байна. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
161	469	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-06-04 Дугаар 2025_279	1. 1.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амраж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Амралтын өдрийг шилжүүлэх тухай" А/208 дугаар тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын Гамшгаас хамгаалах төвийн бүсийн сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулахтай холбогдуулан яам болон харьяа байгууллагын бүх ажилтан, албан хаагчдыг 06 дугаар сарын 14,15-ны өдрийн Бямба, Ням гарагт ажиллуулсан. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : нэг удаагийн шинж чанарта бөгөөд заасан хугацаанд хэрэгжсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%

162	470	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	2. 2.Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2026 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	ХХАААХҮ-ийн салбарын 2026 оны төсвийн саналыг төсвийн хязгаартай уялдуулан боловсруулж, удирдлагуудад танилцуулан нэгтгэж 2025.07.25-ны өдрийн 01/2212 тоот албан бичгээр СЯ, УИХ-ын Тамгын газарт хүргүүлж, төсвийн зарлагын фискал болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын https://pimis.publicinvestment.gov.mn/ системд оруулж ажилласан. Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : хэрэгжсэн бөгөөд цаашид цаг хугацааны хувьд ач холбогдолгүй	Хэрэгжсэн - 100%
163	471	Төсвийн хэмнэлтэд тооцох тухай 2025-06-20 Дугаар 2025_02	1.. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт болон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан боловч 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээний дараах санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцож, хэмнэлтийг тухайн шатны төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг төсвийн холбогдох захирагч нарт даалгасугай:	ХХАААХҮ-ийн сайдын 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах 84 арга хэмжээг батлуулж, 70 худалдан авах ажиллагааны гэрээг байгуулан tender.gov.mn цахим хаягт байршуулж ажилласан. Хяналтаас хасуулах санал : Заасан цаг хугацаанд хэрэгжсэн тул хяналтаас хасах - 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр.	Хэрэгжсэн - 100%
	472		1.1. 1.1. улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан, хавсралтад заасан төсөл, арга хэмжээний нийт 535,908.1 сая (таван зуун гучин таван тэрбум есөн зуун найман сая нэг зуун мянга) төгрөгийн хэмнэлт, санхүүжилт;	орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт болон 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээний 535,908.1 сая (таван зуун гучин таван тэрбум есөн зуун найман сая нэг зуун мянга) төгрөгийн хэмнэлт. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	473		1.2. орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт болон 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилт.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт болон 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааны дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээний 535,908.1 сая (таван зуун гучин таван тэрбум есөн зуун найман сая нэг зуун мянга) төгрөгийн хэмнэлт. Хяналтаас хасуулах санал : хэмнэлт хийгдсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
164	474	Аймаг, орон нутгийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-07-02 Дугаар 2025_11	1.5. салбарын хэмжээнд гаргасан бодлого, шийдвэрийн биелэлт, үр дүнтэй орон нутагт биечлэн танилцаж, хэрэгжилтийг зохион байгуулах, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд.	1.ХХААХҮЯ-ны ажлын хэсэг Архангай, Баян-Өлгий, Завхан, Увс аймагт ажиллаж хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 56 дугаар тогтоолын хэрэгжилттэй танилцаж. Баруун бүсийн хүнсний хэрэгцээг хангаж, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжих гурил, тэжээлийн үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх болон Засгийн газрын хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдтэй холбоотой мэдээлэл өгөв.2.Төрийн нарийн бичгийн даргын А/253 дугаартай тушаалын дагуу тариалан бүхий бүх сумдын Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн 2025 оны хүнсний ногооны тариалалт, ургацын урьдчилсан балансын дүн мэдээг газар дээр нь тулгалт, үзлэг хийх, ургац хураалтын байдалтай танилцах, дүн шинжилгээ хийх, газар тариалангийн цахим систем ашиглалт, урамшууллын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. 3.Бэлчээрийн даацыг тогтоох аргачлалын дагуу тодорхойлж, отор нүүдлийг зохион байгуулан ажиллаж байна. 2025 оны байдлаар 9 отрын бүс 783,3 мян/га талбайд бэлчээрийн даацын мэдээллээр 665809 хонин толгой малын багтаамжтай гэж тодорхойлсон. 2025-2026 онд 9 отрын бүсэд 13 аймгийн 46 сумын 838 малчин өрхийн 991661,5 толгой мал отрын бүсэд өвөлжих хүсэлт ирүүлснээс Орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцэн 12 аймгийн 35 сумын 414 өрхийн 651892 хонин толгой мал өвөлжиж хаваржих шийдвэр гаргасан. Улсын тусгай хэрэгцээний 9 отрын бүсэд хяналт шалгалтаар ажиллаж, орон нутгийн удирдлага, хууль хяналтын байгууллагын мэргэжилтэн, эрүүл мэндийн төвийн эмч нарын бүрэлдэхүүнтэй хамтран малчдад шаардлагатай эмнэлгийн болон холбогдох арга хэмжээг авч ажилласан.	Хэрэгжсэн - 100%
165	475	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус	3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлд ажиллуулахаар тус яамны Салбарын эдийн засгийн үр ашиг төлөвлөлт, мал эмнэлгийн бодлогын зохицуулалт хариуцсан	Хэрэгжсэн - 100%

		эргэлттэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-07-23 Дугаар 2025_29	Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	ахлах шинжээч Д.Хүрэлбаатарын нэрийг Сайдын 2025.02.03-ны өдрийн 01/338 тоот албан бичгээр саналыг хүргүүлсэн. Одоогоор мал эмнэлгийн салбарт мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх байгууллага байхгүй байна. Мал эмнэлгүүд мэдээгүйжүүлэх, нойрсуулах эмийг хүн эмнэлгийн эм ханган нийлүүлэх байгууллагуудаас авч ажил, үйлчилгээндээ хэрэглэж, эрх бүхий холбогдох байгууллагуудад хэрэглээг тогтмол тайлагнан ажиллаж байгаа болно.	
166	476	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2025-07-30 Дугаар 2025_37	2.. “Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, ажлын явц, үр дүнг Засгийн газарт танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, шаардагдах зардлыг 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай.	ХХААХҮЯ “Монгол-Хятадын V экспо”-г БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-ы Хөх хотноо 2025.08.25-29-ны өдөр зохион байгуулсан.Тус экспод Монгол Улсаас 350 гаруй аж ахуйн нэгж ноос, ноолуур, арьс шир, гоо сайхан, бэлэг дурсгал, арьсан эдлэл, хүнс зэрэг 700 гаруй нэр төрлийн органик бараа бүтээгдэхүүнтэй оролцсон.Үндэсний үйлдвэрлэгчид экспогийн үеэр бараа бүтээгдэхүүнээ БНХАУ-ын хэрэглэгчдэд таниулах, худалдах, “Монголын өдөрлөг”, “Инноваци ба гарааны бизнес” форум, хоёр талын B2B уулзалтууд, соёлын солилцооны арга хэмжээнүүд зэрэг дагалдах үйл ажиллагаа өргөн хүрээнд зохион байгуулав. Мөн экспортод гаргахад олон улсын шаардлага стандартыг хангах экспортын өрсөлдөх чадвар, уламжлалт үйлдвэрлэлийн өв соёлыг харуулж, үндэсний брэндийг олон улсад гаргах, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэмжээнүүд болж өнгөрсөн. Монгол Улс болон БНХАУ хооронд байгуулсан “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай Хамтарсан тунхаглал”-д хоёр тал хамтарсан үзэсгэлэн, яармаг зохион байгуулахаар тохиролцсон бол, “Иж бүрэн стратегийн түншлэлийг урагшлуулах тухай Хамтарсан мэдэгдэл”-д худалдааны нийт хэмжээг ойрын хугацаанд 20 тэрбум ам.долларт хүргэх зорилт дэвшүүлсэн. Хяналтаас хасуулах санал : “Монгол-Хятадын Экспо” арга хэмжээ зохион байгуулагдсан.	Хэрэгжсэн - 100%
167	477	Экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-08-20 Дугаар 2025_51	8. Уул уурхайн бус бүтээгдэхүүн экспортлох, импортлох иргэн, аж ахуйн нэгжээс гаргасан хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж, төрийн үйлчилгээ хүнд сурталгүй үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгасугай.	1.Мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын нэг цонхны цахим систем”-ийг (export.mofa.gov.mn) нэвтрүүлсэн. Уг системийг нэвтрүүлснээр төрийн болон төрийн бус байгууллагын ажлын уялдаа холбоо сайжирч, мах, махан бүтээгдэхүүн экспортлох үеийн баримт бичиг бүрдүүлэх, 4 байгууллагаас экспортын гэрчилгээ авахад зарцуулдаг байсан 13 хоногийн хугацааг бууруулж, ажлын 8 цагт багтаасан.2.Малын генетик нөөцийн тухай хууль бусад хууль тогтоомжийн хүрээнд "Тусгай зөвшөөрөл, лиценз олгох цахим бүртгэлийн систем" /license.mofa.gov.mn/-ээр дамжуулан нийт иргэн, аж ахуйн нэгжийн 63 хүсэлт ирснээс хуулийн нөхцөл шаардлага баримт бичгийн бүрдэл хангаагүй 8 аж ахуйн нэгжийн хүсэлтийг буцаалт хийж, хуулийн шаардлагад нийцэж, баримт бичгийн бүрдлийг бүрэн хангасан 55 хүсэлтийг хүсэлтийг шийдвэрлэв. 3.2025 онд БНХАУ, ОХУ, Кувейт, Солонгос, Казакстан, Вьетнам, Япон, Хонконг, Катар, Ирак, Таджикастан, Иран, Арабын Нэгдсэн Эмират улс, Азарбайжан, Турк, Узбекистан, Туркеминстан, БНАСАУ, Бахрайн зэрэг 19 улсад экспортын экспортод гарахад 7350 экспортын гэрчилгээ олгосон.4.Ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох, дамжуулан тээвэрлэх нийт 4941 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.	Хэрэгжсэн - 100%
168	478	Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2025-08-20 Дугаар 2025_56	2.1.. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай: хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай авч хэрэгжүүлэх, нэгдсэн дүнг 2025 оны 11 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт;	Засгийн газрын 2025 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын хангах зарим арга хэмжээний тухай" 56 дугаар тогтоолын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр хуралдаанд "Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүн"-г Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн танилцуулсан. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Бэлтгэл ажил хангагдсан	Хэрэгжсэн - 100%
	479		2.2.. өвөл, хаврын улирлын бэлчээрийн даацыг бодитой тогтоож, байгалийн давагдашгүй хүчин зүйл, ган, зудын	Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс 2025-2026 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг бэлчээрийн ургамлын ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа	Хэрэгжсэн - 100%

			эрсдэлийн үнэлгээ хийж, 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэл багатай даван туулах, урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), холбогдох аймгийн Засаг дарга нарт;	зэрэг мэдээлэлд үндэслэн 8 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар тооцоолсон. Энэ жилийн зуншлагын байдал нийт нутгийн 54.0 хувьд хэвийн, нутгийн 46.0 хувьд гантай болон гандуу байв. Бэлчээрийн даац нийт нутгийн 39.8 хувьд бэлчээрийн нөөцтэй, 19.0 хувьд бэлчээр хүрэлцээтэй, 24.6 хувьд бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 6.3 хувьд 3-5 дахин хэтэрсэн, 10.3 хувьд олон дахин хэтэрсэн гэж дүгнэсэн. Өөрөөр хэлбэл 2025-2026 оны өвөл, хаврын улирлын бэлчээрийн даац нийт нутгийн 60.0 орчим хувьд хүрэлцээтэй, харин 40.0 гаруй хувьд хэтэрсэн байна. Аймгуудаас Баян-Өлгий, Увс, Ховдын ихэнх, Баянхонгор, Говь-Алтай, Төв, Сэлэнгэ, Дундговь, Өвөрхангай аймгийн зарим сумдын нутгаар даац олон дахин хэтэрч гарсан байна. Зудын урьдчилсан төлөвийг газрын ажиглалтын болон хиймэл дагуулын мэдээ буюу ган, зуншлага, өвөл, хаврын бэлчээрийн даац, бэлчээрийн ургац, агаарын температур, хур тунадасны дундаж зэрэг мэдээлэлд үндэслэн Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс боловсруулан гаргасан. Уг үнэлгээнээс үзэхэд нийт нутгийн 3.0 хувьд нэн их, 22 хувьд их, 21.0 хувьд дунд зэрэг, 26.0 хувьд бага, 28.0-д маш бага хүндрэлтэй байхаар байна. Өөрөөр хэлбэл Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудын ихэнх нутгаар цасны нөхцөл тооцоогүй байх үед зудын эрсдэл их болон нэн их түвшинд үүсэж байгаа нь өвөлжилт хүндрэх төлөв өндөр байгааг харуулж байна. Хавсралт : 1 файл	
	480		2.4.. өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд зам, гүүрний засварын ажлыг дуусгах, улсын болон орон нутгийн чанартай авто зам, даваа хаагдахаас урьдчилан сэргийлэх, зам засвар, ашиглалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, аймгийн Засаг дарга нарт;	Олон улсын болон улсын чанартай авто зам, даваан дахь “Шуурхай ажлын хэсэг”-ийг 43 байршилд авто замын засвар, арчлалтын 27 аж ахуйн нэгжийн 197 хүн, 140 нэгж техник хэрэгсэлтэйгээр жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний хугацаанд бэлэн байдлыг хангаж ажиллуулна. Хяналтаас хасуулах санал : Салбарын чиг үүргэт хамааралгүй	Х.Б
	481		2.5.. аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээрийн даацад тохируулан мал өвөлжүүлж, хаваржуулах чиглэлийг тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	“Малын бэлчээрийн даац тогтоох нэгдсэн аргачлал”-ын дагуу Улсын тусгай хэрэгцээний отрын 9 бүсийн бэлчээрийн даац тогтоох ажлыг 2025 оны 07 сарын 23-ны өдөр баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан. Отрын 9 бүсийн бэлчээрийн талбай тус бүрд 4-10 цэгт бэлчээрийн ургамлын дээжийг нэгдсэн аргачлалын дагуу тооцоолж, 2025 оны дундаж ургац 1,2-5,2 цн/га буюу 665809 толгой малыг өвөлжүүлж хаваржуулах бэлчээрийн даацын дүгнэлт гаргасан. Тооцсоноор 2025-2026 оны бэлчээрийн даац 1. Малахын тал отрын бүс нутаг: нийт 73,1 мян.га талбайтай, дундаж ургац 1.3 цн/га, 98320 хонин толгой, 2. Хэрлэн Баян-Улаан отрын бүс: нийт 192,8 мян.га талбайтай, дундаж ургац 5.025 цн/га, 249016 хонин толгой, 3. Чилэн отрын бүс: нийт 34,1 мян.га талбайтай, дундаж ургац 5,2 цн/га, 45758 хонин толгой, 4. Хөх дэл отрын бүс: нийт 37,9 мян.га талбайтай, дундаж ургац 3,2 цн/га, 26 000 хонин толгой, 5. Аргалант отрын бүс: нийт 118,6 мян.га талбайтай, дундаж ургац 0,9 цн/га, 35184 хонин толгой, 6. Баяннуруу отрын бүс: нийт 105,2 мян.га талбайтай, бүсийн дундаж ургац 1,4-2,1 цн/га, 27500 хонин толгой, 7. Ачит нуур отрын бүс: нийт 28,9 мян.га бэлчээрийн талбайтай, дундаж ургац 1,2 цн/га, 28 900 хонин толгой, 8. Багахайрхан отрын бүс: нийт 63,8 мян.га талбайтай, дундаж ургац 2,6-3,9 цн/га, 51373 хонин толгой, 9. Чойбалсан отрын бүс: нийт 124,4 мян.га талбайтай, дундаж ургац 1,83 цн/га, 103758 хонин толгой малын бэлчээрийн даац тодорхойлсон. 2025-2026 онд отрын бүсэд нийт 12 аймгийн 35 сумын 414 өрхийн 651892 хонин толгой малыг өвөлжүүлж, хаваржуулах дүгнэлт, шийдвэр гаргасан. Отрын 9 бүсэд 2025-2026 онд өвөлжиж, хаваржих отор нүүдлийн орох, гарах маршрутыг боловсруулан байгууллагын даргын 2025 оны 09 сарын 26-ны өдрийн А/82 дугаартай тушаалаар батлсан. Батлагдсан маршрутыг “OTORCHIN.GOV.MN” цахим системд байршуулан маршрутын дагуу отор нүүдлийг зохион байгуулж ажилласан. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжилт хангагдсан.	Хэрэгжсэн - 100%

	482		2.9.. мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн хугацаанд чанартай зохион байгуулж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, малын шилжилт, хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Мал эмнэлгийн ерөнхий газар (А.Нарантуяа)-т;	Мал, амьтны 4 нэрийн гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад нийт 43.8 сая толгой мал, амьтан хамруулснаар гоц халдварт өвчний гаралт 2025 онд 7 аймгийн 16 сумын 18 голомтод 33 малчин өрхийн 917 толгой мал өвчилсөн байна (Гахайн африкийн мялзан 3, Хонины цэцэг 11, шүлхий 1, шувууны томуу 3). Гоц халдварт өвчний гаралтыг 2024 онтой харьцуулахад голомтын тоо 14.5 дахин буюу 85.4% буурсан байна. Улсын хэмжээнд 2025 онд 19 нэрийн архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын хэмжээнд 20.3 сая толгой мал, амьтан хамруулснаар 19 нэр төрлийн халдварт өвчний 246 голомтод 1386 толгой мал өвчилж өмнөх он (479 голомтод 1125 тохиолдол)-оос тохиолдлын тоо өмнөх оноос өссөн бол голомтын тоо 51 хувиар буурсан байна. Зооноз, архаг халдварт өвчний тохиолдол 2025 онд 636 байна. Зарим гоц халдварт, зооноз халдварт өвчнөөс сэргийлэх вакцины болзошгүй эрсдэлийн нөөцөд Биокомбинат ТӨХХК-д галзуу өвчнөөс сэргийлэх вакцин 100 л, боом өвчнөөс сэрийлэх вакцин 50 л, адууны томуу өвчнөөс сэргийлэх вакцин 100 л, МЭЕГ-ын нөөцөд 2025 оны 12 сарын 01-ний байдлаар бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцин 10.422 мянган тун, шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин 5.248 мянган тунг худалдан авах гэрээ байгуулагдаж, нийлүүлэлт хийгдэж байна. Бэлэн байдлын нөөц бүрдүүлэлт: 2025 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 21 аймаг, нийслэлийн бэлэн байдлын нөөцөд Ні сор 4947 кг, Ханкон 4098 кг, Триплекан 270 кг, Новасид 80 кг, Хлорын шохой 12740 кг, Роксицид 20 кг, Суперкилл 7942 кг, жавелин 32 сав, нэг удаагийн халдвар хамгаалллын хувцас 16319 ширхэг байна. Аймгуудад байгаа тоног төхөөрөмж багаж хэрэгслүүд: Мананцаржуулагч 120, ДУК 143, Автомакс 557, Мотопомп 170 ашиглаж байна. МЭЕГ-ын 2025 оны жилийн эцсийн нөөц: Ні сор -1139 кг, Hanco WS 2482 кг ,трипле Кан 30 кг, суперкилл 220 кг, нэг удаагийн халдвар хамгаалллын хувцас 21498 ширхэг, олон удаагийн хувцас 144 ширхэг, 16 л автомакс 34 ш, шүршигч аппарат 1 ш, мананцаржуулагч 6 ширхэг, 14 ш хөргөгч, хөргүүр 12 ширхэг байна.	Хэрэгжсэн - 100%
	483		2.11.. ургацын урьдчилсан балансаар улсын хэмжээнд дутагдаж байгаа 100.0 мянган тонн хүнсний улаанбуудай, 2026 оны хаврын тариалалтад шаардлагатай 10.0 мянган тонн үрийн улаанбуудайн нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан нарт;	ХААК ТӨХХК-д 2025 оны эхний үлдэгдэл 73.5 мянган тонн хүнсний улаанбуудайн нөөцтэй байснаас одоогийн байдлаар 68.1 мянган тонныг гурил үйлдвэрлэлд худалдан борлуулж 5.4 мянган тонн үлдэгдэл нөөцтэй байна. 2025 оны дотоодын шинэ ургацаас 7.4 мянган тонн үрийн буудай, 29.5 мянган хүнсний улаанбуудайн нөөцийг бүрдүүлсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	484		2.13.. ургац хураалтын ажилд их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутан, сонсогч, хугацаат цэргийн алба хаагчдыг татан оролцуулах, тэдгээрийн цалин хөлс, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын сайд П.Наранбаяр, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Цаг агаарын төлөв байдалтай уялдуулан ургац хураалтын ажлыг богино хугацаанд шуурхай зохион байгуулах, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллага, орон нутгийн удирдлагуудад хандаж Албан даалгавар гарган үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг зохион байгуулсан. Ургац хураалтад 5.0-6.0 мянган хүн нэмэлтээр ажиллах тооцоо гарсныг Засгийн газрын хуралдаанд танилцуулж оюутан, хугацаат цэргийн албан хаагчдыг ургац хураалтад ажиллуулах шийдвэр гарсаны дагуу холбогдох их дээд сургууль, Зэвсэгт хүчний жанжин штабтай хамтран оюутан, хугацаат цэргийн албан хаагчийг ургац хураалтын ажилд оролцуулах, тэдгээрийн цалин хөлс, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг зохицуулж хяналт тавин ажиллаа. Батлан хамгаалах яам, Боловсролын яаманд хамтран ажиллах чиглэлээр ТНБД-ын 2025 оны 02/2774, 02/2774 албан тоотоор хүргүүлэн зохион байгуулснаар ургац хураалтад 5 их, дээд сургуулиас 1800 оюутан, Зэвсэгт хүчний жанжин штабын 15 анги нэгтгэлээс нийт 1245 цэрэг, байнгын 24500, түр ажилчид 3555, нийтдээ 31100 хүн ургац хураалтад оролцсон байна. Хяналтаас хасуулах санал : нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	485		2.14.. улсын хэмжээнд шаардлагатай улаанбуудай, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээлийн хэрэгцээ, хангамжид үндэслэн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын зохистой харьцааг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын нөөцийг бүрдүүлж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байхад анхаарч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 320.0 мянган тонн цэвэр хүнсний улаанбуудай шаардлагатай бөгөөд 2025-2026 оны гурлын хэрэгцээг хангахад 148.3 мянган тонн хүнсний улаанбуудай дутагдах урьдчилсан тооцоо гарсан. Мөн 2026 оны хаврын тариалалтад 312.8 мянган га талбайд 50.0 мянган тонн улаанбуудайн үр шаардагдах бөгөөд аж ахуйн нэгж, иргэдийн нөөцөлсөн үр 27.2 мянган тонн, ХААК ТӨХХК-д 10.8 мянган тонн үрийн нөөц байгаа бөгөөд дутагдаж байгаа үр 12.0 мянган тонн байна. Дээрх тооцооллыг үндэслэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 004 дугаар зөвлөмжөөр хүнсний улаанбуудайн импортлох хэмжээг 150 мянган тонноор тогтоосон бөгөөд үрийн улаанбуудайг 12.0	Хэрэгжсэн - 100%

				мянган тонныг 2026 оны 03 дугаар сард багтаан импортлох шийдвэр гарган аж ахуйн нэгжүүдэд квот олгох ажлыг зохион байгуулж байна. Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумын аюулгүй нөөцөд бэлтгэх 36.4 мянган тонн бүдүүн тэжээл (өвс)-ийн 86.7 хувь буюу 31.5 мянга, 30.8 мянган тонн хүчит тэжээлийн 42.8 хувь буюу 13.9 мянган тонныг тус тус бэлтгэж, 64.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Хавсралт : 1 файл	
	486		2.15.. мал, махыг эдийн засгийн эргэлтэд оруулах, махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний үйлдвэр, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, хилийн боомтуудын үйл ажиллагааг өргөжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд;	Монгол Улс 2025 онд 34.7 мян.тн адууны мах, 40 тн үхрийн мах, 25.1 мян.тн хонь, ямааны мах, 22.5 мян.тн дулааны аргаар боловсруулсан мах, 3.3 мян.тн малын дайвар, нийт 85.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүнийг /түүхий маханд шилжүүлэн тооцвол 110.7 мян.тн/ 345.3 сая ам долларoop экспортолсон ба өмнөх онтой харьцуулахад 20.4% буюу 14.5 мян.тн-оор нэмэгдсэн байна. ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/01 дүгээр тушаалын хүрээнд БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлохоор хүсэлт гаргасан 12, самар экспортлох хүсэлт гаргасан 1 аж ахуйн нэгжийн ирүүлсэн баримт бичигт үнэлгээ хийж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын 248 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу импортлогч улсын шаардлага хангаж буй тухай ажлын хэсгийн дүгнэлт гаргаж, тус улсын цахим системээр илгээсэн ба үүнээс мах, махан бүтээгдэхүүн экспортлох 1, самар экспортлох 2, таримал экспортлох 2 аж ахуйн нэгжийг импортлогч улсад шинээр бүртгүүлсэн. БНХАУ-д самар экспортлох 21, сүү экспортлох 1, загас экспортлох 5, гурил экспортлох 13, мах, махан бүтээгдэхүүн экспортлох 27, нийт 67 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна. Бүгд Найрамдах Узбекистан Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсад нийт 103.0 мянган толгой амьд малын экспорт хийгдсэн байна. Мах боловсруулах чиглэлээр 21 аймаг, нийслэлд 135 үйлдвэр, гүн хөлдөөх зориулалт бүхий 6.8 мянган тонн багтаамжтай 12, хөргөх, хадгалах зориулалт бүхий 86.0 мянган тонн багтаамжтай 125 агуулахад эрх бүхий иргэн, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.	Хэрэгжсэн - 100%
	487		2.16.. экспорт, импортын бүтээгдэхүүний төлбөрийг бараа солилцоогоор хийх боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учралд, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт;	Ургац хураалтын урьдчилсан дүнгээр энэ намрын ургацаас стратегийн нөөцөд “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 27.3 мянган тонн, гурилын үйлдвэрүүд 126.4 мянган тонныг тус тус худалдан авсан. Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 320.0 мянган тонн цэвэр хүнсний улаанбуудай шаардлагатай бөгөөд 2025-2026 оны гурлын хэрэгцээг хангахад 148.3 мянган тонн хүнсний улаанбуудай дутагдах урьдчилсан тооцоо гарсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28 ны өдрийн 004 дугаар зөвлөмжөөр хүнсний улаанбуудайн импортлох хэмжээг 150 мянган тонноор тогтоосон бөгөөд үрийн улаанбуудайг 12.0 мянган тонныг 2026 оны 03 дугаар сард багтаан импортлох шийдвэр гарсан.	Хэмжигдэхүйц биш
	488		3.. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хүндрэл багатай даван туулахад шаардлагатай санхүүжилтийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	ХХААХҮ-ийн сайдын 2025 оны батлагдсан төсвийн 9 сарын хуваарьт өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах зорилгоор 159 сая төгрөгийг шийдвэрлэж орон нутагт хуваарилж өгсөн. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр хуралдаанд "2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан нэгдсэн дүнг" Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн танилцуулсан. Тус хуралдаанаас хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэл багатай даван туулах арга хэмжээний санал, Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэх зардлын тооцоог боловсруулж танилцуулахыг үүрэг болгосны дагуу Засгийн газрын нөөц сангаас аймаг, нийслэлийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, Зарим аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газарт туулах чадвар сайтай автомашин олгохоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Монгол Улсын шадар сайд Х.Ганхуяг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Монгол Улсын сайд С.Бямбацогт нарт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01/3911 тоот албан бичгээр хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
169	489	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2025-08-27 Дугаар 2025_66	2.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т тус тус үүрэг болгосугай.	Засгийн газрын 2024 оны “Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл тоо хэмжээг тогтоох тухай” 255 дугаар тогтоолоор 600 толгой, 2025 оны “Тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай” 66 дугаар тогтоолоор 500 толгой, нийт 1100 толгой үржлийн адууг 2025 онд улсын хилээр импортлохоор тогтоосон. Улсын Их Хурлын 2025 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 73 дугаар тогтоолоор Засгийн газар жил бүр импортлох мал үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл тоо хэмжээг тогтоохдоо “үржлийн адуу, түүний үр, хөврөлийг импортлох тоо хэмжээг 2026-2036 он хүртэлх	Ахиц гарсан - 50%

				хугацаанд тэг /"0"/ хувьтай тэнцүү байхаар тогтоох” чиглэл болгосон. Үүнтэй холбогдуулан “Үржлийн адуу гадаадаас авах” тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, иргэд 2026 болон 2027 онд авахаар гэрээ хэлцэл хийж, урьдчилгаа төлбөрөө төлсөн нийт 150 адууг 2025 онд худалдан авч тээвэрлэн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтын хилийн бүсийн хяналтын горимд байршуулсан асуудлыг шийдвэрлэх талаар 20 гаруй аж ахуйн нэгж нэгдэн “Цэвэр цусны адуу гадаадаас авах, гадаадад гаргагчдын хүлэг холбоо” ГҮТББ-аар дамжуулан 2025 оны 01/14 тоот албан хүсэлт ирүүлээд байна. Мөн зарим аж ахуйн нэгж, иргэд улсын хилээр үржлийн адуу импортлох эрхээ ашиглаж амжаагүй, импортлох эрхгүй ч олон тооны адуу худалдан авсан асуудлыг шийдвэрлүүлэх тухай хүсэлт ирүүлсээр байна. Засгийн газрын тогтоолын хүрээнд 2025 онд нийт 1100 толгой адууг улсын хилээр нэвтрүүлэхээс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн мэдээллээр зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж 914 толгой үржлийн адууг импортлон авч, 186 толгой адууг улсын хилээр нэвтрүүлэхээр Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтын хилийн бүсэд хорио цээрийн дэглэмд орсон байна.	
170	490	Зорилт шинэчлэн батлах тухай 2025-09-10 Дугаар 2025_91	3.. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох салбар тус бүрийн зорилтыг эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Улаанбаатар хот болон томоохон суурин газруудын агаарын бохирдлыг бууруулах дунд хугацааны төлөвлөгөөний төсөлд өгөх саналыг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
171	491	2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлах тухай 2025-11-05 Дугаар 2025_154	4.. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албатай хамтран улирлын томуугийн эсрэг БНСУ-ын "GCFLU" үйлдвэрийн дөрвөн цэнт вакциныг яам, харьяа байгууллага, үйлчилгээний ажилтан, төрийн тусгай хамгаалалтын нийт 100 албан хаагч дархлаажуулсан. Дархан- Уул аймгийн "Монос" ХХК болон Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нартай хамтран яамны албан хаагчдад "Хамтдаа аян"-г зохион байгуулсан байна. Тус аяны хүрээнд дараах үйлчилгээг үзүүлсэн. Үүнд: 1. Хүчилтөрөгчийн коктейль үйлчилгээ, артерын даралт хэмжих, 2. Элэгний В, С вирус болон ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээ, 3. Танита аппаратын оношлогоо /Биологийн нас, усны түвшин, булчингийн масс, дотор өөх, кальцийн хэмжээ илрүүлэх/, 4. Квантум аппаратын оношлогоо /21 төрлийн эрдэс, 18 хүнд металын хэмжээ, 6 төрлийн витамины дутагдал, биеийн ерөнхий эсэргүүцэл илрүүлэх/, 5. Үс, хуйхны оношлогоо, зөвлөгөө, 6. Арьсны оношлогоо, зөвлөгөө 7. Хөнгөлөлттэй эмийн үйлчилгээнд хамруулсан. Мөн түргэвчилсэн шинжилгээгээр элэгний В вирус илрээгүй албан хаагчийг Дархан -Уул аймгийн "Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төв"-д элэгний В вирусын вакцинд хамрагдахыг зөвлөсөн байна.	Х.Б
172	492	Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай 2025-12-03 Дугаар 2025_184	2.. 2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төлөвлөгөөнд нийцүүлэн салбарын хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг баталж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийж ажиллахыг тухайн салбарын хяналтыг хариуцсан Засгийн газрын гишүүд болон Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Салбарын хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөөнд саналыг боловсруулж ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 184 дугаартай "Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай" тогтоол батлагдсаны дагуу салбарын хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлах тухай ХХАААХҮСайдын тушаал гаргуулахаар тушаалын төсөл, объектын жагсаалтыг гаргаж, абел системд оруулан, хянагдсан, батлуулах шатанд байна. Хавсралт : 4 файл Хяналтаас хасуулах санал : Батлагдаж гарах нь тодорхой болсон тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
173	493	Жагсаалт батлах тухай 2025-12-03 Дугаар 2025_187	2.. 2.Энэ тогтоолын 1,2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зурагтөсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тус тус хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүргүүлээгүй байна.	Зохион байгуулалтаас - 0%

	494		3.. 3.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, төслийн код (“УТ” код)-ын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар (Ц.Батзул)-т тус тус үүрэг болгосугай.	Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, төслийн код (“УТ” код)-ын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлнэ.	Х.Б
	495		4.. Худалдан авах ажиллагааг ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, хууль тогтоомжийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад заасан хугацаанд зохион байгуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн өрөнхийлөн захирагч нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад тус тус даалгасугай.	Худалдан авах ажиллагааг ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, хууль тогтоомжийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад заасан хугацаанд зохион байгуулахад анхаарч ажиллана. Хугацаа болоогүй	Х.Б
174	496	Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-12-17 Дугаар 2025_204	1.. Байгалийн давагдашгүй хүчин зүйл ган, мөндрийн улмаас 2025 онд ургац алдсан тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн 2023-2025 онд авсан Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй, хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацааг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн, хууль, журмын дагуу 6 сар хүртэлх хугацаагаар хойшлуулж, шаардагдах санхүүжилтийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэнд зөвшөөрсүгэй.	Байгалын давагдашгүй хүчин зүйл ган, мөндрийн улмаас 2025 онд ургац алдсан зээлдэгчийн 2023-2025 оны эргэлтийн хөрөнгийн зээлийг хойшлуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд арилжааны 10-н банктай 2023, 2024, 2025 онд байгуулсан эргэлтийн хөрөнгийн зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөх гэрээний төслийг боловсруулж арилжааны банкнаас гэрээний төсөлд санал авч байна. Хавсралт : 3 файл	Ахиц гарсан - 50%
	497		2.. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах арга хэмжээг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод, нээлттэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэнд үүрэг болгосугай.	Байгалын давагдашгүй хүчин зүйл ган, мөндрийн улмаас 2025 онд ургац алдсан зээлдэгчийн 2023-2025 оны эргэлтийн хөрөнгийн зээлийг хойшлуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд арилжааны 10-н банктай 2023, 2024, 2025 онд байгуулсан эргэлтийн хөрөнгийн зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөх гэрээний төслийг боловсруулж арилжааны банкнаас гэрээний төсөлд санал авч байна. Хавсралт : 3 файл	Ахиц гарсан - 50%
Ерөнхий сайдын захирамж					
175	498	Ажлын хэсэг байгуулах тухай 2022-05-11 Дугаар 2022_72	2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, үнийн хэт өсөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай: Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний саналаа тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (З.Мэндсайхан)-т даалгасугай.	Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 4 сарын 15-ны өдөр баталсан Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын 2022 оны “Гурил, махны үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 174 дүгээр тогтоолыг тус тус баталсан. Уг тогтоолд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид 130.0 тэрбум, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид 100.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1 жилийн хугацаатай, жилийн 3-6 хувийн хүүтэй олгож, зээлийн хүүгийн 10.65 хувьтай тэнцүү хэмжээний хөнгөлөлтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. 2.Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 7900.0 тн үхэр, хонь, ямааны махыг бэлтгэж, нөөцөлсөн ба махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн тоо хэмжээтэй тулгахад борлуулалтын дүнгээр үхрийн мах 1342.6 тн, хонины мах 4073.1 тн, ямааны мах 285.0 тн, нийт 5700.7 тн махыг худалдаалж, гүйцэтгэл 72.0 хувьтай байна. 3. Гурил үйлдвэрлэгч 5 аж ахуйн нэгжид нийт 35.2 тэрбум төгрөгийн зээл олгож, уг санхүүжилтээр	Хэрэгжсэн - 100%

				39.2 мянган тн улаанбуудайг дотоодын ургацаас худалдан авсан ба 28.2 мянган тн гурил үйлдвэрлэсэн. Монгол Улсын 2023 оны ургац хураалтын дүнгээр нийт 433.8 мян.тн улаанбуудай хураан авсан ба үүнээс гурилын үйлдвэрт 189.0 мян.тн улаанбуудай нийлүүлсэн. 2024 оны 10 сарын байдлаар хүнсний хэрэгцээнд нийт 115.7 мян.тн улаанбуудайн гурил үйлдвэрлэсэн байна. Хяналтаас хасуулах санал : байнгын бус ажиллагаатай ажлын хэсэг - арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай	
176	499	Ажлын хэсэг байгуулах тухай 2024-10-30 Дугаар 2024_97	2. 2.Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил”-ийг дэмжигч улс, холбогдох олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас санал авч тусган боловсруулан 2024 оны 4 дүгээр улиралд багтаан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Ж.Энхбаяр)-т даалгасугай.	2026 онд манай улсад зохион байгуулагдах "Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил”-ийг дэмжигч улс, холбогдох олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас сайн дурын ажлын хэсэг байгуулан төлөвлөгөөний төсөлд санал аван боловсруулж, арга хэмжээний төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын А/493 дугаар тушаалаар батлуулсан. Мөн “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил” (IYRP)-ийн нээлтийн арга хэмжээг FAO, ADB болон бусад төсөл хөтөлбөр, ТББ-тай хамтран Итали Улсын Ром хотноо 2025 оны 12 сарын 02-ны өдөр зохион байгуулав. "Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил” (IYRP)-ийн хүрээнд Азийн малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг Бэлчээрийн эмэгтэйчүүдийн холбоо, ӨА-н малчдын холбоо (SAPA), MARAG (Энэтхэг), ОУ-н Газрын эвсэл, ICCA Консорциум, ICIMOD, Synchronicity Earth, Wamip Global, IPCN, Anthara, RLN, LPPS, ActionAid India болон бүс нутгийн холбоотнуудын дэмжлэгтэйгээр 2025 оны 12 дугаар сарын 10-12-ны өдөр Энэтхэг улсад хамтран зохион байгуулав.	Хэрэгжсэн - 100%
177	500	Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64	5.. Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.	Яам, түүний харьяа байгууллагуудаас төрийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс Сэтгэл ханамжийн судалгааг google формоор (https://docs.google.com/forms/d/1F46xKDxjRGODY6WR7UHmqOeGSHGB_ynZ5wWTvls2j0E/edit) авч, үр дүнг нэгтгэж байна. Олон нийтээс төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, авлига, ашиг сонирхлын нөхцөл байдал үүсэж байгаа эсэх талаарх судалгааг авахаар яамны байрны хүлээлгийн хэсэг болон хаалганд судалгааны QR код бүхий асуумжийг Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байранд байршуулав. Одоогийн байдлаар авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил илрээгүй болно.	Хэрэгжсэн - 100%
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
178	501	2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2021-03-10 Дугаар 2021_17	XII.5. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж буй цахим хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн биржийн шинэчлэл, “Дархан арьс ширний цогцолбор”-ын бүтээн байгуулалт, өвлийн хүлэмж, төмс, хүнсний ногооны агуулах, логистикийн сүлжээний чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон Хөдөө аж ахуйг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрийн газрын эрх зүйн орчныг сайжруулах ажлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан цахим хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн биржийн шинэчлэл, “Дархан арьс ширний цогцолбор”-ын бүтээн байгуулалт, өвлийн хүлэмж, төмс, хүнсний ногооны агуулах, логистикийн сүлжээний чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, Хөдөө аж ахуйг дэмжих сан болон Жижиг дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, зээл, дэмжлэгийг ил тод, оновчтой зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд даалгав.”	БХБ, ХХААХҮ-ийн болон ЭХ-ний сайд нарын хамтарсан 2023 оны 44, А/68/А75 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Дархан арьс ширний цогцолбор” ОНӨХХК-тай хэлэлцээр хийж, Дархан-Уул аймгийн “Дархан арьс ширний цогцолбор” төслийн 180 га талбайд гүйцэтгэсэн дэд бүтцийн ажилтай танилцан, хэмжилт, тооцоолол хийж, санал дүгнэлтийг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд танилцуулсан. “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-ийн зүгээс ажлын хэсгийн түвшинд анх тохирсон хэлцлээсээ буцаж, хүлээн зөвшөөрөх боломжгүй санал тавьж ирсэн байна. “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК-ийн нэрийг шүүхийн шийдвэрийн дагуу Засгийн газрын 2024 оны 256 дугаартай тогтоолоор “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор“ ТӨХХК гэж өөрчилсөнтэй холбоотойгоор компаний дүрэм, үйл ажиллагааны чиглэлийг Засгийн газрын 2025 оны 96 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. 2025 оны Төсвийн тухай хуульд "Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц"-ийн бүтээн байгуулалтыг 2024-2027 онд 23,8 тэрбум, 2025 онд 7.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт баталсантай холбогдуулан 7,3 тэрбумын төсөвтэй 2.1 км авто зам, 225 сая төгрөг төсөвтэй гадна холбоо, дохиоллын ажлын хүрээнд газрын шилэн кабель 2,500 м, сувагчлалын шилэн кабель 3,950 м, худгийн тоо 12 ширхэг ажил бүрэн дууссан бөгөөд байгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллуулахаар хүлээгдэж байна. "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д Засгийн газрын 2025 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 48 дугаар тогтоол батлуулсан. Засгийн газрын 2025 оны “Жагсаалт батлах тухай” 271 дүгээр	Ахиц гарсан - 50%

				тогтоолоор Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт баталсан.	
179	502	2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34	YIII.5.1. . Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж ажиллах, энэ хүрээнд өөрийн эрхэлсэн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын нийт гишүүдэд; (“Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар 2021-2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав.)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа төрийн байгууллагуудад 2024 оны жилийн эцсээр нийт 61 хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч ажиллаж байсан байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн "144.2.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна" хэсэгт заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2025 оны байдлаар нийт 3 албан хаагчийг ажиллах нөхцөл боломжоор ханган ажиллуулж байна.	Хэрэгжсэн - 100%
	503		YIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэн орох, гарах үйлчлүүлэх зориулалтын зорчих хэсэг, налуу шатыг хальтирдаггүй замын резин будгаар будаж засвар үйлчилгээ хийж сайжруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэглэгээ бүхий зогсоол хийж, орчны хүртээмжийг сайжруулсан байна.	Хэрэгжсэн - 100%
180	504	2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр 35 дугаар тэмдэглэл 2021-06-16 Дугаар 2021_35	XYI.3. . Мах, махан бүтээгдэхүүний экспортын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал бордох зэрэг үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд даалгав.	2022 онд Архангай аймагт махны чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах зорилгоор Сэлэнгэ үүлдрийн 430 толгой үхрийг нийлүүлэн төсөлд сонгон шалгарсан 10 аж ахуйн нэгж, иргэнд, “Махны чиглэлийн цэвэр үүлдрийн Лиммузин үхэр үржүүлж, үржлийн аж ахуй эрхлэх” төслийг “Сэлэнгэ тариа” ХХК-тай гэрээ байгуулан 34 үхрийг, “Махны чглэлийн цэвэр үүлдрийн цэвэр хонь үржүүлж, үржлийн аж ахуй эрхлэх” төслийг “Тайшир-Өргөө” ХХК-тай гэрээ байгуулан 300 хонь тус тус хүлээн авч 6 аж ахуйн нэгжид олгосон байна. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд Говь-Алтай аймагт улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 160 толгой үржлийн сарлаг нийлүүлж, тус аймгийн сарлаг бүхий сумдын сарлаг үхрийн чанар, үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, 8 малчин өрхөд түрээсийн гэрээгээр олгосон. Дээрх төслийн хүрээнд улсын төсвийн 300.0 сая төгрөгийн санхүүжилтээр Төв аймагт мах-ноосны чиглэлийн Эдельбаев үүлдрийн 60 толгой өсвөр хуц нийлүүлсэн. ЭМАА эрхлэгчдийг дэмжих, малчид, мал аж ахуй эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлэх зорилгоор өндөр ашиг шимт мах, сүү, сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт үхрийн 11.0 мян.тун, мах-ноосны чиглэлийн хонины 3.0 мян.тун, нийт 14.0 мян.тун гүн хөлдөөсөн үр, 12 төрлийн ороо идэвхжүүлэгч, үр шингэлэгч бодис, шингэн азотын цехийн шүүлтүүр, хөргөлтийн мотор, усны сав зэргийг улсын төсвийн 725.0 сая төгрөгийн санхүүжилтээр импортолж, МУСҮТ-д хүлээлгэн өгөв. 12.8 мянган бод, 4.5 мянган бог, нийт 17.3 мянган малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, хээл авалт 72 хувьтай байна. ADRA ОУБ-ын 47.0 мянган ам.доллар /160.0 сая төгрөг/-ын санхүүжилтээр Австралийн үндэсний генийн сангаас ноосны чиглэлийн 5 үүлдрийн хуцны 6.0 мянган тун үр импортолж, генийн сан баяжуулсан байна. Хяналтаас хасуулах санал : тогтомжсон үйл ажиллагаа тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
181	505	2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр 57 дугаар тэмдэглэл 2021-10-27 Дугаар 2021_57	IX.6.2. Хүнсний ногооны ангилал, нэр төрлийг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн 8 орны нарийвчлалаар судлан тогтоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт) нарт;	Хүнсний хангамж, аюулгүй байдал хөдөлгөөний хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хүнсний ногоо, жимсний нөөшний “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн 8 орны нарийвчлалаар судлан тогтоож, эдгээр бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварын хэмжээг 20%, өндөгний импортын гаалийн албан татварыг 15% хүртэл нэмэгдүүлэх санал боловсруулж, “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
182	506	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14	XIY.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг	Нийслэлийн хүн амын 2021-2022 оны өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөцийг бүрдүүлж, 2022 оны 03 сарын 25-ны өдрөөс нийтийн хэрэгцээнд худалдан борлуулсан. Худалдаалж байх хугацаа буюу 3.25-7.01-ний өдрүүдэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хамтран хяналт тавин ажилласан. Мөн хүчит шонхор захад худалдаалж буй махны борлуулалтад	Хэрэгжсэн - 100%

			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	хяналт тавих замаар махны бөөний болон жижиглэнгийн үнэд судалгаа, тооцоо хийн үр дүнг удирдлагад тухай бүр танилцуулан ажилласан. Тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар хүн амыг эх орны үйлдвэрийн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангах зорилгоор холбогдох стандартын шаардлага хангасан тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйлдвэрлэсэн улаанбуудай, хүнсний ногоонд 849 иргэн, аж ахуйн нэгжийн 9 нэр төрлийн хүнсний ногооны цахим гарал үүслийн гэрчилгээг авч баталгаажуулан ажиллаж байна. 2025 онд улсын хэмжээгээр 274.1 мянган тонн үр тариа, үүнээс 252.3 мянган тонн улаанбуудай, 101.9 мянган тонн төмс, 208.6 мянган тонн хүнсний ногоо, 133.3 мянган тонн тэжээлийн ургамал, 27.2 мянган тонн тосны ургамал нийтдээ 745.1 мянган тонн ургац хураан авч, ургац хураалтын урьдчилсан дүнгээс харахад Монгол Улсын нийт хүн амын хэрэгцээт улаанбуудайн 62.5 хувийг, төмсний 76.9 хувийг, хүнсний ногооны 72.6 хувийг дотоодын ургацаас хангах боломжтой гэсэн тооцоо гараад байна. Өмнөх онтой харьцуулахад хүнсний ногоо, төмсний үнэ харьцангуй өндөр байна. Хяналтаас хасуулах санал : Утга, агуулгын хувьд дараалсан шийдвэрүүд гарсан бөгөөд цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. Дахин дахин тайлагнах нь тайлангийн утгыг алдагдуулж байна.	
183	507	2022 оны 3 дугаар сарын 9-ний өдөр 15 дугаар тэмдэглэл 2022-03-09 Дугаар 2022_15	XXII.2.3. Эрхлэх асуудлынхаа хүрээний Засгийн газрын тусгай сангийн чиг үүрэг, зориулалтыг эргэн авч үзэх болон сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд үнэлэлт өгөх талаар арга хэмжээ авч, шаардлагатай бол Засгийн газарт танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд.	“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлэх хугацаанд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс өөрчлөлт, шинэчлэлт оруулах талаар ирүүлсэн санал хүсэлтүүдийг үндэслэн 21 аймаг, нийслэлийн бизнес эрхлэгчдийг хамруулан Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу холбогдох байгууллага бизнес эрхлэгчдийн дунд танхимын болон цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж саналыг авч тусгасан. Засгийн газрын гишүүдээс санал авч Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. ЖУРМЫН ӨӨРЧЛӨЛТӨӨР • Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд үзүүлж буй санхүүгийн дэмжлэг, үйлчилгээг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, • Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн Төслийн сонгон шалгаруулах үе шат, түүнд зарцуулах хугацааг багасгах замаар бизнес эрхлэгчдийн дэмжлэг авах хугацаа богиносож боломж нэмэгдэх • Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн зорилтот бүлгүүдийн боломжийг нэмэгдүүлэх, • Сангийн авлагыг бууруулах зорилгоор зээлийн эргэн төлөлтийг барьцаалсан болон бусад хөрөнгөөр хангуулан авсан хөрөнгийг буцаан худалдан борлуулж дараагийн бизнес эрхлэгчдэд олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх боломж бүрдэхээр боловсруулсан. 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд холбогдох шийдвэрүүд гарсан тул хяналтаас хасах, тайлан утгагүй болж байна.	Хэрэгжсэн - 100%
184	508	2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16	XYIII.8.. Хот, хөдөөгийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Хот, хөдөөгийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөний төслийг хүн амын нутагшил, суурьшил болон бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан цогцоор нь авч үзэх, Нийслэл Улаанбаатар хотын хүн амын төвлөрлийг бууруулах, дагуул хот, шинэ суурьшил бий болгоход чиглэсэн оновчтой арга хэмжээний саналыг нарийвчлан судалж, тусгах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Улсын их хурлын чуулганаар шинэчилэн баталсан. УИХ-аар хэлэлцүүлэх ажлын хэсэгт яамны төлөөлөл ажиллан үзэл баримтлалд салбарт хэрэгжүүлэх зорилтыг тусгасан ба "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгож зарласан ба энэ хүрээнд төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”, хангайн бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс” болгохоор тухай бүр санал боловсруулан хүргүүлж Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогыг үргэлжлүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолын хавсралтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймаг руу шилжүүлэхтэй холбоотой асуудал тусгагдсаны дагуу тус яам шилжин ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах -хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%
185	509	2022 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 18 дугаар тэмдэглэл	XI.1.7. 7. Дархан арьс ширний цогцолборын үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны талаар авч буй арга хэмжээний талаар	МУИХ-аас үүрэг болгосны дагуу ХХААХҮЯ болон МУ-н Хөгжлийн банк хооронд салбарын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр ажиллах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Мөн “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-аас Хөгжлийн банкны зээлийн төлбөрт	Хэрэгжсэн - 100%

		2022-03-30 Дугаар 2022_18	танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт;	тооцон шилжүүлэхээр санал болгосон дуусаагүй гүйцэтгэлтэй дэд бүтцийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн бодит гүйцэтгэлийг батлагдсан зураг төсөл, төсөвтэй харьцуулж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий БХБСайд, ХХААХҮСайд, ЭХСайд нарын хамтарсан 2023.03.10-ны өдрийн 44, А/68/А75 дугаар тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсгийн зүгээс “Дархан арьс ширний цогцолбор” ОНӨХХК-тай хэд хэдэн удаа албан хэлэлцээр хийж, Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэр дэх “Дархан арьс ширний цогцолбор” төслийн 180 га талбайд ажиллаж, гүйцэтгэсэн дэд бүтцийн ажилтай танилцан, хэмжилт, тооцоолол хийж, гаргасан санал дүгнэлтийг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд танилцуулсан. “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-ийн зүгээс ажлын хэсгийн түвшинд анх тохирсон хэлцлээсээ буцаж, төрөөс тодорхой хугацаатай эзэмшүүлсэн газрыг болон гүйцэтгэсэн ажлын үнэлгээг үндэслэлгүйгээр өсгөх зэргээр хүлээн зөвшөөрөх боломжгүй санал тавьж өнөөдрийг хүрсэн байна. “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК-ийн нэрийг шүүхийн шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 256 дугаартай тогтоолоор “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор“ ТӨХХК гэж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор компанийн дүрэм, үйл ажиллагааны чиглэл Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 96 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан. Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд "Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц"-ийн бүтээн байгуулалтын ажлыг 2024-2027 онд 23,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар, үүнээс 2025 онд 7.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт баталсантай холбогдуулан дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор“ ТӨХХК байгуулсан тул хяналтаас хасах	
186	510	2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2022-04-08 Дугаар 2022_21	I.1. . Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн төсөл батлагдмагц хуулийг хэрэгжүүлэх шуурхай арга хэмжээний талаарх саналаа Монголбанктай хамтран боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт;	УИХ-аас 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр "Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийг баталсан. Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлөр холбогдох асуудлыг хэлэлцүүлж 3 удаагийн зөвлөмж гаргуулсан. Мөн махны болон гурилын үйлдвэр эрхлэгчдэд олгосон эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан хариуцлагын гэрээ байгуулан, биелэлтийг хангуулж ажилласан. Засгийн газрын 2022 оны “Гурил, махны үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 174 дүгээр тогтоолыг баталсан. Уг тогтоолд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид 130.0 тэрбум, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид 100.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1 жилийн хугацаатай, жилийн 3-6 хувийн хүүтэй олгож, зээлийн хүүгийн 10.65 хувьтай тэнцүү хэмжээний хөнгөлөлтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 7900.0 тн үхэр, хонь, ямааны махыг бэлтгэж, нөөцөлсөн ба махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн тоо хэмжээтэй тулгахад борлуулалтын дүнгээр үхрийн мах 1342.6 тн, хонины мах 4073.1 тн, ямааны мах 285.0 тн, нийт 5700.7 тн махыг худалдаалж, гүйцэтгэл 72.0 хувьтай байна. Гурил үйлдвэрлэгч 5 аж ахуйн нэгжид нийт 35.2 тэрбум төгрөгийн зээл олгож, уг санхүүжилтээр 39.2 мянган тн улаанбуудайг дотоодын ургацаас худалдан авсан ба 28.2 мянган тн гурил үйлдвэрлэсэн. Манай улс 2022 онд 349.8 мянган га талбайгаас 393.6 мянган тонн улаанбуудай хураан авснаас гурил үйлдвэрлэлд 193.0 мянган тонн, Хөдөө аж ахуйг дэмжих санд (хуучнаар) 21.9 мянган тонн, нийт 214.9 мянган тонн хүнсний улаанбуудайгаар гурил үйлдвэрлэн, хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн. Хяналтаас хасуулах санал : цаг хугацааны хувьд ач холбогдолгүй, хэрэгжилт хангагдсан бөгөөд нэг удаагийн шинж чанартай	Хэрэгжсэн - 100%
187	511	2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24	XIY.8. 2. Газрын мониторингийн үр дүнгээр улсын хэмжээнд бэлчээрийн даац хэтэрсэн газрын төлөв байдал, ашиглалтад орон зайн дүн шинжилгээ хийж, шинээр хөв цөөрөм, худаг гаргах асуудлыг хамтран судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Усны газар	Улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 аймаг, отрын бүс нутагт инженерийн хийцтэй 48 худаг шинээр барьж байгуулах ажлын хөрөнгийн хуваарийг ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/43 дугаар тушаалаар, аймаг, орон нутгийн хүсэлтэд үндэслэн шинээр гаргах худгийн байршлыг ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/116 дугаар тушаалаар тус тус баталсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/160, А/197 дугаар тушаалаар тус тус гэрээ байгуулах эрх олгох тухай	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлаг

			(Ш.Мягмар), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (А.Энхманлай) нарт;	тушаал гаргаж 19 багцад инженерийн хийцтэй 46 худаг шинээр барихаар 1,476,874,137.0 төгрөгийн гэрээ байгуулж, өрөмдлөгийн ажлыг эхлүүлээд байна. Сэлэнгэ аймагт шинээр гаргах 2 худгийн ажлын тендер 2025.05.30-ны өдрөөс өмнө нээгдээгүй тул цуцлагдсан.	атай - 50%
188	512	2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 25 дугаар тэмдэглэл 2022-04-27 Дугаар 2022_25	XX.1.5. “Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (С.Мөнхчулуун) нарт;	Улсын Их Хурлаас 2022 оны 4 сарын 15-ны өдөр батлсан Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын 2022 оны “Гурил, махны үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 174 дүгээр тогтоолыг тус тус батлсан. Уг тогтоолд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид 130.0 тэрбум, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид 100.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1 жилийн хугацаатай, жилийн 3-6 хувийн хүүтэй олгож, зээлийн хүүгийн 10.65 хувьтай тэнцүү хэмжээний хөнгөлөлтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. 2.Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 7900.0 тн үхэр, хонь, ямааны махыг бэлтгэж, нөөцөлсөн ба махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн тоо хэмжээтэй тулгахад борлуулалтын дүнгээр үхрийн мах 1342.6 тн, хонины мах 4073.1 тн, ямааны мах 285.0 тн, нийт 5700.7 тн махыг худалдаалж, гүйцэтгэл 72.0 хувьтай байна. 3. Гурил үйлдвэрлэгч 5 аж ахуйн нэгжид нийт 35.2 тэрбум төгрөгийн зээл олгож, уг санхүүжилтээр 39.2 мянган тн улаанбуудайг дотоодын ургацаас худалдан авсан ба 28.2 мянган тн гурил үйлдвэрлэсэн. Манай улс 2022 онд 349.8 мянган га талбайгаас 393.6 мянган тонн улаанбуудай хураан авснаас гурил үйлдвэрлэлд 193.0 мянган тонн, Хөдөө аж ахуйг дэмжих санд (хуучнаар) 21.9 мянган тонн, нийт 214.9 мянган тонн хүнсний улаанбуудайгаар гурил үйлдвэрлэн, хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн. Хяналтаас хасуулах санал : нэг удаагийн чанартай бөгөөд хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
189	513	2022 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 31 дүгээр тэмдэглэл 2022-05-31 Дугаар 2022_31	XXIII.3.2. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтын чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, ажлын явц, үр дүнг танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газар (Д.Батчулуун) нарт;	1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 8.8 сая толгой мал хамруулахаас 9.3 сая толгой мал хамруулж (нэмэлт хуваарь) 105.6% гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 1.3 сая үхэр дархлаажуулахаас 1.2 сая үхэр хамруулж 90%, бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 16.7 сая толгой мал дархлаажуулахаас 15.1 сая толгой мал хамруулж 90.4% гүйцэтгэлтэй. Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 19.3 сая толгой мал хамруулахаас 18.2 сая толгой мал хамруулж 94% гүйцэтгэлтэй тус тус дархлаажуулсан. 2. Гоц халдварт өвчний гаралт 2025(2024) онд 7(14) аймгийн 16 (91)сумын 16(100) голомтод 33(560) малчин өрхийн 917(28.237) толгой мал өвчилсөн байна. (Гахайн африкийн мялзан 3, Хонины цэцэг 11, шүлхий 1, шувууны томуу 1). Гоц халдварт өвчний гаралт 2024 онтой харцуулахад голомтын тоо 14.5 дахин буурсан буюу 85.4 % буурсан байна. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах - нэг удаагийн шинж чанартай бөгөөд шийдвэрүүд гарсан	Хэрэгжсэн - 100%
190	514	2022 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 32 дугаар тэмдэглэл 2022-06-08 Дугаар 2022_32	XY.1. . Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, экспортын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлыг удирдан зохион байгуулах, цаашид хяналтын тогтолцоог боловсронгуй болгох талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгээс авч хэрэгжүүлсэн ажлын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтан нарт даалгав: 1. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, хүнсний чанар, аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангуулах зорилгоор дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, экспортлох үйл ажиллагааг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл түр түдгэлзүүлэх, Монгол Улс, БНХАУ хоорондын 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн	МХЕГ-ын даргын батлсан 01/03, 01/82, НМХГ-ын даргын батлсан 01/501, ЦЕГ, ТЕГ, МХЕГ-ын даргын хамтарсан удирдамжийн хүрээнд улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах 56 аж ахуйн нэгж, үйлдвэрт 2022 оны 06 дугаар сард хяналт шалгалтыг хийсэн. Хяналт, шалгалтаар 29 аж ахуйн нэгжийн агуулахад дулааны аргаар боловсруулсан 8011 тн, 23 аж ахуйн нэгжийн агуулахад 5573 тн ангилж савласан адууны мах, нийт 43 аж ахуйн нэгжид 13584 тн мах хадгалагдаж байгаа нь тогтоогдсон. Үүнээс БНХАУ-ын эрх бүхий байгууллагаас экспортын эрх авсан 11 аж ахуйн нэгжийн дулааны аргаар бэлтгэсэн 5720.6 тн мах, 7 аж ахуйн нэгжийн бэлтгэсэн 3817 тн адууны түүхий мах нь чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангасан. Мөн шалгалтын дүнд үндэслэн 20 аж ахуйн нэгжид зөрчлийн хэрэг нээж, 10 аж ахуйн нэгжид 25.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлсэн 6 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах арга хэмжээг авсан. Засгийн газрын хуралдааны энэхүү тэмдэглэлийн дагуу 2022 оны 06 дугаар сард эхлүүлэх байсан дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний экспортыг түр түдгэлзүүлсэн болно. Монгол Улс, БНХАУ хоорондын байгуулсан дулааны аргаар боловсруулсан мах экспортлох, импортлох үеийн хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн протоколыг шинэчлэх саналыг 2022 оны 06 дугаар сард БНХАУ-д суугаа Элчин сайдаар дамжуулан	Хэрэгжсэн - 100%

			протоколыг хоёр талын хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх ажлыг хятадын талтай хамтран зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт;	тус улсын ГЕГ-ын Гадаад хамтын ажиллагааны газарт дэвшүүлсэн боловч БНХАУ-ын талаас шүлхий, мялзан зэрэг малын халдварт өвчний дэгдэлтийг дарах, энэ талаар Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага өвчингүй болсон тухай хүлээн зөвшөөрсний дараа энэ чиглэлийн хамтын ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой гэж илэрхийлсэн. Хяналтаас хасуулах санал : дараалсан шийдвэрүүд гарсан	
	515		ХҮ.1.4. Дулааны аргаар мах боловсруулах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг нийслэл хотоос үе шаттайгаар гаргах, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Мал эмнэлгийн ерөнхий газар (Д.Батчулуун), Стандарт, хэмжил зүйн газар (Б.Билгүүн)-т;	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулсан Аргалант-Эмээлт дагуул хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу эдийн засгийн тусгай бүс байгуулах суурь бэлтгэл ажлын хүрээнд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг эрэлхийлэх чиглэлээр зохих бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг авч ажиллаж байна. Засгийн газрын 2023 оны 193 дүгээр тогтоолын хүрээнд Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн Техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол /539га/-ыг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн 2023 оны 68 дугаар тогтоолоор батлалсан (НЗД-ын паркийн газрыг 539 га болгон нэмэгдүүлсэн). Нийслэлийн ИТХ-ын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлсан. /https://emeeltpark.mn/16/single/562/. Мах боловсруулах үйлдвэрлэлд “Мал эмнэлгийн нэгдсэн систем”, “Махны үйлдвэрийн үйл ажиллагааны систем”-үүдийн хүрээнд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махыг хүлээн авч үйлдвэрлэлд ашиглах, түүхий эд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлалд хяналт тавьж, бэлтгэсэн бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангагдсан бүтээгдэхүүнд дотоодын болон олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг олгон баталгаажуулж, худалдааны чөлөөт байдлыг дэмжин, зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : хэрэгжилт хангагдсан -	Хэрэгжсэн - 100%
	516		ХҮ.1.7. Төрийн өмчийн лабораторийн шинжилгээ хийх чадавхыг сайжруулах, нэгдсэн тогтолцоотой болгох талаар судалж, танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт.	"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хавсралтад улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх, хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавхжуулах зэрэг асуудлыг тусган ажиллав. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
191	517	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33	XIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг 2025 оны 12 дугаар сарын 14-ний өдөр нээлттэй сонсгол зохион байгуулж танилцуулав. Нээлттэй сонсголын үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах төвийн Нүүр хуудсаар олон нийтэд шууд дамжуулсан. Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%

			салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах.		
192	518	2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2022-07-05 Дугаар 2022_36	XX.5.5. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрт тусгасан нөхцөлийн дагуу “Мах, сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн үхэр, сүүний саалтуур, хөргүүртэй танк, малын тэжээл бэлтгэх болон бусад зориулалтын хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийн гэрээний урьдчилгаа төлбөрийг шийдвэрлэх боломжийг судлан танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд, төслийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банк хооронд Тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулах асуудлыг судлан танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус.	Монгол Улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банк хооронд Тусгайлсан зээлийн хэлэлцээрээр 2021 онд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрт тусгасан нөхцөлийн дагуу “Мах, сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн үхэр, сүүний саалтуур, хөргүүртэй танк, малын тэжээл бэлтгэх болон бусад зориулалтын хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” хэрэгжүүлж байна. Дээрх төслийн хүрээнд Дамжуулан зээлдүүлэх OL-27-07-16КЛ-21 дугаартай 3,845,404.25 евротой тэнцэх хөрөнгийн эх үүсвэрий зээлдүүлэхээр гэрээ байгуулсан болно. Гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу сангийн яаманд төлөлт хийж 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 770.0 мянган еврогийн үлдэгдэлтэй байна. Хяналтаас хасуулах санал : хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	519		XX.12.2. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын байрыг болон хөдөө аж ахуйг дэмжих зээлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд холбогдох байгууллагуудтай байгуулсан гэрээний биелэлтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт тус тус даалгав.	Монголбанк, ХХААХҮЯ, СЯ хамтран 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан 220414/08-159, 72, 1822/175 дугаартай “Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний Хөдөө аж ахуйг дэмжих зээлийн Хүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-ний хэрэгжилт болон Монгол банк, Сангийн яамны 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр хамтран баталсан “Ажлын байрыг дэмжих зээлийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих журам”-д заасан шаардлага, нөхцөлийг хангасан аж ахуйн нэгж, иргэдэд зээлийг олгосон эсэх, ААН, иргэд олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд 2022 он, 2023 онд Монголбанк, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яамны хамтарсан ажлын хэсэг хяналт шалгалт хийсэн. Монгол банкны ерөнхийлөгч, ХХААХҮСайд, Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд хамтарсан шалгалтыг 2022 оны эхний хагас жилд хэрэгжүүлж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн хооронд зээлд хамрагдсан 151 аж ахуйн нэгж, 70 иргэний нийт 221 зээлдэгчид олгосон 230.2 тэрбум төгрөгийн зээлийг, 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр хамтран баталсан удирдамжийн хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд Голомт банк, ХААН банк, Төрийн банк, Капитал банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Ариг банк, Тээвэр хөгжлийн банк зэрэг арилжааны 8 банкаар дамжуулан зээлд хамрагдсан нийт 85 аж ахуйн нэгж, байгууллага, 192 иргэний нийт 277 зээлдэгчид олгосон 107.4 тэрбум төгрөгийн зээлийг тус тус хяналт шалгалтад хамруулсан.Монголбанк, ХХААХҮЯ, СЯ-ны хамтарсан ажлын хэсгээс 2022 оны хяналт шалгалтын дүнг ХХААХҮ-ийн ТЕЗ-ийн дэргэдэх ДАХ-ны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, тогтоолыг СЯ, Монгол банканд хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Хяналтаас хасуулах санал : хяналтыг хэрэгжүүлсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
193	520	2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39	XYIII.3.1.7. "Эмээлт эко аж үйлдвэрийн парк” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг судлан төслийг хэрэгжүүлэх хувилбарын талаарх саналаа 2022 оны 8 дугаар сарын 17-ны дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөнгөлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт;	Улаанбаатар хотыг хөгжүүлэх 24 мега төслийн хүрээнд Эмээлт эко аж үйлдвэрийн парк төслийн бүтээн байгуулалтыг хотын төвөөс 30 км зайд байрлах Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны Шар хөвийн хоолойд 539 га талбайд барих юм. Төслийн хүрээнд 24 МВт дулааны цахилгаан станц, хоногт 6700 метр.куб хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 12.5 км авто зам, үерийн хамгаалалтын байгууламж, хоёр усан сан, инженерийн шугам сүлжээг барьж байгуулна. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн Бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн дөрвөн давхар барилгыг ашиглалтад оруулсан. Улаанбаатар хотоос арьс ширний үйлдвэрүүдийг Эмээлт паркт нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд аж ахуйн нэгжүүдтэй газар ашиглах эрхийн гэрээ байгуулан ажиллаж байна. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн суурь дэд бүтэц 24 МВт-ын Дулааны цахилгаан станц, Бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын "Хуа Зи Технологи” ХХК , “Хуа Ши Энержи Индастри” ХХК-ийн түншлэлтэй, Нийслэлийн Засаг даргын А/1082 захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг " нь Гэрээ байгуулах хэлэлцээрийг хийсэн.	Хэрэгжсэн - 100%

				Хяналтаас хасуулах санал : заасан хугацаа дууссан төдийгүй хувилбарыг сонгож, бүтээн байгуулалт хийгдэж байгаа тул хяналтаас хасах	
	521		XYIII.3.2.8. Инфляцын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн үр дүнгийн талаарх дүгнэлт, тайлбар бүхий мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яаманд тухайн долоо хоног бүр хүргүүлж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн (мах, гурил, сүү, улаанбуудай)-ий үнэ ханшийн мэдээлэл, өртөгийг тооцож, холбогдох мэдээллийг бэлтгэн удирдлагуудад тухай бүр танилцуулж, ажилласан. Хяналтаас хасуулах санал : Нөхцөл байдал өөрчлөгдсөн бөгөөд цаг үеийн шинж чанартай хэрэгжсэн шийдвэрийг хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
194	522	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	XY.1.3. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Ерөнхий сайдын орон нутагт ажилласан томилолтын хүрээнд өгөгдсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй, биелэлт ирүүлээгүй, хангалтгүй ажилласан төрийн албан хаагчдад сануулга өгөх, сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг хуулийн хүрээнд авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хэмжээнд төрийн албан хаагчдад өгөгдсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй, биелэлт ирүүлээгүй, хангалтгүй ажилласан тохиолдолд сануулга өгөх, сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг хуулийн хүрээнд авч ажиллахыг сануулан, мэдээлэл хүргэсэн.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	523		XY.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	ХХААХҮЯ-ны нийт албан хаагчдад 2 жилд нэг удаа явагддаг эрт илрүүлэх, үзлэг, оншилгооны талаар зөвлөмж мэдээлэл хүргүүлсэн байна. Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд Дархан-Уул аймаг дахь "Нэгдсэн II төв эмнэлгийн дэмжих төв", "Экспресс оношлогооны төв"-д яам, харьяа байгууллага, үйлчилгээний ажилтан болон төрийн тусгай хамгаалалтын нийт 148 ажилтан албан хаагчийг хамруулсан.	Хэрэгжсэн - 100%
	524		XY.4. . “Мах, махан бүтээгдэхүүний экспортын өнөөгийн нөхцөл байдал”-ын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан зохих хяналт, шалгалт, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чанар, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан нь тогтоогдсон аж ахуй нэгжийн дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрөөс зохих журмын дагуу экспортлох арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт) нарт даалгав.	БНХАУ-ын Эрээн боомтын Коронавируст халдварын нөхцөл байдлаар шалтгаалан БНХАУ-ын эрх бүхий байгууллагаас Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн экспортлохыг тодорхойгүй хугацаагаар зогсоосон байсан бөгөөд экспортлогч аж ахуйн нэгжийн бэлтгэсэн 3817 тн адууны мах, 6965 тн дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны махыг экспортлох боломжгүй байсан. Харин 2 улсын Засгийн газрын хамтын ажиллагааны дүнд Монгол Улсаас 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мах, махан бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн. Монгол Улс КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс өмнөх 2 жилд 129 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолж байсан бол цар тахлын хязгаарлалт, тээвэр логистикийн хүндрэл, эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалан энэ хэмжээ 45%-иар огцом буурч 2020 онд 38.8 мян.тн, 2021 онд 21.8 мян.тн, 2022 онд 16.0 мян.тн мах, махан бүтээгдэхүүнийг тус тус экспортолсон байна. Монгол Улс 2023 оны гаалийн гүйцэтгэлээр 80.4 мян.тн /түүхий ястай маханд шилжүүлэн тооцвол 117.0 мян.тн/ мах, махан бүтээгдэхүүнийг 322.8 сая.ам.доллороор экспортолсон нь урьд өмнө хүрч байгаагүй өндөр түвшин бөгөөд 2022 онтой харьцуулахад 5 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2. Монгол Улс 2024 онд 71.1 мян.тн мах, махан бүтээгдэхүүнийг 283.2 сая ам доллараар экспортолсон ба нийт экспортын 61%-ийг БНХАУ, 32%-ийг Иран, Ирак зэрэг булангийн орнууд, 7%-ийг бусад улсууд эзэлж байна. Гаалийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн мэдээгээр Монгол Улсаас 85.6 мян.тн махыг 345.3 сая ам доллараар экспортолсон. Хяналтаас хасуулах санал : 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрөөс зохих журмын дагуу - заасан хугацаанд хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%

195	525	2022 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 43 дугаар тэмдэглэл 2022-08-31 Дугаар 2022_43	XII.1.1. Инфляцын нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав: 1. Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, 2023 оны хүн амын гурил, махны хэрэгцээнд зориулан нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн оновчтой схемийг Монголбанктай хамтран шийдвэрлэж, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт;	Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Улсын Их Хурлаас 2022 онд баталсан "Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль", Засгийн газрын 2022 оны “Гурил, махны үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 174 дүгээр тогтоолыг тус тус баталсан. Уг тогтоолд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид 130.0 тэрбум, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид 100.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1 жилийн хугацаатай, жилийн 3-6 хувийн хүүтэй олгож, зээлийн хүүгийн 10.65 хувьтай тэнцүү хэмжээний хөнгөлөлтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 7900.0 тн үхэр, хонь, ямааны махыг бэлтгэж, нөөцөлсөн ба махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн тоо хэмжээтэй тулгахад борлуулалтын дүнгээр үхрийн мах 1342.6 тн, хонины мах 4073.1 тн, ямааны мах 285.0 тн, нийт 5700.7 тн махыг худалдаалж, гүйцэтгэл 72.0 хувьтай байна. 3. Гурил үйлдвэрлэгч 5 аж ахуйн нэгжид нийт 35.2 тэрбум төгрөгийн зээл олгож, уг санхүүжилтээр 39.2 мянган тн улаанбуудайг дотоодын ургацаас худалдан авсан ба 28.2 мянган тн гурил үйлдвэрлэсэн. Манай улс 2022 онд 349.8 мянган га талбайгаас 393.6 мянган тонн улаанбуудай хураан авснаас гурил үйлдвэрлэлд 193.0 мянган тонн, Хөдөө аж ахуйг дэмжих санд (хуучнаар) 21.9 мянган тонн, нийт 214.9 мянган тонн хүнсний улаанбуудайгаар гурил үйлдвэрлэн, хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн. Хяналтаас хасуулах санал : 2023 оны хүн амын гурил, махны хэрэгцээнд зориулан нөөц бүрдүүлэхэд шаардлагатай - заасан хугацаа дууссан	Хэрэгжсэн - 100%
	526		XII.1.4. Махны үнэ, нийлүүлэлтэд онцгойлон анхаарч махыг малчдаас дундын зуучлалгүйгээр эцсийн хэрэглэгчдэд шууд хүргэх оновчтой схемийг гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллах, махны нөөц бүрдүүлэх асуудлаар шийдэл гарган арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт.	Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 4 сарын 15-ны өдөр баталсан Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын 2022 оны “Гурил, махны үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 174 дүгээр тогтоолыг тус тус баталсан. Уг тогтоолд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид 130.0 тэрбум, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид 100.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1 жилийн хугацаатай, жилийн 3-6 хувийн хүүтэй олгож, зээлийн хүүгийн 10.65 хувьтай тэнцүү хэмжээний хөнгөлөлтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. 2.Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 7900.0 тн үхэр, хонь, ямааны махыг бэлтгэж, нөөцөлсөн ба махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн тоо хэмжээтэй тулгахад борлуулалтын дүнгээр үхрийн мах 1342.6 тн, хонины мах 4073.1 тн, ямааны мах 285.0 тн, нийт 5700.7 тн махыг худалдаалж, гүйцэтгэл 72.0 хувьтай байна. 3. Гурил үйлдвэрлэгч 5 аж ахуйн нэгжид нийт 35.2 тэрбум төгрөгийн зээл олгож, уг санхүүжилтээр 39.2 мянган тн улаанбуудайг дотоодын ургацаас худалдан авсан ба 28.2 мянган тн гурил үйлдвэрлэсэн. Манай улс 2022 онд 349.8 мянган га талбайгаас 393.6 мянган тонн улаанбуудай хураан авснаас гурил үйлдвэрлэлд 193.0 мянган тонн, Хөдөө аж ахуйг дэмжих санд (хуучнаар) 21.9 мянган тонн, нийт 214.9 мянган тонн хүнсний улаанбуудайгаар гурил үйлдвэрлэн, хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн. Хяналтаас хасуулах санал : цаг хугацааны хувьд дараа дараагийн шийдвэрүүд гарсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
196	527	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Яамны албан хэрэг хөтлөлтийн ABLE системийг Албан бичиг солилцооны дундын систем /DOCX/-д холбон Төрийн байгууллагууд хооронд баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн. Яаманд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 9893 ирсэн бичиг, 3994 явуулсан бичиг, 711 өргөдөл гомдлыг цахимаар бүртгэлжүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
197	528	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4	V.2. Улсын аварга малчин шалгаруулах талаар авах зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын	Улсын хэмжээнд жил бүр хийгддэг мал тооллогын ажлын үр дүнг чанаржуулах, мэдээллийн баталгаат байдлыг хангах ажлыг малын бүртгэлээр дамжуулан хянах хүрээнд 2023 оны мал	Тодорхой үр дүнд

		дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4	тогтоол гаргахаар тогтов. 2.2024 оноос эхлэн улсын хэмжээнд хийх мал тооллогын ажлыг чанаржуулах, мал тоолж байгаа арга аргачлалыг боловсронгуй болгож малын тоо, толгойг үнэн зөв тоолох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд даалгав.	тооллогын ажлыг уламжлалт хэлбэрээр зохион байгуулж, малын тоо толгойн мэдээллийг "Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-гаар баталгаажуулан дүгнэхээр Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллав. 2023 оны мал тооллогын ажлын үр дүнг "Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-гийн тоон мэдээлэлтэй тулгах ажлыг хийж, системийн үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж, төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2024 оны мал тооллогын ажлын хүрээнд ҮСХ-ны төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн системд бүртгэлтэй малын тоон мэдээллийг урьдчилан тус хороонд хүргүүлж, мэдээллийн сангийн нийцэл хангах ажлыг 2 дох жилдээ хийхээр бэлтгэл хангасан. Мөн 2024 оны мал тэжээвэр амьтны тооллогын ажлыг улсын хэмжээнд эхлүүлсэнтэй холбогдуулан мал танилтын системийг хөгжүүлэхэд ашиглах зурган дата үүсгэн сан үүсгэж байна. Мал аж ахуйн мэдээллийн нэгдсэн сангийн малчин, мал бүхий этгээдийн малын тооны шинэчлэлийг ҮСХ-ны 2024 оны мал тооллогын мэдээллээр шинэчлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулав. ТНБД-ын 02/257 тоот албан бичгийг орон нутагт хүргүүлэн мэргэжил арга зүйгээр ханган, цахим сургалтыг зохион байгуулж мэдээлэл тулгах ажлыг 2025.03.10-ны өдрийн дотор бүрэн хийв. Мөн 2024 оны мал тэжээвэр амьтны тооллогын үеэр цуглуулсан зурган мэдээлэлд үндэслэн мал танилтын систем хөгжүүлэхэд ашиглах зурган сан үүсгэж, танилтын системийн танилтыг хонь, ямааны зурган өгөгдөл дээр туршиж байна.	хүрсэн - 50%
	529		VII.2. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хууль бус үйлдэл, үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагад шалгуулах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд үүрэг болгов.	Хөдөө аж ахуйг дэмжих сангийн үйл ажиллагаанд 2021 онд хяналт шалгалт хийж, шалгалтын танилцуулгыг 2022 оны 3 дугаар сарын 11-ний Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хугацаа хэтэрсэн чанаргүй авлага, харьяалах газруудыг хуулийн байгууллагад шалгуулах шийдвэрийн дагуу ХААДС-ын авлага, өр төлбөрийг барагдуулахаар 2023 онд "Авлага, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө батлуулах тухай" ХХААХҮС-ын А/107 дугаар тушаал, Улсын төсвийн болон сангийн эх үүсвэртэй төсвийн байгууллагуудад ашиглуулж байгаа бараа материал, техник тоног төхөөрөмжийг хууль, журмын хүрээнд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх шийдвэрийг гаргуулан авлагыг бууруулах, зээлдэгч нарын хувийн хэргийг цахим архив үүсгэж, хугацаа хэтэрсэн чанаргүй зээлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдэд дахин зээл өгөхгүй байх ХХААХҮС-ын А/147 дугаар тушаал батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. Өр төлбөрт 2023 онд буудайн өртэй ахуй нэгж, иргэдийн 20 тэрбум төгрөг барагдуулсан. Өр төлбөрөөс 2023 онд Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх арга хэмжээнд олгосон зээлийн өр төлбөрөөс Улсын төсөвт 4.8 тэрбум төгрөгийн өрийг Сангийн яаманд, БНХАУ-ын техник, тоног төхөөрөмжийн зээлийн төлбөрт 2.7 тэрбум төгрөг, ОХУ-ын хөдөө аж ахуйн техникийн зээлд /ДиБиЭм лизинг ХХК/ 8.4 тэрбум төгрөг, БНБУ-ын трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх зээлийн үндсэн төлбөрт 1.6 тэрбум төгрөгийг төлсөн. ХХААХҮ-ийн сайд болон Хөгжлийн банкны захирлын хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсэг Хөгжлийн банкны зээл болох Ди Би Эм Леазинг ХХК-ийн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр ХААДС-аас санал тавьсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг танилцуулан, Хөгжлийн банк судлаж, Сангийн яаманд танилцуулахаар шийдвэрлэсэн. Хугацаа хэтэрсэн чанаргүй авлагыг харьяалах газрыг шүүхэд шилжүүлсэн. Хяналтаас хасуулах санал : ХААДСанг 2023 оны 7 дугаар сард УИХ-ын тогтоолоор татан буулгасан.	Хэрэгжсэн - 100%
198	530	2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 5 дугаар тэмдэглэл 2023-01-25 Дугаар 2023_5	Х.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын саналыг тусгуулан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу нэгтгэн боловсруулж, Засгийн газрын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хяналтаас хасуулах санал : цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон	Хэрэгжсэн - 100%
	531		Х.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот	2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг тухай бүр эрчимжүүлэн арга хэмжээ авч ажилласан.	Хэрэгжсэн - 100%

			түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов.	Хяналтаас хасуулах санал : цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон бөгөөд холбогдох шатны шийдвэрүүд гарсан тул хяналтаас хасах	
199	532	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	ХХААХҮЯ-ны захиалгаар хэрэгжүүлсэн судалгааны ажлын тайлангуудыг Sudalgaa.gov.mn системд оруулж байна. 2023 оны 12 дугаар сарын байдлаар ХХААХҮ-ийн салбарын судалгаа хөгжлийн төвийн гүйцэтгэсэн 5 судалгааны тайланг захиалан хийлгүүлсэн нэгжүүд хүлээн авч акт, тэмдэглэл үйлдсэний дараагаар системд тайлагнасан. 2024 онд “Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх” ажил гүйцэтгэх 240514/03-389 дугаар гэрээ, “Хүнсний аюулгүй байдлыг хангах талаарх гадаад улсын зохицуулалтын харьцуулсан судалгаа” хийх ажил гүйцэтгэх 240514/03-390 дугаар гэрээ, АДАПТ төслөөс санхүүжүүлэх “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх” хийх ажил гүйцэтгэх 240514/03-387 дугаар гэрээ, “Гадаадын зарим улс орны хүнсний хуулийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа” хийх ажил гүйцэтгэх 240514/03-388 дугаар гэрээг тус тус байгуулав. Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд Хууль, тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу Өмгөөллийн "Эс ти эс партнерс" ХХК-аас боловсруулан ирүүлсэн Жижиг, дунд үйлдвэр үйлчилгэг дэмжих тухай хуульд “Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”-ний судалгааны ажлыг хүлээн авч комиссын 2024-07-01-ны өдрийн 07/01 тоот акт үйлдэж, үлдэгдэл санхүүжилтийг олгох тухай 2024-07-01-ний өдрийн Т240701/03-287 тоот гэрээг байгуулан судалгааны тайланг хүлээн авч яамны цахим хуудсанд байршуулав. Салбарын хуулиуд дахь эрх олгосон заалтыг бууруулах, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах болон салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох судалгааг боловсруулах, салбарын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх, цахим системийн үйл ажиллагааг тогтвортой явуулах зэрэг 11 арга хэмжээг 2025 онд төлөвлөн, эдгээр арга хэмжээг төрийн бус байгууллагуудтай хамтран 11 зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлж, судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулсан.	Хэрэгжсэн - 100%
200	533	2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9	III.6. Засгийн газрын бодлого, шийдвэр нийгмийн хүлээлттэй хэрхэн уялдаж байгаа талаар судалгаа хийж, гарсан дүн шинжилгээнд тулгуурлан үндэслэл бүхий тайлбар, холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	2023 онд "Алсын хараа 2050", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө" болон бусад хөгжлийн бодлогын баримт бичгийн 2022 оны жилийн эцэс, 2023 оны хагас жилийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тайланг сайтад байршуулсан. Холбогдох журамд заасны дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн ХШҮ тайланг яамны цахим хуудсанд нээлттэй байршуулж хэвшсэн. https://www.mofa.gov.mn/activity/assessment. ХХААХҮЯ-ны захиалгаар хэрэгжүүлсэн судалгааны ажлын тайлангуудыг Sudalgaa.gov.mn системд жил бүр оруулж байна.	Хэрэгжсэн - 100%
201	534	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөө болон салбарын бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэх, санал солилцох уулзалтыг 2025.01.31-ний өдөр Дархан-Уул аймагт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд зохион байгуулаа. Мөн “Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон жендэрийн мэдрэмжтэй бодлогоор дамжуулан хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын жендерийн тэгш байдлыг сайжруулах нь” төслийн холбогдох хүмүүс оролцож санал солилцов. Уулзалтад Жендэрийн үндэсний хорооны ажлын алба, ХХААХҮЯ-ны жендэрийн салбар зөвлөлийн гишүүд, яамны болон харьяа байгууллагын жендэрийн асуудал хариуцсан албан хаагчид танхим болон цахимаар оролцсон. Тайланг хавсаргав. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
202	535	2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13	IX.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж байгаа дараах төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын дор дурдсан гишүүдэд даалгав: 3.“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн, Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;	Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол хэрэгжиж эхлээд гурван жилийн хугацаа өнгөрсөн энэ хугацаанд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах, улмаар хүнс экспортлогч орон болох зорилготой “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний үр дүнг олон нийтэд танилцуулах хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд болон тус тогтоолыг хэрэгжүүлэгч байгууллага, тус тогтоолын хүрээнд хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж оролцсон арга хэмжээг зохион байгуулсан. https://president.mn/35216/. “Хүнсний	Хэрэгжсэн - 100%

				хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй 1.26 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2577 иргэн, аж ахуйн нэгжид олгож, гол нэр төрлийн хүнсний 19 бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлж, сүүлийн 2 жилийн хугацаанд мах, махан бүтээгдэхүүний экспортын орлого нийт 600.0 сая гаруй ам долларт хүрсэн. Сүү боловсруулах 10, мал төхөөрөх, мах боловсруулах 18, гурилан бүтээгдэхүүний 12, бусад нэр төрлийн бүтээгдэхүүний 13, нийт 53 үйлдвэр шинээр байгуулагдсан. Мөн зоорийн багтаамж 15%, үтрэмийн багтаамж 7%, тариалангийн талбай 13%, зуны болон өвлийн хүлэмж 28%-аар тус тус нэмэгдлээ. Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 37%, ажлын байр 21%, дундаж борлуулалтын орлого 31%, дундаж цэвэр ашиг 32%, үндсэн хөрөнгө 55%, эргэлтийн хөрөнгө 38%, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 46%, нийгмийн даатгал 60%-иар тус тус өссөн байна.	
	536		Х.1.1. Бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн талаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: Гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүн (мах, гурил, будаа, сүү, өндөг, хүнсний ногоо зэрэг) болон эм, тариа, барилгын материал, цементийн үнийн өсөлтөөс сэргийлэх талаар авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний салбарт хамаарах бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх талаар холбогдох судалгаа, тооцоололд суурилсан санал боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд 2023 оны 03 дугаар сард багтаан хүргүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн нарт даалгав;	Монгол Улсын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн талаарх мэдээллийг шаардлагатай тохиолдолд нэгтгэн боловсруулж байна. Дотоодын зах зээл дээрх хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн индекс болон олон улсын зах зээл дээрх үнийн индексийг харьцуулан тухай бүр шинэчлэн боловсруулж байна. Мөн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн огцом өөрчлөлттэй холбоотойгоор шаардлагатай мэдээг тухай бүр бэлтгэн, холбогдох субъектэд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Тухайлбал, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор импортлох мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас баталсан. Энэ хүрээнд дотоодын гурил болон гурилан бүтээгдэхүүний үнэд үзүүлэх нөлөөллийг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 39 дүгээр тушаалаар байгуулсантай холбоотойгоор 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт мэдээлэл хүргүүлж ажилласан. Мах, гурил, будаа, сүү, өндөг, хүнсний ногоо зэрэг хүнсний гол нэрийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор Монгол Улсын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн талаарх мэдээллийг 7 хоног бүр тогтмол нэгтгэн, 7 хоног, сар, жилийн дүнгээр өөрчлөлтийг харьцуулж байна. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар гол нэрийн барааны үнэ өмнөх сараас 1.0 хувиар, өмнөх 7 хоногоос 1.5 хувиар тус тус өссөн байна /Эх сурвалж: ҮСХ-ны 7 хоног бүрийн үнийн мэдээ. НҮБ-ын ХХААБ-ын Хүнсний үнийн индексийн мэдээ/. Хяналтаас хасуулах санал : Заасан хугацаанд хэрэгжсэн тул хяналтаас хасах - Сангийн яаманд 2023 оны 03 дугаар сард багтаан хүргүүлэх	Хэрэгжсэн - 100%
203	537	2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2023-03-29 Дугаар 2023_14	XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: 3.Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт;	Гадаад улсын Засгийн газрын тэтгэлэгт магистр сургалтын хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан 5 албан хаагчийг нэр дэвшүүлсэн. Засгийн газрын тэтгэлэгт магистрын сургалтын хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан 1 албан хаагчтай гэрээ байгуулж магистрын сургалтад хамруулж байна. Сургалтын гэрээнд төрийн албан хаагчийг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах заалт оруулсан (2023 он). Японы Засгийн газрын магистрын хөтөлбөрийн тэтгэлэгт 1 албан хаагч тэнцэж, хөтөлбөр 2024 оны 08 сард эхлэв. Олон улсын байгууллагын төслийн хүрээнд БНСУ-д 1 албан хаагч докторын сургалтад суралцах болж, сургалтын гэрээ байгууллаа. Сургалтын гэрээнд төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах заалт оруулсан (2024 он). Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нийт албан хаагчдад Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтын талаарх мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна. Яамнаас 1 албан хаагч Япон улсад Магистрын тэтгэлэгт хамрагдан суралцаж байна (2025 он)	Хэрэгжсэн - 100%
	538		XVIII.7.4. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй	Японы Засгийн газрын магистрын хөтөлбөрийн тэтгэлэгт 1 албан хаагч тэнцсэн бөгөөд 2025 онд ЖАЙКА-гаас зохион байгуулж буй дунд хугацааны хөтөлбөрт 2 албан хаагч тэнцэж, төгссөн. Олон улсын байгууллагын төслийн хүрээнд БНСУ-д 1 албан хаагч докторын сургалтад тэнцэж, сургалтын гэрээ байгуулан суралцаж байна. Энэтхэгийн Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрт албан хаагчид холбогдох материалуудыг явуулж яам болон харьяа	Хэрэгжсэн - 100%

			холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлах сургалт, аялалд хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	байгууллагаас 5 албан хаагч хамрагдсан. Түүнчлэн, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Тайландын Хаант Улсын Бангкок хотноо "Ази, номхон далайн орнуудын хөрөнгө оруулалтын чуулга зохион байгуулах тухай семинар"-т 1, АХБ-наас зохион байгуулсан "Үндэсний дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөө болон үндэсний зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг нэмэгдүүлэх" сургалтанд 1 тус тус хамрагдсан болно.	
204	539	2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2023-04-05 Дугаар 2023_15	XI.8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн явц болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтыг бүх түвшинд сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав: Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр хэрэгжүүлэх, төсвийн хэмнэлтийн хүрээнд энэ чиглэлийн ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны төсөвт цалин хөлс, нэмэгдэл цалин 8.8 тэрбум төгрөг, НДШ 1.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт 45.4 тэрбум төгрөгөөр батлагдсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар 42.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу хэрэгжилтийг ханган, батлагдсан санхүүжилтийг олгох ажлыг зохион байгуулсан. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : Заасан хугацаанд хэрэгжсэн тул хяналтаас хасах - Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах,	Хэрэгжсэн - 100%
205	540	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтоолоор баталсан “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-ний биелэлтийг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хүрээнд Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ конвенцид нийцүүлэхээр Хүний эрхийн комиссоос санал солилцож зөвлөгөө авсан. Хүний эрхийн комиссоос гаргасан “Хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжилтийг хангах, сургалт зохион байгуулах үүргийг хэрэгжүүлэх аргачлал”-д туссан асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусган боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Мөн ХХААХҮЯ-наас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалахаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Дархан хот дахь ХХААХҮЯ-ны байрны автомашины зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан 4 авто зогсоолын тэмдэглэгээ хийгдсэн. Яамны үүдний 2 налуу гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орж гарахад тохирсон стандартын дагуу засаж сайжруулах талаар мэргэжлийн байгууллагатай холбогдон үнийн судалгаа хийсэн байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг ААН-үүдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих хүрээнд “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2025” нэгдсэн арга хэмжээнд оролцуулахаар мэдээлэл хүргэж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг хамруулан, нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажилласан. Мөн Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн түншлэл-Намрын ногоон өдрүүд 2025” нэгдсэн үзэсгэлэн худалдаанд хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг ААН-үүдийг үзэсгэлэнд оролцуулж бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулах боломжоор хангаж ажилласан.	Хэрэгжсэн - 100%
206	541	2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл	XYIII.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав. (Авлигын төсөөллийн	Транспэрэнси Интернэшнл байгууллагаас авлигын төсөөллийн индексийг тооцоход ХХААХҮЯ-наас мэдээлэл хүсэгүй байна. Төрийн захиргааны удирдлагын газрын Захиргааны эрх зүйн асуудал хариуцсан албан тушаалын чиг үүрэгт авилгын эсрэг арга хэмжээ хариуцах чиг үүргийг	Хэрэгжсэн - 100%

		2023-05-03 Дугаар 2023_19	индексийг тооцоход нөлөө үзүүлэх шалгуур үзүүлэлт (индекс)-ийг тодорхойлоход оролцдог байгууллагуудтай хамтран ажиллах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж, холбогдон гарах зардлыг судлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт)	нэмж, Албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан. Хяналтаас хасуулах санал : хэрэгжсэн тул хяналтаас хасах	
	542		XYIII.9. Нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан эрхэлсэн хүрээний асуудалд хамаарах бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийн төслийг Сангийн сайдтай урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр боловсруулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	“Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36-р тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд дотоодод тарьж ургуулах, өсгөж үржүүлэх болон боловсруулах, үйлдвэрлэх боломжтой барааны гаалийн импортын албан татварын хувь, хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл, холбогдох судалгааг 47 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр, татварыг 2024 оноос үе шаттайгаар эхлүүлэхээр үзэл баримтлалын төсөл, тогтоолын төслийг Сангийн сайдад нийт 6 удаа албан бичгээр хүргүүлж, үзэл баримтлалыг хамтран баталсан (2023 он). Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 01/473 тоот албан бичгээр Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар саналыг боловсруулан хүргүүлсэн. Түүнчлэн хүнс, хөнгөн, жижиг дунд үйлдвэрлэлийг татварыг бодлогор дэмжихтэй холбоотой Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Сангийн яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна (2025 он).	Хэрэгжсэн - 100%
207	543	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21	XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд хүнсний боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг мэдээлэл олгох, хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаж байна. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг өдөрт нэг аяга сүүгээр хангахтай холбогдсон шийдвэрийн хүрээнд нийслэлийн хэмжээнд ерөнхий боловсролын 12 сургуулийн 18840 сурагчид “Сүү” зорилтот төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 1-5 дугаар ангийн сурагчдад 5 өдрөөс 3 өдөрт сүү өгч байгаа төдийгүй нийслэл, дүүрэг болон эцэг эхээс буюу 3 талт хэлбэрээр санхүүжилтийг шийдвэрлэсэн сайн арга хэмжээ болсон байна. Хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэр технологийн паркуудын урьдчилсан тооцоо судалгаа, нарийвчилсан ТЭЗҮ төсөвт тухайн орон нутгийн иргэдийн хүний хөгжил, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөг тооцон тусгаж, төсөл бүрд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэн БОАЖЯ-аар баталгаажуулан ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%
208	544	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	Цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам /ЗГ-ын 2022 оны 352/-ын дагуу нээлттэй мэдээллийг салбарын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, гадаад хамтын ажиллагаа, шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл, шилэн данс, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт, төлөвлөгөө, тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, хүний нөөц, авлигын эсрэг, ХАСХОМ, статистик мэдээлэл, урамшуулал, тусгай зөвшөөрөл, салбарын шагнал, өргөдөл гомдол, бүртгэл, мэдүүлэг гэх мэт 69 цэсэнд ойлгомжтой байдлаар байршуулж, тогтмол шинэчилж байна. 025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 357 шинэ мэдээ, 165 тендерийн урилга, 29 хүний нөөцийн зар, 23 хяналтын хуудас, 21 ХШҮ-ний тайлан, 4 сонгон шалгаруулалтын зар, 29 хэлэлцүүлэг, 3 статистикийн нээлттэй мэдээлэл, 8 ЗГ-ын тогтоол, 1 УИХ-ын тогтоол, яамны 2025 оны үйл ажилагааны төлөвлөгөө, 2024 оны тайлан, албан хаагчдын 2024 он, 2025 оны хагас, бүтэн жилийн гйцэтгэлийн төлөвлөгөө, дотоод худалдааны мэдээ мэдээллээр шинэчилсэн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 8 дугаар зүйлд заасан 69 заалтын 87 үзүүлэлтийн дагуу шил ажиллагааны нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д 2025 оны жилийн 3 дугаар улирлын тайланг илгээж 51%-тай үнэлэгдсэн. 2025 оны жилийн 4 дүгээр улирлын тайланг 12 дугаар сарын 31-ний өдөр илгээсэн. Мэдээллийн сан,	Хэрэгжсэн - 100%

				системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах ажлыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан ажиллаж байна.	
209	545	2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2023-06-07 Дугаар 2023_24	XXV.12.2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 151 дүгээр захирамжаар байгуулагдсан “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах салбар болон орон нутгийн хүрээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох чиг үүрэг, үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэл боловсруулах Ажлын хэсгээс баталсан “2023 онд яам, агентлаг, харьяа байгууллагын эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа эрхлэх чиглэл, ажиллах хүчний боломж, чадамж, гишүүнчлэл, хаяг байршил, тулгарч буй бэрхшээл, давуу талууд зэрэг мэдээллийг хамарсан дэлгэрэнгүй судалгааг 2025 оны 10 дугаар сард шинэчлэн нэгтгэсэн. Мөн салбарт төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжит ажлын холбогдох мэдээллийг хэрэгжилтийн газруудаас авч нэгтгэсэн бөгөөд 2026 онд ТББ-уудаар гүйцэтгүүлэх 754,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 арга хэмжээ байна. ХХААХҮЯ-наас хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт яг ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар 21 аймгийн ХХААГ-уудаас мэдээлэл татан авч ажилласан. Орон нутгийн 7 аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-ууд тайлангаа ирүүлсэн. ХХААХҮЯ-тай гэрээ, санамж бичиг байгуулсан ТББ байхгүй байгаа тул цаашид ТББ-ын удирдлагуудтай уулзалт хийж, цаашид хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. “Хувийн хувшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” 2022 оны 340 дүгээр тогтоолын хүрээнд Монголын ноос ноолуурын холбооны дэргэдэх Баталгаажуулалтын албыг бэхжүүлэх, итгэмжлэлийн хүрээг тэлж оёдол, арьс ширний салбарыг баталгаажуулалтад хамруулах чиглэл баримтлан ажиллаж байна. Мөн баталгаажуулалт хийх шинжээчдийг бэлтгэх, мэргэшүүлэх, "Монголын хаан ширхэгт", "Текстилийн тогтвортой үйлдвэрлэл", "Газар зүйн заалттай бүтээгдэхүүн" зэргийг баталгаажуулан дотоодод болон олон улсад сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхээр "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Хавсралт : 2 файл	Ахиц гарсан - 50%
	546		XXV.12.4. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т даалгаж, хэрэгжилтийн явц, тайланг хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд улирал тутам оруулж, ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Хэрэгжилтийн явц, тайланг хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд улирал тутам тайлагнан ажиллаж байна. Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул хяналтаас хасах - Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Хэрэгжсэн - 100%
210	547	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25	XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах хүрээнд ХХААХҮ-ийн салбарт хэрэжиж буй томоохон хөтөлбөр болох Хүнсний хангамж, Цагаан алт, Шинэ хоршоо чинээлэг малчин, Атар-4 Тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг олон нийтэд таниулах, сурталчлах арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн “Атар-4 Тариалангийн тогтвортой хөгжлийн аян”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Шинэ хоршоо - чинээлэг малчин”, “Цагаан алт” зэрэг үндэсний хэмжээний томоохон хөдөлгөөнийг хэрэгжүүлж, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил дэвшлийг харуулсан томоохон зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, 2024 оны 10 дугаар сард "Алтан намар" арга хэмжээ, 2025 оны 3 дугаар сард УИХ-ын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүдийн танилцах уулзалт, 2025 оны 4 дүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайдын айлчилсан "Атрын 4 дүгээр аян" арга хэмжээг тус тус зохион байгуулж, салбрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниуллаа. Хяналтаас хасуулах санал : илүү ач холбогдол, үр дүнтэй арга хэмжээг хяналтад авч, тайлагнах хэрэгтэй байна.	Хэрэгжсэн - 100%
211	548	2023 оны 6 дугаар сарын 21-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2023-06-21 Дугаар 2023_27	XXVII.4.1. Баруун болон төвийн бүсийн аймгуудын малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой бодлого боловсруулан танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт,	Мал, мах бэлтгэн нийлүүлэлт нөөц, экспортын талаарх танилцуулгыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Монгол Улсын мал сүргийн бүтэц, бэлчээрийн даац, цаг уурын төлөв байдлыг харгалзан Монгол Улсын 2024 онд экспортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээний саналыг боловсруулж Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулсан. “Экспортын нэг цонхны систем”-ийг ашиглан малын	Хэрэгжсэн - 100%

			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт;	гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагуудад экспортын гэрчилгээ авах ажиллагаанд зарцуулах цаг, бүрдүүлэх материалын жагсаалтын давхардлыг багасган хялбар шуурхай ажиллах бүрэн боломжтойгоор систем хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. Ингэснээр хөдөө аж ахуйн гаралтай 27 нэр төрлийн бараа, түүхий эдийн экспортын гэрчилгээ олгох ажлыг үе шаттайгаар нэвтрүүлэхэд бэлэн болсон. Энэхүү системийг ашиглан баруун болон төвийн бүсийн аймгуудын малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой бодлогыг Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яамдууд ашиглах бүрэн боломжтой юм. Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах - тодорхой бодлого боловсруулан танилцуулах	
212	549	2023 оны 8 дугаар сарын 09-ний өдөр 31 дүгээр тэмдэглэл 2023-08-09 Дугаар 2023_31	XIV.4.2. Гамшигт нэрвэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагыг “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн хөнгөлөлттэй зээлд хамруулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх талаар санал боловсруулж, танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт даалгав.	Улсын хэмжээнд 14,613 хоршоо, 235,457 гишүүн бүртгэлтэй бөгөөд үүнээс 10,269 хоршоо, 100,705 малчин гишүүн “Шинэ хоршоо” хөдөлгөөнд хамрагдаж, нийт малчдын 32.6 хувийг эзэлж байна. Хөнгөлөлттэй зээл 854.8 тэрбум төгрөг олгогдож, 7,888 хоршоо, 25,255 малчин хамрагдсан. Зээлийн 60.1 хувь нь үржлийн мал худалдаж бойжуулахад, 9.6 хувь нь үйлдвэрлэлийн зориулалттай хөрөнгө оруулалтад, үлдсэн нь дэд бүтэц, тэжээл, тоног төхөөрөмжийн шинэчлэлд зарцуулагдсан байна. Малжуулах хөтөлбөрт 2025 онд 21 аймаг, нийслэлийн 2 дүүргийн хэмжээнд 822 иргэнг 63.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий бог малд шилжүүлснээр 50.4 мянган толгой малаар малжуулсан байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2022 оны зээлдэгч "Тэргүүн ти жи" ХХК нь сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд 2023 онд Улаанбаатар хотод болсон үерийн гамшигт, Булган аймгийн "Энхжин хүнс" ХХК гахайн аж ахуй эрхэлж байгаад 2023 онд малын халдварт өвчний улмаас малыг устгалд оруулсан тул үйл ажиллагаа бүрэн зогссон байсныг даатгалын байгууллагаас нийт 55 сая төгрөгийн нөхөн олговрыг олгосон байна. Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд тайлант хугацаанд хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах - санал боловсруулж, танилцуулах	Хэрэгжсэн - 100%
213	550	2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр 38 дугаар тэмдэглэл 2023-09-20 Дугаар 2023_38	XII.7.16. Тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, тариалангийн бүс нутаг дахь газар ашиглалтын асуудлыг зохицуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;	Улсын Их хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын 3.1.2-т "Тариаланд тохиромжтой байдлын судалгаанд үндэслэн атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх", 3.10.2-т "Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах" гэж, Засгийн газрын "Аян өрнүүлэх тухай" 47 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Атар-4 Тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.1-т "Тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, шинээр 200.0 мян.га хүртэл атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх" гэж, 1.1.6-д "Хөрсийг хамгаалах ойн зурвас байгуулах, тариалангийн талбайг хашаажуулах, тариалалтын системд олон наст тэжээлийн таримлыг оруулах, таримал бэлчээр хадлан бий болгох" гэж тус тус салбарын бодлогын баримт бичгүүдэд тусгаж, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд тайлант хугацаанд хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах - боловсронгуй болгох саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах	Хэрэгжсэн - 100%
214	551	2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40	2.47. Тариаланчдад зориулан олгож байгаа дизель түлшний хөнгөлөлтөд хадланчдыг хамруулах, Дорнод аймагт үйлдвэр технологийн парк байгуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;	Дорнод зүүн бүсийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк нь Дорнод аймгийн төвд 50 га газарт төлөвлөсөн бөгөөд жилд 3000 тн ноос, 500 тн ноолуур боловсруулах үйлдвэр, сав баглаа боодлын үйлдвэр, өлөн гэдэс, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүд баригдахаар төлөвлөсөн. Тус паркт 2024 онд дараах дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийж гүйцэтгэхэд урьдчилсан байдлаар 9.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай. Үүнд: 1. Цахилгаан хангамж Шинэ ЦТП нөөц цахилгаан үүсгүүр /1.900 сая төгрөг/, 2.Цэвэрлэх байгууламж /6.0 тэрбум төгрөг/, 3.Дулааны шугам сүлжээ /500 сая төгрөг/, 4.3ам талбай /13000м2 гаалийн баталгаат талбай/ /900 сая төгрөг/, 5.Технологийн уураар холбох /400 сая төгрөг/ 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын төсөлд дэд бүтцийн төсвийн санал хүргүүлсэн боловч шаардлагатай төсвийг батлаагүй.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%

				Хавсралт : 1 файл	
	552		2.63. Өвөрхангай аймгийн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулдаг үйлдвэрүүд дунд ашиглагдах Магадлан итгэмжлэгдсэн лаборатори байгуулж, тоног төхөөрөмжөөр хангах, “Өв Эко мийт” орон нутгийн өмчит махны үйлдвэрт шаардлагатай байгаа нэмэлт тоног төхөөрөмжийг нийлүүлэх, мах, ноос, арьс, шир боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулах, борлуулалтыг нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;	Өвөрхангай аймгийн “Өв Эко мийт” орон нутгийн өмчит махны үйлдвэрт шаардлагатай байгаа нэмэлт тоног төхөөрөмжийг нийлүүлэх, мах, ноос, арьс, шир боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулах, борлуулалтыг нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл нь арилжааны банкны эх үүсвэрээр, зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх замаар арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайн аж ахуйн нэгж нь зээлд хамрагдахаар хүсэлтээ ирүүлснийг арилжааны банканд нэрийг уламжлан хүргүүлсэн. (Тухайн аж ахуйн нэгжийн зээл авах асуудал арилжааны банкны асуудал тул биднээс шалтгаалах зүйл байхгүй). Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг хүнсний боловсруулах 11 үйлдвэрлэгч, нийт 1.72 тэрбум төгрөгийн зээл авч, үйл ажиллагаа өргөжүүлэх, шинэчлэх арга хэмжээг авсан. Хяналтаас хасуулах санал : бизнесийн үйл ажиллагаанд яамны зүгээс төслийг банканд уламжлах зэргээр ажилласан тул хэрэгжилт хангагдсан гэж үзэж хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
215	553	2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2023-11-15 Дугаар 2023_46	Х/I.13. “Монгол-Хятадын Экспо” тав дахь удаагийн арга хэмжээг 2025 онд Монгол Улсад зохион байгуулах боломжийн талаар судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт даалгав	Монгол Улсын үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг экспортлох боломж нөхцлийг нэмэгдүүлэх, хоёр орны бизнесийн харилцан түншлэлийг өргөтгөх, зах зээлд хамтран ажиллах зорилгоор 2025 оны 08 дугаар сарын 25-31-ний өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх Хотноо “Монгол-Хятадын V Экспо” Хөх хотын зүүн хойд бүсэд шинээр байгуулагдсан “Чи Лэйчуан” олон улсын хурал үзэсгэлэнгийн талбайд “Ногоон хөгжлийг эрчимжүүлж, хамтдаа ирээдүйг бүтээх нь” уриан дор зохион байгуулав. Үзэсгэлэнд Монгол, БНХАУ, Орос, Солонгос, Бразил, Уругвай, Иран, Австрали, Казакстан, Хонгконг, Тайвань зэрэг 15 орон оролцсон. Үзэсгэлэнгийн гол хэсэг болох Хөх хотын Цэлгэр тал олон улсын үзэсгэлэнгийн төвд 325 мянган хүн ирж, 252 сая юанийн борлуулалт хийсэн байна. ӨМӨЗО-ны Худалдааны газраас мэдээлснээр экспогийн үеэр 65 тэрбум 860 сая юанийн эдийн засаг худалдааны 32 гэрээ байгуулсан байна. Энэ удаагийн экспод Монгол Улсаас 350 гаруй аж ахуйн нэгж ноос, ноолуур, арьс шир, гоо сайхан, бэлэг дурсгал, арьсан эдлэл, хүнс зэрэг 700 гаруй нэр төрлийн органик бараа бүтээгдэхүүнтэй оролцож, 2,7 тэрбум төгрөгийн борлуулалттай оролцсон байна. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд байгуулсан “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-ыг хэрэгжүүлэх хүрээнд “Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг 2015 оноос 2 жил тутам БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотод зохион байгуулахаар "Монгол Улсын Аж үйлдвэрийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яам хоорондын Монгол-Хятадын үзэсгэлэн яармагийг хамтран зохион байгуулах тухай харилцан ойлголцлын Санамж бичиг"-т тохиролцсон байдаг. Улаанбаатар хотод зохион байгуулах асуудлаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдааны танхимын Дэд дарга Канжигө тэргүүтэй төлөөлөгчдийг Монгол Улсад урьж, ээлжит арга хэмжээг зохион байгуулах асуудлаар санал солилцож, мөн анхны баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн албажуулахаар айлын талд хүргүүлсэн. Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжүүлэх хугацаа дууссан байх тул хяналтаас хасах - Засгийн газрын хуралдаанд танилцуулах	Хэрэгжсэн - 100%
216	554	2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэл 2023-11-29 Дугаар 2023_48	XIII.1. Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”-ийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд даалгав	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын нутагт “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк” байгуулах “Монэксалл” ХХК-д Засгийн газрын 2023 оны 423 дугаар тогтоолоор 15 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл олгосны дагуу ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/661 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”-ийн удирдлагатай 2023 оны 231215/06-828 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Говьсүмбэр аймгийн ИТХ-ын 2024 оны 08 дугаар тогтоолоор 3,380 га газрыг үйлдвэр технологийн паркийн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. Засгийн газрын 2024 оны “2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай” 74 дүгээр тогтоолоор паркийн байршлыг баталгаажуулсан. Говьсүмбэр аймгийн Засаг дарга 2024 оны А/331 дүгээр газрын сонгон шалгаруулалт явуулах захирамжийн дагуу газрын зөвшөөрлийг авсан. Паркийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Говьсүмбэр аймгийн Баянтал сумд 30 жилийн хугацаанд 3,380 га газарт үйл ажиллагаа явуулах бөгөөд 15 жилийн дотор	Хэрэгжсэн - 100%

				4 үе шатаар бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахаар төлөвлөсөн. 2025 онд паркийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангуулан, үндсэн үйлдвэрүүдийн хөрөнгө оруулагч талуудтай холбогдох уулзалтуудыг хийж байна. https://www.mofa.gov.mn/news/TIME/67ac15ff45076e7ad179bc88?category=TIME&id=67ac15ff45076e7ad179bc88	
217	555	2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51	XXV.3.2.7. Нэг удаагийн хуванцар сав баглаа боодлын хэрэглээг хориглох, хязгаарлах асуудлыг судлан танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;	МУЗГ-ын 2016 оны 287 дугаар тогтоолоор сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулах зорилгоор “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг баталсан. ХХААХҮСайдын 2017 оны А-138 дугаар тушаалаар 3 зорилт, 29 арга хэмжээ бүхий хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангасан. Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хөтөлбөрийг хүчингүй болсонд тооцсон. Монгол Улсын хүн амын ахуйн хэрэглээнд ашиглаж буй хүнсний бус зориулалтын савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааг “Монголын хүнсчдийн холбоо” ТББ-аар гүйцэтгүүлэхээр 201110/07/470 дугаартай гэрээг байгуулж, 21 аймаг, Улаанбаатар хотын 4,472 өрхийг судалгаанд хамруулсан зориулалтын бус химийн савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааны тайлан хүлээлгэн өгсөн. Улаанбаатар хотын хэмжээнд хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид хүнсний зориулалтын бус хуванцар сав, хэрэглэлийг ашиглах зөрчлийг бүрэн таслан зогсоож, Ерөнхий боловсролын сургуулийн 90 хувь хүнсний зориулалтын сав хэрэглэж байна гэсэн тооцоо гарсан. “Хүнсний зориулалтын бус хуванцар савны хор хөнөөл, өнөөгийн хэрэглээ”-ний талаар 4 видео контент, “Хүнсний бус хуванцар сав хэрэглэхийн аюул”-ын талаар анимэйшн, инфографик, баримтат кино ашиглан бие даасан 1 видео контент, 1 шторк, 1 постер бэлтгэж, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, хөдөө орон нутгийн аймаг, сумдад нийт 400 ширхэг постер тараасан. Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай тул хяналтаас хасах - хориглох, хязгаарлах асуудлыг судлан танилцуулах	Ахиц гарсан - 50%
218	556	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэл 2024-01-03 Дугаар 2024_1	7.1.5. Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо хооронд байгуулсан “Нүүрстөрөгч багатай ногоон хөгжлийн хамтын ажиллагааны тухай” харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт	Экспортод чиглэсэн мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн 85 орчим хувийг БНХАУ дангаараа эзэлж байна. "Нүүрстөрөгч багатай ногоон хөгжлийн хамтын ажиллагааны тухай" харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ногоон хөгжил, тойрог эдийн засаг болон хүнсний алдагдлыг бууруулах ажлын хүрээнд 2023 онд мах, махан бүтээгдэхүүний экспортын квот, аливаа хязгаарыг үгүй хийснээр түүхэндээ анх удаа 80.3 мянган тонн (гулууз махаар 120,000 тонн) мах, махан бүтээгдэхүүн экспортолсон байна. Монгол Улс 2025 онд 34.7 мян.тн адууны мах, 40 тн үхрийн мах, 25.1 мян.тн хонь, ямааны мах, 22.5 мян.тн дулааны аргаар боловсруулсан мах, 3.3 мян.тн малын дайвар, нийт 85.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүнийг /түүхий маханд шилжүүлэн тооцвол 110.7 мян.тн/ 345.3 сая ам долларoор экспортолсон ба өмнөх 2024 онтой харьцуулахад 20.4% буюу 14.5 мян.тн-оор нэмэгдсэн байна.	Хэрэгжсэн - 100%
	557		7.1.6. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгүүдийн хэрэгжилтийн явц, тайланг хагас жил тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох сайд нарт	Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын хүнс, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/83 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Худалдаа, эдийн засгийн газартай нийт 3 удаагийн техникийн уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх санал, баримт бичгүүдийг нэгтгэн боловсруулсан. Ажлын хүрээнд мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний 6 нэр төрөл, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний 11 нэр төрөлд хамаарах эрүүл ахуй, хяналт, хорио цээрийн протоколын төслийг боловсруулан БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын байдлаар маалинга, хошуу будаа, ургамлын гаралтай эмийн түүхий эд, адууны махны протоколуудыг эцэслэн тохирсон бөгөөд бусад протоколуудын хэлэлцээ үргэлжилж байна. Мөн 2005 онд байгуулсан адууны мах экспортлох протоколыг шинэчлэн боловсруулах ажлыг дуусгаж, БНХАУ-ын	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%

				талд албан ёсоор хүргүүлсэн. Үүнтэй холбогдуулан ЭЗХЯ-нд протоколуудын хэрэгжилтийг цахим тоотоор уламжлав.	
219	558	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэл 2024-03-06 Дугаар 2024_9	3.. Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотод 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Беларусийн Засгийн газар хоорондын комиссын долоодугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд бөгөөд тус комиссын Монголын хэсгийн дарга Х.Болорчулуунд даалгав. (Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Беларусийн Засгийн газар хоорондын комиссын долоодугаар хуралдааны дүнгийн тухай)	ЗГХК-ын VII хуралдааны дүн, протоколд тусгагдсан чиглэл, зорилтыг холбогдох яам, агентлаг, байгууллагуудад танилцуулж, хэрэгжилтийг хангах зорилгоор хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хөдөө аж ахуй, аж үйлдвэр, боловсрол, шинжлэх ухаан, онцгой байдлын салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөсөн. Хөдөө аж ахуй, техник, технологийн хамтын ажиллагааны хүрээнд Беларусь улсад үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг Монгол Улсад нийлүүлэх, хамтарсан төв байгуулах асуудлыг бодлогын түвшинд дэмжиж, холбогдох байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж байна. “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК болон Беларусийн “Гомсельмаш” НХН хооронд 2024 онд байгуулсан дилерийн гэрээ, хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу 2 ширхэг өөрөө явагч ангилан хадагч худалдан авч, 2025 онд засвар үйлчилгээ, сервисийн гэрээ байгуулан, ашиглалтын өмнөх заавар, зөвлөгөөг авсан. Мах, сүүний чиглэлийн шилмэл үүлдрийн мал нийлүүлэх талаар хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж, 2024 онд РСУП “Гомельгосплемпредприятие” компаниас 32 толгой симменталь үүлдрийн үхэр худалдан авч, Төв аймгийн 2 сумын кластер аж ахуйд нийлүүлсэн. “МТЗ” үйлдвэрийн трактор, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх асуудлаар Монголын талын хэрэгцээг нэгтгэн, санхүүжилтийн боломжит хувилбаруудыг судалж байна. Боловсрол, шинжлэх ухаан, инновацын салбарт Монгол, Беларусын эрдэмтэн, судлаачдын хамтарсан судалгаа, инновацын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор уулзалт, айлчлалууд зохион байгуулж, археологийн хээрийн судалгаа, шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааг бодитоор эхлүүлсэн. Уул уурхай, аж үйлдвэрийн салбарт “БЕЛАЗ” үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг ашиглах хамтын ажиллагааг үргэлжлүүлэх сонирхлоо Монголын тал илэрхийлж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон “БЕЛАЗ” НХН хооронд үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэлэлцээг үргэлжлүүлж, тусгай протокол байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна	Хэрэгжсэн - 100%
220	559	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэл. 2024-03-20 Дугаар 2024_11	23.9. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон “Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах арга хэмжээний төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт даалгав.” (Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар)	Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2024 онд УИХ-аар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Улсын хэмжээнд 14,613 хоршоо, 235,457 гишүүн бүртгэлтэй, үүнээс 10,269 хоршоо, 100,705 малчин гишүүн “Шинэ хоршоо” хөдөлгөөнд хамрагдаж, нийт малчдын 32.6 хувийг эзэлж байна. Санхүүгийн үр дүн: Хөнгөлөлттэй зээл 854.8 тэрбум төгрөг олгогдож, 7,888 хоршоо, 25,255 малчин хамрагдсан. Зээлийн 60.1 хувь нь үржилийн мал худалдаж бойжуулахад, 9.6 хувь нь үйлдвэрлэлийн зориулалттай хөрөнгө оруулалтад, үлдсэн нь дэд бүтэц, тэжээл, тоног төхөөрөмжийн шинэчлэлд зарцуулагдсан байна. Эдийн засгийн нөлөөлөл: Хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнд хоршооллын нийт борлуулалтын хэмжээ 20 хувиар өсөж, малчин өрхийн дундаж орлого 12–18 хувиар нэмэгдсэн. Зээл, хөрөнгө оруулалтын хөшүүрэг нь 1 төгрөгийн дэмжлэг бүрд 2.8 төгрөгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгож байгаа тооцоо гарчээ.	Ахиц гарсан - 50%
221	560	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл 2024-03-27 Дугаар 2024_12	14.6.. Үүнтэй холбогдуулан дотоодын хэрэглээнээс давсан хүнсний улаанбуудайг экспортлох талаар зохих арга хэмжээ авах, хүнсний улаанбуудайн доод үнийг тогтоох талаар судалж танилцуулах, газар тариалангийн салбарт хэрэглэгдэх машин механизм, тоног төхөөрөмж болон тариаланчдын хавар, намрын тариалалтад ашиглагдах түлш, шатахуунд үзүүлэх дэмжлэгийн талаар Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд даалгав.(Газар тариалангийн салбарын зохицуулалтын талаар авах зарим арга хэмжээний талаар)	2024 оны ургацаас дотоодын хэрэгцээг хангаж хүнсний улаан буудай экспортлох нөхцөл үүсээгүй. Улсын хэмжээгээр 2025 онд 310.1 мянган га-д улаанбуудай тариалахаас 264.8 мянган га-д улаанбуудай тариалалт хийгдсэн байна. Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд технологийн хугацаанд 22.6 мянган тонн шатахуун шаардагдах тооцоог гарган нөөц бүрдүүлэх чиглэлээр Аж үйлдвэр, эрдэс баялагийн яаманд албан тоот хүргүүллээ. Хаврын тариалалтын ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр аймгуудад албан даалгавраар чиглэл хэрэгжүүллээ. "Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл”-ийн 250227/03-145 дугаар санхүүжилтийн гэрээг үндэслэн Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр худалдан авах (хөрөнгө оруулалт) жилийн нийт хүү 18 хувь, ногоон зээлийн нийт хүү 16 хувь (зээлдэгчээс төлөх хүү: жилийн 8 хувь, ногоон зээлийн хүү жилийн 6%, Засгийн газраас хариуцан төлөх 10 хувь)-ийн хүүтэй 48 сарын хугацаатай хөнгөлөлттэй зээлээс 4.8 тэрбум олгосон байна. 500.0 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй зээлд тухайн аймгийнх нь Хүнс, хөдөө аж ахуйн газар хяналтын гэрээ байгуулах хүрээнд 6 аж ахуйн нэгжтэй байгуулсан. Импортоор оруулж байгаа болон дотоодод борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн	Хэрэгжсэн - 100%

				болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгаалллын бодисыг “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох судалгааг боловсруулан, үзэл баримтлалыг Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нартай хамтран батлуулахаар 01/3138 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн болно. Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн чанартай бөгөөд хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах - Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх	
222	561	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13	22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээх хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны явцын мэдээг яам, орон нутагт хэрэгжүүлэх болон багц төсөл тус бүрээр гарган Сангийн яаманд хүргүүлсэн. ХХААХҮЯ зохион байгуулах 11 арга хэмжээнээс 11 гэрээ байгуулсан, ТХААГ зохион байгуулах 7 арга хэмжээнээс 7 гэрээ байгуулсан, Орон нутагт зохион байгуулах 36 арга хэмжээнээс 33 гэрээ байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны явцын мэдээг яам, орон нутагт хэрэгжүүлэх болон багц төсөл тус бүрээр гарган Сангийн яаманд хүргүүлсэн. ХХААХҮ-ийн 2025 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 47.2 тэрбум төгрөг байна. Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй - 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах,	Хэрэгжсэн - 100%
223	562	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15	20.2. Үүнтэй холбогдуулан хууль тогтоомжийн төслийг боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд үүрэг болгов.” (Нийслэл хотын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, бие даан хөгжих баталгаагаар хангах хүрээнд хотын эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн талаар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.)	салбарт хамааралгүй Хяналтаас хасуулах санал : Хамааралгүй тул хяналтаас хасах	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
224	563	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1	19.3.2.. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав.	"Хүний нөөцийн бодлогыг дэмжих систем"-ийг яамны албан хаагчдад танилцуулах арга зүйн сургалтыг 2024.06.03 өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран зохион байгууллаа. Уг сургалт нь байгууллагуудын удирдлагын түвшинд нээлттэй хийсэн бөгөөд төрийн байгууллага, системийн хэрэглэгч болох албан хаагчдад зориулж хийж байгаа анхны сургалт болсон. Сургалтаар "Хүний нөөцийн бодлогыг дэмжих систем"-д орсон албан хаагчдын мэдээлэл түүнийг хэрхэн бүрэн зөв болгох талаар болон хүний нөөцийн шийдвэр гаргахад мэдээллийг хэрхэн ашиглаж болох талаар дэлгэрэнгүй танилцуулж, албан хаагчдад системд нэвтрэх эрх авахад арга зүйн зөвлөгөө өглөө.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
225	564	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1	22.2.4.. Эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэлэлцээний үйл ажиллагаанд зохих дэмжлэгийг үзүүлж, Хэлэлцээний багийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа яам, агентлагийн албан хаагчдын идэвх, оролцоог хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав	БНСУ-тай байгуулах эдийн засгийн түншлэлийг хэлэлцээр, Евразийн эдийн засгийн холбоотой байгуулах чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд зохих дэмжлэгийг үзүүлж, хэлэлцээний багийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагчдын идэвх, оролцоог хангаж ажилласан. Монгол Улс, БНСУ-тай хийх Чөлөөт худалдааны хэлэлцээрийн ажлын хэсгийн ээлжит хуралдаан Эдийн засаг хөгжлийн яамны байранд 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж, нэхмэлийн салбараас хэлэлцээрийн барааны жагсаалтад саналыг тусгах талаар ярилцлаа. Хяналтаас хасуулах санал : цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон байх тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
226	565	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын	19.1. Үүнтэй холбогдуулан зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг малжуулах хөтөлбөрт хамруулах, малчдын амьжиргааг	Малчдыг малжуулах арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн хуваарийн дагуу 21 аймаг, нийслэлийн 3 дүүрэгт нийт 3,419 өрхөд 27.0 тэрбум төгрөгийг зарцуулж, хонин толгойд шилжүүлснээр 132,614 толгой мал худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар	Хэрэгжсэн - 100%

		22-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл 2024-05-22 Дугаар 2024_20.1	дээшлүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаан бүрд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, малчныг малжуулах хөтөлбөрт хамруулах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аймгийн Засаг дарга нарт даалгав.(Зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн талаар)	төлөвлөснөөс малжуулах хөтөлбөрт 21 аймаг, нийслэлийн 3 дүүргээс 4,957 өрх хүсэлт ирүүлснээс 3,363 өрхийн хүсэлтийг аймаг, сумын амьжиргааг дэмжих зөвлөл дэмжиж, 2,596 өрхийн хүсэлтийг Хөдөлмөр эрхлэлтийг байгууллагаас шийдвэрлэн 20.7 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий малаар малжуулсан байна. Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батлсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ийн 5.1.1-т малжуулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр тусгасан бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 1, 2 дугаар тогтоолоор холбогдох төсвийн хуваарийг батлсан байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/50, А/52 дугаар тушаалаар төсвийн хуваарийг батлаж, нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээ тогтоосон байна.	
227	566	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22	37.1.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт	Улсын Их Хурлаас 2024 онд батлсан "Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас 2024 онд “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” 166 дугаар тогтоол, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлсантай холбогдуулан уг хууль тогтоомжийг малчин өрхүүдэд сурталчлан таниулах, сургалт, мэдээлэл хийх, зөвлөн туслах чиг үүрэгтэй ажиллах багт тус яам болон харьяа агентлаг, байгууллагын 26 албан хаагч 12 аймгийн 23 суманд ажилласан. Албан хаагчдын аймаг, суманд нэг сарын хугацаатай ажиллах албан томилолтын зардал болон шаардлагатай бусад зардал, цалин хөлсийг холбогдох хууль журмын дагуу олгосон. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийн зардалд урсгал үйл ажиллагааны зардлаас 108.0 сая.төгрөг, хоршооны гишүүн малчинд олгосон зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 51.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлж ажилласан. Нийт хүлээгдэж буй гүйцэтгэл 99.7 тэрбум төгрөг байна. Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул хяналтаас хасах - албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авах	Хэрэгжсэн - 100%
228	567	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэл 2024-09-11 Дугаар 2024_32	32.16.6. 1/ Төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон хөгжүүлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөн, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа байгууллагыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх ажлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 32 дугаар тэмдэглэл гарсан. Тэмдэглэлийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нийт албан хаагчид үе шаттайгаар шилжин суурьшиж байна. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд хүсэлт гаргасан нийт албан хаагчдын байр, орон сууцны асуудлыг мөн үе шаттайгаар шийдвэрлэж байна. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
229	568	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 37 дугаар тэмдэглэл 2024-10-23 Дугаар 2024_37	37.21.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт бүрэн нүүлгэн шилжүүлж, байршуулах арга хэмжээ шуурхай авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, түүний харьяа ХААК, ХААБ, ХХҮТЦ ТӨХХК болон ЗБДС-ийн Төвийн бүсийг шинээр байгуулж, АДОБАЗ, ХАА-н Халх гол ББББЗ, ЖДҮГ-ыг Дархан-Уул аймагт бүрэн нүүлгэж шилжүүлсэн. Мөн Ургамал хамгаллын газрыг Засгийн газрын тогтоолын дагуу шинээр байгуулж Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байна. Хяналтаас хасуулах санал : хэрэгжсэн бөгөөд нэг удаагийн шинж чанартай тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	569		37.21.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, түүний харьяа байгууллагуудын Дархан-Уул аймагт шилжин ажиллаж байгаа албан хаагчдын амьдрах орон сууцны болон нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэх, ажиллах хэвийн нөхцөлийг хангуулах талаар судлан үзэж, саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, түүний харьяа байгууллагуудын Дархан-Уул аймагт шилжин ажиллаж байгаа албан хаагчдын амьдрах орон сууцны болон нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Нийт 124 албан хаагчийн урьдчилгаа 30 хувь болон ипотекийн зээлийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, бүгд зээлд хамрагдсан байна. Хяналтаас хасуулах санал : хэрэгжсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%

230	570	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэл 2024-10-30 Дугаар 2024_38	38.17.9.3. Хөдөө аж ахуй: • Хоёр улсын мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэр болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын арвин нөөц бололцоонд тулгуурлан хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, Монгол Улсад малын вакцин үйлдвэрлэх төслийг хамтран хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд.	Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй зорилтот хөтөлбөрүүд, тэр дундаа “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд хөнгөн үйлдвэрийн салбарыг дэмжих, тэр дундаа малын гаралтай түүхий эдийн боловсруулалт, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, олон улсын зах зээлд борлуулах чиглэлээр хамтран ажиллах, цаашлаад төсөл хөтөлбөр эхлүүлэх саналыг 2024 оны 9 сард ХХААХҮ-ийн сайд Ж.Энхбаяр Бүгд Найрамдах Казахстан Улсын Гадаад хэргийн дэд сайд Алибек Бакаевтай уулзах үеэр айлын талд уламжилсан хэдий ч одоогийн байдлаар айлын талаас тодорхой хариу ирүүлээгүй байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
231	571	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав: (Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.2. ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.3. нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.4. хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.5. хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.6. захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.7. энэ тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.) заалт бүрээр биелэлт ирүүлэх.	Хууль тогтоомжид тусгайлан эрх олгогдсон боловч одоогоор батлагдаагүй дүрэм, журам, заавар, тушаалын судалгааг урьдчилсан байдлаар хийж, холбогдох жагсаалтыг гаргаж, боловсруулагдаагүй байгаа дүрэм, журам, зааврыг боловсруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын батлагдсан захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүрдлийг хангуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр болон цахимаар тухай бүр хүргүүлж ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээгүй 3.1, 3.2, 3.3, 3.4-т заасан тушаал байхгүй болно. ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээний актын салбарын санг эрхлэн хөтөлж ажиллаж байна. Салбарын санд ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэр байхгүй болно. 2024 онд Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Малчны тухай, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай, Органик бүтээгдэхүүний тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулиуд шинээр батлагдсантай холбогдуулаад холбогдох захиргааны хэм хэмжээний актын төслүүдийг хариуцсан хэрэгжилтийн газрууд боловсруулж байна. “Хуулиар эрх олгосон заалтыг бууруулах, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах” ажилд "Ухаалаг хөгжлийн гарц" НҮТББ-тай 2025 онд 202523/03-428 гэрээ байгуулсан.	Хэрэгжсэн - 100%
	572		39.29.11.4. Дараах асуудлыг судалж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. (Үүнд:4.1. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаа болон захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн шийдвэрүүдийг онол, арга зүйн хувьд нягтлан судалж, дүн шинжилгээ хийн Засгийн газрын 2023 оны 48 дугаар тэмдэглэлийн 4 дэх заалтаар өгөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг 2 дахин багасгах үүргийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх; 4.2. хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний актаар зайлшгүй зохицуулах хэм хэмжээг тусгахдаа түүний агуулга, тавигдах шаардлагыг тодорхой зааж, хуулийн төсөлд заасан захиргааны хэм хэмжээний актын төслийг хамтад нь боловсруулж хэлэлцүүлэн, санал авч байх; 4.3. хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр батлан гаргахгүй байх. -ыг заалт бүрээр гаргаж тайлагнах)	Хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр батлан гаргахгүй байх зарчмыг баримтлан, тухайн чиглэлийн зохицуулалтыг зөвхөн хуулийн хүрээнд хэрэгжүүлж ажиллаж байна. “Салбарын хуулиуд дахь эрх олгосон заалтын судалгааг хийх, эрх олгосон заалтыг бууруулах, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний 250319/03-183 гэрээг "Ухаалаг хөгжлийн гарц НҮТББ"-тай байгуулан, гүйцэтгэлийн тайланг хүлээн авсан байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	573		39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага болох стратегийн хүнс үйлдвэрлэгч, хадгалагч, түгээгч байгууллагуудад Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвтэй уулзалт зохион байгуулж, кибер аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх талаар ярилцсан. Салбарын	Тодорхой үр дүнд

			аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	мэдээллийн системүүдийн ашиглалт үйлчилгээг хангах ажлын зардал, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зардлыг 2025 оны төсөвт тусган мэдээллийн аюулгүй байдлын аудитыг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраар Мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэсэн. Зөвлөмжийн дагуу мэдээллийн аюулгүй байдлын төгсгөлийн төхөөрөмжийн программ хангамж /Endpoint/, серверийн лицензийн windows server 2025 standart болон сүлжээний төхөөрөмжүүдийг худалдан авч тохиргоог хийхээр бэлтгэж байна.	хүрсэн - 50%
	574		39.29.11.1.2. эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэрүүдийг дүгнэлтийн дагуу хүчингүй болгон, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (1.1Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн болон бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөв)	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүргэлтэй хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын захиргааны хэм хэмжээний актуудаас 2025 онд зөвшөөрөл олгохтой холбоотой болон зөвшөөрөл олгох шинж агуулсан захиргааны хэм хэмжээний актыг шат дараалан хүчингүй болгох арга хэмжээ авч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Журам батлах тухай" 2019 оны А/456 дугаар тушаал, “Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээлийн аюулгүй байдалд тавих шаардлага батлах тухай” 2021 оны А/29 дүгээр тушаалыг тус тус Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/100 дугаар тушаалаар, “Таримал ургамлын үр үйлдвэрлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт” батлсан "Жагсаалт батлах тухай" Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/195 дугаар тушаалыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/50 дугаар тушаалаар тус тус хүчингүй болгосныг албан бичгээр тус яаманд хүргүүлсэн болно. Мөн хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэр болон цаашид боловсруулах шаардлагатай захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг Хууль зүй, дотоод хэргийн яам руу 2025.10.30-ны өдрийн 01/3258 албан бичгээр хүргүүлсэн. Хяналтаас хасуулах санал : Заасан хугацаа - 2025 оны 1 дүгээр улиралд багтаан	Хэрэгжсэн - 100%
	575		39.29.11.1.3. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаа, түүнчлэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дагаж мөрдөж байгаа хуулиудаас тусгайлан эрх олгосон заалтын судалгааг гаргаж, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж, тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх;(1.4. цаашид нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох шийдвэрт тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж, санд хөдөлгөөн хийлгэх ажлыг хэвшүүлэх; 1.5. шийдвэрийг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж ажиллах; 1.6. Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх чиг үүргээ биелүүлж ажиллах;))	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/249 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих журам”-ыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ажиллаж байна. “Жагсаалт батлах тухай” ХХААХҮС-ын 2022 оны А/195 дугаар тушаалыг 2025 оны А/50 дугаар тушаалаар хүчингүй болгосныг бүртгүүлэхээр 2025 оны 02/552 албан бичгээр хүргүүлсэн. ХХААХҮС-ын 2019 оны А456 дугаар “Журам батлах тухай” тушаал, 2021 оны А/29 “Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээлийн аюулгүй байдалд тавих шаардлага батлах тухай” тушаалыг 2025 оны А/100 дугаар тушаалаар хүчингүй болгосныг 2025 оны 02/695 албан бичгээр хүргүүлсэн. ХХААХҮС-ын 2025 оны "Жагсаалт батлах тухай" А/161 дүгээр тушаалыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр 2025 оны хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 7243 дугаарт бүртгүүлсэн. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн түвшинг харгалзан импортын мэдэгдэл олгох аьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалт батлсан “Жагсаалт батлах тухай” ХХААХҮС-ын 2025 оны А/571 дүгээр тушаалыг 2025 оны 02/3572 дугаар албан бичгээр хүргүүлсэн. “Хамтын баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх журам" болон "Органик салбарын үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журам”-ыг тус тус баталсан “Журам батлах тухай” ХХААХҮС-ын 2025 оны А/590 дүгээр тушаал, “Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журам” баталсан “Журам батлах тухай” ХХААХҮС-ын 2025 оны А/591 дүгээр тушаалыг 2025 оны 02/3603 албан бичгээр хүргүүлсэн. “Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, төлберийн жишиг үнийг шинэчлэн батлах тухай" ХХААХҮС-ын 2025 оны А/565 дугаар тушаалыг 2025 оны 02/3612 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын салбарын нэгдсэн санд хөдөлгөөн хийсэн. Мөн нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж 2025.10.30-ны өдөр хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%

				Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : Заасан хугацаанд хэрэгжсэн - 2025 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх	
	576		39.29.11.1.7. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах	Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх, боловсруулж батлуулахад Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг баримтлан ажиллаж байна. Мөн тус хуулийн 64.4-т заасан хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яам руу шинээр батлагдсан хэм хэмжээний актуудыг хүргүүлж, бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Захиргааны ерөнхий хуультай холбоотой зөрчил гаргаагүй болно.	Хэрэгжсэн - 100%
232	577	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл 2024-11-20 Дугаар 2024_40	40.19.5.2. Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд орон нутагт байгуулагдсан малчдын хоршоодыг “Өвлийн идэш” арга хэмжээнд оролцуулж, бүтээгдэхүүнийг нь худалдах, зах зээлд нийлүүлэх чиглэлээр дэмжпэг үзүүлэн, холбогдох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын алба (Ё.Азжаргал), “Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо” (Ц.Алтантуяа)-нд	Сар шинийн баярт зориулсан "Амар байна уу 2025" үзэсгэлэн худалдааг нийслэлийн ЗДТГ, ЖДҮҮДТ, Соёолж молл, Их наяд плаза хамтран, Улаанбаатар хот, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 1000 гаруй үйлдвэр, үйлчилгээ, эрхлэгчдийг дэмжин түрээсийн төлбөргүй зохион байгуулсан. Төвийн бүсийн "Цагаан сар-2025" үзэсгэлэн худалдааг ХХААХҮЯ, Жижиг дунд үйлдвэрийн газар, Зээлийн батлан даалтын сан, Дархан-Уул аймгийн ЗДТГ, аймгийн ХХААГ, МҮХАҮТ-ын Дархан-Уул аймаг дахь салбар танхим хамтран зохион байгуулж 250 гаруй иргэн, ААНБ, хоршоо оролцож нийт 1.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд батлан даалттай зээл авч, зориулалтын дагуу төслийг үр дүнтэй хэрэгжүүлсэн "Сүүн цацал баялаг өгөөж хоршоо"-г төвийн бүсийн “Шилдэг хоршоо”-оор шалгаруулсан байна. Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан махны хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, махыг дундын зуучлалгүйгээр хэрэглэгчдийн гарт хүргэх зорилгоор ЖДҮГ, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай хамтран "Өвлийн идэш-2025" өргөтгөсөн худалдааг 2025 оны 11 дүгээр сарын 28-наас 12 дугаар сарын 05-ны өдрийн хооронд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 9 аймгаас 35 аж аухйн нэгж, иргэн оролцсоноос 15 хоршоологч, 20 малчин, нийслэлийн үйлдвэрийн аргаар мах бэлтгэх 8 аж ахуйн нэгж мах, цагаан идээний төрлөөр оролцож, нийт 2,618,365,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.	Хэрэгжсэн - 100%
233	578	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэл 2024-11-27 Дугаар 2024_41	41.23.9.2. Өвөлжилт хүндэрч зам даваа хаагдахаас урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх болон малын тэжээлийн импортод дэмжлэг үзүүлэх асуудлаар холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал) нарт;	Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын байдалд үнэлгээ хийхэд Баян-Өлгийн Сагсай, Завханы Отгон, Баянхонгорын Баянбулаг, Галуутад цагаан зудын, Увсын Малчин, Тэс, Сагил, Улаангом, Давст, Завхан, Түргэн, Ховдын Алтай, Дарви, Үенч, Завханы Цэцэн-Уул, Цагаанчулуут, Баянхонгорын Жаргалант, Бөмбөгөр, Баянговь, Сэлэнгийн Сүхбаатар, Төвийн Угтаалцайдам, Хэнтийн Баян-Адрага, Дорнодын Хөлөнбуйр, Халхголд цагаанаар зудархуу (8 аймгийн 20 сум) байдалтай гарсан. Зудын эрсдэлтэй болон өвөлжилт хүндэрсэн 19 аймгийн 265 суманд өвс, тэжээл, эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүргэхэд хаагдсан зам, даваа нээх шаардлагын хүрээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас нийт 236 техник, хэрэгсэл, орон нутгаас нэмэлт техник хэрэгсэл тус тус гарч, орон нутгаас 5,079 өрхөд 41,845 км зам, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас 8,252 өрхөд 67,297 км зам, нэмэлтээр дайчлагдсан ковш, автогрейдер 29,625 км замыг тус тус гаргасан бөгөөд Улсын хэмжээнд нийт 13,331 өрхөд 138,767 км зам гаргаж ажилласан. ОХУ-ын Засгийн газраас Монгол Улсад тохиолдсон цаг агаарын нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг даван туулахад 7,000 тонн улаанбуудай, 1,300 тонн овъёос, 200 тонн арвай буюу нийт 8,500 тонн тэжээлийн бууцалтгүй тусламж олгохоор болсон. Хяналтаас хасуулах санал : нэг удаагийн шинж чанартай	Хэрэгжсэн - 100%
	579		41.23.9.4. Тэжээлийн таримал тариалах тариалангийн газрын хэмжээг нэмэгдүүлэх, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, хүнсний ногооны механижуулалт, хадгалалтын нөхцөлийг сайжруулах, газар тариалан, мал аж ахуй, боловсруулах үйлдвэрийн уялдааг хангах, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт.	Малын тэжээлийн тогтвортой хангамжийг бүрдүүлэх, сэлгээний таримлын нэр төрөл, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2025 оны 166 дугаар тогтоолыг батлуулж, Дархан-Уул, Дундговь, Дорнод, Төв, Хэнтий, Говьсүмбэр зэрэг аймагт атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх шийдвэр гарч, тариалангийн эргэлтийн талбайг 71.2 мянган га-аар нэмэгдүүлсэн. Аймгуудын ХХААГ-уудаар тариалалтын техникийн бэлэн байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, дилер аж ахуйн нэгжүүдийг трактор, хөрс болосвруулах техник, үр тариа, төмс, хүнсний ногооны үрлүүр, дарш тэжээлийн техникийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажилласан. Дилер аж ахуйн нэгжүүд, ХААК ТӨХХК-ийн оролцоотой уулзалтыг зохион байгуулж эрдэнэ шиш тариалах, дарш бэлтгэх машины системийг шинээр нэвтрүүлсэн. ХААК ТӨХК, Агромаштех ХХК, Энсадатракторон ХХК-иуд эрдэнэ шиш	Хэрэгжсэн - 100%

				тариалах үрлүүрийг нийлүүлсэн. Хаврын тариалалтын техникийн бэлэн байдлыг 90 хувьтай хангасан. Тариалалтын ажилд 3334 трактор, үр тарианы үрлүүр 2112, үүнээс хийн үрлүүр 363, төмс суулгагч 317, хүнсний ногооны үрлүүр 279, анжис 1293, бордоо бууц цацагч 300, хор цацагч 428, бусад хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмж 4353 ажиллаж байна. Ургац хураалтын ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, механикжуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 97 иргэн, аж ахуйн нэгжийн тухайн жилд худалдан авсан 104 ширхэг техникийн үнийн дүнд 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээнд 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, төмс, хүнсний ногооны 1200 га талбайн ажлыг механикжуулах боломж бүрдсэн. Атар 4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд газар тариалангийн техникийн шинэчлэл хийхэд зориулж 10 дилер аж ахуйн нэгжид 25.7 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн хүүгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Мөн 69 аж ахуйн нэгжид техникийн шинэчлэл хийхэд зориулж 20.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг арилжааны банкнаас олгосон. Эдгээр 79 аж ахуйн нэгжид хүүгийн дэмжлэг олгож, хяналтын гэрээ байгуулсан.	
234	580	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэл 2024-12-04 Дугаар 2024_43	43.6.2.. Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгав	Засгийн газрын 2024 оны “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 249 дүгээр тогтоолын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2024 онд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын 15 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох 7,385.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан бөгөөд үүнээс 2025 оны 12 дугаар сарын байдлаар 15 арга хэмжээний 6,318.8 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Барьцаа хөрөнгийн дансанд “Арсайн газар тариалангийн услалтын систем /Увс, Улаангом сум/” төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын санхүүжилтийн үлдэгдэл 520.9 сая, Дархан-Уул аймгийн бэлчээрт гаргах 1 худаг төсөл, арга хэмжээний чанарын баталгаа 5.4 сая төгрөг үлдсэн тул улсын төсөвт төвлөрүүлээгүй.	Хэрэгжсэн - 100%
235	581	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэл 2024-12-20 Дугаар 2024_45	45.7. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд агаар, хөрсний бохирдлыг бууруулах үйл ажиллагааг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт заасан зохицуулалттай уялдуулан дэмжиж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгаж, мөн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Засгийн газраас холбогдох шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзэв(Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай)	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг салбар бүрийн уялдааг ханган шинэчлэн тодорхойлох зорилгоор БОУАӨ-ийн сайдын 2024 оны А/807 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хөдөө аж ахуйн салбарын зорилтыг шинэчлэн тодорхойлохоор ажиллаж байна. Уг ажлын хэсэг нь Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмэр 3.0 баримт бичгийн төслийг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Азийн хөгжлийн банкны техник туслалцаатайгаар боловсруулсан. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт хуулийн төслийг боловсруулахад хөдөө аж ахуйн салбарын зохицуулалтыг салбарын бусад хуультай нийцүүлэн тусгахад анхааран ажиллаж байна. Хөдөө аж аж ахуйн салбарын нүүрстөрөгчийн зах зээлд оролцох нөөц боломж, түүнд шаардлагатай бэлтгэл замын зураглал гаргах чиглэлээр НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн CBIT-2 төсөл, Азийн хөгжлийн банкны "ASDIP" төслийн хүрээнд зарим судалгаа, тооллогын аргачлал боловсруулах чиглэлийн зөвлөх үйлчилгээг санал болгож, хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн 2023 оны БОАЖЯ-наас байгуулсан ажлын хэсэгт ажиллаж, "Нүүрстөрөгчийн зах зээлд оролцох төсөлт үйл ажиллагааг бүртгэх" журмын төсөл боловсруулсан бөгөөд батлагдаж захиргааны хэм хэмжээний актын жагсаалтад бүртгэгдээгүй байна.	Хэрэгжсэн - 100%
236	582	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэл 2024-12-25 Дугаар 2024_46	46.9. Ханой хотноо 2024 оны 11 дүгээр сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын 19 дүгээр хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд бөгөөд тус комиссын Монголын хэсгийн дарга Ж.Энхбаярт даалгав	Талууд хоёр улсын нийгэм, эдийн засгийн байдлын талаар мэдээлэл солилцож, Монгол, Вьетнам хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засаг, зам тээвэр, хөдөө аж ахуй, байгаль орчин, соёл, боловсрол, аялал жуулчлал, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны асуудлуудын талаар хэлэлцсэн бөгөөд ХХААХҮ-ийн сайд Ж.Энхбаяр 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан болно.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
237	583	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар	3.12.3.1. Шуурхай штабаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг яаралтай зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт даалгав;(Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг	Тэмдэглэлээр үүрэг болгосны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх заалтыг үндэслэн "Үйл ажиллагаанд тавигдах шаардлага батлах тухай" Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/270 дугаар тушаалыг батлуулан, захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн. Сангийн сайдаас 2025 оны 01/6928 тоот бичгээр уг тушаалд туссан	Ахиц гарсан - 50%

		тэмдэглэл 2025-01-14 Дугаар 2025_03	дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт, шуурхай удирдлагаар хангах Шуурхай штабын анхдугаар хуралдааны талаар)	агуулгыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын холбогдох тушаалд тусгуулах саналыг ирүүлсэн. Үүний дагуу "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/2435 тоотыг БОУАӨ-ийн сайдад хүргүүлсэн. Хавсралт : 3 файл	
238	584	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл 2025-01-18 Дугаар 2024_44	44.22.1.11. Агаар, орчны бохирдлын талаар холбогдох төрийн байгууллагуудын тоон болон чанарын үзүүлэлт бүхий мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сан, нэгдсэн дашбоард үүсгэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, холбогдох мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавьж, тухай бүр шинэчилж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд	Салбарт хамааралгүй Хяналтаас хасуулах санал : Хамааралгүй	Х.Б
	585		44.22.6.1. Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэн тохиролцох үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох талын оролцоог хангуулан шинэчлэн байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт, Ажлын хэсэгт хариуцсан чиг үүргийн дагуу удирдах албан тушаалтныг оруулан идэвх, оролцоог хангаж ажиллуулах, шаардлагатай мэдээллийг тухай бүр хүргүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгав	Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээрийн төслийг боловсруулахад салбарын төлөөлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодын оролцоог ханган, хоёр талын татвараас чөлөөлөх барааны жагсаалтын санал, зөвлөмж боловсруулах дэд ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн ахлан ажилласан. Ажлын хэсгээс боловсруулсан санал, зөвлөмжийг 2025 оны 01/269, 02/574, 02/651 тоот бичгээр тус тус Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Хавсралт : 3 файл Хяналтаас хасуулах санал : хэрэгжилт хангагдсан	Хэрэгжсэн - 100%
	586		44.22.6.2. Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төсөл болон гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтыг боловсруулахад “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо хөдөлгөөн”, “Атрын-1/ тариалангийн тогтвортой хөгжлийн аян” зэрэг хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог бүрэн хангаж, холбогдох төлөөллийг Ажлын хэсэгт оролцуулж, салбарын нэгдсэн байр суурийг тодорхойлох арга хэмжээг авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгав.”	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” А/02 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбооны хооронд байгуулах чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн хүрээнд салбарын төлөөлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодын оролцоог ханган, хоёр талын татвараас чөлөөлөх барааны жагсаалтын санал, зөвлөмж боловсруулах Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ажлын удирдамжийн хамт баталсан. Дэд ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн ахалж, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа бодлогын уялдааг хангах зорилгоор салбарын 15 мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, 2 аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулсан. Холбоодын саналыг авч, 2 удаагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцээрийн төсөл дэх барааны жагсаалтад холбогдох саналыг 01/269 тоот бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Хавсралт : 3 файл Хяналтаас хасуулах санал : хэрэгжилт хангагдсан	Хэрэгжсэн - 100%
239	587	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2025-01-22 Дугаар 2025_05	5.24.10.1. Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулах төлөвлөгөөний талаар)	Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг Хангайн бүсийн хуралдаан, Хойд бүсийн хуралдаан, Говийн бүсийн хуралдааныг тус тус зохион байгуулсан. Уг хуралдааныг бүсүүдэд зохион байгуулахтай холбогдуулан бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх ажлын хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллахаар дээрх бүсэд хамаарах аймгуудаас ирүүлсэн саналыг судлан үзэж, бүсийн анхдугаар хуралдаануудын үеэр гарсан саналыг ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлж, ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан батлуулсан. Үүний үр дүнд салбарын ҮТП-уудыг байршил, үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрлийг тухайн бүс нутгийн түүхий эдийн нөөц, ажиллах хүчний хангамж, дэд бүтцийн хөгжил, цаашдын төлөвлөлт, бүс нутгийн эдийн засгийн хөгжил, экспорт, импортын боломжуудад тулгуурлан сонгож “Хөнгөн, хүнсний үйлдвэрийн ҮТП-т эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл,	Хэрэгжсэн - 100%

				паркийн байршлын жагсаалт батлах тухай” ЗГ-ын 2025 оны 271-р тогтоолыг батлуулсан. Төвийн бүсэд Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн парк”, Баруун бүсэд Ховд аймагт “Шинэ Ховд аж үйлдвэрийн парк”, Нийслэлд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, говийн бүсэд Говьсүмбэр аймагт “МАА-н шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”, Зүүн бүсэд Дорнод аймагт “Зүүн бүсийн үйлдвэрлэл технологийн парк”-уудыг байгуулахаар төлөвлөн, төр хувийн хэвшлийн оролцоотойгоор бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. Тухайлбал, 2021-2025 оны төсөвт ХАА, үйлдвэрлэлийн кластер байгуулах арга хэмжээний хүрээнд Баянхонгор аймагт нийт 6 багц ажлыг гүйцэтгэн ингэний сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Хавсралт : 5 файл	
	588		5.24.3.2. Аймаг, нийслэлд бэлтгэх нөөцөлсөн махны төрөл, тоо хэмжээг тогтоон, өргөтгөсөн худалдааг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулах, тус арга хэмжээнд орон нутагт байгуулагдсан малчдын хоршоодыг оролцуулах замаар махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, салбар дундын уялдааг ханган ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан нарт;	ХХААХҮЯ-аас мах экспортлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Бодлогын гэрээ”-ний дагуу 2025 оны 02 дугаар сарын 05-20-ны өдрүүдэд төвийн 5 дүүргийн 5 байршилд зохион байгуулж үхэр 27.8 тн, хонь 192.6, ямаа 4.2 тн нийт 224.6 тн мах худалдан борлуулсан. 2.2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд өргөтгөсөн худалдаагаар хонины мах 4586.3 тн, үхрийн мах 1102.5 тн, хүнсний дэлгүүрт жижглэнгээр хонины мах 271.2 тн, үхрийн мах 393.5 тн, нийт 6353.5 тн буюу нийт бэлтгэсэн 8380 тонн махны 76.0 хувийг худалдан борлуулсан. Мөн Малчдын бэлтгэсэн гарал үүсэл нь тодорхой, эрүүл, үйлдвэрийн чанар шаардлагад нийцсэн мал, махыг зах зээлд борлуулж, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор "ЗҮҮН БҮСИЙН МАЛ, МАХНЫ ДУУДЛАГА ХУДАЛДАА"-г Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд UNDP in Mongolia - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр АДАПТ ТӨСӨЛ-тэй хамтран зохион байгууллаа.Тус дуудлга худалдаагаар Сүхбаатар аймгийн Дарьганга сумын малчины хоршоо 205 бог мал, 21 адуу, Дорнод аймгийн Халхгол сумын малчины хоршоо 643 толгой хонь тус тус худалдан борлуулж дотоодын үндэсний үйлдвэрлэгч "Баян тал мах бэлтгэх үйлдвэр", "Дорнод мах маркет" ХХК зэрэг компаниуд үнэ өсгөх зарчмаар оролцон худалдан авсан юм. Хяналтаас хасуулах санал : өргөтгөсөн худалдааг зохион байгуулсан, махны дуудлага худалдаа зохион байгуулсан байна.	Хэрэгжсэн - 100%
	589		5.24.3.5. Хаврын улирлын нөөцийн мах нийлүүлэлтийн үед гэрээний үнийн дүнгээс хамаарч мах экспортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд тодорхой үүрэг хүлээлгэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт	Тус яам мах экспортлогч аж ахуйн нэгжтэй бодлогын гэрээг байгуулан ажилладаг бөгөөд тухайн экспортлогч аж ахуйн нэгжүүдэд тодорхой үүрэг хүлээлгэх тухай зааltыг оруулсан. Үүний үр дүнд махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мах, махан бүтээгдэхүүний 30 орчим экспортлогч аж ахуйн нэгж 3-6 байршилд, 14 хоногийн хугацаанд нийт 230.0 тн орчим үхэр, хонь, ямааны махыг дотоодын зах зээлд үе шаттайгаар худалдаалж, махны үнэ тогтворжиход тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
	590		5.24.3.6. Хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан нөөцөлсөн махны нийлүүлэлт, түгээлт, борлуулалтын үйл ажиллагааны чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт.”	2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд өргөтгөсөн худалдаагаар хонины мах 4586.3 тн, үхрийн мах 1102.5 тн, хүнсний дэлгүүрт жижиглэнгээр хонины мах 271.2 тн, үхрийн мах 393.5 тн, нийт 6353.5 тн буюу нийт бэлтгэсэн 8380 тонн махны 76.0 хувийг худалдан борлуулсан. Нийт 179 дэлгүүрээр үе шаттай худалдааг эхлүүлж, 02 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүүргийн 446 хүнсний дэлгүүрээр үхрийн мах 13800 кг/төг, хонины мах 11800 кг/төгрөгийн үнээр буюу зах зээлийн үнээс үхрийн мах 30-36 хувь, хонины мах 30-35 хувь, ямааны мах 20-30 хувиар хямд үнээр борлуулж, 2024.04.19-ний өдрөөс өргөтгөсөн худалдааг 9 дүүргийн нутаг дэвсгэрт долоо хоног бүрийн амралтын болон ажлын тус бүр 2 өдөр 23-41 байршилд зохион байгуулж, УБ хотын Ерөнхий менежерийн баталсан хуваарийн дагуу Мал эмнэлгийн газар, 9 дүүргийн ЗДТГ, Татварын хэлтэс болон хорооны нийт 60-63 албан хаагч хамтран тухай бүр хяналт тавьж дүн мэдээг нэгтгэн ажилласан. Борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс үхрийн махны үнийг 800 төг, хонины махны үнийг 1800 төгрөгөөр бууруулж өргөтгөсөн худалдаагаар үхрийн мах 13,000 кг/төг, хонины мах 10,00 кг/төгрөг, хүнсний дэлгүүрт үхрийн мах 13,300 кг/төг, хонины мах 10,300 кг/төгрөгийн үнээр худалдан борлуулсан. Махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мах, махан бүтээгдэхүүн 30 орчим экспортлогч аж ахуйн нэгжүүд 3-6 байршилд, 14 хоногийн хугацаанд нийт 230.0 тн орчим үхэр, хонь, ямааны махыг дотоодын зах зээлд үе шаттайгаар худалдаалсан. Хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан	Хэрэгжсэн - 100%

				нөөцөлсөн махны нийлүүлэлт, түгээлт, борлуулалтын үйл ажиллагааны чанар, аюулгүй байдалд Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагчид борлуулалтын цэгт ажиллах хуваарь гаргаж хяналт тавьж ажилласан бөгөөд ХХААХҮЯ-наас хяналтын мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Хяналтын явцад иргэдээс махны чанар, аюулгүй байдалтай холбоотой санал, гомдол гараагүй байна.	
	591		5.24.1.1. Шуурхай штабын хуралдааны үеэр Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэхээр тогтсон асуудалд холбогдох саналаа яаралтай горимоор өгч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	Шуурхай штабын хуралдааны үеэр Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэхээр тогтсон асуудалд холбогдох саналаа яаралтай горимоор өгч ажиллаж байна. 2025 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар яаманд нийт 9040 албан бичиг ирүүлснээс (4390 албан бичиг нь хариутай, 4650 албан бичиг хариугүй) 94.1 хувийг шийдвэрлэсэн, хяналтад 234 албан бичиг байсан байна. Үүнээс Бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хариутай 978 албан бичиг ирснээс 940 албан бичгийг шийдвэрлэж, 38 албан бичиг хяналтад байсан ба шийдвэрлэлтийн хувь 96.1 байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
240	592	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-01-29 Дугаар 2025_06	6.19.2. Мах, махан бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах, үнийг зохистой түвшинд хадгалах, нийслэлийн хүн амын хэрэгцээнд нийлүүлэх махны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан хонь, үхрийн мах экспортлох үйл ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгав.” (Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2025 оны хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай)	Өгөгдсөн үүргийн дагуу Нийслэлд махны өргөтсөн худалдааг зохион байгуулсан мөн нөөцийн махыг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 179 дэлгүүрээр үе шаттай эхлүүлж, 02 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүүргийн 446 хүнсний дэлгүүрээр үхрийн мах 13800 кг/төг, хонины мах 11800 кг/төгрөгийн үнээр буюу зах зээлийн үнээс үхрийн мах 30-36 хувь, хонины мах 30-35 хувь, ямааны мах 20-30 хувиар хямд үнээр борлуулж эхэлсэн 2024.04.19-ний өдрөөс өргөтгөсөн худалдааг 9 дүүргийн нутаг дэвсгэрт долоо хоног бүрийн амралтын 2 өдөр, ажлын 2 өдөр 23-41 байршилд зохион байгуулж УБ хотын Ерөнхий менежерийн батлсан хуваарийн дагуу Мал эмнэлгийн газар, 9 дүүргийн ЗДТГ, Татварын хэлтэс болон хорооны нийт 60-63 албан хаагч хамтран тухай бүр хяналт тавин, дүн мэдээг нэгтгэн ажилласан.Хонь, үхрийн мах экспортлох үйл ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлэх асуудлыг судалж Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд танилцуулахад хонь, үхрийн мах экспортлох үйл ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлэх шаардлагагүй, махны нийлүүлэлтийг тасалдуулахгүй байхад анхаарах зөвлөмж өгсөн. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	593		6.26.2. Үүнтэй холбогдуулан хүйтний улиралд ажлын цагийн зохицуулалтыг уян хатан болгох талаар судалж танилцуулахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд даалгав.” (Нийтээр амрах баярын өдрүүдэд зохицуулалт хийх талаар)	Салбарт хамааралгүй Хяналтаас хасуулах санал : Салбарын эрхлэх асуудалд хамааралгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
	594		6.26.5.2.2. “Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	ХХААХҮ-ийн сайдын 2025.02.28-ны өдрийн "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө батлах тухай" А/96 тушаал албажсан. Энэхүү стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд батлагдсан. Тус яамны чиг үүрэгт хамаарах 129 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж, 2025 оны жилийн эцсийн байдлаар төсөл, арга хэмжээний дундаж 77.1%-тай дүгнэгдэж, цахим системд тайлагнасан. Салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн “Ажил эрчимжүүлэх тухай” А/249 дугаар тушаалаар яамны бүтцийн 12 нэгж, харьяа 8 байгууллагад нийт 126 буюу давхардсан тоогоор 133 үүрэг, даалгавар өгөгдөж, хэрэгжилтэд сар бүр хяналт-шинжилгээ хийж, үр дүнг удирдлагад танилцуулж ажилласан байна. 2025 оны 10 сарын тайлангаар хэрэгжилтийн дундаж 61.1%-тай дүгнэгдсэн, жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн тайланг нэгтгэж байна. “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан бодлогын зорилтыг хэрэгжүүлэхээр 2026 оны салбарын төсөвт 557.2 тэрбум төгрөгийг батлагдсан.	Хэрэгжсэн - 100%

				Хавсралт : 2 файл	
	595		6.26.9.1. Компакт гэрээний урьдчилсан болзолт нөхцөлүүдийг хэрэгжүүлэх хүрээнд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн туршилт, тохируулга эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, Улаанбаатар хотын шинээр баригдаж буй төв цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, 2025 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд, Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг эрчимжүүлж, биелэлтийг Засгийн газарт танилцуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;(Гадаад харилцааны яамаар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар, Мянганы Сорилтын Корпорацаар төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улс хооронд байгуулсан “Мянганы сорилтын компакт гэрээ”-ний хүрээнд хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын талаар)	МУЗГ, АНУ-ын хооронд 2018.07.27-ны өдөр байгуулсан Мянганы сорилтын Компакт гэрээний урьдчилсан болзолт нөхцөлийг хангах хүрээнд МУЗГ-ын 2021 оны 53-р тогтоолоор батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөний хэрэгжилт”-ийг хангаж, тайланг тухай бүр гаргаж албан бичиг болон цахимаар БХБОСЯ болон МСС-руу хүргүүлж ажилласан. УЦБ зайлшгүй суурилуулах шаардлагатай хөнгөн үйлдвэрлэлийн салбарын 30 ААНБ УЦБ суурилуулж, тулгамдсан асуудал болон туршлагаа бусад салбарын үйлдвэр, ААНБ-уудад хүргүүлэн ажиллаж байна. Жайка ОУБ-ын “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд ХХААХҮЯ нь “Үйлдвэрийн хаягдал усны менежменттэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, тогтолцооны талаар ойлголт, мэдлэг мэдээллийг үйлдвэр аж ахуйн нэгж, олон нийтэд сурталчлах, танилцуулах, туршлага солилцох IV ажлын хэсгийг ахлан ажилласан. Энэ хүрээнд хөнгөн, хүнсний үйлдвэрийн ААН-үүдийг воркшоп, хэлэлцүүлэгт өргөнөөр хамруулж, туршлага солилцуулахаар мэргэжлийн холбоодтой хамтран мэдээлэл хүргэж, зохион байгуулалтыг хийж ажиллав. Төслийн тайлангийн хуралд төсөл хэрэгжүүлэх хугацаанд хийсэн ажлын тайлангаа танилцуулж, панелистаар оролцов. Мөн хөнгөн үйлдвэрийн Говь ХК, хүнсний үйлдвэрийн Жүр Үр ХХК-ууд “Урьдчилсан цэвэрлэх байгууламж байгуулсан туршлага”-аа хуваалцав. ЖАИКА-гийн “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн АХ1-ийг ахалж буй БОУАӨЯ-наас "MNS6561:2024 стандартыг хэрэгжүүлэхэд тулгамдаж болзошгүй асуудлуудыг цэгцлэн, хэрхэн шийдвэрлэхийг санал болгосон үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцэх хуралд 2025.12.22-ны өдөр оролцов. “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хамтарсан зохицуулах зөвлөлийн тавдугаар хуралд 2025.09.12-ны өдөр БХБОСЯ дээр болж төслийн төлөвлөлтийн матрицад санал тусгав. Хавсралт : 2 файл	Ахиц гарсан - 50%
241	596	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-05 Дугаар 2025_07	7.26.1.1. Шуурхай штабын хуралдаан дээр Ерөнхий сайдаас өгсөн шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайланг тухай бүр ERP системд тусгаж ажиллахыг Засгийн газрын нийт гишүүдэд;	Ерөнхий сайдаас өгсөн шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр ЗГХЭГ-ын цахим систем (new.unelgee.gov.mn)-ийн Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгавар цэс (https://new.unelgee.gov.mn/task_prime_v3/)-ээр тухай бүр тайлагнаж хэвшсэн байна. Үүнд нийт 5 үүрэг даалгаварт хамаарах 11 зааltын хэрэгжилтийг тайлагнасан.	Хэрэгжсэн - 100%
	597		7.26.2.3.3.2. төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа татаас, дэмжлэгийн үр ашигт дүн шинжилгээ хийж, цаашид үе шаттайгаар багасгах, зогсоох талаар санал боловсруулж, 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт; (З.Эдийн засгийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:)	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн БИОФИН төслийн хүрээнд төсвийн татаас, урамшуулал, дэмжлэг, ялангуяа Хөдөө аж ахуйн салбарын татаас, урамшууллыг тогтвортой хөдөө аж ахуйн практикийг дэмжсэн, байгаль орчин, биологийн олон янз байдалд ээлтэй байдлаар дахин загварчлах боломжийг ялангуяа салбарын хэмжээнд төрөөс олгож буй татаас, урамшууллаас сүүний урамшууллыг нарийвчлан судалсан. Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А218/А146 хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд журамд дордурсан нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулан дахин боловсруулаад байна. 1. Төрөөс олгож буй дэмжлэг, урамшууллын үр дүн, үр нөлөөнд үнэлэлт, дүгнэлт хийж, салбарын дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан, тухайн жилд олгох урамшуулалд хамрагдах таримлын нэр төрлийн жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгасан. 2. Тухайн жилийн урамшууллын жагсаалтад тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс 5-аас дээшгүй таримлын нэр, төрлийн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх хувь, хэмжээг тогтоох зэрэг. Хувь хэмжээ гэдэгт дан ганц мөнгөн урамшуулал бус, мөнгөн бус дэмжлэгийг хувь хэмжээтэй тогтоож өгснөөр төсвийн үр ашгийг илүү нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. 3. Урамшууллын шаардлагыг илүү өндөрсгөсөн. Мөнгөн урамшуулал, мөнгөн бус дэмжлэг олгоход тавих хяналтыг урамшууллын журмын харилцаанд оролцогч болгоноор тусгайлан	Хэрэгжсэн - 100%

				тодорхойлж оруулсан. Одоогийн байдлаар уг журмын төсөлд Сангийн яамны саналыг тусгасан. Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дууссан - 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах	
	598		7.26.2.3.3.4. Энэ тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирал тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт даалгав.	Хавсаргасан тэмдэглэлд үүрэг даалгавар байхгүй байна	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй
242	599	Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-08 Дугаар 2025_08	8.22.6.1. Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд тухайн шийдвэрийн ач холбогдол, үр нөлөөний талаар оролцогч талуудад нэгдсэн ойлголт өгөх ажлыг тухай бүр зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллах, бодлого, шийдвэрийн зорилго, үр нөлөө, ач холбогдлын талаарх мэдээллийг нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав;(Засгийн газрын шийдвэрийн танилцуулга, хэрэгжилтийн талаар)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтөд мал аж ахуйн салбарын нөлөөллийн талаарх, Мал аж ахуйн салбарын өнөөгийн нөхцөл байдлын танилцуулга тус тус бэлтгэж холбогдох шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангав. Монгол Улсын мал аж ахуйн салбарын эдийн засгийн тоон үзүүлэлтийн тойм судалгаа (2020–2024)-г нэгтгэв. МАА-н салбарын болон салбар хоорондын 5 удаагийн хэлэлцүүлэг, семинарт оролцож МАА-н салбарын бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилтийн талаар танилцуулга илтгэл тавьж, хэлэлцүүлсэн. 2025 онд газар тариалангийн салбар дахь бодлогын үр дүнгийн талаарх 79 мэдээллийг яамны албан ёсны цахим хаяг болох mofa.gov.mn-ээр дамжуулан олон нийтэд хүргэсэн. Мөн түүнчлэн "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл" нэгдсэн арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулж, нийт 1.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, эх орны хөрсөнд ургасан эрүүл, баталгаатай, шинэхэн хүнсний ногоо жимс жимсгэнэ зэргийг хэрэглэгчдэд сурталчлан таниуллаа. Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих тухай” 63 дугаар тогтоолоор батлсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд зорилго, агуулга, хэрэгжилтийг таниулах чиглэлээр 2025 оны 1 дүгээр сараас эхлэн хамтран хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагууд, арилжааны банкуудад зориулсан сургалт, хэлэлцүүлэг, үйлдвэрийн аялал, зөвлөгөөн, уулзалтыг танхим болон цахимаар нийт 39 арга хэмжээ зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан цаг үеийн мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсаар олон нийтэд түгээх ажлыг ЖДҮГ-аас гүйцэтгэсэн. Мөн 50,000 дагагчтай нийгмийн сүлжээгээр 802 мэдээ, мэдээлэл оруулж, тухай бүр нийтэд түгээн ажилласан.	Ахиц гарсан - 50%
243	600	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-26 Дугаар 2025_10	10.19.4.1. Тогтоол, шийдвэр батлах эрх зүйн үндэслэлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний дугаар, өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой зааж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засагдарга нарт:(19.4.Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн талаар)	Тогтоол, шийдвэр батлах эрх зүйн үндэслэлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний дугаар, өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой зааж тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн ХХААХҮ-йн сайдаас үүрэг даалгаврыг тодорхой хугацаатай өгч, хэрэгжилтэд 5 ХШҮ хийсэн байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	601		10.19.4.2. Холбогдох хууль тогтоомжоор өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд шуурхай зохион байгуулан бүрэн хангахад анхаарч, эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Засгийн газрын 2025 оны албан даалгаврууудын хэрэгжилтэд сар бүр ЗГХЭГ болон ХХААХҮ-ийн салбарын ХШҮ-ний цахим системээр дамжуулан ХШ хийж, удирдлагуудад үр дүнг тухай бүр танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Ингэснээр албан даалгавраар өгөгдсөн үүрэг даалгаврууд аас зөвхөн 1 арга хэмжээ санхүүжилт шийдвэрлэгдээгүй нь улмаас хэрэгжилт хангагдаагүй байна. Сайд А/249 дүгээр тушаалаар яамны бүтцийн нэгж, харьяа байгууллагад өгөгдсөн 126 үүрэг даалгаварт 5 удаа, ТНБД 19 удаагийн шуурхай хуралдаанаас өгөгдсөн 382 үүрэг даалгаварт тус тус үнэлгээ хийж дүнг удирдлагад танилцуулж ажилласан. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 2, 3 дугаар улиралд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр баталсан 176 тушаал болон 1 дүгээр улирлын байдлаар хэрэгжилт хангалтгүй дүгнэгдэж, 3 дугаар улиралд үргэлжлүүлэн хяналтад авсан сайдын 16, ТНБД-ын 3 нийт 195 тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 98 (50.25 %), хэрэгжих шатанд 61 (31.28%), хэрэгжилт хангалтгүй 17 (8.71%), хэрэгжээгүй 6 (3.07%), хугацаа болоогүй 13 (6.66%) буюу 3 дугаар улирлын байдлаар тушаалын хэрэгжилтийн дундаж дүн 80.11% үнэлэгдэв. Тайлант хугацаанд төлөвлөгөөт	Хэрэгжсэн - 100%

				2 , төлөвлөгөөт бус 20удаагийн удирдамжтай дотоод хяналт шалгалт хийж удирдлагын зөвлөл, удирдлагад танилцуулан холбогдох байгууллага нэгжид санал зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Хавсралт : 4 файл Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах	
244	602	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-03-12 Дугаар 2025_12	12.3.2. Уг хэлэлцээнд эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд оролцох яам, агентлагийн албан хаагчдыг бүрэн хариуцлагатай оролцох байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав	Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн улс орнуудын хоорондын Худалдааны түр хэлэлцээрийг Бүгд Найрамдах Беларус Улсын Минск хотноо 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан. Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төсөлд газар тариалангийн үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтыг боловсруулахад Монголын тариаланчдын үндэсний холбоотой хамтран ажиллаж, зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг хасах саналыг гаргаж /хүнсний зөөлөн улаанбуудай/ хэлэлцүүлсэн. Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төсөл болон гаалийн татвараас чөлөөлөх хөнгөн, хүнсний үйлдвэрийн барааны жагсаалтыг боловсруулж ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Тус жагсаалтыг “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо хөдөлгөөн”, “Атрын-4" тариалангийн тогтвортой хөгжлийн аян” зэрэг хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог бүрэн хангаж, холбогдох төлөөллийг ажлын хэсэгт оролцуулж, салбарын нэгдсэн байр суурийг тодорхойлж ажилласан. Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбооны хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээрийн гурав дахь шатны хэлэлцээний бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун ажилласан. Бэлтгэл ажлыг хангах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцээрийн төсөлд холбогдох саналыг ЭЗХЯ-нд тухай бүр хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
245	603	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-03-26 Дугаар 2025_14	14.16.1.1. Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг эрчимжүүлж, хөдөө аж ахуйн салбарт хиймэл оюун ухаанд суурилсан шинжлэх ухаан, технологийн оновчтой шийдлийг нэвтрүүлэх, их өгөгдөлд тулгуурласан бодлого төлөвлөлт, үйлдвэрлэл үйлчилгээг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр Засгийн газарт тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт;	Тариалсан талбайг зайнаас тандан судлах аргад үндэслэн хянан баталгаажуулахад Тариалангийн үйлдвэрлэлийн цахим системийг хөгжүүлэх (Тариалсан талбайг зайнаас хянан, баталгаажуулах цахим системийг үүсгэх) ажлыг 2026 онд эхлүүлэхээр төсвийн саналд тусгасан. .....AI-ээр хянагдах ухаалаг хүлэмжийн пилот төсөл - KOICA-тай хамтран AI-ээр хяналттай “Air Farm” технологийг туршиж эхэлсэн. ..... Ухаалаг (Smart) greenhouse / AI хүлэмж Улаанбаатар хотод “National Smart Greenhouse Complex” төсөл хэрэгжиж байна (2025–2028). Энэ төсөлд ахисан технологи бүхий хүлэмжүүд, вертикаль тариалалт, AI-ээр хянагдах орчны системүүд, үйлдвэрлэл-судалгааны төвүүд багтана. Үүнд хүлэмжийн гэрэл, температур, чийгшил зэргийг автомат удирдах, өгөгдөлд суурилсан тариалалтын шийдэл ашиглах технологи бий болгох зорилготой. Энэ нь Монголын климатад тохирсон дижитал хөдөө аж ахуйн практикийн анхны томоохон төсөл юм.	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%
	604		14.16.1.2.. Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмж, үр бордоо, ургамал хамгааллын бодисыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт	Монгол Улсын Их хурлаас 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлагдсан бөгөөд тус хуулийн төсөлд трактор, комбайны импортын барааны гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлөхөөр заасан. Хүнс, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татварыг хөнгөлөх Засгийн газрын 2023 оны "Жагсаалт батлах тухай" 107 дугаар тогтоолын хүрээнд сүүлийн 2 жилийн хугацаанд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нийт 250 аж ахуй нэгжид 110 төрлийн 3123 ширхэг тоног төхөөрөмжийн нийт 10.2 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг чөлөөлсөн. Газар тариалангийн үйлдвэрлэл механикжуулалтын түвшинг нэмэгдүүлэх, тариалалт, боловсруулалт, ургац хураалтын ажлыг түргэн шуурхай зохион байгуулах зорилгоор 97 иргэн, аж ахуйн нэгжийн тухайн жилд худалдан авсан 104 ширхэг техникийн үнийн дүнд 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээнд 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр төмс, хүнсний ногооны 1200 га талбайн ажлыг механикжуулах боломж бүрдсэн. Атар-4 тогтвортой хөгжлийн аяны хүрээнд хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн диллерүүдийг дэмжихэд 26.9 тэрбум төгрөг, газар тариалангийн тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 17.79 тэрбум төгрөгийн хөнгөлөлтэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгосон байна. Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар ургац хураалтын ажлын явцтай танилцаж Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймагт 2025 оны 09 дүгээр сарын	Ахиц гарсан - 50%

				03, 09-ний өдрүүдэд ажиллах үеэр тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдээс таримал ургамлыг тариалж ургуулахад орж буй бүх орцууд болох техник, тоног төхөөрөмж, сэлбэг, шатахуун, үр бордоо, ургамал хамгааллын бодисын үнэ жил бүр нэмэгдэж байна.	
	605		14.16.1.3.. Баруун бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн 2022, 2023 онуудад арилжааны банкнаас авсан зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах асуудлыг судалж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт;	Баруун бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн 2022, 2023 онуудад арилжааны банкнаас авсан зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах ажлын хүрээнд арилжааны 10 банктай “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл”-ийн санхүүжилтийн 230330/07-218 дугаартай гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 250708/05-634 гэрээ, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний “Хөдөө аж ахуйг дэмжих зээл”-ийн хүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах 250708/05-627 гэрээг тус тус байгуулж ургац алдсан иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулсан.	Хэрэгжсэн - 100%
	606		14.16.1.4.. Алслагдсан бүс нутагт тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн стандартын шаардлага хангаж, дотоодын үйлдвэрт нийлүүлсэн хүнсний улаанбуудайн нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан нарт	ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/264 дугаар тушаалаар Баруун бүсийн газар тариалангийг үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Баруун бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, гурил, тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах, цаашид бүс нутгийн хэмжээнд импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд "Баруун бүсийн газар тариаланг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө" болон арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. Энэхү төлөвлөөний 3.1.7 дахь заалтад "Алслагдсан бүс нутгийн урамшуулалтай бүтээгдэхүүний нэр төрөл, урамшуулын мөнгөн дүнг ялгаатай тогтоох" заалтыг тусгасан байна. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	607		14.16.7.1.. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон зөвшөөрлийн хугацаа сунгах асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, хууль зөрчсөн зөвшөөрөл олгох шат дамжлагыг нэмэгдүүлсэн захиргааны хэм хэмжээний акт баталсан зөрчлийг даруй арилгаж цаашид гаргахгүй байхад анхаарч ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд;(Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахим хэлбэрт шилжүүлэх, холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар)	"Таримал ургамлын үр үйлдвэрлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт" баталсан "Жагсаалт батлах тухай" Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/195 дугаар тушаалыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/50 дугаар тушаалаар хүчингүй болгосон. "Журам батлах тухай" 2019 оны А/456 дугаар тушаал, "Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээлийн аюулгүй байдалд тавих шаардлага батлах тухай" 2021 оны А/29 дүгээр тушаалыг тус тус Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/100 дугаар тушаалаар хүчингүй болгож, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025.02.21-ний өдрийн 02/552, 2025.03.12-ны өдрийн 02/695 тоот албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нараас санаачлан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон бусад холбогдох материалуудыг судлан, санал боловсруулж ХЗДХЯ-нд хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
	608		14.16.7.2.. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох хүсэлтийг хүлээн авах, магадлан шалгах, шийдвэр гаргахад төрийн мэдээлэл солилцооны “Хур” систем, цахим төлбөрийн баримтын системийг ашиглах, шийдвэрийн талаар мэдэгдлийг “И-Монгол” цахим системээр дамжуулан иргэнд хүргэх нөхцөлийг бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн цахим систем (Liicense), Төрийн үйлчилгээний “e-business.mn” системийг ашиглах арга хэмжээг 2025 оны II улиралд багтаан хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Зөвшөөрлийн нэгдсэн сан (https://license.mn/licensed-organizations/tabs)-д 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2018-2025 онд олгосон нийт 1086 тусгай зөвшөөрлийн мэдээллийг оруулсан. ХХААХҮЯ-ны тусгай зөвшөөрлийн цахим системээс сервис хөгжүүлэлт хийж Санхүү мэдээлэл технологийн төв УТҮГ-т сервисээр мэдээлэл солилцож байна. Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх журмын дагуу системийг ашиглаж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн болон тусгай зөвшөөрлийн мэдээлэл болох шинээр олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаягийн мэдээллийг нээлттэй харж болно.	Хэрэгжсэн - 100%

246	609	Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-02 Дугаар 2025_15	15.13.4.2.. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах хүрээнд жилийн эцсийн тайлан, мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.”	Өргөдөл гомдлын мэдээллийг нэгдсэн сан https://petition.parliament.mn/-д холбогдсон тул цохогдож ирсэн өргөдөл гомдлыг хугацаанд нь хариу өгч, зөв бичих дүрмийн алдаагүй, ямар асуудлыг, яаж шийдвэрлэсэн талаар дэлгэрэнгүй бичиж шийдвэрлэхэд анхаарах зөвлөмжийг албан хаагчдад хүргүүсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ гаргах, хүргүүлэх тухай журмын дагуу 2025 оны жилийн эцсийн тайланг нэтгэж байна. Тайланг 2026 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр дуусгаж, хэрэгжилтэд үнэлгээ хийлгэж хүргүүлэхээр бэлтгэж байна. Иргэд, олон нийттэй харилцах төв 11-11 төвөөс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд ирсэн 241 өргөдөлд гомдлын мэдээг нэгтгэн хүргүүлсэн. Яаманд ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай 2024 оны эцэс, 2025 оны хагас жилийн байдлаарх өргөдөл гомдлын тайланг intranet.gov.mn, office.igovernment.mn, 11-11.mn-ээс гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Ургамал хамгааллын газарт иргэн, аж ахуйн нэгжээс бичгээр болон Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 3 дугаар улирлын тайланг гаргаж, мэдээг нэгтгэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт Төрийн нарийн бичгийн даргын 02/3018 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2025-10-27-ны өдрийн шуурхайн үүрэг даалгаварт "Албан хэрэг хөтлөлтөд онцгой анхаарах, хугацаа хэтэрсэн бичиг, өргөдөл гомдлын тоо, ажлын ачаалал зэргийг харуулсан матриц танилцуулга" бэлтгэж хүргүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар ХХААХҮЯ-д 667 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэсэн 632, хяналтад 25 нь байна, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 241 өргөдөл, гомдол ирснээс 233 шийдвэрлэсэн, 8 нь хяналтад байна.	Хэрэгжсэн - 100%
	610		15.13.5.1.. Нийслэлийн Шуурхай штабын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлж, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэлээр даалгасны дагуу биелэлтийг тухай бүр ERP системээр тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус;	Эрдэнэс Монгол ХХК Хяналтаас хасуулах санал : салбарт хамааралгүй тул хяналтаас хасах	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй
	611		15.13.7.. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. (Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2025 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. ХХААХҮ-ийн салбарт 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 82 худалдан авах ажиллагаанаас 77 худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим хаягаар зарлаж, 75 худалдан авах ажиллагааны гэрээ байгуулж, 91 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын мэдээлэл бэлтгэх, мэдээллийг нэгтгэн боловсруулж, сурталчлан таниулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Хавсралт : 3 файл Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа - 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж,	Хэрэгжсэн - 100%
	612		15.13.8.2.. Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн болон малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний хүрээнд олгож байгаа хөнгөлөлттэй болон ногоон зээлийн шаардлагад үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжтай байх нэмэлт	Ноос ноолуурын салбарын хагас болон бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн болон түүхий эд бэлтгэлийн тогтолцоог 22 стандартын хүрээнд шаардлага хангаж байгаа эсэхийг баталгаажуулж байна. ”Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд олгогдож буй хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй хуулийн этгээд нь Текстелийн тогтвортой үйлдвэрлэл, Хариуцлагатай нүүдэлчин, LWG стандартын шаардлага ханган баталгаажуулалтад хамрагдсан бол ногоон зээлд хамрагдах боломжтой ба	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлаг

			шаардлагыг тусган хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт;	хөтөлбөрийн хүрээнд 23.5 тэрбум төгрөгийн ногоон зээл олгосон. Ноос, ноолуур арьс ширний боловсруулах үйлдвэрүүд "Хот суурин газрын үйлдвэр, аж ахуйн нэгжээс MNS 6561:2024 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага" стандартын дагуу ус нийлүүлэх урьдчилан цэвэрлэх байгууламж барьж ашиглаж байна. Эргэлтийн болон хөрөнгө оруулалтын гэрээнд ногоон зээлийн шаардлагад урьдчилсан цэвэрлэх байгууламжийн шаардлагыг нэмж тусгуулах саналыг гэрээний оролцогч талуудад хүргүүлсэн байна.	атай - 50%
247	613	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-09 Дугаар 2025_16	16.20.1.2. Зайлшгүй шаардлагатайгаас бусад үйл ажиллагааг хуралдаантай давхцуулан зохион байгуулах, албан хаагчдыг томилолтоор ажиллуулахгүй байхад анхаарч, нэгдсэн журмаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Архангай аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан, Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Пүрэвдорж нарт;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нийт албан хаагчид болон харьяа байгууллагын удирдлагуудыг зайлшгүй шаардлагатайгаас бусад үйл ажиллагааг хуралдаантай давхцуулан зохион байгуулах, албан хаагчдыг томилолтоор ажиллуулахгүй байхад анхаарч, нэгдсэн журмаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан болно.	Хэрэгжсэн - 100%
	614		16.20.13.1.. Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор давуу эрх тооцох, экспортод гаргасан бүтээгдэхүүнд урамшуулал олгох, татварын дэмжлэг үзүүлэх бодлогын асуудлаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа томоохон аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, саналыг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт; (Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Дархан-Уул аймагт ажилласан томилолтын талаар ЗГ-дэд танилцуулж дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:)	"Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Төрийн худалдан авах ажиллагаа, зохицуулалт, шинэчлэх шаардлага" зөвлөлдөх уулзалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан (2025.04.11). Тус хэлэлцүүлэгт ЕТГ, Сангийн яам, ХХААХҮЯ, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбоо, Эрдэнэс монгол ХХК, Улаанбаатар төмөр зам ХНН-ийн төлөөллүүд болон ноос, ноолуур, арьс шир, оёдлын салбарын үйлдвэр ААНБ-ууд оролцсон. Хэлэлцүүлгээс гарсан үр дүнг ХХААХҮЯ болон ЕТГ-т албан бичгээр хүргүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн төсөлд тусгуулсан болно.	Хэрэгжсэн - 100%
	615		16.20.13.2.. Экспортод гаргасан бүтээгдэхүүнд урамшуулал олгох, буцаан олголт тооцох, үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих чиглэлээр татварын багц хуулийн төсөлд холбогдох саналыг тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт; (Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Дархан-Уул аймагт ажилласан томилолтын талаар ЗГ-дэд танилцуулж дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:)	Татварын багц хуулийн төсөлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01/3578 тоот бичгээр санал хүргүүлэв. Уг саналд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.1.11. "Экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс шир." гэснийг "Экспортод гаргасан угаасан, самнасан ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөвөр, хонины ноос, хагас боловсруулсан арьс шир" гэж өөрчлөн найруулах гэж тусгасан.	Хэрэгжсэн - 100%
	616		16.20.13.5.. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан хаагчдын орон сууцны ипотекийн зээл, түүнтэй холбогдох асуудлыг цогцоор шийдвэрлэх боломжийг судалж, санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт ;(Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Дархан-Уул аймагт ажилласан томилолтын талаар ЗГ-дэд танилцуулж дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа байгууллагын нийт 193 албан хаагч Дархан-Уул аймагт шилжин ажиллаж, албан хаагчдад орон нутгийн 20-40 хувийн нэмэгдлийг олгуулж байна. Шилжин ажиллаж буй албан хаагчдыг Дарханы Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийн оюутны дотуур байрнаас 30 өрөө тохижуулан, нийт 70-80 албан хаагчийг түр байрлуулж, бусад албан хаагчид орон сууц түрээслэн амьдарч байсан бөгөөд албан хаагчдын орон сууцны захиалга өгсөн нийт 125 албан хаагчийн урьдчилгаа төлбөрийн 30 хувийн төлбөрт нийт 6.1 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлсэн. Нийт 124 албан хаагчийн урьдчилгаа 30 хувь, ипотекийн зээлийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн, бүгд зээлд хамрагдсан байна.	Хэрэгжсэн - 100%
	617		16.20.13.7. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг шийдвэрлэх талаар санал боловсруулж, танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг шийдвэрлэх талаар санал боловсруулан шийдвэрлүүлж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлсэн. Дархан-Уул аймагт яам болон харьяа байгууллагуудын 80% бүрэн шилжсэн ба нүүлгэлтийн зардалд 485 сая төгрөг зарцуулсан байна.	Хэрэгжсэн - 100%

			нарт.” (Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Дархан-Уул аймагт ажилласан томилолтын талаар ЗГ-дэд танилцуулж дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:)		
	618		16.20.2.11.. Олон улсын зах зээлд үүсээд байгаа худалдаа, тарифын тодорхойгүй байдалтай холбогдуулан үүсэж болзошгүй эрсдэлийг тооцож, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжийг хамтран судалж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт.”	Дэлхийн эдийн засгийн худалдааны тарифын нөхцөл байдал, зах зээл дэх ноолуурын борлуулалтыг дэмжих, ноолуур бэлтгэлийн хугацаанд дотоодын үйлдвэрлэгч нарын санхүүжилтийг шийдвэрлэх, зээл олголтыг цаг алдалгүй зохион байгуулах шаардлага үүсэж Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Чиглэл өгөх тухай” 09 дүгээр тогтоолоор чиглэл өгч, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлээр даалгаж Монголбанк, арилжааны банкууд, үйлдвэрлэгч, "Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК, ХХААХҮЯ гэсэн дөрвөлсөн гэрээ байгуулан 7 тэрбум төгрөгийн вексель гаргасан.	Хэрэгжсэн - 100%
248	619	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-23 Дугаар 2025_19	19.24.3.2.. Энэ тэмдэглэлийн 1-д заасан арга хэмжээний хэрэгжилтийг Монголбанктай хамтран шуурхай зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгав.” (1-Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоол, Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг тус тус хангах хүрээнд дэлхийн эдийн засаг, худалдааны тарифын нөхцөл байдал, зах зээл дэх ноолуурын үнийн бодит байдлыг харгалзан ноолуурын худалдан авалтыг дэмжиж, жилийн 12 хувийн хүүтэй 500.0 (таван зуун) тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк (Б.Лхагвасүрэн)-нд зөвлөв;)	Зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Голомт банк”, “Ханбогд кашимер” ХХК болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн хооронд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 250623/06-573/974 дугаартай “Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ” болон 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 250623/06-574-1 дугаартай боловсруулах үйлдвэрээс самнасан ноолуур худалдан авах тухай дөрвөлсөн гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан. Хөдөө аж ахуйн бирж нь векселиэр худалдан авсан ноолуурын баталгаажуулалт, бүртгэлд хяналт тавих үүргээр оролцож, “Говь” ХК-ийн худалдан авсан ноолуурт хяналт тавьж, баталгаажуулалтыг гэрээний хавсралт маягтын дагуу гүйцэтгэн Голомт банк руу эх хувиар хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар векселиэр худалдан авсан ноолуурын эргэн төлөлт бүрэн хийгдэж, хэрэгжилт хангагдсан байна. Хөдөө аж ахуйн биржээс мөн "Хатант интернэшнл" ХХК-ийн самнах үйлдвэрт самнагдсан ноолууранд хяналт хийж, баталгаажуулалтыг маягтын дагуу хөтөлж, Голомт банкинд хүргүүлсэн. Говь ХК нь Голомт банктай 7 тэрбум төгрөгийн векселийн гэрээ байгуулж, Говь-Алтай аймгийн 2, Баянхонгор аймгийн 1 хоршооны нийт 27 малчнаас 3.0 тэрбум төгрөгийн ноолуур худалдан авч векселээр мөнгөжүүлсэн. Хавсралт : 2 файл	Ахиц гарсан - 50%
249	620	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-28 Дугаар 2025_20	20.1.7. Бүсийн хэмжээнд шинэ төрлийн таримал, малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх асуудлыг судалж, танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д даалгав.	2025 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газартай хамтран Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэр дэх 1137.80 га, Хонгор сумын нутаг дэвсгэр дэх 2937.07 га болон 895 га, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 524 га, Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэр дэх 497.1 га, Матад сумын нутаг дэвсгэр дэх 15000 га, Булган сумын нутаг дэвсгэр дэх 1500 га, Баянтүмэн сумын нутаг дэвсгэр дэх 3000 га, Халх гол сумын нутаг дэвсгэр дэх 30000 га, Чулуунхороот сумын нутаг дэвсгэр дэх 4000 га, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэр дэх 651.16 га, Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр дэх 957.84 га, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэр дэх 72.8 га, Баян-Овоо сумын нутаг дэвсгэр дэх 431 га, Биндэр сумын нутаг дэвсгэр дэх 577.4 га, Баянхутаг сумын нутаг дэвсгэр дэх 1049 га, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэр дэх 600 га, 4655.16 га болон 2749.69 га, нийт 71235.02 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 166 дугаар тогтоолыг боловсруулан батлуулсан. Нийт тариалангийн талбайн хэмжээ 71.2 мянган га талбайгаар нэмэгдэж 1033.2 мянган га талбайд хүрэв. Мөн атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх асуудлаар 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн	Ахиц гарсан - 50%

				01/2679 тоот албан бичгээр Увс, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Булган, Төв, Сэлэнгэ, Хэнтий, Хөвсгөл аймгийн Засаг дарга нарт орон нутгийн түвшинд атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж ажиллах талаар албан бичиг хүргүүлэн ажилласан. Уг асуудлаар өмнө нь 5 удаа албан бичгээр чиглэл хүргүүлэн ажилласан ч тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Хавсралт : 1 файл	
250	621	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-07 Дугаар 2025_22	22.20.. Ноолуур бэлтгэлтэй холбогдуулан авах арга хэмжээний талаар хэлэлцээд, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, холбогдох мэдээллийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт даалгав.”	Ноолуурын зах зээлийн байдлын талаар Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр ноолуурын үйлдвэрлэгчид, мэргэжлийн холбоо, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, ноолуур бэлтгэлийн явц, бизнесийн орчин, түүхий эдийн худалдан авалт, дотоод, гадаад зах зээлийн чиг хандлага, тулгамдаж байгаа асуудлын талаар ярилцсан. Үйлдвэрлэгчдээс баруун бүсийн ноолуурын эргэлтийн хөрөнгийн хэмжээ дутагдалтай талаар болон үнийг тогтворжуулах, малчдаас ноолуур худалдан авах, векселийг хэрхэн мөнгөжүүлэх, түүхий эдийг барьцаалах зэрэг асуудлаар дэлгэрэнгүй танилцуулсан. Вексель гаргах талаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлснээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 09 дугаартай тогтоол гарсан. https://www.facebook.com/story.php?story_fbid=1087356193421402&id=100064410953214&mibextid=oFDknk&rdid=waNIybe3gRKUZl1l#. Монгол банк, арилжааны банкууд, Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК-тай дөрвөлсөн гэрээг Хаан банк, Голомт банк, Говь ХК, Ханбогд кашемир ХХК-иудтай байгуулан гарын үсэг зурж албажуулсан. Говь ХК нь Говь-Алтай аймгийн 2, Баянхонгор аймгийн 1 хоршооны нийт 27 малчнаас ноолуур худалдан авч векселээр мөнгөжүүлсэн. Ноолуурын салбарт вексель гаргасан нь хөдөө аж ахуйн салбарт санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлсэн шинэлэг арга хэмжээ болсон. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%
	622		22.21.2.1. Бүсийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал шуурхай боловсруулж ирүүлэхийг Засгийн газрын гишүүдэд;	Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг бүсүүдэд зохион байгуулахтай холбоотойгоор Хангайн бүсийн хуралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Архангай аймагт, Хойд бүсийн хуралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймагт, Говийн бүсийн хуралдааныг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Дорноговь аймагт тус тус зохион байгуулсан. Хуралдааныг зохион байгуулахдаа тухай бүсийн аймгуудаас ирүүлсэн саналыг судлан үзэж, бүсийн анхдугаар хуралдаануудын үеэрх Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч ажилласан.	Хэрэгжсэн - 100%
251	623	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-12 Дугаар 2025_23	23.2.1.1. Өмнөговь аймгийн Даланзадгад суманд хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эрчимжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат нарт даалгав;	Засгийн газрын 2025 оны 271 дүгээр тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркийн байршил, үйл ажиллагааны чиглэлийг баталсан. Тус тогтоолын дагуу улсын хэмжээнд 5 бүс нутагт хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар ажиллаж байна. Өмнөговь аймагт шинээр хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад ХХААХҮЯ-наас Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан дэмжлэгүүдийг үзүүлэн ажиллах юм. Тус байршилд үйлдвэрлэл технологийн парк байгуулах судалгааг гүйцэтгэж буй зөвлөх багийг шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна. Тухайн технологийн паркад хоногт 4 тн ингэний сүү боловсруулах үйлдвэр, жилд 4000 тн ноос угаах үйлдвэрийг байгуулж, ашиглалтад бүрэн оруулахаар бэлтгэл ажлыг хангахаар төлөвлөснөөс гадна гүйцэтгэл 90-100% байна.	Ахиц гарсан - 50%
252	624	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлд	24.35.8.1.. Иргэдээс цахимаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	Өргөдөл гомдлын мэдээллийг нэгдсэн сан https://petition.parliament.mn/-д холбогдсон тул цохогдож ирсэн өргөдөл гомдлыг хугацаанд нь хариу өгч, зөв бичих дүрмийн алдаагүй, ямар асуудлыг, яаж шийдвэрлэсэн талаар дэлгэрэнгүй бичиж шийдвэрлэхэд анхаарах зөвлөмжийг албан хаагчдад хүргүүсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ гаргах, хүргүүлэх тухай журмын дагуу 2025 оны жилийн эцсийн тайланг нэтгэж байна. Тайланг 2026 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр дуусгаж, хэрэгжилтэд үнэлгээ хийлгэж хүргүүлэхээр бэлтгэж байна. Иргэд, олон нийттэй харилцах төв 11-11-ээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2025 оны 01дүгээр сарын 01-нээс	Хэрэгжсэн - 100%

		2025-05-21 Дугаар 2025_24		11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд ирсэн 241 өргөдөлд гомдлын мэдээг нэгтгэн хүргүүлсэн. Яаманд ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай 2024 оны эцэс, 2025 оны хагас жилийн байдлаарх өргөдөл гомдлын тайланг intranet.gov.mn, office.igovernment.mn, 11-11.mn-ээс гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Ургамал хамгааллын газарт иргэн, аж ахуйн нэгжээс бичгээр болон Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 3 дугаар улирлын тайланг гаргаж, мэдээг нэгтгэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт Төрийн нарийн бичгийн даргын 02/3018 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2025-10-27-ны өдрийн шуурхайн үүрэг даалгаварт "Албан хэрэг хөтлөлтөд онцгой анхаарах, хугацаа хэтэрсэн бичиг, өргөдөл гомдлын тоо, ажлын ачаалал зэргийг харуулсан матриц танилцуулга" бэлтгэж хүргүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар ХХААХҮЯ-д 667 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэсэн 632, хяналтад 25 нь байна, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 241 өргөдөл, гомдол ирснээс 233 шийдвэрлэсэн, 8 нь хяналтад байна.	
	625		24.35.7.1.2.. Өөрийн эрхлэх асуудлын хүрээний орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоотой нэгжийн үйл ажиллагааны бүтэц, чиг үүрэгт шинжилгээ, тооцоо судалгаа хийж, харьяа аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн саналыг үндэслэн байгууллагын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн санал боловсруулж, танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд;	ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоо бүхий Мал эмнэлгийн ерөнхий газар нь аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын сул орон тоог царцааж, чиг үүргийн шинжилгээнд үндэслэн сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч 102, Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч 1, Мал, амьтны эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн 6, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч 8, дүүргийн мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч 1, нийт 118 орон тоогоор тус тус цөөрүүлж, бүтэц тогтолцоог шинэчилж батлуулан мөрдөж байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагааны чиг үүргийн шинжилгээг Удирдлагын академиар гэрээгээр гүйцэтгүүлж, тайланг 2025 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авч, ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/548 дугаар тушаалаар "Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц"-ийг шинэчлэн батлуулсан.	Ахиц гарсан - 50%
	626		24.35.7.1.3.. Орон нутагт боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, 2025 оны 07 дугаар сард багтаан танилцуулахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Боловсролын сайд П.Наранбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт;	ХХААХҮ-ийн мэргэжлийн ажиллах хүч бэлтгэдэг мэргэжлийн боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх замаар мэргэжлийн мэдлэг, ур чадвар сайтай оффисын ажилчин, инженер, техникийн ажилчдыг бэлтгэх чиглэлээр салбарын дундын хамтын ажиллагааг сайжруулах, гадаадын их, дээд сургуульд суралцуулах, дадлагажуулах, мэргэжилтэн бэлтгэхийг бодлогоор дэмжих, хамтран ажиллах; Түүнчлэн, тусгай мэргэжлийн ажилчин, инженер, хүнсний технологич, тогооч, оёдолчин, загвар зохион бүтээгч, трактор, комбайнчин, жолооч, агрономич, малчин, малын эмч, техникийн ажилчин, туслах ажилчин, борлуулалтын менежер, түгээгч, үйлчлэгчдийг олноор бэлтгэхийг дэмжсэн бодлого, зохицуулалт хийж, хэрэгжүүлэх шаардлагатай юм. Улмаар "Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний төсөлд Ерөнхийлөгчийн илгээлтэд нарийн мэргэжлийн ажилтнуудыг дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцуулах саналыг тусгав. Энэхүү ажлын хүрээнд Ерөнхийлөгчийн илгээлтийн хүрээнд хөрс судлал мэргэжлээр 1, дэлхийн шилдэг сургуульд суралцах зээлийн хүрээнд агрономи мэргэжлээр 1, Засгийн газрын тэтгэлгийн хүрээнд хөдөө аж ахуйн кибернетик мэргэжлээр 2, сургалтын зээлийн хүрээнд 7 мэргэжлээр 48(мал зүй 2, тэжээл бэлчээр судлал 7, аграномн 15, хөрс судлал 2, ургамал хамгаалал 2, ойн аж ахуй 9, мал эмнэл зүй 11) буюу нийт 9 мэргэжлээр 52 оюутан боловсролын зээлийнсангийн 642.4 тэрбум төгрөгөөр гадаадын их, дээд сургуульд суралцаж байна. Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дууссан - 2025 оны 07 дугаар сард дууссан	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
253	627	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны	25.31.1.1. 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг	ЗГХХГ-аас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ТНБД-ын 2025.08.04-ний өдрийн А/236 дугаар бүхий тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан зөвлөмжийн биелэлтийг 2025.10.28-ны 02/3204 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%

		тэмдэглэл 2025-05-28 Дугаар 2025_25	эрчимжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, дүнг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хавсралт : 2 файл Хяналтаас хасуулах санал : хяналтаас хасах	
254	628	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-04 Дугаар 2025_26	26.27.3.3.. Компакт гэрээний дагуу шинээр байгуулж байгаа Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр болон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг төвлөрсөн дулаанаар хангах ажлыг төлөвлөгөөт хугацаанд дуусгаж, туршилт, тохируулгыг эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын үүрэг гүйцэтгэгч Ж.Батсуурь, Эрчим хүчний сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын үүрэг гүйцэтгэгч С.Одонтуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт.”	Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын хооронд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Мянганы сорилтын Компакт гэрээний урьдчилсан болзолт нөхцөлийг хангах хүрээнд 1) Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөний хэрэгжилт”-ийг хангаж, тайланг тухай бүр гаргаж албан бичиг болон цахимаар БХБОСЯ болон Мянганы сорилтын сан руу илгээж ажиллав. Зайлшгүй суурилуулах шаардлагатай хөнгөн үйлдвэрлэлийн салбарын 30 аж ахуйн нэгж ус цэвэршүүлэх байгууламж суурилуулж, тулгамдсан асуудал болон туршлагаа бусад салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд хуваалцан ажиллаж байна. ЖАЙКА ОУБ-ын “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд ХХААХҮЯ нь “Үйлдвэрийн хаягдал усны менежменттэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, тогтолцооны талаар ойлголт, мэдлэг мэдээллийг үйлдвэр аж ахуйн нэгж, олон нийтэд сурталчлах, танилцуулах, туршлага солилцох IV ажлын хэсгийг ахалж, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн ААН-үүдийг воркшоп, хэлэлцүүлэгт өргөнөөр хамруулж, туршлага солилцуулахаар мэргэжлийн холбоодтой хамтран мэдээлэл хүргэж, зохион байгуулалт хийж ажиллаа. Төслийн тайлангийн хуралд хийсэн ажлын тайланг танилцуулж, панелистаар оролцов. Мөн хөнгөн үйлдвэрийн Говь ХК, хүнсний үйлдвэрийн Жүр Үр ХХК “Урьдчилсан цэвэрлэх байгууламж байгуулсан туршлага”-аа хуваалцлаа. ЖАИКА-гийн “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн АХ1-ийг ахалж буй БОУАӨЯ-наас "MNS6561:2024 стандартыг хэрэгжүүлэхэд тулгамдаж болзошгүй асуудлуудыг цэгцлэн, хэрхэн шийдвэрлэхийг санал болгосон үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцэх хурал (2025.12.22)-д оролцов. “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хамтарсан зохицуулах зөвлөлийн тавдугаар хурал (2025.09.12)-д БХБОСЯ дээр болж төслийн төлөвлөлтийн матрицад санал тусгав.	Хэрэгжсэн - 100%
255	629	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-20 Дугаар 2025_2	2.4.2.2.. Нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор тамхины импортыг 2024 оны импортын хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар квотын зохицуулалтын арга хэмжээ авах асуудлыг судалж, холбогдох саналыг нэн яаралтай Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, тамхи болон бусад бараанд ногдуулах онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, холбогдох зохицуулалтыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус даалгав.”(.Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар)	Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд Монгол Улс нь олон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээ, үүргийг хүлээсэн бөгөөд импортын квот буюу тоон хязгаарлалт тогтоохыг хориглосон байдаг. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (GATT 1994)-ийн XI дүгээр зүйлд: “Гаалийн татвар, татвар болон бусад төлбөрөөс өөр хэлбэрээр аливаа барааны импортод хориг, хязгаарлалт тогтоохыг хориглоно” гэж заасан бөгөөд импортын квот нь уг заалтад хамаарах тоон хязгаарлалтын арга хэмжээ тул зарчмын хувьд хориглогдсон зохицуулалт юм. Иймд нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд импортын квот тогтоохоос өөр, ДХБ-ын гэрээ, хэлэлцээрт нийцсэн бодлогын арга хэмжээг судалж, холбогдох саналыг боловсруулах шаардлагатай гэж үзсэн. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Тус хуралдааны тэмдэглэл нь Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (GATT 1994)-ийн XI дүгээр зүйлийг зөрсөн байх тул хяналтаас хасах	Х.Б
256	630	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 3 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-25 Дугаар 2025_3	3.17.6.2.. Эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд тус чуулганы арга хэмжээнд зохих дэмжлэг үзүүлж, идэвхтэй, оролцоог бүрэн хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	"Эдийн засгийн чуулган-2025" арга хэмжээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбараас "Хүнсний хангамж" сэдэвт салбар хуралдааныг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж ажилласан.	Хэрэгжсэн - 100%
257	631	Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 4	1.1. Эрхэлсэн чиг үүрэг, харьяа салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын агентлаг, төв, нэгж, улсын үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн чиг үүрэг,	Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432004217932.	Ахиц гарсан - 50%

		дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-02 Дугаар 2025_4	үйл ажиллагааны үр ашиг, үндэслэл, хэрэгцээ, шаардлагад дүн шинжилгээ хийж, нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтэц, орон тоог оновчтой тогтоох, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэн гүйцэтгүүлэх саналыг холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулж, 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;	ХХААХҮЯ нь төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог цөөлөх хүрээнд 2025 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан орон тоонд үндэслэн ажлын байрны шинжилгээг хийж, 9 хувиар цомхотгон сайдын 2025 оны Б/14, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/111 дүгээр тушаалаар тус тус орон тооны хязгаар, бүтцийг баталж, мөрдөж байна. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын сул орон тоог царцааж, чиг үүргийн шинжилгээнд үндэслэн нийт 118 орон тоогоор цөөрүүлж батлан, мөрдөж байна. Мал эмнэлгийн ерөнхий газар ХХААХҮ-ийн сайдын 2025 оны А/548 дугаар тушаалаар "Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц"-ийг шинэчлэн батлуулсан. ЖДҮГ нь Засгийн газрын 2025 оны "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолын дагуу бүтэц орон тооны өөрчлөлт хийж, өмнө батлагдсан бүтцээс удирдах 2, гүйцэтгэх 3, нийт 5 албан тушаалтны орон тоог цөөрүүлсэн. Хяналтаас хасуулах санал : Заасан хугацаа дууссан - 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор	
	632		1.2.. Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулахад зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтны чиг үүрэг, хариуцах ажил нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан хаагчийн болон тухайн агентлагийн харьяа төв, орон нутгийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, компани, гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын хариуцсан чиг үүрэг, ажилтай давхардахгүй байх чиглэл баримтлах;	1.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны “Бүтцийн нэгжийн орон тоо шинэчлэн батлах тухай” Б/14 дүгээр тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Яамны бүтцийн нэгжийн албан тушаал шинэчлэн батлах тухай” Б/111 дүгээр тушаалыг тус тус батлуулсан. 2.Тушаал батлагдсантай холбогдуулан яамны төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх 109 албан тушаалын тодорхойлолтод чиг үүрэг, 87 албан хаагчийн мэргэжлийн индексд шинжилгээ хийж, 36 хуудас тайланг боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын шинээр болон шинэчлэн, нэмэлт, өөрчлөлт оруулах нийт 66 албан тушаалын тодорхойлолтын харьцуулалт, танилцуулгыг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 362, 363, 364, 365 дугаар тогтоолыг тус тус батлуулав. 4.Албан тушаалын тодорхойлолтууд шинээр болон шинэчлэн, нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор "Хүний нөөцийн удирдлагын цахим тогтолцоо" системд байгууллагын шинэчилсэн бүтэц, албан тушаалын тодорхойлолтуудыг шинээр оруулж, Төрийн албаны зөвлөлд хянуулан, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр батлуулав. 5."Хүний нөөцийн удирдлагын цахим тогтолцоо" системд бүртгэлтэй 99 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн баталгаажуулав. 6.ХХААХҮ-ийн сайдын 2025.09.09-ний өдрийн А/434 дугаар тушаалаар “Агентлагийн бүтэц орон тоо, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг шинэчлэн батлуулсан. Тус хөтөлбөрт тусгагдсанаар байгууллагын нэгж, албан хаагчдын чиг үүрэг нь салбарын яамны нэгж, албан хаагчдын болон бусад холбогдох төрийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газрын чиг үүрэгтэй давхардаагүй болно. Хавсралт : 5 файл	Хэрэгжсэн - 100%
	633		1.3.. Засгийн газрын агентлагийн бүтцийн нэгжийн оноосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардахгүй байх, хуульд өөрөөр заагаагүй бол дэд, орлогч даргагүй байх, үндсэн чиг үүрэгт хамааралгүй хэлтэс газар дотор байгуулахгүй байх, хэлтэс нь дотроо тасаг, албагүй байхаар тогтоох чиглэл баримтлах;	Мал эмнэлгийн салбар нь сул орон тоог царцааж, чиг үүргийн шинжилгээнд үндэслэн нийт 118 орон тоогоор цөөрүүлсэн. Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээг Удирдлагын академиар гэрээгээр гүйцэтгүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/548 дугаар тушаалаар "Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц"-ийг шинэчлэн батлуулсан. Агентлагийн бүтцийн нэгжийн оноосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардаагүй, орлогч даргагүй, үндсэн чиг үүрэгт хамааралгүй хэлтэс газар дотор байгуулаагүй болно. Засгийн газрын 2025 оны "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолоор тус агентлагийн орон тооны дээд хязгаарыг 46 байхаар тогтоосны дагуу ХХААХҮ-ийн сайдын 2025.09.09-ний өдрийн А/434 дугаар тушаалаар "Агентлагийн бүтэц орон тоо, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг 6 нэгж, 46 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар шинэчилж батлуулсан. Газрын бүтцийн схем нь 3 газар, 3 хэлтэстэй бөгөөд хэлтэс нь дотроо тасаг, албагүй болно. Агентлагийн	Хэрэгжсэн - 100%

				бүтцийн нэгжийн онооосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардаагүй, орлогч даргагүй, үндсэн чиг үүрэгт хамааралгүй хэлтэс газар дотор байгуулаагүй болно. Ургамал хамгааллын газрын нэр давхардаагүй, орлогч даргагүй, үндсэн чиг үүргийн дагуу 3 хэлтэстэй ажиллаж байна.	
	634		1.4.. Засгийн газрын агентлагийн орон тооны дээд хязгаар тогтоох саналыг Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруупах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилгод нийцүүлэн боловсруулах.	Засгийн газрын 2025 оны “Агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолоор тус агентлагийн орон тооны дээд хязгаарыг 46 байхаар тогтоосон. Дээрх тогтоолын дагуу Агентлагийн бүтэц орон тоо, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 6 нэгж, 46 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар салбарын сайдаар шинэчлэн батлуулсан. 2026.01.08-ны өдрийн байдлаар батлагдсан орон тооноос дотогш орон тоотой ажиллаж байгаа бөгөөд төсвийн зардал хэмнэлтийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%
258	635	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-23 Дугаар 2025_09	5.1.3. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа хүний хөгжлийг дэмжих, хүний эрхийг хангах, гэр бүл салалт, гэмт хэргийг бууруулах, хүүхдийн боловсрол, нийтийн эрүүл мэндийг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжлийн төсөл, арга хэмжээг орхигдуулахгүй байхад анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	ХХААХҮ-ийн сайдын 2026 оны төсвийн төсөлд ажилгүйдэл ядуурлыг бууруулах чиглэлээр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгоход зориулж 45.0 тэрбум төгрөг, малчдын хоршоог дэмжих чиглэлээр зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 108.9 тэрбум төгрөгийг тусган УИХ-д өргөн барьж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлд зориулж 35.0 тэрбум төгрөг, малчдын хоршоог дэмжих чиглэлээр зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 75.9 тэрбум төгрөгийг УИХ-аар батлуулан ажиллаа.	Хэрэгжсэн - 100%
	636		5.1.4. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгах Засгийн газраас хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын талаар Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй бодлого, шийдвэрүүдийг хэрэгжүүлэхээр 2026 оны төсвийн төслийг боловсруулж СЯ-аар хянуулан УИХ-д нийт 637.9 тэрбум төгрөг. Үүнээс урсгал зардал 567.1 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 70.9 тэрбум төгрөгөөр өргөн барьснаас салбарын нийт төсөв 557.2 тэрбум төгрөгөөр, урсгал зардал 506.2 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 82.1 тэрбум төгрөөр тус тус батлагдлаа. Хяналтаас хасуулах санал : нэг удаагийн чанартай тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	637		5.1.5. Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, цахимжуулж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, хяналт тавьж, салбар дундын уялдаа зохицуулалтыг хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод.	Яамны цахим төрийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд: 1.Тусгай зөвшөөрөл олгох https://license.mofa.gov.mn/ цахим системийг нэвтрүүлж аж ахуйн үйл ажиллагааны тусгай 17, энгийн 7 зөвшөөрлийн хүсэлтийг авч байна. 2.Урамшуулал олгох http://uramshuulal.gov.mn/ цахим системийг нэвтрүүлж сүү, улаан буудай, хүнсний ногооны урамшууллыг олгож байна. 3. Мал аж ахуйн https://livestock.mofa.gov.mn/, мал эмнэлгийн https://vetinfo.mahis.gov.mn/, газар тариалангийн https://plant.mofa.gov.mn/ нэгдсэн цахим системийг хийж салбарын үйлдвэрлэлийн бүртгэлийг хийж байна. 4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах https://sme.gov.mn/ цахим системийг нэвтрүүлж аж ахуйн нэгж, иргэнд хөнгөлөлттэй зээл олгож байна. 5. Экспортын нэг цонхны үйлчилгээ https://export.mofa.gov.mn/ цахим системийг нэвтрүүлэн мал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, экспорт, импортын гэрчилгээг олгож байна. 6. Албан хэрэг хөтлөлтийн ABLE системийг Албан бичиг солилцооны дундын систем /DOCX/-д холбон Төрийн байгууллагууд хооронд баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
259	638	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-07-30 Дугаар 2025_10	14.4.. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинээр байгуулах хэлэлцээрийн төслийг боловсруулан 2025 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаагаа	хамааралгүй Хяналтаас хасуулах санал : хамааралгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй

			эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.		
260	639	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-08-06 Дугаар 2025_11	9.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав.	нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвлөмж, дүгнэлт гаргуулан ажиллаж байна. Мэдээллийн технологийн чиглэлээр 2025 онд салбарт хэрэгжүүлэх 16 ажлын төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлж, зөвлөмж авч хамтран ажилласан байна	Ахиц гарсан - 50%
	640		8.4. Орон нутагт зуншлага тааруу байгаатай холбогдуулан 2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, өвс, тэжээлийн аюулгүйн болон махны нөөцийг бүрдүүлэх, мах боловсруулах үйлдвэрүүдийн нөөцийн мах бэлтгэх ажилд хяналт тавьж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Батлан хамгаалахын сайд Д.Батлут нарт даалгав.	ХХАА-н салбарын улсын ерөнхий байцаагчийн “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалтад урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 08-00-04/33 дугаартай удирдамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумын аюулгүй нөөцөд бэлтгэх 36.4 мянган тонн бүдүүн тэжээл (өвс)-ийн 86.7 хувь буюу 31.5 мянга, 30.8 мянган тонн хүчит тэжээлийн 42.8 хувь буюу 13.9 мянган тонныг тус тус бэлтгэж, 64.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Аюулгүй нөөцийн хэмжээг өнгөрсөн оны нөөцтэй харьцуулахад өвс 17.2 мянга, тэжээл 18.3 мянган тонноор тус тус илүү бэлтгэх чиглэл өгсөн. Баруун бүсэд өвс 5.6 мянга, хүчит тэжээл 3.6 мянга; Хангайн бүсэд өвс 6.9 мянга, хүчит тэжээл 2.6 мянга; Хойд бүсэд өвс 4.2 мянга, хүчит тэжээл 1.5 мянга; Төвийн бүсэд өвс 3.5 мянга, хүчит тэжээл 1.4 мянга; Говийн бүсэд өвс 4.2 мянга, хүчит тэжээл 1.4 мянга; Зүүн бүсэд өвс 6.8 мянга, хүчит тэжээл 2.1 мянга; Улаанбаатарт өвс 0.1 мянга, хүчит тэжээл 0.2 мянган тонн тус тус бэлтгэсэн байна. Монгол Улс 2025 онд 34.7 мян.тн адууны мах, 40 тн үхрийн мах, 25.1 мян.тн хонь, ямааны мах, 22.5 мян.тн дулааны аргаар боловсруулсан мах, 3.3 мян.тн малын дайвар, нийт 85.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүнийг /түүхий маханд шилжүүлэн тооцвол 110.7 мян.тн/ 345.3 сая ам долларoор экспортолсон ба өмнөх онтой харьцуулахад 20.4% буюу 14.5 мян.тн-оор нэмэгдсэн байна. БНХАУ-д самар экспортлох 21, сүү экспортлох 1, загас экспортлох 5, гурил экспортлох 13, мах, махан бүтээгдэхүүн экспортлох 27, нийт 67 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна.	Хэрэгжсэн - 100%
	641		8.1.2. Бүсийн зөвлөлийн болон Засгийн газрын өргөтгөсөн хуралдааныг бүсийн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тухайн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, орон нутгийн удирдлага, иргэдийн санал, оролцоог ханган, төсвийн хэмнэлтийн горимоор, урлаг, спортын, шаардлагагүй бусад арга хэмжээгүй зохион байгуулахыг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг бүсүүдэд зохион байгуулахтай холбоотойгоор Засгийн газрын өргөтгөсөн хуралдааныг бүсийн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тухайн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, орон нутгийн удирдлага, иргэдийн санал, оролцоог ханган зохион байгуулсан. Үүнд: Хангайн бүсийн хуралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Архангай аймагт, Хойд бүсийн хуралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймагт, Говийн бүсийн хуралдааныг 2025 оны 05 дугаар сарын 12-ны Дорноговь аймагт тус тус зохион байгуулсан.	Хэрэгжсэн - 100%
	642		9.7.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав.	нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвлөмж, дүгнэлт гаргуулан ажиллаж байна. Мэдээллийн технологийн чиглэлээр 2025 онд салбарт хэрэгжүүлэх 16 ажлын төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлж, зөвлөмж авч хамтран ажилласан байна	Ахиц гарсан - 50%

261	643	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-08-20 Дугаар 2025_13	12.6.. Ургац хураалт, хадлан, тэжээл бэлтгэх ажлыг улсын хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж дуусгахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд тус тус даалгав.	Үйлдвэрлэлийн зориулалттай байгалийн хадлан бэлтгэхэд зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн 256.1 мянган га хадлангийн талбайг 400 иргэн, аж ахуй нэгжид олгосон. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны Дорнод аймгийн Чойбалсан сумын улсын тусгай хэрэгцээний газарт байгалийн хадлан бэлтгэж, өвөлжилт хүндрэх эрсдэлтэй аймгуудад өвөлжилтийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 21,300 га талбайд 16, иргэн аж ахуй нэгжтэй гэрээ байгуулснаас 11.200 га талбайг хадаж 275,000 боодол буюу 6,875 тонн хадлан бэлтгэсэн байна. Цаг агаарын төлөв байдалтай уялдуулан ургац хураалтын ажлыг богино хугацаанд шуурхай зохион байгуулах, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах ажлын төлөвлөгөөг гаргаж зохион байгуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллав. Мөн ургац хураалтын өмнө салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ургацыг хаягдалгүй хураах технологийн зөвлөмжийг боловсруулж тариаланчдад хүргэсний зэрэгцээ, ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулахад орон нутгийн удирдлагын зүгээс анхаарах, хэрэгжүүлэх асуудлуудын талаар үүрэг чиглэл өгч хамтран ажиллаа. 2025 онд улсын хэмжээнд 274.1 мянган тонн үр тариа, үүнээс 252.3 мянган тонн улаанбуудай, 101.9 мянган тонн төмс, 208.6 мянган тонн хүнсний ногоо, 133.3 мянган тонн тэжээлийн ургамал, 27.2 мянган тонн тосны ургамал, нийт 745.1 мянган тонн ургац хураан авсан нь өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад 503.3 мянган тонноор буюу 40.3 хувиар ургац буурсан дүнтэй байна.	Хэрэгжсэн - 100%
262	644	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-02 Дугаар 2025_15	10.4.1.. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам /ЗГ-ын 2022 оны 352/-ын дагуу нээлттэй мэдээллийг салбарын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, гадаад хамтын ажиллагаа, шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл, шилэн данс, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт, төлөвлөгөө, тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, хүний нөөц, авлигын эсрэг, ХАСХОМ, статистик мэдээлэл, урамшуулал, тусгай зөвшөөрөл, салбарын шагнал, өргөдөл гомдол, бүртгэл, мэдүүлэг гэх мэт 69 цэсэд ойлгомжтой байдлаар байршуулж, тогтмол шинэчилж баяжуулсан. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 357 шинэ мэдээ, 165 тендерийн урилга, 29 хүний нөөцийн зар, 23 хяналтын хуудас, 21 ХШҮ-ний тайлан, 4 сонгон шалгаруулалтын зар, 29 хэлэлцүүлэг, 3 статистикийн нээлттэй мэдээлэл, 8 Засгийн газрын тогтоол, 1 УИХ-ын тогтоол, яамны 2025 оны үйл ажилгааны төлөвлөгөө, 2024 оны тайлан, албан хаагчдын 2024, 2025 оны хагас жил, жилийн эцсийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, дотоод худалдааны мэдээ мэдээллээр шинэчлэн баяжуулсан.	Хэрэгжсэн - 100%
	645		10.4.4.. Эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, Засгийн газрын агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд буюу мэдээлэл хариуцагчдын хууль биелүүлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хууль биелүүлэх үүргийн хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж ажилласан. Мөн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал” сэдвээр мэдээллийн цагийг яамны нийт албан хаагчдад зохион байгуулсан, шаардлагатай арга зүй, зөвлөмжийг хүргэж, төсөл боловсруулах үйл явцыг нэгэн жигд ойлголттой болгоход чиглүүлсэн. Яамны нийт албан хаагчдад мэдээллийн цагаар 2025 оны 11 дүгээр сард ТЕГ-аас мэдээлэл хариуцах, нууцын хамгаалалтын асуудлаар мэдээлэл хариуцагчдын хүлээх үүргийн талаар сургалт зохион байгуулсан	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
263	646	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16	28.1.3.. иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Дотоод удирдлагын “Able” систем ашигладаг байгууллагууд гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг “Хур” системээр дамжуулан тухай бүр өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санд нэгтгэх тохиргоог хийж системд нэгтгэсэн. Мэдээллийн санд нэгтгэсэнтэй холбогдуулан өргөдөл гомдлын агуулга шошгын жагсаалтад санал өгсөн. Хяналтаас хасуулах санал : тогтолцоо бүрдсэн тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	647		28.2.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгав: 1.1.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах; 1.2.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн	1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарч ажиллаж байна. 2. Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа 100 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 139 заалтыг хяналтаас хасуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлж, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнахад анхаарч ажиллаж байна	Хэрэгжсэн - 100%

			хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнах; 1.3.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтад шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх; 1.4.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтмол хянаж, үр дүнг нэмэгдүүлж ажиллах.		
	648		28.4.1.1.. 1.Хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, дараах арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт: 1.1.хөдөө аж ахуйн салбарыг шинжлэх ухаан, инновац, дэвшилтэт технологид тулгуурлан шинэчлэн хөгжүүлэх болон салбарын хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр эдийн засгийн тооцоо, судалгаа бүхий цогц төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 11 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засгийн тоон үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр гарган, нэгдсэн мэдээллийг боловсруулан, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулахтай холбоотойгоор ХХААХҮ-ийн сайдад танилцуулсан. Мөн салбарын дунд хугацааны бодлогын баримт бичиг болох “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын саналыг тусгуулан, Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн.	Ахиц гарсан - 50%
	649		28.4.1.2.. гангийн нөхцөл байдал, ургац хураалтын дүн болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн тариаланчдад олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах эсэх асуудлыг судалж, саналаа 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах;	"Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 204 дүгээр тогтоолоор гангийн нөхцөл байдал, ургац хураалтын дүн болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн тариаланчдад олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах эсэх асуудлыг шийдвэрлэсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	650		28.4.1.3.. хүнсний улаанбуудайн хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй, гурилын үнийг өнгөрсөн жилийн түвшингээс нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээний санал боловсруулж, Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулах	Засгийн газрын 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанд хүнсний улаанбуудайн хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй, гурилын үнийг өнгөрсөн жилийн түвшнээс нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээний талаарх танилцуулгыг ХХААХҮ-ийн сайд Ж. Энхбаяр танилцуулсан. 2025-2026 оны гурилын хэрэгцээг хангах, нийлүүлэлтийг тасалдуулахгүй, гурилын үнийг нэмэгдүүлэх байхад 148.3 мянган тонн хүнсний улаанбуудай дутагдах урьдчилсан тооцоо 2025 оны ургацын урьдчилсан дүнгээр гарсныг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 004 дүгээр зөвлөмжөөр хүнсний улаанбуудай импортлох хэмжээг 150 мянган тонноор тогтоосон бөгөөд үрийн улаанбуудайг 12.0 мянган тонныг 2026 оны 03 дугаар сард багтаан импортлох шийдвэр гарсан. Хавсралт : 1 файл Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%
	651		28.4.3.. Ургац хураалтын үед тариалангийн талбайд мал оруулахгүй байх талаар нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг тариалан бүхий аймгийн Засаг дарга нарт, тариалангийн талбайг хашиж хамгаалах, ойн зурвас байгуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт тус тус	"Газар тариалангийн салбарын эрсдлийг бууруулах, ургац хураалтын бэлтгэл ажлын төлөвлөгөө"-г боловсруулан батлуулж аймгуудын ХХААГ-т хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан. Энэхүү ажлын хүрээнд газар тариалангийн бүс нутгуудад аймаг, сумдын Засаг даргын захирамжаар байгуулсан "Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд учирсан хохирлыг тогтоох" ажлын хэсгийг эрчимжүүлэх, Захирамжийн хэрэгжилтийг хангуулах чиглээр үүрэг чиглэл өгсөн байна. “Тэрбум-мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тариалангийн талбайг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Сайхан /30,6 км/, Орхон /12 км/, Зүүнбүрэн /24 км/, Дархан-Уул аймгийн Хонгор /36 км/ суманд нийт 4 байршилд улиас, хайлаасны суулгацаар 3 эгнээ хамгаалалтын ойн зурвасыг 102.5 км талбайд байгуулсан. Улсын төсвийн 9,7 тэрбум төгрөгөөр тариалангийн төв бүс болох Сэлэнгэ /186,875 ширхэг/, Дархан-Уул /101,565 ширхэг/ Төв /21,250 ширхэг/, Булган /51,550 ширхэг/ нийт 361,240 ширхэг төмөр бетон шонгоор 1806 км урт 80 орчим мян.га талбайг хамгаалж хашаажуулалтыг 50 хувьд хүргэсэн байна.	Хэрэгжсэн - 100%

	652		28.4.4.. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмж, үр бордоо, ургамал хамгааллын бодисыг гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж, холбогдох саналыг 2025 оны 09 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт	Импортоор оруулж байгаа болон дотоодод борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох судалгааг боловсруулан, үзэл баримтлалыг Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нартай хамтран батлуулахаар 01/3138 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	653		28.4.7.. Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж, хамтран ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд	Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газарт, Төрийн нарийн бичгийн даргаас Боловсролын яамны болон Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга нарт албан тоотоор хандаж отор нүүдэл, байгалийн хадлангийн экспорт, намрын технологит ажилд оюутан болон цэргийн албан хаагч, сонсогч, гэрээт цэргийн албан хаагчдыг татан оролцуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Мөн Эрүүл мэндийн яамнаас аймаг, нийслэлийн эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирагч нарт өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангах отроор өвөлжиж, хаваржиж буй малчдад харьяалал харгалзахгүй тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуул гэсэн чиглэлийг 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 5/4439 тоот албан бичгээр хүргүүлсэн. Улсын тусгай хэрэгцээний 9 отрын бүс нутагт 2025-2026 онд отроор мал өвөлжүүлж, хаваржуулах ажлын хүрээнд бэлчээрийн даац, ургамлын гарц тодорхойлох мониторингийн ажлыг гүйцэтгэж, 665809 толгой мал өвөлжих боломжтойг тогтоож, 2025-2026 онд отрын бүсэд нийт 12 аймгийн 35 сумын 414 өрхийн 651892 хонин толгой малыг өвөлжүүлж, хаваржуулах дүгнэлт, шийдвэр гаргаж хэрэгжүүлж байна. Дорнод аймгийн Чойбалсан улсын тусгай хэрэгцээний отрын бүсэд 11,400 га талбайд аймаг, сум, аж ахуйн нэгж болон иргэдтэй гэрээ байгуулж, зах зээлд 275 мянган боодол өвс нийлүүлсэн. Отрын 9 бүсийн аюулгүйн нөөцөд тус бүрд 1000, нийт 9000 боодол өвс тэжээлийн нөөцийг бэлтгэн, өвөлжилт хүндрэх төлөвтэй аймгуудад өвсний нөөц бүрдүүлэн хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж 29,5 мянган тонн улаан буудайн нөөц бүрдүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
	654		28.14.1.3.. шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллаагүй байгууллага, албан тушаалтанд хууль, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт.	ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулиар нийт 16 байгууллагад 9,190.7 сая төгрөгийн зөрчил илэрч, 6 байгууллагын 5,459.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 10 байгууллагын 3,731.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн. Илэрсэн зөрчлийг өмнөх онтой харьцуулахад зөрчлийн дүн 23,910.7 сая төгрөгөөр буюу 72.2%-иар буурсан байна. Тус аудитаар өмнөх оны зөрчлийг давтан гаргаж, хариуцлага тооцох албан шаардлага авсан байгууллага байхгүй. Шилэн дансны тухай хуулийн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хяналтад авч, ШДНЦС-ээр явцын хяналтыг хэрэгжүүлж, байгууллага, албан хаагчдыг мэдээлэл, зөвлөмжөөр тухай бүр хангаж, хагас, бүтэн жилээр шилэн дансны цахим тайланг хүлээн авч, хянаж, нэгтгэн хууль тогтоомжид заасан хугацаанд ҮАГ, СЯ-нд хүргүүлсэн байна.	Хэрэгжсэн - 100%
264	655	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-17 Дугаар 2025_17	8.4.. Гурилын үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг тогтвортой хангах, үнийн өсөлтөд хяналт тавих талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн болох гурил, махны хангамж, нийлүүлэлт болон үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр тодорхой санал боловсруулан Засгийн газрын дараагийн хуралдаанд оруулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгав.	Засгийн газрын 2025 оны 09 сарын 24-ний өдрийн хуралдаанд “Мал, махны бэлтгэл, гурилын хангамж, нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай танилцуулга” тэмдэглэлийн төслийг боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулсан. Хавсралт:1 файл Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжилт хангасан	Хэрэгжсэн - 100%
265	656	Монгол Улсын Засгийн газрын 2025	11.1.1. 1.хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн мөрөөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах 4 бодлогын хүрээнд 161 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг цаг	Хэрэгжсэн - 100%

		оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-24 Дугаар 2025_18	эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	тухайд цахим системд тайлагнан ажиллаж байна. Мөн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний биелэлтийг сайжруулах, эрчимжүүлэх зорилгоор бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан ажиллаж байна.	
	657		11.2. . 11.2.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэх, эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн захиргааны байгууллагын дарга нарт даалгав.	“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээний дүнтэй уялдуулан төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласан. ЗГХХГ-ын ажлын хэсэгтэй хамтран биелэлтийг дахин гаргаж удирдлагуудад танилцуулан хэрэгжилтийг эрчимжүүлж ажилласан. Хяналтаас хасуулах санал : Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй	Хэрэгжсэн - 100%
266	658	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-10-01 Дугаар 2025_19	9.1.1.. 9.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулж, хууль, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулах төлөвлөгөөний талаар Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.шинээр 2026 онд эхлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу хууль тогтоомжид заасан хугацаанд авлига, албан тушаалын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	2026 онд эхлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу хууль тогтоомжид заасан хугацаанд авлига, албан тушаалын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан зохион байгуулахаар ажиллаж байна.	Х.Б
267	659	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-08 Дугаар 2025_20	16.4.1.. Үүнтэй холбогдуулан 2025 онд багтаан дараах арга хэмжээг авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав: 1.эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг “Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан”-д бүртгүүлэх;	Эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлсэн. Газар тариалангийн нэгдсэн системийн мета-өгөгдлийн мэдээлэл, Мал аж ахуйн нэгдсэн системийн мета-өгөгдлийн мэдээллийг www.metadata.nso.mn системд оруулсан.	Хэрэгжсэн - 100%
	660		16.4.3.. 2.төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх;	Салбарын мэдээллийн системүүдэд И-монголиа академитэй хамтран системийн шинжилгээ хийж, архитектур боловсруулан, нийт 181 хуудас тайлан бичиж, дүгнэлт гарсан. Салбарын цахим үйлчилгээг нэг цонхоор үзүүлэх, e-mongolia, e-business харилцан мэдээлэл солилцох боломжийн талаар зураглал гаргах ажлыг эхлүүлсэн. Дан системээр танилтын ажлыг хөгжүүлсэн. Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэхээр системийн эрхийг хүлээж авсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	661		16.4.3.. 3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх.	Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх ажлын хүрээнд яам болон харьяа байгууллагаас олгож байгаа бүх үйлчилгээг нэгтгэсэн.	Хэмжигдэх хүйц биш
268	662	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-11-05 Дугаар 2025_26	13.3.1.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээг авахыг даалгав: 1.1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр, “Нийгмийн шударга ёсыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар, “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар, “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр, 02 дугаар, 03 дугаар, 04 дүгээр албан даалгавраар өгөгдсөн үүргийн хэрэгжүүлэхтэй холбогдуулан яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/243 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг яамны нэгж болон харьяа байгууллагуудад үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон. Мөн хэрэгжилтийг Засгийн газрын цахим системд тухай бүр тайлагнасан. Тайлангийн 10 дугаар сарын хэрэгжилтээр 92.86% дээд шатны байгууллагын үнэлгээгээр 93%, 11 дүгээр сарын хэрэгжилт 94%-тай байна. https://new.unelgee.gov.mn/law/ Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%

			хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавраар хугацаатай өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;		
	663		13.3.1.2. 1.2.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хангалтгүй дүгнэгдсэн заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөө боловсруулах, салбарын хэмжээнд бодит үр дүнг сар бүр нэгтгэн дүгнэж, товч, тодорхой тайлагнах, өмнөх сард тайлагнасан албан даалгаврын хэрэгжилтийг давтан тайлагнахгүй байх.	Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийг салбарын болон ЗГХЭГ-ын ХШҮ-ний цахим системээр тайлагнаж ажилласан. 2025 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр салбарт хамаарах 17.4. ”Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчин, Улсын аварга саальчин, Улсын аварга фермер, Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч шалгаруулах журам”-ыг бүсчилсэн хөгжлийн бодлого, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх; 17.6. отрын бүсийг “эрүүл бүс” болгох зорилтын хүрээнд аймаг дундын 9 отрын бүсэд “Малын эрүүл мэндийн нэгдсэн төв” байгуулах, бүс тус бүрд ариутгалын автомашин (ДУК) олгох, сэг зэм устгах талбай байгуулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулах; гэсэн заалт хэрэгжээгүй дүгнэгдсэн. Эдгээрээс 17.4 дугаартай арга хэмжээний хэрэгжилт хангагдаж, холбогдох журам Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн, батлагдсан. Харин 17.6 дугаартай арга хэмжээний хэрэгжилт санхүүжилт шийдвэрлэгдээгүй нь улмаас хэрэгжээгүй байна. Үр нөлөө : Засгийн газрын 2022 оны "Журам шинэчлэн батлах, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин, шалгаруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулан, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэв.	Ахиц гарсан - 50%
	664		13.3.3.. 3.“Монгол Улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан яамд таван жилийн салбарын хөгжлийн төлөвлөгөөнд туссан бодлогын өөрчлөлтийн талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа хийх төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 10-20-ны өдрүүдэд хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав;	“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын саналыг тусгуулан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасны дагуу олон нийтээр хэлэлцүүлж, Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн.Мөн холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэхэд гишүүдийн асуултад хариулан оролцсон бөгөөд тус төслийг Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн чуулганаар эцэслэн батлуулсан.	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй
	665		13.3.4.. Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд яам, Засгийн газрын агентлагууд иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг гарган мөрдүүлж, иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл, чанарыг төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;	1. Тус яам болон түүний харьяа байгууллага тухай бүр иргэдийг хүлээн авч уулзаж иргэдээс өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж байна. 2. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 838 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 30 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэхээр хариуцсан албан тушаалтан ажиллаж байна. Тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 710, Мал эмнэлгийн ерөнхий газарт 144, Жижиг, дунд үйлдвэрийн газарт 19, Ургамал хамгаллын газарт 2, нийт 875 иргэн, аж ахуйн нэгж өргөдөл, гомдол ирүүлснээс Засгийн газрын “Иргэд олон нийттэй харьцах 11-11 төв”-өөр дамжин 315 өргөдөл, гомдол ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, харьяа байгууллагын хэмжээнд ирсэн нийт гомдлын 709 буюу 81.0 хувийг иргэний талд шийдвэрлэсэн, 82 буюу 9.3 хувийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй тул мэдээлэл өгч шийдвэрлэсэн, 1 өргөдөл гомдолд тодорхой бус хариу өгсөн, 4 өргөдөл гомдлыг харъяаллын дагуу шийдэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шийлжүүлсэн байна. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%
	666		13.3.7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав;	1. Ерөнхий сайдын 01, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/243 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, үр ашигтүй зардлыг танаж, байгууллагын хэмжээнд хэмнэлтийн горимыг сахин ажиллаж байна. 2. Яам болон харьяа байгууллагын албан хаагчдын 7 хоног бүрийн Мэдээллийн цагийг цахимаар зохион байгуулж хэвшсэн.	Хэрэгжсэн - 100%

	667		13.7. . Үүнтэй холбогдуулан хүнсний улаанбуудайн стратегийн болон 2026 онд тариалах үр тариа, төмс, тэжээлийн таримлын үрийн нөөц бүрдүүлэх, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас газар тариалангийн үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгав.	1. Ургац хураалтын урьдчилсан дүнгээр энэ намрын ургацаас стратегийн нөөцөд “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 27.3 мянган тонн, гурилын үйлдвэрүүд 126.4 мянган тонныг тус тус худалдан авсан. Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 320.0 мянган тонн цэвэр хүнсний улаанбуудай шаардлагатай бөгөөд 2025-2026 оны гурлын хэрэгцээг хангахад 148.3 мянган тонн хүнсний улаанбуудай дутагдах урьдчилсан тооцоо гарсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28 ны өдрийн 004 дугаар зөвлөмжөөр хүнсний улаанбуудайн импортлох хэмжээг 150 мянган тонноор тогтоосон бөгөөд үрийн улаанбуудайг 12.0 мянган тонныг 2026 оны 03 дугаар сард багтаан импортлох шийдвэр гарсан. 2. Байгалийн давагдашгүй хүчин зүйл ган, мөндөрийн улмаас ургац алдсан газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн дарамтыг бууруулах ажлын хүрээнд 2023-2025 онуудад Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй, хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрөөс 6 сар хүртэлх хугацаагаар хойшлуулах шийдвэрийг Засгийн газрын 2026 оны 12 дугаар сарын 17-ны 204 дугаар тогтоолоор батлуулсан байна. Хавсралт : 3 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
ЗГ-ын албан даалгавар					
269	668	Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022-07-04 Дугаар 2022_3	2. Энэ албан даалгаврын 1-д заасан төлөвлөгөөнд тусгах нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санал, зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Мэдээллийн технологийн чиглэлээр 2025 онд хийх 16 ажлын төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
270	669	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6	1. 1.1. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;	Салбарын удирдлага болон албан хаагчид "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", “Хүнсний хангамж, аюулгүй байдал" хөтөлбөрийн зорилго, зорилтын талаар холбогдох томоохон хурал зөвлөгөөн болон орон нутагт ажиллахдаа тухай бүр иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл, малчид тариаланчдад танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг яам, харьяа байгууллагын удирдлагууд, 21 аймгийн ХХААГ-ын дарга болон Захиргаа аж ахуйн албаны дарга нарыг оролцуулан НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Монгол Улсад ТХЗ-той уялдсан төсөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь төсөл”-тэй хамтран 2024 онд зохион байгуулж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар орон нутгийн удирдлагуудад танилцуулав.	Хэрэгжсэн - 100%
271	670	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан болон санаачлан хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-07-03 Дугаар 2023_02	4.1.. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан Улсын Их Хурлаар батлуулсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.	ХХААХҮ-ийн сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/372 дугаар тушаалын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын нэг цонхны цахим систем” (export.mofa.gov.mn) нэвтрүүлснээр мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох үеийн баримт бичиг бүрдүүлэх хүрээнд 4 байгууллагаас экспортын гэрчилгээ авахад зарцуулдаг байсан 13 хоногийн хугацааг ажлын 8 цаг болгосноор цахим системээр 2023 онд 585 хүсэлт, 2024 онд 750 хүсэлтийг шийдвэрлэсэн. Мал сүргийн тоо, бэлчээрийн даацтай уялдуулан 2022 оны 10 дугаар сараас малын махны экспортод хязгаарлалт тогтоохгүй байх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэн, мах, махан бүтээгдэхүүний экспортын зөвшөөрөл олгодоггүй болсон. ХХААХҮ-ийн сайдын 2024 оны “Жагсаалт шинэчлэн батлах тухай” А/222 дүгээр тушаал, ХХААХҮЯ, банк хооронд “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн 240201/07-60 дугаартай санхүүжилтийн гэрээ”, тус гэрээнд 020419/03-300 дугаартай нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг тус тус байгуулсан. Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгийн зээлийг жилийн 18-19 хувь (зээлдэгчээс 5-6 хувь, Засгийн газраас 13 хувь)-ийн хүүтэй 12 сарын хугацаатай олгохоор тусгасан. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй 1.26 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2577 иргэн, аж ахуйн нэгжид олгож, гол нэр төрлийн хүнсний 19 бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлж, сүүлийн 2 жилийн хугацаанд мах, махан бүтээгдэхүүний экспортын орлого нийт 600.0 сая гаруй ам долларт хүрсэн. Сүү боловсруулах 10, мал төхөөрөх, мах боловсруулах 18, гурилан	Хэрэгжсэн - 100%

				бүтээгдэхүүний 12, бусад нэр төрлийн бүтээгдэхүүний 13, нийт 53 үйлдвэр шинээр шинээр байгуулагдсан. Мөн зоорийн багтаамж 15%, үтрэмийн багтаамж 7%, тариалангийн талбай 13%, зуны болон өвлийн хүлэмж 28%-аар тус тус нэмэгдлээ. Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 37%, ажлын байр 21%-аар өссөн байна.	
272	671	2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_01	3.3. . “Дархан арьс, ширний цогцолбор” үйлдвэр, технологийн паркийн үйл ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор эхлүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;	Засгийн газрын 2024 оны 256, 2025 оны 96 дугаар тогтоолоор "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт" ТӨХХК-ий нэрийг "Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж өөрчилсөн. Тус ТӨХХК нь Дархан-Уул аймгийн Хонгор суманд 25 га газарт хүнс болон хөнгөн үйлдвэрийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, үйлдвэр барих аж ахуйн нэгжүүдийг холбогдох дэд бүтэц болон төрөөс үзүүлэх дэмжлэгээр хангах зорилготой бөгөөд 2025 онд Авто зам /6.59 тэрбум төгрөг/, авто замын техник, технологийн хяналтын ажил /260 сая төгрөг/, гадна холбоо дохиоллын ажил /250 сая төгрөг/-ын тендер зарлан, гүйцэтгэгчтэй гэрээг байгуулж, хэрэгжилтийг хангаж байна. “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-аас Хөгжлийн банкны зээлийн төлбөрт тооцон шилжүүлэхээр санал болгосон дуусаагүй гүйцэтгэлтэй дэд бүтцийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн бодит гүйцэтгэлийг батлагдсан зураг төсөл, төсөвтэй харьцуулж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Барилга, хот байгуулалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн болон Эрчим хүчний сайд нарын хамтарсан 2023.03.10-ны өдрийн 44, А/68/А75 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023.03.11-12-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт байрлах төслийн талбай дээр ажиллаж, нэгдсэн санал, дүгнэлт гаргасан. “Дархан арьс ширний цогцолбор” ХХК болон “Монгол Улсын Хөгжлийн банк” хооронд дэд бүтцийн бүтээн байгуулалтын эцсийн өмчлөгчийн асуудлыг шийдвэрлэсний дараа хамтран ажиллах тухай ХХААХҮ-ийн сайдын 2023.08.03-ны өдрийн 01/2715 тоот албан бичгийг “ДАШЦ” ХХК-д хүргүүлсэн. ХХААХҮЯ-ны зүгээс Хөгжлийн банк “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-ий хоорондын маргаантай асуудал шийдэгдэх хүртэл хамтын ажиллагааны хэлэлцээг түр зогсоосон болно.	Хэрэгжсэн - 100%
	672		3.4. Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих, техникийн шинэчлэл хийх төслийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор эхлүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;	Засгийн газрын 2022 оны "Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 424 дүгээр тогтоолын хэрэгжилт хангах хүрээнд 2023-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/362 дугаар тушаалаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан ба хэрэгжилт 2023 оны байдлаар 41 арга хэмжээний хувьд хэрэгжилт 84%-тай байна. Дорнод аймгийн Халх гол сумын нутагт орших Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн эзэмшлийн улсын тусгай хэрэгцээний газарт хамгаалалттай аж ахуй байгуулах төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайдын 2024 оны А/113 дугаар тушаалаар байгуулж, сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан. Уг тусгай хэрэгцээний газарт хамгаалалттай аж ахуй байгуулах нийтлэг дэд бүтцийг шийдвэрлэх хүрээнд 110.0 мянга га газрын кадастрын зураглалд тохируулан эхний ээлжийн 11 худгаас 2023 онд 4 худгийг 2023 онд, 2024 онд 7 худгийг гаргаж ашиглалтад оруулахаар ажиллаж, худаг гаргах ажилд 636.0 сая төгрөг зарцуулсан.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	673		3.5. Мах, арьс шир, ноос, ноолуурыг хаягдал болгохгүй байх, боловсруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд.	Аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилготой Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63, Засгийн газрын 2024 оны "Цагаан алт хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 190 дугаар тогтоол тус тус батлагдсан. “Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл”-ийг арилжааны банкаар олгох санхүүжилтийн гэрээг ХХААХҮЯ, Монголбанк, арилжааны 10 банк хамтран 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Тайлант хугацаанд 378.3 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн 115 гэрээ, 114.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийн 53 гэрээ, нийт 492.9 тэрбум төгрөгийн 168 зээлийн хяналтын гэрээг байгуулсан. Ноолуурын салбарт 322.3, ноосны салбарт 30.3, арьс ширний салбарт 25.4 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн, ноолуурын салбарт 35.8, ноосны салбарт 50.4, арьс ширний салбарт 28.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг тус тус олгосон байна. Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 2024 оны “Жагсаалт шинэчлэн батлах	Ахиц гарсан - 50%

				тухай” А/222 дүгээр тушаал, ХХААХҮЯ, банк хооронд “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн 240201/07-60 дугаартай санхүүжилтийн гэрээ”, тус гэрээнд 020419/03-300 дугаартай нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг тус тус байгуулсан. Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих зээлийг жилийн 18-19 хувь (зээлдэгчээс 5-6 хувь, Засгийн газраас 13 хувь)-ийн хүүтэй 12 сарын хугацаатай олгохоор тусгасан. 2024 онд 18 аж ахуйн нэгж, нийт 45.0 тэрбум, 2023 онд мал төхөөрөх болон мах боловсруулах 35 үйлдвэр, аж ахуйн нэгж нийт 100.0 тэрбум төгрөгийн зээл авсан. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ өмнөх онтой харьцуулахад 10%-аар өссөн байна	
	674		6.10. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд.	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 324 төсөлд 47,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон ба төслийг хэрэгжүүлснээр 1462 ажлын байрыг шинээр бий болгож, 1217 ажлын байрыг хадгалсан бол Хоршоог хөгжүүлэх сангаас 21 аймгийн 330 сумын 492 хоршоонд 20,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, 1325 ажлын байрыг хадгалан, 853 ажлын байрыг шинээр бий болгон ажилласан.	Хэрэгжсэн - 100%
273	675	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1	1.1. Бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлэхийг Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт	МУ-ын урт, дунд хугацааны бодлогод МАА-н гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй байдлаар хөгжүүлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, ХАА-н үйлдвэрлэл технологийн паркийг нийлүүлэлтийн сүлжээний хамт үе шаттайгаар байгуулах зорилтууд тусгагдсан. Үүнтэй уялдуулан салбарын ҮТП-уудыг байршил, үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрлийг тухайн бүс нутгийн түүхий эдийн нөөц, ажиллах хүчний хангамж, дэд бүтцийн хөгжил, цаашдын төлөвлөлт, бүс нутгийн эдийн засгийн хөгжил, экспорт, импортын боломжуудад тулгуурлан сонгож “Хөнгөн, хүнсний үйлдвэрийн ҮТП-т эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт батлах тухай” ЗГ-ын 2025 оны 271-р тогтоолыг батлуулсан. Төвийн бүсэд Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн парк”, Баруун бүсэд Ховд аймагт “Шинэ Ховд аж үйлдвэрийн парк”, Нийслэлд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, говийн бүсэд Говьсүмбэр аймагт “МАА-н шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”, Зүүн бүсэд Дорнод аймагт “Зүүн бүсийн үйлдвэрлэл технологийн парк”-уудыг байгуулахаар төлөвлөн, төр хувийн хэвшлийн оролцоотойгоор бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. Энэ хүрээнд 2021-2025 оны төсөвт ХАА, үйлдвэрлэлийн кластер байгуулах арга хэмжээний хүрээнд Баянхонгор аймагт нийт 6 багц ажлыг гүйцэтгэн ингэний сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Мөн Сэлэнгэ аймгийн ЗД-д эрх шилжсэн "ХАА-н үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/ байгуулах" ажлыг гүйцэтгүүлэхээр Интерконсалтинг констракшн ХХК-тай УТ2104900410 дугаартай гэрээг байгуулж, Мандал, Сант, Баруунбүрэн, Сүхбаатар, Баянгол сумдад барих өвлийн хүлэмжийн барилгын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвөөр 2025.12.11-ний өдрийн 2327/2025 дугаартай магадлал хийлгүүлж, зуны нийлэг хальсан хүлэмж 134 ширхэг болон өвлийн хүлэмж барих бараа материалыг татан авсан. Хавсралт : 8 файл	Хэрэгжсэн - 100%
	676		5.2. Энэ албан даалгаврын 1.1-д заасан реформыг хэрэгжүүлэх хүрээнд Бүсчилсэн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу бүс бүрд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын төслийн бэлтгэл хангах, техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх, зураг төсөв, судалгааны ажлыг эхлүүлэх, олон нийтэд мэдээлэх;(1.1.Бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлэхийг Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт;)	Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын хуралдаанаар "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 64 дүгээр тогтоолыг хэлэлцэн баталсан. Уг тогтоол батлагдахтай холбоотойгоор салбарын чиглэлийн зүгээс холбогдох саналыг боловсруулан Эдийн засаг хөгжлийн яаманд тухай бүрд хүргүүлж ажилласан.	Х.Б
	677		21.1. Төвийн бүсийг хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс болгон хөгжүүлэх, малын гаралтай түүхий эд, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх;	Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний хуралдаанаар Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-ийн нэрийг "Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор" гэж өөрчлөн, компаний дүрмийг шинэчлэн "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт	Хэрэгжсэн - 100%

				оруулах тухай" 96 дугаар тогтоолыг ХХААХҮЯ-наас батлуулсан. "Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк"-т эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалтыг Засгийн газрын 2025 оны "Жагсаалт батлах тухай" 271 дүгээр тогтоол батлуулсан. Тус ТӨХХК нь Дархан-Уул аймгийн Хонгор суманд 25 га газарт хүнс болон хөнгөн үйлдвэрийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, үйлдвэр барих аж ахуйн нэгжүүдийг холбогдох дэд бүтэц болон төрөөс үзүүлэх дэмжлэгээр хангах зорилготой. 2025 онд Авто зам /6,59 тэрбум төгрөг/, авто замын техник, технологийн хяналтын ажил /260 сая төгрөг/, гадна холбоо дохиоллын ажил /250 сая төгрөг/-ын тендерийг зарлан, гүйцэтгэгчтэй гэрээг байгуулаад байна. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс мах, махан бүтээгдэхүүний экспортод хориг, хязгаар тогтоохгүй байх талаар зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ХХААХҮ-ийн сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/372 дугаар тушаалын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын нэг цонхны цахим систем”-ийг (export.mofa.gov.mn) нэвтрүүлснээр мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох үеийн баримт бичиг бүрдүүлж 4 байгууллагаас экспортын гэрчилгээ авахад зарцуулдаг байсан 13 хоногийн хугацааг бууруулж, ажлын 8 цагт багтаасан бөгөөд цахим системээр 2023 онд 585 хүсэлт, 2024 онд 750 хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн. Мал сүргийн тоо, бэлчээрийн даацтай уялдуулан 2022 оны 10 дугаар сараас малын махны экспортод хязгаарлалт тогтоохгүй байх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэн, мах, махан бүтээгдэхүүний экспортын зөвшөөрөл олгодоггүй болсон. 2025 он 85.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүн 345.3 сая ам долларaар экспортолсон.	
	678		21.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” хөтөлбөрүүдийг эрчимжүүлж, ”Атрын IV аян”-ыг эхлүүлж, нээлт хийх;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран Монгол Улсад шинжлэх ухааны үндэслэлтэй атар газар эзэмшсэний 65 жилийн ой, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойших 2.5 жилийн үр дүн, ”Атрын IV аян”-ны нээлт болгож “Алтан намар-2024” фестивалийг 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулсан. 1) “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цагаан алт ба арьс шир, ноос, ноолуурын салбарын тулгамдсан асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Салбарын мэргэжлийн холбоод, үйлдвэрлэл эрхлэгчдийн оролцоог хангаж, “Цагаан алт” хөдөлгөөний талаарх танилцуулга” илтгэлийг хуралд танилцуулсан. 2) “Цагаан алт хөдөлгөөний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч, 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар дэмжигдэн батлагдсан. “Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл”-ийн хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилтийн ерөнхий гэрээ, арилжааны банктай байгуулах “Ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилтийн гэрээ", “Ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээлийн санхүүжилтийн гэрээ"-ний төслүүдийг боловсруулж Арилжааны 10 банкнаас саналыг авч, гэрээг байгуулсан.	Ахиц гарсан - 50%
	679		21.3."Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг үргэлжүүлэн санхүүжилтийг тодорхой болгож, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;	“Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталсан. Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166, “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” 167 дугаар тогтоолыг тус тус батлуулсан. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг өрнүүлж "Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг баталж, төрийн албан хаагчид, хоршоодын холбоо зэрэг байгууллага хамтран 21 аймаг, 330 суманд ажиллаж, малчдын хоршиж нэгдэх үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг хийсэн байна. Мөн малчдын хоршоог төрөөс дэмжиж мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн асуудлаар 2024-05-07-ны өдрийн 240508/03-372 тоот “Санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г Сангийн сайд, ХХААХҮ-ийн сайд, Монгол банкны ерөнхийлөгч, Зээлийн батлан даалтын сан, Арилжааны банк хамтран байгуулсан. Гэрээгээр 2024 онд 500 тэрбум төгрөгийг арилжааны банкны эх үүсвэрээр жилийн 6 хувийн хүүтэй 5 хүртэл жилийн хугацаатай хоршооны гишүүн	Хэрэгжсэн - 100%

				малчдад олгож, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд Засгийн газраас 12 хувийг төлөхөөр тохирсон. “Шинэ хоршоо” хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэн 2024 оноос өнөөг хүртэл 7559 хоршоонд нийт 860.3 тэрбум төгрөгийн зээлийг 25,421 гишүүн малчинд олгосноор 1169 ажлын байр шинээр бий болгож, хоршооны санхүүгийн хүртээмжийг бодитоор нэмэгдүүлсэн бөгөөд олгосон зээлийн 59.6 хувийг үржлийн мал худалдан авах, бойжуулах, борлуулахад зарцуулсан байна. Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээний дагуу хоршоодод мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллаж байна.	
	680		21.4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлэх, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт шилжүүлэхтэй холбоотойгоор Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлээр үүрэг болгосон. Дархан-Уул аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан спорт, соёл үйлчилгээний цогцолборын захиргааны барилгад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг байршуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд үе шаттай шийдвэрлэсэн. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд хүсэлт гаргасан нийт албан хаагчдын байр, орон сууцны асуудлыг мөн үе шаттайгаар шийдвэрлэсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа 8 байгууллагыг 2024 оны 4 дүгээр улиралд Дархан-Уул аймагт бүрэн нүүлгэн шилжүүлсэн. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа Мал эмнэлгийн ерөнхий газар, түүний харьяа 2 лаборатори, ХАА-н судалгаа хөгжлийн төвийг ажлын оффисын зориулалтай байрны асуудал шийдвэрлэгдээгүй байна. Дархан-Уул аймгийн Засаг даргад Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборторийг барих 2 га газрыг шийдвэрлэж өгөх хүсэлтийг уламжлаад байгаа болно.	Хэрэгжсэн - 100%
	681		27. Албан даалгаварт туссан төсөл, арга хэмжээний ач холбогдол, хүлээгдэж буй үр дүнг иргэд, олон нийтэд таниулах, Засгийн газрын нэгдсэн тайлангийн арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулах, шаардлагатай бэлтгэл хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээгээ монголын хөрсөнд ургасан эрүүл хүнсээр бүрэн хангасан "Эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс" болох зорилтын хүрээнд: “Атар 4 аян”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Шинэ хоршоо - чинээлэг малчин”, “Цагаан алт” зэрэг үндэсний хэмжээний томоохон хөдөлгөөнийг хэрэгжүүлж, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын томоохон зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж тухай бүр мэдээллийг түгээсэн. Мөн 2024 оны 10 дугаар сард "Алтан намар" арга хэмжээ, 2025 оны 3 дугаар сард УИХ-ын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүдийн танилцах уулзалт, 2025 оны 4 дүгээр сард "Атар 4 дүгээр аян" арга хэмжээг тус тус зохион байгуулж, салбарын үйл ажиллагаат олон нийтэд сурталчилсан. Засгийн газрын эхний 100 хоногт хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг тухай бүр гаргаж, нэгдсэн байдлаар танилцуулсан. Улмаар Засгийн газрын 2025 оны эхний 3 сард хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санал тусган хэрэгжилтийг олон нийтэд сурталчилсан. Тухайн хугацаанд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг ХХААХҮЯ-ны вэб болон цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүр дамжуулсан.	Хэрэгжсэн - 100%
274	682	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02	1.1.2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан (А1), өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх стратеги төлөвлөгөө боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт, тус чиглэлээр эрхлэх салбарын хүрээний стратеги төлөвлөгөө боловсруулж, танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд;	"Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнөгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө батлах тухай" А/96 дугаар тушаалыг боловсруулж, батлуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	683		1.2.11.“Атрын IV аян”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт;	Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Аян өрнүүлэх тухай" 47 дугаар тогтоолоор Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг эрчимжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолын хавсралтаар "Атар- 4 Тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г батлуулсан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%

	684		2.16. Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	1) Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэн Нийслэлийн төсөвт шаардлагатай төсвийг батлуулж, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн "Дулааны цахилгаан станц болон Цэвэрлэх байгууламжийн ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаад байна. 2) Паркт байрших ААН-үүдтэй паркийн нэгжийн гэрээ болон газар ашиглуулах гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд Булигаар ХК, Арилдий ХХК, Мон-Ирээдүй ХХК, Түмэн-Шир ХХК, "Аура кашмер" ХХК, "Үжин партнерс" ХХК, "Их асар" ХХК-тай "Эмээлт эко аж үйлдвэрийн паркт үйл ажиллагаа явуулах нэгжийн гэрээ" болон "Паркт газар ашиглуулах гэрээ"-г байгуулан ажиллаж байна. Салбарт хамаарах паркийн үйл ажиллагаа хэрэгжиж байна.	Хэрэгжсэн - 100%
	685		2.18. 45,000 тонн нарийн ногоо хураах өвлийн хүлэмжийн кластер бүхий Агросити эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг эхлүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас "Агро-сити" дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах үйлчилгээний тендерийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зарлаж, шалгарсан “Гоби Травэл" ХХК-тай 06 дугаар сарын 18-ны өдөр гэрээ байгуулсан. Гүйцэтгэгчээс хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний эхний тайланг 2025 оны 08 дугаар сарын 23-ны өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд эхний шатны тайлангаар дагуул хотын хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, гадаад дотоод орчны шинжилгээ, барилга байгууламжуудын хүчин чадал, холбогдох бусад суурь судалгаанууд, дүгнэлт боловсруулагдсан. Гэрээт ажлыг 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр эцсийн тайланг хүлээлгэн өгөх бөгөөд ажлын явц 80 хувь байгаа талаар "Агро-сити" эдийн засгийн тусгай бүсээс мэдэгдсэн.	Хэрэгжсэн - 100%
	686		2.21. Хүннү хотод төрийн байгууллагуудыг үе шаттайгаар шилжүүлэх, олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, аялал жуулчлалын цогцолбор, ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, их сургуулийн хотхон бүхий аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлэх бүтээн байгуулалтыг эхлүүлэхийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Засгийн газрын холбогдох гишүүд нарт;	Хүннү хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан "Оюутны хотхон, эрдэм шинжилгээ, судалгааны бүс"-д Олон улсын инженерийн сургуулийн сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахад холбогдох асуудлыг шийдвэрлүүлэхээр Боловсролын яамнаас боловсруулсан 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 2387 тоот албан бичгээр Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургууль болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Аж үйлдвэрийн их сургуулиуд хамтран "Олон улсын инженерийн сургууль байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг ирүүлсэн. Уг Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 04-ны 01/1766 тоот албан бичгээр хариу хүргүүлж, хамтран ажилалаа.	Хэрэгжсэн - 100%
	687		4.19.1. хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хиймэл оюун ухаан, өндөр технологид тулгуурлан хөгжүүлэх бусад улсын сайн туршлагыг судалж, танилцуулах;	Мал тэжээвэр амьтны тооллогын ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсантай холбоотой мал танилтын системийг хөгжүүлэхэд ашиглах зурган дата санг ҮСХ-той хамтран үүсгэж машин сургалтын технологи ашиглан дүрс таних аргаар мал танилтын системийг үүсгэн бичлэгээс хонь, ямааг таних, тоолох туршилтыг хийж байна	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%
	688		4.19.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” хөтөлберүүдийн хэрэгжилтийг эрчимжүзлэх, хэрэгжилтийн явцын үр дүнг танилцуулах;	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд 2024 оны 12 сарын 12-ны өдөр холбогдох өөрчлөлтийг оруулан боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлж байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн хугацаанд 90 хувиар хөнгөлөхөөр нэмэлт өөрчлөлт орсон. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилгоор үйлдвэр, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч эргэлтийн хөрөнгийн 379.3 тэрбум төгрөгийн 117 хяналтын гэрээ, хөрөнгө оруулалтын зээлийн 120.8 тэрбум төгрөгийн 56 хяналтын гэрээ, нийт 500.1 тэрбум төгрөгийн 173 зээлийн хяналтын гэрээг албажуулсан. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй 1.26 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2577 иргэн, аж ахуйн нэгжид олгож, гол нэр төрлийн хүнсний 19 бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлж, сүүлийн 2 жилийн хугацаанд мах, махан бүтээгдэхүүний экспортын орлого нийт 600.0 сая гаруй ам	Хэрэгжсэн - 100%

				долларт хүрсэн. Сүү боловсруулах 10, мал төхөөрөх, мах боловсруулах 18, гурилан бүтээгдэхүүний 12, бусад нэр төрлийн бүтээгдэхүүний 13, нийт 53 үйлдвэр шинээр байгуулагдсан. Мөн зоорийн багтаамж 15%, үтрэмийн багтаамж 7%, тариалангийн талбай 13%, зуны болон өвлийн хүлэмж 28%-аар тус тус нэмэгдлээ. Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 37%, ажлын байр 21%, дундаж борлуулалтын орлого 31%, дундаж цэвэр ашиг 32%, үндсэн хөрөнгө 55%, эргэлтийн хөрөнгө 38%, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 46%, нийгмийн даатгал 60%-иар тус тус өссөн байна. Хавсралт : 2 файл	
	689		4.19.3. махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж, зохиомол хомсдол, үнэ хөөрөгдөхөөс урьдчилан сэргийлэх;	2025 онд өргөтгөсөн худалдаагаар хонины мах 4586.3 тн, үхрийн мах 1102.5 тн, хүнсний дэлгүүрт жижиглэнгээр хонины мах 271.2 тн, үхрийн мах 393.5 тн, нийт 6353.5 тн буюу нийт бэлтгэсэн нөөцийн 8380 тонн махны 76.0 хувийг худалдан борлуулсан. Нийт 9 дүүргийн 446 хүнсний дэлгүүрээр үхрийн мах 13800 кг/төг, хонины мах 11800 кг/төгрөгийн үнээр буюу зах зээлийн үнээс үхрийн мах 30-36 хувь, хонины мах 30-35 хувь, ямааны мах 20-30 хувиар хямд үнээр борлуулсан. Өргөтгөсөн худалдааг 9 дүүргийн нутаг дэвсгэрт долоо хоног бүрийн амралтын болон ажлын өдрүүдэд зохион байгуулсан ба холбогдох төрийн байгууллагууд хяналт тавьж, дүн мэдээг нэгтгэн ажилласан. Борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс үхрийн махны үнийг 800 төг, хонины махны үнийг 1800 төгрөгөөр бууруулж, өргөтгөсөн худалдаагаар үхрийн мах 13,000 кг/төг, хонины мах 10,00 кг/төгрөг, хүнсний дэлгүүрт үхрийн мах 13,300 кг/төг, хонины мах 10,300 кг/төгрөгийн үнээр худалдан борлуулсан байна. Махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мах, махан бүтээгдэхүүн 30 орчим экспортлогч аж ахуйн нэгжүүд 3-6 байршилд 14 хоногийн хугацаанд нийт 230.0 тн орчим үхэр, хонь, ямааны махыг дотоодын зах зээлд үе шаттайгаар худалдаалж, махны үнэ тогтворжиход тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
275	690	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	1.1. Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах;	“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын саналын төслийг боловсруулахдаа 2025 оны 09 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд Шинжлэх ухааны академийн бага хурлын гишүүдээр хэлэлцүүлсэн. 2026 онд улсын хилээр импортлох мал үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл тоо хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд салбарын сургалт эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоо, төр, хувийн хэвшлийн төлөөлөл тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санал авсан байна. Монголын мал зүйч, үржүүлэгчдийн үндэсний холбоотой хамтран “Монголд бий болсон үүлдэр, омгийн малын өнөөгийн байдал ба баталгаажуулалт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж, эрчимжсэн үхрийн аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл, Олон улсын төслийн техникийн ажилтан, зөвлөх, гавьяат мал зүйчид, үүлдэр омгийн малын зохион бүтээгчид зэрэг нийт 34 төлөөлөгч оролцов. “ЦАГААН АЛТ–2025” эрдэм шинжилгээний хурлыг 2025.11.03-ны өдөр арьс шир, ноос ноолуурын салбар гэсэн 2 хэсэгтэйгээр зохион байгуулж, “Цагаан алт” хөдөлгөөний санхүүжилт үйлдвэрлэлийн бүтэц, бүтээгдэхүүний нэр төрөлд нөлөөлөх, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүн, цаашдын зорилт, салбарын хүний нөөц, тулгамдаж буй асуудлууд, гарц шийдэл зэрэг сэдвээр илтгэл хэлэлцэв. “Арьс ширний үйлдвэрлэлийн шинэ технологи, цаашдын чиг хандлага” эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Архангай, Говьсүмбэр, Булган, Хэнтий, Дорнод, Дархан-Уул, Дундговь, Сэлэнгэ, Орхон, Дорноговь зэрэг 10 аймгаас 11 мэргэжилтэн, нийт 100 гаруй эрдэмтэн судлаач, үйлдвэрлэгч тус арга хэмжээнд оролцсон.	Хэрэгжсэн - 100%
	691		1.2. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах;	Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллах хүрээнд залуу албан хаагчдад чиглэсэн “Залуучуудын хөгжлийн төлөөх түншлэл: Салбар дундын уялдаа холбоо” чуулганыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай хамтран Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагын залуу албан хаагчдыг оролцуулан 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулсан.	Хэрэгжсэн - 100%

				Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд шинээр орсон албан хаагчдад зориулсан "Чиглүүлэх сургалт"-ыг зохион байгуулсан. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллаж байгаа бөгөөд яамны хэмжээнд ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээлэл ирүүлээгүй болно. Мөн Ёс зүйн хороотой хамтран 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр танхимын бүтэн 1 өдрийн сургалт зохион байгуулсан. Байгууллагын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан "Ёс зүйг дээдэлсэн төрийн албан хаагч" аяны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дэлхийн ёс зүн өдрийг тохиолдуулан албан хаагчдын дунд эерэг хандлагыг бий болгох нөлөөллийн ажиллагаа хийсэн.	
	692		1.3. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх;	Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх ажлын хүрээнд ХХААХҮЯ-ны хэмжээнд 2025 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан орон тоог 9 хувиар цомхотгон Сайдын 2025 оны Б/14, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/111 дүгээр тушаалуудаар орон тооны хязгаар, бүтцийг баталсан тушаалыг гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шинэчлэгдэн батлагдсан бүтцийн дагуу яамны төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын 96 албан тушаалд хамаарах 66 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 362, 363, 364, 365 дугаар тогтоолуудаар батлуулав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгах ажлын хүрээнд салбарын хэмжээнд нийт 187 орон тоог бууруулан ажилласан.	Хэрэгжсэн - 100%
	693		1.4. Салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг их өгөгдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, ашиглах;	Салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг их өгөгдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд Салбарын их өгөгдөл цуглуулах, бодит цагийн дашбоардод тулгуурлан статистик гаргах, дүн шинжилгээ хийх туршилтын ажил эхлүүлсэн. Энэ хүрээнд Үндэсний статистикийн хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зохион байгуулсан Үндэсний өгөгдлийн хүч санаачилга төсөл, "Хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хурдасгахад өгөгдлийг ашиглах нь" сэдэвт семинарт оролцлоо.	Х.Б
	694		1.5. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах;	Салбарын төрийн өмчит хуулийн этгээдүүдийг нэгтгэх тухай “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулах, давхардсан чиг үүргийг бууруулах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 01/1804 тоот албан бичгийг хүргүүлсэн. Засгийн газар шинээр байгуулагдсантай холбогдуулан Төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэл хийх талаар Засгийн газрын 8 дугаар сарын хуралдааны тэмдэглэл зэргийг харгалзан үзээд төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн зардлыг багасгаж, давхардсан чиг үүргийг оновчтой болгох зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор" ТӨХХК-ийг "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ний бүтцэд нэгтгэн зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг хүргүүлсэн. Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж хамтран ажиллах тухай албан тоотыг ТӨБЗГ-т хүргүүлж, ТӨБЗГ-ын 19 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын тогтоолын төсөл хүргүүлэх нь дэмжигдэж, тогтоолын төслийг ТӨБЗГ-аас ЗГХЭГ-т 2025-09-26-ны өдрийн А-1/1860 тоотоор хүргүүлсэн болно.	Хэрэгжсэн - 100%
	695		1.6. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	"Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулах шаардлагын хүрээнд “MNS3283:1991 Ноос, ноолуур. Үйлдвэрлэл. шивмэл эсгий. Техникийн шаардлага” стандартыг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлэхээр "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-тай 251105/06-876, “Ноос, ноолуур. Хялгас. Техникийн шаардлага. MNS 0037:2007” стандартыг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлэхээр "Монголын ноос ноолуурын холбоо" ТББ-тай 251105/06-877, “Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн технологийн хаягдал. Зумласан ноос. Стандартын техникийн шаардлага. MNS 5251:2008” стандартыг шинэчлэн боловсруулах зөвлөх	Хэрэгжсэн - 100%

				үйлчилгээг гүйцэтгүүлэхээр "Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо" ТББ-тай тус тус гэрээ байгуулэ, хэрэгжилт хангуулсан. БНСУ-ын Хөдөөгийн эдийн засгийн хүрээлэнгээс хамтран хэрэгжүүлж байгаа KAPEX төслийн хүрээнд “Монголын агрономичдын холбоо”-ны гүйцэтгэсэн “Хөрсний бодлогын зөвлөмж гаргах, хэлэлцүүлэг зохион байгуулах” 250902/05-723 дугаартай гэрээ, “Хөрс хамгаалах болон усалгаатай тариалангийн бордооны хэрэгцээ тооцох аргачлал боловсруулах, зөвлөмж гаргах” 250902/05-725 дугаартай гэрээ, “Хөрсний олон улсын ангиллын гарын авлага дахь хээрийн нөхцөлд хөрсийг үнэлэх, лабораторийн нөхцөлд шинжлэх аргачлалыг нутагшуулах, хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулах” 250902/05-722 дугаартай гэрээ, “Хөрсний лабораторийн шинжилгээний аргачлалыг ISO, GLOSOLAN стандартуудаар өргөжүүлэх зөвлөмж боловсруулах” 250902/05-721 дугаартай гэрээний тайланг тус тус хүлээн авсан. Бүгд Найрамдах Узбекстан улсад хонь нийлүүлж буй Малын генетик нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч 3 аж ахуйн нэгжид 100000 толгой хонийг амьдаар экспортод гаргах энгийн зөвшөөрөл олгосон. Намрын ногоон өдрүүд-2025 нэгдсэн арга хэмжээг 2025 оны 09 сарын 22-ноос 28-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд НҮБ-ын Хүнс Хөдөө аж ахуйн байгууллага болон Монголын хүнсчдийн нэгдсэн холбоо ТББ-тай хамтран зохион байгуулсан.	
	696		1.7. Салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан, шуурхай шийдвэрлэх;	Салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийн тайланг ЗГХЭГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу (сэтгүүлд тавих хувилбар) тайлагнаж хүргүүлсэн. Мал аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын арга хэмжээний хэрэгжилтийг орон нутагт мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, эрсдэлийг бууруулсан. Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд газар тариалангийн салбараас хөрсний үржил шимийг сайжруулах, хөрс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг тусган төлөвлөж, тариалангийн талбайг хашаажуулах ажлын хүрээнд Сэлэнгэ /186,875 ширхэг/, Дархан-Уул /101,565 ширхэг/ Төв /21,250 ширхэг/, Булган /51,550 ширхэг/ нийт 361,240 ширхэг төмөр бетон шонгоор 1806 км-ийн урттай 80 мян.га талбайг хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тариалангийн талбайг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Сайхан /30,6 км/, Орхон /12 км/, Зүүнбүрэн /24 км/, Дархан-Уул аймгийн Хонгор /36 км/ суманд нийт 4 байршилд улиас, хайлаасны суулгацаар 3 эгнээ хамгаалалтын ойн зурвасыг 102.5 км-ийн урттай 9234 га талбайг хамгаалан байгуулж байгаа нь 90,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын Их Хурлын 2025 оны нэгдсэн чуулганаар “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай” хуулийг батлуулсан. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-ын хүрээнд “Монгол-Хятадын Экспо” тав дахь удаагийн арга хэмжээг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Хөх хотод 2025 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс 30-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	697		1.8. Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах.	"Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай” хуулийн төсөл, "Хууль батлсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан материалын бүрдүүлбэрийг хангаж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хүрээнд Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж хэлэлцүүлэн оролцсон. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдийн хуралдаанд салбараас хэлэлцүүлэх асуудлаар удирдлагын бүрэлдэхүүнтэй оролцож намын бүлгүүдийг мэдээллээр ханган ажиллаж байна. Тухайлбал 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Ардчилсан намын бүлгийн хуралд Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах тухай Засгийн газрын 56 дугаар тогтоолын биелэлтийн явцыг танилцуулсан.	Хэрэгжсэн - 100%
	698		2.1. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;	1. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдүүлж, хяналт тавьж удирдлагаар ханган ажиллаж байна. Дээрх хууль тогтоомж, үзэл баримтлалыг зөрчсөн аливаа үйлдэл гаргаагүй болно. 2. Гадаад улс орнуудтай хорио цээрийн нөхцөл тохирох, протоколын төслийн санал солилцох	Хэрэгжсэн - 100%

				асуудлууд дээр ХХААХҮЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтэс болон ГХЯ-ны Хөрш орнуудын газар, Гэрээ, эрх зүйн газартай уялдаатай ажиллаж, зөвлөмж туслалцаа авч ажиллаж байна. 3. Сайдын болон ТНБД-ын тушаалын хавсралтад тухай бүрийн уулзах сэдэв, оролцох ажлын цар хүрээ, хэлэлцээрийн сэдвийг тусгайлан зааж ажиллах удирдамжийг баталж, хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн яамны хэмжээнд нийт албан хаагчдыг Гадаад бодлогын үзэл баримтлал болон холбогдох хууль тогтоомжийг тогтмол мөрдөх, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор байгууллагын дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр нийт 8 санал боловсруулж, холбогдох нэгжид хүргүүлснээс 4 саналыг тусган баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.	
	699		2.2. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээлэл болон хууль журмыг зөрчин үндэслэлгүйгээр нууцалсан мэдээллийг зохих журмын дагуу ил болгох, салбарын хэмжээнд “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д хамааруулсан жагсаалтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ТНБД-ын 2025 оны А/312 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлаас гарсан дүгнэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 02/3090 тоот албан бичгээр ТЕГ-т хүргүүлэв.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	700		2.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох;	Мал эмнэлгийн ерөнхий газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Ургамал хамгааллын газар, Малын удмын сангийн үндэсний төв, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төв, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК, Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК, Биокомбинат ТӨХХК, ХАА-н Халхгол ҮББББЗ, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ий цахим хуудсанд байршуулсан мэдээллийн жагсаалт, нээлттэй мэдээллийн ил тод байдлын 3 дугаар улирлын тайланг нэгтгэсэн. Үүнд ил тод байдлын мэдээллийн жагсаалтын дагуу нийт 69 мэдээллээс Мал эмнэлгийн ерөнхий газар 45, Жижиг, дунд үйлдвэрийн газар 51, Малын удмын сангийн үндэсний төв 41, ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төв 42, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК 49, Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК 61 мэдээллийг байршуулсан байна. Харин Ургамал хамгааллын газар шинэчилсэн төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны удирдлагын системд эрх авч мэдээллээ бүрэн оруулж амжаагүй, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны http://otor.gov.mn/, Биокомбинат ТӨХХК-ий http://biocombinat.gov.mn/, ХАА-н Халхгол ҮББББЗ-ны https://khalkhgol.mofa.gov.mn/ цахим хуудсууд засвартайгаас ажиллахгүй, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ий нэр, чиг үүрэг солигдсон тул цахим хуудсаа шинэчилж амжаагүй байна. Харин яамны цахим хуудсанд салбарын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг 69 цэсэнд ойлгомжтой байдлаар байршуулан Яамны цахим хуудсыг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 357 шинэ мэдээ, 165 тендерийн урилга, 29 хүний нөөцийн зар, 23 хяналтын хуудас, 21 ХШҮ-ний тайлан, 4 сонгон шалгаруулалтын зар, 29 хэлэлцүүлэг, 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөө, 2 статистикийн нээлттэй мэдээлэл, 3 статистикийн нээлттэй мэдээлэл, 8 Засгийн газрын тогтоол, 1 УИХ-ын тогтоол болон яамны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2024 оны тайлан, мэдээллээр шинэчлэн оруулж цахимаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
	701		2.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх;	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/10 дугаар тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Ёс зүйн дэд хороог байгуулсан. 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр тохиосон Дэлхийн ёс зүйн өдрийн хүрээнд нийт албан хаагчид ёс зүйн зөрчлөөс ангид байх талаар мэдээлэл хүргүүлсэн. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газрын албан тушаалтанд ирсэн гомдлын дагуу зөвлөгөө өгч ажилласан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%
	702		2.5.Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх;	Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй Төрийн албаны тухай хуулийг чанд мөрдөж, төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах журмын хүрээнд ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Ургамал хамгааллын газар, харьяа төсвийн байгууллагын төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан	Хэрэгжсэн - 100%

				тушаалын сул орон тоог нөхөх, сэлгэн, шилжүүлэн ажиллуулах 9 зар /57 албан тушаал/, сонгон шалгаруулалтын 9 зар /50 албан тушаал/, Төслийн нэгжийн 13 албан тушаалын сул орон тоог нөхөх зарыг тухай бүр яамны цахим хуудас https://www.mofa.gov.mn/humanresource/abz, Дархан--Уул аймгийн зарын цахим сувгуудаар олон нийтэд хүргүүлсэн. ХХААХҮЯ-ны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг 4, МЭЕГ-ын удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг 1, ЖДҮГ-ын удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг 1, Харьяа төсвийн шууд захирагчийн сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг 1, УХГ-ын удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг 2 удаа тус тус зохион байгуулсан. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудалтай холбоотой 67 тогтоол батлуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн https://www.facebook.com/profile.php?id=61571734978346 нүүр хуудсаар нийт 53 мэдээллийг Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Ёс зүйн хороо болон холбогдох төрийн байгууллагын эх сурвалжаас нийтэлсэн байна. Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Ёс зүйн дэд хорооны дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөө, хөтөлбөрийг яамны цахим хуудас болон дотоод сүлжээний АБЛЕ системд байршуулсан. Албан хаагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.	
	703		2.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн холбогдох зардлуудыг хаязгаарлан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийг 2025 оны төсвийн тодотголоор сайдын багцын төсвийг 87.9 тэрбум төгрөгөөр бууруулан баталж, 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр улсын төсвөөс санхүүжих 662.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төлөвлөж, 446.6 тэрбум төгрөг буюу 67.4 хувийн гүйцэтгэлтэй байна. ЖДҮГ нь 2026 оны Төсвийн тодотголын хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж 7 тендер болон шууд худалдан авалтыг хасаж, хэмнэлт хийсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх тухай МЭЕГ-ын даргын 2025-08-05-ны өдрийн 01/776 тоот 14 заалт бүхий албан бичгийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, харьяа байгууллагын дарга буюу төсвийн шууд захирагч нарт хүргүүлэн хагас жил тутам үр дүнг тооцож байх үүрэг чиглэлийг өгсөн байна. АДОБАЗ нь төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. 7 отрын бүс нутгийн “Орон тооны бус зөвлөлийн хурал”-ыг цахимаар зохион байгуулж, шатахуун, албан томилолтын зардал болон бага дүнтэй түргэн элэгдэх материал буюу шаардлагатай сэлбэг хэрэгсэл, бичиг хэргийн материалыг 2 сард нэг удаа худалдан авч, төсвийн хэмнэлтийг хийж ажилласан байна. МУСҮТ нь худалдан авахаар төлөвлөсөн гүн хөлдөөсөн үрийг импортоор орж ирэх бухнаас үр авах замаар шийдвэрлэж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан. Мөн өвс, хадлан тэжээл бэлтгэхэд жил бүр гардаг зардлыг 100% хэмнэсэн байна. Хөдөө аж ахуйн "Халх гол" үндэсний бүтээн байгуулалтын бүс нь 2025 оны улсын тодотгосон төсвөөс үр ашиггүй зардлыг танаж, төсвийг 39.7%-аар хэмнэсэн байна. Хөдөө аж ахуйн бирж нь томилолтын зардлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80 орчим хувиар бууруулсан байна.	Хэрэгжсэн - 100%
	704		3.2.. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох;	Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаврын салбарт хамаарах арга хэмжээтэй холбоотой биелэлтийг тухай бүр цахим системээр дамжуулан тайлагнасаар байна. https://new.unelgee.gov.mn/. ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас яамны дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудад Ерөнхий сайдын албан даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох ХШҮДАГ№25/17, ХШҮДАГ№25/18 тоот дотоод албан бичгийг хүргүүлсэн. Тус албан бичигт Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогтоос ирүүлсэн 2025 оны ХЭГ/2450 тоот "Албан даалгаврын биелэлт хангуулах тухай" албан бичгийг хавсаргасан. Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяад заасан хугацаанд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох тухай Сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний	Хэрэгжсэн - 100%

				өдрийн 01/2912 тоот албан бичиг, мөн Сайдын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн "Үүрэг даалгавар хүргүүлэх тухай" 01/3478 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн байна.	
	705		3.3.. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх.	Засгийн газрын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд 2025 онд газар тариалангийн салбар дахь бодлогын үр дүнгийн талаарх 79 мэдээллийг яамны албан ёсны цахим хаяг болох mofa.gov.mn-ээр дамжуулан олон нийтэд хүргэн ажилласан. Мөн түүнчлэн "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл" нэгдсэн арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 28-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулан нийт 73 асарт нийслэл болон орон нутгийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 146 ногоочдыг зохион байгуулалтад оруулан 1.2 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, эх орны хөрсөнд ургасан эрүүл, баталгаатай, шинэхэн хүнсний ногоо жимс жимсгэнэ зэргийг хэрэглэгчдэд сурталчлан таниуллаа. Органик бүтээгдэхүүний тухай хууль /Шинэчилсэн найрлуулга/ 2024 оны Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн баталж, 2025 онд холбогдох 3 журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/590, А/591 тушаалаар батлуулсан. Мөн Засгийн газрын 2025 онд баруун бүсийн 2025 оны байгаль цаг уур, газар тариалангийн нөхцөл байдалтай холбоотойгоор Гаалийн татварын хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 20 дугаар тэмдэглэлээр албажуулсан. Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд "Мал махны бэлтгэл, гурилын хангамж, нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн тогтоолыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв. Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд "Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 56 дугаар тогтоолд тусгагдсан эрхлэх асуудлын хүрээнд хамаарах холбогдох заалтыг хэрэгжилтийг танилцуулан, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг албажуулсан. Дээрх Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийг тухай бүр салбарын цахим мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэн ажилласан.	Хэрэгжсэн - 100%
	706		4.. Энэ албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд, биелэлтэд нь хяналт тавьж, явц, үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосугай.	Албан даалгаварт туссан холбогдох үүрэг даалгаврын биелэлтийг ЗГХЭГ (//new.unelgee.gov.mn/law/) болон салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ (mofa.igovernment.mn)-ний цахим системээр дамжуулан 2025 онд нийт 4 удаа (08, 09, 10, 12 дугаар сар) тайлагнаж, хэрэгжилт, үр дүнгийн мэдээллийг удирдлагуудад танилцуулж баталгаажуулсан. Засгийн газрын 2025 оны 01 дүгээр албан даалгавраас 17 заалтыг энэ хугацаанд тайлагнаж байна. Албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn цахим системд сар бүр тайлагнаж, илгээсэн. 2025 оны 09 дүгээр сарын тайлангаар хэрэгжээгүй 5 үүрэг, даалгаврыг хариуцсан нэгж, албан хаагчдад хэрэгжилтийг хангуулах талаар ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас яамны дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудад Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох ХШҮДАГ№25/17, ХШҮДАГ№25/18 тоот дотоод албан бичгийг хүргүүлсэн. Тус албан бичигт МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогтоос ирүүлсэн 2025 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн ХЭГ/2450 тоот "Албан даалгаврын биелэлт хангуулах тухай" албан бичгийг хавсаргасан.	Хэрэгжсэн - 100%
276	707	ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04	1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;	ХХААХҮЯ-нд Төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог цөөлөх ажлын хүрээнд 2025 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан орон тоог ажлын байрны шинжилгээ хийж, 9 хувиар цомхотгон Сайдын 2025 оны Б/14 дүгээр тушаал болон ТНБД-ын 2025 оны Б/111 дүгээр тушаалыг батлуулан орон тооны хязгаар, бүтцийг баталсан тушаал гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шинэчлэгдэн батлагдсан бүтцийн дагуу яамны төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын 96 албан тушаалд хамаарах 66 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 362, 363, 364, 365 дугаар тогтоолыг батлуулав. МЭЕГ нь аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын сул орон тоог царцааж, чиг үүргийн шинжилгээнд үндэслэн нийт 118 орон тоогоор цөөрүүлж, орон тоо нэмэгдүүлэх шийдвэр гаргаагүй. Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээг Удирдлагын академиар гэрээгээр гүйцэтгүүлж, тайланг хүлээн авч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/548 дугаар тушаалаар "Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц"-ийг шинэчлэн батлуулсан. ЖДҮГ нь давхардалтай гэж	Хэрэгжсэн - 100%

				үзсэн 3 орон тоог нэгтгэн 2 болгож, бүтцээс хасагдсан удирдах албан тушаалтны хэрэгжүүлэх ажил үүргийг хамгийн ойр хамааралтай нэгжийн удирдах албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтод нэмж, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны "Зөвшөөрөл олгох тухай" 479, 480, "Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай"" 481 дүгээр тогтоолоор батлуулсан. 2025 онд 1 албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгон ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд тухайн сул орон тоон дээр ямар нэгэн томилгоо хийлгүй, бүтцээс хасч цөөрүүлсэн. Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан Ургамал хамгааллын газрын бүтэц, орон тоог хоёр нэгжээр бууруулж, нийт 19 орон тоогоор ажиллаж байна.	
	708		1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад;	2025 оны Дэлхийн ёс зүйн өдрийн хүрээнд нийт албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс ангид байх талаар мэдээлэл хүргүүлсэн. Авлигаас урьдчилан арга хэмжээ хэрэгжүүлж яамны цахим хуудас, фэйсбүүк цахим сүлжээний хуудсанд авлигын эсрэг үзэл санаатай агуулсан богино бичлэг 2 удаа мөн бусад мэдээлэл бэлтгэн хүргэсэн байна. https://www.facebook.com/photo/?fbid=1138053098476221&set=a.193530096261864 https://www.facebook.com/reel/1621565262524603. https://www.facebook.com/reel/1621565262524603. Авлигын эсрэг үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг 2025 оны 11 сарын 11-ний өдрийн байдлаар боловсруулж цахим хуудсанд байршуулсан. https://www.mofa.gov.mn/humanresource/awilgal. Ил тод байдлыг бэхжүүлэх хүрээнд 2025 онд 357 шинэ мэдээ, 165 тендерийн урилга, 29 хүний нөөцийн зар, 23 хяналтын хуудас, 21 ХШҮ-ний тайлан, 4 сонгон шалгаруулалтын зар, 29 хэлэлцүүлэг, 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөө, 2 статистикийн нээллтэй мэдээлэл, 56 тайлан, төлөвлөгөө, товхимлыг https://mofa.gov.mn/ цахим хуудсанд болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны facebook хуудсанд тухай бүр нийтэлсэн байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Дархан-Уул аймаг дахь байр болон Улаанбаатар хотод байрлах Засгийн газрын 9б байранд авлигын эсрэг танилцуулга, наалт зэргийг байршуулсан байна.	Хэрэгжсэн - 100%
	709		1.4.. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/10 дугаар тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Ёс зүйн дэд хороог 7 гишүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Тус дэд хороо нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Мөн харьяа байгууллагуудад ёс зүйн дэд хороо байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%
	710		1.7.. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт;	Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулаагүй бөгөөд ХХААХҮЯ-ны бүтцээс 10 орон тоо хассантай холбогдуулан чиг үүргийн шинжилгээ хийж, зарим албан хаагчдын чиг үүрэгт нэмэлт оруулж, албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдсан төрийн жинхэнэ албан хаагчдын шийдвэрийг гаргаж, шатлан дэвшиж байгаа, ангилал зэрэглэлд өөрчлөлт орсон 23 төрийн албан хаагчийг ТАтХ-д нийцүүлэн тусгай шалгалтыг 2025 онд зохион байгуулж, салбар зөвлөлийн тогтоол, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар албажуулсан. ТЖАХ-ийг албан тушаал бууруулах шийдвэр гаргаагүй болно. https://se.csc.gov.mn/search?sector_id=02001013. Төрийн захиргааны гүйцэтгэх 5 албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2025 онд зохион байгуулж, салбар зөвлөлийн тогтоол, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар албажсан. Мөн харьяа 11 байгууллага (УХГ, ЖДҮГ, МЭЕГ агентлаг зэрэг)-д ТАтХ болон албан даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажилласан.	Хэрэгжсэн - 100%
	711		1.8.. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран зохион байгуулсан "Төрөөс хувийн хэвшилд шилжин ажиллахыг дэмжих өдөрлөг"-т яам	Хэрэгжсэн - 100%

			талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	болон харьяа байгууллагын 21 албан хаагчийг оролцуулсан. Тус өдөрлөгт 22 аж ахуйн нэгж, байгууллага 1117 нээлттэй ажлын байрыг танилцуулж, 300 төрийн албан хаагч, иргэд оролцсон байна. Хяналтаас хасуулах санал : нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжсэн	
	712		17.1.. хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн оновчтой төлөвлөх, хөрөнгө оруулалтыг зөв зохистой зарцуулах, паркт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх талаар нэгдсэн бодлого боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;	Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2024 оны 204 дүгээр тогтоолоор “Хүнд үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт”, Засгийн газрын 2025 оны 271 дүгээр тогтоолоор “Хөнгөн, хүнсний үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт”-ыг тус тус баталсан. Үйлдвэрлэл технологийн паркуудын байршил, үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрлийг тухайн бүс нутгийн түүхий эдийн нөөц, ажиллах хүчний хангамж, дэд бүтцийн хөгжил, цаашдын төлөвлөлт, бүс нутгийн эдийн засгийн хөгжил, экспорт, импортын боломжуудад тулгуурлан Хэрэгжсэн - 100% сонгосон. Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл технологийн паркуудыг төвийн бүсэд Дархан-Уул аймагт “Төвийн бүсийн Хүнс, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк”, Баруун бүсэд Ховд аймагт “Шинэ Ховд аж үйлдвэрийн парк”, Нийслэлд “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”, говийн бүсэд Говьсүмбэр аймагт “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”, Зүүн бүсэд Дорнод аймагт “Зүүн бүсийн үйлдвэрлэл технологийн парк” байгуулахаар төлөвлөөд байна. Үйлдвэрлэл технологийн паркад үйл ажиллагаа явуулах ААН-д хөрөнгө оруулалт, санхүү татвар, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. Хавсралт : 2 файл	
	713		17.2.. “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгож байгаа дэмжлэгийг малчдын хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд чиглүүлэх “Хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр” боловсруулж, бүс нутгийн онцлогийг харгалзан ялгавартай байдлаар хэрэгжүүлэх, зээлийг тасралтгүй олгох чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран бодлогын шийдвэр боловсруулж, хэрэгжүүлэх;	“Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгож байгаа дэмжлэгийг малчдын хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд чиглүүлэх зорилгоор 21 аймгийн бичил, жижиг үйлдвэрийн судалгааг гаргаж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран хэрэгжүүлэх "Дэд хөтөлбөр"-ийн төсөл боловсруулан 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/3674 тоот албан бичгээр тус яаманд хүргүүлсэн. Ерөнхийлөгчийн Тамгын газар, ГБХНХЯ-тай хамтарсан уулзалтыг 2 удаа зохион байгуулаад байна. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд 2023, 2024 онд хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгжүүдээс https://tinyurl.com/58sxb3rv холбоосоор асуумж, судалгаагаар мэдээллийг шинэчилж, үр дүнгийн боловсруулалтыг урьдчилсан байдлаар хийгээд байна. Ерөнхий сайд Г.Занданшатар Дархан-Уул аймагт ажилласантай холбогдуулан "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн үр дүнд тооцоолол хийж, нэгтгэн мэдээллийг танилцуулж ажилласан. Хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний 2024 оны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг 2022 оны хэмжээтэй харьцуулахад дараах байдалтай байна. Тухайлбал, мах, махан бүтээгдэхүүн 211.5 тонн буюу 32%, гурил, гурилан бүтээгдэхүүн 57.8 тонн буюу 28.5%-иар буурсан бол сүүн бүтээгдэхүүн 32.7 тонн буюу 60%-иар, төмс 41 тонн буюу 19.2%, хүнсний ногоо 132.5 тонн буюу 89%, буурцагт ургамал 0.1 тонн буюу 100%, өндөг 0.1 тонн буюу 0.9%, сахар, чихрийн зүйл 28.7 тонн буюу 20.7%-иар тус тус нэмэгдсэн байна.	Ахиц гарсан - 50%
	714		17.3.. хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг 2025 оны 08 дугаар сарын 25-ны дотор Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх;	Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг хэлэлцүүлж, Засгийн газрын 56 дугаар тогтоолоор батлагдсан. Хавсралт: 1 файл Хяналтаас хасуулах санал : Нэг удаагийн шинж чанартай бөгөөд хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах	Хэрэгжсэн - 100%
	715		17.4.. ”Улсын аварга малчин, Улсын хошой аварга малчин, Улсын аварга саальчин, Улсын аварга фермер, Улсын аварга	Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Журам шинэчлэн батлах, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Улсын аварга	Хэрэгжсэн - 100%

			тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч шалгаруулах журам”-ыг бүсчилсэн хөгжлийн бодлого, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;	малчин, улсын хошой аварга малчин, шалгаруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулан аймаг нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэв. Журамд тариалангийн бүс нутагт мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, төрөлжүүлэн хөгжүүлсэн байдлыг голлох үзүүлэлт болгож, 2000-аас доошгүй малчин өрх тутамд нэг улсын аварга малчин өрх шалгаруулахаар туссан. Хяналтаас хасуулах санал : Хэрэгжсэн	
	716		17.5.. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд 7 аймгийн 9 суманд 2,970 га талбайг услах хүчин чадал бүхий 9 услалтын системийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ашиглалтад оруулах;	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд 7 аймгийн 9 суманд 2,970 га талбайг услах хүчин чадал бүхий 9 услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил хийгдэж байгаагаас 7 услалтын системийн ажил бүрэн дуусаж улсын комисс хүлээн авсан. Хэнтий аймгийн Хэрлэн сумын “Дулааны тал”, Говь-Алтай аймгийн Жаргалант сумын “Цахир” услалтын системийн ажил нь тоног төхөөрөмжийн нийлүүлэлтээс шалтгаалан хугацаандаа дуусаагүй бөгөөд гүйцэтгэгч “Жинсийн орой” ХХК, “Комп Трейд” ХХК-ийн түншлэл, “Алтайн Үндэс Констракшн” ХХК нь гэрээ сунгах хүсэлт ирүүлсэн байна. Үр нөлөө : Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын үр дүнд усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 63.5 мянган га хүрээд байна.	Ахиц гарсан - 50%
	717		17.6.. отрын бүсийг “эрүүл бүс” болгох зорилтын хүрээнд аймаг дундын 9 отрын бүсэд “Малын эрүүл мэндийн нэгдсэн төв” байгуулах, бүс тус бүрд ариутгалын автомашин (ДУК) олгох, сэг зэм устгах талбай байгуулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулах;	Отрын бүс нутгийг “Эрүүл бүс” болгох зорилтын хүрээнд аймаг дундын 9 отрын бүсэд "Малын эрүүл мэндийн нэгдсэн төв" байгуулах ажлыг эхний ээлжинд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан отрын бүсэд хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд тус төвийг байнгын үйл ажиллагаатай байлгах зорилгоор хувийн хэвшил, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллахаар санал солилцон гэрээ байгуулан ажиллаж байна. Олон улсын төсөл, хөтөлбөрийн мэргэжилтэн Л.Амарсанаатай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хамтран ажиллаж, дараах 3 үндсэн бэлтгэл шатны ажлыг гүйцэтгэсэн. 1.Хэрлэнбаян-Улаан отрын бүсэд “Малын эрүүл мэндийн нэгдсэн төв” байгуулах судалгаа, газрын байршлын сонголтыг хийж, зардлын төсвийг урьдчилсан байдлаар гаргасан. 2.ДУК автомашины үнийн судалгааг хийсэн. 3.Сэг зэм устгах талбайг төвийн бүтээн байгуулалттай уялдуулан төлөвлөсөн. • “Малын эрүүл мэндийн нэгдсэн төв” байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоог гарган 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 119 тоот албан бичгээр ХХААХҮ-ийн сайдад хүргүүлсэн. • “Мэтагро” компанийн Бизнес хөгжил хариуцсан захирал Б.Оргилтой уулзалт зохион байгуулж "Малын эрүүл мэндийн нэгдсэн төв" байгуулах, танилцуулга хийж цаашдын авч хэрэгжүүлэх ажил, хамтран ажиллах талаар санал солилцов. • Монгол дахь Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид ТББ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, зөвлөх Крис Бартелстай уулзалт зохион байгуулж "Малын эрүүл мэндийн нэгдсэн төв" байгуулах талаарх мэдээлэл танилцуулга, хийж санал солилцож ажиллав. Отор нүүдэл орох болон гарах үед малын хашаа, хороо, бууц, худаг уст цэг зэрэг ашиглалтын бүсүүдэд ариутгал, халдваргүйтгэл хийх, зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулж устгах зэрэг ажлыг чанартай, хугацаанд нь зохион байгуулж хэрэгжүүлэх талаар Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтран ажиллахаар захиргааны даргын 2025 оны 154 болон 167 тоот “Хамтран ажиллах тухай” албан бичиг хүргүүлэн хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй.	Х.Б
	718		17.7.. малын гаралтай түүхий эдийг боловсруулах, ажлын байр нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортод гаргах хүчин чадал бүхий дэлхийн жишигт нийцсэн хөдөө аж ахуйн “Эмээлт эко” аж үйлдвэрийн паркийн инженерийн шугам сүлжээ, эх үүсвэрүүдийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх.	“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.3-д Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгах зорилтууд тусгагдсан. Олон улсын санхүүгийн корпорацын санхүүжилтээр ”Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн арьс шир, ноос боловсруулах үйлдвэрлэлийн бүсийн ТЭЗҮ”-ийг шинэчлэн боловсруулсан. Уг техник, эдийн засгийн үндэслэлийг “Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал”-ын 2025 оны 19 дүгээр хуралдаанаар батлуулсан. Дулааны цахилгаан станц болон Цэвэрлэх байгууламжийн ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтад БНХАУ-ын "Хуа Зи Технологи” ХХК, “Хуа Ши Энержи Индастри” ХХК-ийн түншлэл шалгарч 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр НХААГ/20250101624 дугаартай "Гүйцэтгэлд суурилсан хойшлуулсан хуваарьт төлбөрийн нөхцөлтэй Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажил гүйцэтгэх (EPC) гэрээний баталгаажуулалт (Contract agreement) гэрээ байгуулсан. Гэрээгээр 24МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц болоод ахуйн	Хэрэгжсэн - 100%

				болон үйлдвэрийн бохир ус цэвэрлэх 6'700 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг 2027 онд ашиглалтад оруулна. Ажил эхэлсэн.	
	719		21.. Энэ албан даалгаврын хавсралтад заасан хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.	Засгийн газраас яаралтай санаачлан боловсруулж, өргөн мэдүүлэх, батлуулах хууль тогтоомжийн жагсаалтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хамаарах хууль тогтоомж байхгүй болно. Хяналтаас хасуулах санал : 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх - заасан хугацаа дууссан	Хэрэгжсэн - 100%
277	720	Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай 2025-12-10 Дугаар 2025_05	1.1.. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж төсвийг хуваарилан зарцуулахдаа үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танах, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллах талаар харьяа байгууллагын удирдлагад үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож ажиллах;	Үйл ажиллагааны зардлаас бусад үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танаж, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллах талаар яамны харьяа байгууллагуудад үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг ханган ажилласан. Хяналтаас хасуулах санал : 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж төсвийг	Хэрэгжсэн - 100%
	721		1.2.. төрийн байгууллагын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүүгийн төлбөр, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, онцгой байдлын байгууллагын шаардлагатай урсгал зардлыг тэргүүн ээлжид, бусад зардлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон эрэмбийн дагуу санхүүжүүлэх;	Албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалын шимтгэлийг санхүүжүүлсэн.	Хэрэгжсэн - 100%
	722		1.3.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх;	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/243 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, яамны харьяа байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажилласан. Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, үр ашиггүй зардлыг танаж, байгууллагын хэмжээнд хэмнэлтийн горимыг сахин ажиллаж байна. Яам болон харьяа байгууллагын албан хаагчид шинэ жил, байгууллагын болон салбарын нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулаагүй болно.	Хэрэгжсэн - 100%
	723		1.4.. тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах:	Тэвчиж болох арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд хэмнэж ажилласан Хяналтаас хасуулах санал : Шийдвэрт заасан хугацаа дууссан - 2025 он дуустал хугацаанд зогсоож	Хэрэгжсэн - 100%
	724		1.4.1.. хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх;	1. Ерөнхий сайдын 01, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/243 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, үр ашиггүй зардлыг танаж, байгууллагын хэмжээнд хэмнэлтийн горимыг сахин ажиллаж байна. 2. Яам болон харьяа байгууллагын албан хаагчдын 7 хоног бүрийн Мэдээллийн цагийг цахимаар зохион байгуулж хэвшсэн.	Хэрэгжсэн - 100%
	725		1.4.2.. байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох;	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж олгоогүй болно.	Хэрэгжсэн - 100%
	726		1.4.3.. тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх;	Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авалт хийгээгүй бөгөөд бичиг хэргийн зүйлс худалдан авалтыг хэмнэлттэй горимоор санхүүжүүлсэн	Хэрэгжсэн - 100%
278	727	Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай 2025-12-10 Дугаар 2025_05	1.4.5.. төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх.	Өмнөх оны санхүүжигдээгүй холбогдох хөтөлбөр арга хэмжээний зардлыг ач холбогдлоор нь эрэмбэлэн ХХААХҮСайдын 2026 оны батлагдсан төсвийн багцад тусган 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлуулла.	Хэрэгжсэн - 100%